

БАРБАРА ДЭМИК
АТААРХАХ
ЗҮЙЛ ҮГҮЙ

*Хойд Солонгосын арг түмний
бодит амьдралаас*



ӨМНӨТГӨЛ

Хойд Солонгосын амьдралын үнэн нүүр царайг нүдэнд харагдтал тод томруун дүрслэн үзүүлсэн энэ ном орчин үеийн сэтгүүл зүй, non-fiction буюу баримтат утга зохиолын сонгодог жишээ гэгдэхүйц үнэ цэнэтэй бүтээл болсны дээр дарангуйлагч дэглэм, бурангуй үзэл сурталд гинжлэгдсэн бүхэл бүтэн ард түмний эмгэнэлт хувь заяаг дэлхий нийтэд дэлгэснээрээ ихээхэн ач холбогдолтой юм. Хувь хүний төдийгүй үндэстэн угсаатны эрх ашгийг уландаа гишгэсэн нийгмийн харгис тогтолцоо хүний сэтгэх хийгээд эрх чөлөөг эрхэмлэн дээдлэх үзэл бодлыг ч арчин үгүй хийдгийг хирдхийм хурц жишээнүүдтэй та энэ номын хуудас бүрд тулах болно. Эндээс бид өөрсдийнхөө түүхийн мартаж ёсгүй цаг үеийг ч ахин санаж, тийм тогтолцоо өнөө хэр амь бөхтэй оршсоор буйг, тийм нийгмээс үлдсэн сэтгэлгээ өдгөө хүртэл бүрэн арилаагүйг мэдрэх бизээ. Иргэдээ ядуу, хүлцэнгүй, мэдлэггүй, хязгаарлагдмал, гар харсан нөхцөлд байлгах сонирхол чухам дарангуйлагч, бурангуй засаг төрд л байдаг. Иймэрхүү харанхуй дорд байдал нь, нөгөө утгаараа, өлсгөлөнд нэрвэгдсэн, соёлт хүн төрөлхтөнөөс тусгаарлагдсан хөөрхийлөлтэй энэ оронд ч бус, өнгөн талаасаа нээлттэй мэт харагдагч манай өнөөгийн утаатай нийгэмд ч нүүрлэсээр буйг олж харах шижмийг нээсэн нь уг бүтээлийн далд нэгэн чухаг тал юм.

Хүний эрх, чөлөөт эдийн засаг, ардчиллын тухай бүхний мэдэх зүйлсийг энд нурших шаардлагагүй биз ээ. Үндэстний эрх ашиг гэгч түүнээс дутуугүй үнэт зүйлийг хоёр Солонгосын хуваагдал хийгээд тоталитар дэглэм хэрхэн булшилсаар ирснийг асар олон баримт, гярхай нарийн ажиглалт, эрүүл саруул дүгнэлт, дүрслэлүүдээр дэлгэн үзүүлсэн энэ номыг унших явцад нулимс дуслуулам төдийгүй жигшин зэвүүцэм эмгэнэлт-инээдмийн түүх олонтаа таарах аж.

Монгол үндэстэн дэлхийн хамгийн том гүрнийг цогцлоож явсан түүхтэй атлаа их гүрнүүдийн эрх ашиг, үзэл суртлын дайны гашуун тоглоомоор мөн л хэдэн хэсэг хэрчигдэн салж, зарим нь нэгэнт устаж балрах замдаа ороод байгаа нь нууц биш. Мунхагийн алдаа ухаантны туршлага болдог гэлцэнэ. Бид ч бас алдаанаасаа ангижирчихсан хүмүүс биш ээ. Гадаад орнуудын бодлогоос гадна дотоод дахь дээдсийнх нь эв нэгдэлгүй байдал, доодсынх нь бүхнийг сохроор аялдан дагаж амьдардаг, өнөө маргаашийн талхаас илүүг боддоггүй ядуу сэтгэлгээ улс орноо юунд хүргэж болохыг, юунд хүргэж байгааг та эндээс харна.

Өмнөд ба Хойд Солонгос үе үе хурцадмал байдалд орж буй энэ цаг үед Ази дахь цөөхөн ардчилсан орны нэг болох Монголд ийм ном орчуулагдан гарч буйд ихэд олзуурхан талархана. Сэтгүүлч хүний эр зориг, хурц нүд, өргөн мэдлэг, нөр их хөдөлмөр, сайтар боловсруулалтын жишээ болсон уг бүтээл эрэн сурвалжлах төрлөөр бичдэг манай сэтгүүлчдийн ширээний ном болох нь дамжиггүй ээ. Хэрэгтэй номыг хэрэгтэй цагт нь алдаа мадаггүй, чадамгай сайхнаар эх хэлнээ буулгасан орчуулагч Ш.Энхжаргалд уншигчдынхаа өмнөөс гүн талархал илэрхийлье.

Редактор Л. Өлзийтөгс

ЗОХИОГЧИЙН ҮГ

2001 онд би Лос Анжелес Таймс сонины сэтгүүлчээр томилогдоод Хойд ба Өмнөд Солонгосын аль алиных нь тухай бичих үүрэг хүлээн, Сөүлд очсон юм. Тэр үед Америкийн сэтгүүлчид Хойд Солонгост очихын тулд асар их бэрхшээл туулдаг байсан ба миний бие арай гэж очсоныхоо дараа л нийтлэл бичих бараг боломжгүйг ойлгосон билээ. Барууны сэтгүүлчдийг солонгос иргэдтэй зөвшөөрөлгүй ярьж, элдвийг ухаж төнхөхөөс сэргийлэн "хамгаалагч" хэмээх тусгай ажилтныг дагалдуулдаг ба ирсэн зочдод нэлээд бодож боловсруулсны үндсэн дээр шилж сонгосон газруудаар явах хөтөлбөр санал болгоно. Энгийн иргэдтэй холбоо барих, ярилцах ямар ч боломжгүй. Гэрэл зургууд дээр болон зурагтаар, гайхмаар нэгэн жигд нугас мэт алхах цэргийн парад, удирдагчдадаа хүндэтгэл илэрхийлэн нийтээр хийх гимнастик л гарна. Тэр бүх хоосон царайны цаана юу нуугдаж байгаа бол гэж үргэлж бодогддогсон.

Өмнөд Солонгост байхдаа ийшээ болон Хятад руу оргож гарсан Хойд Солонгосын иргэдтэй уулзаж, ярилцлага хийсний үр дүнд Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс гэж албан ёсоор нэрлэгддэг энэ орны бодит амьдралыг тодорхой хэмжээгээр танин мэдэх завшаан олдсон билээ. Олж авсан мэдээллээ баримтжуулахын тулд нэг газар оршин сууж асан олон хүнтэй уулзаж ярилцах нь дөхөмтэй хэмээн төлөвлөснөөр Хойд Солонгосын хамгийн хойд захад орших Чонжин хотноо амьдарч байсан хүмүүсийг сонгосон билээ. Энэхүү сонгосон газраа Хойд Солонгосын засгийн газрын сайтар өнгөлөн далдлалт хийж гадаадынханд үзүүлдэг "зохиомол" газар байлгахгүй гэсэн зарчмыг баримтлав. Чонжин бол Хойд Солонгосын гурав дахь том хот бөгөөд 1990-ээд оны өлсгөлөнд хамгийн их нэрвэгдсэн газар билээ. Уг хот гадаадынханд хаалттай. Цаг заваа хайрлахгүй илэн далангүй ярилцах олон хүнтэй тааралдсан нь надад аз дайрсных биз ээ. "Атаархах зүйл үгүй" тэрхүү бодит амьдралыг өгүүлсэн нийтлэлүүдээс минь энэ ном урган гарсан юм.

Энэхүү номыг миний Хойд Солонгосчуудтай хийсэн долоон жилийн ярилцлагын үр дүн гэж хэлэхэд болно. Өнөөг хүртэл Хойд Солонгост амьдарсаар байгаа зарим ярилцагчийнхаа хамаатан садан, ах дүүсийн аюулгүй байдлын үүднээс нэрийг нь нууцалсан болой.

Бүх ярилцлагын туршид надтай хамт заавал нэг хүн байдаг байлаа. Ярилцлагад өгүүлсэн түүх бүрийг аль болохоор баримтжуулах гэж би чадах бүхнээ хийсэн, мөн тухайн үед болж байсан үйл явдлуудтай уялдуулах гэж оролдсон минь талаар болоогүй гэж найдна. Очиж үзээгүй газруудынхаа дүрслэлийг би Хойдоос оргогсдын яриа, гэрэл зураг, видео зэрэгт үндэслэн бичсэн билээ. Хойд Солонгос одоо хүртэл хаалттай хэвээр байгаа учир энд өгүүлсэн бүхнийг чин үнэн гэж батлах нь мунхаг хэрэг болох биз ээ. Нэг л өдөр энэ улс дэлхий дахинд нээлттэй болж, тэнд чухам юу болж байсныг мэдэх боломж ирнэ хэмээн найдаж та бүхэнд номоо толилуулья.

ЭЦЭС ТӨГСГӨЛГҮЙ ХАРАНХУЙД ХӨТЛӨЛЦӨН АЛХДАГ БАЙЛАА

Хэрэв та Алс Дорнодын улс орнуудын сансраас авсан шөнийн зургуудыг үзвэл тэдгээрийн дунд ямар ч гэрэлгүй томоос том хар толбо буйг олж харах болно. Энэ харлан байгаа хэсэг бол Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улсын нутаг дэвсгэр юм.

Тэрхүү нууцлаг хар ангалын хажууд Өмнөд Солонгос, Япон, сүүлийн үед бас Хятад улс хөгжил цэцэглэлтийнхээ ид үед гялалзсаар л. Мөнөөхөн сансраас авсан зурган дээр хэдхэн зуун бээрийн дээхэн гудамж, замын гэрэл, сурталчилгааны самбар, түргэн хоолны газруудын неон гэрлүүд хүмүүс хэрхэн ажлаа хийж, хорин нэгдүгээр зуунд цахилгаан эрчим хүчээр бялхан байгааг илтгэх мэт жижигхэн цагаан цэгүүд харагдана. Гэтэл гол дунд нь бараг Английн нутагтай тэнцэхүйц хэмжээний газар харлан нүүгэлтжээ. Тэнд 23 сая хүнтэй улс орон гялайж гялтайх юу ч үгүйгээр, далай шиг хоосон оргих ажээ. Хойд Солонгосыг зүгээр л хов хоосон гэж хэлж болно.

1990ээд оны эхээр Хойд Солонгост харанхуй нүүрлэжээ. Коммунист дэглэмийн түнш орнууддаа маш хямд үнээр шатахуун өгдөг байсан ЗСБНХУ задран унаснаар эдний мөлхөх шахсан, ямар ч үр ашиггүй, унаж асан эдийн засаг сүйрэлд орсон юм. Цахилгаан станцууд балгас болон хувирлаа. Өлсөж ядарсан хүмүүс цахилгааны утсыг таслан авч, зэс голыг нь идэж уух юухан хээхнээр арилжиж байв. Нар жаргах дөхөөд ирмэгц газар нутаг нь бүхлээрээ сааралтаж, навтгар оромжууд нь харанхуйд уусан харагдах бараагүй болно. Хот суурин, тосгод тэр чигтээ үдшийн бүрийд уусна.

"Үзүүлэнгийн хот" Пхеньяны зарим хэсэгт хүртэл, төв гудамжаар нь шөнө алхахад хоёр талд ямар ч барилга байшин үзэгдэхгүй байх нь бий.

Гаднынхны нүдээр Хойд Солонгосын өнөөгийн байдлыг харвал Африк болон Зүүн Өмнөд Азийн цахилгаан эрчим хүч огт хүрэлгүй, алслагдсан тосгодыг санагдуулна. Уг нь Хойд Солонгос тийм ч хоцрогдсон улс биш. Тэд зөвхөн хөгжингүй орнуудаас таслагдаж, соёлт ертөнцөөс тусгаарлагдсан хүмүүс. Тэнд очвол төв замуудынх нь хажуугаар нэгэн цагт улс орныг бүхэлд нь гэрэлтүүлж байсны ул мөр болон үлдсэн өндөр хүчдэлийн тоногдсон шонгуудыг харж болно.

Хойд Солонгосын дунд эргэм насны иргэн Өмнөд Солонгосын америкжсан үеэлээ бодвол гэрэлтэй, хоолтой байхын сайхныг хамаагүй илүү ойлгоно. Учир нь тэд шөнө оройн цагийг дан харанхуйд өнгөрүүлэх хийгээд өлсөхийн зовлонг биеэрээ мэдэрсэн хүмүүс. 1990-ээд оны эхээр АНУ-аас цөмийн зэвсгийн хөтөлбөрөөсөө татгалзсан тохиолдолд улс орноо цахилгаан эрчим хүчээр хангахад нь туслах санал тавьсан байна. Гэвч Бушийн засаг захиргаа Хойд Солонгосчуудыг амлалтаасаа буцсан хэмээн буруутгаж ид дундаа байсан хэлэлцээрээ цуцлав. Хойд Солонгосчууд гэрэл цахилгаангүй, харанхуйд амьдарч буйгаа АНУ-аас тавьсан хориг арга хэмжээний үр дүн хэмээн одоо ч итгэсэн хэвээр. Тэд шөнө ном сэтгүүл уншиж чадахгүй, зурагт үзэж, радио сонсох боломжгүй. Цахилгаангүй байж соёлын тухай ярьсны ч хэрэггүй хэмээн Хойд

Солонгосын хамгаалалтын ажилтан, нэгэн бахим эр надад харамсангуйгаар хэлж билээ.

Энэ харанхуй байдал зарим тохиолдолд давуу тал авчирч байв. Өсвөр насны, үеийнхээ нэгэнд сэтгэл алдарсан залуус олны дунд найзтайгаа хамт харагдаж болохгүй тохиолдолд тэр шүү дээ. Өвөлдөө 19 цаг болов уу үгүй юу томчууд унтахаар хэвтмэгц, гэрээс гарах боломж бүрдэнэ. Хойд Солонгосыг цахилгаанаар бүрэн хангахтай адил боломжгүй зүйлийн нэгэнд тооцогдох хувийн амьдрал, эрх чөлөө тэдгээр залуусын хувьд харанхуйтай л хамт ирдэг байжээ. Далдын хар малгай өмссөн мэт бусдад огт харагдахгүй бол эцэг эх, хөршийнхөн, цагдаагийн нууц ажилтнуудын мөрдөлтөөс ер айлгүйгээр хүссэн зүйлээ хийх боломжтой болно.

Харанхуйд дасаж, дуртай болсон тухайгаа өгүүлэх Өмнөд Солонгосын олон иргэний яриаг сонссон боловч тэр дундаас хамгийн их сэтгэл хөдөлгөсөн нь өсвөр насны охин хүү хоёрын гэрэлгүйн дундах хайр дурлалын түүх юм. Хөрш тосгонд нь амьдардаг, өөрөөс нь гурван насаар ах тэр нэгэн хүү өөрийг нь анх олж харахад охин арван хоёр настай байжээ. Охины гэр бүл Хойд Солонгосын учрыг нь олоход бэрх нийгмийн давхаргын тогтолцооны доод ангилалд хамаарна. Олны дунд хамт харагдвал хүүгийн хувьд ирээдүйн ажил амьдралд нь хар толбо сууж, охины хувьд ёс суртахуунтай эмэгтэй гэсэн нэр алдарт нь сэв суух болно. Тиймээс тэдний болзоо харанхуйд хамтдаа удаан алхахаар л хязгаарлагддаг байв. Өөр хийх юм байхгүй юм чинь. Тэдний болзож эхэлсэн 90-ээд оны эхээр цахилгаангүйгээс болоод кино театр, хоолны газар ч гэж үгүй болсон байлаа.

Охин хүү хоёр оройн хоолны дараа уулзана. Эгч нар, эрэгтэй дүү, саваагүй хөршийнхнийхөө байцаалтаас сэргийлэх зорилгоор охин хаалга тогшихгүй байхыг сануулсан байлаа. Охины гэрийнхэн хоорондоо ямар ч зайгүй, шавааралдуулан барьсан урт нарийхан, нийтийн байшинд амьдардаг байсан ба байшингийнхаа ард арав гаруй айлд зориулсан ганц л жорлонтой. Эдгээр байшин дундаж өндөртэй хүний нүдний дээгүүр татахуйц цагаан хашаагаар гудамжнаас тусгаарлагдсан байв. Харуй бүрий болмогц залуу хүү хашаан дотор хэн ч олж харахааргүй нэгэн буланг олж зогсдог байжээ. Хөршүүдийн аяга тавгаа харшилдуулан угаах, хүмүүсийн бие засах газар орох, гарах зэрэг нь түүний орж ирэх хөлийн чимээг дардаг байжээ. Хүү тэндээ хэдэн цагаар ч хамаагүй охины гарч ирэхийг хүлээн зогсоно. Заримдаа хоёр гурван цаг, заримдаа түүнээс ч удаан хүлээх нь бий. Гэвч тэр залхдаггүй байлаа. Хойд Солонгос дахь амьдралын хэмнэл бусадтай харьцуулахад удаан. Хэн ч бугуйн цаг хэрэглэхгүй.

Охин чөлөөтэй болмогцоо л яаран гарч ирнэ. Байшингаас гарч ирэнгүүтээ тас харанхуйд түүнийгээ олж харахгүй боловч ирснийг нь зөнгөөрөө мэдэрдэг байжээ. Харанхуйг далимдуулан охин нүүр амаа будаж янзлахгүй, тэр чигээрээ гарч ирнэ. Заримдаа тэрбээр өвдөгнөөс доогуур урттай цэнхэр банзал, цагаан цамц, улаан бүч бүхий нийлэг, хямд материалаар хийсэн дүрэмт хувцсаа өмсчихнө. Гаднах төрхөндөө санаа тавих насандаа охин хараахан хүрээгүй байлаа.

Эхлээд хосууд дуугүйхэн алхаж, яваандаа шивнэлдэж, тосгоноос гарангуутаа сэтгэл нь амарч, жирийн ярианд шилжинэ. Хэн нэгэнд харагдахгүй, баригдахгүй болсноо баттай мэдэх хүртлээ бие биеэсээ зай барин алхацгаана.

Тосгоноос дөнгөж гармагц нь, өтгөн шугуйн дунд орших халуун рашаан руу очдог зам тосно. Уг

халуун рашаан нэгэн цагт үе мөчний үрэвсэл, чихрийн шижинг эмчилдэг 130 хэмийн халуун рашаантай, алдартай газар асан бөгөөд автобус дүүрэн хятад жуулчин ирж эмчлүүлдэг байсан бол одоо ажиллахтай, үгүйтэй болжээ. Рашааны орох хаалга нь чулуугаар хүрээлэгдсэн, усан санг дүрсэлсэн дөрвөлжин хэлбэртэй. Гарсан жимүүдийн хоёр талаар нарс, япон агч мод болон охины хамгийн дуртай, намар болохоор бор шар өнгийн навчаа гөвдөг, дорнын хатагтай нарын хэрэглэдэг дэвүүр адил гингко моддыг эгнүүлэн тарьсан байдаг. Ойр орчны уул даваануудын модыг түлшгүй болсон хүмүүс хулгайгаар тайрч авсаар бараг нүцгэрсэн боловч халуун рашааны эдгээр модод үнэхээр үзэсгэлэнтэй байснаас хүрч чадсангүй юу, ямартай ч огтлолгүй хэвээр нь үлдээсэн байв.

Хэдийгээр тарьсан мод нь хэвээр авч бусад зүйл нь удаан арчлаагүйн улмаас муудаж хуучирчээ. Модыг нь тэгшилж тайраагүйгээс замбараагүй сагсайн ургаж, чулуун сандлууд нь цуурч, байгалийн чулуу дэвсэж янзалсан талбайн чулуунууд алга болсноос хорхой идсэн шүд мэт ёозгүй харагдана. 90-ээд оны дунд үе гэхэд Хойд Солонгосын юм бүхэн хуучирч, муудан ажиллахаа больсон байлаа. Сайхан зүйл байлгүй л яахав. Гэхдээ хуучирч муудсан энэ бүхэн шөнийн харанхуйд их л үзэмжгүй харагдах агаад хогийн ургамлаар хүрээлэгдсэн усан сан сарны гэрэлд бүр ч уйтгартай харагдана.

Хойд Солонгосын шөнийн тэнгэр үнэхээр харууштай. Зүүн хойд Азидаа хамгийн үзэсгэлэнтэйд ч орж магад. Нүүрсний тоосонцор, говь цөлийн элс, нүүрстөрөгчийн исэл зэргээр тивийн бусад улс орнуудын агаарыг бохирдуулж дөнгөдөг байсан газар одоо үйлдвэрүүд нь ажиллахаа больсноос болж хамгийн цэвэр агаартайд тооцогдох нь холгүй болж. Тэнгэрт нь анивалзах оддын гэгээг ямар ч хиймэл гэрэлтүүлэг гүйцэхгүй бизээ.

Залуу хос салхинд шарчигнах гингко моддын чимээнээс өөр дуугүй нам гүм орчинд шөнөжингөө алхана. Тэр хоёр юун тухай ярилцдаг байв? Гэр бүлийнхэн, анги хамт олон, уншсан ном, өөр бусад зүйлсийн талаар дуусашгүй яриа хөврүүлдэг байжээ. Хэдэн жилийн дараа би охиноос амьдралынх нь хамгийн жаргалтай мөчүүдийн талаар асуухад энэ үеэ нэрлэж билээ.

Иймэрхүү зүйлс сансраас авсан зурагт тусгагдахгүй нь ойлгомжтой. Виржиниагийн Лангли дэх Тагнуулын Төв Газрын Штаб, ямар нэг их сургуулийн Зүүн Ази судлалын танхим гээд бүгд л Хойд Солонгосыг зайнаас судалдаг. Тэд энэ харанхуй нүхний дунд, сая сая хүмүүс өлбөрч үхсэн энэ оронд, хайр гээч нандин зүйл байдгийг яахан олж харах билээ?

Намайг анх уулзахад мөнөөх охин 31 настай, нас бие гүйцсэн бүсгүй болсон байлаа. Би түүний нэрийг өөрчлөн, номдоо зориулж Ми Ран хэмээн нэрлэсэн. Тэрээр зургаан жилийн өмнө Өмнөд Солонгост оргон ирсэн байв. Хойд Солонгосоос оргогсдын талаар бичиж буй нийтлэлдээ зориулж ярилцлага өгөөч гэсэн хүсэлтийг би түүнд тавиад байсан юм.

2004 онд би Сөүл дахь Лос Анжелес Таймс сонины төлөөлөгчийн газрын даргаар томилогдон очлоо. Миний үүрэг бол Солонгосын хойгийг бүхлээр нь хамруулан мэдээлэх явдал. Эдийн засгийн хувьд дэлхийд арван гуравт бичигддэг, зарим талаараа түрэмгий мэт санагдах ч цэцэглэн хөгжиж буй ардчилсан нийгэмтэй, Ази тивдээ л хурц дайчин сэтгүүлчидтэй Өмнөд Солонгосын хувьд надад ямар ч асуудал гардаггүй байв. Төрийн түшээд нь сэтгүүлчдэд гар утасныхаа дугаарыг өгч, ажлын бус цагаар залгахад нь татгалздаггүй юм билээ. Гэтэл Хойд Солонгост

байдал яг эсрэгээрээ. Тэнд гадаад ертөнцтэй харилцах харилцааг "Империалист Янки Зулбасганууд"-ын талаарх сүр дуулиантай, бас хуурмаг суртал нэвтрүүлэг явуулдгаараа алдаршсан Агуу Их Худалч хэмээх хочтой Мэдээллийн Төв Агентлаг өөрсдийн үзэл сурталд нийцүүлэн барьдаг байна. 1950-1953 оны Солонгосын дайн, Хүйтэн дайны эхэн буюу ид хурцадмал үед америкчууд Өмнөд Солонгосыг хамгаалан дайтаж байсан ба одоо хүртэл тус улсад Америкийн дөчин мянган цэрэг үүрэг гүйцэтгэж буй. Гэтэл Хойд Солонгосын хувьд дайн дуусаагүй үргэлжилж байгаа аятай Америкчуудад дайсагнах үзэл улам газар авсаар байлаа.

АНУ-ын иргэдийг Хойд Солонгос руу маш ховор тохиолдолд нэвтрүүлнэ. Ялангуяа сэтгүүлчдэд ийм боломж олдох нь тун ховор. 2005 онд Пхеньян руу зорчих виз авах боломж надад болон хамт ажилладаг нэгэнд маань олдож, бид удалгүй Ким Чен Ир, түүний нас барсан эцэг Ким Ир Сений агуу удирдлагын дор "цэцэглэн хөгжиж" буй хот дундуур алхаж явлаа. Биднийг хаана ч явсан хар хослол өмссөн туранхайвтар хоёр эр дагаж явсан ба хэн хэн нь өөрсдийгөө ноён Парк хэмээн танилцуулсан. (Хойд Солонгост гаднын иргэдийг дагалдуулах хоёр хамгаалагчийг томилдог нь аль нэг нь гадныхны хахуульд өртөхөөс урьдчилан сэргийлж бие биеэ ажиглах явдал юм). Хамгаалагчид маань албан ёсны мэдээллийн үйлчилгээний талаарх улиг болсон хоосон гоёмсог зүйлсийг өдөр бүр ярих бөгөөд яриандаа "Манай агуу их удирдагч Ким Чен Ир-ийн ачаар" гэсэн үгс ёс юм шиг хавчуулна. Тэд бидэнтэй ярилцахдаа харц тулахаас зайлсхийдэг учир хэлж буй зүйлдээ өөрсдөө итгэдэг бол уу гэж бодол төрүүлнэ. Тэд юу боддог байсан бол? Тэд үнэхээр ярьж хэлж байгаа шигээ удирдагчдаа чин зүрхнээсээ хайртай болов уу? Тэдэнд идэх хоол хангалттай байсан болов уу? Дэлхийн хамгийн ширүүн залхаан цээрлүүлэх дэглэм бүхий нийгэмд амьдрах ямар байдаг бол?

Хойд Солонгост байхдаа дээрх асуултууддаа хариулт авч чадаагүй маань ойлгомжтой. Тиймээс миний асуултад хариулах хүмүүс нь Өмнөд рүү оргогсод болсон юм.

2004 он гэхэд Ми Ран Сөүлээс 20 милийн зайд, өмнө зүгт орших хурц тод гэрэлтэй, эмх замбараагүй гэгдэх Сувон хотод амьдарч байлаа. Уг хотод Самсунг Электроникс байрлах ба Хойд Солонгосчуудын амьдралдаа огт хараагүй ч байж мэдэх компьютерийн дэлгэц, CD/DVD ром, дижитал телевизүүд, флаш диск зэргийг үйлдвэрлэдэг томоохон компаниудын салбарууд байрладаг учраас харьцангуй үйлдвэржсэн бүсэд тооцогддог юм байна (зарим статистикийн мэдээнд хоёр Солонгосын хоорондох эдийн засгийн зөрүү нь 1990 онд хоёр Герман нэгдэх үеийн Баруун, Зүүн Герман хоёрынхоос даруй дөрөв дахин илүү хэмээн дурджээ).

Уг хот чимээ ихтэй, зохицсон зохицоогүй олон өнгөнөөс бүрдсэн газар байлаа. Өмнөд Солонгосын бусад хотын адил олон өнгийн хаяг самбараар гоёсон нэгэн хэв загварын бетон хийцийн байшингуудаас хотын ерөнхий архитектур нь бүрдэнэ. Алдарт Данкин Донат, Пицца хат болон бусад барууны дуураймал үйлчилгээний газрууд хотын төвөөс алслагдсан дүүрэгт сүндэрлэн харагдана.

Эрос мотел, Хайрын буудал гэх мэт нэртэй, цагаар өрөө түрээслүүлдэг олон дэн буудал нууцаар оршино. Энэ хотод замын түгжээ үүсэх нь жирийн үзэгдэл бөгөөд эдийн засаг өсөн дэвжиж байгаагийн том илрэл болсон хэдэн мянган Хьюндай машин зорьсон газраа хүрэхээр бөглөрөн зогсох ажээ. Хотын зам их түгжрэлтэйг олж мэдсэн учраас би галт тэргээр явахаар

шийдэв. Тэгээд Сөүлээс галт тэргээр гуч орчим хором яваад, таксинд сууж болзсон газраа ирлээ. Бидний уулзах газар нь 18-р зууны үеийн цайзын эсрэг талд орших хотын хамгийн нам гүм газрын нэг болох үхрийн шарсан хавиргаар төрөлжсөн зоогийн газар байсан юм.

Эхлээд би Ми Раныг ялган таньж чадсангүй. Миний өмнө нь уулзаж байсан Хойд Солонгосчуудтай тэр үнэхээр адилгүй байлаа. Тэр үед Хойд Солонгосын иргэн асан нийт 6000 шахам хүн Өмнөд Солонгост амьдарч байсныг зүс төрх, биеэ авч яваа байдлаар нь танихад хэцүү биш байв. Тэд хэт богино банзал өмсөх, шинэ хувцасныхаа шошгыг авалгүй явах зэргээр Өмнөд Солонгосын амьдралд дасахад хэцүү байгаагаа шууд харуулдаг учир танихад хэцүүгүй бол Ми Ран харин ч Өмнөд Солонгос эмэгтэйгээс ялгарах зүйлгүй шахам харагдав. Тэрбээр гоёмсог хүрэн цамцны хослол, ижил өнгийн өмдөөр гангарсан байлаа. Түүнийг хараад надад намбалаг бүсгүй юм гэсэн бодол төрсөн. Үсээ мөлчийтөл нь самнаж хиймэл доржпалам шигтгээ бүхий хавчаараар ардаа тогтоосон байв. Өө сэвгүй байдлыг нь эрүүн дээр нь гарсан батганууд болон бэлхүүсэн хэсгээрээ мяраалсан нь л яльгүй бүдгэрүүлж. Гурван сартай жирэмсэн аж. Жилийн өмнө Ми Ран цэргийн газар энгийн албан тушаалд ажилладаг нэгэн залуутай танилцаж гэрлэсэн, удахгүй үрийн зулай үнэрлэхээр тэсэн ядан хүлээж байгаа юмсанж.

Би Хойд Солонгосын боловсролын тогтолцооны талаар мэдэж авахын тулд Ми Раныг үдийн хоолонд урьж тухлахаар болсон юм. Өмнөд рүү оргон ирэхийнхээ өмнө тэрбээр нэгэн уул уурхайн хотод цэцэрлэгийн багшаар ажиллаж байжээ. Харин Өмнөд Солонгост ирээд боловсрол судлалаар Магистрын зэрэг хамгаалахаар хичээллэж байгаа аж. Бид маш чухал, заримдаа бүрдэндүү гунигтай зүйлсийн талаар ярилцав. Ми Ран захиалсан хоолоо идсэнгүй. Учрыг нь асуутал цэцэрлэгийнх нь тав, зургаан настай хүүхдүүд өлсгөлөнгөөс болоод үхэж байсан тухай бодол санаанд нь орж ирээд хоол хоолойгоор нь давсангүй гэнэ. Бяцхан шавь нар нь үхэж байхад Хойд Солонгосын иргэн болж төрсөн чинь бурхны хишиг хэмээн ухуулах хэрэгтэй болдог байжээ. Дэлхийн хоёрдугаар дайнаас эхлээд 1994 онд нас нөгчих хүртлээ Ким Ир Сэн Хойд Солонгосыг дарангуйлж, бурхан адил тахин шүтэгдсэн бол түүний хэмжээлшгүй эрхийг залгамжлагч хүү нь болох Ким Чен Ир бурханы хүү Есүс Христийн хэмжээнд шүтэгддэг юм. Ми Ран Хойд Солонгосын төр засаг иргэдийнхээ тархийг угаадаг тогтолцоог ойлгоод тууштай шүүмжлэгч нэгэн болсон ажээ.

Цаг хиртэй ярилцаж суусны эцэст бид илүү дотно, ний нуугүй тал руугаа хандсан яриа руу орлоо. Ми Раны биеэ эзэмдэх чадвар, илэн далангуй шулуухан байдал нь намайг түүнээс хувийн чанартай асуултууд асуухад түлхэц болсон юм. Хойд Солонгосчууд чөлөөт цагаа хэрхэн өнгөрүүлдэг, тэнд амьдралд нь аз жаргалтай мөчүүд байсан эсэх, мөн найз залуутай байсан эсэх талаар нь би лавлалаа. Тэрбээр "Үүнийг асууж байгаа чинь сонин санагдаж байна. Саяхан би түүнийгээ зүүдэлсэн" гэв.

Ми Ран хүүг өндөр, чацархаг биетэй, духан дээр нь үргэлж халиурч байдаг өтгөн үстэй хэмээн дүрслэв. Нутгаасаа гарснаас хойш хүүтэй маш төстэй Ю Жун Сан хэмээх залуу жүжигчин байдгийг олж мэдэхэд сэтгэл нь нэн таатай байсныг дурсан ярив. (Үүнийг сонсоод би Ми Раны найз залууг Жун Сан гэж нэрлэхээр шийдэв). Залуу хүү ухаантай сэргэлэн, Пхеньяны шилдэг сургуулиудын нэгэнд сурч, ирээдүйн эрдэмтэн болохоор бэлтгэгдэж байсан гэнэ. Тэд олны өмнө

хамтдаа явж болдоггүйн нэгэн учир үүнд оршиж байж.

Хойд Солонгост хосуудын буудал хэмээх ойлголт ч байхгүй. Гэр бүлээс гадуур, тохиолдлын чанартай бэлгийн харьцааг хүлээн зөвшөөрдөггүйг би мэднэ. Гэвч тэдний харилцаа хэр хол явсан тухай мэдэхээр оролдлоо.

Ми Ран инээгээд ийнхүү ярив. Бид гараа барилцдаг болтлоо гурван жил, тэр намайг үнсдэг болтол ахиад зургаан жил үерхсэн. Түүнээс өөр зүйл байдаг ч гэж төсөөлдөггүйсэн. Би Хойд Солонгосоос гарахдаа 26 хүрсэн, сургуулийн багш хийдэг мөртлөө хүүхэд хэрхэн олддог талаар ойлголт ч үгүй байсан.

Ми Ран анхны хайрынхаа тухай үе үе дурсаж, цээжинд нь тэсвэрлэшгүй гуниг төрдөг байснаа нуусангүй. Жун Сан түүний хамгийн сайн анд, мөрөөдөл болоод гэр бүлийнх нь нууцыг хуваалцдаг нэгэн байжээ. Гэвч Ми Ран амьдралынхаа хамгийн том нууцыг түүнд илчилсэнгүй. Тэр Хойд Солонгосыг үзэн яддагаа, өөрт нь таалагддаггүй, өөрөө итгэдэггүй зүйлээ сурагчдадаа ухуулаад зогсож ахуйдаа ямархуу сэтгэгдэл төрдгөө хэзээ ч түүнд ярьж байсангүй. Түүгээр ч барахгүй гэрийнхнийгээ Хойд Солонгосоос зугтахаар төлөвлөгөө боловсруулж байгааг ч цухуйлгасангүй. Жун Санд итгээгүйдээ биш, зүгээр л болгоомж алдан хэн нэгэнд яриад, тэр нь цааш дамжуулах зэргээр аюулд учруулахаас сэрэмжилсэн хэрэг. Тагнуулууд хаа сайгүй л байдаг. Хөршүүд хөршүүдээ илчилж, найзууд найзуудыгаа барьж өгнө. Хайртай хосууд ч бие биеэ барьж өгнө. Цагдаагийн нууц ажилтнууд төлөвлөгөөнийх нь талаар үнэртэх л юм бол гэрийнхэн нь бүгдээрээ ууланд байдаг хөдөлмөрийн лагерь руу цөлөгдөхөөр байжээ.

Би тэгж азаа сорьж зүрхлэхгүй байсан. Би түүнтэй салах ёс ч хийж чадаагүй.

Энэ уулзалтын дараа Ми Ран бид хоёр Жун Саны талаар байнга дурсан ярьдаг болов. Гэр бүлийнхээ амьдралд сэтгэл хангалуун, аз жаргалтай ээж болсон тэрбээр Жун Саны нэр гарч ирэх бүрийд нүүр нь час улайн доошоо харж, ээрч муурдгаа больсонгүй. Түүний талаар ярих Ми Ранд таатай байдгийн учир нь надаас өөр энэ нандин нууцыг нь хуваалцах хүн байхгүйгээс тэр биз.

Жун Санд юу тохиолдсон талаар би сонирхлоо. Тэр мөрөө хавчив. Солонгосын дайн дуусаад тавин жил өнгөрсний дараа, мэдээллийн эрин зуунд хоёр Солонгос хоорондоо харилцах мэдээллийн хэрэгсэлгүй шахам байна. Ийм байхад Баруун Зүүн Германы болон өөр ямар ч газрын тухай ярих нь илүүц биз ээ. Өмнөд, Хойд Солонгосын хооронд утсан харилцаа, шуудан, электрон шуудан аль нь ч байхгүй.

Иймээс Ми Ран хариултыг нь өгч чадахгүй олон асуултыг өөрөөсөө асуусаар л байлаа. Тэр минь өдийд гэрлэсэн болов уу? Миний талаар дурсдаг болов уу? Өөртэй нь салах ёс ч хийлгүй зугтан одсонд буруутгадаг болов уу, Жун Сан өөрийг нь эх орноосоо урвасан этгээд хэмээн үздэг болов уу гэх мэт. "Яагаад ч юм тэр намайг ойлгох юм шиг санагддаг. Гэхдээ яг үнэн хэрэгтээ юу бодож явааг нь мэдэх ямар ч арга алга" гэж Ми Ран хариулсан юм.

Жун Сан, Ми Ран хоёр өсвөр насандаа танилцжээ. Тэд Солонгосын хойгийн зүүн хойд хэсэгт, Оросын хилээс холгүй орших аж үйлдвэржсэн төвүүдийн нэг болох Чонжин хотын захын

хороололд амьдардаг байжээ. Газрын зураг дээр Хойд Солонгосын газар нутаг Дорно дахины уран зураг адил хар будаг хэрэглэн бийрээр зурсан мэт харагдана. Нутаг дэвсгэр нь гайхалтай үзэсгэлэнтэй. Америк стандартаар бол Баруун Хойд Номхон далай орчмын нутаг дэвсгэртэй зүйрлэхээр сайхан гэж хэлж болох ч өнгөний хувьд төдийлөн олон биш. Гацуур, арц, жодоо моддын хар ногоон, цайвар саарал өнгөтэй уул нуруудын өнгөөр байгалийн өнгөний зохицол хязгаарлагдана. Азийн орнуудын хөдөө нутагт түгээмэл байдаг тутарганы талбайн зүймэл урлаг мэт харагдах ногоон өнгө нь зуны улиралд, бороотой үед хэдхэн сар үзэгдээд алга болно. Жилийн бусад үед бүх зүйл бор, шаргал, гандуу өнгөтэй байна.

Өмнөд Солонгосын шуугиантай, завгүй амьдралаас тэс өмнөө. Замын тэмдэглэгээ гэхээр юм бараг байхгүй, цөөхөн машин давхина. Хүмүүс машин худалдан авах чадалгүй гэхээсээ илүү төр засгаас хориглосон учраас хувьдаа унаатай хүн байхгүй. Трактор ч бараг харагдахгүй, харин анжис чирэн залхуутайгаар алхах үхэр хаа сайгүй. Байшингууд нь энгийн, нэг өнгө, хэв загвартай. Солонгосын дайн дууссанаас хойш өөрчлөгдсөн юм байна уу гэмээр. Байшингуудын ихэнх нь 60, 70 аад оны үед угсармал бетонон блок, шохойн чулуугаар баригдсан ба хашиж буй албан тушаалынх нь эрэмбээр улсаас иргэддээ олгоно. Томоохон хотуудад иргэд нь "тагтааны үүр" хэмээн нэрлэгддэг намхан, ганц өрөө бүхий сууцанд амьдардаг бол хөдөө орон нутгийнхан ихэвчлэн нэг өрөө бүхий, дан, баян хуур хэмээн нэрлэгддэг (алсаас олон жижиг хайрцгийг нийлүүлж наасан буюу баян хуур хөгжимтэй адилхан харагддагаас ийнхүү нэрийдсэн) байшингуудад амьдардаг. Маш ховор тохиолдолд зарим айл хаалга, цонхны хүрээгээ цайвар ногооноор будсан харагдах боловч ихэнхдээ цагаан болон саарал өнгө зонхилно.

Жорж Орвэллийн "1984 он" зохиолд дарангуйлагч дэглэмтэй орнуудад суртал ухуулгын самбар дээр ганцхан өнгө хэрэглэдэг хэмээн шогчлон дүрсэлсэнтэй адил Хойд Солонгост социалист реализмын хэв загвартай зургууд дээр агуу их удирдагч Ким Ир Сенийг өөрсдийн дуртай цоглог өнгөөр дүрсэлдэг. Агуу их удирдагч өгөөмрөөр инээмсэглэн, сайхан хувцасласан, улаан хацартай хүүхдүүдээр хүрээлүүлсэн байна. Царайнаас нь шар, улбар шар туяа цацарчээ. Энэ нь Ким Ир Сен бол ард түмэндээ нар нь гэсэн үг.

Улаан өнгө бол зөвхөн ухуулга сурталчилгааны үсгийн өнгө бөгөөд өөр зориулалтаар ашиглаж үл болно. Солонгос хэл нь зураас, дугуй дүрснээс бүтсэн өвөрмөц үсэгтэй. "Ким Чен Ир урт наслаг. Ким Чен Ир бол 21-р зууны наран. Зөвхөн өөрсдийнхөөрөө амьдарцгаая. Бид намынхаа замналаар явна. Энэ дэлхий дээр бидэнд атаархах зүйл үгүй". Энэ мэтчилэн улаан үсгүүд зэвэргэн саарал нутгийг яаруулсан мэт, ямарваа нэг зүйлд уриалан дуудсан мэт тариалангийн талбай, уулын энгэрээр зурайж, гол замуудын хажуугаар машины хурд заах тэмдгүүд мэт онцгойрч, төмөр замын өртөөний дээгүүр болон бусад олон нийтийн газраар жирийн харагдана.

Эдгээр ухуулга сурталчилгаанд итгэхгүй байх шалтгаан өсвөр насанд хүртэл нь Ми Ранд байсангүй. Эцэг нь жирийн нэгэн уурхайчин, орон гэр нь бусдын л адил ядуувтар. Бүх сонин хэвлэл, кино, хэвлэл мэдээлэл хаалттай болохоор үүнээс илүү сайхан амьдрал бий гэж зүүдэлдэг ч үгүй байжээ. Тэр радио телевизээр маш олон удаа Өмнөд Солонгосчууд Америкийн утсан

хүүхэлдэй болохыг, Парк Чун Хи мөн түүний залгамжлагч Чун Ду Хван зэрэг этгээдүүдийн удирдлага доор зовж байдаг талаар сонссон аж. Хятадуудын бүтээн байгуулж буй коммунизм нь Хойд Солонгост Ким Ир Сений буй болгосон хувилбараас хамаагүй дор учраас ард түмэн нь үргэлж өлсдөг гэсэн мэдээлэл авч итгэсэн байв. Энэ бүхний дүнд Ми Ран Хойд Солонгост төрж, халамжит удирдагчийнхаа ивээлд амьдарч буйгаа азтайд тооцох болсон байлаа.

Ми Раны амьдардаг тосгон 70, 80-аад оны үед тийм ч муу амьдралтайд тооцогдохооргүй байжээ. Ойролцоогоор мянган хүн амьдардаг, бусдаас ялгарахааргүй уг тосгоны гол онцлог нь газарзүйн байрлал байв. Тосгоноос нь зургаахан километрийн зайд Япон тэнгис орших учраас тосгоны иргэд үе үе шинэ загас, хавч идчихдэг байж. Тосгон Чонжин хотын доохно байрладаг болохоор хотын ойролцоо орших тосгоны давуу талуудыг эдэлж, мөн ногоо тарих талбай ч хангалттай байсан аж. Талбай харьцангуй тэгш байсан нь тариалах талбай ховор улсад томоохон завшаан тохиолдож буй хэрэг юм. Ким Ир Сен тосгоны ойролцоо орших халуун рашаан дээр өөрийнхөө олон сувиллын газрын нэгийг байгуулсан байв.

Ми Ран айлын дөрвөн охины отгон нь. 1973 онд түүнийг төрөхөд 19-р зуунд Англид таван охинтой байх ямар хэцүү хувь тавилан болохыг Жейн Остин "Бардамнал ба төсөөлөл" дөө бичсэн байдаг даа, эгээ л түүн шиг Өмнөд Солонгост ч гэсэн хэцүүхэн даваануудын нэг байв. Өмнөд, Хойд Солонгост ялгаагүй Күнзийн ёсны дагуу хөвгүүд гал голомтоо залгамжилж, эцэг эхээ асран хамгаалах үүрэг хүлээнэ. Ми Раны эцэг эх нь түүнийг төрснөөс гурван жилийн дараа хүүтэй болж, Ми Ран хэдийгээр отгон нь боловч хамгийн шоовдор хүүхэд болон өсчээ.

Тэднийх баян хуур хэлбэрт дан байшингийн нэг умгархан өрөөнд шахцалдан амьдардаг байсан нь Ми Раны аавын нийгмийн гаралд тохируулж улсаас өгсөн оромж. Байшинд оронгуут шууд гал тогоо байх ба энд зуухандаа нүүрс хийж, гэрээ ч дулаацуулж, хоолоо ч хийнэ. Гэрээ дулаацуулахын тулд шалан доорх ондол хэмээх системийг ашиглана. Гүйдэг хаалгаар гал тогооноос тусгаарлагдсан өрөөнд гэрийнхэн нь гудас дэвсэн унтаж өглөө босоод гудсаа хураана. Бага хүү төрснөөр ам бүлийн тоо нэмэгдэж найм болсон нь таван хүүхэд, эцэг, эх болон эмээ нь юм. Иймээс Ми Раны аав аравтын даргаа хахуульдан байж хажуугийн байшингаа өөрийнхтэйгээ нийлүүлэх эрх олж авснаар байдал арай дээрджээ.

Овоо уужим зайтай газар хүйсээр ялгаварлах явдал илүү тод харагдана. Хоолны үеэр эмэгтэйчүүд гал тогооны ойролцоох намхан ширээнээ цагаан будаанаас хямд бөгөөд тэжээл багатай эрдэнэ шишийн зутан төдийхнөөр хооллодог бол аав хүү хоёр тусгай ширээнээ суугаад цагаан будаа иддэг байв.

Ми Раны дүү Сок Жу хожим нь "амьдрал ийм л байдаг гэж би боддог байсан" хэмээн ярьсан билээ.

Эгч нар нь мэдсэн ч мэдээгүй дүр үзүүлдэг бол Ми Ран л ганцаараа энэ шударга бус байдлыг тэвчиж үл чадан, гомдсондоо мэлмэрүүлж орхидог байжээ.

"Яагаад Сок Жу ганцаараа шинэ гутал өмсөх ёстой юм. Яагаад ээж Сок Жуг л бөөцийлөөд

намайг тоодоггүй юм бэ" хэмээн гомдоллоход тэд хариуд нь юу ч хэлдэггүй байлаа.

Ми Ран залуу охидыг ялгаварлан гадуурхдаг, бусдаас доогуур үздэг тохиолдлуудыг ийнхүү эсэргүүцэж байсан нь олонтаа. Тэр үед Хойд Солонгост охид дугуй унах явдал зүй буст тооцогддог байж. Үүнийг шившигтэй, байж болшгүй зүйлд тооцогддогийн учир нь гуя хасаа ил гаргаж бусдыг буруу зүйлд өдөөн турхирна гэж үздэгтэй холбоотой байжээ. Иймээс ч Хөдөлмөрийн Намаас охид дугуй унах нь хууль бус гэсэн утгатай сануулгыг үе үе гаргана. Ми Ран энэ журмыг тоодог ч үгүй байв. Арван нэгэн настайгаасаа эхлээд гэрийнхээ цорын ганц хуучин япон дугуйг Чонжин орох зам дагуу унана. Өөрийн амьдардаг жижиг тосгоныхоо хавчлагаас зугтаж хаашаа ч хамаагүй явчихмаар санагддаг байв. Гурван цаг орчим уул даваа өгсөж явахын зөвхөн хагас нь хатуу хучилттай. Зөрж өнгөрөх эрчүүд түүнийг элдвээр харааж доромжилно.Зарим нь бүр "Чи бэлэг эрхтнээ урна даа" хэмээн хашгирна.

Заримдаа өсвөр насны хөвгүүд бүлэглэн, замыг нь отоож байгаад дугуйнаас нь унагахаарч оролдоно. Ми Ран тэдний өөдөөс адилхан бүдүүлэг аашилж, харааж загнах зэргээр үзэлцэнэ. Аажимдаа энэ бүхнийг тоохоо больж, сонсоогүй юм шигээр дугуйгаа жийн, замаа хөөх болсон байна.

Тосгонд нь Ми Раных баясагдаг цорын ганц зүйл байсан нь кино театр байв. Ким Чен Ир киног ард түмнийг номхон хүлцэнгүй, үнэнч байлгах чухал хэрэгсэл гэж үздэг байсны ачаар Хойд Солонгосын бараг хот болгон кино театртэй болжээ. 1971 онд 30 настай байхдаа Ким Чен Ир Хөдөлмөрийн Намын Ухуулга Сурталчилгааны Товчооны даргаар томилогдож, ажлын гараагаа эхэлсэн бөгөөд уг Товчоо тус улсын киноны студиудын үйл ажиллагааг хариуцдаг байсан аж. Ингээд 1973 онд тэрбээр "Кино урлагийн тухайд" хэмээх номоо хэвлүүлсний дотор хувьсгалт соёл урлаг, утга зохиол нь хувьсгалын зорилтуудыг биелүүлэхэд ард түмнийг уриалан дуудах маш чухал хэрэгсэл хэмээх өөрийн онолоо дэвшүүлсэн байдаг.

Ким Чен Ирийн удирдлага дор Солонгосын Уран Сайхны Киноны Студи нь Пхеньяны захад төвхнөж, яваандаа гурван сая гаруй хавтгай дөрвөлжин газрыг хамарсан асар том байгууламжтай болж, жилдээ 40 орчим кино үйлдвэрлэж эхэлжээ. Кинонууд ихэвчлэн нэг сэдэвтэй. "Аз жаргалд хүрэх түлхүүр бол хувь хүн хамт олныхоо төлөө амь биеэ хайрлахгүй зүтгэх явдал. Капиталист нийгэм бол сүйрэл." 2005 онд би уг Студид зочлохдоо дэлгүүрийн нүүрэн хэсэг болон стриптиз баарнууд эгнүүлэн барьсан Сөүлийн гудамжуудыг дуурайлган хийсэн байхыг харсан юм. Кинонууд цэвэр үзэл суртлын шинж чанартай хэдий ч Ми

Ран үзэх дуртай байв. Хойд Солонгосын жижиг тосгонд өсөж буй хүүхэд кинонд хэрхэн дурлаж болох вэ тэр л хэмжээнд сонирхон үздэг байв. Ганцаараа кинонд явж болох насанд хүрмэгцээ Ми Ран ээжээсээ тасалбар худалдан авах мөнгө гуйдаг болов. Тасалбар тийм ч үнэтэй биш, хагас вон заримдаа хэдхэн задгай мөнгөөр худалдагдана. Ми Ран үзэж чадах бүхнийг л үзнэ. Зарим кино хүүхэд үзэхэд "хэтэрхий эрсдэлтэй" байв. Жишээ нь: 1985 оны "Миний хайрт" хэмээх кинонд үнсэлдэж буй мэт хэсэг гарна. Гэтэл яг үнэн хэрэгтээ үнсэлдэх үедээ эмэгтэй нь шүхрээрээ хоёр биенээ халхалчихдаг учраас үзэгчид тэдний уруул бодитоор нийлэхийг олж харахгүй. Гэвч энэ нь арван долоогоос доош насны хүүхдэд хориотой гэх ангилалд багтах хангалттай шалтаг аж. Холливудын кино Хойд Солонгост хориотой гэдэг нь ойлгомжтой. Ганц Холливудынх ч биш, үндсэндээ Оросын цөөхөн киноноос бусад бүх гадаадын кино хориотой байв. Ми Ран орос кино

үзэх маш дуртай байжээ. Учир нь орос кино дотоодын киног бодвол үзэл суртал багатай, бас илүү романтик санагддаг байж.

Мөрөөдөмтгий охин кинон дээр гардаг хайр дурлалыг үзээд өөрийгөө оронд нь тавьж боддог ч байсан юм бил үү.

Ми Ран, Жун Сан хоёрыг 1986 онд анх танилцах үед цахилгаан тасраагүй асан учраас кино үзэх бололцоотой байв. Соёлын төв нь 1930-аад оны хэв маягаар, Хойд Солонгос Японы түрэмгийлэлд байсан үед баригдсан, хотдоо л хамгийн сайханд тооцогдох сүртэй том барилга. Хоёр давхар хэрийн өндөр лоожтой уг театрын нүүрэн талыг тэр чигтээ Ким Ир Сений зургаар чимсэн байна. Журамд заасны дагуу агуу их удирдагчийн зураг тухайн байшингийнхаа хэмжээтэй адилхан байх ёстой. Соёлын төв нь кино театрын үүргийг давхар гүйцэтгэж зарим тохиолдолд хурлын танхим ч болно. Олон нийтийн баяр, жишээлбэл Ким Ир Сений төрсөн өдрөөр агуу их удирдагчийн сургаалыг хамгийн сайн дагасан иргэнийг шалгаруулах тэмцээн энэ танхимд болно. Бусад үед нь бол Пхеньянаас хэдэн долоо хоноод л шинээр ирдэг кинонуудыг үзүүлнэ.

Жун Сан Ми Рантай адил киноны төлөө ухаанаа тавьдаг нэгэн байжээ. Шинэ кино ирлээ л гэж сонсвол тэр хамгийн түрүүнд гүйж очно. Тэр нэг удаа үзэхээр очсон кино нь "Шинэ Засгийн Газар мэндлэв" хэмээх тусгайлан бэлтгэсэн зүйл байж. Уг киноны үйл явдал дэлхийн 2-р дайны үед Манжуурт Ким Ир Сенээр удирдуулсан Хойд Солонгосын коммунистууд Японы империалистуудын колоничлолын эсрэг хэрхэн цогтой тэмцэж буйг харуулна. Японы империалистуудын эсрэг тэмцэл нь дээхэн үеийн Холливуд дахь ковбой, индианчуудын адил Хойд Солонгост түгээмэл сэдэв байв. Уг кинонд алдартай жүжигчин эмэгтэй тоглосон учраас маш олон үзэгч ирэх ёстой байжээ.

Жун Сан театрт нэлээд эрт ирлээ. Тэр өөртөө болон ахдаа хоёр тасалбар аваад байв. Үзэх цагаа хүлээн гадуур сэлгүүцэж байхдаа Ми Раныг анх олж харжээ.

Ми Ран театрт орохоор дараалсан олны ард алхаж байв. Хойд Солонгост киноны үзэгчид залуу бөгөөд танхай. Энэ удаагийн үзэгчид бүр балмад гэмээр араншин гаргаж байв. Том хүүхдүүд жижгийнхээ урдуур дайран, дарааллын урд гарч, багачуудаа хойш нь шахна. Жун Сан охиныг сайн харахын тулд урагшаа давшив. Охин бачимдсандаа доороо дэвсэн уйлах нь уу гэмээр харагдана.

Хойд Солонгосын стандартаар царайлаг охин бол цайвар тусмаа илүү сайн, дугариг царай, нум хэлбэрийн амтай байх ёстой. Гэтэл охин дээрх шинж чанарыг агуулаагүйгээр барахгүй огт өөр байлаа. Тэрээр гонзгойвдор царай, монхор хамар, өргөн шанаатай охин байв. Жун Саны хувьд Ми Ран бараг гадны хүн шиг, бүр ширүүн ч гэмээр төрхтэй харагдлаа. Охин театр руу орохоор хөлсөө урсган ноцолдож буй олныг ууртайгаар харж байв. Тэр даруу, ичимхий, инээхдээ гараараа амаа тагладаг бусад охидтой огт адилгүй харагдаж байв. Жун Сан түүнээс Хойд Солонгосын хүнд хэцүү амьдралд нугараагүй зан чанарыг олж хараад өөрийн мэдэлгүй маш ихээр татагджээ.

Жун Сан 15 нас хүрээд охидыг байгалийн жам ёсоор л сонирхон хардаг болсноос биш одоог хүртэл тухайлан нэг охиныг ингэтлээ шохоорхож байсангүй.

Тэр мөрөөдөмтгий өсвөр насны хүүгийн сэтгэхүйгээр Ми Рантай анх нүүр тулан уулзах мөч нь ямар байх талаар дүрслэн бодож үзэв Хожим түүний дурсан ярьснаар төсөөлөлд нь Ми Раны биеэс нууцлаг туяа цацарч байжээ. Энэ жижиг тосгонд ийм охин байдаг гэж ёстой бодсонгүй шүү хэмээн тэр өөртөө шивнэв Жун Сан юу хийхээ шийдэж ядан цугласан хүмүүсийг тойрон хэдэнтээ эргэлдэв. Тэр зодоонч танхай этгээд биш номын хүүхэд байсан учраас бусадтай түлхэлцэн дайрч буцаад театр руу орохоор тэмүүлсэнгүй. Гэтэл нэг мэргэн санаа орж ирлээ. Кино эхлэх дөхсөн ч ах нь ирсэнгүй. Иймээс тэр тасалбараа охинд зарчихвал зэрэгцээд суух боломжтой болно. Учир нь тасалбар дээр суудал заагдсан байгаа. Тэр охинд юу гэж хэлэхээ бодон цугласан хүмүүсийг ахиад нэг тойров.

Эцэст нь танихгүй охинтой тулж ярих зүрх хүрсэнгүй, дөхөн очиж тасалбар авахыг санал болгож чадсангүй. Тэгээд театрт орлоо. Манжуурын цасан цагаан тал дундуур үсээ халимаг болгон тайруулсан зоригт эмэгтэй морь унан давхих дүрс дэлгэц дүүрэн гарч байхад Жун Сан олдсон боломжоо алдсандаа сэтгэл дундуурхан бодлогошрон сууна. Зоригт эмэгтэй Манжуурын тал дундуур хувьсгалын уриаг уухайлан давхисаар. Жун Саны бодлоос харин театрын гадаа үлдсэн охин салсангүй. Кино дуусмагц яаран гүйсээр гарвал тэр аль хэдийн явчихсан байв.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

БОХИРДСОН ЦУС

Арван таван нас хүрэхдээ Жун Сан өндөр нарийхан биетэй, хичээл зүтгэлтэй хүү болсон байв. Хүүхэд байхаасаа л математик болон бусад шинжлэх ухааны хичээлүүдэд онц дүн авдаг, тэргүүний сурагч байлаа. Эцэг нь байнга сэтгэл дундуур явдаг сэхээтэн, хүүхдүүдээ, ялангуяа авьяастай том хүүгээ хөдөөнөөс хот руу шилжүүлэн, сургууль соёлын мөр хөөлгөж, ирээдүйд том хүн болгоно хэмээн мөрөөддөг нэгэн. Хүүгээ дунд сургуулиа амжилттай төгсөөд Пхеньяны сайн гэсэн их сургуульд элсэж суралцаасай гэж хүснэ. Хэрэв Жун Сан гэртээ есөн цагаас хойш ирэх юм уу, даалгавраа хийхгүй, хичээлээсээ хоцрох аваас аав нь хүүхдүүдээ гэсгээн цээрлүүлэх зорилгоор тусгайлан бэлдсэн саваагаа гарган ирж, хайр найргүй ороолгоно. Хүү нь дунд сургуулиа хамгийн сайн дүнтэй төгсөж Чонжины хоёр долоо хоног үргэлжлэх хүнд шалгалтыг давчихвал Ким Ир Сений нэрэмжит Их сургууль ч юм уу, өөр ямар нэг их сургуульд элсэх ёстой. Жун Сан хэдийгээр ахлах сургуулийн эхний жилдээ яваа ч гэсэн ажил амьдралынх нь зам тодорхой болсон учир охид шохоорхон хөөцөлдөж явах зав тэртэй тэргүй байдаггүй байж.

Яг ид хичээл хийж байх, хамгийн тохиромжгүй үед Ми Раны тухай бодол Жун Саны толгойд эргэлдээд байлаа. Богино тайрмал үстэй, газар дэвсэж зогссон охины төрхийг санаанаасаа яаж ч зайлуулах гээд чадсангүй. Түүний нэрийг хэн гэдэг юм бол? Тэр үнэхээр анх харсан шиг нь хөөрхөн охин уу? Эсвэл миний харсан зүйл худлаа юм болов уу? Тэр охин хэн болохыг яаж мэдэх вэ гэхчлэн олон асуултууд ар араасаа хөвөрсөөр байлаа.

Гэтэл түүнийг хэн болохыг олж мэдэх төдийлөн хэцүү биш байв. Ми Ран залуучуудын нүдэнд өртдөг нэгэн аж. Тэгээд ч тайрмал үстэй гэхээр хүмүүс андахгүй байсан бөгөөд хоёрхон найзаасаа асуугаад л хэн болохыг нь мэдэж дөнгөв. Жун Сантай хамт боксын дугуйланд явдаг хүү Ми Раны амьдардаг баян хуур хэлбэрийн байшинд, тэднийхээс хоёр байшингийн цаана амьдардаг болж таарав. Жун Сан түүнтэй охины талаар ярилцаж өөрт хэрэгтэй мэдээлэл олж авсан төдийгүй найздаа охиныг тагнах үүрэг өгчээ.

Тэр хавиар Ми Ран болон эгч нарынх нь талаарх явган яриа үргэлж тарна. Охид бие биеэсээ өрссөн юм шиг царайлаг. Тэд Хойд Солонгост сайханд тооцогддог өндөр нуруутай, бас авьяастай байв. Ууган охин нь дуулдаг байхад дараагийнх нь зураг зурна. Тэд бүгд спортод авьяастай, гар болон сагсан бөмбөгийн төрлөөр бусдыгаа тэргүүлнэ. Гэвч тэдний гэр бүлийн гарал охидыг гутаадаг тухай ойр хавийнхан нь шивэр авир гэлцэнэ.

Асуудлын гол нь үг дуу цөөтэй хатангир эр буюу аавд нь байлаа. Тэрбээр бусадтай л адил уурхайд ажиллана. Хийдэг ажил нь ваарны шавар үйлдвэрлэдэг уурхайн модон тэвшийг засаж янзлах юм. Энэ эрд бусдаас ялгарах гойд юм үгүй ч архи огт хэрэглэдэггүй нь бусдын гайхлыг төрүүлнэ. Уурхайн ажилчид эрдэнэ шишийн нэрмэл их хэмжээгээр хэрэглэж, заримдаа бололцоотой үедээ сожу авч дотроо халаадаг байсан бол Ми Раны аав огт амсахгүй. Тэр согтчихоод өнгөрсөн үеийнхээ тухай элдэв зүйл ярих вий гэхээс ихэд эмээнэ.

Ми Раны аав Тэ Ву 1932 онд хожим нь Хойд Солонгосын дайсан Өмнөд Солонгосын нутаг дэвсгэр болсон нэгэн тосгонд төржээ. Хэр удаан бас хол явснаас үл шалтгаалан солонгосчууд эцгийнхээ талын өвөг дээдсийн өлгий нутгийг унасан газар, угаасан усанд тооцно. Тэ Ву Шар тэнгисийн эрэг дээрх Солонгосын хойгийн нөгөө өнцөгт байрлах Баруун Чунчон аймагт төрсөн аж. Энэ нь цагаан будааны гүн ногоон өнгийн талбайн орон боловч зам нь Чонжиныхтой адил таатай байсангүй. Түүний тосгон жижиг байшингуудтай, шатрын хөлөг шиг дөрвөлжлөн ногоорох цагаан будааны талбайн хажууд орших хуурайвтар газар оршдог байв.

1940-өөд оны үед бүх юмыг, хөвгүүдийн өшиглөж тоглодог бөмбөгийг хүртэл шавар болон сүрлээр л хийдэг байжээ. Цагаан будаа тосгоны оршин тогтнох арга, хүмүүсийн амин сүнс нь байв. Иймээс цагаан будаа ургуулах гэж ургах нарнаас эхлэн нуруугаа бөгтийтөл ажиллана. Тэнд механикжсан ажиллагаа гэж өчүүхэн ч үгүй. Газар хагалах, үр суулгах, будаагаа хураах гээд бүх ажлыг гараар хийнэ. Тосгоны иргэд бүгд тэгшхэн ядуу амьдралтай. Гэвч Тэ Вугийнх л бусдаасаа арай дээр байжээ. Сүрлэн дээвэртэй байшин нь бусдынхаас арай том. Мөн тэднийх 2000 пионг буюу 3200 акр тариалангийн талбайтайн дээр жижиг тээрэм ажиллуулж гэр бүлийнхээ амжиргаанд нэмэрлэнэ. Тосгоны иргэд тэднийд буудай, арвайгаа авчирч тээрэмдүүлдэг байжээ. Ми Раны өвөө нь хоёр эхнэртэй байхыг зөвшөөрөх хэмжээний нийгмийн гаралтай байсан бөгөөд ийм үзэгдэл тухайн үедээ их ховорт тооцогдоно. Хэдийгээр хоёр эхнэрийг хууль бус хүрээнд зөвшөөрөвч хууль ёсоор зөвхөн анхны гэрлэлтийг л хүлээн зөвшөөрнө. Тэ Ву хоёр дахь эхнэрээс нь төрсөн ууган бөгөөд цорын ганц хүү байв. Тэ Вугийн хоёр охин дүү нь түүнийг хаана ч явсан салахгүй. Дүү нар нь байнга дагах нь Тэ Вуд яршигтай байдаг ч охид царайлаг учраас найз нарт нь харин ч таатай байв.

Тэ Ву биеэр томгүй ч зан чанарт нь бусдыг зохион байгуулж, тэргүүлэх чанар давамгайл. Хөвгүүд байлдаж тоглож байхад Тэ Ву л генерал болно. Найзууд нь түүнийг бяцхан Наполеон хэмээн дуудна. Тэ Вугийн найз, одоо хүртэл тэр тосгондоо амьдарч байгаа Ли Жонг Хун дурсан ярихдаа "Тэр шулуухан бас шийдэмгий зантай. Хэлэх гэснээ хэлж чаддаг, хүмүүс ч түүнийг сонсдог. Тэр ухаантай хүүхэд байсан" гэсэн юм.

Бусад тариачдын хүүхдийн адилаар Тэ Ву 15 нас хүртлээ бага, дунд сургуульд сурчээ. Хичээлийг япон хэлээр заана. Япон 1910 онд сүүлчийн хааныг нь түлхэн унагааж, эрхшээлдээ оруулсан бөгөөд түүнээс хойш Солонгосын соёл, уламжлалтай холбоотой бүхнийг гишгэчин, өөрийнхийгөө тулгаж байжээ. Эзлэн авсан эхний жилүүддээ япончууд ахимаг эрчүүдэд урт үсээ тайрахыг тушааж, оронд нь хар малгай өмсөхийг зарлигдсан байна. Хүмүүст мөн япон нэртэй болохыг тулгана. Мөн их хэмжээний татвараар дарамталж, нийт хураасан ургацынх нь 50-иас багагүй хувийг Номхон далайд байлдаж буй цэргийн хүчээ тэтгэж байгаа нэрийдлээр хураан авдаг байжээ. Залуу эрс, хүүхнүүдийг дайнд хувь нэмэр оруулах нэрийдлээр Япон руу илгээж охидыг цэргүүддээ биеийг нь хүчээр үнэлүүлж "зугааны хүүхнүүд" хэмээн нэрлэдэг байв. Иймээс тариачид япончуудыг нэг нүдээр үздэггүй байлаа. Япончуудын зөвшөөрөлгүйгээр тэд нэг ч алхах эрхгүй.

1945 оны 6 сарын 15-нд Ханхүү Хирохито радиогоор япончууд дайнд бууж өгснийг зарлав. Энэ

мэдээ тосгонд ирлээ хэд хоножээ. Тосгоны хөвгүүд энэ мэдээг дуулангуутаа япончуудын байрлаж байсан хуаранд ирж, тэднийг аль хэдийн хамаг юмаа хаяад сүүлээ хавчин зугтаасныг олж мэдэв. Ийнхүү эзлэн түрэмгийлэлд төгсгөл ирлээ. Тосгоныхон энэ сайхан үйл явдлыг тэмдэглэх мөнгөгүй учраас гудамжинд гарч жагсан, бие биедээ баяр хүргэн, хэрэндээ л хөөрцгөөж, "Солонгос улс үүрд мандан бадраг" хэмээн уухайлж байлаа.

Энэ удаа солонгосчууд хувь заяагаа өөрсдөө мэдэх цаг ирлээ хэмээн баярлацгааж байв.

Японы ханхүү бууж өгсөн тухайгаа радиогоор зарлаж байх үед АНУ-ын нийслэл Вашингтон хотноо хуурай замын цэргийн хоёр залуухан офицер газрын зураг харан Солонгосыг хэрхэх тухайгаа ярилцаж байлаа. Вашингтонд Японы эзлэн түрэмгийллийн талаар ихийг үл мэднэ. Герман, Япон улсуудыг дайны төгсгөлд хэрхэх талаар нэлээд боловсронгуй төлөвлөгөө хийгдээд байсан бол одоо Солонгосыг хэрхэх тухай асуудал урган гарч ирэв. 32 жилийн турш дарангуйлсан япончууд Солонгосын нутаг дэвсгэрээс гарч явсны дараа улс орныг удирдан жолоодох хүчингүй болох вий хэмээн америкчууд болгоомжилж байв. ЗХУ-ыг Япон руу довтлох үедээ Солонгосыг түшиц газар болгохоор түрэмгийлж магад хэмээн Америкчууд бас сэжиглэж байжээ. Хэдийгээр Дэлхийн хоёрдугаар дайнд холбоотон болж оролцсон ч ЗХУ-д итгэх Америкийн итгэл суларсаар байлаа. Зөвлөлтийн цэргүүд япончуудыг гарч явахаас долоо хоногийн өмнө Солонгосын хойд талаас аль хэдийн нэвтэрч эхэлсэн байв. Иймээс хамгийн зөв зам бол Зөвлөлтийнхөнтэй итгэлцлээ хадгалж, Солонгосын хойгийн хойд хэсгийг тэдэнд өгөх явдал юм хэмээн ярилцжээ. Хоёр залуу офицерийн нэг, хожим нь Төрийн Нарийн Бичгийн Дарга болсон Дийн Раск тус улсын нийслэл Сөүл хотыг өөрийн хэсэгт буюу АНУ-ын хяналтад үлдээхийг хүсэв. Ингээд хоёр офицер Солонгосын хойгийг хуваах хамгийн зөв шийдлийг хайсны эцэст 38-р өргөргийг сонгож, өмнөд хэсгийг АНУ, Хойд хэсгийг ЗХУ-ын цэрэг түр хяналтдаа байлгахаар болжээ. Ийнхүү дураар аашилж байхдаа тэдний үйлдэл хожим ард түмнийг хувааж, ах дүү, аав охин, ээж хүүг салгасан өргөст тор болон хувирна чинээ санаа ч үгүй биз. Ингэж л Солонгос улс Хойд, Өмнөд гэсэн хоёр хэсэгт хуваагдсан түүхтэй.

Уг хуваалт Солонгосын түүх болон газарзүйн байрлалтай ямар ч холбоогүй. Хятадын газар нутгаас цоройж гарсан эрхий хуруун чинээ хэсэг бол Солонгосын хойг бөгөөд зүүн зүгтээ Япон тэнгис, баруун талаараа Шар тэнгис, Ялу, Түмэн голуудаар Хятадтай хиллэнэ. Хоёр хуваахад зохимжтой хэсэг Солонгосын хойгийн хаана ч байхгүй. Өмнө нь, Японы түрэмгийллээс өмнө Солонгос нэгдсэн улс байж, 1300 жилийн туршид Чусан гүрэн ноёрхож байв. Энэ улс дэлхийн хамгийн удаан оршин тогтносон хаант улсуудын нэгэнд тооцогддог. Чусанаас өмнө Солонгосын хойгт Корёо гүрэн (918-1392 он хүртэл), түүнээс өмнө эрх мэдлийн төлөө өрсөлдсөн гурван ч эзэнт улс байж. Улс төрийн хагалан бутаргах оролдлого л уг үндэстнийг хойд, өмнөд хэмээн хоёр хуваасан ба газарзүйн хувьд зүүн тал нь Япон руу, баруун нь Хятад тийш хэлбийсэн байрлалтай. Хойд, Өмнөд хэмээн хуваасан нь солонгосчуудын санаа бодолтой огт хамаагүй цэвэр гаднын орнуудын түрэмгийлэх бодлого байсан юм. Мөн чанартаа энэ бодлого Вашингтонд боловсрогдож, Солонгост хэрэгжсэн юм. АНУ-ын тухайн үеийн Төрийн Нарийн Бичгийн Дарга асан Эдвард Стэттиниус туслахаасаа Солонгос гэж хаана байдаг улс билээ хэмээн асуусан түүх бий гэнэ.

Солонгосчууд ийнхүү Германы түүхийг давтаж хоёр хэсэгт хуваагдав. Эцэст нь тэд Дэлхийн

хоёрдугаар дайнд түрэмгийлэгч биш харин хэлмэгдэгч боллоо. Тухайн үедээ солонгосчууд их гүрнүүдийн тоглоом болж буйгаа "хаданд хавчуулагдсан халиуны зулзага" хэмээн нэрлэж байв.

Их гүрнүүдийн аль нь ч хоёр Солонгос нэгдэх нөхцөл бүрдүүлэхийг хүссэнгүй. Солонгосчууд өөрсдөө ч хоорондоо эвдрэлцэж эхлэв. Түр зуур газрын зураг дээр тавьсан тэмдэглэгээ удалгүй албан ёсных болов. 1948 онд Принсетоны их сургуульд докторын зэрэг хамгаалсан, 70 настай Сингман Рийгийн удирдлага дор Бүгд Найрамдах Солонгос Улс байгуулагдав. Японы түрэмгийллийн эсрэг тэмцэгч хэмээн өөрийгөө зарласан нэгэн бас өөрийн улсыг буюу Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улсыг байгуулснаа тунхаглав. 38-р өргөргөөр хоёр Солонгосыг тусгаарласан зурвас яваандаа 250 км урт, дөрвөн км өргөн өргөст торон утас, танкны урхи, далан, шуудуу, артилерийн төхөөрөмж болон газрын мина бүхий бүс болон хувирчээ. Хоёр улс аль аль нь засгийн газраа хууль ёсны хэмээн хүлээн зөвшөөрүүлэхээр зүтгэсэн тул дайн гарах нь зайлшгүй болжээ. 1950 оны зургаадугаар сарын 25-ны ням гаригийн үүрээр ЗХУ-ын зэвсэг техникээр хангагдсан Ким Ир Сений цэргүүд дайралт хийв. Тэд Сөүлийг ядах юмгүй эзэлж, цааш өмнө зүгт давшин, Пусанаас бусад бүх газар нутгийг эзэллээ. Гэтэл Генерал Дуглас МакАртураар удирдуулсан АНУ-ын 40,000 цэрэг есдүгээр сард коммунистын хийсэн ялалтыг үгүй болгов. АНУ, Өмнөд Солонгосоос гадна НҮБ-ын эвсэлд Их Британи, Австрали, Канад, Франц, Нидерландын цэргүүд орж, улмаар их эвсэл Сөүлийг буцаан авч, Пхеньян болон бусад хотуудыг эзлэхээр давшилт хийж эхэлжээ. Гэвч тэднийг Ялу голд тулж ирэхийн үес Хятадын коммунист хүчин дайнд орсноор ухрахаас өөр аргагүйд хүрсэн байна. Дахин хоёр жил тулалдсанаас хүн ам ихээр үхэж үрэгдэн, өвчин зовлонд нэрвэгдэв. 1953 оны долоодугаар сарын 27-нд эвлэрлийн гэрээнд гарын үсэг зурах хүртэл нийт гурван сая хүний амь үрэгдэж, Солонгосын хойг сүйрлийн ирмэгт тулсан байлаа. Хилийн зураас 38-р өргөргийн дагуу бага зэрэг нааш цааш болсон ч ерөнхийдөө хэвээр үлдэв. Энэ бол хорьдугаар зууны хамгийн утга учиргүй, хоосон тулаан болж түүхэнд үлдсэн юм.

Коммунистууд тосгоныг нь эзлэн авах үед Тэ Ву 18 хүрсэн байлаа. Дайн эхлэхээс өмнө үрэгдсэн аавыгаа орлож, ээж эгч нартаа цорын ганц өмөг түшиг нь болж байв. Өмнөд Солонгосчууд Хойд Солонгосын дөрөвний нэгд хүрэхгүй цэргийн хүч буюу 65,000 цэрэгтэйгээр хийрхэлдээ хөтлөгдөн, дайнд шунахайран бэлдэж эхэллээ. Тиймээс тэд боломжтой бүх л эрчүүдийг цэрэгт татав. Зарим тариачин Хойд улсын цэргийг тариан талбай өгч магадгүй сургаар нь битүүхэн дэмжицгээж байв. Япончууд ялагдаж явснаас хойш тариачдын амьдрал огт дээрдээгүй боловч ихэнх эрчүүд нь улс төрд ач холбогдол өгсөнгүй. Бид аль нь зөв болохыг огт ойлгодоггүй байлаа хэмээн Ли Жон Хун ярьсан юм. Тэд улс төрийн ямар сонголт хийснээсээ үл шалтгаалан Өмнөд Солонгосын цэрэгт татагдаж эхлэв.

Тэ Ву ч цэрэгт татагдаж, яваандаа дэвшсээр ахлагчийн цолонд хүрч амжжээ. Тэдний ангийн сүүлчийн тулаан 38-р өргөргөөс 40 км-ийн зайд орших Кимва хэмээх тосгоны дэргэд өрнөв. Кимва нь боржин уулсаар хүрээлэгдсэн стратегийн ач холбогдол бүхий хөндий, Америкийн цэргийнхний нэрлэж заншсанаар бол Төмөр Гурвалжин гээч нь юм. (Пёнганг ба Чорвон нь гурвалжны нөгөө хоёр талыг бүтээдэг байна). Кимвад хамгийн хүнд тулааны нэг болсны учир нь Хятадууд дайныг зогсоох зорилгоор фронтын шугамыг өмнө зүг рүү татахаар оролдож байсанд оршино. 1953 оны зургаадугаар сарын 13-ны шөнө Хятадын цэргийн гурван дивизийн нийт 6000 цэрэг НҮБ-ын эвсэл болон Өмнөд Солонгосын цэргүүдийн эсрэг гэнэтийн дайралт хийв. Оройн 19

цаг 30 хоромын үед коммунист хүчнүүд НҮБ-ын байрлалуудыг бөмбөгдөж, 22 цагийн үед гэрэлт пуужингаар буудахад уул толгод хэдэн мянган дайсны цэргээр бүрхэгдэж хөдлөх мэт байхыг бид олж харсан гэж дайралтын талаар нэгэн америк цэрэг тэмдэглэлдээ дурссан байдаг. Уухайн дуу тал талаас цуурайтаж, дайсны цэргүүд дайран орж ирж байлаа. Сүүлд нь Өмнөд Солонгосын цэрэг байсан нэгэн эр "Бид нүдэндээ ч итгэхэд бэрх байлаа. Зүгээр кино зураг авч байгаа юм шиг санагдсан. Долоо хоног тасралтгүй бороо орсон болохоор уул талд цусан гол урсаж буй мэт байсан" хэмээн дурсчээ.

Энэ үед эмнэлгийн салаанд байсан Тэ Ву ангийг нь хятадууд бүслэх үед Өмнөд Солонгосын цэргийг дамнуурга дээр тавиад зөөж явсан байна. Найрамдлын хэлэлцээрт гарын үсэг зурахаас хоёрхон долоо хоногийн өмнө Тэ Ву болон түүний анги нэгтгэлийн таван зуу орчим цэрэг олзлогдсон юм.

Ийнхүү түүний Өмнөд Солонгосын иргэн байсан түүх төгссөн болой.

Ми Раны эцэг олзонд байхад нь юу тохиолдсон талаар хэнд ч яриагүй юм. Коммунистуудын дөнгөнд байсан цэргийн олзлогдогсодтой учирсан бүхэн түүнд ч бас тохиолдсон л байж таарна. Ху Жэ Сук хэмээх эр дайны олзлогдогч байгаад хорих лагериас оргожээ. Түүний ярьснаар бол тэдэнд усанд орж, үс сахлаа хусаж, шүдээ угаахыг огт зөвшөөрдөггүйгээс бөөс хуурсандаа баригдан, эдгэрээгүй шарх нь бохирдож, маш хүнд нөхцөлд байсан ба гадна өдөрт ганц удаа л цагаан будаа, давстай ус зэргээр голоо зогоож байжээ.

Энхийн хэлэлцээрт гарын үсэг зурсны дараа дайны олзлогдогсдын солилцоо болов. Энэ үеэр коммунистууд 12,773 хүн буцаасны дунд 7,862 нь Өмнөд Солонгосын иргэн байжээ. Мөн хэдэн мянган олзны хүнийг гэрт нь буцаагаагүйн дотор Тэ Ву орсон байна. Тэднийг Пхеньяны галт тэрэгний буудлаас ачихаар нь Өмнөд Солонгос руу явж байна гэж бодсон гэдэг. Гэтэл хойд зүгт буюу нүүрс олборлодог уул руу авч явжээ. Дотоод Явдлын Яамны Барилгын Цэргийн ангийн дэргэд цэргийн олзлогдогсдын шинэ лагерийг нүүрсний уурхай түшиглэн барьсан байжээ. Хойд Солонгос дахь нүүрсний уурхайнууд бохир заваанаас гадна маш аюултай нөхцөлд ажиллана. Цөөнгүй тохиолдолд уурхай нурж, галд автана. Хугийн дурссанаар тэдний амь ялааныхаас үнэгүй байжээ. "Уурхай руу өглөө бүхэн алхахдаа би байнга айдас өвөрлөж явна. Ярганы газар руу алхаж байгаа үхэр шиг л санагддаг. Тэндээс амьд гарч ирэх эсэхээ ч мэддэггүй байв" хэмээн Ху Жэ Сук хожим нь дурсан ярьсан юм.

1956 онд Хойд Солонгосын Их хурал Өмнөд Солонгосын цэргийн олзлогдогсдод иргэншил олгох зарлиг гаргажээ. Ингэснээр тэдний ачаа бага зэрэг хөнгөрсөн ч хэзээ ч нутаг буцахааргүй болсон юм. Хамгийн хүнд нөхцөлтэй нь нүүрсний уурхайнууд. Тэнд үргэлж осол болж, гал түймэр гарах учир ажиллагсад байнгын айдастай. Тэ Вуг Хятадын хилийн ойролцоох Мусан хэмээх тосгонд төмрийн хүдэр олборлодог уурхайд томилов. Тэнд ажиллагсад бүгд Өмнөд Солонгосчууд ба нийтийн байранд амьдарна.

Уг байранд амьдрагсдын нэг нь 19 настай ганц бие охин байж. Тэр хөөрхөн гэхээргүй боловч бусдын сэтгэлийг татахаар охин байлаа. Охин ээж эгч нараасаа л холдож байвал хэнтэй ч хамаагүй гэрлээд тусдаа гарахад бэлэн байжээ. Дайны дараа гэрлэх насны эрчүүд ховордсон үе. Байрны эзэн охиныг Тэ Вутай танилцуулжээ. Охиноос өндөргүй Тэ Ву зөөлөн яриатай учир

нүүрсний тортог доороос ч эелдэг зан чанар нь харагдаж, охин дэлхий дээр гон бие гозон толгой залууг өрөвдөн, тэр жилдээ тэд гэрлэсэн байна.

Тэ Ву энэ нутгийн амьдралд маш түргэн дасан зохицжээ. Түүнд орчиндоо уусахад тийм ч хэцүү байсангүй. Тэдний хэлдгээр Солонгос бол нэг үндэстэн, нэг ард түмэн. Нүүр царай нь ч төстэй. Пхеньян аялга, Пусаны гуншаа дуудлагатай адилгүй болохоор зарим тохиолдолд шоолуулна. Дайны эмх замбараагүй байдал хоёр Солонгосын ард түмнийг хооронд нь хангалттай хольж хутгажээ. Коммунистуудаас, дэглэм, шийтгэлээс эмээсэн мянга мянган хүн 38-р өргөргөөс өмнө зүг рүү дүрвэсэн байна. Тэдний дунд газрын эзэд, бизнесмэн, Христос шашинтнууд, санваартан, япон түншүүд хүртэл байлаа. Коммунизмыг дэмжигч цөөн хүн Хойд Солонгос руу оржээ. Олон зуун хүн улс төрийн тодорхой үзэл бодолгүй учраас хар аяндаа хоёр талын аль нэгд орсон байдаг. Аль нь Өмнөд аль нь Хойд Солонгосын иргэн байсныг хэлж мэдэх хүн огт байсангүй. Гэрлэснийх нь дараа Тэ Вуг эхнэртэй нь Чонжины ойролцоо жижиг уурхай руу шилжүүлэв. Тэнд тэднийг хэн ч танихгүй. Гэхдээ гарал үүслийнх нь талаар хэн ч юу ч сэжиглэх үндэслэлгүй авч зөвхөн Хойд Солонгост л байдаг зарим нэг онцлогоор хэн нэг нь мэдэж л байв.

Дайны дараа Ким Ир Сений хамгийн түрүүнд хийсэн ажил гэвэл журмын нөхөд дундаасаа дайсныг олж нухчин дарах явдал байв. Энэ ажлаа тэр өөртэй нь өрсөлдөх боломжтой өндөр албан тушаалтнуудаас эхэлсэн юм. Тэрбээр бүр Манжуураас эхлэн мөр зэрэгцэн тулалдаж явсан журмын олон нөхдөөсөө ийм л шалтгаанаар салжээ. Өмнөд Солонгос дахь Коммунист Намыг үндэслэгч нөхдийг ч баривчлах тушаал гаргав. Тэд дайны үеэр үнэлж баршгүй гавьяа байгуулсан ч одоо нэгэнт хэрэг нь дууссан тул тэднээс салах хэрэгтэй. 1950иад оны үед ийм маягаар эртний Хятадын эзэнт улсын жишгийг даган ухаантай, чадалтай олон хүнийг хэлмэгдүүлжээ.

Дараа нь Ким Ир Сен жирийн ард иргэд рүү анхаарлаа хандуулж эхлэв. 1958 онд бүх иргэнээ улс төрийн найдвартай байдлаар нь ангилах төсөл хэрэгжүүлэх зарлиг гаргав. 1960, 1970-аад оны Хятадын Соёлын хувьсгалын үеэр гарсан "капиталистуудыг үзэн ядагч" Улаан хамгаалагч хөдөлгөөнтэй адил төстэй үйл явдал өрнөв. Нийгэмд айдас үүсгэж хөрш нь хөршийгөө, найз нь найзыгаа барьж өгөх боллоо. Хойд Солонгосчууд хүмүүсийн алдаан дээр системтэй ажиллана. Хүн бүрийг найман шат бүхий удам угсааны шалгалтад оруулна. Сонбун хэмээн нэрлэгддэг тэр үнэлгээг хийхийн тулд эцэг эх, өвөг эмэг, үеэл байтугай хаяалуудыг нь хүртэл шалгана. Хөдөлмөрийн Намын Эрчимжүүлсэн Даалгавар гэх сүртэй нэрийн дор тухайн иргэн үнэнч эсэхийг судлах олон үе шат бүхий кампанит ажил явагдана. Хөдөлмөрийн Намын Эрчимжүүлсэн Даалгавар нь энэ үйл ажиллагааны эхний шат байлаа. Дараагийн шат нь Иргэдийг Ойлгох Төсөл гэх мэтээр улам боловсронгуй, тандалтын хэмжээ нь илүү нарийн болж байлаа.

Хорьдугаар зуунд нийгмийн өөрчлөлт, ардчилал гэж ярьдаг болсон үед Хойд Солонгос урагш дэвших биш хойшоо ухралт хийлээ. Тэд феодалын системийн арай сайжруулсан хувилбар руу тэмүүлж, улс эх орноо өнгөрсөн зуун руу буцааж аваачлаа. Өнгөрсөн зуунд Солонгос улс бараг Энэтхэгтэй адил маш хатуу кастын тогтолцоотой байжээ. Язгууртнууд цагаан цамц, адууны сүүлээр хийсэн өндөр хар малгай өмсөж, харин боолууд хүзүүндээ модон сэтэр зүүдэг байж. Хуучин нийгмийн давхаргын бүтэц нь Хятадын философич Күнзийн баримталж асан зарчим буюу хүн төрөлхтөнийг пирамид хэлбэрийн нийгмийн бүтцэд хамааруулж байв. Ким Ир Сен Күнзийн

энэ зарчмын хамгийн хүнлэг бус элементийг нь авч Сталинизмтай хослуулан хэрэгжүүлж эхлэв. Пирамидын оройд Ким Ир Сен болон түүний гэр бүл, түүнээс доошоо гурван том ангийн 51 ангилал байна. Гурван том анги гэдэг нь үндсэн анги, эргэлзээтэй анги, сэжигтэй анги.

Сэжигтэй давхаргад Японы гэйшатай төстэй, мөнгө төлсөн үйлчлүүлэгчдэд бусдаас арай илүү үйлчилгээ үзүүлдэг бүсгүйчүүд, зөн билэгтнүүд, бөө нар орно. Өмнөд Солонгос руу оргож очсон хүмүүсийн дурссанаар дараах хүмүүсийг албан ёсоор сэжигтний тоонд хамааруулна. Үүнд: чинээлэг тариачид, үйлдвэрлэгчид, газрын эзэд, мөн хөрөнгийг нь бүрмөсөн хураасан иргэд, АНУ, Японыг дэмжигсэд, өмнөд Солонгосоос цагаачлан ирэгсэд, Буддын болон Христос шашинтнууд, цөлөгдсөн албан тушаалтнууд, Солонгосын дайны үеэр Өмнөд Солонгосынхонд тусалж байсан хүмүүс.

Өмнөд Солонгосын цэрэгт алба хааж байсны хувьд Тэ Ву нийгмийн давхаргын ангиллын хамгийн доор биш ч түүнээс үл ялиг дээгүүр давхаргад харьяалагдах болов. Хамгийн доод давхаргад нийт хүн амын нэг хувь буюу ЗХУ-ын үлгэр дууриалаар баригдсан хөдөлмөрийн лагерьт насаараа цөлөгдсөн 200,000 хүн орно. Нийгмийн доогуур давхаргаас гаралтай иргэд үзүүлэнгийн хот Пхеньян, бусад үржил шимтэй, тааламжтай уур амьсгалтай газруудад амьдрах эрхгүй байв. Хятад, Орост Коммунист нам нь ихэнх ажлын байрыг хяналтдаа байлгадагтай адил жишиг бүхий Хойд Солонгост Тэ Ву Хөдөлмөрийн Намд элсэн орох тухай бодож ч зүрхэлдэггүй байв.

Тэдний давхаргынхныг сайтар ажиглаж байх үүргийг хөрш айлууд нь хүлээдэг аж. Хойд Солонгос иргэдээ 20 буюу түүнээс дээш айл өрхөөс бүрддэг инминбан буюу "хорьт" хэмээх зохион байгуулалтад оруулсан ба айл өрх бүр бие биеэ бүртгэж, хянах үүрэгтэй. Хорьтыг тусгайлан томилсон дунд насны эмэгтэй ахлах ба өөрийн хороонд ажиглагдсан сэжигтэй зүйл бүхнийг дээд удирдлагадаа мэдээлэх үүрэгтэй. Доод давхаргад харьяалагддаг иргэн нийгмийн байдлаа өөрчлөх, давхарга дээшлэх боломж бараг л үгүй. Иргэдийн хувийн хэргийг Ардын Аюулгүй Байдлыг Хамгаалах Яам хариуцах бөгөөд халдлагаас сэргийлж, уулархаг Янганг мужид хадгална. Доод давхаргын иргэн зиндаа өөрчлөгдөхөд дээшээ биш доошоо л орох магадлалтай. Сахилгын зөрчил гаргасан хэн боловч бүлийнхээ нийгмийн байдлаас хамааран дээд давхаргад харьяалагддаг байсан ч, намын боловсон хүчин байлаа ч, доод давхарга руугаа шилжих шийтгэл хүлээх ба тэндээ насан туршдаа үлдэнэ. Амьдралд суусан нэг л толбо хэзээ ч арилахгүй, насан туршид дагана. Хуучин Солонгосын кастын системтэй адил гэр бүлийн байдал удам дамжих чанартай. Жишээлбэл: эцгийн хийсэн нүгэл үр хүүхэд ач гуч хүртэл нь дамжина.

Ийм төрлийн хүмүүсийг "цус нь бузартсан буюу цэвэр биш цустай гэр бүл" хэмээн нэрийддэг ажээ.

Ми Ран болон түүний эгч дүү нар яг л ийм маягаар аавынхаа хийсэн "нүглийг" үүрэх хувь заяатай байж. Аавд нь амьдралын ямар бэрхшээл тохиолдсон байна үр хүүхэд нь яг л адилхан зүйлийг туулж өнгөрүүлэх ёстой.

Ми Ран хүүхэд насандаа өөрийг нь төрөхөөс өмнө гэр бүлд нь байсан хар сүүдрийг ажиглах ч үгүй явжээ. Аав нь Өмнөд Солонгосоос гаралтай гэдгийг хүүхдүүддээ хэлэхгүй байхаар эцэг эх

хоёр шийдэж. Сайн сургуульд орж, сайхан ажил хийж чадахгүй, амьдрал нь удахгүй ямар ч утгагүй болно гэдгийг нь мэдсээр байж хүүхдүүдээ хичээлдээ шамдахыг захиж яах юм бэ? Тэд юуны төлөө хөгжмийн дугуйланд явж, спортын амжилт гаргах гэж мэрийх юм бэ?

Хойд Солонгосчуудад харьяалагдах давхаргынх нь талаар ил тод мэдээлдэггүйгээс хүүхдүүд гэр бүлд нь ямар асуудал буйг эхэндээ сайн мэддэггүй байлаа. Гэвч өсөж том болох тусмаа аавд нь ямар нэг нууц буйг хүүхдүүд мэдэрч эхэлсэн байна. Тэдний эцэг зожиг, өвөрмөц эр, даагдахааргүй хүнд ачааг үүрч яваа мэт сэтгэгдэл төрүүлнэ. Түүнийг гэх төрөл садан байсангүй. Ганц өөрийнхөө өнгөрсөн түүхийн тухай ч биш ер нь л Тэ Ву угаасаа бараг дуугарахгүй. Асуултад ганц нэг богино үгээр л хариулна. Ер нь л ярьж харагдахгүй дээ. Гэртээ ойр зуурын юм засаж янзлах, өөрийг нь ярих завгүй байлгах ямар нэг юм хийх үедээ л сэтгэл нь хөнгөрсөн байртай харагдана.

Багадаа генерал болж тоглодог байсан сэргэлэн хүүгээс үлдсэн зүйл нэгээхэн ч үгүй гэлтэй. Охид нь өндөр нуруу, чийрэг бие бялдрыг нь өвлөн авсан ба ээж нь л аавынх нь өмнөөс бүхнийг ярьдаг байжээ. Хүүхдүүдийг сургах хэрэгтэй үед, хөршдөө гомдол тавих бүх л тохиолдолд эхнэр нь нөхрийнхөө өмнөөс ярина. Тэ Вуд хэлмээр зүйл байвч дотроо хадгалахыг илүүд үзнэ. Хойд Солонгосын нийгэмд Тэ Ву шиг доод давхаргын иргэнд сонин олж уншина гэдэг ховор завшаанд тооцогддог. Тэ Ву сонин олдмогц гэрт байдаг цорын ганц гэрэлтүүлэг болох 40 лааны гэрэл дороо хичээнгүйлэн, бас чимээгүйхэн уншиж сууна. Ким Ир Сений агуу их амжилтуудаар дүүрсэн Хөдөлмөрийн Намын Родонг Синмун сонин, орон нутгийн Хамбук Дэйли сонинуудыг уншиж байхад түүнд юу бодогддог байсан бол? Тэр уншиж буй зүйлдээ итгэдэг байсан болов уу?

Эцгийнх нь ийм байдал Ми Раныг их цухалдуулдаг байв. Бүр хожим аав нь санаатай дуугаа хураадаггүй, зөвхөн өөр дээрээ анхаарал татахгүй байх зорилготой болохыг Ми Ран ойлгосон юм. Энэ нутгийн амьдралд дасан зохицохоор чармайж байсан Өмнөдийн хэдэн мянган цэргээс маш олон нь сорилтыг даалгүй сөхөрч байв. Ми Раны ээжийн ярьснаар аавынх нь ойрын найз, адилхан түүхтэй дөрвөн хөөрхий эр жижигхэн зөрчил гаргасныхаа төлөө цаазлуулж, шарилыг нь нийтийн оршуулгын газар булсан гэнэ.

Сэжигтэй давхаргын гишүүний хувьд тэдэнд эргэлзэх ч эрх байхгүй. Ким Ир Сенийг битүү егөөдөх, өмнөд Солонгосын талаар дурсан ярих зэрэг л таныг асуудалд оруулах хангалттай шалтгаан болно. Солонгосын дайны тухай, хэн эхэлсэн тухай ярихыг хориглоно. Албан ёсоор (Хойд Солонгост албаны бус түүх гэж байхгүй) Өмнөд Солонгосчууд Америкийн эзлэн түрэмгийлэх тушаалын дагуу анх Хойд Солонгос руу дайрснаар хоёр Солонгосын дайн эхэлсэн. Тэдний 38-р өргөргөөр анх дайралт эхэлсэн талаар албан ёсны түүхэнд нэг ч үсэг байхгүй. Хөдөлмөрийн Намын сонин Родон Синмун дээр "АНУ-ын империалистууд өмнөдийн утсан хүүхэлдэйнүүдэд манай орныг эзлэн түрэмгийлэх тушаал өгснөөр Солонгосын дайн эхэлсэн түүхтэй" хэмээн бичдэг.

1950 оны зургаадугаар сарын 25-нд үнэн хэрэг дээрээ юу болсон талаар санаж буй хүмүүс чимээгүй байсан нь аминд өлзийтэй гэдгийг бас мэднэ.

Хүүхдүүд өсөж, өсвөр насандаа хүрэх үед эцгийнх нь нийгмийн гарлаас шалтгаалан амьдралд нь тулгарах бэрхшээлүүд нэмэгдэж эхэллээ. Хүүхэд 15 нас хүрч, бүрэн бус дунд боловсрол

эзэмшээд, цаашид үргэлжлүүлэн суралцах хүсэлтэй бол ахлах сургуульд өргөдөл гаргаж шалгалт өгнө. Ахлах сургуульд тэнцээгүй нь үйлдвэр, нүүрсний уурхай гэх мэт газруудад илгээлт өвөрлөн очно. Ми Раны эгч дүү нар өөрсдийгөө цаашид суралцах сурагчдын тоонд орно гэдэгт огтхон ч эргэлздэггүй байв. Тэд царайлаг, ухаалаг, хичээлдээ сайн, урлаг спортын авьяастай учир үеийнхэн нь, багш нар нь ч сайн ханддаг байв. Тэд чадваргүй, авьяасгүй байсан бол ахлах сургуульд сурах эрхийг нь хасахад хялбар байх асан биз.

Ми Раны хамгийн том эгч Ми Хи сайхан сопрано хоолойтой нэгэн. Түүнийг солонгосчуудын дуртай ардын дуунаас, бүр Ким Ир Сенийг магтсан дуу ч бай дуулахад хөршүүд нь ирж сонсох дуртай байлаа. Ми Хиг олон нийтийн арга хэмжээнүүдэд урьж дуулуулна. Сайхан хоолойтой байх нь тэнд ховорт тооцогддог. Ми Хи маш үзэсгэлэнтэй, нэг удаа нэг зураач түүнийг хөргөө зуруулаач хэмээн гуйж байсан ч удаатай. Тэрбээр урлагийн сургуульд орох шалгуурыг бүх талаараа хангаж байсан ч элсүүлэхээс татгалзсаныг нь сонсоод хэдэн өдрөөр уйлсан гэдэг. Ээж нь шалтгааныг нь мэдэж байсан хэдий ч сургууль дээр нь очиж элсүүлээгүй шалтгаанаа тайлбарлахыг шаарджээ. Хичээлийн эрхлэгч ээжид нь зөвхөн сайн сонгбунтэй (гаралтай) сурагчдыг урлагийн сургуульд элсүүлэх заавартайг аятайхнаар тайлбарласан байна.

Ми Ран эгч нарынхаа адил урлаг спортын онцгой авьяастай байсангүй. Гэвч тэр царайлаг, сайн сурагчийн тоонд орно. Түүнийг 15-тай байхад сургууль дээр нь бараан хувцастай, чухал царайтай хэдэн хүн ирж. Тэд оква буюу Хөдөлмөрийн Намын штабын тавдугаар тасгийн гишүүд бөгөөд Ким Ир Сен, Ким Чен Ир хоёрт зориулсан гэрийн үйлчлэгч шалгаруулахаар охидыг сонжин явж байсан хүмүүст юм. Сонгогдсон охид удирдагчдын орон даяар байрлах байрнуудын нэгэнд хуваарилагдахын өмнө цэргийн ангид очиж сургалтанд хамрагдана. Ажилд орсон л бол охид гэртээ ирэх эрхгүй. Харин ар гэрийнхэнд нь нөхөн олговор болгож, үнэтэй бэлэг сэлт ирнэ. Охид яг ямар ажил хийдэг талаар тодорхой мэдээлэл үгүй. Зарим нь нарийн бичгийн дарга, үйлчлэгч, дуучин, нөгөө хэсэг нь нууц амрагууд нь байсан гэх цуу яриа сонсогдоно. Ми Раны үеэл эгч нь ийм ажил хийхээр сонгогдсон найзаасаа бага сага зүйл сонсож мэдсэн байв.

Ми Раны нэг найз Ким Ир Сен, Ким Чен Ир чинь бусадтай л адилхан эрчүүд шүү дээ гэж аминчлан шивнэж л дээ. Ми Ран толгой дохиод, ийм юм байдаг л юм байх даа хэмээн маш ихээр гайхсан байна. Түүний насны охидод нууц амраг гээчийн талаар ямар ч мэдлэг байхгүйгээр барам агуу их удирдагчдаа яаж ч үйлчилсэн нэр төрийн асуудал хэмээн бодно. Хамгийн царайлаг бөгөөд ухаантай охид л сонгогдоно.

Ажилд элсүүлэгчид ангид орж ирэхэд бүгд цэх сууж хүлээнэ. Охид уртааш нь эгнүүлсэн ширээнүүдэд хоёр хоёроороо сууна. Ми Ран дунд сургуулийнхаа дүрэмт хувцастай сууж байлаа. Хөлдөө зотон даавуун шаахайтай. Албаны хүмүүс ширээнээс ширээ рүү очихдоо хэсэг азнаж, охидыг гярхай ажиглаж байснаа Ми Ран дээр ирээд "Бос. Биднийг дагаад багш нарын өрөөнд оч" гэж тушаав.Охины хувийн хэргийг судалж, өндрийг нь хэмжээд асуултаар булж эхэллээ. Дүн, дуртай хичээл, эрүүл, ямар нэг эрхтэн нь өвддөг эсэх талаар асуув. Ми Ран өөрийнхөө л хэрээр тайван итгэлтэй хариулж.

Ингээд тэднийг явснаас хойш ямар ч хариу ирсэнгүй. Тэднээс хариу сонсож, сонгогдох гэж

яарсандаа ч биш ахиад л гологдлоо гэсэн гашуун бодол охиныг зовоож байв.

Тэр үед хүүхдүүд гэр бүлийнх нь гарал үүсэл ирээдүйд нь ихээхэн үүрэг гүйцэтгэж буйг ойлгож ухаарсан цаг. Тэд эцэг нь хилийн нөгөө талаас гаралтай, учир нь энд түүний хамаатан садан гэхээр нэг ч хүн байхгүй гэдгийг мэдэж байв. Гэвч яаж тэр юм бол? Тэд эцгийгээ Өмнөдөд хавчигдсанаасаа болж баатарлагаар хил даван зугтаж хойд нутагт ирсэн үнэнч коммунист хэмээн таамаглаж байв. Эцэст нь Ми Раны дүү Сок Жу үнэнийг илрүүлжээ. Байнга хөмсөг зангидаж явдаг, бачимдуу зантай хүү багшийн сургуульд орохоор шамдан бэлтгэж байж. Тэр бүх хариултыг төгс мэдэж байлаа. Гэвч шалгалтанд унаснаа сонсонгуутаа Сок Жу шалгалтын комиссоос тайлбар шаарджээ.

Үнэн учрыг мэдээд тэд бүгд сэтгэл санаагаар унаж гүйцэв. Тэдэнд түүхийг зөвхөн Хойд Солонгосын хувилбараар ухуулж өсгөсөн. Америкууд бол нүглийн хүүдийнүүд, харин Өмнөд Солонгосчууд тэдний өрөвдөлтэй боолууд. Хүүхдүүдэд АНУ-ын бөмбөгдөлтөд өртөж сүйрсэн нутгийнх нь зургийг байнга үзүүлнэ. Мөн түүхийн номоос Америк болон Өмнөд Солонгосын цэргүүд дайны үеэр гэмгүй номхон иргэдийг устгаж байсан тухай олж уншсан. Тэдний сурах бичгүүд дээр түлэгдсэн, гэмтсэн, жадлуулсан, буудуулсан, хордсон үрэгдэгсдийн талаар дүүрэн бичсэн байдаг. Тийм бузар Янкитай эцэг нь мөр зэрэгцэн тулалдаж явсан гэдгийг мэдсэн хүүхдүүдэд газар дэлхий хөмрөх шиг л болсон нь мэдээж. Сок Жу амьдралдаа анх удаа архи уув. Тэр гэрээсээ зугтааж найзындаа хоёр долоо хоног амьдраад найз нь ятгасны эцэст гэртээ буцаж харьжээ. "Ямар ч байсан чиний төрсөн эцэг шүү дээ" хэмээн найзынхаа хэлсэн үгийг Сок Жу сэтгэл зүрхэндээ ойрхон хүлээн авч аавыгаа ихэд өрөвджээ. Гэртээ буцаж ирээд эцгийнхээ өмнө өвдөг сөгдөн хүлцэл өчихдөө аавынхаа уйлахыг амьдралдаа анх удаа харсан бөлгөө.

Хүүхдүүд эцгийнхээ гарал үүслийн талаарх үнэнийг хэзээ хойно олж мэдсэн байлаа. Тэ Ву Өмнөд Солонгосын цэрэг байсан мөн сэжигтэй давхаргад хамрагддаг талаарх хов жив өдөр ирэх тусам газар аван, захиргаанаас тэднийг байнга ажиглаж байхыг хөршийнхөнд нь тушаасан аж.

Жун Сан кино театрт харсан охиныхоо нэрийг олж сонссон даруйдаа тэдний гэр бүлийн тухай хов яриаг ч бас дуулав. Ийм охинтой орооцолдох нь ирээдүйд ямар балаг тарьж болох талаар Жун Сан сайтар ойлгож байжээ. Тэр хулчгар биш ч улс даяар ноёрхож байсан Күнзийн системийн бүтээгдэхүүн, дуулгавартай хүү учраас аавынхаа төлөө, ачийг нь хариулахаар төрсөн гэдэгтээ төгс итгэдэг тул мөрөөдлийг нь биелүүлэхээр Пхеньяны Их Сургуульд орохоор шамдан бэлтгэж байв. Тиймээс хамгийн сайн дүн авч, хатуу чанд сахилга баттай байх ёстой. Багахан ч гэсэн зөрчил гаргах л юм бол сүйрэх магадлалтай. Учир нь өөрийнх нь гэр бүлийн гарал үүсэл ч эргэлзээтэй байжээ.

Жун Саны эцэг эх дэлхийн хоёрдугаар дайны сүүлээр, бараг хоёр саяд хүрээд байсан Япон дахь солонгосчуудын нэгэн гэр бүлийн гишүүн болж Японд мэндэлсэн байна. Уг нь тэд Японд сурахаар очсон нийгмийн элит хэсгийнхэн, Японы дайнд туслахаар дайчлагдсан иргэд, цагаачилсан ажиллах хүчин гээд төрөл бүрийн хүмүүсээс бүрдсэн Солонгосын нийгмийн нэгэн хэсэг байжээ. Зарим нь баяжсан ч, зарим нь ядуугаараа. Тэд буцаад нутагтаа очихыг хүсэвч, чухам аль Солонгос нь тэдний эх орон бэ гэдэг асуултад хариулт олдохгүй байв. Солонгос улс хоёр

хуваагдсаны дараа Япон дахь солонгосчууд дагаад хоёр хуваагдав. Хойд Солонгосыг дэмжигчдийг нэгтгэсэн Солонгос Иргэдийн Нэгдсэн Холбоо хэмээгч байгууллага ч бий болж.

Эдгээр үндэстний үзэлтнүүдийн хувьд Хойд Солонгосыг дэмжих шалтгаантай байв. Учир нь тэд л Японы түрэмгийлэгчдээс улс орноо аварсан байхад, Өмнөдүүдийг Япончуудтай хамтран ажилласан гэж үзсэн аж. 1960 он хүртэл Хойд Солонгосын эдийн засаг Өмнөдийнхөөсөө хамаагүй хүчирхэг байжээ. Хойд Солонгосын үзэл суртлын хэрэгслүүд улаа бутарсан хацартай хүүхдүүд талбай дээр тоглож, агуу их удирдагч Ким Ир Сений ивээл дор шинээр байгуулагдсан улс цоо шинэ машин техникээр арвин ургац хураан авч буйг сурталчилж, Япон дахь солонгосчуудын сэтгэлийг татдаг байв. Одоо бол тэдний хийсэн шиг хуурамч суртал ухуулга, зар самбарыг хэн ч тоохгүй өнгөрөөх хэмжээний мэдээлэл газар сайгүй бий болж. Гэтэл тэр үед суртал гэдэг итгэл төрүүлэхээр, сэтгэлд ойрхон санагддаг байжээ.

Наян мянга гаруй хүн уг сурталчилгаанд автсаны дотор Жун Саны эмэг ээж, өвөг эцэг нар оржээ. Жун Саны эцгийн талын өвөө нь Японы Коммунист Намын гишүүн бөгөөд зүүний үзлээсээ болж шоронд хүртэл сууж байсан нэгэн. Шинээр байгуулагдсан улсдаа хувь нэмэр оруулахад хэт хөгшиднэ хэмээн өөрийгөө үзсэн өвөг эцэг том хүү нь болох Жун Саны эцгийг Хойд Солонгос руу илгээсэн байна. Жун Саны эцэг 1962 онд Япон тэнгисээр 21 цагийн туршид усан онгоцоор аялсны эцэст Хойд Солонгосын барааг харсан гэнэ. Инженер мэргэжилтэй түүний хэрэгцээ улс оронд тун их байсан учир түүнийг Чонжины ойролцоо нэгэн үйлдвэрт хуваарилжээ. Хэдэн жилийн дараа эцэг эхтэйгээ хамт Японоос өөртэй нь ойролцоо хугацаанд ирсэн нэгэн дэгжин бүсгүйтэй танилцав. Жун Саны эцэг гэрсэг, шувтан цээжтэй, муруй нүүртэй хэдий ч боловсролтой, ухаантай нэгэн байсан ба гэрийнхэн нь түүнийг "царайгаараа бол далайн дээрэмчин, хэл яриагаараа харин цэцэн зохиолч" хэмээн хошигнон шоолдог байж. Уйгагүй зүтгэл, сайхан сэтгэлээрээ залуу сайхан эмэгтэйн сэтгэлийг татаж эцэст нь түүнтэй гэрлэжээ.

Жун Саных бусдыгаа бодвол амьдралын түвшин арай дөнгүүр байсан нь түүний эцэг эх мөнгөө сайн зохицуулж сурсных. Тэд хахууль өгч тусдаа байшин олж авсан нь ардаа ногооны талбайтай байж таарч, том завшаан болов. 1990 он хүртэл Хойд Солонгосчууд хувьдаа тариа ногоо тарих эрхгүй байлаа. Гэртээ тэднийх дотроо дүүрэн хөнжил хувцастай таван том хувцасны шүүгээтэй. Шалан дээр гудас зулж тавиад унтдаг, өглөө босоод хурааж ханын шүүгээнд хийдэг. Айл хэдэн хувцасны шүүгээтэйгээрээ зиндаа нь тодорхойлогддог учраас эднийх нэлээд чинээлэг айлын тоонд орно. Тэднийх цахилгаан сэнс, зурагт, оёдлын машин, хөгжим тоглуулагч, зургийн аппарат, тэр ч бүү хэл маш ховор боловч дотор нь хийх хангалттай хүнс байхгүйгээс төдийлөн хэрэгцээтэйд тооцогддоггүй хөргөгч зэрэг цахилгаан хэрэгсэлтэй байлаа. Хамгийн сонирхолтой нь Жун Саных Солонгос үүлдрийн сэгсгэр үстэй спицтэй төстэй, жижигхэн цагаан нохойтой байв. Хөдөө тосгонд амьдардаг хүмүүс нохойтой боловч бошинтаг хэмээх халуун ногоотой тусгай хоолоор тэжээдэг нохой байдаг гэж урд хожид сонсоо ч үгүй ажээ. Өөрсдийгөө яая гэж байж нохойг тусгай хоолоор тэжээнэ гэдэг байж болшгүй зүйл.

Японоор Кита Чосен хэмээн нэрлэгддэг Японы солонгосчууд тусдаа ертөнцөд амьдарна. Тэд өөрийн гэсэн аялгатай, өөр хоорондоо л гэрлэнэ. Хэдийгээр Японы жинхэнэ тансаг стандартаас хол боловч жирийн иргэдтэй харьцуулахад хавьгүй чинээлэг. Тэд шинээр байгуулагдсан улсдаа ирэхдээ арьсан гутал, сайхан ноосон цамц өмссөн байхад нутгийн иргэд зотон даавуун гутал, гялгар синтетик хувцастай байв. Японд амьдардаг хамаатнууд нь иен илгээдэг тул валютын тусгай

дэлгүүрт орж, цахилгаан бараа худалдаж авдаг байсан ажээ. Зарим нь унаж байсан машинаа хүртэл тээвэрлэж авчирсан боловч сэлбэг хэрэгсэлгүйн улмаас эсвэл эвдэрчихдэг, үгүй бол засгийн газартаа хандивлах хэрэгтэй болно. Нэлээд хэдэн жилийн дараа Японы солонгосчуудын ах дүү, хамаатан саднууд Мангёнбонг92 хэмээх усан онгоцоор Хойд Солонгос дахь ах дүү нартаа зочилж ирэхдээ мөнгө, бэлэг авчирдаг болсон ажээ. Энэ усан онгоцыг засгийн газар нутагтаа валют оруулахыг дэмжих зорилгоор явуулж эхэлсэн байжээ. Төр засаг нь орж ирж байгаа мөнгөнөөс татвар авна. Хэдийгээр ийм давуу талтай боловч Японы солонгосчууд нийгэмд доогуур байр эзэлж байв. Тэд хэдийгээр эх орныхоо төлөө Япон дахь тохитой амьдралаа золиослон байж ирсэн боловч нийгэмдээ сэжигтэй давхаргад хамаарагдана. Тэр нийгэмд Хөдөлмөрийн Намын гишүүн биш л бол мөнгөтэй хэнд ч болов итгэхгүй. Жун Саных гадаад улс оронтой холбоотой байх эрх бүхий цөөхөн айлын тоонд ордог боловч ингэснээрээ бас итгэлгүй хүмүүсийн жагсаалтад багтдаг нь уг дэглэмийн хүчин чадал иргэдээ гадаад ертөнцөөс тасалдагт гол учир нь байлаа.

Японоос ирэгсэд идеалист үзэл санаагаа маш түргэн гээхэд хүрчээ. Түрүүлж ирсэн хүмүүс нь Японд үлдсэн хамаатан садандаа ирэхгүй байхыг сануулсан захидал явуулж байсан ч эзэндээ хүрдэггүй байж. 1970-аад оны эхээр Японы Солонгосчууд олноороо баригдан, ахалж байсан хүмүүс нь цаазлуулж, харин гэрийнхэн нь хөдөлмөрийн лагерьт цөлөгджээ.

Жун Сан эцэг эх нь эдгээр явдлын талаар хоорондоо шивнэлдэж байхыг сэм сонсчээ. Хэн нэгнийг ачихаар ирэхдээ урьдчилж мэдэгдэх нь үгүй. Шөнө дөлөөр машин ирж байшингийнх нь өмнө зогсоно. Тухайн хүн юмаа бэлдэж, баглах гэж нэг хоёр цаг болно. Жун Сан сэтгэлдээ байнгын айдас агуулж, түүнийгээ хэн нэгэнд илэрхийлж чадалгүй, үргэлж дотроо хадгална. Энэ бүхнээс улбаалан тэр юу хэлэхээ сайтар бодож ярьдаг ухаанд суралцсан байлаа.

Жун Сан өөртөө дайсан бэлдэхгүй байх талаар бас анхаарна. Хүүхдүүдийн ихэнх нь оймсгүй нүцгэн хөлдөө гутал угласан байхад Жун Сан зузаан ноосон оймс өмсөх боловч баригдахгүйн тулд урт өмдөөр далдална. Тэр хожим нь өөрийгөө махчин араатнаас сэргийлэн үргэлж дээд сэргийн өндөр сэрэмжтэй байдаг хоёр том чихтэй амьтантай зүйрлэсэн сэн.

Хэдийгээр зузаан ноосон цамц, цахилгаан хэрэгсэл, сайхан хөнжилтэй байсан ч сэтгэл санааны хувьд Жун Саных Ми Раныхаас дээрдэх юм бараг үгүй. Японоос ирэхдээ царайлаг, алдартай охин байсан Жун Саны ээж хөгшрөх тусмаа ямар ч баяр жаргалгүй хүн болон хувирч, өөрийнх нь бодлоор үр дүнгүй өнгөрөөсөн охин насандаа харамсан уйтгарлах болов. Дөрвөн хүүхэд төрүүлснийхээ дараа тэр сайн тэнхэрсэнгүй. Оройд аав нь тамхи татан, гүн санаа алдан чимээгүй сууна. Хүн чагнаж байгаа вий гэж санаа зовсондоо биш зүгээр л сурснаараа тэд шивнэлдэн, зөөлөн ярина. Тусдаа байшинд байгаагийн давуу тал нь хүн сонсчихно гэж зовох явдал бага байлаа. Гэвч тэд хэзээ ч хүссэнээ, юу мэдэрч буйгаа чангаар илэрхийлж зүрхэлдэггүй байв. Тэдэнд социализмын энэ диваажинг орхиж, капиталист Япон руу буцмаар байгаагаа илэрхийлэх зүрх үгүй.

Хүн болгон сэтгэлдээ харамсал тээвч илэрхийлж ярихгүй. Энд ирсэн нь алдаа байсныг өдөр ирэх тусам улам илүү ухамсарлах болов. Япон руу буцна гэдэг боломжгүй зүйл нь тодорхой.

Тиймээс тэд байгаа байдалдаа сэтгэл ханамжтай амьдрахыг эрхэмлэх болов. Тэдний хувьд цорын ганц найдвар нь нийгэмд тогтсон шатаар дээш авирах явдал байлаа. Тиймээс гэр бүлийн найдвар Жун Сан дээр тогтоно. Хэрэв тэр л Пхеньяны Их Сургуульд орж суралцаж чадвал яваандаа Хөдөлмөрийн Намд элсэн орох зөвшөөрөл авч, гэр бүлийнх нь Японтой холбоотой гутамшиг холдон одох байв. Байнгын дарамт Жун Саны уур уцаарыг хүргэж шийдэмгий бус байдалтай болгоно. Тэр кино театрт харсан охиныхоо тухай мөрөөдөн, танилцах эсэхээ шийдэж ядан эргэлзэвч ямар ч алхам хийсэнгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

ҮНЭНЧЭЭР ИТГЭГЧИД

Хойд Хамёнг мужийн төв Чонжин бол Хойд Солонгосынхоо стандартаар ч мууд тооцогдох, амьдрах хүсэл төрөхөөргүй хот. Хагас сая хүн амтай энэхүү хот Япон тэнгисийн эргийг өгсөж уруудан тахиралдсан боржин уулын хормойд оршино. Уг эргийн шугам Мэйн муж улстай зүйрлэхүйц үзэсгэлэнтэй, ус нь гүн, хага ташим хүйтэн, сайн, бөх завьгүй бол загасчлахад бэрх. Уулс нь салхийг төдийлөн сайн хааж чаддаггүй учраас газар тариалан хөгжих боломж тааруу, өвөлдөө хасах 40 хэм хүртэл хүйтэрнэ. Нам доор газар орших эргийн дагуу л Солонгос үндэсний хоолны цөм болох цагаан будаа тариалах боломжтой. Түүхээс үзвэл солонгосчууд амьдралдаа гаргасан амжилтаа хөдөөгөөс хэр хол, хотожсон төв хэсэгт хэр ойрхон байгаагаараа хэмждэг. Энэ бол ганц Солонгос ч биш Ази үндэстний онцлог юм. Чонжин нь Солонгосын газрын зураг дээр тэмдэглэгдээгүй, нутгийн алс хойд захад Пхеньянаас илүү Оросын Владивостоктой ойролцоо оршино. Өнөөдөр ч Чонжиноос Пхеньян хүртэл асар аюултай эргэлтүүдтэй шороон замаар 330хан км газрыг гурав хоног туулж хүрнэ.

Чусан гүрний үед нийслэл нь одоогийн Сөүл хотын орчимд байхад хаандаа үнэнч бус зан гаргасан албатуудыг энд цөлдөг байжээ. Тэдний ген үлдсэн ч юм уу, одоогийн Хойд Хамёнг мужид хамгийн тэсвэртэй, бас хурц хүмүүс төрж өссөн байдаг.

Хорьдугаар зуун хүртэл Солонгосын хамгийн хойд захын Түмэн голоор Орос Хятадтай хиллэдэг энэ муж хүн амын нягтшил сийрэг, эдийн засгийн хувьд ч тааруу байв. Өнгөрсөн зуунуудад хүүхдийг айлгадаг Солонгос үлгэр дэх барын тооноос Чонжины хүн амын тоо бага шахуу байжээ. Гэтэл өнөөдөр бар гээч амьтан байхгүй шахам болжээ. Эдгээр бүх зүйл Японы эзлэн түрэмгийлэлтэй хамт өөрчлөгдөж. Хойд Хамёнг муж нь япончуудын Дэлхийн хоёрдугаар дайны үед Манжуур руу довтлохоор зэхэж байсан замд байрлаж асан болохоор тэд түшиц газраа болгохоор төлөвлөж байв. Хоёрдугаарт тэд Мусаны эргэн тойронд олборлоогүй нүүрс, төмрийн хүдрийг их хэмжээгээр олборлож эх орон руугаа ачдаг байжээ. Тэр үеийн загасчдын жижигхэн тосгоныг тэд жилд гурван сая тонн ачаа тээвэрлэх чадал бүхий усан боомт болгон өөрчилсөн аж. 1910-1945 оны Японы ноёрхлын үеэр япончууд Чонжин боомтод том том ган хийц барьж, өмнө зүгт тэлэн, Нанам орж, гурвалжин хайстай орчин үеийн өндөр байшинтай хот болгосон гэдэг. Японы Эзэн Хааны Армийн явган цэргийн 19-р дивиз Зүүн Хятадыг булаан эзлэхэд тусалж байсан ба удирдлагын төв нь тэнд байрлаж байжээ. Эргийг уруудаад сумны даринаас эхлээд тариалангийн бордоо хүртэл үйлдвэрлэдэг химийн үйлдвэрийн томоохон төвийг Хамун хотод бий болгосон байна.

1950иад онд коммунистууд засгийн эрхэнд гарснаар дайнд сүйдсэн үйлдвэрүүдийг сэргээн засварлаж, өөрсдийн өмч хэмээн зарлав. Хойд Солонгосын томоохон үйлдвэрийн нэг болох Чонжины Япон Төмөрлөгийн Үйлдвэрийг Кимчэкийн Ган, Төмөрлөгийн үйлдвэр болгон хувиргажээ. Ким Ир Сен зүүн хойд бүсийн үйлдвэржилтийг өөрийнхөө амжилтын дээд нь болгон бахархангуй сурталчилж эхлэв. Өнөөг хүртэл Чонжины оршин суугчид хотынхоо өнгөрсөн

түүхийн талаар мэдэх юм бараг үгүй, учир нь Хойд Солонгосын дэглэм япончуудын бүтээн байгуулалтыг хүлээн зөвшөөрөхөөс илт татгалздаг. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улсын хэмжээнд Чонжины нэр төр, хүн ам өсөн нэмэгдэж, 1970-аад он гэхэд уг хот 900,000 гаруй хүн амтай, Хойд нутгийн хоёр дахь том хот болон өргөжин тэлжээ. (Одоо бол Чонжины хүн ам буцаад 500,000д хүрч, Хамуны дараа орсноор улсынхаа гурав дахь том хот болжээ) Төмөр гангийн хот хэмээгддэг асан Чонжин хот төмөр гангийн үйлдвэртэйхээ хувьд эдийн засаг, стратегийн ач холбогдол нь өсөн нэмэгдсээр л байлаа. Цаг, зурагт, нийлэг эд, эм, трактор, тоног төхөөрөмжийн эд анги, анжис, зэвсэг үйлдвэрлэнэ. Хавч, сам хорхой зэрэг далайн гаралтай бүтээгдэхүүн экспортолно. Боомтыг усан онгоц үйлдвэрлэх зориулалтаар ашиглаж эхлэв. Тэд мөн эргийн дагуу байрлаж асан Японы цэргийн баазуудыг мэдэлдээ авч, Япон руу довтлох пуужингийн бааз байгууллаа. Гэвч эргэн тойрны тосгод нь нийгмийн сэжигтэй давхаргынхан амьдардаг цөллөгийн зориулалттай байжээ. Гэтэл стратегийн ийм чухал ач холбогдолтой хотыг найдваргүй хүмүүсийн гарт орхиж болохгүй учир үндсэн давхаргаас боловсон хүчнүүдийг Чонжин руу дайчилж эхлэв. Чонжин хотыг захирдаг элит гаралтай хэсгийнхэн доод давхаргынхантай яг нэг дор биш ч ойрхон амьдарна. Энэ бөглүү хотод нийгмийн дээд доод давхаргын гишүүд нэг дор зохицон амьдарч буй нь Чонжин хотыг илүү сонирхол татам болгож байв.

Сонг Хи Сук бол нийгэмдээ, удирдагчдаа үнэн голоосоо итгэгсдийн нэг байжээ. Дөрвөн хүүхдийн эх, үйлдвэрийн ажилчин тэрбээр Хойд Солонгосын үлгэр жишээ иргэдийн нэг. Ким Ир Сений гаргасан лоозонг ямар ч эргэлзээгүйгээр цээжилж сахин биелүүлнэ. Хатагтай Сонг (Тэнд эмэгтэйчүүд тэр бүр нөхрөөрөө овоглоод байдаггүй) амьдарч буй нийгэмдээ сэтгэл хангалуун, идэвхи зүтгэлтэй. Хэтрүүлж хэлсэн хүнд суртал ухуулгын шинжтэй киноны гол баатар гэмээр нэгэн байв. Залуудаа ч яг л ийм дайчин эмэгтэй байж. Түүний төрх Ким Чен Иррийн кинонуудын гол баатрын дүрд хамгийн сайн тохирно. Төгрөг саран мэт дугариг, булцгар царай нь хоол муутай байсан ч үргэлж цатгалан мэт харагдуулдаг, нуман хэлбэрийн ам нь уйтгартай байсан ч баяр баясгалантай мэт сэтгэгдэл төрүүлнэ. Налчгар хамар, эрэмгий харц нь итгэж болох үнэнч шударгыг нь илтгэнэ.

Өөрийнх нь шүтэж, хүчин зүтгэж ирсэн тогтолцоо нь худал хуурмаг, муу муухайгаар дүүрэн байсныг мэдсэнийхээ дараа ч хатагтай Сонг итгэл үнэмшилдээ үнэнч байсан юм. Надтай анх уулзахдаа тэрбээр "Би зөвхөн маршал Ким Ир Сен болон эх орныхоо төлөө амьдарч байлаа. Үүнээс өөр бодол надад нэгээхэн ч удаа орж ирж байгаагүй" хэмээн ярьсан билээ.

Хатагтай Сонг Дэлхийн хоёрдугаар дайны сүүлчийн өдөр буюу 1945 оны наймдугаар сарын 15-ны өдөр мэндэлжээ. Аав нь механикч хийдэг байсан төмөр замын ойролцоо түүний бага нас өнгөрч. Солонгосын дайн эхлэхэд АНУ-ын тэргүүлсэн НҮБ-ын хүчин эсрэг талаа холбоо харилцаагүй болгохыг зорьж байсан учраас төмөр замыг сэхээ самбаагүй бөмбөгдөнө. АНУ-ын Тэнгисийн Цэргийн Миссури тэргүүтэй байлдааны хөлөг онгоцууд Япон тэнгисээс Чонжин болон эргийн бусад хотууд руу галлаж байв. Америкийн байлдааны нисэх онгоцууд толгой дээгүүр эргэлдэж хүүхдүүд айн зугтаана. Заримдаа онгоц, нисэгч нь харагдахаар доогуур ниснэ. Өдрийн цагаар хатагтай Сонгийн ээж зургаан жаахан хүүхдээ чирч ууланд нуух ба шөнө буцан ирж

байрныхаа өмнө ухсан нуувчиндаа унтана. Хатагтай Сонг айсандаа ээж эгч нарынхаа бөөрөнд наалдан хярдаг байжээ. Нэгэн өдөр ээж нь хүүхдүүдээ ууланд орхиж аавынх нь байдлыг мэдэхээр явж. Урд шөнө нь бөмбөгдөлт болж вагоны эд анги хийдэг нэгэн үйлдвэр газрын хөрснөөс арчигдсан гэж сонссон байж. Ээж нь уйлсаар орж ирэв. Эцэг чинь алагдсан байна хэмээн өвдөг дээрээ сөхрөн мэгшив. Хүүхдүүдийнхээ дунд ээж нь их удаан уйлжээ.

Аав нь алагдсан явдал хатагтай Сонгийн дайсныг үзэн ядах үзлийг нь хурцалж, эх орондоо үнэнч байх итгэлийг нь нэмэгдүүлсэн юм. Хүүхэд ахуйн хамаг сайхан үеэ дайны хөлд өнгөрөөсөн хатагтай Сонг амьдралынхаа утга учрыг Хөдөлмөрийн Нам болгож, нам юу хэлнэ түүнийг биелүүлэхэд бэлэн хэмжээнд үзэл санаа нь төлөвшжээ. Тэр Ким Ир Сентэй адил ядуу гарал үүсэлтэй, амьдрал нь ч сайн биш болохоор намын гишүүн болох зам нь төдийлөн бэрхшээлтэй байсангүй. Өө сэвгүй гарал үүсэлтэй, коммунизмын үзэл суртлыг амьдралын зорилгоо болгосон ийм эмэгтэй сайн хүнтэй гэрлэх нь тодорхой байж. Ингээд хайрт намынх нь нэгэн ажилтан одоогийн нөхөртэй нь танилцуулжээ. Тэр нь бас намын гишүүн. Хатагтай Сонг өөрийгөө намын гишүүн бус хүнтэй гэрлэнэ гэж төсөөлсөн ч үгүй. Нөхөр Чанг Богийнх нь эцэг нь дайны үед тагнуулын алба хашиж байсан нэлээд сайн намтартай нэгэн. Дүү нь Хойд Солонгосын Ардын Аюулгүй Байдлын Яаманд алба хашна. Өөрөө Ким Ир Сений их сургуулийг сэтгүүлчээр төгссөн ба энэ нь дэглэмийн хамгийн чухал мэргэжилд тооцогддог байсан учраас Чанг Бо ирээдүйтэй гэдэг нь тодорхой байлаа. Ким Ир Сен намын үзэл сурталд тохирсон нийтлэл бичдэг сэтгүүлчид бол манай нийгмийн баатрууд хэмээн тунхаглан зарласан ажээ.

Чанг Бо чацархаг, үеийнхнээсээ хавьгүй өндөр залуу.

Харин хатагтай Сонг метр тавин хоёр хүрэхтэй үгүйтэй учраас нөхрийнхөө сугаар л татна. Царай зүсээр бусдын доор орохооргүй, улс төр болон гарал үүслийн хувьд өөгүй залуу хос Пхеньянд амьдрах шалгуурыг ядах юмгүй хангахаар байв. Зөвхөн Пхеньянд л гаднын зочид олноор ирдэг учир удирдагч уг хотод ихээхэн анхаарал тавьж оршин суугчдыг нь гадаад төрх, үзэл бодлоор нь шалгаруулан сонгодог байна. Гэтэл тэд Пхеньянд бус Чонжин руу томилогдсон учир нь тэдний мэргэжил мэдлэг, чадвар чухам тэнд илүү хэрэгтэй байсных. Гэхдээ Чонжин хотод амьдрахдаа тусгай хангамж авах бөгөөд хотын хамгийн сайхан хэсэгт төвхнөжээ.

Үл хөдлөх хөрөнгө буюу байр орон сууцыг хувиарлахдаа тухайн хүний нийгмийн давхаргыг харгалзан үздэг нь хүн бүхэн тэгш эрхтэй байх ёстой гэсэн Хойд Солонгосын үндсэн үзэл баримтлалын эсрэг юм. Амьдрахад хамгийн тохь тух муутай дүүргүүдэд хотын өмнөд хэсэг орох бөгөөд тэнд уурхайн ажилчид баян хуур хэлбэртэй нэг давхар байшинд амьдарна. Хойшоо чиглэх тусмаа байдал улам л муудна. Нанам руу ойртох тусам байшингуудын давхар өндөрсөж арван найм буюу тэр үеийн хамгийн өндөр давхарт хүрнэ. Хэдийгээр цахилгаан шат огт тавиагүй боловч барилгачид цахилгаан шатны босоо үүр хийж үлдээжээ. Дайны дараах барилгуудын ихэнхийнх нь архитектур Солонгос ахуйд тохируулан өөрчилсөн зүүн Германы загварынх. Давхруудын хооронд шалны халаалтын систем суулгахад зориулсан зайтай ба орон сууц бүрт айл өрхөд зарлал хүргэх зориулалт бүхий чанга яригчийг байрлуулсан байна.

Чонжин орчин үеийн Пхеньянаас хол хоцрогдсон хот. Гэвч Хойд Хамёнг мужийн төв энэ хотод мужийн томоохон засаг захиргааны төвүүд, Хөдөлмөрийн Намын штаб байрлана. Уг хот их

сургуультайгаас гадна, металлурги, уул уурхай, хөдөө аж ахуй, урлаг, гадаад хэлний дээд сургууль, гурван ч театрын дээд сургууль ба нэлээд хэдэн театр, Ким Ир Сенд зориулсан хувьсгалын түүхийн музейтэй. Зүүн боомтын эсрэг талд гадаадын зочид гийчдэд зориулсан Чонмасан зочид буудал байрлах ба ойролцоо нь Оросын Элчин Сайдын Яам оршино. Хотын гудамж, талбайг Москва болон бусад коммунист хотуудын адил төр засаг иргэдээсээ илүү эрх мэдэлтэйг харуулах зорилготойгоор асар томоор барьж байгуулсан байна. Хамгийн олон хүнтэйг нь нэгдүгээр гудамж хэмээн тодотгох ба өргөн нь хотынхоо өргөнтэй тэнцэхүйц. Гудамж нь зургаан эгнээ машин зэрэгцэн явахаар өргөн боловч тийм олон машин уг хотод үгүй. Хоёр талаар нь хуайс мод эгнүүлэн тарьж үндсийг нь цагаанаар будсан харагдана. Цагаанаар будсан учир нь хортон шавьж ба хүйтнээс хамгаалах, эсвэл төрийн учир тайрч огтолж үл болно гэдгийг харуулах зорилго гэхчилэн тайлбарлана. Замын хашлагыг бас цагаанаар будсан байна. Эгнэсэн моддын хооронд улаан өнгөөр будсан уриа лоозон бүхий самбарууд, харин ард нь хааяа нэг ёлтойж харагдах гудамжны гэрлүүдийг байрлуулсан байдаг. Явган зам нь Champs Elysees хэмээх Францын алдарт гудамжтай адил өргөнтэй боловч тэртэй тэргүй цөөхөн машинтай болохоор хүмүүс машин замаар явахыг илүүд үзнэ. Гэрэл дохио гэж үгүй учраас дохиур барьсан замын цагдаа робот маягийн хөдөлгөөнөөр хөдөлгөөнийг зохицуулна. Гол зам Ким Ир Сений 3.6 метр урт хөргөөр өмнө талаа чимсэн Хойд Хамёнг мужийн Театрын үүд хүрээд дуусна. Харин театрын араар буюу Нака уулаар хотын зүүн хойд хэсэг төгсөх бөлгөө. Өдгөө уулын модыг тайрч, бэлд нь оршуулгын газар харлах болсон ч уул үзэсгэлэнтэй хэвээр. Чонжин хотын төв анх харахад аятайхан сэтгэгдэл төрүүлэх боловч сайтар ажиглавал барилга байшингуудынх нь цемент ховхорч унасан, гудамжны гэрлийн шонгууд гулзайсан нь мэдэгдэнэ. Гэвч Чонжинд цөөхөн ирэх гийчид үүнийг тэр бүр анзаараад байдаггүй биз.

Хатагтай Сонгийн гэр цахилгаан шатгүй найман давхар орон сууцны хоёр давхарт байрлана. Байр нь дотроо устай, бие засах газартай болохыг хараад Сонг ихэд баярлажээ. 1960аад онд Хойд Солонгост ийм байранд амьдрах нь хэрийн хүнд, ялангуяа гарал доогуур хүнд олдохгүй завшаан билээ. Шалнаасаа халдаг ба халаалтыг цахилгаан станцаас нэгдсэн байдлаар дамжуулна. Залуу хосод тавилга гэж гавихаар зүйл байсангүй. Тэднийх хоёр өрөөтэйн нэг нь эцэг эхийнх, нөгөө нь хүүхдүүдийнх. Ууган охин Ок Хи 1966 онд төрснөөс хоёр жилийн дараа бас нэг охин, түүний дараа гуравдахь охин нь мэндэлжээ. Тухайн үедээ эмэгтэйчүүд хүүхдээ эмнэлэгт төрүүлэхүйц хэмжээнд анагаах ухаан нь хөгжсөн байсан ч хатагтай Сонг бүх хүүхдээ эх баригчийн ч тусламжгүйгээр, өөрөө төрүүлжээ. Тэр харагдаж байгаатайгаа адилхан зөөлөн биш, бэрхшээлтэй тулгараад ирэхээр чанга хатуу бүсгүй байлаа.

Хатагтай Сонг сагстай хувцас барин угаалгын газар руу явж байх замдаа нэг охиноо төрүүлж. Түүнийг ууган охиноо төрүүлэхэд нялх биетэй эхийн алдсан төмрийн дутагдлыг нөхөх, тэнхрүүлэх зорилготой, далайн нялцгай замган шөлийг хадам эх нь хийж өгчээ. Харин ахиад охин төрүүлэхэд нь сэтгэл дундуур байгаагаа илэрхийлэн шөл хийж өгсөнгүй, өөдөөс нь замаг шидээд "өөрөө шөл хийж уу" гэжээ. Гурав дахь охиноо төрүүлснийх нь дараа хадам эх нь хатагтай Сонгтой дуугарахаа больсон байна. Тэгээд чи охин төрүүлэхээс өөр юм мэддэггүй амьтан байна гэж дарамталжээ.

Хатагтай Сонг цөхөрсөнгүй. Түүнийг гэртээ ганцаараа байхад нь дөрөв дэх хүүхэд нь

мэндэлжээ. Хэвлийгээр нь базлаад байхаар нь ажлаасаа эрт ирсэн боловч зүгээр сууж чадахгүй зангаараа шалаа зүлгээд л байж. Гэтэл гэнэт хамаг бие нь шархирч өөрийн эрхгүй угаалгын өрөөг зүглэв. Эцэст нь хүү мэндлэв. Гэр бүлийнхэн нь баярлаж, хадам ээж нь түүнд далайн замгийн шөлөө ахин хийж өгөх нь тэр.

Чангбо томилолтоор явсан байсан учир хүүтэй болсноо тухай маргааш нь олж мэдэв. Тэр ажлаа дуусгангуутаа эхний галт тэргээр гарахдаа шинээр мэндэлсэн хүүдээ дугуй худалдаж авахаа мартсангүй.

Дөрвөн хүүхэдтэй, гэрийн ажилтай байсан ч хатагтай Сонг долоо хоногийн зургаан өдөр, бүтэн цагаар Чусаны Хувцасны Үйлдвэрийн өдөр өнжүүлэх бүлгийн санхүүгийн тасагт туслах ажилтнаар ажиллана. Хөдөлмөрийн насны залуучуудын хорин хувь нь цэргийн албанд дайчлагдсан болохоор үйлдвэрүүдийг эмэгтэйчүүд нуруун дээрээ авч явахаас аргагүй. Хойд Солонгос нэг хүнд ноогдох цэргийн тоогоороо дэлхийд тэргүүн байр эзэлдэг. Хатагтай Сонг нэг хүүхдээ үүрч, нөгөө хоёрыг нь хөтлөн ажилдаа ирнэ. Хүүхдүүд нь үйлдвэрийн өдөр өнжүүлэх бүлэгт хүн болжээ. Өдөрт найман цаг ажиллах ба үдийн хоолны завсарлагаар ээлж хүлээлцэх хооронд дуг хийж амжина. Ажлын дараа үйлдвэрийн хурлын танхимд хэдэн цагаар үргэлжлэх үзэл суртлын ухуулгад суух хэрэгтэй болно. Нэг өдөр нь Америкийн империалистуудтай тэмцэх тухай ярих бол нөгөө өдөр нь Ким Ир Сен дэлхийн хоёрдугаар дайны үеэр япончуудтай хэрхэн дайтаж байсан талаар бодит болон хэтрүүлэгтэй түүхүүдийг ярьж өгнө. Намаас гаргасан шийдвэрүүдийн талаар өгүүлэл бичиж, мөн Ханбук Илбо сонины товчлол хийнэ. Энэ бүхнийг дуусгаад гэртээ ирэхэд 22 цаг гучин хоромд болсон байна. Хоолоо хийгээд гэр орноо цэвэрлэснийхээ дараа л унтаад өглөө үүр хаяарахаас өмнө босож гэрийнхнийхээ унд цай, хувцас хунарыг бэлдэнэ. Ингээд долоо хагаст гэрээсээ гарч ажил руугаа явна. Тэр таваас илүү цаг унтаж бараг л үзээгүй. Долоо хоног бүрийн Лхагва гаригийн өглөө Социалист Эмэгтэйчүүдийн Холбооны Хуралтай учир эрт ажилдаа ирнэ. Баасан гаригийн орой өөрийгөө шүүмжлэх хуралтай. Энэ хурлын үеэр тасгийнхан нь нэг нэгээрээ босож, өөрийн хийсэн алдаа дутагдлыг ний нуугүй ярих ёстой. Үүнийг Католик шашны гэмээ хүлээдэг заншлын коммунист хувилбар гэлтэй. Хатагтай Сонг үргэлж би сайн ажиллаж чадахгүй байгаа хэмээн үнэн зүрхнээсээ өөрийгөө шүүмжилнэ. Тэрбээр өөрийн хэлсэндээ бүрэн итгэлтэй байлаа. Нойр дутуу өнгөрөөсөн өдрүүд, өөрийн шүүмжлэл, урт лекцүүд зэрэг тархи угаах хэрэгслүүд нь өөр юм бодох ч сэхээ өгдөггүй байж. Сонг хатагтай үнэхээр Ким Ир Сений хүссэн бие хүн болсон байлаа. Ким Ир Сений зорилго нь шинэ улсыг байгуулахад биш илүү сайн хүмүүсийг бий болгох буюу хүний мөн чанарыг өөрчлөх явдал байсан бөлгөө. Иймээс тэр чухе хэмээн нэрлэх өөрийн философийг бий болгож түүндээ Маркс, Энгельсийн үзэл санаанаас тусгасан ба "өөртөө итгэх" хэмээн орчуулагдсан байдаг.

Чухегийн гол санаа нь хүн бүх зүйлийн эзэн бөгөөд бүхнийг шийднэ. Гэхдээ ядуу нь баянтайгаа, тариачин нь газрын эзэнтэйгээ тэмцэж хүн бүр тэгш амьдрах ёстой хэмээн номлодог. Өөрөөр хэлбэл хүнийг бурхан биш хүн өөрөө бүтээсэн гэсэн санаа. Гэвч Ким Ир Сен коммунизмын гол сургаал болох дэлхий дахины эв санааны нэгдэл, нийтлэг байх тухай санааг нь орхигдуулж, Солонгос үндэсний үзлийг хэт шүтдэг нэгэн. Солонгосчууд бол тусгай хүмүүс, бурхнаас онцгой болгон төрүүлсэн гэдэгт итгэж, хүчирхэг хөршүүд болох Япон, Солонгос, Орос улсуудад найдах хэрэггүй хэмээн үзнэ. Өмнөд Солонгосчууд бол Америкаас хараат байдгийнхаа

хувьд шившигтэй хүмүүс. Ким Ир Сен ард түмэндээ хандаж гаргасан олон номлолынхоо нэгэнд "Бид хэнээс ч хараат байх ёсгүй. Хувьсгалаа өөрсдөө манлайлан хийж, эх орноо өөрсдийн хүчээр өөрчилнө. Өөрсдийн хүч чадалдаа итгэж өөрсдийн ухаанаар улс эх орноо хөгжүүлнэ" хэмээн хэлсэн байдаг.

Засгийн эрхэнд гармагцаа Ким Ир Сен Японы эсрэг дайтаж байхдаа олсон санаагаа социализмын үед ард түмнээ хяналтдаа байлгах хэрэгсэл болгон ашиглахаар шийдэв. Тэрээр хувийн хүслээсээ түрүүлж хамт олны эрх ашгийг бодох ёстой хэмээн ард түмэндээ ухуулж байлаа. Ард түмэн нь цорын ганц, агуу их удирдагчдаа ямар ч хэл үггүй захирагдах ёстой. Тэр удирдагч нь Ким Ир Сен өөрөө.

Ингээд тэр ханаж цадсангүй, хайрлуулахыг хүсэж байлаа. Энд тэндгүй хадсан зурагт хуудас, самбарууд дээр Ким Ир Сен өөрийг нь бахархан харж буй улаан хацартай хүүхдүүдийн дунд зогсож, танан цагаан шүд гарган, нүүр дүүрэн инээмсэглэн буйгаар зурагдсан байдаг. Хүүхдийн дугуй, тоглоомууд арын дэвсгэрийг нь дүүргэсэн байх ба үүгээрээ тэр Иосиф Сталинтай биш харин Санта Клаустай адил өгөөмөр удирдагч гэдгээ харуулахыг зорино.

Хонхорхой бүхий хацар нь бусад дарангуйлагчидтай харьцуулахад арай эвэргүү харагдуулна. Ким Ир Сенийг ард түмэн нь эцэг хэмээн хүндэлж, хайрлаж харьцахыг хүснэ. Ким Ир Сен ард түмнийхээ дунд орж, тэднийг бүгдийг нь өөрийн мах цусны тасархай хэмээн ойлгуулахыг хичээнэ. Энэ бол Карл Марксын зорьж байсан коммунизм гэхээсээ илүү бүх хүн өмнө нь бөхийж, нар хэмээн нэрлэдэг Японы хаант засаглалтай илүү адил нийгэм байлаа.

Дарангуйлагч бүрт төстэй зүйл байдаг. Сталины ЗХУ-аас эхлээд Маогийн Хятад, Чаушескугийн Румын, Саддам Хуссейний Ирак гээд бүх дарангуйлагч дэглэмд адил төстэй зүйл бий. Тухайлбал, төв талбайд нь сүндэрлэсэн дарангуйлагчдын хөшөө, албан тасалгаа бүрт өлгөсөн тэдний хөрөг, бугуйн цагны нүүрэн дээр зурсан зураг гээд. Гэтэл тэдгээрээс Ким Ир Сен ялгарч чадав. Чухам юугаараа ялгарсан гээч? Тэр хувь хүнийг шүтэх үзлийг шинэ шатанд гаргасан юм. Тэр хүмүүсийн шашин шүтлэгийг ашиглав. Тэр шашны хүчийг сайтар ойлгосон нэгэн байсан ба коммунист дэглэм тогтохын өмнө, Пхеньяныг зүүн зүгийн Иерусалем хэмээн нэрлэгдэж, Христос шашны төвүүдийн нэг байх үед авга ах нь Протестант урсгалын сүмийн хамба асан бөлгөө. Гэтэл Ким Ир Сен засгийн эрхэнд гармагцаа сүмүүдийг хааж, библи уншихыг хориглож, сүсэгтнүүдийг алс хол цөлж, Христосын хөргүүдийн оронд өөрийнхөө зургийг ард олондоо шүтүүлэх болжээ.

Сурвалжлагч, сэтгүүлчид Ким Ир Сен, Ким Чен Ир-ийн талаар Пентекостал номлогч шиг завсар чөлөөгүй магтан дуулна. Сонинууд нь их удирдагчтай холбоотой ер бусын үзэгдлүүдийн тухай дуу дуугаа авалцан бичнэ. "Живж буй усан онгоцны цэргүүд Ким Ир Сений тухай дуу дуултал далайн шуурга намдаж аврагдав. Ким Ир Сенийг цэрэггүй бүс рүү явж байхад нь Өмнөдийн мэргэн буучийн сумаас түүнийг хамгаалж үл мэдэгдэх хүч манан хөшиг татжээ. Тэр зулган мод дэлбээлүүлж, цас хайлуулах хүчин чадалтай. Хэрэв Ким Ир Сен бурхан юм бол хүү Ким Чен Ир нь бурханы хүү буюу Есүс Христтэй адил болж таарлаа. Ким Чен Ир-ийг төрөхөд гэрэл цацруулсан од тэнгэрт харагдаж, давхар солонго татжээ" гэх мэт. Бид Хойд Солонгосчуудыг шоолон инээлдэж, элэглэдэг. Гэтэл хорвоод мэндэлснээсээ эхлээд ийм үзэл сурталтай нүүр

тулдаг, өдрийн 14 цагийг үйлдвэрийн хүүхэд саатуулах газар өнгөрөөдөг, бүхэл амьдралынхаа турш үзсэн кино, уншсан ном сонин, дуулдаг дуу, гудамжинд хадсан самбар гээд сурталчилгааны бүх хэрэгслээр гагц Ким Ир Сений тухай ярьж, магтан дуулж, түүний талаар эргэлзээ үүсгэж болзошгүй гаднын мэдээлэл нэвтрэх бүх замыг хаасан байхад энэ бүхнийг хэн давж гарч ирэх сэн билээ?

1972 онд Ким Ир Сений 60 насны ой буюу Хойд Солонгосын үндэсний баяраар Хөдөлмөрийн Нам их удирдагчийнхаа дүрстэй энгэрийн тэмдгийг ард түмэндээ тараав. Удалгүй хүн бүр энэ тэмдгийг зүрхнийхээ дээхэн байнга зүүж явах шаардлагатай боллоо. Хатагтай Сонгийн гэрийн цулгүй хананд зөвхөн Ким Ир Сений хөрөг өлгөөтэй байна. Айлууд ханандаа өөр юу ч өлгөхийг төр засгаас хориглох бөгөөд ах дүү хамаатан садныхаа зургийг ч тавьж үл чадна. Ким Ир Сен бол чамд хэрэгтэй цорын ганц хамаатан хэмээн 1980-аад он хүртэл сурталддаг байсан бол түүнээс хойш Хөдөлмөрийн Намын дарга Ким Чен Иррийн, түүний дараахан эцэг хүү хоёрын хамт авахуулсан хөрөг гээд нэг айл энэ гурван зургийг л ханандаа хадах эрхтэй байжээ. Сонин хэвлэлүүд агуу их удирдагчдын хөргийг гал уснаас аврах гэж яваад амь үрэгдсэн баатруудын тухай өгүүлнэ. Хөдөлмөрийн Намаас хөргүүдийг цагаан алчуурын хамт ард иргэддээ үнэгүй тараах бөгөөд тоосыг нь арчих зориулалттай уг алчуурыг тусгай хайрцагт хадгална. Алчуур нь цонхны шилний завсраар орох чийгээс үүсэх хөгц, мөөгөнцөр зэргээс хөргүүдийг хамгаалахад их хэрэг болно. Ардын Хянан Шалгах Хорооноос хөргүүдийг хэр цэвэр хадгалж байгааг сард нэг удаа айл өрхүүдээр явж шалгана.

Хатагтай Сонг шалгалтаас айдаггүй байлаа. Учир нь тэрээр хичнээн яарсан ч өглөө бүр гудсаа хураахдаа, үдийн хоолоо бэлдэж байхдаа, хүүхдүүдээ тоглуулахаар гарахын өмнө ч байнга хөргүүдийг арчина. Хувцасны энгэрт нүх гаргадаг гээд удирдагчийнхаа зурагтай тэмдгээ эмэгтэйчүүд зүүх дургүй байхад хатагтай Сонг дуртай нь аргагүй зүүнэ. Нэгэн удаа хувцсаа сандруу солихдоо тэмдгээ зүүхээ мартаад гарчихаж. Гэтэл гудамжинд Нийгмийн Хэв Журам Сахиулах Бригадын гишүүний таних тэмдэг ханцуйдаа зүүсэн нэгэн өсвөр насны сурагч тааралдаж, тэмдгээ зүүхийг сануулж гэнэ. Эхний удаа тэмдгээ зүүхээ мартсан иргэн сануулга авч, үзэл суртлын сунжирсан лекцэнд сууж хувийн хэрэгтээ тэмдэглүүлнэ. Гэтэл хатагтай Сонг тэмдгээ зүүхээ мартсандаа үнэн сэтгэлээсээ сандарч тэвдсэн тул хүү өрөвдөж түүнийг тэмдгийг нь авчруулахаар явуулсан байна.

Хатагтай Сонг Ким Ир Сений сургаалын дагуу амьдралаа залахыг хичээнэ. Түүнд сургаалиудыг мэдэхгүйн зовлон үгүй. Үйлдвэрийнхээ суртал ухуулгын танхимд олон цагаар сонссон болохоор ихэнхийг нь цээжээр мэднэ. Тиймээс үр хүүхдээ хүмүүжүүлэхдээ хүртэл удирдагчийнхаа хэлсэн үгээс иш татна. Үнэнч шударга байдал, өөрийгөө золиослох чадвар зэрэг нь хувьсгалд зориулах ёстой хувь хүний эрхэм чанарууд юм гэх мэт. Хүүхдүүд нь бид үндэсний удирдагчдадаа бүгдийг зориулах ёстой гэсэн үзлээр хүмүүжиж байв. Хүүхдүүд өөрсдийн төрсөн өдрийг тэмдэглэхгүй атлаа Ким Ир Сений төрсөн өдрийг дөрөвдүгээр сарын 15-нд, Ким Чен Иррийнхийг хоёрдугаар сарын 16-нд тэмдэглэнэ. Энэ өдрүүд үндэсний баярт тооцогдох бөгөөд айл өрх бүрийн нормт хүнсэнд мах дагалдан ирнэ. Хожим цахилгааны хямрал нөмөрсөн жилүүдэд зөвхөн энэ хоёр өдөрт

л айл өрхүүдийг гэрэлтэй өнжүүлдэг байжээ. Төрсөн өдөр болохоос хэдэн өдрийн өмнө Хөдөлмөрийн Нам хүүхэд бүрт хоёр гурван кило хэртэй чихэр жимс тараана. Жигнэмэг, цэлцэгнүүр, шоколад, бохь зэрэг амттан авна гэдэг хүүхдүүдийн хувьд маш их аз завшаантай хэрэг. Гэхдээ яг төрсөн өдөр болтол хүүхдүүд амттаныг идэх эрхгүй. Зарим эхчүүд энэ бичигдээгүй дүрмийг зөрчдөг боловч хатагтай Сонг ягштал дагаж мөрдөнө. Төрсөн өдрөөр хатагтай Сонгийн хүүхдүүд их удирдагчдын хөргийн өмнө бөхийн ёсолж, "Хүндэт эцэг Ким Ир Сен танд баярлалаа" хэмээн хэлэх үед ээж нь хүүхдүүдээ бахадсан харцаар хардаг байжээ.

Олон жилийн хойно хатагтай Сонг энэ бүхнээ эргэн

дурссан юм. Тэр өөрийгөө азгайд тооцож байлаа. Чанг Бо сайн нөхөр байв. Тэр эхнэр хүүхдээ зоддоггүй, халамжтай, архи уусан ч хэр хэмжээгээ мэддэг, уухаараа улам л хөгжилтэй болж, улам таргалаад байгаа гүзээгээ төмбөлзүүлэн хөхөрнө. Тэднийх хайраар дүүрсэн, аз жаргалтай гэр бүл. Хатагтай Сонг гурван охин, хүү, нөхөр, заримдаа хадам ээждээ ч хайртай байлаа. Мөн дээрээс нь Ким Ир Сен эцгээ хайрлана.

Хатагтай Сонг тэр он жилүүдээс тааламжтай дурсамж бүхий хэдэн жилийг санаандаа авч үлджээ. Хатагтай Сонг нөхөртэйгөө хоёулаа амарч, хүүхдүүд нь хичээлдээ явдаггүй зарим нэг Ням гаригийг гэр бүлээрээ өнгөрөөснөө санана. Хоёр жил тэд гэр бүлээрээ гэрээс нь холгүй байх наран шарлагын газар очжээ. Хэн нь ч сэлж чадахгүй учраас бүгдээрээ эрэг даган алхаж, дун түүн гэртээ авчирч хоол хийж иджээ. Нэг удаа хүүгээ 11 настай байхад нь хатагтай Сонг Чонжины амьтны хүрээлэнд дагуулж очжээ. Өөрөө хүүхэд байхдаа тойрон аяллаар амьтны хүрээлэнд очиж үзсэн байв. Түүнийг үзэж байхад тэнд бар, заан, баавгай, чоно байсан бол хүүтэйгээ очиход нь хэдхэн шувуу л үлдсэн байж. Үүнээс хойш хатагтай Сонг амьтны хүрээлэн рүү дахин зүглээгүй гэнэ.

Хүүхдүүд нь өсвөр насанд хүрээд ирэхэд л гэр бүлд нь асуудал үүсэж эхлэв. Дөрвөн хүүхдээс хамгийн хэцүү нь том охин Ок Хи байв. Тэр эхтэйгээ усны дусал мэт адил боловч арай булцгар, мөн үргэлж хөмхий зуулттай явна. Ок Хи хурц ааштай охин болж төлөвшив. Ээж нь уучламтгай, зөөлөн сэтгэлтэй байхад охин нь уцаартай, шаналж зовсон төрхтэй. Гэртээ шөнийн бор хоногт орж ирдэг ажилтай ээжийн том охин болж мэндэлсэн тул тэр гэрийн бүх ажлыг нуруундаа үүрдэг, ийм үүрэг хүлээхдээ төдийлөн дуртай биш байжээ. Ок Хи ээжтэйгээ адилхан учирсан зовлонтойгоо эвлэрээд явдаг зантай хүн биш байж. Тэр амьдралыг нь ямар ч утга учиргүй болгож буй тэнэг зүйлсийг тэвчиж байгаатайгаа эвлэрч үл чадна. Энэ нь залхуу, дуулгаваргүйдээ биш юм. Зүгээр л өөрт утгагүй санагдсан зүйлээ хийхийг хүсдэггүй байв.

Өсвөр насны охид хөвгүүд эх оронч үүргээ биелүүлэхээс гадна заавал хийх ёстой байдаг "сайн дурын ажил" гэгч Ок Хигийн санаанд үл нийцнэ. Хүүхдүүд 12 хүрмэгцээ л намар, хаврын ажилд дайчлагдаж, цагаан будаа тариалах, зэрлэг өвс зулгаах зэрэг ажлыг хийх ёстой. Тэр хаврын ажилд явж нүдийг нь хорсгосон шавьжны хор талбай дээгүүр цацаж, хувин дүүрэн бордоо зөөн гүйж байхдаа хорссондоо байж ядна. Бусад хүүхэд эгнэн алхахдаа Социализмыг хамгаалцгаая хэмээн нэгэн зэрэг дуулж байхад Ок Хи л ганцаараа хөмсөг зангидан дуулахгүй алхана.

Хамгийн хэцүү үе нь орон сууцнуудын нийтийн бие засах газраас "шөнийн бордоо" цуглуулах

ажил байжээ. Химийн бордоо олддоггүй учир хүний ялгадасыг оронд нь ашигладаг байж. Айл өрх бүр долоо хоног тутам хувин дүүрэн ялгадас өгөх ёстой бөгөөд нэлээд зайтай орших агуулахад тушаана. Оронд нь талон өгөх бөгөөд үүнийгээ хүнс болгож авна. Өмхий ханхлуулсан энэ бохир ажил ихэвчлэн хүүхдүүдэд ноогдоно. Ок Хи өөрийн ухаанаа ашиглан ажлаа хөнгөвчлөх арга олов. Тэднийг хуурах тийм ч хэцүү биш байлаа. Ялгадас хадгалдаг агуулах манаачгүй байж. (ялгадсыг хэн л хулгайлаа аж) Тиймээс охин сэмээрхэн агуулах руу орж хувин дүүрэн ялгадас хулгайлаад буцаан тушааж талоноо олж авна.

Ок Хи гэртээ ирээд өөрийн зохиосон бяцхан залиныхаа талаар хөгжилтэйгөөр ярьж өгтөл худлаа хэллээ гэж ээждээ зэмлүүлсэн байна. Ок Хи хүүхдүүдийнх нь дундаас хамгийн сэргэлэн ухаантай гэдгийг хатагтай Сонг гадарлалгүй яахав. Тэр гурван настайдаа байхдаа уншиж сураад Ким Ир Сений урт ишлэлүүдээс цээжилснээ хэлж сонирхуулахад ах дүү хамаатан садан нь бахаддаг байж. Гэвч ялгадас тушаах ажил дээр гаргасан зан ээжийг нь түгшээж, "Ок Хи бол хувиа хичээгч юм байна. Бүх хүн зэрэгцэн алхах ёстой нийгэмд энэ хувиа хичээгч яаж зохицон амьдрах юм бол" хэмээн түгших болжээ.

Охин ахлах сургуулиа төгсөхөд аав нь танил талаараа дамжуулан барилгын компанид ухуулагчийн ажил олж өгөв. Ок Хи төлөвлөгөөгөө давуулан биелүүлсэн бригад болон тэдний ачаар зам засварын ажлаа цаг хугацаанд нь амжилттай гүйцэтгэж байгаа барилгын ангийнхаа үйл ажиллагааг сурталчилж, магтан дуулсан мэдээллүүд бичих үүрэгтэй. Компани өөртөө ухуулгын машинтай. Тэр нь үнэн хэрэгтээ хоёр талдаа "Нийгмийг чучхе сургаалийн дагуу өөрчилъе" гэсэн уриа бичээстэй армийн ямбий фургон. Машин барилгын талбайгаар тойрон явахад Ок Хи бичсэн мэдээллээ чанга яригчаараа уншина. Энэ нь биеийн хүчний биш, хялбар, сонирхолтой ажил бөгөөд бас ухуулга сурталчилгаа хийдгийн хувьд шаггүй нэр хүндтэй.

Эцэг эх нь охиныхоо ирээдүйг баталгаатай болгохын тулд Хөдөлмөрийн Намаас тохирох нөхөр хайж эхэллээ. Хатагтай Сонг охиндоо аав шиг нь хүн олж гэрлүүлэхийг боддог байсан тул нөхөртөө өөрийнхөө залуу хувилбарыг хайх даалгавар өгсөн байв. Чанг Бо томилолтоор явж байхдаа галт тэргэнд сэтгэл татам залуутай зэрэгцэн сууж таарчээ. Чой Ёнг Су Чонжиноос хойхон орших Ражин хотод амьдардаг, бас нэлээд боломжийн гэр бүлээс гаралтай байв. Тэр Солонгосын Ардын Армийн энгийн ажилтан буюу бүрээ тоглодог ажилтай. Гайгүй цолтой, армид алба хашдаг хэн боловч Хөдөлмөрийн Намд элсэх зам нь дардан тул залуу тун ч ирээдүйтэй санагдаж, Чанг Бо гэртээ зочлохыг урьжээ. Ок Хи, Ёнг Су хоёр 1988 онд Хойд Солонгосын уламжлал ёсоор Ким Ир Сений хөшөөний өмнө гэрлэх ёслолоо хийжээ. Ок Хи ухаа өнгийн хүрэм, хар өмд, Ёнг Су бараан өнгийн костюмаар гоёцгоож, асар том хүрэл хөшөөний өмнө зэнзийрхсэн байдалтай зургаа татуулсан байна. Тэд их удирдагчийн хөшөөний өмнө баглаа цэцэг тавин ёсолж, тэр их хүнээр гэрлэлтээ баталгаажуулсандаа сэтгэл хангалуун буцацгаав. Ингээд гэртээ хатагтай Сонгийн бэлтгэсэн идээ ундаа бүхий найр хийжээ. Уламжлал ёсоор бэр болон хүргэний гэрт хоёр цайллага хийх ёстой. Үүнээс үүдэн худуудын хооронд бяцхан өрсөлдөөн болно. Хөршүүд, хамт ажиллагсад уригдан ирж бэлэг сэлт өгдөг учир тэднийг чадлаараа дайлах ёстой. Тэдний өгдөг эд зүйлс нь хөнжил, гал тогооны хэрэгсэл, толь, гоо сайхны ширээ, хэрэв ар гэр нь боломжтой бол цахилгаан бараа, оёдлын машин хүртэл бэлэглэнэ. Хатагтай Сонгийн хувьд нөгөө тал нь өөрсдөөс нь гарал үүслийн хувьд дээгүүр учир бага зэрэг санаа зовж байв. Иймээс тэр бүх чадлаараа

хичээж, баярын ширээг идээ ундаагаар дүүргэв. Цагаан будааны боов, жигнэсэн наймаалж, шарсан дүпү, арзгар хавч болон гурван төрлийн хатаасан загас сэлтийг бэлтгэн ширээнээ өрсөн байлаа. Энэ бол тэдний гэр бүлээрээ хамтдаа барьсан хамгийн элбэг дэлбэг, тансаг зоог нь байлаа.

Ёнг Су юнжу хэмээх гар аргаар нэрсэн, хямд архинд дуртай нэгэн бөгөөд хэдэн аягыг хөнтөрсний дараа хөгжимчний уян налархай зан нь алдагдаж, муу муухай ааш нь цухалзаад ирнэ. Ок Хид түүний биеэ тоосон ихэмсэг зан эхлээд эгдүү хүргэм санагддаг байсан бол сүүлдээ зэвүү нь хүрдэг болов. Залуу хос төмөр замын ойролцоо өөрийн гэсэн байранд нүүж орсон боловч Ок Хи байнга эцэг эхийнхээ гэрт гүйж очно. Нэг өдөр нь нүд нь хөхөрчихсөн явдаг бол маргааш нь уруулаа сэт цохиулсон ирнэ. Гэрлэснийсээ хойш хагас жилийн дараа Ёнг Су хамт ажилладаг залуутайгаа зодоон хийж, цэргийн хөгжмийн чуулгаасаа хөөгдөв. Тэндээсээ Мусан дахь төмрийн хүдрийн уурхайд цөлөгджээ. Одоо түүнд Хөдөлмөрийн Намд элсэх ямар ч боломж үгүй болов. Намын гишүүнд элсэх өргөдлөө хувь хүн хорь гаруй насандаа л гаргах ёстой бөгөөд намын нарийн бичгийн дарга шалгаж шийдвэр гаргах хүртэл тодорхой хугацаа шаардагдана. Намд элсэхгүйгээр албан тушаал дэвшинэ гэж санасны ч хэрэггүй. Тэр үед хүндрэлтэй жирэмслэлтээс болж Ок Хи ажлаасаа гарсан байв. Түүний байдал хэзээ ч ийм хэцүү байсангүй.

Тун ч удалгүй хатагтай Сонгийн хүү санааг нь зовоож эхлэв. Хүү нь Ок Хитэй огт адилгүй, үлгэр жишээч хүүхэд байж. Нам Ок аавтайгаа адилхан биерхүү, шөрмөслөг хүү. Түүнийг дуугаа өндөрсгөхийг, бусадтай хэрэлдэж байхыг харсан хүн бараг үгүй. Эцэг эх, эгч нар нь юу гэнэ, түүнийг л хийнэ. Байгаа эсэх нь ч мэдэгддэггүй хүүхэд гэж Ок Хи эрэгтэй дүүгийнхээ тухай бусдад ярина. Нам Ок сурлагадаа гавихгүй боловч харин спортоор шилдэгт орно. Тэр хана руу бөмбөг өшиглөн ганцаараа тоглож байхдаа их л жаргалтай харагдана. Арван нэгэн нас хүрэхэд нь нэгэн дасгалжуулагч хүүгийн хөл, гарыг хэмжиж үзээд Чонжины биеийн тамирын тусгай сургуульд шилжүүлжээ. Тэр үед хүүхэд өөрөө ч, гэр бүл нь ч бус зөвхөн нам засгаас хэнийг жирийн сургуулиас гаргаж төрөлжсөн сургууль руу шилжүүлэх, үндэсний шигшээ багт оруулах ёстойг шийддэг байжээ. Арван дөрвөн настайдаа Нам Ок Пхеньян руу боксоор хичээллэхээр явлаа.

Ингээд долоон жилийн туршид Нам Ок жилд хоёрхон удаа л гэртээ ирэх зөвшөөрөлтэй байсан агаад нэг ирэхдээ арван хоёр л хононо. Хатагтай Сонг хүүтэйгээ бараг уулзахгүй. Тэр угаасаа л ээжийнхээ энгэрт наалдаад уйлдаг зангүй, дээр нь тийм ч дотно биш харьцаартай байсан бол одоо бүр харь хүн шиг болжээ. Тэгээд хатагтай Сонг хүү нь өөрөөсөө тав эгч хүүхэнтэй учир үүсгэсэн болохыг шивэр авир ярианаас мэдэж авч. Гэтэл хүү нь Пхеньянаас ирэхээрээ гэртээ биш тэр хүүхнийдээ байх болжээ. Энэ бол хоёр шалтгаанаар тун ноцтой хэрэг байв. Хойд Солонгосын эрчүүд уламжлал ёсоор өөрөөсөө эгч бүсгүйтэй болзох ёсгүй, гэрлэхийн өмнө бэлгийн харьцаанд орохыг хориглодог. Хоёрдугаарт, Нам Ок сургуулиасаа, мөн Социалист Залуучуудын Лигээс хөөгдөж, цаашилбал Хөдөлмөрийн Намд элсэх эрхээ хасуулах аюулд ороод байлаа. Айлын ганц хүүгийн хувьд тэр гарал үүсэл сайн эмэгтэйтэй гэрлэж, гал голомтоо авч явах ёстой. Эцэг эх нь бүх учрыг шалгаасан боловч тэр юу ч дуугарсангүй. Гэр бүлийнхнээсээ улам л холдож, амралтаараа ирэхээрээ үзэгдэхийг ч болив.

Нэгэн өдөр Чанг Бо эхнэртэйгээ зурагт үзээд сууж

байлаа. Эднийх байрандаа өөрийн гэсэн зурагттай цөөн айлын нэг. 1989 онд зурагт дундаж ажилтны гурван сарын цалинтай тэнцэх буюу 175 долларын үнэтэй байсан ба худалдаж авахын тулд тусгай зөвшөөрөл хэрэгтэй. Худалдаж авахаасаа илүү, сайн ажилласан хүмүүст Ким Ир Сений бэлэг хэмээн үнэгүй олгодог байж. Аав нь Солонгосын дайны үед Өмнөд Солонгосыг тагнах ажлаа гарамгай гүйцэтгэж байсны учир Чанг Бо зурагттай болоход хүндрэл гарсангүй. Тэдний зурагт хэдийгээр Японы Хитачи брэндийнх боловч Солонгосын Сонгнаму хэмээх нэртэй. Хойд Солонгост зурагт радиог эзэндээ очихоос нь өмнө зөвхөн төр засгийн мэдээллийн сувгуудыг хүлээн авдаг болгон өөрчилнө. Гэлээ ч гэсэн үзэгчдэдээ сонирхолтой л байлаа. Ким Ир Сений шөнө болгон хийдэг номлолыг эс тооцвол спортын уралдаан тэмцээн, концерт, олон ангит жүжгүүд, мөн Ким Чен Ирийн студид бүтээсэн кино гарна. Амралтын өдрүүдээр тусгай хөтөлбөр нэрийн дор Орос кино гаргана. Тэд хөршүүддээ телевиз үзэх бололцоо олгохын тулд хаалгаа үргэлж нээлттэй байлгана. Нөгөө л хамт олонч зангаа хадгалах намын захиасыг биелүүлж байгаа нь энэ.

Чанг Бог асуудалд оруулсан нэвтрүүлэг бол гутлын үйлдвэр бороотой улиралд зориулан усны гутал үйлдвэрлэж буй талаар гарсан мэдээ байв. Үйлдвэрийн ажилчид гутлын дамжлага дээр шаламгайлан ажиллаж, нэг дор хэдэн арван гутал үйлдвэрлэж байгааг дэлгэцээр харуулж, нэвтрүүлэгч гутлын чанарыг магтаж, мөн борлуулалт их байгааг цохон тэмдэглэв.

"Ийм олон гутал үйлдвэрлэж байгаа юм бол миний хүүхдүүд яагаад усны гуталгүй байгаа юм бэ" гэж Чанг Бо чангаар хэлээд инээчхэв. Дараа нь яах билээ гэдгээ бодож ч амжаагүй байхад тэр үг амнаас нь уначихжээ.

Хатагтай Сонг хөршүүдийнхээ хэн нь матсаныг олж мэдэж чадсангүй. Нөхрийнх нь хэлсэн үгийг тэр даруйдаа хорьтын даргад уламжилсан нь цаашлаад Ардын Аюулгүй Байдлын Яаманд хүрсэн байв. Энэ сүртэй нэртэй газар бол Хойд Солонгосын улс төрийн цагдаа л гэсэн үг. Уг яам маш олон мэдээлэгчээс бүрдсэн сүлжээтэй. Өмнөд Солонгос руу гарсан цагаачдын яриагаар бол тавин хүн тутамд нэг мэдээлэгч байдаг ажээ.

Нутаг нэгтнээ тагнах явдал уг нь өнгөрсөн үед л хамаатай баймаар. Хатагтай Сонгийг зогсоож энгэрийн тэмдгийг нь шалгасан Социалист Залуучуудын Холбооны хүү шиг хүүхдүүд олноороо байх бөгөөд тэд нийгмийн дэг журмыг сахиулахын тулд хүмүүс хувцаслах ёсыг дагаж байгаа эсэх, тухайлбал фудболк, жинс өмсөж ром тоо хэрэглэж байгаа эсэх, мөн үсээ хэт ургуулах зэргээр капитализмын үзэл суртлыг дэмжиж байгаа эсэхийг нь шалгана. Эрчүүд үсээ таван сантиметрээс илүү ургуулж болохгүй. Халзарч явуу эрчүүд л долоон сантиметр ургуулж болно. Энэхүү журмуудыг олонтаа зөрчвөл Ардын Стандартын Цагдан Сэргийлэхээс баривчлах хүртэл арга хэмжээ авч болно. Мөн цагдаагийн хөдөлгөөнт эргүүл гарах бөгөөд тэд гудамжаар явж дүрэм зөрчсөн этгээдийг илрүүлэх эсвэл айл өрхүүдэд урьдчилан хэлэлгүйгээр гэнэтийн айлчлал буюу шалгалт хийх эрхтэй. Тэдний шалгадаг зүйл нь айл өрхүүд цахилгааны нормоо хэтрүүлэн хэрэглэж байгаа эсэх, 40 лаанаас дээш гэрэл хэрэглэж байгаа эсэх, халуун тогоо, будаа агшаагч хэрэглэж байгаа зэрэг юм. Нэг удаагийн гэнэтийн шалгалтаар хөрш айлын эзэгтэй халуун тогоо хэрэглэж байснаа нуух гэж хөнжил доороо хийснээс болж гал гарсан ч түүх бий. Хөдөлгөөнт эргүүлийнхэн ихэвчлэн шөнө дундаас хойш тухайн айл өрхөд, аялах зөвшөөрөл аваагүй этгээд

хоноглож байгаа эсэхийг шалгах зорилгоор орж ирнэ. Хөдөө тосгоноос ирсэн хамаатан садан эсвэл хайр сэтгэлтэй хүн нь хонож таарвал бөөн асуудал үүснэ. Зөвхөн цагдан сэргийлэхийнхэн болон сайн дурын холбооныхон бус, хүн бүр бие биеэ ажиглаж дүрэм журам зөрчсөн тохиолдолд мэдээлэх үүрэг хүлээнэ. Улс орон хэт ядуу, цахилгааны хомсдолд орсноос цахим аргаар тагнах аргагүй учир хүн-тагнуул дээр түшиглэн үйл ажиллагаагаа явуулна. Сонин хэвлэлүүд үе үе эцэг эхээ барьж өгсөн баатарлаг хүүхдүүдийн тухай өгүүллэг бичиж сүр бадруулна. Гэрт нь орж зурагт үзчихээд матчих явдал ийм дэглэмийн үед ердөө ч гайхах зүйл биш ажээ.

Чанг Богийн байцаалт гурван өдөр үргэлжлэв. Байцаагч нар хашгирч, хараан зүхэж байсан боловч харин ч гар хүрээгүй гэж тэр эхнэртээ хэлжээ. Чанг Бо хэл ярианыхаа авьяасаар өөрийгөө хамгаалан гарч чадсан байна. "Би тэдэнд үнэнээ хэлсэн. Би хэнийг ч дайрч доромжлоогүй. Би зөвхөн хүүхдүүддээ гутал авч өгч чадаагүй байна. Энэ гутлуудаас авч өгөх юмсан л гэж ярьсан" хэмээн зүтгэсэн ажээ.

Тэр хэцүү байдлаас үнэхээр эвтэйхэн сугарч чадсан байна. Том гүзээтэй, дарга төрхтэй, ширүүн царайтай тэрбээр Хөдөлмөрийн Намын томоохон албан тушаалтан мэт аашилж, улс төрийн цагдан сэргийлэх эцэстээ хэргийг нь хааж, ял шийтгэлгүй өнгөрөөжээ.

Харин гэртээ буцаж иртэл эхнэр нь байж сууж ядтал нь яншжээ. Энэ бол тэдний гэрлэлтийн түүхэн дэх хамгийн том хэрүүл байлаа. Асуудлын гол нь нөхөр нь төр засгаа хүндлээгүйд биш түүнийг амьдралд нь анх удаа маш их айдаст автуулсанд оршиж байж. Хатагтай Сонг үргэлж биеэ зүй ёсоор авч явж, төр засаг, их удирдагчдаа үнэн зүрхнээсээ бүхнээ зориулж явсан болохоор түүнд ийм их айдас төрөх юм гэж огт бодож байсангүй. Гэрт хөршийнхөн байхад яах гэж тийм дэмий юм ярив? Байгаа бүхнээ алдахад хүрнэ гэж бодсонгүй юу гэж тэр нөхөр рүүгээ дайрлаа.

Үнэн хэрэг дээрээ ийнхүү шийтгэлгүй өнгөрсөндөө эхнэр нөхөр хоёр хязгааргүй баярлав. Чанг Богийн нийгмийн гарал сайн байсан, намын гишүүнчлэл, мөн хатагтай Сонгийн хорьтын дарга байхдаа гаргасан итгэл зүтгэлийг Ардын Аюулгүй Албаныхан үнэлсэндээ ийм хөнгөн өнгөрөөлөө гэдэгт хоёулаа итгэлтэй байлаа. Хэрэв эдгээр хүчин зүйлүүд үгүй бол Чанг Ботой адилхан зүйл хэлсэн хэн ч байсан шоронд орох нь гарцаагүй байсан аж. Нэгэн эр Ким Чен Иррийн намхан нурууны талаар онигоо яриад насаараа шоронд хоригдох ял авсан гэж тэд сонссон билээ. Хатагтай Сонгтой хамт ажилладаг асан нэгэн эмэгтэй өдрийн тэмдэглэл дээрээ бичсэн зүйлээсээ болж шоронд ороход нь муу урвагч хийсэн зүйлийнхээ үрийг хүртэв гэж тухайн үед бодож байснаасаа Сонг одоо ичих шиг болдог гэж ярьж билээ.

Хэрэг явдал үнэхээр гайгүй өнгөрлөө. Болсон явдлаас сургамж авсан Чанг Бо хэл яриандаа их л хянуур ханддаг болов. Гэвч тэр үзэл бодол өөрчлөгдөж байгааг анзаарчээ. Олон жил Чанг Бо бодол санаанд нь үе үе цухасхан орж ирсээр асан эсэргүү бодолтойгоо зөрчилдсөөр л байв. Одоо тэр бодол нь үл итгэх үзлээр солигджээ. Чанг Бо жирийн хүмүүсийг бодвол мэдээлэлд илүү ойрхон хүн. Хойд Хамёнг Мужийн Мэдээллийн Компанид ажилладаг Чанг болон түүний хамтран ажиллагсдад гадаад орнуудын, шүүлтүүрт ороогүй мэдээлэл бэлнээр олдоно. Тэд уг мэдээллүүдийг хүлээн авч улсынхаа зорилгод нийцүүлэн хянан цэвэрлэж, түгээх ажлыг эрхэлдэг байлаа. Капиталист орнууд тухайлбал Өмнөд Солонгос 1988 онд зуны Олимпийг эх нутагтаа

хэрхэн зохион байгуулж байгааг үзэх завшаан тохиолджээ. Ажил хаялт, аллага, байгалийн гамшиг гээд дэлхийн өнцөг булан бүрт болж байгаа үйл явдлын талаарх хангалттай мэдээлэл тэдэнд ирнэ.

Чанг Бо бизнес мэдээлэл бичих тусгай үүрэгтэй. Тэр хамтрал, үйлдвэрүүдээр тэмдэглэлийн дэвтэр, дуу хураагчтай явж удирдаж буй хүмүүсээс нь ярилцлага авна. Буцаж ирээд бичгийн машин байхгүйгээс зүгээр үзэг цаас нийлүүлэн аялынхаа талаар болон эдийн засаг хэрхэн урагшилж буй талаар мэдээлэл бичнэ. Тэр үргэлж эерэг зүйл бичихийг хичээвч ямар нэгэн үнэний үзүүрээс байнга оруулна. Гэвч Пхеньян дахь түүний ахлах редакторуудын гараар ороод л тэр үнэний үзүүр ор сураггүй болно. Чанг Бо эдийн засгийн өсөлтийн талаарх сүр дуулиантай мэдээлэл худал хуурмаг болохыг хэнээс ч илүү мэднэ.

Хамт ажиллагсад дотор нь үнэн сэтгэлээсээ итгэдэг нэгэн найз түүнд бий. Тэд өөрсдийн амьдарч буй дэглэм улам бүр жигшил зэвүүцлийг нь хүргэж буй тухай сэтгэгдлээ хуваалцах дуртай. Хоёулаа уулзахаараа хатагтай Сонгийн нэрсэн архинаас нэг лонхыг задалж хэдэн хундага явуулсныхаа дараа хөршүүд нь хуванцар хананы цаанаас сонсохооргүй нам дуугаар "Тэд бүгд худалч, яаж ингэж чадаж байна аа" хэмээн тэсэж ядан хэлнэ. "Зальт этгээдүүд" хэмээн найз нь хариуд нь дэмжинэ. Ок Хи аавыгаа найзтайгаа ярьж байхыг сэм сонсоод сэтгэл дотроо дэмжин толгой дохино. Аав нь эхлээд анзаарангуутаа охиноо шууд хөөн явуулсан боловч яваандаа эвлэрч хэнд ч хэлэхгүй гэсэн өчгийг нь авсны дараа нууцаа охинтойгоо хуваалцах болжээ. Ким Ир Сен өөрийнх нь зохион ярьдгаар Японы империалистуудтай тулалдаж байсан цогтой тэмцэгч биш, харин ЗХУ-ын утсан хүүхэлдэй болох, Өмнөд Солонгос Азийн хамгийн баян улсуудын нэг болсон, тэнд энгийн ажилчин хүн хүртэл хувьдаа машинтай болсон тухай ярьж өгнө. Коммунизм эдийн засгийн тогтолцооны хувьд сүйрч байгаа иймээс Хятад, ЗХУ капитализмаар замнаж эхэлж байгаа тухай бас хэлсэн юм. Эцэг охин хоёр ийнхүү хэдэн цагаар ярилцах ба аль нэг хөрш нь сэм чагнахаас сэргийлэн үргэлж шивнэлдэнэ. Гэхдээ дэглэмдээ туйлаас итгэгч хатагтай Сонгийн эзгүй хойгуур л ийм завшаан олддог байсан бөлгөө.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХАР ТОЛБО БҮДГЭРЭВ

1989 оны 11 сарын есөнд Зүүн Германы Засгийн газар Баруун Герман руу нэвтрэн орох хязгаарлалтыг хүчингүй болгох шийдвэр гаргасны дараа 1,2 сая хүн хил гарч, Берлиний ханыг нурааж эхэлснээр 1990 он гэхэд хананы багахан хэсэг нь л түүхийн дурсгал болон үлдсэн билээ. ЗХУ ганцаардаж эхлэв. Мао Зэдунгийн хөрөг Америкийн жуулчид Бээжинд ирэхдээ худалдаж авдаг загвар муутай цагны нүүрэн дээр л үзэгдэх төдий болж Румыны коммунист дарангуйлагч, Ким Ир Сений дотнын найз Николай Чаушеску буудуулж, Лениний хөшөөг буулган, хэдэн хэсэг болгон буталж эхэлсэн цаг үе. Дэлхий дахины коммунистууд түргэн хоол, бургер идэн, кока колагаар даруулж сайхныг нь гайхаж байлаа. Гэтэл Хойд Солонгост л ямар ч өөрчлөлт гарсангүй.

Тэд дэлхийн бусад орнуудад коммунист дэглэм нуран унаж байгааг өөрийнхөөрөө л тайлбарлаж байв. Родон Синмун сонинд коммунист дэглэмүүд нуран унаж байгааг ард түмнийх нь сул дорой байдалтай холбоотой мэтээр ухуулна. (Хойд Солонгосын хэвлэлүүд ард түмнээ бусад үндэстнээс төрөлхийн хол давуу хэмээн сурталчилдаг). Зүүн Европын орнууд болон хятадууд төрөлхийн сул дорой, сахилга бат муутай учраас ялагдалд хүрч, социализмын замналаас ухарсан. Бид төрөлхийн давуу чанараа хадгалж, Ким Ир Сенээр удирдуулж байгаа цагт дэглэмээ бүрэн бүтэн хадгалж үлдэн, цаашид ч хөгжин цэцэглэх болно хэмээн сурталчилж, зөвхөн өөртөө найдах сэтгэлгээг үргэлжлүүлэн номлосоор иргэдээ гадаад ертөнцөөс тасалсан хэвээр байлаа. Үүнээс үүдэн ард түмэн нь бусад орнуудад юу болж байгааг анхаарч үл төвдөн, өөрсдийн замналаа цаашид үргэлжлүүлсээр.

Хатагтай Сонг ер нь л байдал биш болж буйг гэрчилсэн олон үйл явдал өрнөж байхад нүдээ тас анин, чихээ бөглөсөн мэт өнгөрүүлсээр байв. Эхлээд шинж тэмдэг бараг ажиглагдахааргүй хэмжээнд байсан бол удалгүй хэдхэн агшинд анивалзаад хэвийн болдог гэрэл хэдэн хором тасарч, сүүлдээ хэдэн цаг, өдрөөр байхгүй болдог болжээ. Аажимдаа цахилгаан тасрах нь жирийн үзэгдэл болж, долоо хоногт хэдхэн цагаар ирдэг болов. Орон сууцны хэрэглээний ус тасарлаа. Хатагтай Сонг ус ирмэгц байгаа бүх хувин саваа дүүргэн авч, хэрэгцээний усаа нөөцлөх хэрэгтэйг ухаарчээ. Гэвч зөвхөн ундны хэрэгцээндээ л хүрэх хэмжээний ус нөөцөлж чадахаас биш угаалга, цэвэрлэгээ хийхэд хаанаа ч хүрэхгүй. Байрны усны насос цахилгаанаар ажилладаг тул цахилгаан дахин ирэхээс өмнө ус дуусна. Тиймээс хуванцар савнууд цуглуулж, нэг байшингийн цаана орших худгаас ус авдаг болов. Ус зөөх нь хатагтай Сонгийн өглөөний жижүүрт ажлын нэг болон хувирлаа. Өглөө босоод гудаснуудаа хурааж, их удирдагчийнхаа хөрөгний тоосыг арчдагтай нь адил заавал хийх ажлын нэг болов. Ажил руугаа явахаар нэгдүгээр замаас суудаг трамвайн ажиллах цагийн хуваарь цахилгааны саатлаас болоод тогтворгүй болсон тул хатагтай Сонг явган явахыг илүүд үзэх болсноос бага насны хүүхэдгүй ч илүү эрт босох шаардлагатай тулгарав. Трамвай хааяа нэг ирэхээр зорчигчид нь багтахгүйгээр барахгүй, зарим нь шатнаас дүүжлэгдэн ил явна. Хатагтай Сонг ажил руугаа алхахад ойролцоогоор нэг цаг зарцуулна.

Чонжины үйлдвэрүүд Поханаас хойд зүгт, Японы цэргийн бааз байсан, одоо Хойд Солонгосын Ардын Армийн штаб болсон Нанам хүртэл арван гурван км үргэлжилсэн нутаг дэвсгэрт байрлана. Томоохон үйлдвэрүүдэд Чонжины Төмөрлөг, Кимчакийн Ган ба Төмөрлөгийн үйлдвэрүүд, Химийн Гаралтай Бөс Барааны Үйлдвэр, Металлургийн Хоёрдугаар Үйлдвэр, тавдугаар сарын 10 хэмээх Нүүрсний Уурхайн Машин Механизмын Үйлдвэр, мөн бугын цусан эврээр эм үйлдвэрлэдэг Мажоны Эмийн Үйлдвэр зэрэг орно. Хатагтай Сонг үйлдвэрлэлийн районы төгсгөл хэсэгт орших, үндэсний томоохон үйлдвэрүүдийн нэг болох Чусаны Хувцасны Үйлдвэрт ажилладаг байв. Уг үйлдвэрийн Чонжины салбар хоёр мянган ажилчинтайгаас дарга нар, машины жолооч нараас бусад нь эмэгтэйчүүд. Тэндхийн иргэд амьдралынхаа ихэнх үеийг дүрэмт хувцас өмсөж өнгөрөөдөг болохоор уг үйлдвэр оюутны, дэлгүүрийн худалдагчийн, галт тэрэгний үйлчлэгчийн, үйлдвэрийн ажилчдын дүрэмт хувцас л үйлдвэрлэнэ. Хувцсыг 1939 онд Солонгосын нэгэн эрдэмтний зохион бүтээсэн виналон хэмээх гялалзсан нийлэг материалаар хийнэ. Уг материалыг Чонжингоос эргийн доод хэсэгт 175 милийн цаана орших Хамхунг хэмээх газар үйлдвэрлэдэг.

1988 оны эхээр виналон материалын нийлүүлэлт тасалдах болов. Хатагтай Сонг болон үйлдвэрийн бусад ажилчдын сонссоноор даавууны түүхий эд олдохоо больсон, бас цахилгаан байхгүй учраас нийлүүлэлт тасалдах болжээ. Хэн ч тодорхой мэдээлэл өгсөнгүй. Даавуугүйгээр хувцас үйлдвэрлэх боломжгүйгээс үйлдвэр сул зогсох болов. Оёдолчид үйлдвэрийнхээ шалыг угаах, тоног төхөөрөмжийнхөө тоосыг цэвэрлэх зэргээр цаг нөгцөөж, материал ирэхийг хүлээнэ. Үйлдвэр нам гүм боллоо. Урьд нь оёдлын машины тачигнах дуу сонсогддог байсан үйлдвэрийн зааланд одоо зөвхөн хог шүүрдэх, шал арчих чимээ л сонстоно.

Ажилчдыг сул зогсоохгүйн тулд үйлдвэрийн захиргаа "тусгай ажил" зохион байгуулжээ. "Тусгай ажлын хүрээнд" бүсгүйчүүд худалдаж, солилцож болох бүх зүйлийг эрж хайж, олдсон зүйлээ зарахыг нь зарж, хүнсээр солихыг нь солих болов. Нэг өдөр эмэгтэйчүүд төмөр зам дээр гарч, нохойн баас цуглуулан бордоонд хэрэглэх юм болов. Дараа нь хаягдал төмөр цуглуулжээ. Эхлээд зөвхөн оёдолчид гардаг байсан бол дараа нь хатагтай Сонг зэрэг захиргааны ажил эрхэлдэг бүсгүйчүүд хүртэл хамрагдах боллоо. Зарим нь хүүхдүүдээ харан үлдэж байхад үлдсэн нь хаягдал түүхээр гарах зэргээр "тусгай ажлаа" ээлжээр хийж эхлэв. Хүрэх зам хэцүү байвч, "намаа бид хамгаална" хэмээн дуулан алхацгаана. Нэгэн удаа тэд далайн эрэг рүү хаягдал метал түүхээр явав. Хатагтай Сонг уг нь хөлөө норгох дургүй байлаа. Тэрбээр хүүхдүүдээ бага ахуйд хясаа түүхээр гэрийнхээ ойролцоох эрэг рүү явахдаа хүртэл усанд хөлөө дүрдэггүй байжээ. Хатагтай Сонгийн үеийнхэн дотор усанд сэлж чаддаг хүн ховор. Ус гүехэн байсан ч тэр жихүүцнэ. Гэвч энэ удаа аргагүйн эрхэнд өмдөө өвдөг хүртлээ шууж байгаад, зотон шаахайгаа тайлалгүй ус туулж, сагсаараа хаягдал төмөр шүүв. Ажлын өдөр дуусахад дарга нар нь төлөвлөгөөгөө биелүүлсэн эсэхийг шалгах гэж түүсэн төмрийг нь жигнэж үздэг байжээ.

Эмэгтэйчүүд энэ тааламжгүй аяллаас яаж ийгээд сугарч үлдэхийг хичээдэг байлаа. Цалин авахгүй ч хэн ч ажлаасаа гарч зүрхлэхгүй. Ажил хийхгүй бол хүнсний талон олдохгүй. Хэрэв ямар нэгэн хүндэтгэх шалтгаангүйгээр долоогоос дээш хоногийн хугацаагаар ажил тасалбал хорьж саатуулах төв рүү илгээнэ.

Зарим эмэгтэй гэр бүлийн хэн нэгэн өвдсөн хэмээн шалтгаан тоочиж, эмчээс магадлагаа авчирна. Ингэхийн тулд нүд ирмэж толгой дохиод л болоо. Бүсгүйчүүд тэртэй тэргүй хийх ажилгүй болохоор дарга нар нь ч эмчийн магадлагааг шалгаж үзэхийг урьдал болгохгүй. Гэтэл энэ бүхэн хатагтай Сонгод нэг л биш санагдана. Тэр урьдын адил яг л цагтаа ажилдаа ирнэ. Оёдолчид ажилдаа ирэхгүй болохоор хүүхэд саатуулах газар ч ажиллахгүй. Дарга нар нь цаг нөхцөөхийн тулд Ким Ир Сений тухай лекц уншихыг оролдох боловч цахилгааны хүчдэл муугаас үйлдвэрийн танхимд харанхуй оргих тул энэ санаагаа орхино. Олон жилийн туршид өдөрт арван дөрвөөс арван таван цаг ажилладаг байсан хатагтай Сонгод анх удаа амрах завшаан олдов. Тэр ширээн дээрээ гараа дэрлээд л зүүрмэглэчихнэ. Энэ байдал хэр удаан үргэлжлэх бол гэсэн зурвас бодол хааяа нэг орж ирдэг байжээ.

Нэгэн өдөр хатагтай Сонгийн дарга, ажилчдын хүндлэлийг хүлээсэн, шударга, ажилдаа махруу намын гишүүн нэгэн эмэгтэй үлдсэн ажилчдыг өрөөндөө дуудаад санаа нь зовсон байртай хоолойгоо зассанаа "Байдал ойрын ирээдүйд сайжрах төлөвгүй боллоо. Иймээс эгч нар минь өөр өөрсдийн замаа бодох хэрэгтэй боллоо доо" хэмээн хэлэв. Хатагтай Сонг үүнийг сонсоод цочирдов. Даргынх нь хэлсэн өөр арга зам гэдэгт арай л биеэ үнэлэх гэсэн утга агуулагдаагүй байлтай. Тэгэхээр наймаагаар амьдралаа залгуул гэсэн үг үү?

Бусад коммунист орнуудтай адил Хойд Солонгос ч хар захтай байлаа. Ихэнх бараа бүтээгдэхүүнийг хувиараа зарж, худалдаж авах нь хууль бус ч хар зах оршсоор л байв. Хар захын талаар гаргах журам үргэлж шинэчлэгдэх боловч хэн ч мөрдөхгүй. Ким Ир Сен ард иргэддээ ногоо тарьж, хураасан ургацаа зарж борлуулах зөвшөөрөл олгосноор хүмүүс хатагтай Сонгийн байрны ард байх хоосон зайг ашиглан зах бий болгов. Зах ч гэж дээ шороон дээр саравч босгоод л дотор нь хураасан ногоогоо зарна. Голцуухан шар манжин, байцаа зарах боловч заримдаа хуучин хувцас, хэрэглэж байсан сав суулга, хуучин ном ч наймаалах нь бий. Шинээр үйлдвэрлэгдсэн бараа бүтээгдэхүүн зарах хориотой. Шинэ бүтээгдэхүүнүүдийг зөвхөн их дэлгүүрээр л зарна. Тариа будаа зарах бас л хориотой. Зарж байгаад баригдвал шууд л шоронд сууна.

Хатагтай Сонгийн бодлоор гадаа нь ажиллаж байгаа зах бохир, замбараагүй газар. Наймаачид нь ихэвчлэн ахимаг насны эмэгтэйчүүд. Тэд зарах ногоон дээрээ бохирон суугаад хахирган дуугаар ногооныхоо үнийг зарлан бахиралдана. Хэдийгээр эмэгтэйчүүд тамхи татахыг ард нийтээрээ жигшин зэвүүцдэг ч тамхичин эмэгтэйчүүд энэ зах дээр байж л байна. Эдгээр хөгшин эмсийг хараад хатагтай Сонгийн зэвүү хүрнэ. Ер нь л зах дээр юм зарна гэдэг тийм хүсмээр ажил биш байлаа. Үзэл сурталтай, соёлтой, коммунист хүний хувьд хар зах дээр наймаа хийнэ гэдэг бол байж болшгүй зүйл хэмээн манай хатагтай бодно.

Үнэн хэрэгтээ жинхэнэ коммунистуудад дэлгүүр орох хэрэг ч байхгүй. Учир нь Их эцэг хэрэгцээнээсээ илүү зүйл худалдан авахын эсрэг соёл бий болгохыг чармайж байв. Дээрээс нь хэрэгцээт зүйлсийг нь улсаас тараагаад өгчихөж байгаа юм чинь.

Гэтэл Азийн бусад оронд зах гэдэг зүйл жинхэнэ утгаараа хөгжин цэцэглэж байхад Хойд Солонгосын хамгийн алдартай нь болох Пхеньяны нэг, хоёрдугаар их дэлгүүрт зарагддаг бараанууд нь нэр төдий л зүйлс байх. 2005 онд Пхеньянд очихдоо би энэ хоёр дэлгүүрээр орж

үзсэн. Нэгдүгээр давхартаа Хятадад үйлдвэрлэсэн дугуй тавьсан нь үнэхээр зарж байсан уу эсвэл гадаадынханд зориулан үзмэр болгон тавьсан эд үү гэдгийг нь ялгаж чадаагүй. Пхеньянд 1990ээд оны үед очсон зарим гадныхан ярихдаа дэлгүүрүүдийнх нь цонхон дээр хуванцар чихэр жимс үзүүлэн болгож тавьсан байсан гэлцсэн нь ортой л байх.

Энэ улсад бүх зүйлийг их удирдагч Ким Ир Сений хишиг нэрээр тараадаг учраас дэлгүүр хэсэх шаардлагагүй. Зун, өвлийн нэгжгээд иж бүрэн хувцас гээд жилд хоёр удаа хувцасны хангалт авчихна. Шинэ хувцаснуудыг ихэвчлэн Ким Ир Сений төрсөн өдрөөр ажлын газрын хэлтэс, тасаг эсвэл сургуулиар дамжуулан тараана. Энэ нь их удирдагч сайн сайхан бүхний эх үндэс гэдгийг харуулах зорилготой. Зотон, хулдаасан шаахай тавьж өгнө. Арьсан гутал маш тансаг хэрэглээнд орох бөгөөд хамаатан садан нь гадаадад амьдардаг, эсвэл гадагшаа томилолтоор явдаг хүмүүс л арьсан гутал, шаахай өмсөж чадлаа гайхуулна. Хувцасны үйлдвэрүүдээс хувцасны хангалт ирнэ. Виналон хэмээн хувцас хийдэг материал нь будаг даахдаа муу тул хэдхэн өнгө л зонхилно. Хар хөх бол үйлдвэрийн ажилчдынх, албан хаагчдынх саарал эсвэл хар, улаан өнгө харин сурагчдын улаан бүчнийх гэх мэт. Сурагчид арван таван нас хүрч, эвлэлийн гишүүн болох хүртлээ өсвөрийн пионерийн гишүүн байж улаан бүч зүүн хичээлдээ явна.

Хүмүүст мөнгө байхгүй болохоор дэлгүүр ороод ч яах билээ. Цалин хэмээн олгож буй зүйл нь нэр төдий, хөдөлмөрийн хөлс гэхээсээ тэтгэмжид илүү ойртоно. Хатагтай Сонгийн сарын цалин болох 64 вон нь албан ёсны ханшаар 28 доллар бөгөөд нийлэг материалаар хийсэн ганц цамц ч авч хүрэхгүй. Цалин нь ойр зуурын хэрэгцээнд буюу үс засуулах, кино үзэх, автобусны билет авах, сонин худалдан авах зэрэгт л арай ядан хүрнэ. Дээр нь эрэгтэйчүүд нь тамхи, эмэгтэйчүүд нь оо энгэсэг авна. Хойд Солонгосын эмэгтэйчүүд оо энгэсэг их хэрэглэдэг. Тэдний түрхдэг час улаан уруулын будаг нь барууны 1940өөд оны кино оддыг санагдуулах бөгөөд ягаан хацар өнгөлөгч нь өвөл даарснаас болоод цонхийсон царайг нь засаж өгнө. Чонжины дүүрэг бүрт улсын дэлгүүр байна. Дүүрэг бүрийн дэлгүүр ялгарах юмгүй ижил. Бүсгүйчүүд гадаад байдалдаа их анхаарал тавьдаг. Хатагтай Сонг нүүрээ будахгүй гарч явснаас өглөөний ундаа уухгүй байхыг илүүд үзнэ. Төрөлхийн буржгар учир үсчинд очих хэрэг гарахгүй. Харин бусад эмэгтэйчүүд үсчинд очиж хими хийлгэнэ. Үсчний газар нь үйлчилгээний газар гэхээсээ илүү хурлын танхимыг санагдуулна. Танхимд нь хоёр эгнээ сандал эгнүүлэн тавьж нэг эгнээнд нь эмэгтэйчүүд нөгөөд нь эрэгтэйчүүд сууж үсээ засуулдаг. Үсчид бүгд төрийн үйлчилгээний албан хаагчид бөгөөд Үйлчилгээний Товчоонд харьяалагддаг. Энэ товчоо гутал болон дугуй засварын үйлчилгээг давхар хариуцдаг.

Хүнсний, бичиг хэрэгслийн, хувцасны дэлгүүр байна. Гэхдээ ЗХУ-ынх шиг урт дараалал үүсэх нь бараг үгүй. Хэрвээ дуу хураагч, цаг ч юм уу том зүйл худалдаж авах болбол харьяалагдах хэлтсийнхээ даргад өргөдөл бичиж зөвшөөрөл авах ёстой. Мөнгөтэй л бол хүссэн зүйлээ худалдаж авна гэсэн ойлголт үгүй ажээ.

Хойд Солонгосын тогтолцооны томоохон амжилтуудын нэг нь улсаас үнэгүй олгодог хүнсний ногдол. АНУ-ын 31 дэх ерөнхийлөгч Херберт Хүүверийн сонгуулийн амлалт болох "айл бүрийн тогоонд тахианы мах" гэдэг шиг Ким Ир Сений амлалт нь хүн бүрт өдөрт гурван аяга будаа, махтай шөл өгөх явдал байлаа. Будаа, ялангуяа цагаан будаа тэдний хувьд хамгийн дээд хоол. Гэвч энэ нь хүн бүрт зориулсан амлалт биш байлаа. Зөвхөн дээдчүүдийн хүрээнийхэнд л

хүртээлтэй. Харин жирийн иргэд нийгмийн гарлынхаа хэр хэмжээгээр улсаас амуу будааны хувь хүртэнэ. Биеийн хүчний хүнд хөдөлмөр эрхэлдэг нүүрсний уурхайн ажилчид өдөрт 900 грамм амуу буудай хүртэж байхад үйлдвэрийн ажилчин хатагтай Сонгод 700 грамм ногдоно. Улсаас хоолны хольц, тухайлбал шар буурцгийн сүмс, ургамлын тос, гоймонг хүртэл ард иргэддээ үнэгүй түгээнэ. Үндэсний баярын өдөр буюу Ким Ир Сений төрсөн өдрөөр гахайн мах, хатаасан загас олгоно.

Хамгийн сайхан зүйл нь намар кимчиний байцаа тараах явдал байв. Кимчи гэдэг нь халуун ногоонд дарсан байцааг хэлэх бөгөөд цагаан будаа шиг Солонгосын үндэсний хоолны салшгүй хэсэг. Солонгосчуудыг кимчигүй удаан тэсэхгүй гэдгийг дарангуйлагчид сайн ойлгосон байлаа. Гэр бүлийн том хүнд 70 кг, хүүхдэд 50 кг байцаа ногдох учир хадам ээж нь хамт амьдрах болсноос хойш хатагтай Сонгийн гэр бүл 410 кг байцаа авдаг болжээ. Байцааг давслаад, их хэмжээний улаан перцээр амталж, заримдаа вандуй бас зулзаган сам хорхой хольж болдог. Хатагтай Сонг улаан лууван, манжингийн кимчи дарна. Тэрээр энэ ажилдаа хэдэн долоо хоног зарцуулж, дарж дууссанахаа дараа өндөр шавар ваарнуудад савлана. Чанг Бо түүнд кимчинүүдийг зоорин дахь өөрсдийн хэсэгт аваачиж тавихад нь тусална. Уламжлал ёсоор кимчигдарахдаа гадаа цэцэрлэгт нь ваартай нь булдаг ба энэ нь кимчиг хүйтэн байлгах боловч хөлдөөхгүй зориулалттай юм. Гэтэл орон сууцны хувьд ийм боломж үгүй учир урт модон тэвш хийж ваарнуудаа байрлуулаад гадуур нь шороогоор чигжинэ. Ингээд ажил дууссаны дараа тэвшээ хамгийн сайн цоожоороо цоожлох ёстой. Чонжинд кимчиний хулгай түгээмэл байв. Хойд Солонгос шиг хамт олонч, өөрийгөө биш бусдыг боддог оронд хүртэл хулгай байх юм даа. Хэн ч кимчигээ бусадтай хуваахыг хүсэхгүй нь ойлгомжтой.

Ким Ир Сений олсон амжилт эхний үедээ үнэхээр анзаарахгүй өнгөрөөх аргагүй байв. 1945 онд Солонгос үндэстэн хоёр хуваагдсаны дараа Хойд нь Өмнөдөөсөө хамаагүй баян байжээ. 1960-аад онд Солонгосын эрдэмтэд "эдийн засгийн гайхамшиг" хэмээх нэр томъёо гаргаж ирсэн нь Хойдчуулын эдийг засгийг хэлсэн хэрэг. Он удаан жил өлсгөлөн байсан ард түмнийг хоолтой нь залгуулна гэдэг асар их амжилт байв. Ялангуяа сайтар тунгаан бодоогүй хуваалт хамгийн үржил шимтэй газрыг нөгөө талд үлдээсэн ба дэд бүтэцгүй шахам болсон, байшин барилгын далан хувь нь дайны хөлд нурж сүйдсэн орныг боломжийн түвшинд авчирсан гэж үздэг. Хүн бүр орох орон өмсөх хувцастай болов. 1949 он гэхэд Хойд Солонгос бичиг үсэг үл мэдэх явдлыг бүрэн устгасан Азийн анхны орон боллоо. 1960-аад оны үед тус оронд айлчлахаар Хятадын хилийн зүгээс галт тэргээр ирэх зочид хүн амын амьдралын түвшин сайн байгааг шагшин магтдаг байв. Үнэн хэрэгтээ Хятадад амьдарч байсан уугуул солонгос үндэстнүүд Мао Зэ Дуны санаачилсан Агуу Их Хамтралжих хөдөлгөөнөөс улбаалан бий болсон өлсгөлөн гачлангаас зугтааж Хойд Солонгосыг зорьцгоож байв. Хүн ард нь байшингаа ваараар дээвэрлэж, 1970 он гэхэд хот тосгон бүр цахилгаанжсан байв. Хамгийн цөлх гэгддэг Тагнуулын Төв Газрын шинжээч Хелен Луис Хантер хожим нь нууцлалын зэрэглэл нь цуцлагдаж хэвлэлд нийтлэгдсэн тайландаа Ким Ир Сений Хойд Солонгосын хүн ардын амьдралын түвшин гайхах сэтгэгдэл төрүүлсэн тухай цухас дурдсан байдаг.

Тус улс социалист системийн орнууд дотроо үлгэр дууриал болж байлаа. Тэд Хойд Солонгосын ололт амжилтыг бахдаж, Өмнөд Солонгосын хоцрогдлыг гайхацгааж, социализм үнэхээр гэрэлт

ирээдүй авчирна хэмээн итгэцгээж байв.

Гэтэл бодит байдал үнэхээр тийм байв уу? Хойд Солонгосын эдийн засгийн өсөлт мэт харагдаж асан бүхэн худал хуурмаг, нүд хуурах төдий зүйл байжээ. Эдийн засгийн үзүүлэлтээ нийтэд зарладаггүй бөгөөд зарлавал хуурмаг зүйлийг мэдээлж, ирсэн зочдоо, зарим тохиолдолд өөрсдийгөө ч мунхруулах гэж үгээ барна. Эдийн засагчид газар тариалангийн үйл явц буюу ургац хураалт, үйлдвэрийн бүтээгдэхүүний гарцын талаар статистик мэдээ санаанаасаа зохиож хэлнэ. Үнэндээ бодит байдлыг дарга нартаа тайлагнахаас эмээдэг байжээ. Нэг нь нөгөөдөө худлаа хэлж, доороосоо дээшээ хуурмаг тоо баримтаар цэнэглэгдсэн ийм нөхцөлд Ким Ир Сен эдийн засаг нь нурулсад орох үед л сая бодит байдлыг мэдсэн нь аргагүй биз ээ.

Бусдаас үл хамаарч, бие даасан улс орон болгон хөгжинө хэмээн хоосон цэцэрхсэн тэд нэг системийн орнуудаасаа яах аргагүй туслалцаа авдаг байжээ. Нефть, цагаан будаа, бордоо, эм, эмнэлгийн хэрэгсэл, үйлдвэрийн тоног төхөөрөмж, том оврын болон суудлын машинуудыг тусламжаар авна. Чехословакаас рентгений тоног төхөөрөмж, инкубатор авч, Зүүн Герман уран барилгачдаа илгээнэ. Ким Ир Сен Орос Хятад хоёрыг маш чадварлагаар сөргөлдүүлж, дундаас нь аль болох их тусламж олж авахыг чармайж байв. Хуучны маягийн дарангуйлагчийн ёсоор хөрш орнуудаасаа бас хүндлэл хүлээж, Сталин хуягласан лимузин явуулж, Мао Зэ Дун бүрэн тоногдосон галт тэрэгний цуваа бэлэглэсэн байна.

Ким Ир Сен болон 1980-аад оноос эцгийнхээ албыг бага багаар авч байсан Ким Чен Ир нар улс орондоо бий болсон гамшигт байдлыг даван туулахын тулд газар дээр нь зааварчилгаа өгдөг болов. Эцэг хүү хоёрт мэдэхгүй чадахгүй юм гэж байсангүй. Геологи ч бай, мал аж ахуй ч бай тэд бүгдийг мэднэ. "Агуу их удирдагчийн хүү, манай ирээдүйн удирдагч ямааны аж ахуйд айлчлан очиж, газар дээр нь зааварчилгаа өгч, хүнлэг энэрэнгүй сэтгэл гаргасан явдал нь тус газрын үйл ажиллагаа болон ямааны сүүний гарц, цагаан идээ боловсруулалтад ихээр нөлөөлөхүйц онцгой чухал үйл явдал боллоо" гэж Ким Чен Ирийг Чонжины ойролцоо ямааны аж ахуйд очсоных нь дараа Мэдээллийн Төв Агентлаг сүр дуулиантай мэдээлнэ. Нэг өдөр манай хүнсний гол бүтээгдэхүүн цагаан будаа бус төмс байх ёстой гэсэн зарлиг гаргана. Дараа нь тэмээн хяруул үржүүлэх нь хүнсний хомсдолоос гарах арга зам хэмээн тунхаглана. Ким Ир Сений хийсэн бодлогогүй, үндэслэл муутай нэг алхам бүрд улс орон нь бүдчин байлаа.

Улсын төсвийн ихэнх хувь цэргийн зардалд явж буй нь тодорхой байв. Хойд Солонгосын үндэсний нийт бүтээгдэхүүний 25 хувийг батлан хамгаалах зардал идэж байхад үйлдвэржсэн орнуудад энэ төрлийн зардал таван хувь л байдаг. 1953 оноос хойш ямар нэг тулаан болоогүй атал АНУ-ын Пенсилвани муж улстай тэнцэхүйц энэ жижиг улс дэлхийд цэргийн тоогоороо дөрөвт ордог бөгөөд нийт албан хаагчдын тоо нь нэг сая орчим. Хүн амын дунд явуулдаг ухуулга сурталчилгаагаар бол империалист гүрнүүд Хойд Солонгос руу бууны амаа чиглүүлэн хэзээ мөдгүй дайрахад бэлэн байдаг аж. 1991 онд ЗХУ-ын Улс Төрийн Товчооныхны дунд Хойд Солонгосын ирээдүйн залгамжлагч болохын хувьд нэр хүнд нь гялалзтал өсөж байсан Ким Чен Ир улсынхаа зэвсэгт хүчний дээд командлагчаар томилогдов. Хэдэн жилийн дараа Ким Ир Сений онол чучхэ-д зориулж босгосон хөшөө дурсгалын хажууд тус улсын төрийн бодлогын гол цөм нь манай Ардын Арми байх болно гэсэн утга бүхий сурталчилгааны самбарууд сүндэрлэх болов.

Үүнээс эхлэн залуу Кимийн тухай кинонууд театруудад давамгайлан гарах болж тэрбээр томоохон тоглоом буюу цөмийн зэвсэг, алсын тусгалтай пуужин үйлдвэрлэхэд анхаарлаа хандуулах болжээ. Дэлхийн хоёрдугаар дайны төгсгөлд АНУ Хирошимаг бөмбөгдсөнөөс хойш, Ким Ир Сен өөрийн орныг цөмийн зэвсэг бүхий их гүрэн болгохыг мөрөөдөж, 1960-аад оноос хойш Пхеньяны хойд хэсгийн уулархаг нутагт орших Зөвлөлтийн загвараар баригдсан Ёнбений цөмийн туршилтын төвд судалгаа явуулж эхэлжээ. Улс орных нь нэр хүнд олон улсын хэмжээнд буурч байх үед улсынхаа болон өөрийн нэр хүндийг аврах цорын ганц арга зам нь цөмийн хөтөлбөрийг эрчимжүүлэх явдал хэмээн Ким Чен Ир үзэв. Хуучирсан үйлдвэрүүд болон дэд бүтцээ сэргээн босгохоор оролдохын оронд Америкийн эзлэн түрэмгийллийг цөмийн зэвсгээр тогтоон барих нэрийн дор нийт төсвийн ихэнхийг зэвсэглэлээр хөөцөлдөхөд зарцуулж байлаа. 1989 онд цөмийн тогоонд ашигладаг түлшний савхнаас цөмийн зэвсгийн плутон гаргаж авах зорилгоор баяжуулах үйлдвэр байгуулжээ. 1990өөд онд АНУ-ын Тагнуулын Төв Газрын мэдээлснээр гаргаж авсан плутон нь нэгээс хоёр атомын бөмбөг хийхэд хангалттай болсон байжээ. Ким Чен Ирийн хувьд зорилгодоо хүрч л байвал улс орон дампуурах эсэх нь огт хамаагүй болов. "Цөмийн зэвсэг, пуужин зэрэг нь эрх мэдлээ хадгалж үлдэх цорын ганц арга зам гэж үзэж байсан" хэмээн Пхеньянаас дүрвэсэн өндөр тушаалын албан хаагч 2006 онд надад өгсөн ярилцлагадаа дурдсан билээ.

Хойд Солонгосын байдал улам хэцүү болсоор. Ким Чен Ир хүйтэн дайн дуусч, хуучин социалист системийн орнууд зэвсгийн хэнээрхлээ орхиж зах зээлийн эдийн засаг руу шилжиж байгааг ойлгохыг ч үл хүснэ. Өрсөлдөгч Өмнөд Солонгос нь 1970-аад оны дунд үеэс Хойд хөршөө гүйцэн түрүүлж, дараагийн арван жилийн дотор Хойд нутаг тэдний тоосонд үлдэв. ЗХУ, Хятад улсууд коммунизмын эв нэгдлийг ч огоорон төлбөрөө цагт нь төлдөггүй төрийн мэдлийн үйлдвэрүүдтэй Хойд Солонгостой биш Хьүндэй, Самсунгтай бизнес хийхийг эрхэмлэх болов. 1990 онд задран унахынхаа өмнө ЗХУ Өмнөд Солонгостой дипломат харилцаа тогтоосон нь Хойд Солонгосын нэр хүндийг дэлхий дахинд навс унагав. Хятад хоёр жилийн дараа ЗХУ-ын жишгийг дагажээ.

1990ээд оны эхээр 10 тэрбум долларт хүрээд байсан өрөө төлж чадахгүйд хүрсэн Хойд Солонгосоос зээлдүүлэгчид залхаж эхлэв. Москва импортолдог бүтээгдэхүүнүүдэд урьдын социалист системийн орнуудын төлдөг байсан хөнгөлөлттэй үнэ биш дэлхий дахины жишиг үнэ төлөхийг шаардах болжээ. Өмнө нь Хойд Солонгосын шатахууны дөчин таван хувь, хүнсний бүтээгдэхүүний гуравны хоёрыг хангаж уруул шүд шиг ойрхон хэмээн хэлэгддэг байсан Хятад улс одоо импортын бүтээгдэхүүнийхээ үнийг урьдчилан бэлэн мөнгөөр төлөхийг шаардах болов.

Ийнхүү тус үндэстэн гацаанд орлоо. Хямд түлш, шатахуун, түүхий эдгүйгээр үйлдвэрүүд нь ажиллах аргагүй болж экспортлох бүтээгдэхүүнгүй болов. Экспортгүйгээр валютын нөөцгүй, валютгүйгээр шатахуун импортлох ямар ч боломжгүй болж. Ингэснээр улс орон даяар цахилгаан хангамж үгүй болж, цахилгаанаар ажилладаг усан шахуургатай нүүрсний уурхайнууд хаагдав. Нүүрсний хомсдол эргээд цахилгаан станцуудыг элгээр нь хэвтүүлж, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний гарцад ч нөлөөлж эхлэв. Хамтралууд ч ялгаагүй, цахилгаангүйгээр үйл ажиллагаа нь доголдож эхэлжээ. Тэдний үржил шим муутай хөрснөөс 23 сая хүнийг тэжээх хэмжээний ургац авах нь үргэлж хүндрэлтэй байж. Механикжсан усалгааны систем нь цахилгааны тасалдлаас болж

ажиллахгүйд хүрч, химийн бордоо, шавьжны хорны үйлдвэрүүд нь шатахуун болон түүхий эдийн хомсдолоос шалтгаалан хаагдсанаас хөдөө аж ахуйн салбар дампуурч эхлэв. Хүнсний хомсдол бий болж ард олон өлсгөлөнд нэрвэгдэж, хөдөлмөрийн бүтээмж буурлаа. Ийнхүү тус улсын эдийн засаг чөлөөт уналтад орсон юм.

Хойд Солонгос 2009 оны байдлаар хүнсний ногоо, тариа, цагаан будаа зэрэг газар тариалангийн гаралтай хүнсний бүтээгдэхүүнээ нийтийн эзэмшлийн газар тариалдаг цорын ганц улс болон үлдсэн байв. Улс бүх ургацаа хураан авсныхаа дараа тодорхой хэсгийг нь тариаланчдад буцааж өгнө. Гэвч 1990-ээд оны эхээр ургац багасч, тариаланчид өөрсдөө хүнсний хомсдолд орсон учир ургацаа нуудаг болов. Саравчныхаа дээвэр дээр ургацаасаа нуусан тариаланчийн дээвэр нурж баригдсан тухай яриа ч гарч байлаа. Нийтийн тариалангаас илүү өөрийнхөө саравчны ард хувийн жижиг талбай эсвэл уулын бэл дэх атар газрыг ашиглан тарьсан тариан талбайгаа гэх болжээ. Хөдөө талаар нь явж үзвэл хувийн талбай болон хамтралын тариан талбайнууд тод ялгарч харагдана. Хувийн ногооны талбайд хүнсний ногоо алаглан ургаж, харин дэргэд нь сайн дурынхан эх оронч үүргээ биелүүлж тарьсан хатангиршсан үр тарианы хэдхэн үе бүхий хамтралын тариан талбай хөглийн харагдана.

Хотынхон энэ хямралд илүү өртсөний учир нь хөдөөгийнхөнтэй адил ногооны талбайгүйд байлаа.

Гэрлэснээсээ хойш хатагтай Сонг хоёр гялгар уут бариад хүнсний ноогдлоо авахаар ойролцоо орших хүнс түгээх цэг рүү арван тав хоног тутамд явдаг байв. Ороход өрсөн үй түмэн бараан дундаас сонголтоо хийдэг их дэлгүүртэй энэ хүнсний цэг огт адилгүй. Ямар ч хаяг байхгүй, гадуураа төмөр хашаатай, "хүнс тараах цэг" хэмээн нэрлэгдэх байшингийн гадаа эмэгтэйчүүд дугаарлан зогсоно. Хүн бүхэн цаанаас зааж өгсөн өдөртэй. Хатагтай Сонг сар бүрийн 3,18нд хуваарьтай. Хэдийгээр хуваарьт өдрөө очих боловч дараалал ихтэй учраас хэдэн цагаар зогсох хэрэг гарна. Байшин руу ороход халаалтгүй цементэн ханатай жижиг өрөөнд бүртгэлийн дэвтрээр дүүрсэн ширээнийхээ ард залхсан царайтай эмэгтэй угтана. Хатагтай Сонг ноогдол хүнснийхээ дэвтр, бага зэрэг мөнгө, ажлын газрынх нь төлөвлөгөөгөө биелүүлсэн гэсэн тодорхойлолт зэргийг эмэгтэйд өгөхөд тэрээр ноогдох хүнсийг нь тооцоолж, дэвтр дээр нь бичилт хийнэ. Хатагтай Сонг, Чанг Бо хоёр тус бүрдээ 700 грамм, хадам ээж нь тэтгэвэрт гарсан болохоор 400 грамм, хүүхэд тус бүр 500 грамм амуу будааны нормтой. Хэрэв гэр бүлийн гишүүдээс хэн нэг нь томилолтоор явсан бол гэртээ байгаагүй өдрийнх нь тоогоор амуу будаанаас суутгана. Бичилт хийж дууссаны дараа эмэгтэй тамгаа авч улаан бэхэнд дүрж байгаад гурван хувь баримт дээр дарна. Нэг хувь баримт хатагтай Сонгод очно. Ингээд агуулах руу очиж хүнсээ торондоо хийлгэж аваад харина.

Уутан дотор юу байгааг гаднаас нь хараад таах боломжгүй. Заримдаа байх ёстойгоосоо бага, заримдаа их байх жишээтэй. 1989 оны үед тэдний хүнсний ноогдол мэдэгдэхүйц багасчээ. Ноогдлоо авахдаа урд өмнөхөөс хөнгөн байгааг нь анх мэдэрснээс хойш очих тутамд уут нь улам л хөнгөрөх болов. Зарим сард 25 хоногт, дараагийн сард нь 10 хоногт л хүрэлцэх хүнс олгох болов. Цагаан будаа нүдний гэм болж арвай, амуу тариа л олдохтой үгүйтэй. Ургамлын тос хааяа нэг олддог байсан ч одоо сураггүй болжээ. Хатагтай Сонг гомдол гаргая гэж бодсон ч үгүй. Бодсон ч

тэр гомдоллож чадахааргүй нэгэн билээ.

Хожим нь "хэрвээ би гомдол тавих юм бол нөгөөдүүл чинь ирээд л шууд ачаад явчихна шүү дээ" хэмээн ярьсан юм. Засгийн газар нь үүссэн нөхцөл байдлын талаар үнэмшихэд бэрхээс нь эхлээд илэрхий хийсвэр хүртэл янз бүрийн тайлбар хийж байлаа. "Хоёр улс нэгдэх тэр тэнгэрлэг өдөр өлссөн Өмнөд Солонгосын ард түмэнд өгөхөөр төр засаг нь хүнс нөөцөлж байгаа. АНУ хориг тавьснаас болж хүнсний хомсдол үүсч байна гэх мэт". Хэдийгээр ор үндэсгүй боловч хүмүүс итгэж л байлаа. Учир нь 1993 оны эхээр Цөмийн Зэвсэг Үл Дэлгэрүүлэх Гэрээг цуцлахаар сүрдүүлсний хариуд АНУ эдийн засгийн хориг тавихаар айлгасан байна. Родонг Синмун сонинд АНУ-ын тавьсан хориг арга хэмжээнээс болж манай ард түмэн удаан шаналан зовж байна хэмээн бичнэ.

Тэд өөрсдийгөө тэвчээртэй гэж үздэг. Үнэхээр ч тэвчээртэй хүмүүс. 1938-1939 он хүртэл Ким Ир Сен Японыг эсэргүүцсэн партизануудаас бүрдсэн жижиг отрядыг командалж 20 гаруй хэмийн тэсгэм хүйтэнд, цас зудан дундуур, өлсгөлөн гачланг эс тоож, мянга мянган дайснуудын эсрэг хэрхэн баатарлагаар тулалдаж байсан тухай худал түүх зохиож өлсгөлөнд нэрвэгдсэн ард түмнээ уг баатарлаг жишээг даган дуурайхыг уриалж байлаа.

"Дэлхий дээр ямар ч хүчин Солонгосын ард түмний хувьсгалын үйл хэрэгтээ ялалт байгуулах замд саад болж үл чадна. Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улс үргэлж хүчирхэг гүрэн байх болно" хэмээн сурталчилна.

Өлсгөлөнг тэсэж гарах нь иргэдийн эх оронч үүрэг болон хувирлаа. Пхеньяны сурталчилгааны самбарууд дээр "Өдөрт хоёр л удаа хооллож заншицгаая" гэсэн лоозонгууд шинээр бичигдэв. Зурагтаар гэдэс нь мушгирч өвдсөн эр хэт их будаа идсэнээс болжээ гэсэн утгатай баримтат кино цацагдана. "Хүнсний хомсдол бол түр зуурын асуудал. Ирэх жилийн ургацаар бид хангалттай үр тариа, хүнсний ногоо, цагаан будаа хурааж авна" хэмээн хөдөө аж ахуйн албаны хүмүүс сонинд нийтлэгдсэн ярилцлагадаа дурдаж байв.

Гадаадын хэвлэл 1992 онд Хойд Солонгос дахь хүнсний хомсдлын талаар бичихэд, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь асар дургүйцэн, няцаахыг оролдож байлаа.

Төр засгаас хүнсийг маш хямд үнээр түгээдэг. Ингэснээр манай хүмүүс будаа ямар үнэтэйг мэддэггүй. Энэ бол Хойд Солонгос дахь бодит байдал. Бид ард түмнээ хоол хүнсний талаар санаа зовохгүй амьдраасай гэж хүсэж байна.

Хэрэв тэд бодит байдлыг элдвийн худал ухуулга сурталчилгаагүйгээр мэдэх юм бол ямар аюултай нөхцөлд буйгаа ойлгох байсан биз ээ. Тэдэнд сонголт үгүй. Нутгаасаа зугтан гарч, удирдагчдаа түлхэн унагаж, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эсэргүүцэх эрхгүй болохоор ямар ч арга үгүй. Нийгэмдээ зохицож амьдрахын тулд хүмүүс чөлөөтэй сэтгэж, аливааг эрэгцүүлэн бодох хэрэггүй. Гэтэл хүн гэдэг амьтанд байгалиас заяасан өөдрөг зөн совин гэж бас

байдаг ажээ. 1930-аад онд Германы еврейчүүд үүнээс дор байна гэж үгүй хэмээн өөрсдийгөө зоригжуулж асан бол Хойд Солонгосчууд энэ бол цаг зуурын асуудал, удахгүй бүх зүйл сайхан болно гэж өөрсдийгөө хуурна.

Ухуулга сурталчилгааны шинэ кампанит ажил хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор дотооддоо чагнах, тагнах явдал хэр хэмжээнээс хэтрэв. Хүмүүс бодит байдлын талаар гомдол тавих тусам үүний эсрэг авах хэмжээг улам чангатгав.

1970аад оноос эхлэн хатагтай Сонг үе үе хорьтын даргаар сонгогдон ажиллах болжээ. Жил бүр хорьтын даргаар дунд насны, гэрлэсэн, хариуцлагатай эмэгтэйг сонгодог бөгөөд энэ дүрд хатагтай Сонг маш сайн тохирохоор хүн. Тэрээр ажилсаг, эрч хүчтэй, хувийн зохион байгуулалт сайтай, үнэнч, хичээл зүтгэлтэй бас бусадтай учир зүйгээ сайн ололцоно. Өөрийн бүлгийн арван таван айлаас хэн нь явган зам цэвэрлэж, байшингийн урд талын зүлгийг тайрч, хог хаягдал цуглуулж хаях талаар хуваарь гарган ягштал мөрдүүлнэ. Ямар нэг сэжигтэй зүйл гарвал дээш нь яаралтай мэдэгдэх үүргийг тэр хүлээнэ.

Хатагтай Сонг Ардын Аюулгүй Байдлыг Хамгаалах Яамны нөхөр Канг хэмээх эмэгтэй ажилтанд илтгэх үүрэгтэй. Нөхөр Канг Хөдөлмөрийн Намын гишүүн, Пхеньянд танил талтай гэгдэх нэгэнтэй гэрлэсэн ба өөрөөс нь хэдэн насаар эгчмэд эмэгтэй. Хэдэн сар болоод нөхөр Канг хатагтай Сонгийн ирж ганц нэг аяга эрдэнэшишийн нэрмэл уунгаа тайланг нь сонсоно. Тэдний байрны оршин суугчид асуудал гаргадаггүй, байр бүхэлдээ тайван болохоор хатагтай Сонгод илтгэх зүйл бараг үгүй. Нэг удаа Чанг Бо хүүхдийн гутлын тухай ярианаас болж асуудалд орсноос бусдаар тэдний байрныхан өөр хүндрэл гаргаж байсангүй.

Гэвч нөхөр Канг хатагтай Сонгийг шахаж шаардах болов. Хүнс ховор байхад хүмүүс элдэв юм ярих л ёстой, нийгмээ муулж буй эсэхийг заавал олж мэд гэж тулгаж эхэллээ.

Тэд юу ч ярьдаггүй гэж хатагтай Сонг эсэргүүцнэ.

Үнэхээр юу ч ярихгүй. Хүмүүс хоорондоо ярилцаж байснаа түүнийг орж ирмэгц дуугаа хурааж, эвгүй нам гүм байдал үүснэ. Дарга нь дээш нь тэдний тухай тайлан тавьдгийг хүн бүхэн мэдэх юм хойно.

Нөхөр Кангийн сэтгэл ханасангүй. "Чи эхлээд өөрөө төр засгаа муулаад үз. Хүнс яагаад ховордоод байна гэх мэт. Тэгээд яахыг нь хар" хэмээн зааварчилна. Хатагтай Сонг сулхан толгой дохиод хурдан холдож явахыг хичээнэ. Тэр хэлснээр нь хийе гэж хэзээ ч бодож байсангүй. Хөршүүдээс нь хэн ч эсэргүү бодол санаа өвөрлөөгүй гэдгийг хатагтай Сонг сайн мэдэж байлаа. Тэдэн дунд ардын дайсан үнэхээр байхгүй. Хатагтай Сонг үзэл суртлаас залхаж эхэллээ.

Хоол муутайгаас болоод тэр ядарч турж эхлэв. Үр хүүхдээ тэжээх хоол хэрхэн олох талаар өдрийн бодол шөнийн зүүд болно. 1991 оноос хойш хувцасны үйлдвэр огт ажиллахаа больж сүүлийн нэг жилд тэр гар дээрээ бэлэн мөнгө тавиагүй. Хүнсний бүтээгдэхүүн байхгүй болохоор түгээх төвүүд ч ажиллахгүй. Иймээс хүнсний талон аваад ч хэрэг нь үгүй болов. Чанг Бо илүү цагаар ажилласныхаа хөлсөнд ургамлын тос, жигнэмэг, тамхи архи зэргийг олж ирдэг байснаа ч

больж. Их дэлгүүрүүдийн лангуунууд бүр хоосров. Үйлдвэр нь хаагдсаны дараа хатагтай Сонг хар зах дээр очихоос ичдэг байснаа больжээ. Хар зах дээр хүнсний олдоц сайн. Заримдаа будаа харагдах боловч тэнгэрт хадсан үнэтэй. Нэг кило будаа 25 вон буюу хүнс түгээлтийн төвөөс авдгаас нь арав дахин илүү үнэтэй.

Хатагтай Сонг хар зах дээр ажиллах тухай бодсоор л байв. Тэр юу хийж чадах билээ? Өөрт нь газар байхгүй учраас ногоо тарьж зарах боломж үгүй. Хэдэн тоо л нааш цааш болгохоос өөр наймааны чадвар гэхээр юм бас үгүй. Дөрвөн хүүхэд тэжээдэг, дээрээс нь том охиныхоо хуримыг хийсэн болохоор хадгалсан мөнгө гэхээр юм үлдээгүй. Сүүлд нь тэр гэрийнхээ эд хогшлоос зарж болох юм гэж бодоод эд зүйлээ тооцоолж үзэв. Дорно дахины нэг зураг, зурагт, нөхрийнх нь номууд бас оёдлын машин.

Хатагтай Сонгтой адил мянган мянган хүн юугаа зарж өл залгуулах талаар бодолд автсан байлаа. Хаанаас хүнс олох вэ?

Чонжинд газар гэж юм байхгүй болтол нь бүгдийг цардсан учир ойрхон гарч, ойд ан хийж, жимс түүж амь зуулгаа залгуулна гэсэн ойлголт үгүй. Хатагтай Сонгийн гэрийн ойролцоо байдаг далайн эргээс загас түүх гэхээр ус нь хэт гүнзгий учир гараар загас барих боломжгүй. Хүнс залгуулж болох цорын ганц газар нь Нанамын ойролцоох ногоо болон цагаан будааны тариалангийн талбайнууд байлаа.

Хүмүүс хоол хүнс олохоор ихээхэн хол газрыг туулах болов. Кёнсаны ойролцоох цэцэрлэгт хүрээлэнгээс жимс түүхээр хүмүүс олноор ирдэг боллоо. Амралтын өдрүүдээр Чонжиныхон таван км-ийн зайд орших энэ цэцэрлэгт хүрээлэн рүү зугаалга хийж буй дүр үзүүлэн алхан ирнэ. Хэн ч өлссөндөө хоол эрэн ирж байгаагаа мэдэгдүүлэхийг үл хүснэ. Энд Япон руу экспортолдог бэрсүүт жүржийн хэрийн том, алим шиг буржгар гадаргуутай лийр тариалдаг. Лийр боловсроод ирэхээрээ модноосоо унаж түүхэд амар болно. Лийр түүгчдийн ихэнх нь хүүхдүүд. Сургуульд өгдөг үдийн хоол багассаар сүүлдээ байхгүй болох үед өлссөн хүүхдүүд хичээлээ таслан хоолны эрэлд гарав. Хүүхдүүд төмөр утсаар хийсэн торон хашааны доогуур ядах юмгүй мөлхөн орж, жимс авч иддэг байлаа. 1992 онд арван настай байсан нэг хүү автобусны арын шатнаас зүүгдэн Нанамын эцсийн буудалд хүрч уг цэцэрлэгт хүрээлэн рүү нэг цаг хэртэй алхаж хүрдэг байж. Жижигхэн биетэй болохоор түүнийг хэн ч үл анзаарна. Торон хашааны доогуур ядах юмгүй шурган орж авчирсан уутандаа багтах хэрээр нь лийр чихэж авчраад найзууддаа хувааж өгдөг байснаа хожим нь дурсан ярьсан юм.

Бусад хүмүүсийн ярьсан түүх бүр ч өрөвдөлтэй. Тухайн үед анагаахын сургууль төгсөөд резидентурынхаа үед явж байсан Ким Жи Юн нэгэн амралтын өдрөөр эцэг эх, эгч, нөхөр болон хоёр бяцхан дүүтэйгээ цэцэрлэгт хүрээлэн рүү алхан ирсэн байна. Уйлж сандаргаад байсан хоёр бяцхан дүүгээ үүрч дүүрсээр зорьсон газраа очиход үд өнгөрсөн байж. Гэтэл тэднээс өмнө олон хүн ирсэн байсан учир жимс бараг үлдсэнгүй. Арай ядаж ганц ширхэг бага зэрэг ялзарсан лийр олж аваад гэртээ авчирч чанаад тав хувааж эцэг эх, хоёр бага дүү, хүргэн ахдаа хувааж өгөхөд өөрт нь болон эгчид нь үлдэх юм байгаагүй хэмээн дурсан ярьсан юм. 1993 оны есдүгээр сарын есний өдрийг тэр хэзээ ч мартдаггүй. Бүхэл өдөржин өлөн хоосон явсан Ким Жи Юн амьдрал нь

эргэлт буцалтгүйгээр өөрчлөгдсөнийг ойлгож цаашдаа хэрхэн амь зуухаа мэдэхгүй мэлрэхэд хүрчээ. Ард түмэн бодит байдлыг ойлготлоо олон жил байдал дээрдэнэ хэмээн найдсаар байсан билээ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хайр дурлалын түүх

Хүмүүс хотоос хөдөө тийш хүнс хоолны эрэлд цуврахыг анх ажиглах үедээ Ми Ран ахлах сургуульд сурч байв. Чонжин руу дугуйгаа унаад явж байхдаа гуйлга гуйх гэж буй юм шиг тааран уут барьсан хүмүүс замын хоёр талын цэцэрлэгт хүрээлэн рүү хошууран явж байх нь тааралддаг байв. Зарим нь тутарганы талбай руу ч явж харагдана. Аавынх нь ажилладаг шаазангийн шавар олборлох уурхайнуудын арын уулнаас түлээний мод түүж буй хотынхонтой ч тааралдана. Уг нь Ми Ран хотынхныг өөрсдөөс нь хамаагүй дээр амьдралтай гэж боддог байлаа. Учир нь Чонжинд зөвхөн Хөдөлмөрийн намын гишүүд болон тэдний гэр бүлийнхэнд зориулсан их дээд сургууль, том театр, хоолны газрууд байрладаг.

Гэтэл бол жижигхэн хотыг тойрсон хэдэн тосгоноос бүрдсэн асар өргөн төв гудамж бүхий дүүрэг юм. Японы түрэмгийлэгчдийг ялсан Ким Ир Сений амжилтыг бахархаж, мөнхжүүлэхээр барьсан том чулуун хөшөө төв гудамжинд нь байрлана. Шаазан ваарны, керамикийн хоёр ч үйлдвэр байх бөгөөд 1948 оны зургаадугаар сарын таванд Ким Ир Сен зочилж, газар дээр нь даалгавар өгсний дурсгалд зориулж "зургадугаар сарын таван" хэмээн нэрийдсэн цахилгаан хэрэгслийн томоохон үйлдвэр оршино. Ми Раны төрөлх тосгон яг хөдөө биш ч хотыг бодвол тариалангийн газар хүрэлцээтэй. Далайн эрэгтэй ойролцоо газрын хөрс элсэрхэг, овон товон багатай бас үржил шимтэй байдаг. Далайн эргээс холдоод уул руу өндөр газартаа нарс мод элбэг. Баян хуур хэлбэртэй байшингуудын хоорондох нарийн зурвасуудад улаан чинжүү, байцаа, манжин, бүр тамхи хүртэл тариалах болов. Бүх эрчүүд тамхи татдаг болохоор дэлгүүрээс авснаас өөрсдөө тарьж ургуулах нь хамаагүй хямд тусна. Хавтгай дээвэр бүхий байшинтай хүмүүс дээвэр дээрээ тэвш байрлуулж, ногоо тарих нь бий. Хэдийгээр энэ мэтээр ногоо тарих боловч хэмжээ нь бага учир эрх баригчид тоож оролдох нь үгүй. Өлсгөлөнгийн эхний жилүүдэд хүмүүс ийм маягаар амиа аргацааж байлаа.

Аав нь цалин авах нь багассаар бүр болих үед Ми Раны ээж амжиргаагаа залгуулахаар ханцуй шамлан ажилд оров. Хэдийгээр ээж нь гэрийн сайн эзэгтэй байгаагүй ч, аргагүй байдалд орохоороо бас ч чаддаг юмтай хүн байж. Гэрээрээ дүпү хийж заран, бас гахай үржүүлэхээр оролдсон ч тэжээлийн хомсдлоос амжилтгүй болж, харин оролдсон зүйлүүдээс нь хамгийн амжилттай нь дуураймал зайрмаг болов. Ээж нь хуучин хөлдөөгч хүнээс худалдан авав. Сүү, цөцгий олдохгүй учир дүпү шахсанаас үлдсэн шингэнийг ашиглана. Түүнийгээ улаан шош, элсэн чихэртэй холиод мөсний саванд хийгээд хөлдөөнө. Хүмүүс хүүхдээ эрхлүүлэхээс татгалздаггүй, илүү ганц хоёр воныг амттан авахад дуртайяа зарцуулдаг учраас уг бизнес амжилт олж байв. Хөдөлмөрийн Намаас хувиараа мөнгө хийхийг хориглосон боловч ээж нь тоосон ч үгүй. Ээж нь эсэргүү санаатайдаа биш, үзэл сурталд төдийлөн ач холбогдол өгдөггүйдээ тийм зоригтой байсан юм. Дуураймал зайрмаг зарж олсон мөнгөөрөө амуу будаа заримдаа цагаан будаа ч авдаг байжээ.

Ми Раныг далдуур шүтэн бишрэгч Жун Сан бас өлсгөлөнг мэдрэхгүй амьдарч байв. Жун Саны аавын талын эмээ өвөө нь бараг жил бүр усан онгоцоор айлчлан ирнэ. 1990-ээд оны эхээр усан

онгоц Чонжинд ирэхээ больсноос хойш Жун Саныхан хамаатнуудтайгаа уулзахаар Уонсон боомт ордог болов. Онгоцны тавцан дээр зогсож буй хамаатнуудтайгаа уулзан тэврэлдэж, уйлалдаж байх зуур өвөө нь зузаан түрийвчтэй мөнгө хүүгийнхээ халаасанд шургуулна. Мөнгөө аль болохоор мэдэгдэхгүй дамжуулахгүй бол албаныхан харчихвал татвар өгөхийг шаардана. Заримдаа дугтуйнд 2000 доллартай тэнцэхүйц иен байна. Японы солонгосчууд өөрсдийнх нь өгдөг мөнгөгүйгээр тэндэх хамаатнууд нь өлсөж зовно гэдгийг сайн мэддэг байжээ.

Жун Саны байшин ардаа хувийн хашаатай байсан учраас аав нь талбайгаа жижиглэн хувааж, төрөл бүрийн ногоо тарих болов. Тэр жижигхэн тэмдэглэлийн дэвтэр дээр ямар үр тарьсан, суулгацын гүн, үр нь хэр зэрэг хугацааны дараа соёолсон, ногоо ургаад боловсрох хүртэл ямар хугацаа орсон зэргийг нарийн бичиж тэмдэглэдэг байв. Ээж нь Японоос худалдаж авсан сайхан гал тогооны хэрэгслээ нарийн хоол хийхдээ ашиглана. Хурц иртэй хутгаараа лууван, манжинг савхан хэлбэрээр хэрчиж, агшаасан будаан дээр тавиад далайн байцаанд ороож иднэ. Үүнийг кимбаб гэж нэрлэх бөгөөд өмнөд Солонгост алдартай Японы макигийн хувилбар байжээ. Талбайдаа ургуулсан ногоо, хар захаас авсан будаа хоёроороо хооллон Жун Саны гэр бүл Хөдөлмөрийн Намын элит гишүүдээс бусад хүн амын ихэнхээс нь илүү тансаг амьдарч байлаа.

Тэдний цорын ганц бахархал бол Жун Сан хүү өөрөө байв. Шөнийн нэг цаг хүртэл хичээлээ давтсаныхаа дараа түр дугхийгээд үүрээр босож хичээлдээ бэлтгэнэ. Аав нь байнга яншиж, өөрөө ч гэр бүлийнхнийхээ хүслийг биелүүлэхийг хичээн, тун шургуу хичээллэсний үр дүнд Пхеньяны Их Сургуульд элсэн орж дөнгөв. Хэдийгээр Ким Ир Сений нэрэмжит их сургууль биш ч муугүй амжилт байлаа. Жун Саны элсэн орсон сургууль ирээдүйн эрдэмтдийг бэлтгэдэг гэдэг утгаараа гэр бүлийн гарлаас илүү сурлагын амжилтыг хардаг болохоор Жун Сан элсэж чадсан байв. Жун Саны бодлоор бол уран зохиол, философиор мэргэжих, бүр болдогсон бол кино найруулагч болохыг хүсэж байлаа. Гэвч Пхеньянд очих цорын ганц зам шинжлэх ухааны чиглэлээр сурах явдал гэдгийг аав нь мэдэж байсан болохоор хүүгээ эрдэмтэн судлаач болохыг тулгасан байна.

Хойд Хамён мужийн жирийн нэг хүү Пхеньяны Их сургуульд элсэж орно гэдэг асар том амжилт байв. Энэ сургуульд орсноор Жун Сан цэргийн албанаас чөлөөлөгдөж, нийгмийн давхаргаа дээшлүүлж, Хөдөлмөрийн намд элсэх боломж нээгдэв. Өөрийн орны улс төрийн тогтолцоонд эргэлзэх болсон Жун Сан хэрвээ коммунизм гэж тийм төгс зүйл юм бол Зүүн Германчууд яагаад Берлиний ханыг нураасан тухай эргэцүүлэн, хариулт олохыг хичээнэ. Намд элсэж, сургуулиа төгссөнөөр нийгмийн үндсэн давхарга руу шилжих бололцоотой болохоо ч сайн мэдэж байв.

Жун Сан өөрөөрөө бахархаж байв. Тэр чинээлэгдүү амьдрал, сурлага сайтайгаараа бардамнаж байсан удаагүй. Гэвч энэ удаад Пхеньянаас буцаж ирснийхээ дараа өөрийгөө дайнаас ирсэн баатар шиг төсөөлж байжээ. Цэргүүд шиг их сургуулийн оюутнууд ч бас дүрэмт хувцсаа сургуулийн бус орчинд ч байнга өмсөж явах ёстой. Дүрэмт хувцас нь давхар энгэртэй ногоон хүрэм, өмдний хослол, цагаан цамц, зангианаас бүрдэнэ. Ногоон өнгө залуу нас болон ногоорон харагдах уулыг их удирдагчийн хэлснээр бэлгэддэг гэнэ. Өөртөө улам бүр итгэх болсон Жун Сан Ми Раныг болзоонд урих эсэхээ шийдэж ядан байлаа. Охиныг анх кино театрт харснаас хойш таван жил өнгөрсөн боловч Жун Сан Ми Раныг огт мартсангүй. Сургуульд нь авьяастай, царайлаг охид олон байсан ч хэн ч түүний сонирхлыг Ми Ран шиг тэгтлээ татаагүй билээ.

Жун Сан дурласан охиныхоо талаар зарим зүйлийг мэдэж авсан байв. Ахлах сургуульд сурч байхдаа эгч Ми Суктай нь найзалдаг байжээ. Ми Ранаас хоёр насаар эгч Ми Сук охид дундаас хамгийн эршүүд зантай нь. Гар бөмбөгийн шигшээ багт тоглодог түүнтэй Жун Сан найзуудынх нь сургуулилт хийдэг зааланд байнга тааралдана. Мөн Ми Раны гэрийн ойролцоо байрладаг боксын дугуйланд найз нь явдаг учраас гэрийнх нь ойролцоо эргэлдэх шалтгаан Жун Санд байв. Ми Раных зурагт худалдан авч бусдадаа хүртэмжтэй байлгахын тулд хаалгаа түгждэггүй байв. Нэг удаа Жун Сан зурагт үзэх гэсэн найз нарынхаа хамт Ми Раныд яваад орчихов. Хүмүүс кино үзэж байхад Жун Сан зурагт Ми Ран хоёрыг ээлжлэн ширтэж байлаа. Ми Ран царайлаг охин болсон байв. Тэр түүний уруул, хамар, ам, нүдийг ээлжлэн харж, юу нь сэтгэлийг нь ингэтэл татаад байгааг олж харахыг хичээнэ.

Охинтой үерхэж ирээдүйдээ эрсдэл учруулах хэрэгтэй эсэхээ Жун Сан удтал тунгаан бодсоны эцэст үерхэхээр шийдлээ.

Жун Сан 1991 онд нэгдүгээр дамжааны зуны амралтаар нутагтаа ирэхдээ Ми Рантай уулзахаар зэхэв. Гэрийнх нь ойролцоо эргэлдэж байгаад зах руу явахыг нь олж харуутаа хэдэн үг солихоор шийдлээ. Гэтэл дөхөж яваад ээж нь ардхан талд нь явж байгааг олж харан зүрх алджээ.

Ингээд Ми Сукийг дүүтэйгээ танилцуулаад өгөөч хэмээн гуйлаа. Урьдчилан тохиролцсоны дагуу Жун Саныг Ми Раны гэрт ирэхэд эгч нь дүүгээ "гараад ир, манай найзтай танилц" хэмээн дуудав. Ми Ран толгойгоо цухуйлгаснаа ичив бололтой буцаад шургав. "Дуудаад ирэхгүй бол чирээд гаргана шүү" гэж эгч нь хашгирав. Эцэст нь Ми Ран Жун Сантай мэндлэхээр гарч ирлээ. Ми Рантай анх удаа нүүр тулан уулзаад цамцных нь зах хөлсөнд норохыг мэдэрчээ. Ми Рантай ярьж байхдаа хоолой нь чичирч, гар нь салгалсан ч орхиод явахад дэндүү оройтжээ. Тэр бүхнийг эхнээс нь ярьж гарлаа. Анх кино театрт өөрийг нь хэрхэн олж харснаа, хэдэн жилийн турш сэтгэлдээ үргэлж хадгалж явсан зэргээ яриу. Тэгээд ярианыхаа эцэст өөртэй нь үерхээч хэмээн гуйлаа.

Би уг нь даалгавраа сайн хийж онц сурах ёстой. Гэтэл хичээл хийх гэхээр чи бодогдоод төвлөрч чадахгүй юм хэмээн пал хийтэл хэлж орхив.

Ми Ран юу ч хэлсэнгүй, Жун Сантай харц тулгарахаас зайлсхийн алсыг ширтэн зогссоор байлаа. Ми Раныг юм хэлэхгүй болохоор сандарсандаа толгой нь зад үсрэх гэж байгаа мэт санагдана. Яриандаа оруулахыг оролдон "Чи намайг өөрийг чинь ширтээд л байхад анзаардаггүй байсан гэж үү?" хэмээн асуув. "Үгүй, ёстой тийм гэж бодоогүй. Би чамд дургүй байгаа юм биш л дээ. Гэхдээ юу бодож байгаагаа бичээд чамд захиа явуулъя" хэмээн Ми Ран хэлэв. Өнгөн дээрээ хөндий мэт царайлсан ч үнэн хэрэгтээ Ми Ран маш их баярлажээ. Үерхье хэмээн гуйж буй залуу нь царайлаг, сайхан ааштай, сайн хүн байлаа. Ми Раны мэддэг хөвгүүдээс хоёрхон нь коллежид сурдаг байсан боловч Пхеньянд биш. Тэр маш их гайхсан боловч гэрийнх нь ойролцоо Жун Саны эргэлдээд байсны учрыг сая л ойлгох шиг болжээ. Дээр нь Жун Саны ногоон дүрэмт хувцас маш их таалагдав. Хоёр эгнээ гялалзсан сайхан товч бүхий дүрэмт хувцас өмссөн тэнгисийн цэргийн

офицер өмнө нь зогсож байх шиг санагджээ. Ми Ран үерхэж үзээгүй боловч нэлээд цааргалж байж хариу өгөх ёстой гэдгээ зөн совингоороо мэдэрсэн байна. Үерхэх дуртай байгаага нэг их үзүүлэхгүйгээр яаж зөвшөөрсөн хариу өгөхөө сайн мэдсэнгүй. Эцэст нь маш хуурай, албаны өнгөтэй захиа бичиж хэдэн долоо хоногийн дараа Жун Санд өглөө. "Хичээлээ давтах гэхээр төвлөрч чадахгүй байгааг чинь харгалзан үзээд би чиний тавьсан саналыг зөвшөөрч байна" хэмээн уг захиандаа өгүүлжээ. Ингэж тэдний харьцаа 19-р зууны үеийн захидал солилцох хэмжээнд арай гэж очив. Охин хүү хоёрт холбоотой байх цорын ганц арга нь захидал бичилцэх байлаа. 1991 онд Өмнөд Солонгос гар утасны дэлхийн хамгийн том үйлдвэрлэгч, экспортлогч улс болоод байхад Хойд Солонгост гар утас хэрэглэж үзсэн хүн цөөн байжээ. Утсаар ярихын тулд холбоон дээр очно. Цаас ховордсоны улмаас захидлаар харилцах ч хэцүү болсон цаг. Амуу тарианы хальсаар хийсэн цаас нь чангахан дарахад урагддаг эд байж. Тиймээс хүмүүс сонины зах хайчилж аваад цаас болгон хэрэглэнэ. Ми Ран импортоор орж ирсэн цаас худалдан авах гэж ээжээсээ хэдэн вон гуйж шалсаар авна. Ноороглох ямар ч боломжгүй учраас хэдэн цагаар сэтгэл дотроо бодсоны эцэст цаасан дээр буулгана. Пхеньян, Чонжин хоёрын зай холгүй боловч захиа эзэндээ очих гэж дор хаяж нэг сар болдог байжээ.

Тэднийг үерхэж эхлэх үед Ми Ран ахлах сургуулийн төгсөх ангид сурч байлаа. Найз залуу нь өөрөөс нь хамаагүй дээгүүр зиндаанд байгаа нь Ми Раныг айлгана. Жун Санд импортын цаас ямар ч асуудалгүй олдож, тэр найз охиндоо хэдэн хуудас захиа тосон балаар бичнэ. Эхлээд албан ёсны хуурайдуу байсан харилцаа яваандаа насанд хүрсэн хүмүүсийн хайр сэтгэлийн харилцаа болон хувирлаа. Жун Сан хэзээ ч Холливудын хайр сэтгэлийн сэдэвтэй кино үзээгүй боловч орчин үеийн гал дөлтэй хайр сэтгэл ямар байх талаар өөрөө ургуулан бодож захидалдаа тусгана. Гал шаргал болон ягаан өнгөөр туяарсан тэнгэрийн хаяаны наахан талд бие бие рүүгээ тэмүүлэн гүйж байгаагаар өөрсдийгөө дүрслэн бичнэ. Пхеньянд очоод уншсан яруу найргуудаасаа иш татна. Мөн хайрын тухай шүлэг бичиж явуулна. Цаасан дээр бичиж байгаа болохоор ичиж зовох шаардлага үгүй.

Жун Сан тэр үед ажил хийж эхлээд байсан Ми Сукт захиагаа хаяглана. Ми Ран үерхлийнхээ тухай ганцхан Ми Сукт л цухуйлгасан байв. Харин Жун Сан хэнд ч хэлсэнгүй. Үерхлээ яагаад нууц байлгах ёстойгоо тэд хэзээ ч ярилцаж байсангүй. Учир нь тэнд нийгмийн давхарга болон бэлгийн харьцааны талаар хэн ч нээлттэй ярьж, бас шүүмжилж зүрхэлдэггүй байсан ба энэ нь төр засгаа доромжилсонтой адилд тооцогдоно. Хэрэв тэд гэрлэвэл Жун Саны ирээдүйн ажил, намд элсэх зэрэгт нь саад тотгор болно гэдгийг хоёул мэдэж байв. Жун Саны аав мэдвэл сайн юм болохгүй нь ч тодорхой байлаа. Жун Сан гэрлэхээр бол өөрийн хүрээлэл буюу Японы солонгосчуудын нэгтэй гэрлэх нь тодорхой юм. "Битгий охид хөөгөөд гүйгээд бай. Эхлээд сургуулиа төгс" гэж аав нь номчирхоно.

Хойд Солонгос дахь гэрлэлт, хайр сэтгэл, бэлгийн харилцааны талаар товч дурдья. Хойд Солонгосчууд болзох, хэсэг хамтран амьдрах талаар ойлголт ч байхгүй. Ихэнх гэрлэлт төлөвлөгдсөн байдаг. Гэр бүлийнхэн, намын дарга эсвэл зүгээр ажлын газрын дарга нь хүмүүсийг хооронд нь танилцуулж гэрлүүлнэ. Бие биедээ сайн байгаага хос хоёр олны дунд харуулж болохгүй. Гараа барилцах нь ч хүртэл хориотой. Өмнөд Солонгос руу оргосон хүмүүсийн яриагаар гэрлэхийн өмнө бэлгийн харьцаанд орох, оюутнууд жирэмсэн болох зэрэг нь байж

болшгүй зүйл. Хэрвээ ийм тохиолдол гарвал олны шившиг болно. Тэнд Өмнөд Солонгос, Японыхтой адил хосуудын буудал үгүй. Аялах зөвшөөрлийн бичиггүйгээр зүгээр л буудалд буух ямар ч боломжгүй ба гэрлээгүй хосыг буудал хүлээн авах ч үгүй. Чонжины зарим хүн хэрэв гэрлээгүй хүмүүс бэлгийн харьцаанд орохыг хүсвэл уул эсвэл цэцэрлэгт хүрээлэн рүү явдаг хэмээн ярьсан билээ. Гэвч миний уулзсан хүмүүс дотор ийм харьцаанд орж байсан хүн таараагүй.

Ичимхий, даруу байдал Солонгосын соёлын салшгүй хэсэг юм. Сөүлд очиход сургуулийн сурагч охин богино эрэн банзал өмссөн байх нь захаас аваад тааралдана. Гэтэл нэг зуун жилийн өмнө Солонгос эмэгтэйчүүд бүх биеэ халхалсан нөмрөг маягийн хувцас өмсдөг байжээ. 19-р зуунд аялан бичигч Изабелла Бэрд Бишоп 1897 онд Пхеньянаас хойхон оршдог нэгэн тосгоны эмэгтэйчүүд мусульман шашинт эмэгтэйчүүдийн өмсдөг буркатай адил хувцас өмссөнийг "манай манаач нарын торон малгайтай адил боловч асар том" хэмээн тодорхойлсон ба хэмжээ нь долоон тохой урт, таван тохой өргөн, гурван тохой гүн учир эмэгтэй хүний биеийн галбирыг бүрэн нууж чадна гэжээ. Дунд болоод дээд давхаргын эмэгтэйчүүд тогтоосон цагаас бусад үед гадаа гарах эрхгүй, тэр цагт нь гудамжинд нэг ч эрэгтэй хүн байхгүй болдог аж. Бишоп олон орноор тухайлбал лалын шашинтай орнуудаар аялсныхаа дараа Солонгосын эмэгтэйчүүд бол хамгийн их дарлал доромжлол амсаж яваа хүмүүс хэмээн тодорхойлсон байна.

Өмсдөг хувцас нь өөрчлөгдсөн боловч хуучин хандлагууд нь хэвээр. Ким Ир Сен засгийн эрхэнд гарсныхаа дараа бэлгийн харилцааны талаарх бурангуй үеийн хуучинсаг үзлийг коммунист дэглэмийн үзэн ядалттай хослуулж нухчин дарж эхэлжээ. Бүх эмсийн хүрээлэнг хаагаад зогсохгүй баян эрчүүдийг зугаацуулдаг үйлчилгээтэй кисаенг хэмээх газруудыг байхгүй болгов. Садар самууныг дэлгэрүүлэгчдийг цаазалж байв. Харин өөрийн болон бага залуудаа плэйбой байсан хүү Ким Чен Иррийнхээ бусармаг үйлдлүүдийг олон нийт мэдэхгүй хэмээн бодно. Харин иймэрхүү асуудалд орооцолдсон намын гишүүд шууд ажлаасаа халагддаг байжээ.

Ким Ир Сен ард түмнээ эрт гэрлэхийг хориглож эрэгтэйчүүд гуч, эмэгтэйчүүд хорин найман насандаа гэрлэх тухай шийдвэрийг 1971 онд гаргажээ. Хойд Солонгосын сонины мэдээлснээр иргэд нь эх орныхоо төлөө хангалттай зүйл хийсний дараа өөрийнхөө амьдралыг бодож гэрлэж болно. Харин энэ нь Солонгосын ёс заншил биш байв. Хуучны заншлаар бол эмэгтэйчүүд 14 нас хүрэхдээ хадамд гарсан байх ёстой. Гэтэл дээрх шийдвэрийг гаргасан учир нь цэргийн эрчүүдээ бодсон хэрэг байлаа. Эмэгтэйчүүдийг хорин найм хүртлээ гэрлэхийг нь хориглохоор цэргийн албан хаагчид албаа дуусгаад буцаж иртэл нь сүйт бүсгүй нь хүссэн ч хүсээгүй ч хүлээх болно. Ингээд төрөлт буурч эхлэв. Энэ хязгаарлалт 1990-ээд онд хүчингүй болсон ч тэд одоо хүртэл залуус эрт гэрлэхтэй төдийлөн эвлэрч чадахгүй л байгаа.

Суртал ухуулгын кампанит ажлууд эмэгтэйчүүдийг социалист нийгмийн үзэл сурталд тааруулан үсээ янзлуулахыг уриалдаг ба энэ нь дунд насны эмэгтэйчүүд үсээ богино тайруулж хими хийлгэх, хадамд гараагүй бүсгүйчүүд үсээ ургуулах боловч задгай тавихгүй боох буюу сүлжих ёстой гэсэн үг. Эмэгтэйчүүд нь өвдөгнөөс дээш татсан банзал, ханцуйгүй цамц өмсөж үл болно. Сонирхолтой нь 1970-аад онд Парк Чунг Хи хэмээх цэргийн дарангуйлагчийн захиргаанд байхад Өмнөд Солонгосын эмэгтэйчүүд мөн үс болон хувцаслалтын талаар үүнтэй төстэй журмыг сахидаг байжээ. Хойд Солонгос цаг хугацааны хувьд Өмнөд хөршөөсөө хэр хоцорч байгааг, мөн

Өмнөд Солонгосын хэр өөрчлөгдөж байгааг зөвхөн энэ жишээнээс тодорхой харж болно. Хэдхэн жилийн өмнө Өмнөд Солонгосын жуулчид ирж очихыг зөвшөөрдөг Хойд Солонгосын хэсэгт явж байхдаа богино жинсэн өмд, майка өмссөн Өмнөдийн залуу бүсгүйг хараад зочид буудлын хаалгачийн царай зэвхийрэн унах нь уу гэмээр болж байсныг би харсан. Миний ярилцсан Өмнөд рүү оргон гарагсадын ихэнх нь, залуус олны нүдэн дээр үнсэлцэж байгааг хараад ихэд гайхсанаа нуугаагүй юм.

Жун Сан Ми Ран хоёрын харилцаа цахилгаан тасарснаар илүү дотно болж эхлэв. Гэрэлгүй, тас харанхуй амьдралыг цахилгаанжсан ертөнцийнхөн хэзээ ч гүйцэд ойлгохгүй байх. Гудамжинд сүүмийх ч гэрэл үгүй, айлуудын хөшиг, хаалганы завсраас гийх юу ч үгүй орчин. Хэн нэгэн явж байгааг зөвхөн тамхиных нь галаар л олж мэднэ.

Оройн хоолны дараа Жун Сан түр гарах зөвшөөрөл авна. Их сургуулийн оюутан, хорин нас хүрсэн, үеийнхнээсээ толгой өндөр тэрээр эцгээсээ эмээдэг хэвээр л байв. Ахлах сургуулийн тэр энэ найзтайгаа уулзчихаад 21 цаг гэхэд ороод ирнэ гэж хэлээд гарч явна. Гэвч шөнө дунд хүртэл гэртээ эргэж ирэхгүй.

Ми Раных руу очихдоо Жун Сан гуч орчим хором алхдаг. Хэдийгээр Ми Ран ээждээ аяга таваг угаахад нь туслаад гарч ирэх болоогүйг мэдсэн ч Жун Сан яаран алхана. Ми Раны хөрш, түүнтэй хамт боксын дугуйланд явдаг найзынх нь нүүсэн тул тэнд байгаагаа тайлбарлах шалтгаангүй болсон учир Ми Раныг нуугдан хүлээнэ. Ийн бусдад мэдэгдэхгүй гэсэндээ чимээгүй зогсож байхад зүрхнийх нь цохилт дуулдах шиг болдог байжээ.

Энэ үед тэдний хамтдаа очиж болох цөөхөн газар бүгд хаалгаа барьсан байв. Кёнсаны кино театр, зоогийн газрууд бүгд цахилгаан тасарсны улмаас хаагджээ. Чонжины төвд нуурын эрэг дээр орших Залуучуудын Парк руу явж болох ч хотын төвөөс зах орохын тулд зөвшөөрөл хэрэгтэй байдаг тул яах ч арга үгүй. Кёнсаны галт тэрэгний буудлын арын цэцэрлэгт хүрээлэн рүү очих гэхээр таньдаг хүнтэй таарч мэдэх тул бас зүрхшээнэ.

Тэгэхээр хамгийн зөв арга бол хамтдаа алхах. Цорын ганц зам нь хотын дундуур явж уул руу чиглэнэ. Эхлээд тэд ямар нэг юмнаас зугтаж байгаа мэт харагдахгүй гэсэндээ чадлаараа зөөлхөн алхана. Ким Ир Сений инээмсэглэсэн зураг бүхий самбар, "Намын шийдвэрийг бид дагана", "Ким Чен Ир-ийг өөрсдийн амиараа хамгаалъя" гэх мэт сүржин үгс бүхий замын тэмдгүүдийг өнгөртөл юу ч ярихгүй. Цэнхэр цэцгэн хээгээр чимэглэсэн нуман дээвэртэй гулдан хаалга хүрэхийн өмнө замын хажууд жад барьсан цэргүүдийн өнгө алагласан зураг бүхий самбар байх. Ингээд бага зэрэг цаашлахаар хотоос гарч, амсхийнэ. Энд ирэхэд тэдний хараа харанхуйд аль хэдийн дасч юмсыг ялгаж харахтайгаа болно. Замын хоёр талаар өндөр гээч нь ургасан модод мөчрөө даахгүй бие бие рүүгээ ханаран орооцолдож сүүдрэвч үүсгэсэн байдаг. Үүлгүй үед одод модны мөчрийн завсраар харагдана. Хэдэн хормын дараа зам өгсүүр болж ирнэ. Чулуурхаг уулын хажуугаар нарсны өтгөн шугуй хөглөрч, бэлээр нь хөх ягаан өнгийн цэцэгс багсайн ургасан харагдана.

Элсэрхэг эрэг бүхий жижиг горхийг уг зам дайран гарах бөгөөд Онфо хэмээх эндээ л нэртэй ходоодны өвчнөөс эхлээд үргүйдлийг хүртэл эмчлэх ид шидтэй халуун рашаанд цутгана. Уулын

оройд замын төгсгөл хавьд олон харуулын цэгээр хүрээлүүлсэн Ким Ир Сений өргөө байрлана. Ким Ир Сен улс даяар иймэрхүү гуч орчим өргөөтэй гэлцэнэ. Олон буутай цэрэг манаж байдаг болохоор энгийн хүмүүс тийшээ зүглэхийг ч зүрхлэхгүй. Тэндээс намын гишүүдэд зориулсан тусгай зэрэглэлийн нэгэн рашаан сувилал үзэгдэнэ. Өмнө нь нийтэд зориулан барьсан рашаан сувиллууд эдийн засгийн хямралаас болж бараг л үүдээ барих шахаж, балгас төдий л юм үлджээ. Уг рашаан сувиллыг 1946 онд барьсан ба нээлтэн дээр нь агуу их удирдагч ирж байжээ. Түүнээс хойш засвар хийгдээгүй гэлцэнэ. Гэвч залуу хос энэ бүхнийг ажиглах ч сөхөөгүй, хамт байгаадаа сэтгэл хөөрөн, удаан алхсанаас өвдөх хөлөө ч үл тооно.

Яриад л, алхаад л байна. Яриа нь хэн хэндээ маш сонирхолтой. Нүүр тулаад ирэхээрээ Жун Саны нөгөө захиан дээр бичдэг шиг романтик байдал огт үгүй болно. Гэхдээ Ми Раныг хүндэлж соёлтой харьцдаг байсан агаад гурван жил үерхсэнийхээ дараа л гарыг нь хааяа атгадаг болжээ. Жун Сан хамт сурдаг оюутнууд, дотуур байрны тухай, бас оюутнууд батальон болон хуваагдаад цэргүүд шиг гараа саван алхаж оройн тооллогод ордог тухай, Ми Раны амьдралдаа ганц удаа, хүүхэд байхдаа тойрон аяллаар очиж, Пхеньянаар аялсан тухайгаа ярина. Ухуулга сурталчилгаанд Пхеньяныг дэлхийн архитектурын сор болсон барилга байшингуудтай, орчин үеийн үлгэр жишээ хот мэтээр ард иргэддээ ухуулдаг. Жун Сан хос цамхаг бүхий хамгийн дээд давхартаа эргэлддэг ресторантай Корё зочид буудлын тухай үлгэр мэт зүйлийг Ми Ранд ярьж өгнө. Жун Сан дотор нь орж үзээгүй боловч удахгүй баригдаж дуусах 105 давхар, Азидаа хамгийн өндөрт тооцогдох ёстой уг зочид буудлын сүр хүчийг холоос харж алмайрдаг тухайгаа хүүрнэнэ. Газар доор 91 метрийн дор байх Пхеньяны метро болон олон салаа гэрэл, Ким Ир Сений зүймэл шилэн хөрөг бүхий буудлуудын талаар бас ярьж өгнө.

Пхеньянд байхдаа Жун Сан долларын дэлгүүрт орж, эрвээхэйн хэлбэртэй, дөрвөлжин болор шигтгээтэй үсний хавчаар авчирч өгсөн нь Ми Раны хамгийн гоёмсог нандин зүйл нь болов. Тэр амьдралдаа хэзээ ч ийм сайхан бэлэг авч үзээгүй байжээ. Ээжийнхээ байцаахаас айж Ми Раны хавчаараа зүүж зүрхэлсэнгүй, дотуур хувцсандаа ороогоод далдын далд нуужээ.

Жун Саны Пхеньян дахь амьдрал Ми Ранд хүршгүй сайхан мэт санагдан, амьдралын талаар бага ч гэсэн ойлголт өгч, зарим талаар бяцхан атаархал төрүүлдэг байлаа. Ми Раны ахлах сургуулийн төгсөх ангийн сурагч болохоор цаашид дээд сургуульд орж чадахгүй байх вий хэмээн сэтгэл нь түгшиж байв. Эгч нарынх нь мөрөөдөл аавынх нь нийгмийн гарлаас болж нэг нэгээрээ нуран унасан байлаа. Дээд сургуульд орж сурахын тулд Дээд Боловсролын Газраас зөвшөөрөл авдаг энэ нийгэмд гурван эгчийн нэг нь л дээд сургуульд орсон боловч хүссэн мэргэжлээрээ сурч чадаагүй. Дуулах гоц авьяастай эгч нь биеийн тамирын сургуульд орсон тул сурч гавьсангүй, гэрлэхээр дундаас нь хаясан байна.

Жун Саны яриаг шимтэн сонсоод Ми Раны ирээдүйнхээ талаар бодож үзэв. Үйлдвэрийн ажилчин болж, бас нэг ажилчин залуутай гэрлэж, үр хүүхэдтэй болоод, хөгшрөөд үхэх ирээдүй өөрийг нь хүлээж байгаа мэт бодогдоно. Жун Сан найз нөхөд, нэг өрөөнд хамт амьдардаг оюутнуудынхаа талаар ярих тусам Ми Ранд улам хэцүү болж ирэв. Жун Сан Ми Раныг сэтгэлээр унаж байгааг гадарласан ч өөрөө "Надад амьдралын зорилго алга" хэмээн санаандгүй хэлэх хүртэл нь эргэлзэж байсан аж. Пхеньянд очоод хэдэн долоо хоногийн дараа "Байдал өөрчлөгдөж болно. Хэрэв чи

амьдралаа өөрчлөхийг хүсэж л байгаа бол өөртөө итгэх хэрэгтэй, тэгсэн цагт мөрөөдөл чинь биелэх болно" гэсэн үгс бүхий захиаг Ми Ранд илгээжээ.

Жун Сан энэ захиагаараа намайг зоригжуулж, амьдралаа өөрчлөх хүслийг минь бадраасан хэмээн Ми Ран хожим ярьсан юм. Хэдийгээр сурлага гайгүйтай ч тэртэй тэргүй юунд ч хүрэхгүй юм чинь хичээгээд хэрэггүй гэсэн бодлоор хичээлдээ хандах хандлага нь суларч, дүн нь муудсан байв. Харин Жун Саны үг түүнийг орвонгоор нь өөрчилж номд шамдах болов. Гэрийн ажлаас чөлөөлж өгөхийг ээжээсээ гуйж, багшаасаа дээд сургуулийн шалгалт өгөхөд нь туслахыг хүсэв. Хэрэв дээд сургуульд орж чадахгүй бол өөрийн минь л хохь хэмээн өөртөө амлаж байлаа.

Хичээл зүтгэлийнхээ үр шимийг хүртэж Ми Ран Чонжины тэргүүний гурван багшийн сургуулийн нэг болох, Ким Чен Ир-ийн ээж Ким Жон Сукийн нэрэмжит багшийн сургуульд тэнцэв. Эгч нар нь чадаагүй байхад Ми Ранд яаж ийм их аз дайрав аа? Өөрөө ч гайхаж байв. Ми Ран хэдийгээр сурлагаар дажгүй боловч ангидаа тэргүүлж чаддаггүй байж. Өөр шиг нь сурлагатай боловч нийгмийн гарлаараа хамаагүй сайн охид зөндөө байхад яагаад намайг оруулсан юм бол гэж гайхна. Ядаж л өөрийг нь хасаад арын хаалгаар ороод ирэх хүүхэд ч байж л баймаар.

1991 оны намар гэрээсээ нүүж сургуулийнхаа дотуур байранд оров. Сургууль нь Похан дүүргийн төвд Ким Ир Сений хөшөөний ард байх паркийн эсрэг талд байрлана. Сургуульдаа ирэнгүүтээ Ми Ран ихэд гайхан баярлав.

Сургуулийн дотуур байранд дөрвөн охин нэг өрөөнд амьдрах ба тус бүр нэг ортой байсан нь халсан шалан дээр гудас дэвсээд унтдаг охинд орчин үеийн санагдалгүй яахав. Гэвч өвөл болж хүйтрээд ирэхэд дотуур байр нь халаалтгүй болохыг ойлгов. Ийнхүү яагаад нэгдүгээр дамжааны оюутныг дотуур байранд уриалгахан хүлээж авсны нууц тайлагджээ. Ми Ран шөнө унтахдаа гадуур хувцас, олон давхар оймс өмсөж нүүр гарын алчуураар толгойгоо ороодог байв. Сэрэхэд нь амьсгаанд нь норсон алчуур цантаж хатуурсан байна. Охид сарын тэмдэг ирэх үед хэрэглэдэг алчуураа угаалгын өрөөнд угаагаад хатаахаар дэлгэх төдийд л хөлдсөн байна.(тэр үед эмэгтэйчүүдийн хэрэглэл байгаагүй бөгөөд чинээлэг амьдралтай айлын хүүхдүүд маарл, хөвөн, бусад нь хямд даавуу хэрэглэдэг байжээ). Ми Ран өглөө болохыг үзэн яддаг байж. Учир нь Жун Саны сургууль шиг тэд өглөө зургаан цагт босох ба ялгаа нь цэргүүд шиг урам зоригтой алхах биш бүгд бие засах өрөө рүү гүйлдэн, тэнд хатаахаар тохсон даавуунуудын дор зогсож, мөс шиг хүйтэн усаар нүүрээ угаацгаана.

Дотуур байрны хоол бүр муу. Өдөрт хоёр л удаа хооллох уриалга гарсан байсан тэр үед сургуулийн дотуур байр ганц л хоол өгнө. Тэр нь давс, ус, шар манжингийн навчаар хийсэн шөл төдий зүйл. Заримдаа нэг халбага будаа, эрдэнэшиш зэргийг нэмэх боловч хоолоо арвижуулах гээд ялзартал нь чанана. Охид өвдөж эхэллээ. Ми Раны өрөөний нэг охин хоол тэжээлийн дутагдлаас болж нүүрнийх нь арьс нь гуужин унаж, аргагүйн эрхэнд сургуулиа орхиж, бусад нь ч даган гарч эхэлсэн байна.

Ми Ран ажилсаг ээжийхээ ачаар эдийн засгийн хямралын үеэр өлсөхийг мэдэрч үзээгүй байсан бол энд л бусад хүмүүс хэрхэн зовж байгааг өөрийн биеэр амсав. Ээжээсээ хүнс явуулахыг гуйсаар сүүлдээ ч чадахаа байж зөвшөөрөл гуйн дотуур байрнаас гараад, сургуультай нь ойрхон

хамаатныдаа хичээлийн өдрүүдэд хонож, амралтын өдрүүдээр гэртээ харина. Уг нь үүнийг сургууль нь зөвшөөрдөггүй боловч нэг ч гэсэн хүн хоол хороохоо больсонд баярлаад л явуулж орхино.

Энэ үед Жун Саны амьдрал хамаагүй дээр байлаа. Элит оюутнууд буюу маргаашийн эрдэмтэн мэргэд улс эх орныг өлсгөлөнгийн аюулаас аварна гэж үзэж төр засгаас тэдэнд илүү анхаарал халамж тавьж байв. Өглөө эрт босож цэргийн маршаар явдаг нь хэвээрээ боловч тэд өдөрт гурван удаа хооллодог, дотуур байр нь халаалттай, хичээлээ давтах нөхцлийг нь бүрдүүлэх гэж цахилгааныг нь тасалдаггүй байжээ.

Жун Сан, Ми Ран хоёр жилд гурван удаа л бие биеийнхээ барааг харна. Оюутны өвөл, зуны амралт, хаврын ажил. Өмнө нь хаврын тариалалтын үеэр Пхеньяны оюутнуудыг хөдөө явуулж тариалалтанд тусалцуулдаг байсан юм. Харин одоо хооллож чадахгүйгээсээ болж гэр лүү нь явуулдаг болжээ. Өмнө нь сайн дурын ажлыг үздэггүй байсан Жун Сан одоо бол тэсэн ядан хүлээдэг болж. Энэ нь түүнд хичээл номоосоо хөндийрч, амрах боломж олгоно. "Би заримдаа бүхнийг хаячихаад түүн рүүгээ л гүйчихмээр санагддаг байлаа. Амьдралд хамгийн чухал зүйл бол хүний сэтгэл юм байна гэдгийг би тэр л үед ойлгосон" хэмээн хожим нь дурсан ярьж билээ.

1993 оны намар Жун Саны эгч гэрлэх гээд ид ажилтай байсан үе. Эцэг эх нь хичээлээ таслан ирж хэрэггүй хэмээн хориглосон ч Жун Сан гэнэт очиж Ми Раныгаа баярлуулахаар шийдэв. Энэ үед галт тэрэг цахилгаанаар ажилладгаас шалтгаалаад явалт нь тохиолдлын шинжтэй болсон байв. Яаж ийгээд тасалбар олж авсан ч орсон хойноо суудал олдохгүй нь олонтаа. Галт тэрэгний буудлууд үргэлж хүнээр дүүрэн. Хүмүүс буудал дээр тамхи татан, дэмий л холхицгоож, дараагийн галт тэргийг хүлээнэ. Ингээд арай ядаж нэг галт тэрэг ирмэгц дайрч, ноцолдох, хагархай цонхоор нь орох зэргээр зэрлэг авирлацгаана. Тасалбар олдоогүй ч Жун Сан буудал дээр яаж ийгээд орчих санаатай хүлээв. Нэг өдрийн дараа ачааны галт тэрэг олж машинистад нь хэдэн тамхи өгч байж, Чонжин руу явахыг нь мэдэв. Тэр нүүрээ алчуураар битүүлээд нүүрсний вагонд орж суулаа. Жун Сан ганц энэ тохиолдолд ч биш, олон удаа энэ мэтээр аялсан юм.

Чонжины өмнөх өртөөн дээр Жун Сан вагоноос үсрэн буугаад шууд Ми Раны гэр рүү гүйв. Ням гаригийн өглөө эрт, уулздаг өдөр нь биш байсан боловч Жун Сан тэссэнгүй. Харанхуй болохыг яагаад ч хүлээж чадахааргүй байв. Амралтын өдөр болохоор Ми Раныг гэртээ байгаад эргэлзсэнгүй. Үерхэж эхэлснээсээ хойш анх удаа гэрт нь өдрийн цагаар очиж буй нь энэ. Ээж нь хаалга тайлж өгөв. Уг нь Ми Раны ээж түүнийг хөршийнх нь хүүхдүүдтэй тоглодог хүү гэж мэдэх боловч энэ удаа хөө тортог болсон царайг нь хараад таньсангүй. Тэгээд ч Ми Ран гэртээ эзгүй байж таарав.

"Нэг сонин хүн чамтай уулзахаар ирсэн. Ямар янзын хүмүүстэй нөхөрлөөд байна даа" хэмээн ээж нь Ми Раныг зандарчээ.

Жун Саны аав нь хичээлээ таслан байж ирсэн хүүдээ тийм ч таатай хандсангүйгээр барахгүй чухам ямар шалтгаантайг нь шалгааж гарав. Нэг орой ээж нь эзгүй, аав нь шөнийн ээлжинд гарсан хойгуур Жун Сан Ми Раныг очив. Гэтэл санаандгүй аав нь буцаж ирж таараад нуугдсан байна.

Хожим нь хосууд эцэг эхээ хуурснаа ярьж баахан инээлдэцгээсэн гэнэ. Үнэн хэрэгтээ эцэг эхээ тийнхүү хуурах нь өөрсдөд нь ч таалагдаж. Хувийн нууц гэж байхгүй нийгэмд хэн хэнээсээ айлгүйгээр бусдыг шоолон инээсэн явдал хоёр биедээ итгэж болох юм гэсэн сэтгэгдэл үлдээж, зарим нэг хязгаарлалтыг давсан хэрэг болсон биз ээ.

Тэд их инээлддэг байлаа. Инээнэ, ярина. Хожим амьдрал нь баталгаатай тайван болсон хойно тэртээ жилүүдийг хоёулаа амьдралынх нь хамгийн аз жаргалтай мөчүүд байсан хэмээн дурсан ярьсан билээ. Залуу насны хөнгөмсөг зангаасаа болж эргэн тойронд нь юу болж буйг тэд огт анзаардаггүй байж.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ

БУРХАН ҮГҮЙ БОЛОВ

1994 оны долоодугаар сар гэхэд Ми Ранд багшийн сургуулиа төгсөн, дипломоо авахад ганцхан шалгалт дутуу байлаа. Төгсөөд Чонжины төвийн нэгэн цэцэрлэгт дагалдагч багшаар томилогдов. Есдүгээр сарын долоонд хүүхдүүд нь үдийн хоолоо идэхээр явж Ми Ран ангиа цэвэрлэхийг хүсэж, хоолоо идэхээр багш нарын хооллож байсан өрөө рүү явахаар зэхэж байтал шатаар нэг хүн яаруу өгсөх сонсогдов. Ми Ран гараад хартал дөнгөж сая гэр лүүгээ явсан охидын нэг байв. Боосон үс нь даахиран сэгсийж, амьсгаадсанаас юу хэлж байгааг нь хэн ч ойлгосонгүй. "Нас барчихлаа. Байхгүй болчихлоо" гэж амьсгаадан бархирна. "Чи чинь юугаа яриад байна аа?" хэмээн нэг багш асуутал "Агуу их маршал нас барчихлаа шүү дээ" гэв.

Ким Ир Сенийг ярьж байгаа нь тодорхой байв. Багш нар жаахан хүүхэд ингэж ярьж байгаад гайхаж хоцров. Удирдагчдаар тоглоом тохуу хийхийг хатуу хориглоно хэмээн цэцэрлэгт зааж сургадаг. Тиймээс багш нар охиныг тайвшруулахыг оролдож "Чи муу ёрын юм ярьж, социализмыг гутаан доромжилж байна" хэмээн чанга дуугаар загнав. "Үгүй ээ, би өөрөө зурагтаар харсан" хэмээн охин зүтгэнэ. Багш нар охинд итгэсэнгүй. Таван настай хүүхэд юу ч зохион ярьж чадахыг мэдэх юм хойно. Арван долоон цагаас зурагт эхэлнэ. Сургуульд нь зурагт, радио аль нь ч байхгүй тул тэд юу болж байгааг мэдэхээр гудамжинд гүйлдэн гарцгаав. Охин хэдэн гудамжны цаана байдаг гэр рүүгээ багш нарыгаа дагуулан гүйлээ. Охины гэр рүү өгстөл зурагтын өмнө шахалдсан олныг олж харав. Бүгд царай нь барайж, нүдээ бүлцийтэл уйлцгаасан нь илт. Эхлээд мэгшиж байсан хүмүүс яваандаа эхэр татан уйлж эхлэв. Урьд шөнө нь орсон дуу цахилгаантай борооны ус нэлийсэн гудамжинд зогсоод хүмүүс уйлалдсаар л байв. Ми Ран яахаа ч мэдэхээ болив. Тэр Ким Ир Сенийг жирийн хүмүүсээс өөр, тэнгэрийн хүн мэтээр төсөөлж явж. Гэтэл үхэшгүй мөнх гэж итгэж явсан агуу их удирдагч нь таалал төгсчихдөг юм байна. Тэгэхээр бидний амьдралд юу ч тохиолдож болох нь ээ...

Хойд Солонгосчууд Ким Ир Сений нас барсныг сонсох үедээ хаана юу хийж байснаа бүгд маш сайн санадаг. Ярилцлага хийх үед би "Та тэр явдлын талаар сонсохдоо хаана юу хийж байсан бэ?" хэмээн ёс мэт асуух болсон юм. 1990-ээд оны амьдралынх нь дурсамж ухаан санааг нь самууруулдаг тул тэр талаар ярих байтугай санахаас ч зайлсхийдэг хүмүүс маань энэ асуултыг сонсонгуутаа ер бусын гэмээр сэргэж тэр өдөр хаана, юу хийж байснаа яг таг ярьж өгдөг билээ. Тэр явдал хүмүүсийг гүн цочролд оруулсан нь илт.

Ингээд Солонгосын дайнаас хойш тус улсад болсон хамгийн том гай гамшиг агуу их Маршал Ким Ир Сен таалал төгссөн явдал болов. Эдийн засаг нь сүйрч байгаад ч биш, Орос Хятад хоёр Өмнөд Солонгостой найрамдаад ирсэнд ч биш, ер нь л Хойд Солонгосын нэр хүнд олон улсын тавцанд буурч байсан үе. НҮБ-ээс болон АНУ-ын шинэ, дайчин ерөнхийлөгч Билл Клинтон тус улсыг цөмийн зэвсэг хадгалдаг байраа шалгуулахыг шаардаж, 1993 онд Хойд Солонгос Зэвсэглэлээр үл хөөцөлдөх гэрээнээс гарч, цөмийн зэвсгээр цаашид хөөцөлдөх шийдвэрээ баталгаажуулсан нь хүйтэн дайны дараах үеийн цөмийн хийрхлийг үүсгэсэн юм. Дараа жил нь Пхеньяны хойд хэсгээс 72 км-ийн зайд орших Ёнбены цөмийн тогооноос плутон баяжуулах ажлаа

үргэлжлүүлэхэд Пентагон урьдчилсан цохилт өгөх төлөвлөгөө боловсруулж эхэлсэн байлаа. Хариуд нь Хойд Солонгосчууд дайн зарлахаар заналхийлэв. Пхеньяны албаны хүмүүс Сөүлийг үнс нурам болгоно хэмээн сүрдүүлж байсан удаатай.

Зургаадугаар сард нь АНУ-ын ерөнхийлөгч асан Жимми Картер Пхеньянд гурав хоногийн гэнэтийн айлчлал хийв. Хэлэлцээрийн үед Хойд Солонгос цөмийн хөтөлбөрөө зогсоовол цахилгаанаар туслах гэрээ хийхийг санал болгов. Картер мөн Өмнөд Солонгосын ерөнхийлөгч Ким Ёнг Самыг Пхеньянд айлчлахыг урьсан урилгыг дамжуулсан байна. Салан тусгаарласан хоёр Солонгосын удирдагчдын уулзалт 1994 оны зургаадугаар сарын 25-нд товлотсон байлаа.

Зургаадугаар сарын зургаанд Ким Ир Сен Пхеньяны Хойд хэсэгт орших байрнуудынхаа нэгэнд очиж, зочноо хүлээж авах ажил цэгцэрсэн эсэхийг шалгасан байна. Замдаа нэгэн хамтралын саалийн аж ахуйгаар орж газар дээрх зөвлөгөө гэгчийгээ өгөөд, оройн хоолондоо буцаж иржээ. Ингээд хооллож дууссаныхаа дараа гэнэт зүрхний шигдээсийн учир ухаан алдан унасан аж. Ийнхүү их удирдагч хэдэн цагийн дараа ертөнцийн мөнх бусыг үзэв. Ким Ир Сений үхлийн тухай ард нийтэд 34 цагийн дараа мэдээлсэний учир хэдийгээр хорин жилийн өмнө Ким Чен Ир залгамжлагчаар тодорсон ч коммунист дэглэмийн үед анх удаагаа үе залгамжлах тохиол гарч байгаа болохоор бэлтгэх хэрэгтэй байсных биз ээ.

Ким Ир Сен нас барах үедээ 82 настай байсан нь Хойд Солонгосын эрчүүдийн дундаж наслалтаас хамаагүй доогуур байж. Удирдагч хүзүүн дээрээ гольфийн бөмбөгний чинээ ургацагтай байсан бөгөөд ард түмнээс бусад дээд албаны хүрээнд бол удахгүй болсон нь тодорхой байжээ. Гэхдээ эрүүл мэнд нь муудаж байгаа талаар хэн ч ярьж зүрхэлдэггүй байж. Тэр ард түмнийхээ зөвхөн эцэг нь төдий биш, тэдний Жорж Вашингтон нь, Мао нь, ер нь л бурхан нь байж.

Хатагтай Сонг үдийн хоолоо бэлдэж байлаа. Ажилладаг үйлдвэр нь аль хэдийн хаагдаж, цалин авахгүй болсон учир Чанг Бо радио станцын ажилдаа явах нь ч цөөрөн, том өрөөндөө зурагтын мэдээ эхлэхийг хүлээн сууж байлаа. Тэр өдрийн үдээс хойш цөмийн зэвсгийн хэлэлцээрийн талаар тусгай мэдээ гарах ёстой. Нэг сарын өмнө Хойд Солонгос Олон Улсын Атомын Энергийн Агентлагтай хамтран ажиллахыг татгалзах үед зурагтаар тусгай мэдээ нэвтрүүлсэн юм. Чанг Бо сэтгүүлч болохоороо энэ бүхнийг сонирхон, дипломат ажиллагааны арга, эргэлт зэргийг сайн ойлгодог бол хатагтай Сонгод залхуутай санагддаг байлаа. Байгаа жаахан эрдэнэ шишээрээ маргааш нь яаж амттай агшаамал хийх вэ гэх мэт ойр зуурын асуудал л сэтгэлийг нь бага зэрэг зовооно. Гэтэл гэнэт нөхөр нь хуруугаа тас хийлгэн "Нэг юм болжээ. Ямар нэг том зүйл болж" хэмээн хашгирав. Хатагтай Сонг гүйн ирж харвал нэвтрүүлэгч гашуудлын хар хувцас өмсөж, хар зангиа зүүсэн байв. Хатагтай Сонг гараа арчиж, зурагтынхаа өмнө суулаа.

Солонгосын Хөдөлмөрийн Намын Төв Хороо, Намын Цэргийн Төв Комисс, Ардын Төв Хороо, БНАСАУ-ын Захиргааны Зөвлөл, болон нийт ард түмэн, Хөдөлмөрийн Намын Төв Хорооны Ерөнхий Нарийн Бичгийн Дарга, БНАСАУ-ын Ерөнхийлөгч, агуу их удирдагч нөхөр Ким Ир Сен зүрхний шигдээс өвчнөөр нас нөгчсөнийг нийт ард түмэндээ гүнээ гашуудан мэдэгдэж байна. Бидний хүндэт эцэг, агуу их удирдагч маань улс үндэстнийхээ тусгаар тогтнолын төлөө амь биеэ зориулан, эх орныхоо хөгжил цэцэглэлт, ард түмнийхээ аз жаргал, сайн сайхны төлөө, Солонгос

үндэстэн дахин нэгдэх үйлс, тусгаар тогтнолын төлөө амьдралынхаа сүүлчийн мөч хүртэл цуцашгүй тэмцээний эцэст биднээс үүрд одлоо.

Хатагтай Сонгийн бие цахилгаан гүйдэлд цохиулах мэт, бүх зүйл утга учиргүй болох шиг санагдав. Өмнө нь ээжийнхээ нас барсныг сонсоход л ийм мэдрэмж төрсөн боловч тэр үед хатагтай Сонг сэтгэл санааны бэлтгэлтэй байсан юм. Гэтэл агуу их удирдагчийн бие муу байгаа талаар тэр огт сонсоогүй бөгөөд гуравхан долоо хоногийн өмнө Жимми Картерыг тосон мэндчилэхийг нь харсан билээ. Энэ үнэн байх ёсгүй. Нэвтрүүлэгчийн яриаг сонсохыг хичээсэн боловч зөвхөн амны хөдөлгөөн нь л харагдаж юу хэлж байгааг огт ойлгосонгүй. Хатагтай Сонг уйлж эхлэв. Бид чинь яаж амьдрах болж байна аа? Агуу их маршалгүйгээр бид юу хийж чадах билээ хэмээн өөрийн эрхгүй бувтналаа.

Харин Чанг Бо л ямар ч сэтгэлийн хөдөлгөөн үзүүлсэнгүй. Царай нь цонхийж, хоосон хана ширтэн хөдөлгөөнгүй суусаар л. Хатагтай Сонгийн хамаг цус хөөрч, шатаар гүйх шахам буугаад, хашаандаа гарч ирэв. Тэнд хөршүүд нь цугларч, газар сөхрөн суугаад толгойгоороо цардмал зам мөргөн уйлалдсаар.

Хатагтай Сонгийн том охин Ок Хи гэрлэснийхээ дараа барилгын нэгтгэл дэх суртал ухуулгын ажлаасаа гарсан ч сайн дураараараа хорооны театрт жүжигчилсэн тоглолтод оролцох болсон байлаа. Тэр хорьтынхоо цагдаагийн газрын зохион байгуулсан жүжигт оролцон, цагаан хоолойгоор "Эх орноо хамгаалахын тулд олон тагнуул барьцгаая, Хэрэг хийсэн бол сайн дураараа хүлээ" гэх мэтийн үгсийг эршүүд, захирангуй дуугаар хэлж, хүмүүсийг хамтран ажиллахыг уриална. Ок Хи нөхөр хоёр хүүхдийн хамт Чонжины нүргээнтэй төмөр замын буудлын ойролцоо, умгархан байранд амьдарна. Сургуулилтаасаа тараад ядарсан хүн гэртээ ирж, үдийн хоолоо бэлдэх гэтэл гэртээ байх ёстой нөхөр нь алга. Хажуугийн айлаас зурагтын дуу гарахыг сонсоод шагайвал нөхөр нь хөршүүдтэйгээ зэрэгцэн суугаа харагдав. Нүд нь улаанаар эргэлдэх боловч согтуу биш байлаа. Хүүе, юу болоод байна аа, яагаад өдөр мэдээ гаргаад байгаа юм бэ? гэж нөхрөөсөө асуутал "Амаа татаад өөрөө үзэхгүй юу" гэж зандрав. Юм хэлбэл улам гаарна гэдгийг нь мэдэх учир Ок Хи дуугүй болж зурагт үзэж эхлэв. Өрөөнд байсан хэн бүхэн нүдэндээ нулимстай, уй гашууд автана. Ок Хи гашуудсан ч үгүй, баярласан ч үгүй, харин жаахан дургүй нь хүрэв. Тэр үхээ л биз. Харин би амьд байна, би өлсөж байна хэмээн бодсон ч аль болох анхаарал татахгүйн тулд хэсэг хугацаанд чимээгүй суусныхаа дараа босч, нөхөртөө "би явж үдийн хоолоо бэлдлээ" хэмээв. Нөхөр нь өөдөөс нь муухай харлаа. Хэдийгээр уудгаасаа болоод Хөдөлмөрийн Намаас хөөгдсөн ч намдаа үнэнч, өөрийгөө дээд тушаалын ажилтан хэмээн бодсон хэвээр. Тэр ийм чухал үед над шиг хүн л хүмүүст хэрхэгийг нь хэлж өгөх ёстой хэмээн өөрийгөө дөвийлгөн бодно. Асар их уй гашуу тохиолдоод байхад төдийлөн ач холбогдол өгсөн шинжгүй харагдах эхнэрээ хараад Ёнг Су чи бол хүн биш хэмээн хяхтнан занав.

Ок Хи гэртээ орж үдийн хоолоо бэлдчихээд, идэнгээ радио сонслоо. Нэвтрүүлэгч үе залгамжлах тухай ярьж байна. Агуу их удирдагчийн цорын ганц залгамжлагч, нөхөр Ким Чен Ир бидэнтэй байгаа цагт хувьсгалын ялалт бат бөх хэвээр байх болно Гэртээ ганцаараа сууж байхдаа Ок Хи бодолд умбав. Ким Ир Сенийг нас барсны дараа Хойд Солонгосын одоогийн дэглэм нуран унаж, байдал дээрдэж магадгүй гэсэн горьдлого нь талаар болов. Хүү нь эрх мэдлийг авчээ. Хүү

нь эцгээсээ долоон дор хэмээн аав нь найздаа хэлж байсан нь чихэнд нь сонсогдох шиг болов. За ингээд бид өнгөрчээ хэмээн сэтгэлдээ хэлээд өөрийгөө өрөвдсөндөө жинхэнэ ёсоор уйлж эхлэв.

Цэцэрлэгт хүрээлэнгээс лийр хулгайлан, голоо зогоодог асан Ким Хиюук хүү агуу их удирдагч Ким Ир Сенийг нас барахад арван хоёртой байлаа. Тэр Чонжины Малумын дунд сургуулийн долдугаар ангид сурч байв. Гашуудал зарласан өглөө Хиюук хичээлдээ явах эсэхээ шийдэж ядан эргэлзсэн гэнэ. Хичээлдээ явах дургүй байсны учир нь сургууль руугаа авч явах хоол хүнс гэх юм гэрт нь бараг үгүй. Хичээл дээр шал дэмий цонхоор ширтэн сууж байснаас ы цэцэрлэгт хүрээлэнд очиж жимс түүх эсвэл хүнсний наймаачдаас ямар нэг юм хулгайлж идсэн нь хамаагүй дээр гэж бодно. Хоёр өдөр дараалан хичээл тасалсан тул буцаж очихоос жийрхэж байлаа. Багш нь мэдээж зодно гэж бодохоос хөл нь урагш хөдөлж өгдөггүй. Аль хэдийн хоцорсон атлаа явж ядан, юу юугүй буцаад гүйх нь үү гэмээр алхана. Гэтэл ангийнхан нь сургуулиас гараад гүйлдэж байхыг хараад маш их баярлав. Тэднийг гэртээ очиж чухал мэдээ сонс хэмээн явуулсан байлаа. Хүүхдүүд зах дээр очиж ямар нэг юм гуйж, үгүй бол хулгайлж гэдсээ борлуулахаар гүйлдэцгээв. Гэтэл зах дээр ч бараг хүн алга. Ганц нэгээс бусад бүх лангуу хаалттай. Үлдсэн наймаачид нь толгойгоо гудайлган гашуудацгааж байлаа. Гэнэт Хиюукт гуниг төрөв.

Энэ үед Пхеньянд Жун Сан амралтын өдрөө орондоо ном уншсан шиг тааваараа өнгөрөөж байв. Гэртээ бол орондоо ном унших гэхээр хараа муудна гээд аав нь зөвшөөрдөггүй байж. Өглөө эрт салхивчаа онгойлгосон боловч өрөөнд бүгчим халуун байснаас Жун Сан футболка, богино төдийг хэдэрсэн байв. Гэтэл өрөөнийх нь нэг оюутан гүйн орж ирээд "Бүх оюутан гадаа цуглаж байна. Яаралтай мэдэгдэл хийнэ гэнэ" хэмээн мэдээлэв. Жун Сан дуртай дургүй босож, өмдөө углангаа ахиад л цөмийн зэвсгийн талаар биз хэмээн дотроо дургүйхэн бодно. Уур нь хүрэв. Амралтын өдрөөр ч амраахгүй юм. Жимми Картерын айлчлалыг эс тооцвол улс орон нь НҮБ-тэй сөргөлдөх замдаа орсон гэдгийг Жун Сан мэдэрч байв. Хэдэн сарын өмнө тэдний сургуулийн бүх оюутан дайн эхэлбэл сайн дураар цэрэгт татагдана гэдгээ цусаараа тангараглацгаасан байлаа. Зарим охин гараа зүсэхдээ хэтрүүлснийг эс тооцвол бүгд энэ явдлыг оногдсон үүргээ хэмээн ямар ч асуудалгүй хүлээж авсан. За ингээд ойлгомжтой. Бид дайнд явах нь гэж Жун Сан хашаан дотор алхаж явахдаа өөртөө хэлэв. Хашаан дотор нийтдээ 3000 оюутан дамжаа, цолны эрэмбэ зэргээрээ дараалан жагссан харагдана. Нар хурцаар халж, тэд ханцуйгүй дүрэмт хувцастай хэрнээ байдгаараа хөлөрцгөөнө. Үдийн алдад цагаан хоолойгоор нэгэн эмэгтэй хүн чичирсэн, гашуудал дүүрэн хоолойгоор ярьж эхлэв. Цагаан хоолой нь хуучирч муудсан тул ярьж байгааг нь оюутнууд ойлгохтой үгүйтэй. Жун Сан үгийн дундаас өвчин, нас барсан зэргийг ялгаж сонсоод, дээрээс нь олны яриаг сонсож байж юу болсныг ойлгов. Бүгд гашуудан уйлж эхлэв. Нэг оюутан ухаан алдаж унав. Хэрхэхээ мэдэхгүй хий дэмий л тэвдэцгээнэ. Төгсгөлд нь гурван мянган оюутан нэг нэгээрээ толгойгоо гудайлган сөгдөн суулаа. Жун Сан ч бусдыг дуурайв. Толгойгоо гудайлгасан учир нүүрэн дэх эргэлзээг нь хэн ч ажигласангүй. Оюутнуудын мэгшилт сүүлдээ хэмнэлтэй болж эхлэв. Ойр хавьд нь өөрөөс нь бусад нь уйлж байлаа. Гэтэл тэр ганцаараа л огт уйлсангүй. Уг нь Жун Сан кино үзсэн ч, ном уншсан ч уйлж байдаг зөөлөн сэтгэлтэй хүүхэд учир дүү нь шоолж, аав нь охин шиг зөөлхөн байх хэрэггүй гэж сургадаг. Гэтэл тэр элбэг нулимс хаачив? Яагаад тэр уйлахгүй байна? Ким Ир Сен нас барчихаад байхад гашуудахгүй байна гэж үү? Тэр агуу их удирдагчдаа хайртай байгаагүй гэж үү?

21 настай их сургуулийн оюутан Жун Сан төр засагтаа эргэлзэнгүй ханддаг байв. Аливаа зүйлийг эргэцүүлэн боддогтоо өөрийгөө тооно. Гэхдээ хэзээ ч төр засгийнхаа эсрэг тэмцэж, дайсан болох хэмжээнд шүүмжилнэ гэж өөрийгөө бодож байсангүй. Тэр коммунизмд итгэж, капитализмаас хамаагүй хүнлэг систем хэмээн боддог байв. Аажимдаа Хөдөлмөрийн Намын гишүүн болж, эх орныхоо ирээдүйн сайн сайхны төлөө зүтгэнэ гэдэг хэтийн зорилготой. Ер нь улсын сайн их сургуулийн оюутнууд бүгд л ийм итгэл үнэмшилтэй төгсдөг байв.

Гэтэл одоо гашуудаж байгаа оюутнуудын дунд ганцаараа уйлахгүй сууж байхдаа хэрэв энэ уйлж буй хүмүүс агуу их удирдагчид үнэн сэтгэлээсээ хайртай юм бол надад яагаад тийм мэдрэмж төрөхгүй байгаа юм бол? Би ер нь ямар хүн болж хувирсан юм бэ? хэмээн эргэцүүлэв. Гэнэт түүнийг бөөн гуниг нөмрөн авчээ. Ойр дотнын найз олонтой гэдэгтээ итгэж явсан атал одоо энэ уйлан байгаа хүмүүс дотно нөхөд нь биш, таньдаг хүн л төдий юм байна. Тэгэхээр тэд ч өөрийг нь сайн мэдэхгүй болж таарлаа. Хэрэв тэд мэдэх юм бол намайг хэрэгт хийх байх даа.

Энэ нээлт хачин аймшигтай санагдав. Ирээдүй нь тэр чигээрээ уйлах чадвараас нь хамаарах нь. Зөвхөн ажил ч биш, Хөдөлмөрийн Намын гишүүн болох эсэх, цаашид нийгмийн гарлаа өөрчилж чадах эсэх зэрэг хувь заяаны чухал асуудал энэ цагт уйлж чадах эсэхээс нь шалтгаалж байна шүү дээ. Энэ бол үхэх сэхэхийн тухай асуудал байлаа. Жун Санд дахин айдас төрөв.

Эхлээд нүдээ бусдад харуулахгүйн тулд тонгойж байсан Жун Сан нэг чигт удаан гөлрөхөд улайж нулимс нь гарав. Ширтэлт. Уйлалт. Гэтэл удалгүй бие махбодь нь дасаж, уг үйлдэл механик болон хувирлаа. Тэр удалгүй үнэхээр уйлж буйгаа мэдрэв. Бусадтай л адилхан мэгшин уйлж эхэллээ.

Үдийн зар хүмүүст хүрсний дараа хэдхэн цагийн дотор Хойд Солонгосын өнцөг булан бүрт хүмүүс Ким Ир Сений хөшөөнд хүндэтгэл илэрхийлэхээр цувж гарлаа. Тус улсад их удирдагчийн 34,000 хөшөө байдаг гэсэн тоо бий. Хүмүүс гунигаа бусадтай хуваалцахыг хүсч байлаа. Гэрээсээ гарцгааж, хот болгоны оюун санааны төв болсон хөшөөд рүү цувна.

Чонжинд нийт 500,000 хүн оршин суудаг боловч Похан талбайд удирдагчийн цорын ганц хүрэл хөшөөтэй. Хүмүүс өргөн талбайг дүүргэж, бүр Хувьсгалын Түүхийн Музейн өмнөх талбайгаас халин гарчээ. Цаашлаад олны урсгал зүүн зүгт тэлж, нэгдүгээр замаас Мужийн Театр хүрч, ойр орчмын гудамжийг дүүргэсэн байлаа. Дээрээс нь харвал нэгэн зорилго чиглэлтэй шоргоолжны цувааг санагдуулна.

Хэнээрхэл ба олноор цугласан хүмүүс нийлэхээрээ аюулт үр дагавар авчирдаг билээ. Хүмүүс урагшаа ухаангүй мэт зүтгэж бүл чадал муутай нэгийгээ даран унагаж, цэвэрхэн тэгшилж тайрсан бутан хашааг дайран гишгэлж гарлаа. Хэдэн гудамжны цаанаас талбайд гарч байгаа шуугиан сонсогдох нь үймээн самуун дэгдэв үү гэлтэй. Тэр нь нэг бол бороо орж, байсхийгээд халуун нар шатсан өвөрмөц өдөр байлаа. Нарны малгай өмсөж, шүхэр барихыг зөвшөөрөхгүй болохоор хүмүүс хөлс нулимсандаа нэвчих нь үү гэмээр харагдана. Олон хүн ухаан алдаж унав. Хоёр дахь өдрөөс эхлээд цагдаагийнхан зохицуулах оролдлого хийж эхэллээ.

Гашуудагсад ажлын газраараа, анги хамт олноороо зохион байгуулалттай цугласан байв. Цугласан бүлэг бүр Азид гашуудлын цэцэг хэмээн нэрлэгддэг удвал цэцгийн баглаа, мөнгө муутай нэг нь хээрийн цэцэг түүн ирж хөшөөнд өргөж байлаа. Хүмүүс арваас хорин таван хүнээс бүрдсэн эгнээгээр жагсаж хөшөөнд цэцэг өргөх ээлжээ хүлээн зогсоно. Удаан зогссоноос хөл нь өвдсөн, ядарсан настай нэгнийг залуус тохойноос нь дэмжин байгаа нь ажиглагдана. Ээлж нь ирэхэд тэд хөшөөнд ойртож очоод өвдөглөн сууж толгойгоо газар хүргээд, хөшөө рүү биширсэн нүдээр өлийн харцгаана. Ким Ир Сен тэртээ дээр нарсан төглийн дээгүүр алсыг ширтэж, гурван давхар байшинтай тэнцэхүйц хөл нь л гэхэд ямар ч өндөр хүн хүрэхээргүй дээр байрлана. Доор нь сөгдсөн хүмүүст хөшөө амьд мэт байгаа бололтой шууд л харьцаж эхлэх юм. "Бурхан минь, бурхан минь. Та яаж биднийг орхин явж чадав аа" хэмээн мэлмэрүүлэн уйлна. "Та биднийг яагаад ийм гэнэт орхин явав" хэмээн нэгэн эр дуу тавина.

Дугаарлан хүлээж буй хүмүүс дээш үсрэн, толгойгоо балбаж, хуурамчаар ухаан алдаж унан, хувцсаа урж тастан, гараа зангидан агаарт зангах зэргээр элдвээр авирлаж эхлэв. Уй гашуудлын жүжиг сүүлдээ өрсөлдөөн болж хувирав. Хэн хамгийн чанга уйлж, хэн хамгийн их гашуудаж байна вэ? Гашуудагсдыг зурагтаар үзүүлж байлаа. Үсээ үгтээн уйлж байгаа эмэгтэйчүүдийг, толгойгоороо мод мөргөх насанд хүрсэн эрчүүдийн хацар дээгүүр урсах нулимсыг, хөлөг онгоцныхоо шургийг мөргөх усан цэргүүдийг, бүхээгтээ уйлж байгаа нисэгчдийг гээд янз бүрийн төрхийг зурагтаар хэдэн цагаар харуулж байлаа. Энэ дүр зургуудыг аянга цахилгаан, орж буй бороотой ээлжлэн харуулж байсан нь Армагедоныг санагдуулна.

Пхеньяны зурагтаар "Манай үндэстний оршин тогтнож ирсэн таван мянган жилийн түүхэнд учирч байгаагүй уй гашуу бидэнд тохиолоо" хэмээн сүр дуулиантайгаар зарлана.

Хойд Солонгосын үзэл суртлын машин урд өмнөхөөсөө илүүтэй ажиллаж эхэллээ. Ким Ир Сен үхээгүй тухай утгагүй зүйлүүдийг зохион, олон нийтийн толгойг эргүүлж эхлэв. Засгийн газар нь их удирдагчаа өнгөрсний дараахан эх орныхоо өнцөг булан бүрт 3200 дурсгалын хөшөө босгож "Мөнхийн Амьдралын Цамхгууд" хэмээн нэрийдсэн байна. Ким Ир Сен бидэнтэй хамт байхгүй ч сэтгэл зүрхэнд минь үүрд Ерөнхийлөгчөөрөө үлдэнэ. Ард түмэн нь аль болохоор их гашуудаж чадвал Ким Ир Сен эргэж ирнэ гэсэн утгатай баримтат кино хүртэл шинээр гаргав. Түүнд өгүүлснээр агуу их Маршалыг бурхан болоход тэнгэрээс хэдэн Мянган тогоруу шарилыг нь авч явахаар буун ирсэн боловч ард түмэн нь хэрхэн уйлж, орилж, цээжээ урж, үсээ үгтээн, газар мөргөхийг хараад чадалгүй буцаад нисчихсэн юм байх.

Эхлээд сайн дураар эхэлсэн гашуудал сүүлдээ эх оронч үүрэг болон хувирчээ. Эмэгтэйчүүд арав хоногийн гашуудлын үед нүүрээ будаж, үсээ янзлуулах ёсгүй. Архи уух, бүжиглэх, наргих цэнгэх, хөгжим тоглохыг бүрмөсөн хориглов. Хорьтын дарга нар хүмүүс хөшөө рүү хэр олон явж байгааг, мөн үнэхээр гашуудаж байгаа эсэхийг царай, дууны өнгө зэргээс нь хүртэл олж харахыг хичээн ажиглана.

Ми Ран арван өдрийн гашуудлын хугацаанд өдөрт хоёр удаа хөшөө рүү явна. Нэгэнд нь цэцэрлэгийнхээ хүүхдүүдтэй, нөгөөд нь хамт ажилладаг багш нартайгаа. Тэр айж эхэллээ. Ганц өөрийнх нь гашуудах үүрэг ч биш хүүхдүүдийг албаар гашуудуулж, хэнээрхүүлж байгаа нь айдас

төрүүлнэ. Нэг таван настай охин учиргүй чанга дуугаар уйлаад, гашуудсанаа харуулахыг хичээж буйг нь хараад ингэж байгаад ухаан алдаж унах вий хэмээн санаа зовов. Гэтэл охин үнэн хэрэгтээ гар руугаа нулимж байгаад шүлсээрээ нүүрээ норгож байсан юмсанж. "Хэрэв чи уйлахгүй бол муу хүн болно" гэж ээж хэлсэн хэмээн охин Ми Ранд үнэнээ хэлжээ.

Чонжины нэгэн нэртэй жүжигчин нулимсаа хүчээр гаргах гэж нэлээд сандарсан байна. Ингэснээр тэр зөвхөн улс төрийн төдийгүй мэргэжлийн хувьд өөрийгөө эрсдэлт байдалд оруулах дөхжээ. Ким Хи Янг хожим дурсан ярихдаа уйлна гэдэг бараг ажил маань болоод байв. Би хэдийгээр шаардлага гарвал уйлдаг боловч тэр үед жаахан сандарсан хэмээн дурсан ярьсан юм.

Хиюук ангийнхантайгаа хамт хөшөө рүү өдөрт хэдэнтээ очно. Учир нь хөшөөнд хүндэтгэл үзүүлсний дараа будааны боов тараадаг байсан учир хүүхдүүд ээлжээ дуусгачихаад буцаад дараалсан хүмүүсийн ард очиж зогсоно.

Ким Ир Сений хөшөөнд хүндэтгэл үзүүлж, түүнийг нас барсанд гашуудаж байсан сая сая хүнээс хэд нь үнэн сэтгэлээсээ гашуудаж, хэд нь зүгээр дүр эсгэж байсан бол? Тэд агуу удирдагчаа үгүй болсонд гашуудаж байсан уу, эсвэл өөрсдийнхөө төлөө санаа зовох сэтгэл нь дийлж байсан уу? Эсвэл тэд бусдыгаа дагаад л уйлаад байсан юм болов уу?

Мэдээж тэр олон хүн дотор үнэн сэтгэлээсээ гашуудах нэгэн байсан л байх. Гашуудлын үеэр сэтгэл санааны гэнэтийн цочролоос болж настай хүмүүс олноороо зүрхний шигдээс, цус харвалтаар өөд болцгоож байлаа. Энэ явдлын дараа хүн амын нас баралтын хэмжээ огцом өссөн юм. Зарим нь амиа хорлож байв. Хойд Солонгост нойрсуулах эм байдаггүй, зөвхөн цэргүүд л буу зэвсэгтэй учраас амиа хорлох хамгийн шилдэг арга нь өндөр байшингийн оройгоос дээрээс үсрэх. Харин нэг хэсэг нь албаар өлсөж байв. Тэдгээрийн нэг нь Чонжины Мужийн Эмнэлгийн хүүхдийн эмч Ким Жи Юнгийн эцэг байсан билээ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

ДУСАЛ ЗАЛГУУЛАХЫН ТУЛД ШАР АЙРГИЙН ШИЛ ХОЁРЫГ АВЧРАХ ХЭРЭГТЭЙ

Ким Ир Сенийг нас барах үед шатахууны хомсдолд ороод байсан учир өвчтөнүүдийг түргэний машинаар бус, ах дүү, хамаатан садан нь үүрч дүүрэн, эсвэл модон тэргээр эмнэлэг рүү авчирдаг болсон байв. Ким Жи Юний ажилладаг жижгэвтэр эмнэлэг Похан талбайгаас холгүй орших учир гашуудлаа илэрхийлэх цуглааны үед шархдаж, гэмтэж, ухаан алдсан хүмүүсийг олноор нь хүлээн авахаас өөр аргагүйд хүрээд байлаа. Нэг умгар өрөөнд тав таваар нь шахалдуулан тавьсан төмөр орнууд өвчтөнүүдээр аль хэдийн дүүрч, дараа дараагийнх нь хүмүүс сандал, шалан дээр дугаараа хүлээн зовцгоодог байв.. Хамаг эрчим хүчээ Ким Ир Сений хөшөөг өдөр шөнөгүй гэрэлтүүлэхэд зориулж буй учир өдрийн цагаар хааяа нэг л цахилгаан ирнэ. Зун нь гэдэсний хижиг дэлгэрсэн тул эмнэлэг пиг дүүрээд байсан үе. Эцэг эхчүүд халуунд хэт их уйлснаас болж шингэний дутагдалд орсон хүүхдүүдээ хүүхдийн тасагт авчирсаар л. Таталт өгсөн хүүхдүүд ч ирж байлаа. Ким эмчийн ердийн ажлын хуваарь өглөөний долоон цаг гучин хормоос оройн найман цаг хүртэл үргэлжилдэг бол энэ үед хааяа нэг гарч хөшөөнд хүндэтгэл илэрхийлэхээс бусад үед бараг л 24 цаг ажиллаж байв. Өргөсөн тангарагтаа үнэнч тэрбээр ингэж их ажиллаж байгаадаа харамсаж гомдоллосон удаагүй. Энэ хооронд хувийнх нь амьдрал нуран унаж буйг анзаарах сөхөө ч байсангүй.

28 настай Ким эмч хамт олон дотроо хамгийн залуу, бас намхан нь байв. Дөнгөж 143 см орчим нуруутай, 45 кг жинтэй учир өсвөр насны өвчтөнүүдээсээ бараг ялгарахгүй. Нум хэлбэртэй жимбэгэр улаан уруул, зүрхэн хэлбэртэй царай нь бүсгүйг ихэд ялдам харагдуулна. Дутуугаа нөхөх гэсэн мэт түүнд тэсвэр, тэвчээр, ажилсаг чанар харамгүй заяажээ. Цалингүй, ээлжинд гарах ажилд үргэлж сайн дураараа оролцоно. Ажлаа дууссаны дараа Хөдөлмөрийн намын үүрт бас зохих үүргээ гүйцэтгэнэ. Бүх байгууллагын адил тус эмнэлэг ч бас намын үүртэй. Дөрвөн эмч тутмын нэг нь намын гишүүнээр сонгогдох боломжтой учир, нэлээд өрсөлдөөнтэй. Ким эмч өөрийгөө намын гишүүнд сонгогдоно гэдэгт эргэлзэлгүй, хамаг хүч авьяасаа дайчлан зүтгэнэ. Эмэгтэйчүүд дүрэм журам мөрдөхдөө илүү, архи дарс хэрэглэдэггүй болохоор намын гишүүн болох магадлал өндөр. Түүний сахилга баттай, хатуу чанга зан чанар нь намын сайн гишүүн болоход гарцаагүй тохирно. Ким эмч төр засгийн тогтолцоо, коммунист дэглэмд эргэлзэлгүй итгэдэг нь хүүхэд наснаас нь аавынх нь олгосон хүмүүжилтэй холбоотой бөлгөө.

Солонгосыг Хятадаас тусгаарладаг хилийн цэг болох Түмэн, Ялу голуудаар дамжин олон зууны турш нааш цааш цагаачлах нэлээд олон тооны уугуул солонгосчууд Манжуурт амьдардаг. Кимийн эцэг хилийн цаахна байдаг, солонгосоор ярьдаг нэгэн тосгонд төрж, 1960-аад оны үед олон мянган хүнийг өлсгөлөнд хүргэсэн Маогийн Их Үсрэлтийн бодлогын үед Хойд Солонгос руу зугтааж гарсан нэгэн. Ким Ир Сенийг Маотой адил биш коммунист мөрөөдлийг жинхэнэ залгамжлагч, өөр шиг нь жирийн ажилчин хүмүүст шударга ёс, эрх тэгш байдлыг авчрагч агуу хүн хэмээн үзэж, үнэнчээр зүтгэдэг байлаа. Барилгын хар ажилчин, жирийн нэгэн тэрбээр зургадугаар ангийн боловсролтой хэдий ч ухаантай, зүтгэлтэй учраас Хөдөлмөрийн Намд элсэж дөнгөсөн байна. Барилгын бригадынхаа Намын үүрийн дарга байсан ч хэдэн жилийн өмнө тал цус харваснаас болж ажил үүргээ өгөхөд хүрчээ. Хүүгүй тул ганц охиноо ажлыг нь үргэлжлүүлж, эх орныхоо төлөө нэгэн болгохын төлөө мэрийсэн билээ.

Ирээдүйн эмч Ким охин энэ үүргээ биелүүлэхийн тулд урам зоригтой сурч хөдөлмөрлөж байв. Долоон настайдаа пионерт элсэж, гал улаан бүч хүзүүндээ зүүхдээ хязгааргүй баярлажээ. Дараа нь 13 настайдаа Социалист Залуучуудын Эвлэлд элсэж, Ким Ир Сений зурагтай тэмдэг зүүхдээ ч өөрөөрөө бахархаж байв. Залуучуудын Эвлэлд элсэх нь Хойд Солонгосчуудын хувьд намд элсэх суурь байсан бөгөөд хүүхэд 13, 14, 15 насандаа уг Эвлэлд элсэх ёстой. Чухам хэзээ элсэх нь сурлага, сахилга батаас шалтгаалдаг байж. Бага ангиасаа л Ким хичээлдээ сайн, бусдаасаа давуу болох нь харагдсан аж. Маш нямбай бичигтэй, багшийн асуултад хариулахаар хамгийн түрүүнд гар өргөдөг онц сурлагатан байв. Сургуулиа төгсөхөөсөө өмнө, 16-тай байхдаа Ким анагаахын дээд сургуульд урилгаар оржээ. Өөрөө багш юм уу сэтгүүлч болохоор мөрөөддөг байсан ч барилгачин хүний охин эмч болохоор сонгогдоно гэдэг алдаж болохооргүй завшаан байжээ.

Ким, Чонжины Анагаах Ухааны Дээд Сургуульд ангийнхнаасаа хоёр насаар дүү байхдаа элсэн оров. Долоон жил суралцаад төгсөж, Хойд Хамёнг мужийн хамгийн нэр хүндтэй эмнэлэг болох Мужийн Ардын Эмнэлэгт дагалдан эмчээр томилогдон ажиллаж байхдаа ч жаахан охин шиг харагдсан хэвээр. Нутгийнхан энэ эмнэлгээ Чех Эмнэлэг хэмээн нэрлэнэ. Учир нь 1960-аад оны үед социалист дэглэмийн орнуудын харилцан туслалцах хамтын ажиллагааны хүрээнд Чех эмч нар эхо аппарат, нярайн инкубаторт өгчээ. Эмнэлэг одоог хүртэл Европ онцлогоо хадгалдаг хэдий ч тоног төхөөрөмж нь хуучирч муудаад салж унадгийн даваан дээр очсон учир наалддаг туузаар торгооно. Дагалдах хугацаа нь дууссаны дараа Ким эмч Похан дүүргийн, гэрт нь ойролцоо байрлах нэгэн жижигхэн эмнэлэгт хуваарилагдав. Өглөө ажилдаа долоон цаг гучин хоромд ирж, "12 цагийн дотор дор хаяж 32 өвчтөн үзэж эмчлэх ёстой" хэмээн дүрэмд заагдсан байна. Өглөө нь эмнэлэг дээрээ өвчтөнүүдэд үзлэг хийгээд, үдээс хойш гадуур үзлэг хийдэг багт орж ажиллана. Цагаан нөмрөг өмсөж, цагаан малгайны доор үсээ шууж нуусан Ким эмч түргэн хоолны тогоочийг санагдуулна. Чагнуур, тариур, боолт, гэдэсний эм, антибиотик чихсэн, өөртөө томдсон хүнд үүргэвчээ үүрч, хоёр эмчтэй хамт айл өрх, сургуулиудаар явна. Хэдэн байр дундаа нэг ариун цэврийн тасагтай, түүнийг нь хорьтын дарга удирдана.

Эмч нар амь биеэ үл хайрлан хүний төлөө ажиллах тангараг өргөсөн, үүндээ ч үнэнч хүмүүс. Эхо аппарат хүрэлцээгүй учир рентгений аппарат их хэрэглэснээс болж туяаны хордлогод орох нь олонтаа. Зарим настай эмч хараагүй болсон тохиолдол ч бий. Тэд өвчтөнд цусаа өгөөд зогсохгүй шаардлагатай үед арьснаасаа өгч түлэгдэгсдийг аварна. Ким эмч туранхай, намхан учраас ингэх шаардлага гардаггүй байсан боловч ууланд очиж эмийн ургамал түүхээс чөлөөлөгддөггүй байв.

Хойд Солонгост эмээ өөрөө найруулах нь эмч хүнд зайлшгүй байх ёстой чадваруудын нэгд тооцогддог. Дулаан уур амьсгалтай газар амьдардаг эмч нар хөвөн тариалж, боолтын материалаа бэлдэнэ. Бүх эмч эмэнд хэрэглэх ургамлаа өөрсдөө бэлдэх үүрэгтэй. Ким эмчийн тасгийнхан хавар намрын саруудад аль болох их эмийн ургамал түүж, нөөцлөхийг хичээнэ. Хээр хөдөө нүүр гараа угаахтай үгүйтэй олон хоног аялна. Түүсэн ургамлаа эмийн санд авчирч өгөхөд, жинлэж үзээд нормоосоо дутуу байвал буцааж ууланд явуулна. Жирийн иргэд ойр ургадаг уулаас эмийн ургамлыг нь дамлах, хувьдаа хэрэглэхээр түүгээд дууссан тул эмч нар уул өгсөн маш хол газар аялах хэрэгтэй болно. Сэтгэцийн өвчинд сайн, булчин суллах үйлчилгээтэй гэгдэх цээнэ цэцгийн үндэс хамгийн хэрэгцээтэйд тооцогдоно. Зэрлэг төмс сарын тэмдгийн мөчлөгийн алдагдлыг

эмчилдэг. Багваахай цэцэг ходоод эмчилдэг бол цагаан гаа хамрын ханиадаас сэргийлдэг. Антибиотик байхгүй үед дархлаа сайжруулдаг атрактилод хэмээх хятад эмийн ургамлыг ашиглана.

Олон жилийн туршид Хойд Солонгосын эмч нар Европын анагаах ухааныг уламжлалт аргатай хослуулан хэрэглэж иржээ. Өвчин намдаагч эм өгөхийн оронд өвдсөн газрын цусны эргэлтийг сайжруулах арга болох бумба тавьж эмчилнэ. Хятадуудаас сурсан бас нэг арга нь төөнүүр. Мэдээ алдуулагч байхгүй үед жижиг мэс ажилбар хийхийн тулд зүү тавьж мэдээ алдуулна.

Зүү зарим тохиолдолд маш сайн үйлчилдэг. Харин заримдаа үгүй. Мэдээ алдаагүй өвчтөнийг алдуурах, ноцолдохоос сэргийлэн мэс заслын ширээн дээр хүлнэ. Хойд Солонгосчууд өвчин зовлон дааж сурсан хүмүүс болохоор төдийлөн асуудал үүсгэхгүй. Өчүүхэн жаахан өвдөлтийг даадаггүй Өмнөдийнхөн байсан бол тэсэх ч үгүй хэмээн Ким эмч хожим нь дурсан ярьсан билээ.

Хэдийгээр эм, эмнэлгийн материал хомсдолтой байсан ч эрүүл мэндийн тогтолцоо Коммунизмын өмнөх үеийг бодвол илүү сайн байлаа. Эмнэлгийн бүх төрлийн үйлчилгээ үнэгүй байх нь Үндсэн хуулиараа баталгаажсан байдаг. Ким эмч анагаах ухааны салбарт ажиллаж байгаагаараа бахархаж, өвчтөндөө үзүүлж буй үйлчилгээгээнээсээ сэтгэл ханамж авна. Гэтэл 1990-ээд оны эхэн үеэс эм, эмнэлгийн материалын хомсдол гүнзгийрч эхлэв. Тоног төхөөрөмжийн ихэнх нь хуучирч эвдрээд хэрэглэхийн аргагүй болжээ. Сэлбэг хэрэгсэл авах гэхээр хуучин социалист орнууд дахь үйлдвэрүүд нь хувьчлагдчихаж. Чонжины эмнэлгүүд эмийн хангамж, цахилгаангүй болсны улмаас бараг ажиллахаа болив. Гаднаас эм импортлох гэхээр санхүүгийн байдал хэцүү. Ким эмчийн үүрдэг цүнх дундарсаар сүүлдээ ганцхан чагнуур л үлджээ. Өвчтөнүүд нь Хятад, Япон руу захих юмуу хар зах дээрээс дамын үнээр эм худалдан авах мөнгөтэй гэж найдан, жор бичих нь л түүний цорын ганц хийж чадах зүйл болсон байлаа.

Ким эмчийн сэтгэл дундуур байдал 1993 онд даргатайгаа анх удаа ам зөрснөөс хойш л ил гарав. Хувийн бизнес хийсний улмаас эдийн засгийн гэмт хэрэгт холбогдсон 27 настай залууг эмчлэх үүргийг түүнд өгчээ. Тэр залуу шоронгоос эмнэлэгт шилжин ирэхдээ нийт долоон жилийн ялынхаа гурвыг нь эдэлчихээд байсан аж. Тэжээлийн дутагдлаас болж тураалд орж, хавирга нь хэрзийж, хурц бронхитоос болж шаналан байлаа. Залууд яаралтай антибиотик өгөх гэтэл дарга нь зөвшөөрсөнгүй." Наадах чинь гэмт хэрэгтэн. Наадхад чинь өгсөнөөс өөр өвчтөнд өгсөн нь дээр" гэв. "Энэ хүнийг эмнэлэгт хэвтүүлсэн болохоор эмчлэх л ёстой. Өвчтөн л бол өвчтөн. Бид түүнд антибиотик өгөөд аварч чадна шүү дээ" хэмээн Ким эмч маргалаа. Түүний уйгагүй чанар нь цаашид өвчтөний төлөө тэмцэхийг шаардаж байлаа. Даргатайгаа хэдэн өдөр маргасан боловч барсангүй. Өвчтөнийг эмчлэлгүй эмнэлгээс гаргалаа. Ким эмч хөөрхий залуугийн гэрт өдөрт хоёр удаа очно. Гэвч эмгүйгээр биеийн байдал нь улам дордож, санаагаар ч унаж эхлэв. Би амьдрах хувьгүй юм байлгүй дээ хэмээн цөхрөнгүй хэлсээр нэг л өдөр амиа хорложээ. Энэ залуугийн үхэлд Ким эмч өөрийгөө болон эмнэлгээ буруутай гэдэгт эргэлзсэнгүй. Ким эмч, дарга хоёрын хооронд үүссэн сөргөлдөөн зогссонгүй. Иймээс хүүхдийн тасаг руу шилжих өргөдөл өгөв. Тэнд хүмүүсийг арай ч ингэж ялгаварлахгүй байлгүй хэмээн боджээ.

Энэ үед хувийнх нь амьдрал уналтад орж байлаа. Түүний хайр сэтгэл, амьдралын хэмнэл хоёр

хэзээ ч таарч байсангүй. Хэнхэг, зарчимч зан нь эрчүүдийг холдуулдаг байв. Бүтэн цагаар ажилладаг болсноос нэг жилийн дараа тэр аль анагаахын сургуулиас л үерхдэг байсан залуудаа хаягдаж, маш их сэтгэлээр унажээ. Найзаасаа хүнтэй танилцуулаад өгөөч гэж гуйснаар одоогийн нөхөртэйгөө танилцаж, гэрлэжээ. Нөхөр нь 26-тай боловч цэргийн алба хаасныхаа дараа оройтож сургуульд орсон учраас дөнгөж нэгдүгээр дамжаанд сурч байлаа. Ким эмч нөхрөө сургуулиа төгстөл өөрийнхөө цалингаар амьдарч болох биз хэмээн найдаж байжээ. "Чи түүний бардам занг хөндөнө дөө. Эмэгтэй, эмч хүн оюутантай гэрлэнэ гэдэг чинь юу гэсэн үг вэ? Эхнэрээрээ тэжээлгэхийг ямар ч эр хүсдэггүй" хэмээн ээж нь сануулж байж.

Хурим хийснийхээ шөнө л засахгүй алдаа хийснээ Ким эмч ойлгов. Гэвч жирэмсэн болсноо мэдээд шууд салж чадсангүй. Хүүгээ төрүүлснээс хойш хэдэн сар хөхөөрөө тэжээхийн тулд хадмындаа амьдраад дараа нь аавынх руугаа буцаж нүүв. Тэдний заншлаар гэр бүл салахад хүүхэд нь хадам талдаа үлддэг аж.

Авдаг цалин нь гэрлэлт бүтэлтэй болоход саад болж асан бол тэр нь одоо бүр байхгүй боллоо. Ким эмч сард 80 доллар буюу 186 воны цалин авдаг байсан нь жирийн ажилчныхаас гурав дахин их байжээ. Энэ мөнгөөрөө тэр нөхөр, эцэг эх, хадамд гарсан дүүгээ тэтгээд болоод л байсан юм. Цалин, хүнсний норм аль нь ч үгүй болж Ким эмч заримдаа цэцэрлэгт хүрээлэнгээс лийр хулгайлж, уул хадаар идчихмээр юм хайн тэнүүчилдэг болсон байв. Заримдаа өвчтнөөс уут гоймон, хэдэн ширхэг эрдэнэ шиш авчхаад маш их ичиж, санаа нь зовно. Өвчтнөөсөө хахууль авдаг эмч нарыг Ким эмч мэддэг, өөрийгөө хэзээ ч тэд нар шиг болохгүй гэж хатуу боддог байжээ. Гэвч өлсөж байгаа ходоодыг яах сан билээ?

Ким эмч хорин найм хүрэхдээ гэр бүлийн амьдрал нь бүтэлгүйтэж, хүүхдээ асрах эрхээ хадмууддаа алдаж, эцэг эхтэйгээ амьдардаг нэгэн болсон байлаа. Тэр урьдынхаасаа ч их чармайлт гарган ажиллах боловч цалин гэхээр юм авах нь үгүй. Өлсөж, ядарч, ядуурч хэнээр ч хайрлуулдаггүй өрөвдөлтэй нэгэн болсон байлаа.

Энэ бол Ким Ир Сений нас барахын өмнөх жил Ким эмчийн амьдарч байсан байдал.

Бусадтайгаа л адил Ким эмч, Ким Ир Сений нас барсныг үдийн мэдээгээр олж сонсов. Гэдэсний хижиг туссан нэгэн өвчтөнийг халдвартын эмнэлэгт хүргэж өгчихөөд дөнгөж ажил дээрээ буцаж ирээд байв. Эмнэлэг рүүгээ орж ирэнгүүтээ зурагтын өмнө уйлж байгаа эмч нарыг олж харлаа.

Ингээд Ким дөчин хором орчим алхаж гэртээ хүрэв. Нүд нь бүрэлзэж, нулимсаар дүүрээд харж болохгүй, арай л бүдэрч уначихалгүй алхаж байв. Аав нь гэртээ унтаж байжээ. Охиныхоо алхааг сонсоод сэрж орон дээрээ суулаа.

Охин нь өвчтөнүүдийнхээ талаар хэрхэн шаналдгийг мэдэх юм болохоор "Юу болов? Өвчтөнүүдийн чинь нэг нас бараа юу" хэмээн аав нь гайхан лавлав.

Ким эмч аавынхаа гар дээр уналаа. Тэр хайртай залуудаа хаягдахдаа, нөхрөөсөө салж, хүүхдээ хүнд алдахдаа, аав нь цус харвахад ч ингэтлээ гашуудан уйлж байсангүй. Эдгээр бол хүний

амьдралд тохиолддог л бэрхшээлүүд. Анагаахын боловсролтой, үхэлтэй бишгүй нүүр тулж байсан боловч Ким Ир Сенийг ингээд явчих юм гэж тэр огт бодоогүй.

Хамт ажилладаг эмч нарт нь бас төстэй зүйл тохиолджээ. Тэд шөнийн ээлжинд ажиллаж байхдаа хуйвалдааны онол бий болгон, хэлэлцэн байв. Зохиосон онолынх нь нэг нь "Өмнөд Солонгосын удирдагчтай дээд хэмжээний уулзалт хийх гэж байгааг боогдуулах үйл ажиллагаа явуулахын үүднээс агуу их удирдагчийг нь хөнөөсөн" гэх хувилбар.

Ким Ир Сений нас барсны дараах хэдэн өдөр манан дунд өнгөрөв. Сэтгэлийн дарамт, нойргүйдэл хоёроос ядарч туйлдсан Ким эмч гэр бүлийг нь ямар гай нөмрөөд байгааг эхэндээ ажигласангүй. Тэтгэвэрт суулгахад хүргэсэн өвчнөөсөө болж аав нь сэтгэл санаагаар ихэд дордсон билээ. Гэтэл их удирдагч байхгүй болж аавыг нь бүр хэвтүүлээд авав. Аав нь орондоо буруу харан хэвтэж, хэлэн дээрээ юу ч тавихаа болилоо.

Ким Ир Сен шиг агуу хүн үхэж байхад над шиг юунд ч хэрэггүй амьтан амьдарч, хоол хороогоод яах юм бэ хэмээн уйлна. Ким эмч аавыгаа ятгаж тайвшруулахыг оролдон, тайлбарлаж, уйлж, айлган сүрдүүлж ч үзэв. Та хэрвээ юм идэхгүй юм бол би ч идэхгүй. Хамтдаа үхье хэмээн айлгав. Ээж нь ч өлсөнө хэмээн сүрдүүллээ. Ажлын газраас Хөдөлмөрийн Намын үүрийн нарийн бичгийн даргыг авчирч аавыгаа ухуулж ч үзлээ. Бас хүч чадлыг нь тэтгэх гэж судсаар нь тэжээл ч өгөв. Энэ бүхэн ямар ч тусыг олсонгүй аав нь дэмийрч эхэллээ. Тэр нэг бол Ким Ир Сенийг магтана эсвэл зэмлэнэ. Нэг өдөр аав нь Ким Ир Сенд ямар их хайртай байснаа, түүнгүйгээр амьдарч чадахгүйгээ шивнэв. Дараагийн өдөр нь Ким Ир Сений үхэл Хойд Солонгосын тогтолцоо нуран унаж байгаагийн баталгаа хэмээн хэлж охиноо ажил дээрээсээ цаас олж ирэхийг гуйжээ. Тэгээд хүч чадлаа шавхан байж Хөдөлмөрийн намын үнэнч гишүүн болохын хувьд би сүүлийн даалгавраа биелүүлж байна. Охиныг минь миний ажлыг үргэлжлүүлэхийг зөвшөөрч, намын үнэнч сайн ажилтан болгон хүмүүжүүлэхийг хүсэлт болгож байна гэсэн утга бүхий захиа бичин охиндоо өгөөд эмнэлгийнхээ намын үүрийн нарийн бичгийн даргад гардуулаарай хэмээв. Дараа нь ахиад нэг хуудас цаас аваад галзуу хүн шиг сараачиж гарав. Ким эмч аав нь ухаан самуурч гэж боджээ. Энэ Хятадад байдаг миний хамаатан садны нэрс. Тэд чамд тусална гэв. Тэр нь угийн бичгэрхүү зүйл байлаа. Ким эмч цочирдов. Аав нь түүнийг эх нутгаа орхиод Хятад руу яв гэж байгаа юм уу? Өөрөө Хятадаас зугтааж, охиноо Ким Ир Сенийг хайрлах сэтгэлээр хүмүүжүүлсэн аав нь уу? Тэр урвагч юм биш биз? Эхлээд цаасыг шууд ураг гэснээ аавынхаа сүүлийн гэрээсийг арай ч тасдаж зүрхэлсэнгүй. Тэгээд охин наснаас нь хадгалагдаж ирсэн сүүлчийн зүйл болох цоож түлхүүртэй жижиг хайрцгандаа уг цаасыг дөрвөлжлөн эвхээд хийж орхилоо.

Ким Ир Сенийг газар доорх бунханд оршуулав. 1924 онд Ленинийг оршуулахад хийсэн ёслолоос хойш социалист орнуудад заншил болсны дагуу шарилыг нь занданшуулж, үзүүлэнд тавьжээ. Засаг төрөөс хоёр өдрийн оршуулах ёслолыг долоодугаар сарын 19,20-ны өдрүүдэд нарийн зохион байгуулсан байна. Пхеньяны төв радиогоор мэдээлснээр Ким Ир Сений шарилыг Кадиллак машин дээр байрлуулж, гашуудлын цуваа хот дундуур Ким Ир Сений талбайгаас эхлэн Ким Ир Сений нэрэмжит Их Сургууль, гучин нэгэн метр өндөр Ким Ир Сений хөшөөний хажуугаар өнгөрч, Хувьсгалчдын гулдан хаалга хүртэл явсан байна. Талийгаачийн хөргийг байрлуулж цэцгээр чимэглэсэн лимузин, гуулин хөгжмийн хамтлаг, олон зуун цэрэг, зуугаад

машин цуваа дагалдан явжээ. Дараагийн өдөр нь ёслолын арга хэмжээ болж өнгөрөв. Улс даяар дуут дохио хангинаж, машин, галт тэрэг, усан онгоцууд чагнаалаа дуугаргаж, хүндэтгэл үзүүлсэн байна. Ингээд гашуудлын ёслол дуусч, хүмүүс ердийн амьдралдаа эргэн оров.

Ким эмч өөртөө тохиолдсон зовлонг мартаж гэж цаг хугацааг умартан, улайран ажиллаж эхлэв. Ким Ир Сенийг нас бараад долоо хонож байхад эцэг нь өөд болсон учир гэртээ харих ямар ч хүсэлгүй болжээ. Халуу шатсан өдрүүд үргэлжилж, хижиг өвчний тархалт тахлын хэмжээнд хүрчээ. Солонгосын дайны дараа бохир усны сувгаа олигтой засаж янзлаагүйн улмаас цэвэршүүлээгүй ус голын урсгалд орж тэр усанд нь эмэгтэйчүүд угаалга хийдэг учраас Чонжин халдварын голомт болж, ямар ч өвчин дэлгэрсэн дарагдахад хэцүү болсон байна. Цахилгаан өглөө оройдоо нэг нэг цагаар ирэх учир хүмүүс усаа том торхонд хадгалаад, ариутгаж цэвэрлэх боломж гардаггүй учир бактери үржих үндэс суурь болно. Уг нь гэдэсний хижгийг антибиотикоор амархан дарж болох ч 1994 он гэхэд антибиотик огт олдохоо больжээ. Саван ч байсангүй.

1994 оны ер бусын халуун зуны дараа тэсгэм хүйтэн өвөл болов. Ууландаа хасах гучин таван хэм хүртэл хүйтрэв. Харин дараа зун нь асар их бороо орсноос үер усны аюул болж тутарганы талбай усанд автсан байна. Ингээд Хойд Солонгосын засгийн газар түүхэндээ анх удаа хүнсний хомсдолд орсноо хүлээн зөвшөөрсөн юм. НҮБ-ын тусламжийн багийнхан 1995 оны есдүгээр сард ирэхдээ үерээс болж 15 тэрбум долларын хохирол учирсан ба 5.2 сая хүний амьдралд нөлөөлж, 96,348 айлын гэр нурж, 500 мянган хүн орон гэргүй хоцорч, 1,9 сая тонн ургац алдсан хэмээн мэдээлжээ.

Хүүхдийн тасагт өвчтөнүүдэд нь нэгэн жигтэй шинж тэмдэг илрэхийг Ким эмч ажиглав. 1980-аад оны сүүлч 1990-ээд оны эхээр төрсөн хүүхдүүд гайхмаар жижиг биетэй, бага сургуулийн сурагч байхдаа өчүүхэн жижигт тооцогддог асан өөрөөс нь ч хамаагүй бага аж. Булчингийнх нь хөгжил дэндүү муу бөгөөд өлссөн бие махбодь булчингаа хэрэглэж амь зогоодог бөгөөд үүнийг нь "тураалд орох" гэж нэрлэдэг. Хүүхдүүд түгжрэл болох нь ихсэж өвдсөнөөсөө болж амь нь тэмцэн уйлж хашгирна.

Түгжрэл болж буйн гол шалтгаан нь хэрэглэж байгаа хүнсэнд байлаа. Гэрийн эзэгтэй нар хийдэг шөлөө ногоотой болгож харагдуулахын тулд элдэв өвс ургамал түүж нэмдэг болжээ. Будааны оронд эрдэнэ шиш хүнсний гол бүтээгдэхүүн болж хүмүүс өвс, хивэг, эрдэнэ шишийн гол, мөчир зэргийг түүж хоолондоо нэмэрлэнэ. Томчууд иймэрхүү хоол хэрэглээд аргалчихдаг бол хүүхдүүд шингээж чадахгүй түгжрэл болох нь олонтаа. Эмнэлэг дээр эмч нар энэ асуудлын талаар хоорондоо зөвлөлдөөд эцэст нь дээрх материалыг хоолондоо ашиглахдаа юуг анхаарах талаар томчуудад зөвлөгөө өгч эхлэв. Та бүхэн модны холтос болон өвс хоолондоо хэрэглэвэл эхлээд сайн хатаагаад нунтагласны дараа хоолондоо хийгээд маш удаан буцалгах хэрэгтэй. Тэгвэл хүүхдэд шингэц нь илүү хэмээн Ким эмч эцэг эхчүүдэд хэлж өгнө.

Арай том хүүхдүүд болон томчуудын хувьд дахин нэг өөр өвчний шинж тэмдэг илэрч эхлэв. Өвчтөнүүдийн гарын шуу, хүзүүгээр гялалзсан тууралт гардаг болсон нь сайн анзаараагүй хүнд хүзүүний зүүлт зүүсэн мэт харагдана. Нүднийх нь хажуугаар тууралт гарсан хүмүүс нүдний шил зүүсэн мэт харагдах ажээ. Үүнийг "нүдний шилний өвчин" гэж албан бусаар нэрлэдэг ч үнэн

хэрэгтээ хүнсэнд ниацин дутагдахад гардаг арьс ярших өвчин гэгч юм. Зөвхөн эрдэнэ шишээр хооллодог хүмүүсийн дунд энэ өвчин түгээмэл тохиолддог байна.

Хүүхдүүд бага зэргийн ханиад шуухинаа, гэдэсний өвчтэй гэж хүргэгдэж ирээд л гэнэт нас бараад байлаа. Хүнсний хомсдол, тэжээллэг бус байдал дархлааг нь сулруулсантай холбоотой байсан гэнэ. Антибиотик байсан ч бие махбодь нь дийлэхээргүй сул болсон байв. Нялх хүүхдүүд бүр хэцүү нөхцөлд байлаа. Эх нь өөрөө олигтой хоол идэж чадахгүй болохоор хөхөнд нь сүү орохгүй, хүүхдийн тэжээл байхгүй, сүү олдоц муутай. Өмнө нь сүү муутай эхчүүд цагаан будааны шүүсээр хүүхдээ тэжээдэг байжээ. Гэтэл одоо ихэнх нь цагаан будаагаа олж авч чадахгүйд хүрчээ.

Бас ямар нь мэдэгдэхгүй, оношлогдохгүй хачин шинж тэмдэг бүхий өвчтэй хүүхдүүд бий болов. Тэд цонхийсон, заримдаа хөхөвтөр царайтай, арьс нь ямар ч уян хатан чанаргүй цаас шиг хэврэг. "Заримдаа гэдэс нь хавагнаж, заримдаа зүгээр болдог. Яагаад байгааг нь мэдэх аргагүй. Уйлаад зогсохгүй. Би саатуулж ч чадахаа байлаа" гэж ээжүүд ярина.

Ким эмч толгой дохиж өрөвдөхөөс хэтрэхгүй. Байдлыг сайн ойлгох авч хэлэх үг олдохгүй. Идэх юм гэрт нь огт байхгүй, олох ч боломжгүй ээжүүдэд хүүхдээ сайн хоолло гэж хэлж зүрхлэх билээ.

Эмчилж чадахгүйгээ мэдсээр байж Ким эмч хүүхдүүдэд эмнэлэгт хэвтэх бичиг хийж өгнө. Эмнэлэгт ч хүнс гээд байх юм үгүй. Өглөө үзлэгээ хийгээд явж байхад Ким эмчийг хүүхдүүдийн нүд салахгүй дагана. Гарч явахад нь ч араас нь харсаар л байгааг тэр мэдэрнэ. Өөрсдийг нь эдгээж, идэх юм өгөх байх даа гэж горьдсон нүдээр хардаг хүүхдүүд удахгүй ямар ч найдваргүй гэдгийг ойлгов.

Хүүхдүүд над руу буруутгасан нүдээр хардаг байсан. Дөрвөн настай багачууд хүртэл удахгүй үхэхээ мэдэрч, эмч бидэнд яагаад туслахгүй байгаа юм бол гэж гайхсан нүдээр хараад л. Миний хийж чадах ганц зүйл гэвэл үхсэн хойно нь уйлж, ээжүүдийнх нь уй гашууг хуваалцах л байлаа гэж тэр олон жилийн дараа ярьсан юм.

Ким эмч эргэн тойронд нь байх элдэв өвчин, зовлон шаналлыг өөрөөсөө холуур өнгөрөөж сураагүй, туршлагагүй шинэхэн эмч учир бүх зүйлийг сэтгэл зүрхэндээ ойрхон хүлээж авдаг байжээ. Хүүхдүүдийг өвдөхөд сэтгэл зүрхээрээ мэдэрнэ. Олон жилийн хойно өөрийнх нь нүдэн дээр нас барсан хүүхдүүдээс хэн нэгийг санаж байгаа эсэхийг лавлахад бүгдийг нь санаж байна хэмээн хариулсан юм.

Он жил өнгөрөх тутам эмнэлэгт өвчтөнүүдэд өгөх зүйл багассаар байлаа. Нүүрсгүй болсноос байрны доод хонгилд байх зуухыг гаргаж хаяжээ. Усгүй болсноос шалаа ч олигтой цэвэрлэж чадахаа болив. Өдрийн цагаар эмнэлгийн хонгилд харанхуй учир эмч нар тайлангаа бичих гэж цонхны гэрэл бараадна. Өвчтөнүүд эмнэлэгт хэвтэхдээ хөнжил хүнсээ өөрсдөө авч ирнэ. Боолтын материал дутмаг учир орны даавуу цуулж хэрэглэдэг болов. Харин эмнэлэг дуслын шингэн үйлдвэрлэх боловч савлах шил байхгүй. Иймээс дуслын шингэн тариулах өвчтөнүүд Чонжины

хамгийн алдартай шар айраг болох "Раквон" эсвэл "Парадайз"-ийн шил авчирч эмнэлэгтээ тушааж байж тариагаа авна.

Шар айргийн нэг шил авчирвал нэг л дуслын шингэн авна. Хоёрыг авчирвал хоёрыг авдаг байв гэж Ким эмч дурсан ярьж билээ.

Яваандаа эмнэлэг хоосров. Тэртэй тэргүй эмчилгээ хийгдэхгүй юм чинь эмнэлэгт хэвтээд ч яахав дээ.

Ким Чен Ир сүүлийн арван жил аавынхаа халааг авах бэлтгэл ажил хийж, эрх мэдлийг бага багаар гартаа оруулж байсан болохоор Ким Ир Сенийг нас барсны дараа улс оронд төдийлөн их өөрчлөлт орсонгүй. Олон жилийн үр ашиггүй үйл ажиллагааны улмаас эдийн засаг уналтад орох нь тодорхой байлаа. Гэтэл агуу их удирдагч нь угтан ирэх он жилүүдэд болох гамшигт үйл явдлаас зугтаж байгаа мэт үхээд өгдөг. Тэр үнэндээ яг зөв цагтаа үхсэн аж. Хэрэв их удирдагч ахиад хэдэн жил амьдарсан бол Хойд Солонгосчууд өдгөө түүнийг улс орноо удирдаж байх үед байсан боломжийн амьдралаа тийм гэгэлгэнээр эргэн дурсахгүй биз ээ. Ким Ир Сений үхэл коммунист дэглэмийн сайн сайхан яг дуусан унтарч буй үетэй давхацсан билээ.

1995 он гэхэд Хойд Солонгосын эдийн засаг их удирдагчийн шарил адил мөс шиг царцанги болоод байв. 1991 онд нэг хүнд ногдох ДНБ 2460 ам.доллар байсан бол 1995 онд 719 ам.доллар болтлоо буурчээ. Бараа бүтээгдэхүүний экспортын хэмжээ хоёр сая ам.доллараас 800 мянган доллар болтлоо уруудсан байна. Эдийн засгийн уналт амьтай бүхнийг дуугуй болгож, аажмаар үхүүлэх аймшигтай уршиг дагуулав.

Чонжины далайн эргийн дагуух томоохон үйлдвэрүүд зэвэнд идэгдэж, нурж унах дөхсөн харагдах агаад яндангууд нь шоронгийн төмөр сараалж мэт ёрдойх болов. Үйлдвэрийн яндангуудаас утаа гарч буй эсэхээр хүмүүсийн амьдрал ямар байгааг хэмжиж болох мэт. Хааяа нэг сайндаа л хоёр гуравхан үйлдвэрийн яндангаас утаа гарч харагдах бөгөөд бусад нь амьгүй мэт дүнсийнэ. Хот тэр аяараа сүйрч байлаа. Үйлдвэрүүдийн гол хаалгыг том цоожоор цоожилсон байх боловч хулгайч нар аль хэдийн эвдэж, тоног төхөөрөмжийг нь тоножээ.

Үйлдвэрийн дүүргийн хойд тал дахь боомтын далангуудыг далайн давалгаа чимээгүй бөгөөд уйтгартай цохих нь харагдана. Өмнө нь Орос, Японы ачааны хөлөг онгоцууд ирж хүн зон үймж асан боомт одоо эл хуль. Зөвхөн хэдэн зэвэнд идэгдсэн дотоодын хөлөг л хөглийж харагдана. Боомтын ар талын хадны орой дээр "Ким Чен Ир бол 21-р зууны агуу их хүү" хэмээн том улаан үсгээр бичсэн нь бүдгэрч ягаавтар өнгөтэй болсон нь сэргээн будахгүй бол удахгүй хаднаасаа өнгө ялгарахгүй нь уу гэмээр.

Хойд Солонгосын хамгийн бохирдсон хотын нэг болох Чонжин одоо цэвэршиж, чимээгүй хоосон хот болон хувирчээ. Зүүн Хойд Азид хуурай улиралд тооцогддог намар, өвлийн цагаар тэнгэр цэнхэр, жаварлаг байдаг. Төмрийн үйлдвэрүүдээс гардаг хүхрийн үнэр арилж хүмүүс дахиад далайн салхиар амьсгалах боломжтой болов. Бетон хананууд зун цагт мөлхөө өвсөөр хучигдана. Ямар ч хоггүй болоод байлаа. Хойд Солонгосчууд хог их тарьдагтаа биш харин ч

эсрэгээрээ тэдэнд хаях юм тун ховор. Эдийн засаг зогсолтод орсон энэ үед соёлт ертөнцийн ул мөр үгүй болсоор байлаа. Салхинд хийсээд эсвэл газраар хөглөрч харагддаг гялгар уут, чихрийн цаас, усанд хөвөөд байж л байдаг ундааны лааз ор сураггүй болжээ. Тамхи татаж байгаад ишийг нь зам дээр хаяхад тэр дороо л алга болно. Үлдсэн чимх ч болов дүнсийг нь аваад сонинд ороож татах гэж байгаа нь тэр.

НАЙМДУГААР БҮЛЭГ

БАЯН ХУУР БА САМБАР

Ким Ир Сен нас барснаас болж Ми Раны хөгжмийн шалгалт хойшлогдож, 1994 оны намар хүртэл сургуулиа төгсөж чадсангүй. Багшилж эхлэх, ер нь ямар ч ажил эхлэхэд таатай үе биш байлаа. Чонжины хүнсний түгээлт бүрмөсөн зогссон учир Ми Ран аавынх руугаа буцаж нүүх талаар бодож эхлэв. Гэртээ ойрхон ажил олохоор хөөцөлдөж, аз болоход аавынх нь ажилладаг уурхайн ойролцоо цэцэрлэгийн багш хийх завшаан таарав. Ээж, аав нь Ми Раныг гэртээ буцаж ирсэнд баярлан угтав. Хадамд гараагүй охид эцэг эхтэйгээ амьдрах нь жирийн хэрэг тул Ми Ран ээжийнхээ гэр ахуйн ажилд тусалж, ажилдаа бараг явахаа больсон аавдаа хань болох үүрэгтэй боллоо. Өөрөө ч хоол ундтай залгасан тул энэ үүргээ биелүүлэхэд ер түүртсэнгүй. Том хоёр эгч нь нөхөрт гарч, дүү нь багшийн сургуульд орсноор тэднийх эл хуль оргиод байсан тул Ми Ран ирсэн нь завшаан болов.

Ми Ран ажил руугаа 45 хором алхаж очно. Цэцэрлэг нь Чонжинд дадлага хийж байсан газартай нь тун төстэй. Гаднах төмөр хашаан дээрээ наран цэцэг гоёмсгоор зурж, хаалгандаа нуман дээвэр гарган чимэглээд дээр нь "Бид аз жаргалтай хүүхдүүд" гэж бичээгүй бол энэ нэг давхар бетон байшин их л ёозгүй харагдахаар ажээ. Гадаа хашаанд нь эвдэрхий модон сандалтай эргэдэг тоглоом, гулсуур, сармагчин хэлбэртэй савлуур зэрэг бий. Ангиуд нь нэг хэмжээтэй, бүгд самбарынхаа дээр эцэг хүү удирдагчийн хөргийг залсан байна. Хоёр хүүхэд суух ширээ нь төмөр хүрээн дээр хавтгай мод байрлуулсан төдий. Өрөөний нэг буланд хүүхдүүдийн унтдаг гудас хураалттай. Эсрэг талд нь цөөхөн хэдэн ном бүхий тавиур байх. Номуудыг дээр үед уг эхээс нь хувилж авсан учир одоо элэгдээд уншигдахаа ч байжээ. Ном цаас ховор тул зарим идэвхтэй ээж хувилсан номоос гараараа хуулж уншиж өгөх нь бий.

Хот хөдөөгийн цэцэрлэгийн ялгаа хүүхдүүд дээр маш тод илэрч байв. Хөдөөнийх нь хотынхоосоо хамаагүй ядуу. Цэцэрлэгт дүрэмт хувцас гэж үгүй учир хүүхдүүд халаалтгүй өрөөнд даарахгүйн тулд ах эгчээсээ дамжиж ирсэн хуучин хувцасуудыг олон давхарлаж өмсөн ирцгээнэ. Хүүхдүүд ямар ноорхой юм өмсдөг юм бэ дээ гэж Ми Ран өрөвдөнө. Хувцсыг нь нэг нэгээр нь тайлсаар байгаад үлдэж байгаа нь өчүүхэн жижиг бие. Гарыг нь дулаацуулахаар атгахад хурууд нь хушганы самрын чинээ л юм болно. Тав зургаатай хүүхдүүд гурав дөрөвтэй юм шиг л харагддаг байлаа. Чонжин дахь шавь нар нь үйлдвэрийн ажилчид, албаны хүмүүсийн хүүхдүүд байсан бол энд уурхайчдын хүүхдүүд хүмүүжнэ. Хүнс хоол хомстсон энэ үе уурхайчдад илүү хүнд тусаж байна уу даа гэсэн бодол Ми Ранд төрнө. Өмнө нь хүнд хөдөлмөр эрхэлдэг учир жирийн ажилчдаас илүү буюу 900 грамм цагаан будааны нормтой байсан уурхайчид уурхай нь хаагдсанаас хойш юу ч авахаа болив. Хүүхдүүд цэцэрлэгээс өдөрт ганц удаа өгдөг үдийн хоол буюу хуурай навч давсны хольцтой шөлийг идэх л гэж ирдэг байх гэж Ми Ран таамаглана.

Нөхцөл ийм ч гэлээ Ми Ран ажлаа сэтгэл өөдрөг эхэллээ. Боловсролтой, хүндтэй давхаргын нэг гишүүн - багш хэмээх мэргэжлийг жирийн уурхайчин, түүн дотроо нийгмийн доод давхаргын хүний охин эзэмшинэ гэдэг дээдийн дээд заяа. Үрчлээг нь тэнийлгэхээр гудасныхаа доор хийсэн цагаан цамцаа өглөөд гарган өмсөнө.

Цэцэрлэг найман цагт ажиллаж эхэлнэ. Нүүр дүүрэн инээмсэглэн, хүүхдүүдээ угтаж аваад хуваарьт суудалд нь суулгасныхаа дараа Ми Ран баян хуур хөгжмөө авчрав. Багш нар баян хуур хөгжим тоглож сурах шаардлагатай, төгсөхдөө Ми Раны өгсөн хөгжмийн шалгалт гэж бичсэн маань баян хуурын шалгалт байсан юм. Тоглодог л бол хэн ч байсан баянхуур хөгжим үүрээд барилгын талбай болон ямар нэг биеийн хүчний хөдөлмөр эрхэлж буй ажилчдыг дэмжих, урамшуулах зорилгоор хувьсгалт маршийн ая тоглох нь түгээмэл учир ард түмний хөгжим хэмээн нэрлэдэг ажээ. Ингээд багш нар хүүхдүүдтэйгээ хамт "Бидэнд энэ дэлхийд атаархах зүйл үгүй" хэмээх, Америкийнхаар бол "Twinkle twinkle little star" шиг хүүхэд бүрт аялгуу нь танил болсон дууг дуулна. Тэр алдарт дуунд: Эцэг минь! бидэнд Энэ дэлхий дээр атаархах зүйл гэж үгүй Бидний гэр намын ивээлд буй Бид бүгд ахан дүүс Хөөрхөн хүүхдүүд минь Аюулт галын дөл ойртон ирсэн ч бүү ай Хүндэт эцэг минь бидэнтэй байна Энэ дэлхий дээр бидэнд атаархах зүйл үгүй хэмээн өгүүлдэг.

Ми Ран Ми Хи эгч шигээ хөгжимдөж, дуулах авьяастай биш бөгөөд дуулахыг нь Жун Сан анх сонсоод бүр цочсон билээ. Харин хүүхдүүд түүний солгой хоолойг төдийлөн анзаарахгүй. Дуулах үедээ хүүхдүүд багш руугаа толгойгоо өргөн харж, урам зоригтойгоор дагадаг байлаа. Тэд багшийгаа шүтэн биширч, өөдрөгөөр даган дууриана. Дүү нь түүнтэй насны хувьд дэндүү ойролцоо байснаас, эгч дүүгийн гэхээсээ илүү өрсөлдөгчийн харьцаатай байсандаа Ми Ран харамсдаг. Хэрэв насны хувьд нэлээд зөрүүтэйсэн бол дүүдээ зааж сургаж, заримдаа эгчирхэж байсаар өдийд бага насны хүүхэдтэй харьцах талаар аль хэдийн эв дүйтэй болчихсон байхгүй юу.

1977 онд бичсэн Социалист Боловсролын тухай Илтгэлдээ Ким Ир Сен "Зөвхөн ухаалгаар боловсруулсан улс төр, үзэл суртлын мэдлэгийн үндсэн дээр ард түмэнд шинжлэх ухаан, технологи болон биеийн тамирын боловсролыг амжилттай олгоно" хэмээжээ. Хүүхдүүд уншиж чадахгүй тул Ми Ран удирдагчдын сургаалаас уншиж өгч, цээжлэх шаардлагатай мөрүүдийг нь дагуулж хэлүүлнэ. Өхөөрдмөөр хөөрхөн жижигхэн амьтад Ким Ир Сений үгээс татсан ишлэлүүдийг шингэн хоолойгоор даган унших нь томчуудын хайрыг татаж, сонссон хэн бүхэн өөрийн эрхгүй инээмсэглэнэ. Үзэл суртлын хичээл дууссаны дараа хүүхдийн сэтгэхүйд арай ойр зүйлс зааж эхэлнэ. Гэхдээ хүүхдүүд ямар ч хичээл үзлээ гэсэн агуу их удирдагч сэтгэл зүрхэнд нь үргэлж ойрхон, ямагт хамт байдаг. Математик, газарзүй, уншлага, дуу хөгжим, зураг гээд ямар ч хичээл заавал их удирдагчийг шүтэж, дайсныг үзэн ядах талаар ухуулсан утгатай байна. Нэгдүгээр ангийн математикийн өгүүлбэртэй бодлогод: "Найман хөвгүүн, есөн охин Ким Ир Сенийг магтсан сүлд дуулал дуулж байна. Нийт хэдэн хүүхэд дуулж байна вэ?" "Японы түрэмгийлэгчдийн эсрэг хийсэн дайны үеэр нэгэн охин эх оронч цэргүүдэд мэдээ дамжуулахаар явж байхдаа захидлаа таван алим хийсэн сагсанд нуун явжээ. Гэтэл Япон цэрэг замд нь зогсоож, хоёр алимыг нь булаан авав. Тэгвэл сагсанд нь хэдэн алим үлдэх вэ?" "Солонгосын Ардын Армийн гурван цэрэг Америкийн гучин цэргийг буудан устгажээ. Хэрэв хүн тус бүр адил тооны цэргийг буудан хөнөөсөн бол нэг цэрэг хэдэн Америкийг устгасан бэ?" гэсэн байх жишээтэй.

2003 онд хэвлэгдсэн нэгдүгээр ангийн унших бичгийн номд дараах шүлэг орсон байна. Шүлгийн нэр нь "Бид юуг зорино вэ?". Бид хаана ирчихэв? Бид ойд ирчихлээ Бид хаашаа явж байна вэ? Бид уулыг даван алхаж байна. Бид юу хийх гэж байна вэ? Бид Японы цэргүүдийг устгах гэж байна Бас

нэгдүгээр ангийн дуу хөгжмийн хичээл дээр "Янки зулбасгануудыг буудацгаая" гэдэг дуу заадаг.

Эгнэгт бидний дайсан бол

Эх орныг минь булаан эзлэхээр санаархах

Америк зулбасганууд

Өөрийн гараар хийсэн буугаар

Тэднийг би буудна. Пүн Пүн Пүн.

Унших бичгийн номуудад бичихдээ Христосын номлогчид,

Японы түрэмгийлэгчид, Америк зулбасганууд хүүхдүүдийг хэрхэн зодож, жадалж, түлж, нүүр рүү нь хүчил цацан, худагт живүүлж байгаа тухай л өгүүлдэг. Америк цэргийн гутлыг тосолж өгөхөөс татгалзсан бяцхан хүүг дэвсэлж алсан тухай ч байна. Германы нацистууд еврейчүүдийн эсрэг гаргасан шог зураг дээрээ жүүдүүдийг дүрсэлдэгчлэн, Америк цэргүүдийг унжгар урт хамартайгаар дүрслэн зурна.

Ми Ран Солонгосын дайны үед америкчуудын гаргаж байсан зэрлэг догшин авирын талаар ихийг сонссон боловч итгэх эсэхээ үл мэднэ. Ээж нь нэг удаа Солонгосын дайны үеэр өндөр, царайлаг Америк цэргүүд хот дундуур машинтайгаа явах үеэр хүүхдүүд дагаж гүйдэг байсан тухай ярьж өгчээ.

Та зугтаахын оронд араас нь дагадаг байсан гэж үү?

Бидэнд бохь өгдөг болохоор л дагадаг байсан юм.

Тэд чинь та бүгдийг алах гэдэггүй байсан юм уу? Эх охин хоёрын хооронд ийм яриа болж өнгөрчээ.

Түүхийн хичээл дээр хүүхдүүд тойрон аяллаар явна. Томоохон бага сургуулиуд "Ким Ир Сений Судалгааны Төв" хэмээх сүржин нэртэй өрөөнүүдийг засаж тохижуулсан байна. Уурхайчдын тосгоны цэцэрлэгийн хүүхдүүд, Кёнсаны бага сургууль дээр зочилж, бусад өрөөнүүдээсээ цэмцгэр, саруулхан, илүү дулаан тэр тусгай өрөөнд орж үзжээ. Хөдөлмөрийн намын төлөөлөгч үе үе ирж сургуулийн үйлчлэгч тусгай өрөөг цэвэрлэж, янзалж байгаа эсэхийг шалгадаг уламжлалтай. Өрөө шүтээний газар шиг л байлаа. Ким Ир Сенд зориулсан тусгай өрөөнд орохдоо инээж, түлхэлцэж, хоорондоо ярьж болохгүйг цэцэрлэгийн бага ангийн хүүхдүүд хүртэл сайн мэднэ. Гутлаа тайлаад эгнэж зогсоно. Дараа нь их удирдагчийн зургийн өмнө гүн мэхийн ёслоод "Эцэг минь баярлалаа" хэмээн хэлнэ.

Өрөөний хамгийн чухал хэсэг бол шилэн хоргон дахь Ким Ир Сений төрсөн газар, Пхеньянаас холгүй орших Мангёндэ тосгоны загвар юм. Хүүхдүүд сүрлэн дээвэртэй байшингууд бүхий тосгоны дуураймал загварыг харж агуу их удирдагчийнх нь төрж өссөн газартай эчнээ танилцаж, бас удирдагч нь эх оронч хувьсгалчдын гэр бүлээс гаралтай, амьдрал нь төдийлөн чинээлэг байгаагүй тухай мэдэж авна. Тэдэнд бас 1919 онд удирдагч долоон настай байхдаа тавдугаар сарын нэгний бослогын үеэр Японы түрэмгийлэгчдийн эсрэг уриа хашгиран босогчидтой нэгдсэн, баян газрын эздийг хэрхэн үзэн ядаж өссөн зэргээр бага наснаасаа л хувьсгалын үйлсэд бэлтгэгдэж өссөн тухай ярьж өгнө. Бас 13 настайдаа хувьсгалын үйл хэрэгт зүтгэхээр гэрээсээ

явсан хэмээн ярина. Хананд өлгөсөн зургуудад Ким Ир Сен япончуудтай хэрхэн тулалдаж явсныг дүрслэн үзүүлсэн байна. Албан ёсны хэмээн тооцогддог түүхэнд нь түүний Орост өнгөрөөсөн цаг хугацаа болон ард түмний удирдагч болоход нь Сталины оруулсан хувь нэмэр зэргийг үл өгүүлнэ. Ким Ир Сен бараг ганцаараа япончуудыг ялсан мэт ойлголт төрүүлдэг.

Ким Ир Сен нас барснаасаа хойш амьд байх үеэсээ илүү алдаршив. Пхеньянаас цаг тооллын хуанлийг өөрчлөх тушаал буулгалаа. Христийн тооллоос Чучхегийн тоолол руу шилжих болов. Ким Ир Сений төрсөн он буюу 1912 оноос цаг тооллын бичиг эхэлж, түүний өнгөрсөн 1994 он нь Чучхегийн 84-р он болжээ. Хожим нь түүнийг "Мөнхийн ерөнхийлөгч" хэмээн нэрлэсэн ба улс эх орныг үеийн үед "Мөнхийн амьдралын цамхаг" доорх бунхнаасаа удирдаж, Хөдөлмөрийн Намаа даргалан, улс орон дахь хамгийн дээд албан тушаал Үндэсний Батлан Хамгаалах Комиссоо захирна хэмээн тунхаглажээ. Хэдийгээр Ким Чен Ир төрийн тэргүүн мөн боловч аавыгаа ерөнхийлөгч хэмээн хүлээн зөвшөөрсөн нь нэгдүгээрт эцэгтээ үнэнчээ харуулах, хоёрдугаарт өөрөөс нь хамаагүй илүү нэр хүндтэй түүний сүр хүчийг ашиглах гэсэн давхар зорилгыг агуулсан байжээ. 1996 оноос өмнө Ким Чен Ир өөртөө хөшөө босгохыг хориглож, хөрөг зургийг нь залахад дурамжхан хандаж, олны өмнө төдийлөн гарч ирдэггүй байсан бол эцгийгээ өнгөрснөөс хойш эрс өөрчлөгдөв. Тэр жилдээ Боловсролын Яамны сайд орон даяар бүх сургуулиудад Ким Чен Ир Судалгааны Хүрээлэн байгуулах тушаал гаргав. Эцэгт нь зориулсан тусгай танхимуудтай бараг адил. Ялгаа нь Ким Ир Сений төрсөн Мангёндэ тосгоны оронд Ким Чен Иррийн төрсөн, төрөх үед нь давхар солонго татсан хэмээн ярьдаг Пекту хэмээх Хятад, Хойд Солонгосын хил дээр орших галт уулын загварыг байрлуулсан байна. Үнэн хэрэгтээ Ким Чен Ир Оросын Хабаровск хотын ойролцоо төрсөн боловч, хайрт удирдагчаа харь оронд биш нутгийнхаа Тангун бурхан мэндэлсэн гэгддэг Пекту уулыг сонгож авсан нь тохиолдлын зүйл биш.

Түүхийг дахин зохиох, домог бүтээх гэдэг тэдэнд тийм ч хэцүү биш. Ганц асуудал нь удирдагчдаа зориулж байшин барилга барих, хуучин нэгийг нь засах ажил болов. Ким Чен Иррийн танхим аавынхаасаа дутахгүй чанар, өнгө үзэмжтэй байх ёстой. Гэтэл үйлдвэрүүд зогссоноос үүдээд цемент, шил, мод гээд л барилгын материалын олдоц тун муу болсон байлаа. Чонжины шилний үйлдвэр үйл ажиллагаагаа зогсоосон учраас хамгийн олдоц муутай нь цонхны шил байв. Цонх хагарвал модоор битүүлэх, эсвэл гялгар уутаар бүрдэг болсон үе байжээ. Улс орон даяар шил үйлдвэрлэж буй цорын ганц үйлдвэр нь Шар Тэнгисийн эрэг дээр орших Намбод байсан ч сургуулиудад тэндээс шил худалдаж авах мөнгө үгүй байлаа. Кёнсаны цэцэрлэг төлөвлөгөө зохиов. Төлөвлөгөөний дагуу багш сурагчид, нутагт нь хамгийн их олдоцтой вааран эдлэл цуглуулж, Намбод аваачиж давсаар солиод, тэр давсаа зарж, шил авах мөнгө олох ёстой. Энэ төлөвлөгөө төвөгтэй байсан ч өөр илүү санал гараагүй учир хэрэгжүүлэхээр болов. Улс орон даяар явагдаж буй кампанит ажлын хүрээнд Ким Чен Иррийн танхимыг сургууль, цэцэрлэгүүд дотоод нөөц бололцоогоо ашиглан засах ёстой болсон учир ийн чадах бүхнээ хийсэн билээ. Захирал нь багш, эцэг эхийн төлөөлөгчдийг Намбо явахыг хүсэв. Ми Ран хамгийн сэргэлэн, авхаалжтай, итгэл даахуйц нь болохоор уг бүлэгт орон явахаар боллоо.

Явах тухайгаа сонсонгуутаа Ми Ран газрын зураг судалж эхэллээ. Намбо, Солонгосын хойгийн нөгөө талд, Пхеньянаас баруун урд зүгт байрлана. Ямар ч галт тэргээр явсан заавал Пхеньянаар дайрах ба их дээд сургуулиуд төвлөрсөн газрын ойролцоох зөрлөг дээр зогсох учир Жун Саны

байгаа газар руу яваад очих боломжтой юм байна хэмээн хөөрөн баярлалаа.

Ким Ир Сенийг нас барснаас хойш Ми Ран найз залуутайгаа холбоотой байж бараг чадахаа больжээ. Уг нь нэгнээсээ ичин, тавгүй байдаг тэр үе нь өнгөрч, хамтдаа байхдаа тайван, жаргалтай болж эхэлж байсан юм. Гэтэл сүүлийн үед, өмнө нь долоо хонож ирдэг асан захиа хэдэн сарын дараа ирдэг, заримдаа бүр огт ирэхээ больсон байна. Хүмүүс үүнийг галт тэрэгний буудлын ажилтнууд дулаацах гээд түлчихдэг байх хэмээн таамаглана.

Жун Саны нутагтаа ирдэг нь ч цөөрөв. Ми Ран гэртээ суугаад Жун Санаас захиа ирэхийг, мөн гэнэт ороод ирж магадгүйг нь зүгээр л хүлээн суудагтаа их дургүй. Тиймээс төрөлхийн хөдөлгөөнтэй, авхаалжтай тэр бүсгүй Намбо явах замдаа Жун Сантай өөрөө уулзахаар шийдлээ. Гэтэл Пхеньянд очих, эсвэл дайран гарахад шаардлагатай замын зөвшөөрөл авах гэж нэг том даваа байдаг. Пхеньян үзүүлэнгийн хот болохоор засгийн газраас, орж гарах хүмүүсийн тоог зориудаар хязгаарлана. Ми Раны гэрийн ойролцоо Хүүгийнх нь өсөлт зогссоноос болоод Пхеньянаас хөөгдсөн нэгэн гэр бүл Ми Раны гэрийн ойролцоо амьдардгийг бүсгүй мэдэж байлаа. Жирийн хүмүүс зөвхөн зохион байгуулалттайгаар, албан газар, анги сургуулиараа тойрон аялал хийх журмаар л Пхеньянд очиж болно. Ми Ран ангиараа явсан тойрон аяллаар ганц л удаа улсынхаа нийслэлд очиж үзсэн байлаа. Тэгэхээр түүнд замын зөвшөөрөл авах ямар ч арга үгүй. Галт тэрэг зогсохоор нь зүгээр л буугаад явчихья хэмээн шийдэв.

Тэд тавуулаа Намбо орохоор хөдлөв. Захирал, эцэг эхийн төлөөлөл хоёр хүн, бас нэг багш, тэгээд Ми Ран. Зам муугаас болоод Намбо орох галт тэрэг гурван өдөр явж хүрэв. Галт тэрэг чахран зогсоход Ми Ран цонхоор гөлрөн, хамт явж буй хүмүүсээсээ яаж сугарч үлдэх вэ хэмээн санааширч байлаа. Хамгийн залуу, нийцтэй, сэргэлэн, яриа хөөрөөтэй багш яагаад гэнэт ийм дуугай томоотой болсон талаар хамт явагсад нь гайхаад сүүлдээ шалгааж эхэллээ. Гэр бүлийн асуудал аа, санаа зоволтгүй гэж Ми Ран хариулав. Нэгэнтээ худлаа хэлсэн болохоор дараагийн худал ар араасаа төрж эхлэв. Буцахдаа галт тэрэгнээс бууж, хамаатантайгаа уулзчихаад дараагийн галт тэргээр Чонжинд очье хэмээн шалтаглан үлдэв. Бусад нь төдийлөн гайхсангүй, толгой дохин өрөвдсөн харцаар үдэцгээв. Учир нь Ми Раныг гайгүй амьдралтай хамаатнаасаа мөнгө гуйхаар буулаа хэмээн бодоцгоосон байна. Ингэж ойлгох ч шалтгаан байлаа. Чонжины бараг бүх хүн, ялангуяа багш нар сүүлийн нэг жил цалингийн бараа хараагүйгээс хоосорцгоосон ажээ.

Галт тэрэг хөдлөхөд Ми Ран бөглүү, гэрэл муутай буудал дээр зогссоор хоцорлоо. Тэр хэзээ ч ганцаараа аялж үзээгүй. Мөнгө гэхээр юмгүй, бичиг баримтын зөрчилтэй түүнийг шалгах л юм бол Пхеньянаар явах биш зөвхөн дайран өнгөрөх эрхтэйг нь төвөггүй олж илрүүлэхээр байв. Галт тэрэгнээс буугаад гарц руу ойртож буй хүмүүсийн цувааг хараад, хүн бүрийн бичиг баримтыг цагдаа шалгаж буйг олж мэдэв. Эндхийн шалгалт Чонжиныхоос хамаагүй чанга гэгдэнэ. Ийм юм болно гэж Ми Ран огт бодсонгүй. Хэрэв замын зөвшөөрөлгүй хот руу нэвтрэх гэж байгаад баригдвал, Ми Раныг баривчлах, цашилбал хөдөлмөрийн лагерьт цөлөх, хамгийн наад зах нь ажлаас нь халах аюул хүлээж байлаа.

Ми Ран өөр гарц бий эсэхийг шалгахаар эргэн тойрноо харав. Гэтэл нэгэн дүрэмт хувцастай эр

өөрийг нь ажиглан байхыг харлаа. Байн байн эргэн харсаар алхаад л байв. Гэтэл нөгөө хүн дагаад л байлаа. Ярьж болохоор ойртож ирсэн хойно л тэр хүн өөрийг нь эргүүлэх гэж байгааг сая мэдрэв. Айсандаа болоод өмссөн дүрэмт хувцас нь цагдаагийнх биш механикийнх байсныг ч анзаарсангүй. Залуу өөрийнх нь насны, түвшин царайтай хүн байв. Ми Ран найз залуутайгаа уулзахаас бусад бүх үнэнээ залууд тайлбарлан хэллээ. Миний эрэгтэй дүү галт тэрэгний буудлын ойролцоо амьдардаг юм. Би дүүтэйгээ уулзмаар байна. Даанч замын зөвшөөрлөө мартаж орхижээ. Шалгалт их чанга уу? гэж залуугаас асуулаа. Механик залуу овоолсон ачаануудын араар явж, ачаа нэвтрүүлдэг, шалгагч байдаггүй хаалгаар охиныг гаргаж өглөө. Залуу ахин уулзаж болох эсэхийг асуухад худлаа нэр, хаяг цаасан дээр бичиж өгчихөөд маш их санаа зовов. Ганцхан өдрийн дотор амьдралдаа хэзээ ч хийж байгаагүй үйлдлүүдээ дэндүү олныг хийлээ дээ.

Их сургуулийн үүдэнд жижүүр хийж байсан оюутан Ми Раныг сэжигтэй нүдээр харна. Тэгснээ Жун Саныг олж ирэхээр гүйв. Хашаан доторх сургуулийн эргэн тойрныг хармаар байвч биеэ барин тайван суухыг хичээв. Догдолсон сэтгэлээ дарахын тулд үсээ янзалж, хөлсөнд норсон цамцаа янзлан сууж байлаа. Хэдийгээр нар сургуулийн барилгын цаагуур орсон боловч өдрийн халуун буураагүй хэвээр. Ми Ран хооллохоор зоогийн газар руу явж буй эрчүүдийн сүүдрийг ажиглан сууна. Шинжлэх ухааны их сургуульд эрэгтэй эмэгтэй оюутнууд хамт суралцдаг гэх боловч үнэн хэрэгтээ эмэгтэйчүүдийн тоо маш цөөн. Эмэгтэй оюутнууд нөгөө талд нь тусдаа амьдардаг. Жижүүрийн өрөө рүү нэг оюутан толгойгоо цухуйлган "Тэр үнэхээр чиний дүү гэж үү? Найз залуу чинь биш биз" гэж саваагүйтэх сонсогдоно. Жун Саныг гарч ирэх үед нэлээд бүрэнхий болсон байлаа. Тэр дугуй унаж богино өмд, футболка өмсчээ. Өөрийг нь хүн эргэж эрнэ гэж огт бодоогүй нь илт. Ар талынх нь харуулын гэрэл асаатай болохоор Жун Саны нүүрний хөдөлгөөн сайн харагдаж байв. Шанааных нь ясны байдлаар инээж байна уу гэж Ми Ран таав. Жун Сан дугуйныхаа жолоон дээр гараа тавьсан хэвээр "Итгэмээргүй юм. Энэ үнэхээр чи гэж үү" хэмээн инээсээр угтав. "Ойрхон ирж таараад" гэж Ми Ран мөн инээсээр хариулжээ.

Ингээд х осууд сургуулиас холдон алхлаа. Жун Саны танил ч юм уу хамт сурдаг оюутнууд ч юмуу исгэрч шүгэлдсээр байсан ч тэр хоёр эргэж ч харсангүй. Өөрсдийнх нь талаар хов яриа Жун Саны, магадгүй Ми Раны ч эцэг эхэд хүрч мэдэх байсан ч энэ тухай бодох сөхөө байсангүй. Хэсэг алхсаны дараа Жун Сан дугуйгаа унаж, Ми Ран арын ачаан дээр нь сундлав. Ми Раны гарын нүцгэн хэсэг Жун Саны цээжинд үе үе хүрч байсан нь тэдний бие хамгийн ойр хүрэлцсэн анхны тохиолдол ажээ.

Жун Сан найз охиныхоо зориг зүрхтэйг гайхан шагшрав. Хамаатнуудаас нь нэг нь ч Пхеньянд ирэх зөвшөөрөл авч чадаагүй байхад, Ми Ран хүрээд ирж шүү дээ. Нэг оюутан ирээд эгч чинь гадаа хаалган дээр хүлээж байна гэхэд нь андуурч л гэж бодсон. Яаж ч уран зөгнөж, мөрөөдсөн Ми Раныг хүрээд ирнэ гэж төсөөлсөнгүй. Ми Ран чухам юугаараа түүнийг татаад байгааг ойлгох гэж хичнээн хичээгээд ч бардаггүй байсан бол харин одоо ухаарчээ. Энэ охин байнга л адал явдал, гэнэтийн бэлгээр дүүрэн байдаг юмсанж. Нэг бодлын дэндүү эмзэг, гэнэн, өөрөөс нь хамаагүй чадал муутай ч, нөгөө талаар ийм гэнэтийн зүйл хийх сэтгэлийн хүчтэй хүн аж. Тиймээс түүнийг дутуу үнэлж болохгүй гэж өөртөө үргэлж сануулж байв. Тэр орой мөчир доорх сандал дээр сууж байхдаа мөрөөр нь тэврэхэд татгалзаагүйд нь бас л гайхан алмайрчээ. Намар ирж байгаа болохоор шөнөдөө жихүүн учир Жун Сан охиныг дулаацуулахаар мөрөөр нь тэвэрсэн юм.

Гарыг нь авч хаях байх даа гэж бодож байтал огт тэгсэнгүй. Хамтдаа бие биеийнхээ илчинд тавтай нь аргагүй суусаар байлаа.

Залуус ам хуурайгүй ярьж, ярих зүйл дуусахаар босож алхаад л, хөл нь ядрахаар газар олж суусаар, шөнийг амархан барав. Энэ үед Пхеньянд хүртэл гудамжны гэрэл асахаа больж, айлуудын цонхоор гэрэл үзэгддэггүй болсон байлаа. Яг төрөлх тосгондоо байгаа юм шигээр харанхуйд нуугдан байлаа. Харанхуйд нүд дасаад ирэхэд хажууд байгаа хүмүүсийн дүрсийг л ялгах төдий болж, харин бусад хүни хөлийн чимээ, яриагаар нь, эсвэл тамхины галаар нь таньж байв. Хос хоёр хэн ч садаа болохгүй орчинд, өөрсдийн эрхээр сэтгэл амар байхын сайхныг дахин эдэлж суулаа.

Шөнө дунд өнгөрснөөс хойш Ми Раны ядарсан нь мэдэгдэж эхлэв. Замд аялж явахдаа сайн амарч чадаагүй учраас ядрахаас ч аргагүй байлаа. Жун Сан буудлын өрөө авах мөнгөтэй эсэхээ шалгаж халаасаа тэмтэрч үзэв.Өөр ямар нэгэн санаа агуулалгүйгээр "явахаасаа өмнө зочид буудалд орж, жаахан ч гэсэн нойр ав. Замын зөвшөөрөлгүйг чинь буудлын үйлчлэгч мэдэхгүй байх" гэж ятгатал Ми Ран огт зөвшөөрсөнгүй. Үгүй би харих ёстой гэж зүтгэв. Барих ёстой дүрэм журмаа хангалттай зөрчсөн учир буудалд хонож ахиад нэгийг зөрчих ямар ч хүсэлгүй байлаа. Тэд галт тэрэгний буудал руу дугуйгаа дундаа хийн алхацгаав.Хэдийгээр үүр хаяарах болоогүй ч буудал дээр олон хүн байна. Галт тэрэг хуваариараа явахаа больсноос хойш хүмүүс шөнөжин дугаарладаг зуршилтай болжээ. Буудлын ойролцоо нэгэн эмэгтэй том гээчийн тогоо тавьж, шар буурцгийн шошны шөл чанан зарахыг цугласан олон дуртай нь аргагүй худалдан авч иднэ. Жун Сан жигнэмэг, савтай ус өгсөн болохоор Ми Ран замын хүнсгүйдэх зовлонгоос айсангүй. Галт тэрэг ирмэгц сууж аваад нам унтлаа.

Гэртээ ирээд л Ми Раны хөөрсөн сэтгэл замхран алга болжээ. Пхеньянаас ирж очиход тохиолдох хүндрэл хайр сэтгэлийнх нь ирээдүйг бүрхэг болгочих шиг санагдуулав. Жун Сантай хэзээ дахин уулзахаа үл мэднэ. Жун Сан хичээл сургуультай завгүй байхад, Ми Ран эцэг эхтэйгээ амьдарч байдаг. Хойд Солонгос шиг ийм жижигхэн улсад Пхеньян саранд очих мэт хол санагдах нь гачлантай.

Ми Ран бас замдаа харсан, мэдэрсэн зүйлдээ шаналах болов. Чонжиноос холдож үзэлгүй хичнээн ч жил болсон юм. Гэтэл өөрийнх нь мужид хүртэл, шавь нар шиг нь, заримдаа бүр тэднээс жаахан, ноорхой хувцастай хүүхдүүд галт тэрэгний буудал дээр гуйлга гуйн зогсох нь өр өвдөм.

Намбод цонхны шилээ худалдаж авчихаад зочид буудалд хоноглох мөнгөгүй тул Ми Ран нөхөдтэйгөө галт тэрэгний буудал дээр, гадаа унтжээ. Буудлын өмнө талын жижигхэн цэцэрлэгт, өтгөн зүлгэн дээр хүмүүс картон цаас, хулдаас дэвсээд унтацгааж байлаа. Ми Ран хэвтрээ олох гээд нааш цааш хөрвөөж байтал хэдэн хүн босож зогсоод, хоорондоо шивнэлдэн модны дор цагираглан нам унтаж буй хүнийг заав гэнэ. Гэтэл тэр хүн унтсан биш амь тавьсан байжээ.

Хэсэг хугацааны дараа үхэр тэрэгтэй хүмүүс ирээд шарилыг тэргэнд ачлаа. Ми Ран шарилыг тэрэг рүү пид хийтэл шидэхийн өмнөхөн хальт харвал талийгаач дөнгөж өсвөр насны хүү байв. Цээжийг нь эхэлж тавьчихаад, хөлийг нь шидэх үед цамцных нь энгэр задгайрахад шөнийн

харанхуйд хавирганы нь хэрзийсэн яс тодоос тод харагдав. Түүн шиг туранхай бас үхсэн хүн харж байгаагүй болохоор Ми Ран эвгүйцэж унтахаар шургав.

Хөөрхий хөвгүүнд юу тохиолдсон байж таарах вэ? хэмээн Ми Ран бодолхийлэв. Арай өлсөж үхсэн юм биш байгаа? Тэр үед хүмүүс хүнсний гачаалд орж, төр засгаас хүртэл хүлээн зөвшөөрсөн боловч улс оронд нь хүн өлбөрч үхсэн талаар Ми Ран сонсоогүй байв. Африк, Хятадад ийм явдал гарч байсан. Мао Зе Дуны санаачилсан гайтай эдийн засгийн бодлогоос болоод 1950, 1960-аад онд хэдэн сая хүн өлсгөлөнгөөр үхсэн, харин бидэнд Ким Ир Сен удирдагч байгаа болохоор санаа зовох зүйлгүй гэж өөр хоорондоо ярьцгаана.

Хэдхэн цаг хамт байхдаа дэмий зүйл шалгаагаад яахав гээд юу болж буй талаар Жун Санаас асуугаагүйдээ Ми Ран харамсав. Гэтэл энэ аяллын дараа гэртээ ирчихээд урд нь санаанд нь ордоггүй байсан олон зүйлийг ажиглаж эхэлжээ. Анх цэцэрлэгт ирэхдээ хүүхдүүдийн давжаа биетэйг гайхдаг байсан бол цагийн зүүг урагшлуулсан юм шиг хүүхдүүд улам жижгэрсээр буйг олж харав. Доод хонгилд байгаа зуухыг галлаж өрөөнүүдийг дулаацуулахын тулд хүүхэд бүр цэцэрлэгтээ ирэхдээ нэг тэвэр мод авчрах ёстой. Гэтэл ихэнх нь модоо ч даахгүй. Нарийхан хэрзгэр хүзүүн дээр том толгой нь дэнжигнэж, Ми Раны гарт багтмаар нарийхан бэлхүүсний дээхнээс хэрзгэр хавирга нь цухуйна. Заримынх нь гэдэс хавагнаж эхлэв. Ми Ран Африкийн Сомалигийн өлсөж үхсэн, цэрдийсэн гэдэстэй хүүхдийн зураг харснаа санав. Хэдийгээр эмнэлгийн хэллэгийг санахгүй ч багшийн сургуулийн багш нарынх нь ярьснаар энэ цэрдгэр гэдэс уургийн хурц дутагдлаас үүсдэг болохыг мэдэж байлаа. Хүүхдүүдийнх нь хар үс өдөр өдрөөр шингэрч, өнгө нь хувиран улаан шаргал өнгөтэй болж байгааг Ми Ран бас анзаарлаа.

Хүнс байхгүй тул цэцэрлэгийн хоолны газар хаагдлаа. Хүүхэд бүр гэрээсээ идэх хоолоо авчрах ёстой болов. Нэг хоёр хоосон ирэхэд бусдынх нь хоолоос бага багаар тэдэнд өгдөг байсан ч хоол өгч явуулсан бусад эцэг эх гомдоллосноос хойш болив.Өөрсдөө ч идэж чадахгүй, хүүхдэдээ өгч явуулж байхад та бусдад хуваагаад байх юм гэж нэг ээж Ми Раныг зэмлэжээ.

Ми Ран цэцэрлэгт нь гадаадын нэг тусламжийн байгууллага жигнэмэг, хуурай сүү тараах гэж байна гэсэн яриа сонслоо. Бүгд их цэвэрлэгээ хийж, гадаах замаа засаж цэмцийтэл нь цэвэрлээд, гайгүй хувцасладаг хэдэн хүүхдээ үзүүлэхээр бэлтгэв. Гэтэл хүлээсэн тусламж ирсэнгүй. Оронд нь багш болгонд жижиг газар олгож, эрдэнэ шиш тарихыг тушаасан байна. Хурааж авсан эрдэнэ шишээ голоос нь салгаад попкорн маягийн юм болтол нь чанаж хүүхдүүдэд хоолны оронд өгч эхэллээ. Тэр нь хүүхдүүдийн өлсгөлөнг дарах боловч тэжээллэг чанар бараг үгүй байжээ.

Багш нар бүх хүүхдэд тэгш хандах ёстой. Гэвч Ми Ран нэг хүүхдэд илүү хайртай байжээ. Хью Рюн гэдэг урт сормуустай, том нүдтэй охин. Эхний үед хайр хүрэм, идэвхтэй, багшийнхаа хэлсэн үг бүрийг анхааралтай сонсдог хүүхэд байсан бол яваандаа үлбэгэр, нойрмог нэгэн болж хувирчээ. Охин заримдаа хичээл дээр унтаад өгөхөөр нь Ми Ран "сэрээрэй сэрээрэй" хэмээн дуудавч ч охин гараа дэрлэн унтсаар л байна. Нэг удаа тэгэхээр нь хоёр гарыг нь эрүүн доороос нь сугалж нүүрийг нь өөр рүүгээ харуултал охины нүд хавдсан зовхиныхоо доороос харагдахтай үгүйтэй байжээ. Гарт баригдсан үс нь хатуу, хүрэхэд эвгүй болсон байлаа.

Хэдэн өдрийн дараа охин ирэхээ болив. Гэр нь ойрхон байдаг учир юу болсныг асуухаар орьё уу гэснээ болив. Тэртэй тэргүй ойлгомжтой байхад юу ч асууж орох юм билээ. Тус болж чадахгүй юм чинь.

Ангийнх нь олон хүүхэд үүнтэй төстэй байдалд орлоо. Хичээл зааж байхад суудал дээрээ тогтохгүй унаад өгнө. Гайгүй шиг нь гадаа тоглож байхад тэдгээр хүүхдийн зарим нь ширээ дэрлээд, зарим нь гудсан дээр тэрийн хэвтэцгээх боллоо.

Эхлээд эцэг эх нь нормтой түлээгээ өгч чадахаа болино. Дараа нь өгч явуулдаг хоолыг нь дийлэхээ болино. Удалгүй хүүхэд хичээлд оролцохоо больж, ширээ дэрлэн унтах бөгөөд эцэст нь хичээлд ирэхээ зогсдог ийм л дараалалтай болсон байв. Гурван жилийн дараа тавин хүүхэдтэй байсан анги арван таван хүүхэдтэй л үлдсэн юм.

Тэр хүүхдүүдийг яасан бол гэж Ми Ран бодохоос ч айна.

Ми Ран найз залуутайгаа, дараагийн өвөл нь уулзав. Энэ удаад Жун Сан түүнд гэнэтийн бэлэг барихаар шийдсэн байлаа. Өвлийн амралтаараа ирээд гэрт нь очиж аав ээжтэй нь нүүр тулахаас эмээн шууд цэцэрлэг дээр нь очив. Ажил нь дууссан боловч Ми Ран ангиа цэвэрлэн, яваагүй байж таарлаа.

Ангид томчуудын сандал үгүй учир хайртай шавийнхаа сандал дээр биеэ эвхэж суугаад юу болж байгаа талаар Жун Санд ярьж өгөв. "Чи юу хийж чадах юм бэ? Энэ хүмүүст эзэн хаан ч тусалж чадахгүй. Битгий бүгдийг ийм эмзэг хүлээж ав л даа" гэж Жун Сан найз охиноо тайтгаруулахыг оролдов.

Тэдний яриа нэг л урагшилсангүй. Хэн хэн нь өлсөхийн зовлонг мэдрэлгүй амьдарч байлаа. Жун Саны аав гэрийнхээ арын талбайд тарьж чадаагүй бүхнээ Японоос ирсэн мөнгөөр хар захаас худалдаад авчихна. Өлсгөлөнгийн энэ үед нийгмийн гарал тийм ч хурц асуудал биш болсон учир Ми Раны хайртай эгч сайн айлын бэр болсон, нөхөр нь цэргийн хүн учраас танил талаараа дамжуулан тэднийд тусалж дөнгөөд байлаа. Цахилгаангүй болсноос хойш дуураймал зайрмагаа хийхээ больсон ч Ми Раны ээж зүгээр суулгүй гахай тэжээх, дүпү хийх, эрдэнэ шиш тээрэмдэх зэргээр байнга л нэг зүйл санаачилж мөнгө олох ажлаа үргэлжлүүлсээр.

Арваад жилийн дараа Ми Ран өөрөө ээж болж, жирэмслэлтээс нэмсэн жингээ хасахаар аэробикээр хичээллэж байхдаа сэтгэл нь маш их хөндүүрлэдэг болжээ. Өөрөө гэртээ тийм сайхан хооллочихоод, турж үхэх шахаж байсан хүүхдүүдийн төлөө юу ч хийгээгүйдээ гутарна.

Нэг үхэл эмгэнэл байдаг бол зуу хүрэхээрээ тоо баримт болон хувирдаг нь батлагдсан зүйл. Ми Раны хувьд ч тийм байжээ. Тэр гагцхүү энэ нь эдийн засгийн хямралын хүнд үед өөрийнх нь амьд гарах цор ганц арга байсныг л ойлгоогүй юм. 90-ээд оныг амьд давахын тулд хүн бүхэн бусадтай хоолоо хуваалцах сайхан сэтгэлээ гээж, сэтгэцийн өвчтэй болохгүйн тулд өрөөлд санаа тавихаа больсон юм. Яваандаа Ми Ран гудамжаар дүүрэн хэвтэх шарилуудын дэргэдүүр сэтгэл хөндүүрлэхгүйгээр алхдаг болсон. Таван настай хүүхэд өлсөж үхэхийн даваан дээр хэвтэж байхад

туслах сэтгэлгүйгээр өнгөрч дассан байлаа.Хайртай шавьдаа хоолноосоо илүүчлээгүй юм чинь огт танихгүй хүүхдэд туслахгүй нь ойлгомжтой биз ээ.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

САЙН НЬ ТҮРҮҮЛЖ ҮХДЭГ

Коммунист дэглэмтэй орнуудад төр засаг хүмүүсээ бэлэнчлэх сэтгэлгээнд сургасан байдаг. Гэтэл өлсгөлөнгийн үеэр Хойд Солонгосын олон иргэн энэхүү сэтгэлгээнээсээ гарч, өөрсдийнхөө төлөө тэмцэх болсон билээ. Хүмүүс үхлээ хүлээн дэмий хэвтсэнгүй. Төр засгаас олгодог байсан хүнсний хангалт зогсоход, голоо зогоохын тулд хамаг оюун бодлоо шавхаж, төрөл бүрийн санаачлага гаргах болов. Хувингаар хавхархуу юм хийж хээрээс жижиг амьтан урхихах, тагтан дээрээ тор тавьж бор шувуу барихыг хичээнэ. Өвс ургамлын тэжээллэг чанарыг судалж эхлэв. Эцэг өвгөд нь өлсгөлөнгийн үеэр ямар арга хэрэглэн амьд гарч байсныг хоорондоо ярилцан, олж мэдсэнээ амьдралд хэрэгжүүлж эхэллээ. Нарс модны холтос дотор байдаг чихэрлэг хальсыг авч нүдэн, гурилын оронд идэхээр оролдов. Царсны боргоцойн самрыг няцлан аман дотор оронгуутаа хайлдаг цэлцгэнүүр болгоно.

Ичих нэрэлхэхээ умартан, малын гэдсэнд нь шингээгүй гарсан эрдэнэ шишийн үрийг ялгадаснаас нь түүх, усан онгоцны үйлдвэрийн ажилчид хүнс хадгалдаг савны ёроолыг хуурайдан цоолж, өмхий үнэртэй тос шалан дээр нь асган хатааж, дээр нь асгарсан будааны үртсийг түүх зэргээр, нэг үгээр, идэж болох бүх зүйлийг цуглуулах аргад суралцан амиа зогоож сурав.

Далайн эргээс хүмүүс элс ухан дун түүж, хувин хувингаар далайн замаг зөөвөрлөх болов. Гэтэл удалгүй тагнуулчдаас сэргийлэх нэрээр, 1995 онд засаг захиргаанаас далайн эргийн дагуу хашаа барьсан байна. Энэ нь үнэн хэрэгтээ өлссөн иргэдийг загас барихаас сэргийлсэн хэрэг. Тэгэхээр нь хүмүүс харуул хамгаалалтгүй хад цохионоос олсоор дүүжлэгдэн далайн замаг түүж эхэлжээ.

Юу хийж, хэрхэн амь зогоох талаар хүмүүс төр засгийн заавар хүлээсэнгүй. Төр засаг ч улс орон нь хүнсний гүн хямралд орсныг гүйцэд хүлээн зөвшөөрөхийг хүссэнгүй, эрх мэдэлтнүүд амиа л хоохойлохыг хичээж байв. Эрдэнэ шишийн гурил хийхдээ хальс, гол, үр, үндэс гээд юуг нь ч хаялгүй хамт тээрэмддэг болов. Хэдий эдгээр нь тэжээллэг чанар байхгүй ч гэлээ хүнсийг арвижуулна. Гоймонг идэнгитэй болгохын тулд хамгийн багадаа нэг цаг чанах хэрэгтэй. Шөлөндөө модны навч, өвс хийвэл ногоотой мэт харагдана, нарсны хальсаар хийсэн нунтгаар бялуу хийж болно гэхчилэн бүсгүйчүүд хоолны орцны талаарх мэдлэгээ хуваалцаж байв.

Хүмүүс юуг, хэрхэн идэх юм болгох талаар ухаан бодлоо уралдуулж гарлаа. Эрт босоод арай гэж өглөөний хоол олж идэнгүүтээ оройн хоол хэрхэн олох талаар тархиа гашилгаж эхэлнэ. Өдрийн хоол гэдэг зүйл өнгөрсөн үеийн сайхан дурсамж болон үлджээ. Өглөөний хоолноос авсан илчлэгээ хадгалахын тулд өдрийн хоолны цагийг унтаж өнгөрүүлнэ.

Хүмүүс бүх чадлаараа ийн хичээсэн ч өлсгөлөн даамжирсаар л байлаа.

Хувцасны үйлдвэр хаалгаа барьсны дараа хатагтай Сонг юу хийхээ сайн мэдэхгүй уймарч эхлэв. Социалист нийгмийн үлгэр жишээ иргэн тэрбээр капитализмыг санагдуулсан бүхнийг үзэн

ядсан хэвээр. Хайрт удирдагч Ким Ир Сен "Социалист нийгмийн иргэн бүр капитализм болон шинэчлэлийн хортой үзэл санаанаас улс үндэстнээ хамгаалах ёстой" хэмээн сургасан учир түүнийг нь давтан хэлж, хэлбэрэлтгүй даган мөрдөнө.

Ким Ир Сенийг нас барснаас хойш гэр бүлд нь цалин авдаг хүн үлдсэнгүй. Намын гишүүн, улсын радиод нэр хүндтэй алба хашдаг нөхөр нь ч ялгаагүй. Сэтгүүлчдэд байнга олддог тамхи, архи ч Чан Бо авчрахаа болилоо. Хатагтай Сонг эцэст нь эргэлзээгээ орхиж, хоол хүнс олох арга хайх хэрэгтэйг ойлгов. Гэвч яаж?

Хатагтай Сонгод наймаа эрхлэх ямар ч авьяас байхгүй. Тавин нас хүрсэн атлаа сампинд хэдэн тоо нааш цааш хийхээс өөр чадах зүйл үгүй. Энэ бодлоо гэрийнхэнтэйгээ хуваалцахад, хоол хийх авьяасынх нь талаар сануулжээ. Цагийн сайханд хатагтай Сонг материал нь олдож л байвал амттай хоол хийж, гэр бүлийнхнээ дайлах дуртай байж. Энэ нь ч нөхөрт нь таалагдаж амтархан иддэг байжээ. Тэд гадаадаас хоолны жор суралцана гэж байхгүй болохоор өөрийнхөө мэддэг болон уламжлалт аргуудыг л эргэлдүүлнэ. Гэхдээ Хойд Солонгосын хоолны жор бас ч чамлахаар биш. Өмнөд Солонгосын рестораны эздээс цөөнгүй нь Хойд нутгаас гаралтай байдаг юм билээ. Тогооч нар их бүтээлч, нарсны мөөг, далайн замгаар гайхалтай сайхан хоол бэлдэнэ. Тухайн улиралдаа элбэг байдаг ногоог цагаан будаа, арвай, эрдэнэ шиштэй холин улаан шош, чинжүүгээр амтална. Үндэсний хамгийн нандин зоог нь сагадын хүйтэн гоймонд жантай шөл дагалдуулдаг Пхеньян нэнгмён нэртэй хоол юм. Тухайн нутгийн заншлаас шалтгаалан өндөг, өргөст хэмх, лийр нэмж болно. Хатагтай Сонг энэ хоолыг хийхдээ гоймонг нь дэлгүүрээс худалдан авдаг, завтай бол өөрөө гурил зуурдаг байжээ. Улсаас өгдөг хэдхэн төрлийн материалд тохируулан заримдаа твигим гэдэг шаржигнуур ногоо хийдэг байж. Нөхрийнхөө төрсөн өдрөөр цагаан будаагаар дөк хэмээх боов хийсэн байна. Өөрөө гэртээ архи нэрчихнэ. Охид нь ээжийнхээ дарсан кимчиг хавийн айлуудаас хамгийн амттай нь гэж магтдаг байлаа.

Гэрийнхэн нь хатагтай Сонгийг авьяасаа ашиглаад хоолны бизнес хий хэмээн ятгаж эхлэв. Хүмүүс өлсөж зовж буй энэ хүнд үед хамгийн зөв арга бол тэжээллэг чанар сайтай дүпү хийх явдал гэж тэд санал болгов. Солонгосчууд дүпүг хоол хүнсэндээ өргөн хэрэглэдэг учраас зарагдахгүй байхын зовлонгүй гэлцэнэ. Дүпүг загасны оронд эсвэл, улаан чинжүүгээр амтлан шарж, дангаар нь зарж болно. Шар буурцаг авч бизнесээ эхлэхийн тулд гэртээ байгаа үнэд хүрэх зүйлээсээ зарж эхлэв. Энэ аянд хамгийн түрүүнд өртсөн зүйл бол Чанг Богийн, Солонгосын дайны үед тагнуул байсан аавынх нь гавьяагаар олж авсан зурагт.

Дүпү хийх нь хялбархан боловч их хөдөлмөр орно. Шар буурцгийг сайтар нухсаны дараа өтгөрүүлэх бодис нэмнэ. Дараа нь нимгэн материалд боож, бяслагтай адил усыг нь шахаж гаргана. Тэгээд усархаг сүү, бас шар буурцагны хальс үлдэнэ. Хатагтай Сонг гахай худалдаж авбал энэ үлдэгдлээр тэжээж болох юм байна гэж боджээ. Байрных нь ар талд юм хадгалах зориулалттай пингүүд байдаг. Хатагтай Сонг зах дээрээс гахайн тооройнд зориулсан сүрлэн хэвтэр авч пиндээ хийж цоожлов.

Эхний хэдэн сар бизнес нь овоо урагштай явж байлаа. Хатагтай Сонг жижигхэн гал тогооны өрөөгөө дүпүний үйлдвэр болгон хувиргаж, пийшин дээрээ шар буурцагны том торх тавьсан байв.

Чанг бо хийсэн жорыг нь уншиж батлах үүрэгтэй. Гахайн тоорой авч шар буурцагны сүү, хальс, мөн зарим бололцоотой үедээ өвсөөр тэжээсэн нь амжилттай болж тооройнууд нь томорсоор байв. Гэвч өдөр ирэх тусам түлээ нүүрс олдох нь хэцүү болсоор байлаа. Цахилгаан долоо хоногт хэдхэн өдөр л ирэхдээ дээд тал нь 60 лааны ганц гэрэл, зурагт, радио асаахад л хүрэлцэх төдий.

Түлээгүйдээд дүпүгээ ч хийж чадахаа болив. Дүпү хийхгүй болохоор гахайгаа тэжээж чадахгүйд хүрлээ. Дан өвсөөр тэжээе гэвэл гараар өвс түүхэд маш их хугацаа шаардагдана.

Хатагтай Сонг нэг өдөр нөхөртөө бид өөрсдөө бас өвс идвэл яасан юм бэ гэв. Эхэндээ тоглоомоор хэлсэн ч сүүлдээ жаахан бодсоноо гахай хордохгүй байгаа юм чинь бид ч гэсэн яах ч үгүй хэмээн нэмэв.

Ингээд энэ гэр бүлийн хувьд шинэ дэглэм эхэллээ. Хатагтай Сонг хотын төвөөс хойш, урагш алхан идэж болох ногоонуудыг түүж гэртээ авчирна. Хэрэв уул руу явбал багваахай цэцэг мэтийн цаг сайхан байхад хүртэл хүмүүс хоолондоо хэрэглэдэг байсан амттай ургамлууд ургадаг л гэх. Хатагтай Сонг хааяа ногоочдын огтолж хаясан байцааны илжирсэн навч олно. Хээрээс олсон бүхнээ нийлүүлэн, дээр нь багахан мөнгөөр хар зах дээрээс авсан эрдэнэ шишийн гурилаа нэмээд хоол болгон идэх болов. Хэрэв эрдэнэ шишийн гурил авч хүчрэхгүй бол нарсны хальсаар хийсэн гурилыг нь авна.

Хэрэв хоол хийх авьяасгүйсан бол хоол гэж нэрлэгдэх энэ элдэв зүйлийн холимогийг хэн ч идэхээргүй байлаа. Харин хатагтай Сонг сайтар нухаж, няцалж, нүдэж хүний гэдсэнд шингэхэд хялбар болгоно. Мөн боловсруулсан зүйлээ хэвэнд оруулахад хэрэглэгддэг бодисууд байхгүй болохоор зүгээр л зутан төдий зүйл болно. Цорын ганц амтлагч нь давс. Бага зэргийн сармис, улаан чинжүү амтыг нь арай дээр болгох ч үнээс нь болоод авч чадахгүй. Ямар ч тос олдохгүй болохоор хоол хийх бас амар биш. Нэг удаа хатагтай Сонг эгчийнхээ хадам эгчийнд зочилж очоод эрдэнэ шишийн гол болон шошоор хийсэн зутан өгөхөөр нь идэх гэтэл цааш орсонгүй. Эрдэнэ шишийн гол нь хуурай, гашуун болохоор хоолой дээр нь тээглэчихээд явж өгөхгүй, хажууд байгаа хүмүүсээсээ үхтлээ ичжээ.

Ким Ир Сенийг нас барсан жил идсэн цорын ганц амьтны мах нь мэлхий байв. Ах нар нь хөдөөнөөс мэлхийн мах явуулдаг байжээ. Хатагтай Сонгийн хадам эгч мэлхийн махыг шар буурцгийн сүмсээр амтлан шарж, гоймонтой холиод өгөхөд үгээр хэлэхийн аргагүй амттай байж билээ хэмээн хатагтай Сонг дурсан ярьсан. Солонгосчууд мэлхийн мах хэрэглэдэггүй учир хатагтай Сонг өмнө нь амсаж ч үзээгүй байж. 1995 онд их хэмжээгээр барьснаас болж Хойд Солонгост мэлхий утсан тул хатагтай Сонг түүнээс хойш дахин идсэнгүй.

1995 оны дунд үе гэхэд хатагтай Сонгийнх гэртээ байсан үнэтэй болгоныг зарж дуусгажээ. Зурагтаа зарсны дараа, гэрийнхээ цорын ганц тээврийн хэрэгсэл байсан унадаг дугуй, хувцсаа хийж өмсдөг оёдлын машин гээд л цувраад үгүй болов. Чанг Богийн цаг, хуримаар нь бэлэглэсэн дорнын уран зураг ч зарагдав. Ихэнх хувцас, модон шүүгээгээ ч зарав. Нэгэн үе их давчуу санагддаг байсан хоёр өрөө байр хоосорч, ханан дээр нь агуу удирдагчдын зураг л өлгөөстэй байдаг боллоо. Одоо байраа л зарахгүй бол өөр юу ч үлдсэнгүй.

Хойд Солонгост хүмүүс амьдарч буй байраа эзэмших эрхгүй. Гэвч үл хөдлөх хөрөнгийн хууль бус зах зээл аль хэдийн бий болж иргэд албаны хүмүүсийг хахуульдаж байгаад байраа наймаалж эхэлжээ. Хатагтай Сонг нөхөр нь Орост ажиллаж, байраа сайжруулахаар мөнгө явуулсан нэгэн эмэгтэйг таньдаг байв. Хатагтай Сонгийн байр хотын төвд, байрлал маш сайтай. Нийтийн тээврийн хэрэгсэл явахаа больсон энэ үед байрлал маш чухал байжээ. Тэднийх энд хорин жил амьдарч, олон сайхан найз нөхөдтэй болсон ба эзэгтэй олон жил хорьтын дарга хийхдээ нэг ч дайсан өөртөө бий болгоогүй юм. Бидэнд ийм том байр хэрэггүй, багасгасан нь дээр хэмээн ярилцаад зарахаар болов. Охид нь бүгд нөхөрт гарч, ганц хүү нь өөрөөсөө эгч бүсгүйтэй амьдрах болсон учир хатагтай Сонг, нөхөр Чанг Бо болон хадам эх гурвуулаа үлдсэн байв. Хүүгээ өөрөөсөө эгч хүүхэнтэй амьдрах болсоныг гутамшиг гэж хатагтай Сонг бодож байсан авч нэг ч гэсэн хүн тэжээхгүй, одоохондоо сайн л байна гэж санааширчээ.

Байраа 10,000 вон буюу 3000 орчим доллараар зарж, нэг өрөө байранд нүүж орлоо. Зөрүү мөнгөөрөө цагаан будааны бизнес эрхлэхээр шийдэв.

Цагаан будаа Солонгосчуудын хувьд хоолны хольц төдийгүй дангаараа ч хоол болдог. 1995 оноос хойш Чонжины оршин суугчид будааг зөвхөн өндөр үнээр хар зах дээрээс л авах болсон байв. Хойд Хамёнг муж будаа тариалахад тохиромжгүй уур амьсгалтай, бас уулархаг. Тийм болохоор хотын иргэдийн хэрэгцээт будааг өөр мужаас машин болон төмөр замаар тээвэрлэдгээс шалтгаалж будааны үнэ өндөр байдаг. Хатагтай Сонг хямд газраас будаа авч галт тэргээр нутаг руугаа зөөх төлөвлөгөөтэй байв. Будаа, бүх төрлийн үр тариа зарах нь дээд зэргийн хууль бус үйлдэлд тооцогдогддог ч хүн болгон хийгээд байхаар нь хатагтай Сонг ч гэсэн үзээд алдахаар шийдлээ. Будаагаа зарж бага зэргийн ашиг олохоос гадна өөрсдөдөө ч гэсэн илүүчилж дөнгөх байх хэмээн найдна. Ингэж бодохоор хар шүлс нь аяндаа асгарч байлаа. 1994 оноос хойш тэд олигтой аяга будаа идээгүй билээ.

Хатагтай Сонг 10,000 воноо дотуур хувцсандаа далдлан нуулаа. Өмнөд Пёнганг мужид очиж 200 кг цагаан будаа худалдан авав. 1995 оны 11 сарын 25. Суудлынхаа доор хагас шуудай будаа хийгээд галт тэргэнд суун харих дөхсөн үе. Чанг Богийн танил талаар дамжуулж, гурав дахь зэрэглэлийн галт тэргэнд унтдаг тасалгаа авч чадсан байна. Эхний хоёр зэрэглэлийнх нь намын гишүүд, цэргийн албан хаагчдад зориулагдана. Галт тэрэг урт учир эргэлт хийх үед цонхоор харахад сүүлийн вагонуудын зорчигчид зогсоогоороо яваа харагдана. Зогсохоос гадна хөл гишгэх зайгүй чихцэлдэнэ. Зарим нь галт тэрэгний дээвэр дээр ч явах нь цөөнгүй. Өглөө найман цаг гучин хормын алдад сэрж орноосоо буюгаад хамт аялагсадтайгаа ганц хоёр үг сольж байтал гэнэт галт тэрэг савлаж хатагтай Сонгийг авч шал руу шидлээ. Галт тэрэг хажуугаараа унаснаас болж хатагтай Сонг шалан дээр биш цонхны төмөр хүрээг хацраараа дэрлэн унасан байжээ.

Хүмүүс хашгиралдан аврал эрцгээж байв. Галт тэрэг зүгээр л бөөн төмөр болсон харагдана. Олон хүнтэй явж байсан галт тэрэг онхолдож, ихэнх зорчигч нь үрэгджээ. Азаар эхний хэдэн вагон арай гайгүй гарчээ. Синпогийн ойролцоо болсон энэ ослын үеэр 700 гаруй хүн үрэгдсэн гэж шуугицгааж байсан боловч уламжлал ёсоор албан ёсны мэдээлэл цацагдсангүй, нуун дарагдуулаад өнгөрөв.

Хатагтай Сонг хацартаа гүн шархтай, хөлийнх нь арьс хуурч, нурууны холбогч эдийн гэмтэлтэй ч ослоос амьд гарсан байна. Ослын дараа дөрөв хоноод хатагтай Сонг Чонжинд буцаж ирлээ. Тэр өөрийгөө азтай хүн гэж үргэлж боддог билээ. Ким Ир Сений хайран дор төрж өссөн, сайхан гэр бүлтэй болсон, тэгээд галт тэрэгний гамшигт ослоос амьд гарлаа. Тэгэхээр өөрийгөө азтай гэж бодох эрхтэй. Хатагтай Сонг галт тэрэгнээс өргүүлж буухдаа шүд зуун өвчнөө тэвчиж байв. Галт тэрэгний буудлын тавцан дээр зогсож буй нөхөр хүү хоёроо хараад амьд үлдсэнээ бурханы ивээл хэмээн дахин хязгааргүй их баярлажээ. Будааных нь ихэнх нь байхгүй болсонд ч тэгтлээ харамссангүй. Гэмтэл нь өөрийнх нь төсөөлснөөс хамаагүй хүнд байв. Сэтгэл хөдлөлийн үе дууссаны дараа асар хүнд гэмтсэнээ тэр олж мэджээ. Эмч үзээд өвчин намдаах эм өгч гурван сар орноосоо босохгүй байхыг зөвлөсөн ч зөвлөгөөг нь дагаж чадсангүй. Түүнийг хэвтчихээр хэн хоол олох билээ?

Өлсгөлөнгийн үед хүмүүс шууд турж үхдэггүй ажээ. Эхлээд ямар нэгэн хүнд өвчин хүрдэг. Хүнс тэжээлийн дутагдал биеийн дархлааг муутгаж, өлсгөлөн хүмүүс сүрьеэ, гэдэсний хижиг тусах нь ихэснэ. Тэжээлээр дутсан бие махбодь антибиотик байсан ч хүлээж авах чадалгүй болж, ердийн өвчнүүд гэнэт эмчлэгдэхээргүй болон хүндэрч байлаа. Хоол тэжээлийн чанар өөрчлөгдөхөөр бие махбодь ч даган өөрчлөгдөж, цус харвалт, зүрхний шигдээс зэрэг өвчин улам түгээмэл болж байв.

Өлсгөлөн хэмээх үхлийн элч таваас доош насны хүүхдүүдийг авч эхлэв. Хүүхдүүд эхлээд ханиадтай ирээд удалгүй хатгаа болон хүндэрч, гэдэсний өвчин төд удалгүй цусан суулга болон хувирч байлаа. Эцэг эх нь тусламж эрэх сөхөө ч үгүй байхад л хүүхэд нь өнгөрөөд өгнө. Удалгүй үхлийн элч далаас дээш насныхныг хараалж улмаар жар, тавьтангууд руу давшив. Тэд тэртэй тэргүй хорвоогоос явах нь ойртсон, гэхдээ ийм ч хурдан биш сэн. Удаах бай нь эрчүүд болов. Эрчүүд биед нь өөхний нөөц үгүй, туранхайгаас болоод үхэлд олноор өртөж байлаа. Метаболизм нь илүү илчлэг зарцуулах учир булчин шөрмөстэй чийргүүд нь сулбагаруудаасаа түрүүлэн явцгааж байлаа. Хамгийн хэрцгий нь үхлийн элч хоол хүнс хулгайлдаггүй, худлаа ярьж, хууль зөрчиж, нөхрөө худалддаггүй номхон хүлцэнгүйчүүдийг нь түрүүлэн авч одно. Аушвицийн лагериас гарч ирснийхээ дараа Италийн зохиолч Примо Леви "Хорих лагераас гарч ирснийхээ дараа амьд үлдэгсэд ахин бие биетэйгээ уулзахыг хүсээгүй. Амьд үлдэхийн тулд хийсэн бүхэн нь ахин тэднийг бие биеэ харах хүсэлгүй болгосон" хэмээн дурссан байдаг.

Арван жилийн дараа эргээд дурсахад сайхан сэтгэлтэй, жирийн, хүний хэлснээр л байдаг хүмүүс нь түрүүлж үрэгдсэн байж билээ хэмээн хатагтай Сонг хүүрнэсэн юм.

Хатагтай Сонгийн гэр бүлийн хувьд хадам ээж нь хамгийн түрүүнд одсон билээ. Чанг Богийн ээж хүүгээ гэрлэсний дараа удалгүй хамт амьдрахаар тэднийд нүүж иржээ. Солонгосын ёсонд ууган хүү нь эцэг эхээ харж хандах үүрэг хүлээдэг ч үнэн хэрэгтээ бэр л бүхнийг хийдэг аж. Иймээс Солонгос эмэгтэйчүүд хадам эхтэйгээ сайн харилцаатай байдаггүй нь ойлгомжтой. Хатагтай Сонгийн хадам эх гэрлэснийх нь дараах хэдэн жил түүнд амар заяа үзүүлдэггүй нэгэн байжээ. Ялангуяа гурван охин дараалан төрүүлээд байсан үед нь байнга өөчилж зовооно. Харин тэднийд бага хүү мэндэлсний дараа ааш аяг нь арай зөөлөрчээ. Хатагтай Сонг үүргээ чин

үнэнчээр биелүүлж, хадам эхийгээ өргөн тэтгэсээр өнгөрүүлсэн билээ.

Намар хураасан ургацынхаа нөөцийг дуусаж, тариалалтын нөр их ажил өрнөдөг учраас хавар, хатуу хахирган улиралд тооцогдоно. Энэ хавар хатагтай Сонг зургаан сарын өмнөх галт тэрэгний ослоос олсон гэмтэл нь бүрэн эдгээгүй байсан учраас урд өмнөхөөсөө хүнд үеийг туулав. Хадам эх нь 73 настай бөгөөд Хойд Солонгосын эмэгтэйчүүдийн дундаж наслалтын хувьд харьцангуй өндөрт тооцогдох тул зохих насаа насалсан хэмээн үзэж болох ажээ. Хэрвээ хоол унд хүрэлцээтэй байсан бол хөөрхий эмээ бүр ч олон жил амьдрах байсан даа гэж хатагтай Сонг харамсангуй бодно. Ажил хийж, уул руу явж чадахгүй учраас хатагтай Сонг гэрийнх нь ойр орчимд байх идэж болох бүх л төрлийн өвс ургамлыг шөлөндөө холих болов. Хадам ээж нь яс арьс болж, нүдийг нь тойроод яршиж эхлэв. 1996 оны тавдугаар сард тэр цусан суулга тусаж, хэд хоногийн дараа өөд болжээ.

Хатагтай Сонг хадам ээжийнхээ хойноос гашуудаж дуусаагүй байтал, намрын үзэл суртлын кампанит ажил нэрмэв. Зурагт хуудсууд дээр нэгэн эр чанга яригч барин ард түмнийг шинэ зуунд шилдэг бүтээлтэй орохын тулд түр зуурын хүндрэлийг хамтын хөдөлмөрөөр туулъя хэмээн уриалах ба түүнийг дуулгатай цэрэг, зээтүү барьсан уурхайчин, нүдний шил зүүж төлөвлөгөө бүхий хавтас барьсан эрдэмтэн, толгойдоо алчуур зангидсан уурхайчин, улаан туг барьсан генерал зэрэг хүмүүс дагалдсан байна. Албан ёсны мэдээллээр Ким Чен Ир хүртэл жирийн төмстэй хоол идэж байна хэмээн мэдээлнэ.

Гэртээ нөхөртэйгээ хоёулхнаа үлдсэн хатагтай Сонг ахиад байраа багасгахаар шийдлээ. Энэ нь овоохойноос арай том, цементэн шалтай, хана нь хадаас даахааргүй оромж байсан учир хатагтай Сонг хоёр удирдагчийнхаа зургийг өлгөж төвдсөнгүй. Зургуудыг нямбайлан ороогоод далд хийв. Тэдэнд цөөхөн эд хогшил үлдсэн байлаа. Агуу их удирдагчийн зохиосон номуудаас бусад Чанг Богийн гэх бүх номыг зарж дуусчээ. Өөрийн хамгийн хайртай эд болох кимчи дардаг ваараа хүртэл аль хэдийн зараад идсэн байж. Тэдэнд хос савх, хэдэн аяга, хоёр халбаганаас өөр юм бараг үлдсэнгүй.

Чанг Бо мужийн радио станциас гарч төмөр замын хэвлэлийн албанд ажилд орсон ч цалин гэхээр юм авсан удаагүй. Төмөр замынхан хүнсний хангалт ирвэл хамгийн түрүүнд түүнд өгөхөөр амласан боловч тэр хангалт огт ирсэнгүй. Хатагтай Сонг, Чанг Бо хоёр байрныхаа зөрүүнээс олсон мөнгөө идээд дуусав. Хааяа том охин Ок Хи нь гэрээсээ ганц нэг шуудай эрдэнэ шиш авчирч өгөх боловч нөхөртөө баригдахаас айгаад тэр бүр чадахгүй. Муухай ааштай нөхөр нь мэдвэл хүнс хулгайллаа гээд хэвтгэл нь ч зодож мэднэ. Хэдийгээр мөнгөтэй, идэх уух юмтай ч гэсэн хадмуудтайгаа хуваалцахыг үл хүснэ.

Хатагтай Сонг уул руу явж чадахгүй болсон ч эрт босдог хэвээр. Өглөө эхлээд зургаан цагт босдог байснаа сүүлдээ тавд босдог болж, шөнөдөө соёолсон байж мэдэх ногооны эрэлд гарна. Тэгээд олсон өвсөө зөөлөртөл нь чанаад зутан маягийн юм хийж, дээрээс нь хэдэн халбага эрдэнэ шишийн гурил нэмээд л иднэ. Хоолоо идэж дуусангуутаа хувцсаа ч тайлалгүй газар дэвссэн гудас шиг юман дээрээ өнхрөөд л хурхирч гарна. Өглөө ахиад хоолны эрэлд гарах ёстой тул тогтсон цагтаа л сэрдэг зуршилтай болжээ. Өөр юу ч сонирхохоо больж, бүр үсээ ч самнахаа байж,

хувцсаа угаах тухай бодохоос ч дургүй нь хүрнэ. Хатагтай Сонг турж, үлдсэн ганц өмд нь арай гэж ташаан дээр нь тогтох болсон байлаа. Унтаж байхдаа өөрийгөө үхсэн мэт санаж, сүнс нь бие дээгүүр нь тэнүүчилж, дээрээс нь харж байна хэмээн зүүдэлнэ.

Чанг Богийн эрүүл мэнд ч их муудаж байлаа. Солонгос хүн гэхэд их том биетэй, заримдаа таргалж, 90 кг хүрч байсан үе түүнд бий. Таргалаад байхаар нь эмч нар тамхи татаж жин хаяхыг хүртэл зөвлөж байсан удаатай. Харин одоо бол нэг хэсэг түүний бахархал байсан цүндгэр гэдэс нь юу ч үгүй шалчийж, арьс нь хуурайшин, биеэр нь харшил гарч эхэллээ. Эрүүнийх нь арьс унжиж, ярихдаа ээрч муурах болов. Хатагтай Сонг нөхрөө Төмөр замын эмнэлэгт үзүүлтэл, тал цус харвасан онош тавьжээ. Чанг Бо төвлөрөхөө байж, нүд нь бүрэлзээд үзгээ ч барьж чадахгүй болсон учраас ажиллахаа болив.

Чанг Бо өдрийн туршид шалнаа дэвссэн гудсан дээрээ хэвтэх болж, хөл нь хөөж хавагнав. Хүүхэд байхад нь хийж өгдөг асан ээжийнх нь гарын дүпү, дөнгөж гэрлэснийхээ дараа эхнэрийнх нь хийж өгдөг асан цагаан гаагаар амталсан жигнэсэн хавчны мах ямар амттай байж вэ гэх зэргээр үргэлж хоол ярих болов. Тэр арваад жилийн өмнө эхнэрийнхээ хийж өгдөг байсан хоолны орц бүрийг маш тодорхой санана. Чанг Бо хоолны тухай ярихдаа мөрөөдөмтгий жаахан хүүхэд шиг болно. Эхнэрийнхээ гарыг атгаад хамт өнгөрүүлсэн сайхан дурсамжаасаа ярина.

Нэгэн өглөө "хань минь хоёулаа ресторан орж улаан дарс уух уу?" хэмээн асуув. Тэд гурав хоног хэлэн дээрээ юу ч тавиагүй байлаа. Хатагтай Сонг нөхрөө дэмийрч байгааг нь ухаарав.

Хатагтай Сонг гэрээсээ гүйн гарч, зах руу хурдаллаа. Нурууныхаа өвчнийг таг мартан гүйж байхдаа гуйж, хулгайлаад ч хамаагүй нөхөртөө хоол олж ирэх л хэрэгтэй хэмээн бодов. Азаар гоймон зарж байсан эгчийгээ зах дээр олж харлаа. Эгч нь бас л хөл гар нь хавантай хэцүү байдаг учраас юм гуйж зүрхэлдэггүй бол энэ удаа ичиж нэрэлхсэнгүй. Эгч нь ч татгалзсангүй.

Би дараа танд мөнгийг нь өгнөө хэмээн хэлчихээд буцаад гэр лүүгээ гүйлээ. Чанг Бо хөнжил дотроо эвхрэн хэвтэж байлаа. Хатагтай Сонг нөхрөө нэрээр нь дуудав. Хариу хэлэхгүй болохоор нь хатагтай Сонг дөхөж очоод эргүүлтэл яс арьс болтлоо турсан үе мөч нь хөшиж, нүд нь гөлийсөн харагджээ. Хатагтай Сонг хэдийгээр өнгөрснийг нь мэдсэн ч ханийхаа цээжийг балбан, нэрээр нь дуудан цурхиран уйллаа.

Чанг Бог нас барсны дараа хүү Нам Ок нь ээжтэйгээ хамт амьдрахаар нүүн ирэв. Найз хүүхэнтэйгээ амьдрахаар явснаас нь хойш огт уулзаагүй байж. Хатагтай Сонг цорын ганц хүүтэйгээ бага байхаас нь л таатай харилцаж байсангүй. Хүү нь сахилгагүй хүмүүжилгүйдээ биш түүнийг дуугүй байдлаас нь гарган ярилцаж, дотно харьцаа тогтоох ямар ч боломжгүйд асуудлын гол байжээ. Гэрлээгүй, бас өөрөөсөө эгч хүүхэнтэй хамт амьдарч байсан, эцэг эхтэйгээ харилцаа холбоогоо тасалсан зэрэг нь энэ хүнд хэцүү үед ямар ч ач холбогдолгүй болон хувирчээ. Хамгийн гол нь тэд бие биедээ хэрэгтэй байлаа. Хатагтай Сонг гэртээ ганцаар болохоор, бас Нам Окийн найз хүүхнийд нь идэх уух юм огт байхгүй учраас ээж дээрээ ирсэн аж.

Нам Ок идэр насаа боксчин болоход зориулж шамдан хичээллэж байсан ч биеийн тамирын

сургуулийн нөхцөл маш хүнд байжээ. Нэг өвөл гэртээ чихээ хөлдөөчихсөн ирсэн байна. Ингээд сургуулиасаа гарч, Чонжинд буцаж ирээд гэр бүлийнхээ уламжлалаар төмөр замд ажиллах болжээ. Гэтэл бас л цалин авахгүй байлаа. Хүнсний хангалт ирвэл хамгийн түрүүнд өгнө хэмээн аавыг нь хуурсныхаа адил зүйлийг хэлж ажиллуулсаар .

Нам Ок эрүүл чийрэг, том биетэй, аавтайгаа тун адилхан боловч илүү булчинлаг өндөр залуу болсон байлаа. Иймээс түүнд амьд үлдэхийн тулд их хэмжээний хоол хүнс хэрэгтэй байв. Бие махбодь нь өлсөн хамаг өөхөө хайлуулан дуусгахад Нам Ок марафон гүйгчтэй адил болж харин булчин нь дуусаад ирэхийн алдад амьд хүүр болон хувирлаа. 1997 1998 оны хахир өвөл Нам Ок ханиад хүрч, эмчилж чадахгүй байсаар өвчин нь даамжирч хатгаа болон хүндрэв. Яс арьс болтлоо турсан хүүгээ хатагтай Сонг өргөөд эмнэлэгт аваачиж үзүүлье гэхээр өргөж үл дийлнэ. Түргэн тусламжийн машин гэж байхгүй учраас өөрөө эмнэлэг дээр очиж учрыг тайлбарлав. Эмч түүнд пенициллин олж уулгах жор бичиж өгөхөөр нь зах орж асуухад нэг кило эрдэнэ шишийн үнэ буюу 50 воны үнэтэй байлаа. Эрдэнэ шишийг нь сонгов.

Нам Ок 1998 оны гуравдугаар сард гэртээ ганцаар байхдаа өнгөрчээ. Тэр үед хатагтай Сонг зах дээр хоол хайн тэнүүчилж явсан байна. Түүнийг уулын оройд аавынх нь хажууд оршуулсан бөгөөд Төмөр Замын Товчооноос шарилын хайрцаг гарган өгчээ.

1998 он гэхэд Хойд Солонгосын хүн амын ойролцоогоор арван хувь буюу 600,000-2,000,000 хүн өлсгөлөнгөөр нас барсан гэх тоо баримт бий. Чонжинд бусад мужийнхнаас түрүүлж хүнсний хангамж тасарсан болохоор мужийн нийт хүн амын хорин хувь нь нас барсан байх магадлалтай. Эмнэлгүүд нь өлсгөлөнгөөр нас барсан хүмүүсийн тоог гаргадаггүй байсан учраас нарийвчилсан тоо хэлэх боломжгүй юм.

19962005 онд Хойд Солонгос нийт 2.4 тэрбум ам.долларын хүнсний тусламж хүлээн авах байсны ихэнх нь АНУаас ирэх байлаа. Гэвч төр засаг нь хүнсний тусламж хүлээн авахыг зөвшөөрсөн ч дагалдаж ирэх хүмүүсийг нь нэвтрүүлэхдээ дурамжхан байв. Арай гэж ирсэн, тусламжийн гараа сунгаж буй байгууллагуудын ажилтнуудыг ажлын байрнаасаа, зочид буудлаасаа гарах зөвшөөрөл аваад гармагц нь ядуухан хувцасласан хүмүүс дагана. Сургууль, хүүхэд асрах газруудад очиход нь жин алдаагүй, хамгийн сайхан хувцасласан хүүхдүүдээ л ил үзүүлнэ. Засгийн газар хүнсний тусламж хүссээр байсан боловч ядуучуудаа нуусаар л байлаа. Тусламжийн байгууллагын ажилтнуудад Солонгос хэл сурахыг нь ч зөвшөөрөхгүй.

1997 онд тусламжийн байгууллагын хэдэн ажилтныг Чонжинд нэвтрэхийг нь зөвшөөрөв. Аксион Контре Ла Фэйм буюу "Өлсгөлөнгийн Эсрэг Үйл Ажиллагаа" хэмээх нэртэй Францын хүмүүнлэгийн байгууллагын ажилтан нэгэн сэтгүүлч "Надад Чонжин боомтын ойролцоо байрлах Чонмасон зочид буудлаас гарах эрх байхгүй. Гарвал машинд дайруулна гэдэг үндэслэлээр миний гарах эрхийг хаасан" хэмээн бичсэн байна. Уг байгууллага хүнсний тусламж зориулагдсан хүмүүстээ хүрч байгаа эсэхийг шалгаж чадахгүй болохоор удалгүй төлөөлөгчийн газраа татан буулгажээ. "Хил Хязгааргүй эмч нар" хэмээх байгууллага бас тус улсаас гарч явжээ. НҮБ-ын Хүнсний Хөтөлбөрийн шугамаар ирж буй улаан буудай ачсан усан онгоцууд 1998 оноос Чонжин боомтод ирж эхэлжээ. Гэтэл ирсэн улаан буудайг цэргийн машинууд ачаад л явчихдаг байв. Маш

бага хэсэг нь цэцэрлэг сургуулиудад очиж, ихэнх нь цэргийн ангиудын нөөцөнд үлдэж, үлдсэн нь хар зах дээр зарагдах болжээ. НҮБ өөрийн гэсэн хяналтын системээ тогтоохын тулд Хойд Солонгост арав шахам жил ажилласан юм. 1998 оны сүүлч гэхэд өлсгөлөнгийн ид үе өнгөрлөө. Энэ нь ямар нэг зүйл сайжирсандаа биш үхэх ёстой нь бүгд үхээд дууссан бөгөөд тэжээх амь цөөрсөндөө байсан юм гэж хатагтай Сонг хүүрнэсэн билээ

АРАВДУГААР БҮЛЭГ

БҮТЭЭЛЧ ЭХЧҮҮД

Хатагтай Сонг хүүгийнхээ оршуулгад оролцож чадсангүй. Уй гашуу, өлсгөлөн, болж өнгөрсөн бүхэн бие сэтгэлийг нь эзэмдчихээд өндийх ч сөхөө байсангүй. "Хүүгээ үхвэл үхэг гэсэн шиг ганцаарангий нь орхичихсон" хэмээн ярихдаа тэр мэгшин уйлна. Сонг дахин гэртээ очсонгүй. Юу ч идэлгүй, муужирч унатлаа гудамжаар тэнэв.

Хуучин гэрийнхээ хажууд өлссөнөөсөө болоод эвхрэлдэн, хөлдөх дөхсөн ээжийгээ охид нь арайхийн олж авав. Гуравдугаар сарын сүүл байсан ч хоол тэжээлийн хурц дутагдалд орж, турж ядарсан хүн бол шөнөдөө хөлдөж үхэх хэмжээний хүйтэн байв. Охид ээжийгээ хараад сэтгэл нь өвдөж, хүнд цохилтод оржээ. Хатагтай Сонг төрөлхийн буржгар үсэндээ их нямбай ханддаг байсан бол одоо хиртэж, ширэлдээ даахирсан бөөн юм болчихож. Хувцас хунар нь шороотой холилдон тэр гэхийн тэмдэггүй болжээ. Хоёр дахь охин нь ээжийгээ гэртээ авчирч хувцсыг нь тайлаад хүүхэд шиг усанд оруулав. Тавин хоёртой гэхэд ээж нь турж эцээд дөнгөж Ок Хигийн найман настай хүүтэй адил харагдаж байлаа. Охид мөнгө цуглуулж, ээждээ нэг уут гоймон авлаа. Зохих ёсоор хооллож, тэнхрүүлсний эцэст хагас сарын дараа хатагтай Сонг юу болсныг санахтайгаа болж, нөхөр хүү хоёроо алдсандаа ахиад л гүн уй гашууд автав.

Гурван жил дараалаад гурван дотны хүнээ алдсан байлаа. Хадам ээж нь 1996 онд, нөхөр нь 1997 онд, дараа жил нь хүү нь өөд болжээ. Тэр байгаа бүхнээ, тухайлбал хайрт маршал, нөхөр, хүү, хадам ээж гээд бараг бүгдийг алджээ.

Хэсэг хугацаа өнгөрсний дараа хатагтай Сонг гэртээ буцаж очих зоригтой болов. Уг нь тэрбээр гэрээ гэмт хэргийн газар хэмээн үзэж, очихоос түдгэлзэн, өөрийгөө гэмт хэрэгтнээр тодруулан сэтгэлдээ гэсгээж байжээ. Гэр рүүгээ алхаж байхдаа өмнөх уулын хормойд буй хайртай хүмүүсийнхээ булш руу харав. Хоёр дахь хүргэн нь булшнууд дээр модон багана байрлуулсан байна. Гэртээ дөхөж очоод хаалга нь хагас онгорхой байхыг харав. Хаалгаа түлхэж, гэрт нь хэн нэгэн байгаа эсэхийг шалгав. Хэн ч байсангүй. Гэвч хөнгөн цагаан тогоо, хоёр аяга, хос савх гээд хэрэглэж байсан зүйлс нь алга. Хулгайч авч болох бүх зүйлийг, бүр хоёр удирдагчийн зурагтай жаазны шилийг хүртэл мултлан оджээ.

Хатагтай Сонгод өөрийнх нь аминаас өөр авч явах зүйл үлдсэнгүй. Яагаад амьд байгаагаа ойлгож ядна. Зүгээр л зогсолгүй явсаар, хаа нэгтээ унаад л нүд аньчих юм сан хэмээн бодов. Гэвч тэр үхсэнгүй. Харин ч өөр бизнес эхлэв.

Энд өлсгөлөнгийн их сонин чанар байна. Юм доод туйлдаа хүрээд ирэхээр буюу үхэл хэдэн зуу, хэдэн мянгадаа хүрээд ирэхэд, дагаад шинэ бизнес бий болж эхлэв. Социалист нийгмийн хүнсний түгээлт байхгүй болоод ирэхэд бизнес хөгжин цэцэглэх боломжийг нээж өгөв. Хүн болгон уул руу гарч жимс самар түүх эсвэл нарс модны холтос хуулж чадахгүйгээс хойш хэн нэг нь хүнс олж, бусад нь авахаас өөр аргагүй байдалд хүрдэг. Ингээд загас, мах, нарийн боовны худалдаачид гээд л төрөл бүрийн наймаачид төрж эхэллээ.

Хойд Солонгост бага зэргийн ногоо тарихаас бусад бүх төрлийн бизнес хориотой гэдгийг дээр өгүүлсэн билээ. Ким Чен Ир энэ тал дээр эцгээсээ илүү чанга бодлого баримталж, "Социалист нийгэмд хүнсний хомсдлыг хүртэл социалист аргаар шийдвэрлэх ёстой. Хүмүүст хүнснийхээ асуудлыг өөрсдөө шийд хэмээн орхих нь хувиа хичээх явдлыг газар авахуулна" гэж 1996 оны 12 сард хэлсэн үгэндээ дурдсан байдаг. Ким Чен Ир улс оронд нь хүнсний хомсдол нүүрлээд буйг бараг хүлээн зөвшөөрдөггүй боловч энэ үгэндээ яах аргагүй дурдсан байна. Өөрсдөө тарьсан ногооноосоо бусад төрлийн хүнсний бүтээгдэхүүн зах дээр зарахыг хатуу хориглосон байдаг. Хувиараа бизнес хийх гэсэн ямар ч оролдлого эдийн засгийн гэмт хэрэгт тооцогдож, хөдөлмөрийн лагерьт цөлөх, хээл хахуулийн хэрэг хавсарсан байвал цаазаар авах хүртэл шийтгэлтэй.

Гэтэл өлсөж үхэхдээ тулаад ирэхээр, төр засгаас ямар нэг арга хэмжээ авахгүй болохоор хүмүүс өөрийн эрхгүй хувиараа санаачлага гаргахаас өөр аргагүйд хүрчээ. Хүн гээч өдөрт дор хаяж 500 калори авч байж амьдрах чадвартай болдог ба ойд амьдарч байгаа мэт өвс ногоохноор хооллосон хүмүүс гурван сараас илүү яахин тэсэх билээ. Үхэлтэй бараг нүүр тулсан хатагтай Сонг мэтийн хүмүүс амьд явахын тулд бүхнийг хийх зориг дүүрэн болдог юм санж.

Будааных нь бизнес нурснаас хойш, Хатагтай Сонг их хэмжээний мөнгө шаардахгүй, ийш тийш явдаггүй, аль болох энгийн бөгөөд хүмүүст хэрэгтэй бизнес хийх ёстойг сайтар ухаарчээ. Түүний хамгийн сайн чадах ажил бол хоол хийх. Гэтэл түлээ ховордсон тул энэ бүтэхгүй санаа. Ойр орчмын уул нурууд нүцгэрч, түлээний мод олохын тулд хүмүүс улам хол явдаг болжээ.

Сайтар бодсоны эцэст хатагтай Сонг жигнэмэг хийж зарахаар шийдэв. Жигнэмэг хийхэд аравхан хором шаардагдах тул нэг тэвэр түлээгээр хэд хэдэн тавиур жигнэмэг хийж дөнгөнө. Талхыг бодвол хурдан болох ба өлсөж буй хүмүүст хямд үнээр өл залгуулах боломжийг бий болгосноороо давуу талтай байлаа.

Нөхөр нь мөрийтэй тоглоомонд эргэлт буцалтгүй орсон тул салаад төрхөмдөө буцаж ирээд байсан хатагтай Сонгийн бага охин Ёнг Хи ээжтэйгээ хамтрахаар шийдэв. Ёнг Хи хэсэг хаягдал төмөр олоод нэгэн гагнуурчнаар зууханд хийдэг хоёр давхар тавиур хийлгэснээр жигнэмгүүд нь дээр доороосоо жигд болох болжээ. Хатагтай Сонг охинтойгоо зах дээр явж өөрсөдтэй нь адилхан бизнес хийдэг бүсгүйчүүдээс жигнэмэг худалдан авч амталж үзээд, хамгийн таалагдсан нэгэн жигнэмэгийн орцыг дуурайлган хийхийг оролдож эхлэв. Хатагтай Сонг бас жигнэмэг хийх арга барилд суралцахаар нэгэн эмэгтэйд туслах ажилтнаар хэсэг хугацаанд ажиллаж үзсэн байна.

Анхны туршилт төдийлөн бүтэлтэй болсонгүй. Эхний тавиур нь жирийн байтугай өлсгөлөнд нэрвэгдсэн хүн ч идэхээргүй юм болов. Гэвч хайран юм хаяснаас гээд олигтой болоогүй жигнэмгүүдээ бүгдийг нь өөрсдөө идэв. Яваандаа элсэн чихэр, өсгөгч хоёр хийх хэрэгтэйг олж мэдлээ. Дээрээс нь бас сүү нэмж үзэв. Гурилаа дөрвөн янзын хэлбэр оруулан хэрчээд жигнэхэд яг л жигнэмэг шиг харагдаж, хүмүүс амттай бөгөөд шингэц сайтай хэмээн дуртайяа авч идэх болов.

Хатагтай Сонг өглөө таван цагт босоод жигнэмгээ хийж эхэлнэ. Өрсөлдөөн ихтэй байснаас жигнэмгээ аль болох шинээр нь борлуулчих санаатай. Тэрэг, сагсны аль нь ч байхгүй тул,

жигнэмгээ хуванцар түмпэнд хийгээд хүүхэд үүрч яваа юм шиг зөөлхнөөр мөрөн дээрээ тавин гарч явна. Явган зорчигч олонтой, хөл хөдөлгөөн ихтэй гол гудамжинд гарч хэсэг гэлдрээд нуруугаа амраах гэж гудамжинд завилж суун, хорьтын дарга байх үедээ гишүүдээ хогоо цуглуулах, ялгадас цуглуулж тушаах зэрэг ажилд дууддаг байсан нэгэн жигд хүчтэй хоолойгоороо жигнэмэг авахыг уриалан дуудсаар сууна. Галт тэрэгний ослоос нуруундаа авсан гэмтэл нь бүрэн эдгээгүй тул шүд зуун тэвчиж байлаа. Gwaja sassayo буюу Гважа сасаёо гэдэг нь солонгосоор "жигнэмэг аваарай" гэсэн үг бөгөөд дуу шиг ритмээр уянгалуулан хэлж болдог ажээ. Хатагтай Сонг угийн наймааны авьяастай нэгэн байж. Хүмүүс сайхан ааш, дулаахан харцанд нь татагдах бөгөөд эргэн тойронд нь суух хэдэн арван эмэгтэйгээс ганц түүнийг л зорьцгооно. Өдөрт арван дөрвөн цаг ажилласны дараа халаасандаа 100 вон 50 цент өвөртөлж, жигнэмгээрээ солилцсон бас бус зүйл, тухайлбал улаан чинжүү, хэдэн ширхэг нүүрс зэргийг барьсаар гэртээ харина. Оройн хоолныхоо орцыг маргааш хийх жигнэмгийнхээ материалтай авахад хүрэлцээд л байдаг болов. Гэртээ унах шахсан хүн ирээд хоолоо хам хум идэв үү үгүй юу орон дээрээ өнхрөөд л хурхирч өгнө. Ингээд хэдхэн цагийн дараа босч бүх зүйл ахиад л эхэлнэ. Гэхдээ тэр одоо өлсөхөө больсон.

Дунд насны хэдэн мянган эмэгтэй эгээ л хатагтай Сонгтой адил бизнес хийж байлаа. Тэдэнд дэлгүүр, лангуу гэхээр юм байсангүй. Өөрчлөлтийн үед Орост их дэлгэрч байсан киоск буюу ТҮЦ байгуулахаасаа ч уг эмэгтэйчүүд айцгааж байлаа. Эмэгтэйчүүд бизнесийн тухай юу ч мэдэхгүй. Насан туршид нь хувийн бизнес хийх нь хамт олныхоо эрх ашгийг умартаж, хувиа хичээж байгаа хэрэг мөн гэж номлоод, хийсэн буюу хийхээр оролдсон бүхнийг хатуу чанга шийтгэж байсан юм чинь юугаа ч мэдэх билээ. Гэтэл өлсгөлөн зовлонд автсан эхчүүд, өөрсдийнхөө хүрээнд зах зээлийн эдийн засгийг бий болгож, амьдралдаа хэрэгжүүлж эхэллээ. Хатагтай Сонг бартер хүртэл хийдэг болов. Залуучууд алс хол ууланд очиж түлээний мод бэлтгэн авчирч, хатагтай Сонгийн жигнэмгээр солилцдог болжээ. Шаттай нэг нь шонгийн модонд шат тавьж авираад цахилгааны утас таслан авч хүнсээр солино. Орхигдсон үйлдвэрүүдийн түлхүүрийг олж авсан нэг нь машин техникээс зөөхийг нь зөөж, тонохыг нь тонож, хаалга, цонх гээд л хүнд хэрэг болох бүхнийг хуу хамах болов.

Үйлдвэрүүд ажиллахгүй болохоор хүмүүс жигнэмгийн тавиур ч бай түрдэг тэрэг ч бай бүгдийг гараар хийнэ. Бүсгүйчүүд зотон даавууны үлдэгдэл, хуванцрын өөдсийг хайлуулан нийлүүлээд гутлархуу юм хийж өмсөнө. Жуучин дугуй, модон хаалга, цахилгааны утас нийлж тэргэнцэр болох бөгөөд наймаачид бараагаа гэрээсээ зах хүртэл зөөх тээврийн хэрэгсэл нь тэр болно.

Хүмүүс өөрсдийгөө боловсруулж байлаа. Нүүрсний уурхайчин, боловсрол гэхээр юмгүй нэгэн эр дорнын анагаах ухааны ном олж, Чонжины ойролцоо ургах эмийн ургамлуудыг таньж олох зорилгоор идэвхийлэн судалж эхлэв. Мань эр эмийн ургамал танихдаа зарим эмчээс ч илүү болж биеийн хүчний хөдөлмөр хийж дассан учраас бүр хол явж түүх болжээ.

Эмч нар ч гэсэн мөнгө олох өөр арга эрэлхийлэх болов. Өөрсдөд нь эм байхгүй учир гэртээ, эмнэлэг дээрээ жижиг мэс ажилбар хийж хэдэн цаас зулгааж байлаа. Хамгийн ашигтай нь үр хөндөх. Үр хөндөх нь хэдийгээр хууль бус ч эмэгтэйчүүдийн дунд жирэмслэлтийг хянах хамгийн түгээмэл арга болон хэрэглэгдэг байв. Хэдийгээр хосууд өлсгөлөнгөөс болж бэлгийн дур хүсэл нь суларч, эрчүүдийн дунд үргүйдэл бий болж байсан ч хүүхнүүд жирэмслэх нь бишгүй л байлаа.

Тэжээж чадахгүй байж хүүхэд төрүүлэхийг үл хүсэх тул таслан зогсоохыг илүүд үзнэ. Хэдэн жилийн өмнө Ок Хи үр хөндүүлэхээр найзыгаа дагуулсаар эмнэлэгт очиход 400 вон буюу найман кг будааны үнэтэй байсан бол одоо нэг хувин нүүрсний үнээр л хийдэг болжээ.

Ким эмч мэс ажилбар хийхэд суралцаагүй учир хүмүүст өвчний магадлагаа бичин өгч оронд нь юухан хээхэн авна. Хойд Солонгост цалин авахгүй байсан ч хүндэтгэх шалтгаангүйгээр ажил тасалбал гуч хоног хорих ялаар шийтгэх учир хүмүүс хуурамч магадлагаа аваад хоол ундны эрэлд гарцгаадаг байжээ. Өргөсөн тангараг, эх орныхоо төлөө зүтгэх үйлсийнх нь эсрэг байсан боловч өвчтөнүүддээ, өөртөө ч амьд үлдэхэд нь тусалж буйгаа Ким эмч ухаарчээ.

Ми Раны ээж самбаатай тул дахин нэг шинэ бизнест хөл тавилаа. Том охиныхоо танил талаар дамжуулан тээрэм ажиллуулах зөвшөөрөл олж авчээ. Зайрмаг, дүпүтэй адил цахилгаан шаардахгүй, гар ажиллагаатай учир тээрмийн бизнес нь унах вий гэсэн айдас энэ удаа үгүй байв. Тээрмээ босгоход нь ах дүү, найз нөхөд хамаатан садан нь бүгд л эрвийх дэрвийхээрээ туслав. Тэр үед амралтаараа ирээд байсан Жун Сан хүртэл гар бие оролцжээ. Ингээд тээрэм боссоны дараа хүмүүс шуудайтай эрдэнэ шишээ тал бүрээс тээрэмдүүлэхээр авчирах боллоо. Тэдний хувьд эрдэнэ шишээ бүтнээр нь худалдаж аваад үндэс, хальс, гол гээд л хаях юмгүй тээрэмдүүлсэн нь хямд тусна. Хэрэв сайтар няцалж, нунтаглахгүй бол ходоодонд шингэхгүй. Иймээс тээрэм эрэлттэй бизнес болж чаджээ.

Худалдах юм байхгүй болоод ирэхээр хүмүүс өөрсдийгөө зарж эхэллээ. Ким Ир Сен эмсийн хүрээлэнг хаасан боловч биеэ үнэлэлтийг хэзээ ч бүрмөсөн устгаж чадсангүй. Нуугдмал байсан энэ үзэгдлийг өлсгөлөн ил болгож гудамжинд гаргалаа. Энэ удаа арай өөр хэлбэрээр. Саяхан гэрлэсэн залуу эхчүүд хүүхдээ хоосон хонуулахгүйн тулд биеэ үнэлж эхлэв. Төлбөр нь хэдэн чихэртэй төмс, нэг уут гоймон төдийхөн. Чонжины Төв Галт Тэрэгний буудлын гаднах талбай биеэ үнэлэгчдийн цугладаг газар. Хэзээ ирэх нь тодорхойгүй галт тэргийг хүлээх хэдэн зуун хүн уг талбайд хөлхөлдөнө. Хэрэв этгээд хувцас, богино банзал, жинс, энгэр задгай цамц мэтийг өмсөж, элдэв зүүлт чимэглэл зүүсэн байвал цагдаагийнхан шууд баривчлах тул тэд даруухан хувцаслана.

Ок Хи гэр бүлийн хамт, галт тэрэгний буудлын яг хажууд амьдарна. Тэдгээр хүүхнийг харах бүрдээ Ок Хи өмнөөс нь ичиж, харц буруулах бөлгөө. Тэнд Ок Хитэй нүдээрээ харилцдаг нэгэн бүсгүй байх бөгөөд заримдаа түүн рүү хараад инээмсэглэнэ. Тэр бүсгүй бусдыгаа бодвол арай дээр хувцасласан байх бөгөөд өөртөө илүү итгэлтэй, цэвэр цэмцгэр харагдах ажээ.

Нэг өдөр Ок Хи гэрээсээ гартал нөгөө эмэгтэй өөрийг нь хүлээх мэт үүднээс нь хэдхэн алхмын зайтай зогсож байх нь тэр. "Эгч ээ, ах минь хөдөөнөөс ирчихээд бидэнд хэдэн үг солих газар байдаггүй ээ. Та нэг өрөөгөө түр зээлэхгүй юу" гээд ард нь ичингүйрэн зогсож байгаа эр рүү эрүүгээрээ дохив. Ок Хи хэсэг зуур эргэлзсэнээ зөвшөөрөв. Нөхөр нь ажилтай, хүүхдүүд нь сургуульдаа явсан тохиромжтой үе. Тэгээд ч тэр эмэгтэй Ок Хид 50 вон төлж, үүнээс хойш байнга зочлох болов. Заримдаа хүүхдүүдэд нь чихэр хүртэл авчрах боллоо.

Аль аль нь хууль бус үйлдэл хийж буйгаа мэдэж байлаа. Ямар нэг үйлчилгээ үзүүлснийхээ

төлөө мөнгө авах нь бас л хууль бус хэрэг. Гэвч энэ бол амьдрах л гэсэн арга.

Ихэнх наймаа хуучин тариачдын зах дээр цэцэглэж байлаа. Урьдын сайхан өдрүүдэд хуучин хувцас хунар, байшингийнхаа арын цэцэрлэгт тарьсан ногооноос хэрэгцээнээс илүү гарсныг нь зарах зөвшөөрөл ард түмэндээ олгосон гэдгийг уншигч авхай та хэдийн мэдэх болсон. Харин шинэ эд зүйлийг зах дээр зарж болохгүй, учир нь шинэ юмс улсын их дэлгүүрүүдэд л зарагдах ёстой. Хүүхдүүдээ бага байхад хатагтай Сонг мөнгөтэй үедээ зах дээр очиж өглөөний цайндаа өндөг худалдаж авдаг байжээ.

1990ээд онд Чонжинд өлсгөлөн ноёлж байх ид үед ч гайхалтай нь хар зах дээр хүнс дааж давшгүй өндөр үнэтэй ч, гол нь байсаар л байлаа. Уулын гүнд нууцаар тариалсан байцаа, манжин, улаан лооль, төмс гээд л бүх төрлийн ногоо зах дээр алаглана. Тариачид амьд гарах цорын ганц арга нь үржил шимтэй л бол хаана ч хамаагүй, ургаж л болох бүх зүйлийг тарих явдал гэдгийг маш сайн ухаарсан байлаа. Бүх анхаарал хамтралын газарт биш хувийн тариалангийн талбайд төвлөрч, хувийн ногоо нь шатрын хөлөг мэт эрийж байхад хамтралынх бараг ургасан юмгүй.

Гэтэл зах дээр гэнэт цагаан будаа үзэгдэж эхлэв. 40 кг-ийн будааны шуудайн дээр USA, WFP, EU гэх зэргээр латин үсгээр бичсэн байх ба НҮБ-ийн тэмдэг, Америкийн далбаа харагдана. Америкийн далбааг хүн бүр сурталчилгааны зурагт хуудаснаас мэднэ. Тэдгээр зурагт Америкчууд хүн алж, цусанд хутгалдсан, бусдыг жадаараа сүлбэсэн дүрслэлтэй байдаг учраас танихгүй байхын аргагүй билээ. Гэтэл тэр будааны уутан дээр яагаад хамгийн гол дайсных нь далбаа байдаг билээ? Нэг мэдэмхий нь Хойд Солонгосын цэргүүд Америкийн дайны хэнээтнүүдээс олзолж авсан юм хэмээн тайлбарлана. Харин нэг өдөр хатагтай Сонг зах дээр зарж байсантай адил ууттай будаа ачсан машины цуваа боомтоос хот руу хөдлөхийг олж харжээ. Хэдийгээр машинууд энгийн дугаартай ч хатагтай Сонг цэргийнх гэдгийг нь мэдэж байв. Учир нь тухайн үед цэргийнхнээс өөр хэнд ч шатахуун олддоггүй байжээ. Тэгэхээр цэргийнхэн хүмүүнлэгийн тусламжийг дундаас нь зувчуулж, өөрсдөө ашиг олохоор хар зах дээр зардаг байх нь ээ?

Хаанаас, ямар ч замаар ирсэн нь хамаагүй, гол нь зах дээр цагаан будаа харсандаа Чонжинчууд үнэхээр баярлаж байв. Хар зах руу очих бүрдээ хатагтай Сонг ямар нэг сонин шинэ зүйл бий болсныг олж хардаг боллоо. Тоор, усан үзэм, гадил гээд л. Хатагтай Сонг хамгийн сүүлд хэзээ гадил харснаа санахгүй байлаа. Хорин жилийн өмнө Чанг Бо хүүхдүүдээ баярлуулах гээд авчирч байсан тэр үед ч байж мэднэ. Нэг өдөр жинхэнэ жүрж олж харав. Хатагтай Сонг жүржийг зургаас л харснаас биш огт амталж үзээгүй байлаа. Удалгүй зах дээр шинэ жимс ирснийг харав. Энэ нь шаргал өнгөтэй, биржрүүтэй, ногоон үзүүртэй эд байлаа. Энэ чинь юу гэгч вэ гэж найзаасаа асуутал хан боргоцой хэмээн хариулжээ.

Хойд Солонгосын түүхэнд анх удаа гэр ахуйн бараа урьд үзэгдээгүйгээр хямдрав. Энэ нь 1970-1980 онд Хятадын удирдагч Дэн Сяопиний явуулсан эдийн засгийн шинэчлэлийн бодлогын үр дүн юм. Хятадаас бичгийн цаас, үзэг, харандаа, сайхан үнэртэй үсний шингэн саван, сам, хумсны хутга, сахлын хутга, зай, тамхины асаагуур, шүхэр, тоглоомон машин, оймс гээд л олон төрлийн бараа орж ирж эхлэв. Эх орондоо олон жил юу ч үйлдвэрлээгүйгээс жирийн зүйлс гайхамшиг болох нь энэ.

Хувцас хунарт ч өөрчлөлт орж эхэллээ. Зах дээр огт үзэгдэж байгаагүй этгээд өнгийн, тухайлбал ягаан, шар, улаан шар, номин өнгийн хувцас зарагдах болов. Материал нь гэхэд л Хойд Солонгост үйлдвэрлэсэн даавуунаас чанарын хувьд хол давуу, зөөлөн, өнгө сайтай. Заримдаа шошгыг нь авчихсан сайн чанарын хувцас мэр сэр үзэгдэх нь тэдний хэлж заншсанаар "доод тосгон" буюу Өмнөд Солонгост үйлдвэрлэсэн юмс хэмээн наймаачид өөр хоорондоо шивнэлдэнэ. Тэгэхээр тэд дайсан гэгдэгч улсаасаа хувцас мөнгө төлөн авч байгаа байх нь.

Хатагтай Сонгод зах очих бүрт өргөжин томорч буй мэт санагддаг байлаа. Хөгшин голдуу эмэгтэйчүүд бохир газар дэвссэн берзент дээр ногоо тавьж зардаг дүр зураг бүхий хар зах өнөөдөр өнгө өнгийн бараа өрсөн тэрэг, тавиураар дүүрэн. Тэр битгий хэл хүмүүс бараагаа нарнаас хамгаалан шүхэр хүртэл дээрээ тавих боллоо. Сунам голын эрэг орчимд бий болсон бас нэгэн зах өдөр өдрөөр хаяагаа тэлсээр Чонжины хамгийн том зах болон өргөжив. Энэ зах харин Азийн бусад захуудтай адил төрөлжсөн маягийн зохион байгуулалттай. Нэг хэсэг нь дан хүнсээр төрөлжсөн байхад бусад нь гоо сайхан, гутал, хувцас гэх мэт. 2002 онд хэдийгээр хожимдсон боловч Ким Чен Ир сая л захын үйл ажиллагааг хууль ёсны болгожээ. Харин Чонжины удирдлагууд өөрсдийн бодит байдлыг эртнээс ойлгож зохих арга хэмжээг авсаар иржээ. Захын удирдлагууд наймаачдаас өдөрт 70 вон хурааж авна. Хураамж төлж чадахгүй жижиг наймаачид захын хаалганы гадаа наймаагаа эрхэлдэг байв. Хатагтай Сонгийн бизнес хэзээ ч дангаараа лангуу түрээслэх хэмжээнд очиж байсангүй. Тэгээд ч түрээс төлөхийг хүсэхгүй байлаа. Гэвч тэр Чонжины баруун хэсэгт орших дүүрэг болох Сонгниёны захын тогтмол бизнес эрхэлдэг наймаачдын нэг болж амжив.

Зах дээр наймаа хийх хүмүүсийн бизнесийг дагаад өөр төрлийн бизнес бий болж байв. Сунамын гадаа маш олон модон тэрэгнүүд эгнүүлэн зогсоож, эзэд нь ээлжээ хүлээн, суух нь сууж, унтах нь унтана. Энэ бол худалдан авагчдын барааг зөөх хөлсний тэргүүд. Чонжинд такси, хүн тэрэгч байхгүй учир (засгийн газраас тэдгээр зүйлсийг ямба гэж үзэн хориглоно) оронд нь зөөврийн модон тэргүүдийг хэрэглэж эхэллээ. Иймээс хэрэгтэй орон зайг нөхөх, өөрсдөө ч ажилтай байх зорилгоор хүмүүс тэргээр үйлчилдэг болов. Үсчдэд хайч толь хоёр л хэрэгтэй учир авсаархан явуулын үйлчилгээ үзүүлж мөнгө олно. Тэд хүнсний захын ойролцоо ажилладаг учир наймаачид хүнсэнд үс оруулчихна гэж хөөж, заримдаа маргаан үүсдэг байжээ. Үсчид нэг нүдээрээ үсээ засуулж байгаа хүнийхээ хүзүүг зүсчихгүй санаатай харж, нөгөө нүдээрээ цагдаа харуулдана. Цагдаа харах л юм бол ажлынх нь хэрэгслийг хурааж аваад торгох учир аль болох нүдэнд нь өртчихгүйг хичээн ажиллана. Гэдэс нь хонхолзож ядарсан, өлөн нүдтэй хүүхнүүд сүүлчийн хэдэн воноороо үсэндээ хими хийлгэнэ.

Захын хажууд хүмүүс бас явуулын хоолны газар ажиллуулах болов. Тоосго өрж хөл болгоод дээр нь зузаан хавтан тавьж ширээ хийн, хувин доош нь харуулан тавьж сандал болгосон хоолны газар. Хүмүүс хоол аваад уур нь ч дарагдаж амжаагүй байхад ховдоглон үмхэлцгээнэ. Харин тогооч нар будгийн саваас томгүй дөрвөлжин төмөр зуухны аман дээр л эргэлдэж хөлс нь урсана. Ардаа нялх хүүхдээ бүслэн тогтоосон эмэгтэй зуухны хажууд эргэлдэн хоол хийхтэй нь олонтоо учирна.

Захыг гарал үүсэл гайгүй хүмүүсийн очих ёсгүй газар хэмээн үздэг учраас наймаачдын ихэнх нь эмэгтэйчүүд байлаа. 1990-ээд онд захууд өргөжиж томорсон ч эмэгтэйчүүдийн тоо нэмэгдсэн үү гэхээс буурсангүй. Эрчүүд ажлын газраа цагийг дэмий өнгөрөөж байхад эхнэрүүд нь зах дээр зогсож, жинхэнэ мөнгө олдог ажлаа хийнэ. Хожим Өмнөд рүү зугтан гарч, сэтгүүлч болсон Чонжины уугуул Жу Сунг Ха "агуу их удирдагч эмэгтэйчүүд наймаа эрхлэхийг чимээгүйхэн хүлээн зөвшөөрсөн юм. Хэрэв эмэгтэйчүүдийг мөнгө олохыг нь хориглосон бол хувьсгал гарах байлаа" хэмээн хүүрнэсэн билээ.

Үүний үр дүнд эмэгтэйчүүд шинэ эдийн засгийн нүүр царай болон хувирлаа. Эрчүүд улсын, цалингүй ажилтайгаа зууралдаж суухад бүсгүйчүүд мөнгө олж байв. Зарим эмэгтэй "эрчүүд гэр сахидаг нохойноос ялгаагүй боллоо" хэмээн хоорондоо сэм шивнэлдэнэ. Хэдийгээр бүсгүйчүүд мөнгө олж гэр бүлээ тэжээж байсан ч улс оронд олон жилээр ноёлсон эцгийн эрхт ёсыг халж чадсангүй. Гэхдээ бас хоосонгүй, зохих хэмжээний эрх чөлөө олсон билээ.

Гаднаас нь харвал Чонжин өөрчлөгдөөгүй мэт. Нэгэн хэвийн Сталинч маягийн албан байгууллагын саарал байшингууд дүнсийж, замын хажуугаар хоёр удирдагчийн амжилтыг харуулах, гандсан улаан бичиг бүхий самбарууд ёрдойно. Цаг хугацааг 1970 он дээр гацааснаас уг хот царцсан мэт байлаа. Гэвч Хатагтай Сонг тэр гэхийн тэмдэггүй, ямар ч эмх цэгцгүй нөхцөлд амьдарч буйгаа сайн ойлгож байв. Зөв нь буруу болж, дээшээ харсан зүйл доошоо болох тохиолдол бишгүй байжээ. Эрчүүд биш эхнэрүүд мөнгөтэй болж, зах урьд хожид хэзээ ч байгаагүй их хэмжээний хүнсээр халгиж цалгиж байхад хүмүүс өлбөрч үхсээр л. Хөдөлмөрийн намын гишүүд өлбөрцгөөж байхад эх орныхоо төлөө хуруугаа ч хөдөлгөж үзээгүй хүмүүс мөнгө олсоор л.

Хатагтай Сонг шуналын туламнууд гэж аман дотроо бувтнана. Өмнө нь өөрөө болон эргэн тойрных нь байгаа бүх хүн ядуу байсан болохоор Сонг олон юм боддоггүй сэн. Гэтэл одоо баян нь улам баяжиж, ядуу нь ядуугийн туйл болсоор байв. Арван жилийн өмнө эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял сонсох ёстой байсан хүмүүс шинэ гутал хувцас өмссөн шигээ гудамжаар хээвнэг алхаж явах боллоо. Гэтэл өдөр шөнөгүй ажиллаж байсан хүмүүс өлссөөр. Инфляци хяналтаас гарав. 1998 оны сүүлч гэхэд хар зах дээрх цагаан будааны үнэ 200 вон болтлоо өссөн байлаа. Цалин тавьж эхэлсний дараа ч жирийн ажилчид, багш нар бүтэн сарынхаа цалингаар гэр бүлийнхээ зөвхөн хоёр гурван өдрийн хүнсний хэрэгцээг хангах төдий. Хүүхдүүд газраар мөлхөн шуудайнаас асгарсан цагаан будааг шороо хог шороотой нь хамт түүцгээнэ.

Хатагтай Сонг найман настай Сонг Чол хэмээх хүүг мэддэг байжээ. Тэр тоор зардаг ааш муутай эцгийнхээ хамт өдөр бүр зах дээр ирнэ. Тоор муу зарагдах тул "Тоор ах" хэмээн хочлогдсон эр гэр бүлээ тэжээх гэж зовж байлаа.

Чи тэр хүүхдүүд шиг яваад юм олж идээч гэж Тоор ах нэгэн өдөр хүүгээ зандарчээ.

Сонг Чол дуулгавартай хүү болохоор эрчүүд хавч идэн, архи ууж байсан ширээнд хүрч очоод муудсан загасны үлдэгдэл олж үмхчихээд буцаад аавынхаа хажууд ирэхдээ гэдэс нь маш хүчтэй базалж байгааг хэлжээ. Аав нь сүүлчийн ганц воноороо тэрэг хөлсөлж хүүгээ эмнэлэгт аваачихаас

өмнө тэр хоолны хурц хордлогоос болж энэ хорвоог үүрд орхисон юм. Үхсэн, үхэж буй хүмүүстэй тааралдах өдөр бүрийг хатагтай Сонг тун хүнд үдэж байлаа. Нөхөр, хүү хоёроо алдсан, өдөр бүр үхэлтэй тулгарч байсан ч энэ бүхэнтэй эвлэрч үл чадна. Нэгэн орой хатагтай Сонг үлдсэн хэдэн жигнэмэгээ зарчих санаатай галт тэрэгний буудлаар эргэлдэж зогстол хоёр хүн их л хүнд ачаатай бололтой тэрэг түрэн явахыг сонирхон хартал тав зургаан хүний шарил ачсан тэрэг байв. Урд шөнө нь өлбөрч үхсэн хүмүүсийн шарилыг ачиж яваа нь тэр байж. Үхэгсдийн үе мөч унжиж, толгой нь цардмал зам дээгүүр чирэгдэнэ. Гэтэл тэдний дунд дөч орчим насны хүн нүдээ анивчин байх нь хараахан үхээгүй ч удахгүй нь тодорхой болоод ачиж явсных бололтой.

Хатагтай Сонг нөхөр хүү хоёроо бодохоос өрөвдөж гол нь харладаг. Гэхдээ одоо бол тэднийгээ гэртээ, орон дотроо нас барж, хүн шиг үдүүлсэнд бурханд талархах болжээ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

ТЭНЭМЭЛ ХООЛНЫ САВУУД

Хатагтай Сонг Чонжины галт тэрэгний буудал дээр өдөр болгон шахам очихдоо өмднийх нь салтаа өвдөг хүртлээ унжсан, үйлдвэрийн ажилчны хэт томдсон хөх ягаан дүрэмт хувцас өмссөн жаалтай байнга таардаг байв. Хүү хөлдөө гутлын оронд хулдаасан уут угласан харагдана. Ширэлдэж, даахирсан үс нь бөөстжээ. Насыг нь тодорхой хэлэхэд хэцүү. Учир нь хүү 14 настай ч наймтай л юм шиг харагдах ажээ.

Хатагтай Сонг жигнэмэгээс нь зарагдахгүй үлдвэл хүүд өгдөг, бусад үед бол төдий л үл анхааран хажуугаар нь өнгөрнө. Галт тэрэгний буудлаар тэнүүчлэх хэдэн зуун хүүхдүүд ялгагдах юмгүй. Эцэг эх нь нас барсан юмуу, хоол хүнсний эрэлд гараад эргэж ирээгүй эдгээр хүүхдүүдийг нутгийнхан "тэнэмэл хоолны савууд" хэмээн нэрлэх болжээ. Хүүхдүүд галт тэрэгний буудал дээр өвдөл цөвдөл хайн, сүрэг тагтаа шиг сүлжилдэн, хүмүүст ад болно. Гэргүйдэл гэж огт байгаагүй улсад энэ нь цоо шинэ үзэгдэл байлаа.

Ким Хиюук давжаа биетэй боловч эрүүл чийрэг, бас зальтай хүү. Хүн идэх юм худалдаж аваад ам руугаа хийж амжихаас нь өмнө шүүрэн авч хүүе гэхийн завдалгүй залгиж орхино. Наймаачид зарж буй зүйлээ саванд хийн, нягт нэхсэн тороор бүтээж, хамгаалахыг хичээвч Ким Хиюук тороо нээхийг нь амдаж байгаад савыг нь түлхэн асгаж юм шүүрэн зугтана. Энэ бол амьд явахын эрхээр хар багадаа сурсан чадвар бөгөөд том болох тусам нь улам мэргэжсээр байлаа. Ийм чадваргүйгээр тэр амьд үлдэхгүй байсан биз.

Хиюукийн гэр оронгүй болсон түүх нь Хойд Солонгосын хүн амын үндсэн давхарга хэрхэн уналтад орсны бодит жишээ юм. Хиюук 1982 онд жинхэнэ коммунист гэр бүлд төржээ. Эцэг нь Өмнөд рүү довтолоход бэлтгэгдсэн, элит цэргийн ангийн офицер байгаад Хөдөлмөрийн намд элсэн орсны ачаар загас, хушны мөөг экспортолдог цэргийн нэгтгэлд ажиллах болжээ. Гэр бүл нь Сунамд ээжийнх нь ажилладаг нэхмэлийн үйлдвэрийн ойролцоо амьдарч байжээ. Хиюукийг хоёр сартайд ээж нь ажилдаа орж, түүнийг үйлдвэрийн өдөр өнжүүлэхэд өгсөн байна.

Гурван настай байхад нь ээж нь зүрхний дутагдлаас болж нас барснаас Хиюукийн амьдрал орвонгоороо эргэсэн юм. Тэр ээжийнхээ царайг бүдэг бадаг санадаг ч оршуулган дээр нь хүж асааж байсан нь ой ухаанд нь тодхон үлджээ. Аав нь удалгүй өөр хүнтэй гэрлэв. Хиюук, ах Чол хоёр хоолноос болж хойд эхтэйгээ үргэлж муудалцдаг байв.

Хөвгүүд сахилгагүй, хөдөлгөөнтэй бас үргэлжийн өлсгөлөн. Хойд ээж нь өөрийнхөө охинд илүү хоол өгөөд байна гэж тэд бодно. Тэд гал тогооноосоо эрдэнэ шишийн гол хулгайлж, зах дээр очиж чанасан гоймонгоор солино. Хойд ээж нь хүнсээ цоожтой саванд хийдэг болчихонгуут нь хөнжлийг нь хулгайлж хүнсээр сольжээ.

Хиюук арван настай байхдаа анх танихгүй хүнээс хулгай хийжээ. Улаан шоштой цагаан будааны боов хулгайлаад зугтахад наймаачин гүйцэлгүй хараасаар хоцорсон гэнэ. Тэр боов нь дэндүү

амттай байсан учраас дахин нэгийг хулгайлахаар буцаж ирээд цагдаад баригджээ. Аав нь цагдаагийн газраас хүүгээ гаргаж аваад гэртээ ирснийхээ дараа суран бүсээр гувруутгал нь ороолгоод "миний хүүхдүүд хулгай хийх ёсгүй. Хулгай хийснээс өлсөж үхсэн нь дээр" хэмээн уугчсан байна. Тэр үед Хиюук хулгай хийсэндээ харамсаж, толгойгоо гудайлган, цагдаагийн газраас нүд дүүрэн нулимстай гарч байжээ.

Гэвч Хиюук аавынхаа үгэнд оролгүй хулгай хийсээр л Чонжины баруун хэсэгт орших тойрогт нүүрсний уурхайнууд байх. Харин уурхайн доод талд цэцэрлэгт хүрээлэн бий. Хиюук найзуудтайгаа автобусны арын шатнаас дүүжлэгдэн тэнд очиж, цэцэрлэгээс лийр хулгайлах болов. Лийргүй болмогц эрдэнэ шиш хулгайлж эхэлжээ. Түүнийг балчир учраас баригдсан ч анхааруулсан болоод харуулууд суллана. Хулгай хийхдээ Хиюук ичих зовохыг умартав. Ким Ир Сенийг нас барсны дараа хөшөөнд нь хүндэтгэл илэрхийлэхээр, хүмүүсийн авчирч тавьсан цагаан будааны боовыг ч байлгасангүй.

Аав нь хүүгийнхээ энэ үйлдлийг тэвчихийг хүсээгүй ч гэрт нь хүүхдүүдээ тэжээх зүйлс хомс байлаа. Хойд эх нь охиноо аваад төрхөмдөө буцав. Аав нь сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн асрамжийн газрын намын үүрийн даргаар ажиллах болж, хөвгүүдээ өмнө нь асрагчдын амьдарч байсан нэг өрөөнд оруулав. Хиюукт тэнд амьдрах таалагдаж байлаа. Өөрийг нь том хүн шиг бодож, ний нуугүй ярилцах өвчтөнүүдийн ганцаардлыг мэдэрч, тэдэнтэй аль болох их цаг өнгөрөөхийг хичээх болов. Гэвч асрамжийн газар ч хүнсгүйдэж эхэллээ. Хиюукийн эцгийн эрхэлдэг ажил асрамжийн захирлаас илүү эрх мэдэлтэй ч, хүнсний хувь илүүг олоход нь тус болсонгүй. Гэвч танил талаа ашиглан хөвгүүдээ асрамжийн газар өгч дөнгөсөн байна.

Ихэнх социалист орнуудын адил тэнд ч гэсэн зөвхөн өнчин биш эцэг эх нь асрах боломжгүй хүүхдүүдийг ч асрамжийн газарт хүлээн авдаг байв. Дотуур байртай сургуулийн адил асрамжийн газар нь хүүхдүүдэд хичээл зааж, байраар хангана. Аав нь есдүгээр сард мужийн хамгийн хойд захад Хятадын хилтэй ойролцоо орших Онсонд байх Донсоны 24-р асрамжийн газарт хөвгүүдээ хүргэж өгөв. Энэ үед Хиюук 11тэй, ах нь 14-тэй байжээ. Эцэг нь хөвгүүдтэйгээ галт тэргэнд зургаан цаг босоогоороо явсаны эцэст зорьсон газартаа хүрэв.

"Та хоёр бол төрсөн ах дүүс. Бие биедээ дэм болж, бусдад дээрэлхүүлэхгүй байхыг хичээгээрэй" гэж замын турш нэг ч үг дуугараагүй аав нь хөвгүүдээ хүлээлгэж өгөхдөө захиж.

Эцгийгээ араас нь хараад асар их хөгширснийг нь сая л анзаарав. Нэгэн цагт өндөр, царайлаг, жавхаатай явсан аав нь бөгтөр, буурал, туранхай өвгөн болжээ.

Эхний үед асрамжийн газрын хоол тун дажгүй байв. Эрдэнэ шиш, арвай, хямд буудайтай хольсон ч гэсэн өдөр бүр нэг аяга будаа иднэ. Сүүлийн хэдэн жил хөвгүүд үүнээс сайн хоол идэж байсангүй. Хашаан дотор гүйлсийн мод ургаж буйг хүүхдүүд олж мэдээд чадахын хэрээр түүж, цадталаа идэх болов.

Гэтэл өвлөөс хоол нь багасаж ирэв. Будааны оронд давстай усанд чанасан эрдэнэ шишийн хэдхэн гоймон хөвсөн шөл өгөх боллоо. 1996 оны эхний гурван сар гэхэд 27 хүүхэд нас барав.

Хиюук ахтайгаа хичээлээ таслан, хот орж хүнсний эрэлд гарна. Хотод ч байдал сайнгүй байлаа. Хиюук өөрийнх нь үеийн, зургаан настай дүүтэйгээ хоёулхнаа амьдардаг нэг хүүтэй танилцав. Тэд өнчин учир хөршүүд нь хааяа нэг зутан авчирч өгөхөөс бусдаар өөрсдөө амь зогоодог байжээ.

Хиюук ах болон шинээр танилцсан найзынхаа хамт хоолны эрэлд гардаг болов. Хиюук богино пагдгар хөлтэй боловч урт, хүчирхэг гартай учраас мод хаданд сайн авирна. Нарс модонд авирч гараад гаднах холтсыг нь хуулан авч доторх зөөлөн, шүүслэг, шар хальсыг нь авч идэцгээх болов. Өлссөндөө Хиюук модонд авираатай чигээрээ нарсныхаа хальсыг үмхэлдэг байв. Бусад хүүхдүүд бас л тэдэнтэй адил зүйл хийх учир Хиюук бусдын гарч чадахааргүй өндөрт авирдаг болжээ. Чи ч жижигхэн сармагчин юм аа гэж шинэ найз нь гайхах бахархах хослуулан хэлжээ.

Хиюук харх, хулгана, мэлхий, шанаган хорхой барьж сурав. Мэлхий устахад царцаа, голио хөөцөлдөх болжээ. Бага байхад нь найзууд нь Сунам голын зүлэгнээс голио барьж идэхэд ой нь гутдаг асан Хиюук одоо аль хэдийн цамаан зангаа хаяжээ. Тор олоод түүгээрээ хавх хийж бор шувуу агнаж эхэллээ. Агнасан бор шувуугаа өд сөднөөс нь салгаад шарж идэцгээнэ. Хувин, утас ашиглан тагтаа барихыг оролдсон боловч болхи хавханд нь тагтаа орж өгөхгүй байлаа.

Нэгэн удаа Хиюукийг эзэнгүй нохой сүүлээ шарвалзуулан дагахаар нь хуурч явсаар найзынхаа хашаанд оруулж, хувинтай усанд хийгээд таглаж орхижээ. Усанд живсэн нохой арван хором хэртэй тарчилсны эцэст амь тавьсны дараа арьсыг нь өвчиж шарж идэцгээсэн ажээ. Солонгосчууд нохойн мах иддэг боловч Хиюук амьтанд хайртай учир амсаж төвддөггүй байв. Ахиад тэр нохой авласангүй. 1996 оны дунд гэхэд угаасаа нохой ч ховордож эхлэв.

Хиюук хулгай хийсээр л байлаа. Тэд айлын хашаа давж ороод газар булж орхисон ваартай кимчи ухан гаргаад шууд л үмхэлдэг байжээ.

Аавынхаа "хулгай хийснээс өлсөж үхсэн нь дээр" хэмээн хэлснийг үргэлж сэтгэлдээ хадгалдаг байсан боловч "хэрэв үхчихвэл чи баатар биш" гэж хэлсэн нь ч бас санагдсаар.

Хиюук гэрээ санаж эхлэв. Аавыгаа болон 16 хүрээд, насанд хүрсэн шалтгаанаар албан ёсоор асрамжийн газраас хасагдсан Чол ахыгаа санаж байлаа. Ах нь түүнийг олон золгүй явдлаас аварч хамгаалдаг байсан болохоор өмөг түшгийг нь үргэлж үгүйлнэ. Чол аавыгаа дуурайсан өндөр, биерхүү болохоор бусдад зодуулахын зовлонг мэдэлгүй өсөж, өөрийгөө, дүүгээ хамгаалж чаддаг байв. Гэтэл ах нь байхгүй болохоор Хиюук байнга зодуулна. Нэг өдөр ойд очин, нарсны хальс хуулж байхдаа Онсоны танхай хүүхдүүдтэй нүүр тулчихав. Хотын хүүхдүүд асрамжийн газрынхныг хоолыг нь хулгайлдаг гэж боддог учир тааралдсан газраа шийтгэдэг байжээ. Эхлээд хөвгүүд нүүр рүү нь хувин дүүрэн ус цацлаа гэж бодсон Хиюук дараа нь хөл нь цусанд хутгалдсан байхыг харав. Гуяыг нь сүхээр цавчсан байжээ. Шарх нь эдгэмэгц Чонжин орох галт тэргэнд нууцаар суун одлоо.

Чонжинд ирээд сөнөсөн мэт болсон төрөлх хотоо таньсангүй. Бүх зүйл эвдэрч, нурж, тарж бутарсан байлаа. Дэлгүүрүүд бүгд хаалттай. Троллейбус явахгүй байсан учир нэгдүгээр замыг даган гэр рүүгээ алхлаа. Сунам голын гүүрэн дээгүүр гарахдаа үйлдвэрүүдийн яндангаас утаа

гарахгүй байхыг ажиглав. Ээжийнхээ ажилладаг асан Химийн Нэхмэлийн Үйлдвэр рүү эргэхдээ том гулдан хаалга нь цоожтой байхыг харав. Доторх тоног төхөөрөмж нь тоногдоод байхгүй болжээ. Гэрийнхээ орчимд очоод сэтгэлээ барьж дийлсэнгүй, нулимс нь асарлаа. Хүүхэд ахуйд нь байсан зүйлс бүгд үгүй болж, саргүй шөнө тал дунд явж буй мэт сэтгэгдэл төрж байжээ.

Нэлээд төөрч явсны эцэст төрсөн гэрээ арай ядан олов. Нээлттэй орцны хаалгаар орж харанхуйд шатыг тоолон өгсөв. Дээшлэх тусам чангарах хүүхдийн уйлах дууг эс тооцвол байшинд хүн байна уу гэмээр санагдана. Байшин андуурсан юм биш байгаа гэж бодов. Гэр нь найман давхарт байдаг ба үүдэнд нь ирэхэд хаалганы завсраар гэрэл харагдав. Хүү ихэд баярлан аав, ах хоёр нь эсвэл аль нэг нь гэртээ байгаа байх нь гэж боджээ. Хаалгаа тогшив. Хүүхэд тэвэрсэн залуу, сайхан бүсгүй хаалга онгойлгож өглөө. Бүсгүй Хиюукийг гэрт орохыг уриад юу болсныг тайлбарлаж өгчээ. Бүсгүй нөхрийн хамт уг байрыг Хиюукийн ааваас жилийн өмнө худалдан авсан байна. Аав нь хаягаа үлдээгээгүй бөгөөд хөвгүүдийг маань ирвэл намайг галт тэрэгний буудлаас олоорой гэж хэлүүлсэн байлаа.

Чонжины галт тэрэгний буудал. Энд юу ч үгүй, амьдрах аргагүй болсон хүмүүс ирдэг байв. Ирээд цөхөрч, замын хажууд хэвтээд өгдөг гэсэн үг биш. Ирж буцаж буй галт тэрэгний цувааг харж сэтгэлдээ бага ч гэсэн итгэлийн цог олж авцгаадаг учраас ирдэг байлаа. Ирж буй галт тэрэг хүнс авчирч магад, бас тэр галт тэргэнд суугаад аль нэг сайхан газар руу явах ч юм билүү хэмээн мөрөөддөг байжээ. Чонжин бол галт тэрэгний сүлжээний огтлолцлын цэг. Хүмүүс бусад хотууд буюу Хамхун, Килжу, Кимчак хотуудад байдал асар хүнд учир Чонжиныг зорин нүүдэллэцгээж байлаа. Хэн ч бууж өгөхийг хүссэнгүй.

Галт тэрэгний буудал хэмээх хоёр давхар өндөр цонхнуудтай гантиг байшингийн нүүрэн талд Ким Ир Сений том хөргийг байрлуулжээ. Хөргийн дор хааяа л зөв явдаг цаг хадсан байна. Дотор тал нь тамхины утаагаар дүүрэн. Хүмүүс юуг ч юм хүлээн сууцгаана. Сууж чадахааргүй нь хүлээлгийн өрөөнд зулан хэвтэцгээнэ. Хиюук аавыгаа эрэн хүмүүсийн дундуур хэрэн явлаа. Өндөр, биерхүү улсыг тогтон ажиглана. Заримдаа хэвтэж, сууж буй хүмүүсийг тонгойн харах ч тохиолдол гарна. Таньдаг хүн олон тааралдсан ч аав ах хоёрынх нь тухай нэг нь ч мэдэхгүй байв. Очих газар байхгүй учир Хиюук заалны буланд хэвтэр олж аваад цагариглан хэвтээд өгөв. Өглөө босож, ажилладаг угаалтуур олж нүүрээ угаасан боловч толгой дахь бөөс нь байж ядтал загатнуулсан хэвээр.

Энэ улсад хүмүүс тогтмол гэрийн хаягтай, ажлын байртай байж амь зуух ёстой. Учир нь гэрийн хаягаар хүнсний хангамжид хамрагдана. Гэрээсээ явчихвал хоолгүй гэсэн үг. Иргэд аялах зөвшөөрөлгүйгээр хажуу хотын хамаатныдаа ч очиж зүрхэлдэггүй байжээ. Шөнө хоног төөрүүлэхээр ирсэн зочид хүртэл хорьтын даргад бүртгүүлэх ёстой ба хорьтын дарга нь цагдаад тухайн хүний бүх мэдээллийг дамжуулдаг. Цагдаагийн газраас айлуудад үе үе гэнэтийн шалгалт хийж, зөвшөөрөлгүй хүн гэртээ хонуулсан эсэхийг шалгана. Иргэн бүр 12 хуудастай, паспорттай адил иргэний бичиг баримтыг байнга биедээ авч явах ёстой.

Ийм байсан систем өлсгөлөнгийн үеэр өөрчлөгдлөө. Хүнсний хангалт байхгүй болохоор хүмүүст тогтсон хаягтай байх шаардлагагүй болов. Сууна гэдэг өлсөж үхнэ гэсэн үг. Төр засгийн

айлган сүрдүүлэлт ч хүмүүсийг гэрт нь тогтоож чадахаа больсон байна. Хүмүүс эхний үед хоол эрж олохоор элдэв муу бодолгүй тэнүүчилдэг байлаа. Аажимдаа хүн чанараа гээж эхлэв. Хүүхэд, залуусаа аврахын тулд дунд болон хөгшин настай хүмүүсийн хоолыг хязгаарлаж эхлэв. Үүний үр дүнд өнчин хүүхдийн тоо эрс нэмэгджээ.

Тэнүүлч хүүхдүүд галт тэрэгний буудал дээр бужигнах хүмүүсийн дунд олноороо хэрэн хэснэ. Тэд яг Хиюук шиг үйлдвэрийн ажилчдын хөх ягаан өнгөтэй дүрэмт хувцас өмсдөг. Үйлдвэрүүд хаагдсан учир нөөцөнд байсан хувцсуудыг үйлдвэрүүдийн захиргаанаас хүмүүст үнэгүй тараасан нь хүүхдүүдэд ийн оногдсон учиртай. Хэдхэн хүүхэд гуталтай байх боловч удахгүй хүнсээр сольцгоогоод хөл нүцгэрна. Ингээд оронд нь уут углаж, хөлөө хөлдөөх нь олонтаа.

Хүнс хомсдолын эхний жилүүдэд хүүхдүүд гуйлга гуйж амиа зогоодог байсан бол удалгүй гуйлгачин хүүхдийн тоо хэт олон болсноор хоол илүүчилдэг байсан сайхан сэтгэлтэй хүмүүс хүчрэхээ болив. Өглөгийг цатгалан хүмүүс л өгдөг, хүүхдүүд чинь өлсөж байхад бусдын хүүхдэд гар сунгах хэрэггүй гэсэн зарчим үйлчилж эхэллээ.

Гуйлга гуйх боломжгүй болоод ирмэгц хүүхдүүд газраас ам руугаа хийж болох бүхнийг түүж амиа зогоож эхлэв. Хоол олж чадахгүйд хүрвэл бусдын татсан тамхины иш түүж, хаягдал цаасанд ороон татаж, өлсгөлөнгөө дарж байлаа. Бараг бүх хүүхэд тамхи татаж сурсан байв.

Олуул нийлж дээрэм хулгай хийдэг хүүхдүүдтэй Хиюук заримдаа нийлнэ. Чонжин гудамж, танхайчуудаараа хэзээний алдартай. Гэхдээ өлсгөлөнгийн үед хулгай дээрэм нь илүү хэрэгцээнд тулгуурласан шинжтэй байв. Том хүүхдүүд хөдөлмөрөө нарийн хуваарилна. Том биетэй чадалтай, хурдан гүйдэг хүүхдүүдийг жижиг биетэй сул доройнуудтай нийлүүлж хуваарилна. Томчууд нь хүнсний лангуунууд руу гүйн очиж, бүх зүйлийг нурааж буулгах үүрэгтэй. Уурласан наймаачин хүүхдүүдийг хөөхөөр ухасхийх хооронд жижгүүд нь амжин ирж хүнснээс хулгайлна.

Бас нэг арга нь буудай ачсан хурдтай биш явж буй машин, галт тэрэг дээр авиран гарч шуудайг нь хурц хутгаар зүснэ. Асгарч үлдсэн бүхэн нь хүүхдүүдийн олз болно. Удалгүй төмөр замын удирдлагаас буудайны хулгайчдыг харвал дор нь бууд гэсэн тушаал гаргажээ.

Энэ үнэхээр осолтой амьдрал байлаа. Хүүхдүүд олсон жаахан зүйлээ бусдад дээрэмдүүлэхээс сэрэмжилж, цурамхийхгүй хонох нь олонтаа. Хүүхдүүдийг бэлгийн гаж хүслээ хангах, бас хүнс хоол олох хэрэгсэл болгон ашигладаг тухай яриа дэгдэж эхлэв. Хиюукт таньдаг хүмүүс нь хүүхдүүдийг мансууруулан алаад иддэг хүмүүсийн тухай аймшигтай зүйлсийг ярьж өгчээ. Төмөр замын шугамын ойролцоо галт тэрэгний буудлын ард хоол хийж зардаг хүмүүсийн тогоонд хөвж буй саарал өнгөтэй мах бол хүний мах хэмээн шивэр авир хийнэ.

Зохиомол яриа ч бай, үгүй ч бай хүний мах иддэг, зардаг хүмүүсийн тухай цуу яриа хар зах дээгүүр өргөн тархлаа. Хатагтай Сонгийн танил, зах дээр наймаа хийдэг авгай хаанаас авчирсныг нь баттай мэдэхгүй бол мах битгий авч байгаарай хэмээн чухалчлан сануулаад, хүний мах идээд амттайг нь гайхдаг нэгнийг таньдаг тухайгаа хэлсэн байна. Хэрэв мэдэхгүй бол гахай, үхрийн мах гэж андуурна шүү хэмээн тэр айсан Хатагтай Сонгод нэмж сануулжээ.

Энэ цуу яриа өдрөөс өдөрт улам аймшигтай болж байлаа. Нэгэн нүгэлт эцэг өлссөндөө төрсөн үрээ алж идсэн гэнэ. Хүний яс чанаж байгаад нэгэн эмэгтэй цагдаад баригджээ гэхчлэн ярина. Миний ярилцсан Өмнөд руу зугтан гарсан хүмүүсийн хэлснээр хүний мах идсэн нь нотлогдсон хоёр ч хүнийг цаазаар аваачсан гэдгийг баттай мэдэж байв Энэ хоёр хэргийн нэг нь Чонжинд, нөгөөх нь Синюжид гарсан гэнэ. Гэвч энэ үзэгдэл Хятадад 1958-1962 онд болсон өлсгөлөнгийн үеэр нас барсан хүмүүсийн тоо 30 саяд хүрсэн шиг аймшигтай, нийтийг хамарсан байдалд хүрсэнгүй.

Махчид, хүн идэгсэдийг байсан байгаагүй хүүхдүүд гудамжинд удаан амьдарч чадахааргүй байв. Багачууд нь хэдхэн сар л амьдарч байлаа. Төмөр замын ойролцоо амьдардаг Хатагтай Сонгийн том охин Ок Хи гэр лүүгээ харих замдаа хүүхдүүдтэй үргэлж тааралддаг байжээ. Энэ жаахан хүүхдүүд тэртэй тэргүй маргааш гэхэд л өлбөрч үхнэ дээ гэж туслахгүй өнгөрснөө цагаатган бодож, хурдан алхан оддог байлаа.

Миний уулзсан, Чонжиноос гаралтай хүмүүсийн ихэнх нь галт тэрэгний буудал дээр, бүр галт тэрэг дотор ч үхсэн хүмүүсийн шарил бөөн бөөнөөрөө овоорч, хөлд тээглэн байдаг байсан тухай ярьсан билээ. Нэгэн үйлдвэрийн ажилчин, Килжугаас Чонжин хүрэх замд суусан галт тэргэнд нь гартаа намын батлахаа тас атгасан цэргийн офицер үхсэн байсан ба хамт зорчигсод гайхах ч үгүй, цэрвэх ч үгүй явсан тухай ярьсан юм. Шарил тэдэнтэй хамт Чонжин хүртэл зорчиж, галт тэрэгний буудал дээр талийгаачийг гаргасан байна.

Галт тэрэгний буудал дээр цэвэрлэгээний ажилтнууд нийтийн газруудыг шалгаж, модон тэргэн дээр шарилуудыг бөөнөөр нь ачиж хаа нэгтээ аваачна. Тэд хүлээлгийн өрөө болон бусад хүмүүс олноор цугладаг газруудыг байн байн шалгаж, газраар нэг зулсан хүмүүсийн аль нь урд өдрөөс хойш хөдөлгөөнгүй байсныг олох гэж нэгд нэгэнгүй ширтэцгээнэ. Заримдаа өдөрт гуч хүртэл тооны шарил буудлаас гаргаж байсан гэж Хиюук ярьсан юм. Нас барсан хүмүүсийн өнгөтэй өөдтэй хувцас, хэрэглэл, бичиг баримтыг хулгайлсан байдаг учир хэн болохыг танихад тун бэрх. Галт тэрэгний буудал дээр нас барсан хүмүүсийн гэрийнхэн үхэж үрэгдсэн байх магадлал өндөр учир ихэнх тохиолдолд нийтийн оршуулгын газар булшилдаг ажээ. Өөд болсон эцэг өвгөдөө хаана оршуулснаас амьд үлдэгсдийн амьдрал хэр байх нь шалтгаалдагт нийтээрээ итгэдэг Күнзийн нийгэмд ингэж хорвоогоос үдэж, үдүүлэх нь гутамшигт тооцогдоно. Хятадын хилийн ойролцоо иймэрхүү оршуулга болж байхыг нүдээр үзсэнээ Өмнөд Солонгосын "Сайн Найзууд" хэмээх буддын шашны байгууллагын ажилтнууд, Америкийн тусламжийн байгууллагын ажилтан Андрию С. Нациоз нар гэрчлэн ярьсан юм. Андриюгийн ярьснаар шарилуудыг цагаан хулдаасанд ороогоод, оршуулгын газрын ойролцоо ухсан нүх рүү шидэж булмагц, дараа нь ажилчид толгойгоо бөхийлгөн цөөн хором хүндэтгэл илэрхийлээд л өнгөрсөн байна.

Хиюук аавыг нь бас иймэрхүү байдлаар оршуулсан гэдэгт итгэлтэй байв. Хожим нэлээд хэдэн жилийн дараа нэгэн танилынх нь ярьснаар 1994 оны өвөл аав нь галт тэрэгний буудал дээр амьдарч байгаад 1995 онд эмнэлэгт хэвтжээ. Хулгай хийхээс үхэхийг илүүд үздэг аав нь нас барсан хүмүүсийн эхэнд байсан биз ээ.

Аавыгаа олох горьдлого тасарсан болохоор Хиюукт Чонжинд удах шалтгаан байсангүй. Тэр галт тэргээр туулайчилж эхлэв. Энэ нь тийм ч хэцүү байсангүй. Галт тэрэг зугуухан явж, ямар ч хуваарьгүйгээр зогсоно. Хиюук галт тэрэгний араас гүйж хоёр бүхээгийн холбоос төмрөөс барьж аван сармагчных шиг урт хүчирхэг гараараа биеэ дээш татан авирч гарна. Галт тэрэг хүмүүсээр битүү чихээстэй явах тул цагдаа нар хүмүүсийн дундуур чихцэлдэн байж замын бичгийг нь шалгана. Хиюук зай муутай газар дургүй тул галт тэрэгний дээвэр дээр авиран гараад дунд хэсэгт нь үүргэвчээ дэр болгон тавьж, цахилгааны утсанд хүрэхээс сэргийлэн хэвтээд өгнө. Хэдэн цагаар дээвэр дээр хэвтэхдээ галт тэрэгний хөдөлгөөнд бүүвэйлэгдэн, тэнгэрт түгсэн оддыг ширтсэн шиг явдаг байжээ.

Эхлээд Хиюук хотын захаас хэтэрдэггүй байлаа. Чонжинд буцаж ирээд өмнө нь лийр, эрдэнэ шиш хулгайлж иддэг байсан цэцэрлэг дээрээ ирвэл буутай харуулууд манадаг болсоныг мэдэв. Эндээс хоол залгуулах найдвар тасарсан тэрбээр Онсонд буцаж ирэв. Гэтэл Онсон Чонжиноос дээрдэх юмгүй болсон байлаа. Асрамжийн газрын хашаанд ургадаг байсан жимсний модод бас хувхайрсан байв. Асрамжийн газраас нь хэдхэн километрийн зайд дотуур байрных нь цонхоор нарийхан саарал усан зурвас буюу Түмэн гол үзүүр нь үл харагдан урсаж үзэгддэг байлаа. Тэр голын цаад талд холтсыг нь хуулаагүй модод, харуул хамгаалалтгүй эрдэнэ шишийн талбай байдаг. Энэ газрыг Хятад улс гэнэ.

Хятад, Хойд Солонгосын хил голын дагуу 1368 километр үргэлжлэх ба голууд аль аль нь Хойд Солонгосынхны хувьд Пякту, Хятадуудын хувьд Чангбай хэмээн нэрлэгдэх уулаас эх аван урсдаг ажээ. Өмнө талаараа, Солонгосын дайны үед Хятадын цэрэг АНУ-ын хүчнийг ялсан газар гэдгээрээ алдартай Ялу голтой хиллэнэ. Өнөөдөр Хятад ба Хойд Солонгосын албан ёсны бизнесийн ихэнх нь энэ голын Шар тэнгисээс эх авдаг хэсгээр дамжин явагддаг. Харин Түмэн гол Ялутай харьцуулбал горхи төдий бөгөөд гүехэн зөөлөн урсгалтай. Хойд зүгт Түмэн гол Хойд Солонгосын зүүн хойд хилийн зурвас болон урсах бөгөөд цаашид Владивосток руу дамжин үргэлжилнэ. Борооны улирлын үеэр, ус ихтэй байхад жирийн нэгэн сэлээд хил гарчихаар хэмжээний нарийхан гол.

Асрамжийн газрын хөвгүүдийг Түмэн голын ойролцоо тоглохыг нь хориглоно. Эргийн орчим тэр чигээрээ цэргийн хориотой бүсэд тооцогддог. Хэрэв хүүхдүүд голын салаануудад сэлж байгаад тэр бүс рүү ойртож очвол хилийн цэргийн буутай албан хаагчид хөөж холдуулна. Голын эрэг тэгш, хүн халхалчих хэмжээний өвс ургамалгүй. Гэвч Онсоноос урагш нэг хоёр цаг хэртэй алхаад хүн амын нягтшил бага, өндөр бут өвс ургасан эргийн хэсэг рүү очиж болно. Тэр хэсэгт нь хилийн цэгүүдийн байршлын хоорондын зай хол тул бут өвсөнд нуугдсаар хил давах боломжтой. Хилийн цэгүүдэд цэргүүд хоёроороо жижүүрлэдэг ба нэг нь унтаж нөгөө нь манаагаа хийнэ. Гэвч шөнийн нэг цагаас хойш хоёулаа унтаад өгөх нь элбэг.

1997 оны сүүлчээр Хиюук анх удаа Түмэн голыг гаталжээ. Хуурай улирал байсан болохоор усны түвшин бага, хилийн зурвасын хоёр талд барьсан элсэрхэг далангуудын үзүүр нийлэх гэж байгаа мэт харагдана. Ус, мөс шиг хүйтэн байсан учраас Хиюук цохиулсан мэт цочив. Хэдийгээр усны түвшин гүндээ л Хиюукийн цээжээр татаж байсан боловч, урсгал нь хөлийг нь газраас үе үе хөндийрүүлж байлаа. Тэр урсгал уруудан голыг ташуу гатлав. Эцэст нь голыг эрэг дээр гарахад

хувцас нь хуяг дуулга мэт дарайн хөлдсөн байна.

Хиюук өмнө нь Хятадыг хэзээ ч тэгтэл сонирхож байсангүй. Манайхтай л адил ядуу социалист орон гэж бодож байж. Эхлээд харахад нээрээ л өөрийнхөөс нь ялгагдах юмгүй мэт. Гэтэл голоос холдоод нутгийн гүн рүү ороход хэдэн километрээр үргэлжилсэн тариан талбай харагдана. Жижигхэн улаан тоосгон байшингуудын орой дээр саяхан хураасан эрдэнэ шишээ хальслан сагсанд хийж тавьсан ба хажууд нь хулуу, шош зэргийг хийсэн савнууд ч эгнэсэн байх ажээ. Хиюук жижгэвтэр хот руу зүглэв. Төсөөлөн бодсоноос нь хамаагүй амьд байх агаад такси, моторт дугуй, унадаг дугуйн такси гээд л зүсэн зүйлийн тээврийн хэрэгсэл хөлхөлдөнө. Хаягийг Хятад Солонгос хос хэл дээр бичсэн байх аж. Энэ хотын оршин суугчдын цөөнгүй нь солонгос гаралтай солонгосоор ярьдаг хүмүүс болохыг мэдээд Хиюук маш их баярлажээ. Хятадууд хүүг харангуутаа л Хойд Солонгосынх гэдгийг нь төвөггүй танив. Ганц хувцас муутайдаа ч биш, арван таван настай гэхэд дөнгөж метр дөчийн өндөртэй, тэжээл дутагдлын гол шинж болох биедээ томдсон толгойтой байсан нь түүнийг амархан таниулжээ. Хүүхдүүд хоол тэжээлийн хомсдолд ороход толгой нь хэвийн хэмжээтэй байх атлаа үе мөчийнх нь өсөлт зогсдог билээ.

Зах дээр хуучин хувин сав, гоёл чимэглэлийн зүйлс, эртний эдлэл зардаг нэгэн эртэй танилцав. Тэр Хиюукээс нүүрсний гал дээр халаадаг буюу цогийн индүүний аль болох хуучны загварыг нутгаасаа олж авчирч чадах эсэхийг нь асуужээ. Хойд Солонгосын бараг бүх айлд ийм индүү байдаг боловч хувцас нь хиймэл нийлэг материалаар хийгдсэн учраас хэрэглэх нь үгүй. Нутагтаа очоод индүүнүүдийг бараг үнэгүй шахам авч Хятадад ирээд нэг бүрийг нь арван доллараар зарж чамгүй ашиг олох болов. Олсон мөнгөөрөө ахин бараа авч Хятадад авчирч зарна. Вааран эдлэл, гоёл чимэглэл, зураг, чулуу гэх мэт. Эмэгтэйчүүд хүүхдээ үүрэхдээ хэрэглэдэг подеги хэмээх даавуу худалдан авч бараагаа дотор нь хийн нуруундаа бэхлээд л нааш цааш явдаг байжээ.

Хиюукийн хил гардаг хугацаа нь хоорондоо ойртсоор л. Хилийн харуулуудын анхаарал султай, идэвхгүй, эсвэл хахууль авдаг хэсгүүдийг олж тогтоов. Ус руу орохын өмнө бүх хувцсаа тайчиж орох нь зүгээр гэдгийг бас мэдэж авсан байна. Бараа болон хувцсаа усанд хүргэхгүйн тулд толгой дээрээ барин Түмэн голыг тэнцвэртэйгээр гаталж сурчээ. (Хувцас бараагаа гялгар уутаар чанга гэгч ороодог ба энэ нь бүдрээд усанд унавал эд зүйлээ норгохгүй байхад тустай) Хятадын цагдаагийнхан Хойд Солонгосоос ирсэн оргодлыг илрүүлбэл дор нь буцааж илгээдэг тухай мэдээлэлтэй болсон тул ирээд удахгүй.

Хиюук хулгай хийхээ болив. Гэдэс нь өлсвөл олсон мөнгөөрөө хоол аваад л идчихнэ. Оргодол шиг харагдахгүйн тулд өөртөө өмд, футболка, цэнхэр малгайтай хүрэм, пүүз зэргийг худалдан авч өмслөө. Тэр амьдралаа авч явах хэмжээнд хүрэхийг мөрөөддөг байжээ. Хувиараа бараа худалдан авах, зарах хориотой, аялах зөвшөөрөлгүйгээр улсын хилээр гарах гэмт хэрэг үйлдсэнд тооцогддогийг бид аль хэдийн мэдэх билээ. Хиюук арван зургаа хүрсэн болохоор албан ёсоор насанд хүрсэнд тооцогдож хэрэг үйлдвэл хариуцлагыг нь өөрөө хүлээхээр болсон байлаа.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ

ТОГЛООМ ТӨДИЙ ДҮРЭМ ЖУРАМ

Инуитчууд цасыг ойролцоо утгатай олон үгээр илэрхийлдэгтэй тун төстэйгөөр Хойд Солонгосчууд шоронг ч олон янзаар нэрлэнэ. Ажлаа таслах гэх мэт жижиг зөрчил гаргасан нэгнийг жибкюлсо буюу Ардын Аюулгүй Байдлын Агентлагийн хяналтад байдаг саатуулах газар руу, эсвэл родонг данриёндэ буюу хөдөлмөрийн лагерьт нэг, хоёр сараар хорьж, зам хучих мэтийн хүнд хөдөлмөр хийлгэж шийтгэнэ.

Хамгийн зартай нь куанлисо буюу "хяналт удирдлагын газар" гэсэн утгатай шорон юм. Энэ нь улсын хойд захад орших ба хэдэн зуун километр үргэлжилсэн газар нутгийг эзэлдэг байна. Сансрын мэдээнээс үзвэл тэнд 200,000 орчим хүн хоригдож байгаа юм. Ким Ир Сен засгийн эрхэнд гармагцаа, засаг захиргааг нь шүүмжилж, өөрийг нь эсэргүүцэх магадлалтай бүх хүн буюу газрын эздийн үр удам, тэрслүүд үзэлтэй улс төрчид, Японыг дэмжигчид, Христос шашны номлогчдыг энэхүү, өөрийнх нь санаачилгаар Оросын Гулагийг дуурайлган барьсан хөдөлмөрийн лагерь гэгчдээ цөлсөн байдаг. Гадаадын сонин уншиж байгаад баригдсан эр, согтоод Ким Чен Ирийн нурууны өндрийг шоглон ярьсан хүн, өдрийн тэмдэглэлдээ улс төрийн талаар буруу зүйл бичсэн эмэгтэй гээд төр засгийн удирдлагаа шүүмжилсэн учраас төрийн эсрэг гэмт хэрэгтэнд тооцогдож шууд л хорих лагерь руу илгээгдсэн жишээ олон бий. Хойд Солонгосчууд хоорондоо хэн нэгнийг шөнө дунд авч яваад ахиж сураг нь сонсогдоогүй тухай шивнэлддэгийг би сонссон. Квалисо буюу хөдөлмөрийн лагерьт очсон хоригдол насан туршдаа тэндээ ял эдэлдэг. Хөдөлмөрийн лагерьт хоригдох ялаар шийтгүүлсэн хүний аав ээж, ах эгч, төрөл төрөгсөд нь мөн хамт шийтгүүлэх ба үүнийгээ "бузартсан цусыг цэвэрлэх ажиллагаа" хэмээн нэрлэнэ. Цусан төрөл биш болохоор хань ижил нь энэ шийтгэлээс чөлөөлөгдөх боловч хууль ёсны гэрлэлтээ хүчээр салгуулах үүрэгтэй. Кванлисод ямар байдаг талаар мэдээлэл маш бага. Тэр талаар ярих хүн ч цөөхөн.

Бас нэг төрлийн хөдөлмөрийн лагерьийг киёовасо хэмээн нэрлэдэг нь "засан хүмүүжүүлэх төв" гэсэн утгатай, улс төрийн биш гэмт хэрэг үйлдэгсэд, тухайлбал хууль бусаар хил зөрчигсөд, хууль бус наймаа эрхлэгсэд, эсвэл зүгээр л наймаачид гэх мэт хүмүүсийг хорьж, үзэл санааг нь цэвэрлэж, зөв төлөвшүүлэх зорилготой ажээ. Энэ нь кванлисо буюу улс төрийн лагериас аюул багатай, хоригдох хугацаагаа давж чадвал эрх чөлөөтэй болох боломжтой ажээ.

Ким Хиюук 16 насныхаа төрсөн өдрийн дараахан Онсонд асрамжийн газраас холгүй, найзынхаа гэрт байхдаа баривчлагджээ. Найзынх нь гэр төрсөн гэртэй нь төстэй санагддаг учир очих дуртай байжээ. Хиюук Хятад руу явж ирээд удаагүй байсан бөгөөд анхны явалт нь араасаа олон аялал дагуулсан болохоор цагдаагийнхан хараандаа авсан байлаа. Хиюук найман сарын халуун буурахаар түлээ хагалахаар хүлээж байв. 16 цагийн үед байшингийн арын хашаанд зогсож байтал хоёр эрэгтэй хүн өөрийг нь ажиглан байгааг анзаарчээ. Хэдийгээр дүрэмт хувцас өмсөөгүй ч өөрийг нь баривчлахаар иржээ гэдгийг харцнаас нь мэдэв. Сүхээ аваад байшингийн өмнө талын хашаа даван зугтаая хэмээн бодсоор удаан алхав. Гэтэл байшингийн өмнө ч хүмүүс байгааг харлаа. Нийтдээ найман хүн байх шиг. Зугтаад нэмэргүйг мэдсэн Хиюук айдсаа дарахын тулд мод

хагалж эхэллээ.

Нууц цагдаагийнхан Хиюукийг Онсоны төвд байх штабтаа авчрав. Тэд улс төрийн хэрэг мөрддөг, үндэсний аюулгүй байдлын агентлаг Бовибугийн ажилтнууд байжээ. Хятадад байхдаа Хиюук Хойд Солонгос руу хулгайгаар орох гэсэн хүмүүст газрын зураг зурж өгсөн учраас бодсоноос нь ч ноцтой хэрэг тулгах шинжтэй болов. Хойд Солонгосын эрүүгийн хуулийн 52-р зүйлээр "Эх орноосоо урвасан" хэрэгт сэжиглэгдлээ. Уг зүйл нь: "Гадаад улс руу оргон зугтаасан, дайсны талд урвасан, гадаадын элчин сайдын яамнаас орогнол хүссэн, дайсагнасан орны байгууллага хувь хүмүүст тусалж, орчуулагч, хөтөч хийсэн, эд материал, оюун санааны тусламж үзүүлсэн тус улсын иргэн хэн боловч цаазаар авхуулах ялаар шийтгэгдэнэ" гэсэн утгатай.

Цагдаагийнхан модон савааны тусламжтайгаар Хиюукийн хэргийг хүлээлгэв. Нуруу, мөр, гар хөл, шилбэ гээд л толгойноос бусад газрыг нь гувруу таттал нь саваадаж байв. Хиюук эвхрэлдэн хэвтэж, цохиулж буй газраа гараараа хамгаалахыг оролдож байлаа. Өөрийн гэсэн хорих газар, шорон байхгүй учраас хүн хэвтэх, хажуулдах ямар ч зайгүй байгууллагынхаа жижигхэн өрөөнд хорих болов. Шөнө нь унтаж чаддаггүй болохоор өдөр нь өөрийн эрхгүй зүүрмэглэчихээд, зодож байхад хүртэл унтаа байдал нь гарч өгдөггүй байжээ. Цаашид юу болох талаар Хиюук тааварлах ч үгүй байв. 10 настайдаа л нэг удаа цагаан будааны боов хулгайлаад баригдсанаас биш урд нь ямар ч хэрэг хийсэн мултраад л гардаг байжээ. Харин одоо түүнтэй ноцтой гэмт хэрэгтэн, насанд хүрсэн хүн шиг хандаж тамлан зовоож байна. Хүүд ямар ч аргагүй, гарцгүй болж бүх юм төгсөж байгаа мэт санагдаж эхлэв. Байцаалтын үеэр ярьж чадахгүй, зөвхөн амандаа бувтнах төдий л болсон байлаа. Тамлаж байгаа хүмүүст асуусан бүхнийг нь ярьж өгсөн боловч тэдний мэдэхийг хүссэн зүйл нь нутаг руу нь хулгайгаар шургалахыг санаархаж байгаа хятад худалдаачдын хаана буйг мэдэх явдал аж. Гэвч Хиюук худалдаачид хаана байгааг үнэхээр мэдэхгүй байлаа.

Хэдэн сарын дараа Хиюукийг жирийн дэглэмтэй шоронд шилжүүлж, тамлалт ахиад л эхэллээ. Азаар Хиюукийн хэргийн талаар шүүх хурал болсонгүй. Хятадад байгаа худалдаачдыг нь олоогүй болохоор өөрсдөө хариуцлага хүлээхээс зайлсхийж, үндэсний аюулгүй байдлын газрын цагдаа нар эх орноосоо урвасан хэргийг нь хүчингүй болгожээ. Хиюук хууль бусаар хил нэвтэрсэн хэргээр шийтгүүлж, гурван жил хөдөлмөрийн лагерьт хоригдох ял сонсчээ.

Онсоноос дөчин километрийн зайд орших Хөүрөн хэмээх хилийн хотын захад орших "Кёвасо 12" шорон руу тэрээр галт тэргэнд гартаа гавтай ачигдав. Түүнийг буудал дээр бусад хоригдолтой нийлүүлээ. Хоригдлуудыг бүдүүн олсоор холбож, хотын дундуур алхуулан, уулын орой дээр байх лагерь руу мацуулав. Том гулдан хаалга чихран онгойж шинээр ирэгсдийг угтжээ. Хаалганы дээр Ким Ир Сений хэлсэн үгээс иш татсан лоозон байна. Хиюук лоозон руу харахаас ч зүрхшээж, газар ширтсээр хаалгаар орлоо.

Хиюукийг эхлээд эмнэлэгт авчран жин, өндрийг нь нь үзжээ. Лагерьт дүрэмт хувцас байхгүй учир хоригдлууд өөрсдийнхөө хувцастай хоригдоно. Цамц нь захтай бол хоригдлуудын статуст зохихгүй гээд урж хаяна. Тод өнгийн хувцас байвал хураагаад авчихна. Хиюукийн Хятадаас худалдаж авсан цэнхэр хүрмийг харуулууд хураажээ. Хамт байсан хоригдол пүүзийг нь өөрийн болгосон байна.

Уг лагерьт мянга таван зуун хоригдол байсны ихэнх нь настай хүмүүс. Хиюук хамгийн жижиг биетэйд орох боловч бас ч бусдад дээрэлхүүлэхээргүй хүчтэй. Хамгийн хачирхалтай нь, тэнд очсон хойноо бодтол үндэсний аюулгүй байдлын газарт хоригдох үедээ хамаагүй сайн хоол идэж байж. ҮАБГ хоригдол цөөтэй учир ажилтнууд нь захаас гоймон худалдан авч хоригдлуудаа хооллодог байжээ. Гэтэл энд эхний оройн хоолыг идсэнийхээ дараа л хоригдлууд болох настай хүмүүс яагаад ийм туранхай, эвхэрсэн байгаа, мөр нь цамцныхаа захаар хувцасны өлгүүр шиг цухуйж буйн учрыг ойлгожээ. Харуул хоолоо "будааны өнхрүүш" хэмээн нэрлэсэн боловч үнэн хэрэгтээ эрдэнэ шиш, хальс, гол, навч зэргийг машиндаж хийсэн байв. Теннисний бөмбөгөөс томгүй тэр зүйлээ оройн хоол гэж нэрлэн, хааяа хэдэн шош нэмж өгнө.

Хоригдлууд өглөө долоон цагаас орой нар шингэтэл ажиллах ёстой. Уг лагерь мод, тоосгоны үйлдвэр, уурхай болон газар тариалан гэх мэт олон төрлийн үйлдвэртэй. Хөдөлмөрийн лагериуд гэрийн тавилгаас эхлээд унадаг дугуй гээд үйлдвэрлэхгүй юм үгүй. Хиюук мод цавчдаг хэсэгт хуваарилагдав. Хэт намхан болохоор хоригдол тус бүр хэдэн мод огтолсныг тоолох, хэр хугацаагаар амарсан зэргийг бүртгэх ажилд томилогдов. Гэхдээ энэ ажилдаа Хиюук дургүй байлаа. Өөрөөсөө дор хаяж арван насаар ах хүмүүсийг тэр яаж хянах болж байна? "Тэд ямар шийтгэл авна, чи ч бас тийм шийтгэл хүлээнэ. Оргохыг оролдсон хэн ч буудуулна. Тэгэхээр чи ч бас буудуулна гэж мэдээрэй" хэмээн ажилд хуваарилсан хуяг архирсан байна.

Хиюукийн ээлжин дээр биш ч нэг хоригдол зугтаахыг оролджээ. Хамт ажилласан хүмүүсээсээ сугаран үлдэж мод руу гүйн ороод гарц хайж эцэж ядартлаа яваад эцэст нь төв хаалган дээр ирж өршөөл гуйсан байна. Лагерьин хашаа гурван метр өндөр бөгөөд дээгүүр нь хурц өргөстэй төмөр тор татсан учир эндээс хэн ч зугтах боломжгүй. Тэр хоригдлыг агуу их удирдагчийн энэрэнгүй сэтгэлийн ачаар өршөөн хэлтрүүлсэн гэнэ.

Хоолны үеэр, унтахдаа, мөн үзэл суртлын хичээлд суух үеэр л хоригдлууд ажилладаггүй байв. Шинэ жилийн баярын үеэр Ким Чен Иррийн ард түмэндээ хүргэсэн баярын мэндчилгээг үг бүрчлэн цээжиллээ. "Манай ард түмэн ирж буй шинэ жилдээ гаргасан бодлого, дүрэм журмаа чанд биелүүлэн, үзэл суртал, шинжлэх ухаан, технологи, цэрэг зэвсгийн хүчээ бишрэн хүндэтгэж, олсон амжилтаа бататган, шинэ шатанд хүрэх ёстой" хэмээн уг мэндчилгээнд дурдсан байжээ.

Шөнөдөө эрчүүд нүцгэнээр, хүйтэн цардмал шалан дээр унтах ба нэг өрөөнд тавин хүн хоригдоно. Хөнжлийн тоо цөөн учир хүмүүс дулаацах гэж бие биедээ наалдан унтана. Заримдаа арван хүн ч нэг хөнжил нөмрөх тохиолдол гарна. Ярих ч сөхөөгүй ядарсан байх учир хоригдлууд бие биеийнхээ нурууг маажиж, хөлийг нь үрж дулаацуулаад нам унтацгаана. Нэг хөнжилд аль болох олон хүн багтаахын тул хөл толгойгоо зөрүүлэн хэвтэцгээж, бие биеийнхээ хөлийг үрж дулаацуулна.

Хиюук анх ирэхдээ хоригдлуудыг хуягуудаас дутахгүй харгис, зэрлэг хэмээн бодож, ихэд айн цэрвэж байлаа. Аймшигтай хүчирхийлэгч, засаршгүй гэмт хэрэгтнүүд, бэлгийн гаж донтонгууд байх юм бодож байтал харин ч эсрэгээрээ. Хүмүүсийн бэлгийн дур хүслийг өлсгөлөн номхотгосон байлаа. Бэлгийн харилцаа, зодоон цохион маш цөөхөн. Нийлдэг гудамжны хүүхдүүдээс нь харин ч

хавьгүй дээр санагдав. Ихэнх нь зах дээр наймаа хийсэн, эсвэл хил гарч байгаад баригдсан эдийн засгийн гэмт хэрэгтнүүд. Хулгайчид нь зөвхөн хоол хулгайлсан хэргээр хоригдсон байх аж. Тэдний нэг хамтралын мал хариулдаг асан, дөчин настай малчин эр байх. Хийсэн хэрэг нь үхсэн тугалыг мэдээлэлгүй гэртээ аваачиж, махыг нь чанаж эхнэр хүүхдээ хооллосон гэнэ. Хиюукийг түүнтэй танилцах үед арван жилийн ялаасаа тавыг нь эдэлчихсэн байжээ. Хиюук үргэлж түүний суганд шигдэж унтана. Малчин зөөлхөн яриатай, сайхан ааштай хүн байсан боловч ямар нэг шалтгаанаар ахлах хуягуудын нэг нь түүнийг нэг нүдээр үзэхгүй. Эхнэр хүүхэд нь эргэхээр хоёр ч удаа ирсэн боловч уулзуулсангүй, эргэлтийг нь ч оруулсангүй. Уг нь хуягууд өөрсдийн ивээл дор байдаг хоригдлуудын эргэлтийг нь оруулж тусалдаг байсан юмсанж. Малчин залуу өлсгөлөнгөөр бие баржээ. Унтахаар хэвтээд л босож ирсэнгүй. Шөнөдөө нэг нь өнгөрөх явдал хоригдлуудын дунд жирийн үзэгдэл. Өлсгөлөнгөөр үхэж буй хүмүүс ихэвчлэн цөсөөрөө бөөлжиж, биед нь байсан шингэн гарч дуусахад жижиг хөөс уруул дээр нь үлдэнэ. Өглөө болтол хэн шарилыг гаргая гэж бодохгүй.

Өглөө хуяг ирэхэд өрөөнийх нь хэн нэгэн тэр тэр үхсэн гэж мэдээлээд л гүйцээ. Эрчүүдийн мод цагаалдаг уулан дээр шарилуудыг аваачиж чандарлана. Гэр бүлийнхэн нь эргэж очихоос нааш хайртай, дотнын хүмүүс нь нас барсан тухай мэдэхгүй. Ганц Хиюукийн өрөөнд л гэхэд долоо хоногт хоёроос гурван хүн үхдэг байжээ.

"Хэн ч өөрийгөө үхчихнэ гэж боддоггүй байсан. Бүгд амьд гарч, гэрийнхэнтэйгээ уулзана хэмээн мөрөөддөг байлаа. Гэтэл үхэл гэнэт л ирнэ" гэж олон жилийн дараа Хиюук Сөүлд амьдарч байхдаа надад ярьсан юм. Тэр үед Хиюук Варшавт хүний эрхийн хуралд оролцож, Хойд Солонгост хүний эрх хэрхэн зөрчигддөг талаар илтгэл тавиад дөнгөж буцаж ирсэн үе юм. Дараа нь Аушвицаар бас очиж, туулсантай нь адилхан зүйл тэнд болж байсан тухай сонссон аж. Хоригдож байсан лагерьт нь зарим нэгийг нь цаазалж, нөгөө хэсгийг нь үхтэл зоддог байсан ч хорт хийгээр утаж, үй олноор нь хөнөөж байгаагүй. Хойд Солонгосын дэглэм өлсгөн үхүүлэх чадалтай, өрсөлдөхүйц аргаар салдаг зуршилтай.

"Кёвасо 12"-т өнгөрөөсөн амьдралынхаа талаар Ким Хиюукийн ярьсан зүйлсийг батлах ч, үгүйсгэх ч аргагүй юм. Гэвч ярьсан зүйлийнх нь ихэнх хөдөлмөрийн лагериудад хоригдож асан, бас хуягаар ажиллаж байгаад Өмнөд руу зугтаж гарсан хүмүүсийн яриатай таарсан билээ.

Хиюук "Кёвасо 12"-оос 2000 оны долоодугаар сарын 12-нд суллагдсан байна. Тэр үндэсний аюулгүй байдлын газарт хоригдсонтойгоо нийлээд нийт гурван жилийн ялаас жил найман сарыг нь эдэлчихээд байв. Дөхөж буй Хөдөлмөрийн намын ойг тохиолдуулан өршөөл үзүүллээ гэж тайлбарласан боловч түүнээс хэцүү гэмт хэрэгтнүүд олноороо ирж байсан тул зай гаргах гэж л намайг сулласан байх гэж Хиюук ярьсан юм.

1996 оны 12 сард Ким Чен Ир "Хүнсний асуудал эмх замбараагүй байдал үүсгэж байна. Хувиараа наймаа хийх явдал нь Хөдөлмөрийн намыг тарж бутрах аюулд хүргэж болзошгүй. Хүмүүсийг хүнсний асуудлаа өөрсдөө шийд хэмээсэн нь тариачид, ганзагын наймаачид болон захыг хөхиүлэн дэмжсэнтэй адил бөгөөд үүнээс улбаалан Чехословак, Польш улсад болсон шиг нам хагаран бутрах аюул нүүрлэж мэднэ" хэмээн цохон тэмдэглэсэн юм. Ким Чен Ир дэлхийн

бусад дарангуйлагчдын адилаар ганцаар ноёрхсон засаглал үнэмлэхүй эрх мэдэлтэй байх ёстойг сайн мэддэг байжээ.

Хүнсний хямрал тогтворжоод ирэх үед Ким Чен Ир өнгөрсөн жилүүдэд хэт зөөлөн бодлого барьж байснаа ухаарч, алдаагаа засахаар улайрч эхэллээ. Шинээр гарч ирсэн эдийн засгийн гэмт хэрэгтнүүд болох ганзагын наймаачид, тариаланчид, хууль бус наймаачид, Зүүн Европ болон ЗХУ зэрэг коммунизмын санаанаас ухарсан улс гүрнүүдэд боловсрол эзэмшсэн хүмүүсээр шоронгууд дүүрэв. Өмнөх байдал руугаа буцан орохоор тэмүүлэх дэглэмийнхэн өөрсдөд нь саад хийж мэдэх хэн бүхнийг баривчлан хорих болов.

Үүнтэй зэрэгцэн Ким Чен Ир 1046 км үргэлжлэх Хятадын хил рүү нэмэлт хүч илгээж харуул хамгаалалтыг чангатгалаа. Хойд Солонгосын засгийн газар Хятадын эрх мэдэлтнүүдээс өөрийнх нь улсаас оргож нутагт нь очсон иргэдийг баривчилж, буцаан тушаах хүсэлт тавьснаар Хятадын нууц цагдаагийнхан хилийн ойролцоох хот тосгодын зах дээгүүр хоол эрэн тэнүүчилж буй нөхдийг агнахаар харуулд гарах болжээ. Мөн Хойд Солонгосын нууц цагдаагийнхныг Хятадын захуудаар эргүүл хийлгэхийг ч зөвшөөрсөн байна. Хамгийн аюултай нь тэдгээр нууц ажилтнууд өөрсдөө оргон зугтаагсдын дүртэй байв.

Хэрэв хил зөрчихдөө зөвхөн хоол ундны эрэлд явсан бол шоронд хоёр сар хүртэлх хугацаагаар хоригдох, харин хил давуулан хууль бус наймаа хийсэн эсвэл Өмнөд Солонгосын шашныхантай холбоо тогтоохоор оролдсон бол хөдөлмөрийн лагерьт хоригдох ялаар шийтгүүлж байлаа.

Гэр оронгүй, тэнэмэл хүүхдүүдийг ч өршөөсөнгүй. Галт тэргэнд замын бичиггүй зорчсон, Хятад руу зугтаасан хэнийг ч болов нас хүйс харгалзахгүй хатуу шийтгэнэ хэмээн Ким Чен Ир зарлигдаж байв. Есдүгээр сарын 27-ноор нэрлэсэн 927 хэмээх төвүүдийг байгуулсан нь орон гэргүй хүмүүсийн хоргодох газар мэт ойлгогдох боловч үнэн хэрэгтээ албан бус шорон байжээ. Тэдгээр төвүүд нь бохир заваан, халаалтгүй бас хоол унд тааруу. Иймээс гэр оронгүйчүүд баригдаж, энэ газарт орохгүйн тулд цагдаагийн нүдэнд өртөхгүй байхыг хичээх болов.

Чонжин хот энэ бүх жилүүдэд ачааны хүндийг үүрсэн байна. Чусан гүрний үеэс л цөлөгдөгсөд, тэрс үзэлтнүүд, буруу номтнуудын эх нутаг байсаар ирсэн Чонжин улс төрийн төвийн хувьд ч бас л хатуу хөтүүг туулах болов. Бусад хэсэгтэй харьцуулахад Чонжинд хамгийн түрүүнд хүнсний хангалт ирэхээ больсон. Үүнийг зарим хүн Ким Чен Ир-ийн Чонжинд дургүйнх хэмээн жиг жуг гэлцдэг байлаа. Хамхуныг үл тооцвол Чонжины хүнс тэжээлийн дутагдлын хэмжээ улс орон даяар хамгийн өндөр гарсан байна. Гэхдээ үүний ачаар энд далд эдийн засаг сайн хөгжсөн билээ.

"Төр засаг биднийг яагаад өөрсдөө амьдраг гээд орхичихож болдоггүй юм бол?" хэмээн захын авгайчуул өөр хоорондоо шивнэлдэх боллоо. "Хэн ч төр засгийг сонсохоо больсон" хэмээн нэг залуу хэдэн жилийн өмнө надад ярьж билээ.

Хойд Солонгосын аль ч хоттой адилгүй, Чонжин л намын хараа хяналтаас ангид байлаа. 2005 он гэхэд Чонжины Сунам улсаа хамгийн том захад тооцогдох болсон байв. Барааны сонголтын хувьд Пхеньянтай харьцуулшгүй. Хан боргоцой, киви, жүрж банан, герман шар айраг, орос архи

гээд л бүх зүйл байна. Зах дээр Холливудын киноны хууль бусаар олшруулсан DVD нууцаар зарна. Тусламжаар ирсэн цагаан будаа, эрдэнэ шишийг нээлттэй арилжина. Биеэ худалдах явдал цагаандаа гарчээ. Чонжины галт тэрэгний буудал дээр биеэ үнэлэхээр зогсох эмэгтэйчүүд ямар зорилготой зогсож буйгаа мэдэгдэхээс айхаа больжээ. Пхеньянтай харьцуулахад Чонжин харьцангуй баруунжаад байлаа.

Гэтэл Ким Чен Ир улсынхаа гуравдагч том хотыг намынхаа үндсэн шугамаас хазайлгахыг хүссэнгүй. Хэдийгээр шатахуунгүйн улмаас сул зогсож байгаа ч Чонжины ган, нэхмэлийн ба бусад үйлдвэрүүд улс эх орноо аж үйлдвэржүүлэх бодлогынх нь салшгүй хэсэг болох ёстой байв. Цэрэг армийн талаас нь авч үзсэн ч Чонжин Хойд Солонгосын хоёр дахь том дайсан Японтой ойрхон оршдог гэдэг утгаараа ач холбогдлоо алдахгүй. Чонжины өмнөд эргийн шугам нь Япон руу чиглэсэн зэвсэг, төхөөрөмж, анги нэтгэлээр дүүрсэн байжээ. Үүний нэг нь 1998 онд пуужингийн туршилт хийсэн Мусудан-ри холын тусгалтай пуужингийн бааз юм.

Эцгийгээ нас барсны дараа, Ким Чен Ир Чонжинд байрлах Зургаадугаар армийг цэвэрлэх ажиллагаа явуулж эхэлсэн байна. Зургаадугаар арми бол Хойд Солонгосын сая цэрэгтэй армийн хуурай замын цэргийн ангиудын нэг бөгөөд хотын төвөөс өмнө зүгт орших Нанам дүүрэгт штаб нь байдаг ажээ. Нэгэн шөнө хүмүүсийн ид нойрон дунд хэдэн арван машины моторын бөглүү дуу гарч, утааны эхүүн үнэр үнэртсэн нь зургаадугаар армийн нийт 3000 цэрэг, танк, хуягт машинууд хотоос гарч байсан нь тэр аж. Цуваа эхлээд Нанам буудлын хажууд цуглаж, дараа нь эвдэрч хонхойсон замаар тэнгэр нүргэлэх мэт их чимээ гарган хөдөлсөн гэнэ. Оршин суугчид цочиж айсан боловч хэн ч хаалгаараа толгойгоо цухуйлгаж зүрхэлсэнгүй.

Гэтэл тэр шөнө юу болсон талаар Родон Синмун сонинд ч, зурагтаар ч ямар нэг мэдээлэл гарсангүй. Хойд Солонгосын армид эрчүүд 10 жил цэргийн алба хаадаг ба гэрээс нь аль болох хол ангид хуваарилдаг тул ар гэрийнхэнтэйгээ холбоо барих ямар ч аргагүй учраас юу болсон тухай мэдээлэл цэргүүдээс авах ямар ч боломжгүй.

Үнэн зөв мэдээлэл байхгүй болохоор хүмүүс цуурч эхлэв. Арми Америкийн зулбасгануудтай нөгөө удаан хүлээсэн дайнаа хийх юм гэнэ. Өмнөд Солонгосынхон дайрах гэж байгаа гэнэ. Төрийн эргэлт гарах гэж байгаа юм болов уу гэх мэтчилэн элдэв таавар тарж байлаа. Зургаадугаар армийн офицерууд Чонжины боомт, цэргийн анги нэтгэлүүдийг мэдэлдээ авах гэж байгаад бүтэлгүйтсэн, яг тэр үед хэсэг хүн хуйвалдаж, Ким Чен Ирийг хөнөөх гэж байсан гэсэн яриа маш түргэн тархжээ.

Хуйвалдагсдыг Хятадын бизнесмен санхүүжүүлж байсан гэж Ким эмч эмнэлэг дээрээ байхдаа сонсчээ.

Цэцэрлэг дээр багш нар хоолны өрөөнд цугларч хуйвалдагсдын нэгийнх нь хамаатан гэж ярих тогоочийн амнаас юу болсон талаарх яриаг сонсоцгоов. Хуйвалдааныг Өмнөд Солонгосын Ерөнхийлөгч Ким Янг Сам санхүүжүүлсэн гэж тэрээр хэлсэн байна.

Дунд сургуулийн нэгэн багш хуйвалдаанд оролцсон хүмүүстэй хамаатай гэгдэх хөршүүдийнх

нь нэгийг бузартсан цустай учраас гурван сартай нялх хүүхдийнх нь хамт шөнөөр ачаад явахыг мэджээ. Шөнө дунд машин ирээд л ачаад явчихсан гэнэ. Хүүхдийг нь машины тэвш рүү зүгээр л эд бараа шиг шидчихсэн гэж тэр багш Ми Ранд шивнэсэн юм. Түүнээс хойш, гуравхан сартай нялх амьтан машины тэвшин дээр нааш цааш бөмбөрөн нүүр амаа цохиулан яаж зовсон бол гэхээс Ми Раны сэтгэл өвдөж, энэ явдал өдөр нь бодогдож, шөнө нь зүүдлэгдсээр их удсан билээ.

Эцэст нь Зургаадугаар арми татан буугдаж, Вонсаны Есдүгээр армийн анги нэгтгэлүүд орыг нь эзэлсэн аж. Гэхдээ уг Армид юу тохиолдсон, ямар шалтгаанаар татан буугдсан шалтгаан одоо хүртэл нууц хэвээр.

Тагнуулын шинжилгээнд төрийн эргэлт хийх оролдлогуудын талаарх мэдээллийг оруулахгүй. Бослого тэмцэл, төрийн эргэлт ба алан хядлага хийх оролдлого гарч байсан гэсэн мэдээ бий ч нотлогдсон нь үгүй. Зургаадугаар армийн талаар хамгийн үнэмшилтэй тайлбар нь Ким Чен Ир санхүүгийнх нь талаар илүү хяналттай болохыг хүссэн бололтой. Хойд Солонгосын цэргийнхэн нарсны мөөг, загасны хоолоос авахуулаад, сэргээх эм хүртэл янз бүрийн бүтээгдэхүүнийг экспортолж, мансууруулах бодис хүртэл гадагш нь наймаалж их хэмжээний валют олдог байв. Чонжинд болон хаа сайгүй зарж асан тусламжийн будаа цэргийнхний гараар орж хар зах дээр гарсан нь тодорхой байлаа. Цэрэгт мафи маягийн бүлэглэл үүсч, томчууд нь хээл хахуульд автаж, асар их ашиг хонжоо хувьдаа олсон байх магадлалтай. 1998 онд Өмнөд Солонгос руу оргосон цэргийн офицер, зургаадугаар армийнхан Чонжины захад хамтралуудын тарьдаг мансууруулах бодис зарж, ашгаас нь хүртдэг байсныг Өмнөдийн хилийн байцаагчдад ярьсан тухай мэдээлэл бий.

Арми татан буугдсаны дараа Чонжинд хачирхалтай зүйлс их гарах болжээ. Пхеньянаас прокурорын тусгай баг ирж, үйлдвэрүүд дээр авлига байгаа эсэхийг хатуу чанга шалгаж эхлэв. Үйлдвэрүүдээс хамгийн чанга гараар орсон нь Кимчакийн Гангийн үйлдвэр байлаа. Энэ үйлдвэр 90-ээд оны туршид ажиллаагүй, 10 яндангийн зөвхөн хоёроос нь л утаа гарч харагддаг байсан ба цехийн зарим дарга ажилчдаараа хаягдал төмөр түүлгэж, Хятадуудтай хүнсээр солилцдог байжээ. Энэ нь хүрэлцэхээ болимогц машин, тоног төхөөрөмжөө задалж зарах болжээ. Ингээд олсон мөнгөнийхөө ядаж хагасаар нь ажилчдадаа хоол хүнс худалдан авдаг байжээ.

Уг гангийн үйлдвэрийн 10 гаруй удирдах ажилтныг буудан хороожээ. Ардын Аюулгүй Байдлын Хороо Сунамын захын хажуу дахь шавар шавхай болсон газарт цаазлах үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үүний дараа прокурорууд жижиг байнуудыг онилж эхэллээ. Тэд хоолоор солихын тулд телефон утасны шугамаас зэс утас дэлссэн хүн, ямааны хулгайч, эрдэнэ шиш ба малын хулгайчид, зах дээр цагаан будаа зарагсдыг намнаж эхлэв.

1997 онд хулгай хийсэн, юм дарж нөөцөлсөн, үр тариа, будаа зарсан зэрэг хүмүүсийг социалист амьдралын хэв маягийг доромжлон гутаасан хэргээр цаазлах ялаар шийтгэнэ гэсэн зар тарсан байв.

Хойд Солонгосын эрүүгийн хуулинд хүний амь санаатайгаар хөнөөх, нам засгаасаа урвах, алан хядах үйл ажиллагаа явуулах, төрийн болон ард түмний эсрэг гэмт хэрэг үйлдэх зэрэгт цаазаар

авна хэмээн заасан байдаг боловч үнэн хэрэгтээ Хөдөлмөрийн Намын нэр хүндийг ямар нэгэн хэмжээгээр гутаасан хэнд ч энэ ял хамаардаг юм. Өмнөд нутаг руу дүрвэгсдийн яриаг сонсож байхад завхайрсан, биеэ үнэлсэн, баривчилгааг эсэргүүцсэн, замбараагүй байдал гаргасан хэргээр 1990-ээд онд хүмүүсийг олноор нь цаазалж байжээ. Хиюукийн амьдарч байсан хилийн ойролцоох хотод л гэхэд архидан согтуурч нүцгэн гүйснийхээ төлөө дөрвөн оюутан цаазаар авахуулсан байна.

Өмнө нь тэнд юм бүхэн замбараатай, хатуу чанга, ойлгомжтой, гэмт хэрэг багатай байлаа. Гудамжны танхайчуудын зодоон, хардалтын улмаас л хүний амь үрэгддэг байж. Бие биеэсээ илүү гарах юмгүй болохоор хулгай ч бага байв. Хүмүүс ямар дүрэм журмыг сахин биелүүлж, аль шугамаас давахгүй амьдрах ёстойгоо сайн мэддэг байлаа. Гэтэл одоо дүрэм журам тоглоом төдий болж амьдрал замбараагүй, аймшигтай болжээ.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ

ХУДГИЙН МЭЛХИЙ

Жун Сан нэгэн зун амралтаар гэртээ ирэх үедээ гэмт хэрэгтнийг нийтийн өмнө хэрхэн цаазлахыг харжээ. Хэдэн өдрийн туршид чанга яригчтай машин хотыг тойрон давхиж, цаазлах товыг зарлан байлаа. Багийн дарга нар айлуудын хаалгыг тогшиж, тов сонссон эсэхийг шалгаж байв. Жун Сан өрөвчхөн сэтгэлтэй, хүн, амьтны цус үзэж чаддаггүй учраас очихыг хүссэнгүй. Арван хоёртой байхад нь аав нь нэг удаа хүчээр тахиа гаргуулжээ. Тахиаг хүзүүнээс нь барихдаа гар нь чичрэхийг харсан аав нь "Чи ийм байж яаж эр хүн болох гэсэн юм бэ" хэмээн зэмлэсэн байна. Ааваасаа айхын эрхэнд хүзүүг нь хуга мушгиж үүргээ биелүүлсэн боловч орой нь хоол идэхээс татгалзав. Хүн үхэхийг харна гэдэг түүний хувьд төсөөлшгүй аймшигтай зүйл санагдана. Очихгүйгээр баттай шийдсэн байлаа. Гэвч цаазлах өдөр ирж, хүн бүхэн хошуурахад Жун Саны хөл өөрийн эрхгүй олныг даган одов.

Ми Ран, Жун Сан хоёрын шөнө алхаж хүрдэг байсан халуун рашаанаас холгүй жижиг голын элсэрхэг далан дээр цаазын ялыг гүйцэтгэхээр болсон байлаа. Жун Саныг очиход тэнд аль хэдийн гурван зуу орчим хүн цуглаж, хүүхдүүд сумны хонгио түүхийн тулд аль болох урагшаа гарахыг хичээнэ. Жун Сан ч байдлыг сайн харах санаатай тохойгоороо нудран урагш тэмүүлэв.

Ардын Аюулгүй Байдлынхан горхины хажуу талын ойн цоорхойг түр шүүх болгон прокуроруудад ширээ засаж, хоёр том чанга яригч байрлуулжээ. Хэрэгтэн шонгийн модонд авирч, зэс утас таслан зарсан хэргээр яллагдах гэж байлаа.

"Энэ этгээдийн хийсэн үйлдэл ард түмний өмч хөрөнгөд ноцтой хохирол учруулж, манай социалист системийг сүйрүүлэх зорилготойгоор хийгдсэн байна. Энэ бол социалист улсын дайснуудад тусалж, төр засгаасаа урвасан хэрэг яах аргагүй мөн" хэмээн паржигнасан чанга яригчаараа яллагч бархирахад өмгөөлөгчийн үүрэг гүйцэтгэмэр аядах нэгэн хуульч "үнэн зөв" гэсэн ганц өгүүлбэр л хэлэв. Тиймээс хэрэгтэнд цаазаар авах ял оноож даруй гүйцэтгэсүгэй гэж гуравдагч этгээд хэлснээр, ялыг гүйцэтгэхээр болов.

Яллагдсан эрийг толгой, цээж, хөлнөөс нь модон шонд хүлсэн байв. Гал нээх салааныхаа, хүлсэн олс руу гурван чиглэлд тус бүр гурван сум, нийт есөн сумаар буудах ёстой. Эхэнд буудуулсан толгой унжихад ирэхээр амьгүй бие нь доош унаж хамгийн сүүлд хөл хэсэг нь суларснаар хэрэгтэн газар унана. Энэ нь хэрэгтэн үхэхдээ хүртэл ард түмнээсээ уучлал гуйж байгаа мэт харагдуулах арга юм.

Жижиг хулгайн төлөө алах ял хэт хүнддэж байна гэсэн Жун Сан шиг бодолтой хүмүүс цугласан олны дунд цөөнгүй байлаа. Цахилгааны шугамууд тэртэй тэргүй ажиллагаагүй. Хулгайлсан зэс нь хэдэн уут будаа хүрэх төдий л байсан биз.

"Хөөрхий минь. Охин дүү нар нь яаж амь зууна даа. Хоёр ч дүүтэй хүн шүү дээ" хэмээн Жун

Саны хажууд зогссон хүн хэлэх нь сонстов. Жун Сан эцэг эх нь нас барсан учраас хамгаалах хүнгүй амьтан юм байна даа хэмээн бодлоо. Ми Ран харин над шиг л ядуу уурхайчин эцгийн хүүхэд байх хэмээн харамсангуй бодсон аж. Жун Саныг ингэж төсөөлөн бодож дуусаагүй байхад буун дуу гарлаа. Толгой, цээж, хөл. Толгой нь устай бөмбөлөг шиг зад тавьж, газраар цус нэлийн, арай л олны хөл доогуур урссангуй. Жун Сан бөөлжих шахаад, цугларсан олны дундаас арай гэж гаран гэр рүүгээ яарлаа.

Чонжинд очих бүрдээ Жун Сан улсынхаа болохгүй байгаа зүйлүүдийг улам ихээр олж харах болов. Их сургуулийн хашаанд болохгүй бүхнээс хол, тайван сайхан амьдардаг учир гадуур юу болж байгааг тэр бүр мэдэхгүй. Хоол дутагдаж, цахилгаан ирэхгүйн зовлонг тэр бараг үзээгүй. Пхеньяны том их сургуулийн оюутнууд давуу хотын давуу эрхтэй иргэдийн тоонд орно. Сургуулийн хашаанаас гармагц бодит байдал хацрыг нь алгадаад авах шиг угтдаг байв.

Багадаа амттай хоол иддэг байсан зоогийн газар, анх Ми Раныг харсан кино театр гээд сайхан дурсамжуудыг нь сэргээдэг газрууд бүгд хаалгаа барьжээ. Үндэсний баяр буюу Ким Ир Сен, Ким Чен Ирийн төрсөн өдрүүдээс бусад үед цахилгаан ирэхгүй.

Харанхуй болохоор эх эцгийнхээ үглэж яншихыг сонсон гэртээ л сууна. Жун Саны Япон дахь хөрөнгөтэй өвөө нь нас барж, үлдсэн хүмүүс нь ядуу хамаатнууддаа тэр болгон мөнгө явуулахаа больсон байлаа. Ээжийнх нь хэрэх өвчин бүр дордон, зах руу явж ч чадахгүй, Японоос авчирсан үнэтэй оёдлын машинаа ч хэрэглэж дөнгөхгүй болжээ.

Шөнө болгон яг адилхан. Аав нь тамхиныхаа галыг улалзуулан, харанхуйд сууж, байн байн уртаар санаа алдах нь муу мэдээ дуулгахын шинж бөгөөд "Нөгөө муу хэн багш чинь явчихаж гэнэ. Чи санаж байна уу" гэж Жун Санаас асууна. Тооны, хятад хэлний багш нар бүгд хорвоог орхисон байлаа. Жун Санд Зүүн Европын кино урлагийн тухай сэтгүүлээ хааяа зээлүүлдэг байсан уран зохиолын багш нь мөн үгүй болж. Эдгээр багш бүгд тавь гаран насны сэхээтнүүд, сургууль цалингаа өгч чадахаа больсноос хойш амьдрах өөр аргагүй болсон хүмүүс байлаа. Өмнө нь Пхеньянаас амралтаар ирэхээрээ Жун Сан сургуулиараа орж багш нартайгаа уулзах дуртай байв. Багш нар нь ч сайн шавиараа бахархан таатай угтана. Гэтэл одоо ойрхон өнгөрөхөөс ч дөлдөг болов. Өөр хэн нэгэн хайртай багш нь өнгөрсөн тухай сонсохоос эмээнэ.

Үхэл залуучуудыг ч тойрсонгүй. Жун Саны ээж ангийнх нь хүүхдүүд нас барсан тухай, мөн их сургуулийнхаа шалгалтанд унаад цэрэгт явсан хүүхдүүдийн тухай дуулгана. Жун Сан ангийнхантайгаа холбоо тасарсан боловч цэрэгт явсан нь лав өлсөж үхээгүй байх гэж бодлоо. Учир нь Ким Чен Ир сонгун онол буюу "бүхний түрүүнд цэргийнхэн" гэдэг санааг дэвшүүлсэн болохоор цэргийнхнийг хангалтаар таслах нь бага гэсэн ойлголттой байв. Гэтэл түүний бодол буруу байлаа. Чонжины эргэн тойронд холхих цэргүүдийн бүс туранхай биед нь томдож, олмыг нь эцэс дээр нь тавьсан ч холхиндог харагдана. Хоол тэжээлийн дутагдлаас болж царай нь цонхийсон, ихэнх нь дөнгөж метр тавин хоёр орчим өндөртэй. (Хойд Солонгост залуу үеийнхний өсөлт буурснаас болж арми нь цэрэгт татах өндрийн хэмжээг багасгасан) Шөнө байраа орхиж айлын хашаа даван кимчи ухах юм уу ногоо зулгаах замаар хулгай хийж өл залгадаг байжээ.

Жун Саны хөрш айлуудын ихэнх нь хашааны өндрийг цагдаагийн ажиглалтад зориулж 1.5 метрээс дээш байлгаж болохгүй гэсэн журмыг үл хайхран хашаагаа өндөрсгөсөөр л. Жун Саных ч адил. Гэсэн хэдий ч хулгайч ногооны талбайд нь гурван ч удаа нэвтэрч сармис, төмс, байцаа, хулгайлжээ. Жун Саны аав ногоо тарих тухай сэтгүүлээ сайтар судалж, ямар үр тарьсан, хэр хугацаанд тариа соёолдог талаар нарийн тэмдэглэл хийдэг байв. "Ядаж ногоог боловсортол нь хүлээж болдоггүй юм байх даа" гэж аав нь аргаа баран уйлан үглэнэ. Нохдынх нь нэгийг хулгайлахад Жун Саны ээж санаагаар их унажээ. Ээж нь Сан Жуныг бага байхаас эхлээд л жиндо үүлдрийн гөлөгнүүд тэжээж, хоолыг нь хүртэл өөрийн гараар хийж өгдөг байсан ба хүүгээ сургуульд орсных нь дараа бичсэн захидлууд нохдынх нь тухай мэдээллээр дүүрэн байдаг байжээ. Нохойг нь алж идсэн байх гэхээс ээж нь байж ядсан гэнэ.

Үнэн хэрэг дээрээ нохой алагдах юу ч биш байлаа.

Японоос гаралтай айлууд мөнгөтэй байх магадлал өндөр учир дээрэмдүүлж, зарим тохиолдолд гэр бүлээрээ хүйс тэмтрүүлсэн ч удаатай тул тэднийх болгоомжтой байхыг хичээх боллоо. Бусдад идэх уух юмтай гэдгээ мэдэгдэхгүйн тулд хурдхан хоолоо идчихээд л унтдаг болов.

Ким Ир Сенийг нас барахад жинхэнээсээ уйлахгүй байгаагаа мэдэрснээс хойш Жун Сан нийгмийн тогтолцооны талаар урмыг нь хугалсан зүйл олноор олж харах болсон байна. Үзэж харж, сонсож буй бүхэн үзэл бодол нь төлөвшихөд тус болж байлаа. Их сургуулиас олж мэдсэн зүйлс ч өөрийг нь өөрчилж байгааг мэдрэв. Тэр амьдралдаа анх удаа шинэ үзэл санаа олж авчээ.

Хүүхэд байхдаа Жун Сан роман, гүн ухаан, шинжлэх ухаан, түүх, түүгээр ч барахгүй Ким Ир Сений хэлсэн үг гээд л олдсон бүхнийг уншдаг байжээ. Хотын номын дэлгүүрт Америкчуудын хэрцгий бүдүүлэг, Өмнөд Солонгосчуудын аймхай хулчгар, харин өөрсдийнх нь эрэлхэг зоригт зангийн тухай өгүүлсэн зохиолуудыг зарна. Хааяа нэгхэн Лев Толстой, Максим Горький зэрэг Оросын зохиолчдын бүтээлүүд харагдана. Ахлах сургуульд нь Боловсролын Хэрэгсэл ба Материал Хангамжийн албанаас номоор хангадаг байснаас гадна аав нь Грек, Ромын түүхийн боломжийн цуглуулгатай байсан учраас Жун Сан ном унших, тухайлбал Ханнибал Ромын эзэнт гүрнийг хэрхэн аюул заналд учруулаад өөрөө ялагдлаа хүлээн зөвшөөрөхийн оронд шоронд суусан тухай унших маш дуртай байжээ.

Пхеньянд очих үедээ Жун Сан илүү орчин үеийн зохиол унших хүсэлтэй болсон байв. Их сургуульд нь номын санчийн лангууны ард солонгос хэлнээ хөрвүүлсэн барууны хэдэн ном байх. Эдгээр номыг нийтэд уншуулах хориотой, зөвхөн тэргүүний хэдэн оюутан л авах эрхтэй байжээ. Азаар төр засгийн дээд албаныхан Хойд Солонгост барууны уран зохиол гадарладаг элит сэхээтэн хэрэгтэй хэмээн шийдсэн учраас эдгээр ном хадгалагдаж байжээ. Тэр цуглуулгын дотор Америк номууд ч байлаа.

Жун Саны дуртай ном нь "Салхинд туугдагсад". Уг номын уянгын өнгө аяс нь бага сага төстэйг эс тооцвол Солонгосын санаанаасаа зохиосон шахам зохиолуудтай адилгүй байсан аж. Уг номыг уншаад Америкийн иргэний дайныг Солонгосын дайнтай жишин, Жун Сан гайхшралд автсан байна. Нэг үндэстэн хоорондоо дайтах нь ямар харамсалтай түүх болохыг мэдэрч, америкчууд ч гэсэн солонгосчуудтай адил зовлон туулсан ард түмэн гэдгийг ойлгов. Гэхдээ Америкчууд

Солонгостой адил тарж бутарсан чигээрээ үлдэлгүй, дайны дараа нэгдэж чадсан нь бахархалтай байлаа. Гол дүр Скарлет О Харагийн эр зоригийг бахдаж байв. Дотоодын кинонууд дахь үргэлж эр зориг гарган эх орныхоо төлөө тулалдаж байдаг гол дүрийн эмэгтэйчүүд Скарлеттай төстэй мэт боддог байв. Гэвч Скарлет О Харагийн дүр илүү хувийн, өөрийн гэсэн мөн чанартай байхад Хойд Солонгосын киноны гол баатар эх орныхоо төлөө амиа өгөхөөс буцахгүй нэгэн байдгаагаараа ялгагдана. Мөн Америк зохиолд хайр сэтгэл гардаг бол тэднийд тийм зүйл огт байхгүй.

Энэ бол улсынх нь стандартаар маш их эрсдэл дагуулсан алхам байлаа. Жун Сан илүү ихийг уншихыг хүсэж байв. Сидней Шелдоны "Сахиусан тэнгэрүүдийн хилэн"-гээс аваад Габриел Гарсиа Маркесийн "Зуун жилийн ганцаардал" гээд олдож байгаа болгоныг шуналтайгаар уншина. 1930-аад оны сонгодог болох Дэйл Карнегийн "Хэрхэн найз нөхөдтэй болох ба бусдад яаж нөлөөлөх тухай зөвлөмж" нэртэй номыг уншсанаар анх удаа барууны үзэл санааг тусган авч цочирдсон байна. Номд өгүүлэх зөвлөмжийг уншаад итгэж чадсангүй. Бусдыг хайрлаж, хүндэтгэж сур. Америкийн тэр аймаар капиталист нийгмийн бүтээгдэхүүн энэ зохиолч яаж ийм зүйл хэлж чаддаг байна хэмээн Жун Сан өөрөөсөө асуув. Америкчууд чинь алаад бай, эс бөгөөс чи өөрөө алуулна гэсэн харанхуй ойн зарчмаар амьдардаг гээгүй бил үү?

Жун Сан ангийнхнаасаа бас ном зээлж уншдаг байлаа.

Нөлөө бүхий ах дүү хамаатан садан нь гадаадад томилолтоор явахдаа төрөл бүрийн ном сэтгүүл авчирч бэлэглэдэг учраас томоохон их сургуулийн оюутнууд хоорондоо солилцон уншдаг юмсанж. Солонгос хэл дээрх материал уугуул солонгосчуудаас бүрддэг Хятадын Янбианы мужид олдоц сайтай байж. Хамт сурдаг нэг оюутан нь Хятадын дунд сургуульд үздэг бэлгийн хүмүүжлийн тухай нэгэн сурах бичгийг өгсөн нь Жун Саны хувьд нүдийг нь нээж өгчээ. Жун Сан хорин настай. Түүний мөн гэрлэж амжаагүй буй үеийнхнийх нь бэлгийн амьдралын талаарх мэдлэг Хятадын дунд сургуулийн сурагчийнхаас ч тааруухан байгааг ойлгов. Эмэгтэй хүмүүст сарын тэмдэг ирдэг гэдгийг ч тэр мэддэггүй байжээ. Жун Сан тэр номоос маш их юм мэдэж авчээ. Хятадын Коммунист Намын их хурал дээр Маогийн Соёлын хувьсгалыг шүүмжилсэн илтгэл тавьсныг уншиж үзээд ихээр гайхсан байна. Хөдөлмөрийн нам жишээ нь Ким Ир Сенийг шүүмжилж байвал мөн ч жигтэй юм болно оо доо.

Нэгэн өдөр Жун Сантай хамт сурдаг оюутан дөхөж ирээд, эргэн тойрноо болгоомжлонгуй харснаа "Энэ их сайн ном. Чи унших уу" хэмээн сэмээрхэн шивнэжээ.

Тэр нь Оросын засгийн газраас гаргасан эдийн засгийн шинэчлэлийн тухай нимгэвтэр ном байлаа. Хүүгийн аав нь Пхеньян дэх Оросын элчингийн номын үзэсгэлэнгээс авсан байжээ. Орос чөлөөт зах зээлийн эдийн засаг руу шилжихээр бэлтгэж байсан 1990-ээд оны эхээр хэвлэгдсэн ном байна. Жун Сан гарт нь аюултай зүйл орсныг мэдрэв. Тэд ямар нэг гадаадын ном сэтгүүл олбол шууд цагдаад мэдэгдэх ёстой. Жун Сан баригдвал өөрөө, бас нөгөө оюутан, дээр нь эцгийг нь ч ноцтой асуудалд оруулах өндөр магадлалтай. Жун Сан номыг шүүгээндээ хувцасныхаа дор түргэн гэгч нь нууж орхилоо. Дотуур байранд нь дөрвөн оюутан нэг өрөөнд амьдрах ба өрөө бүр хос давхар ортой. Тиймээс шөнө хөнжил дотроо гар чийдэн барьж байгаад уншив.

Капитализм эхний шатандаа баялаг бүтээхийн тулд хүмүүнлэг бус байдаг. Жирийн ажилчин хүнтэй баялгаа тэгш хуваалцах тухай ойлголт байхгүй. Эдийн засгийн хөгжил эмх замбараагүй эхэлсэн. Гэвч орчин үеийн капитализм илт давуу хөгжиж, өмнө нь хийсэн алдаагаа засчээ. Жишээлбэл: Монополийн эсрэг хууль нь төрийн хяналтгүй, эмх цэгцтэй үйлдвэрлэлийг бий болгохыг зорьсон гэсэн утгатай зүйлийг Жун Сан уг номоос уншжээ.

Уг номд тэтгэврийн тогтолцоо, даатгал, нийгмийн халамж үйлчилгээний талаар дэлгэрэнгүй тайлбарласан байв. Социалист систем үр ашиггүй байдлаасаа болоод дэлхий дахинд нуран унасан гэнэ. Энэ бүхнийг уншиж байхдаа Жун Сан толгой сэгсрэн гайхаж, бодолд дарагдлаа.

1996 онд Жун Сан сургуулиа төгсөж, дипломоо өвөртлөв. Чонжинд буцаж очсонгүй, сургуулийнхаа судалгааны тэнхимд судлаачаар үлдлээ. Тэр одоо албан ёсоор насанд хүрч, бие даасан иргэн болсон учраас их сургуулийнхаа газар нутгаас гадагш гарах эрхтэй болов. Сургуулийнхаа дотуур байраас гарч, тавилга тохижилт муутай нэг бохир өрөө хөлсөлжээ. Байрны эзэд нь настай, хараа сонсгол муутай хоёр хөгшин байсан ч Жун Санд таалагддаг байлаа. Энэ байр Жун Саны зорилгод яв цав нийцэв.

Өөрийн гэсэн амьдрах газартай болсон учир өвөг эцгийнхээ өгсөн сүүлчийн мөнгөөр Сони зурагт худалдан авлаа. Хуулийн дагуу авсан зурагтаа Цахилгаан Долгионы Товчоонд бүртгүүлэв. Хойд Солонгос дотооддоо цахилгаан бараа үйлдвэрлэх боломжгүй болсон учраас гаднаас импортолдог ч, зарахынхаа өмнө улсын станциуд нь суваг солигчийг нь дуураймал эдээр сольж гаднаас ирэх бүх төрлийн мэдээллийн сувгийг хаадаг байжээ. Тэд өөрсдийгөө намгийн мэлхийтэй зүйрлэнэ. Дэлхий ертөнц гэдэг тэдний толгой дээрх гэрлийн тойргоор л хязгаарлагдана. Техник сэтгэлгээтэй мэргэжилтнүүд цахилгаан хэрэгслийн системийг өөрчлөхтэйгөө байлгүй яахав. Радионы хувьд асуудалгүй: арыг нь онгойлгоод хуваарилагчийн дамжуулагч туузыг тасалж, оронд нь резин тууз хийн, дуртай үедээ хуваарилагчийг эргүүлэх боломжтой болгож орхино. Зурагтын хувьд арай илүү мэргэжлийн ур чадвар шаардагдана. Цахилгаан Долгионы Товчоо шинээр авсан зурагтын товчийг лацаддаг нь уг товчоогоор баталгаажсаныг илтгэнэ. Лацыг гэмтээхгүйгээр хуваарилагчид хүрэхийн тулд Жун Сан урт нарийн зүү ашиглаж товчийг түлхэв. Өрөөнд нь арын хашаа руу гардаг хаалга байх бөгөөд Жун Сан тэр хашаанд антенн байрлуулж дөнгөв. Бүх хүн унтсаны дараа туршилтаа үргэлжлүүлэн, хайсаар байж хүссэнээ оллоо. Хайж байсан зүйл нь Өмнөд Солонгосын суваг байсан юм.

Байрны эздэд мэдэгдэхгүйн тулд Жун Сан зөвхөн тэднийг бөх гэгч нь унтсан шөнө дөлөөр зурагтаа үздэг байлаа. Яагаад гэвэл өрөөнүүдийнх нь хана цаана нь унтаж байгаа хүний хурхирах дуу сонсогдохуйц нимгэн билээ. Зурагт нь чихэвчний оролтгүй учраас дууг нь сонсогдох төдий сул дээр тавиад өөрөө өвдгөө нугалан, цээжээ бөхийлгөж, чихээ наагаад, бие нь чилээд хөдөлж чадахгүй болтлоо сонсдог байжээ. Үзэхээсээ илүү сонсох нь чухал. Гэхдээ зурагт нь асаалттай үед дээд зэргийн сонор сэрэмжтэй байна. Цахилгаан Долгионы Товчооныхон тохиромжгүй цагаар гэнэтийн шалгалт хийдэг нь гайхах зүйл биш. Хэдэн хаалганы цаадтайх хөршийнх нь нохойтой. Хэрэв тэдний нохой хуцаад эхэлбэл Жун Сан яаран нэвтрүүлгийн төв суваг дээр эргүүлэн аваачиж антеннаа нуухаар гүйн гардаг байлаа.

Тэгтэл нэг л өдөр Товчооныхон тэднийхээр айлчиллаа. Хурц нүдтэй ажилтан цаасан лацыг скочоор бүрсэнийг олж хараад их л нухацтайгаар учрыг асуулаа. Жун Саны зүрх нь хүчтэй цохилж эхлэв. Өмнөд Солонгосын суваг үзэж байгаад баригдаж, гэр бүлээрээ хөдөлмөрийн лагерь явсан жишээг Жун Сан мэднэ. Өмнөд Солонгосын радио сонссон гэж сэжиглэгдсэн найз нь бүтэн жилийн турш байцаагдахдаа нарны гэрэл огт үзээгүй гэх бөгөөд гарч ирэхдээ царай нь үхсэн хүнийх шиг цонхигор, мэдрэл нь орж гардаг болсон байжээ. Лацыг нь хуурахаас сэрэмжилж скоч наасан хэмээн Жун Сан аль болох жишимгүй хариулсан байна. Байцаагч хөмсгөө атируулснаа гараад явчихжээ.

Түүнээс хойш Жун Сан илүү болгоомжлох ёстой байсан боловч мэдээлэл авах гэсэн хүслээ барьж дийлсэнгүй. Зурагт нь дэлхий дахины мэдээллээс гадна өөрийнх нь орны талаар хэзээ ч сонсож байгаагүй зүйлийг таниулж байлаа.

Жун Сан хэдийгээр таамаглаж байсан боловч хэзээ ч тодорхой мэдэж байгаагүй олон гайхалтай зүйлийг ойлгож авчээ. АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтон эх оронд нь цахилгаан, шатахууны тусламж санал болгосон ч төр засаг нь цөмийн зэвсэг, пуужин хийхээ урьтал болгосон, хэдэн мянган тонн тусламжийн цагаан будааг ард түмэнд нь хандивласан зэргийг мэдэж авав.

АНУ-ын Конгрессын төлөөлөгчид хэвлэлийн бага хурал хийлгэж Хойд Солонгост хоёр сая хүн өлсгөлөнгөөс болж нас барсныг дэлхий дахинд мэдэгдсэн, хүний эрхийн байгууллагуудаас тус улсын 200,000 хүн хөдөлмөрийн лагерь цөлөгдсөн, Хойд Солонгос дэлхий дахинд хүний эрхийг хамгаалах талаараа хамгийн сүүлд ордог улс гэх зэрэг гайхмаар, түгшмээр өчнөөн зүйл мэдэж авсан байна.

2000 онд Өмнөд Солонгосын телевизээр Ерөнхийлөгч Ким Дэ Жун Хойд Солонгосын Ерөнхийлөгч Ким Чен Иртай уулзахаар Пхеньян руу явах тухай мэдээ цацагдах болов. Уг дээд хэмжээний уулзалтын үеэр Өмнөд Солонгосын телевизээр Хойд Солонгосын ерөнхийлөгч Өмнөдийнхөө ерөнхийлөгчтэй ярилцсан бичлэгийг гаргахад Жун Сан үзэж анх удаа ерөнхийлөгчийнхөө жинхэнэ дуу хоолойг сонссон байна. Дотоодын хэвлэл мэдээллийн хэрэгслээр бол ерөнхийлөгчийн дүрсэнд мэргэжлийн нэвтрүүлэгч дуу оруулдаг тул галтай, цогтой, жинхэнэ удирдагч хүний хоолой ард түмэнд нь сонсогддог байлаа. Гэтэл Жун Саны сонссоноор Ким Чен Иррийн хоолой хөгширсөн, яхир, осолгүй л хүнийх байна гэж ялгагдах төдийн байлаа.

Энэ чинь жинхэнэ хүн байжээ гэж Жун Сан өөртөө хэлжээ.

Өмнөд Солонгосын телевизийг үзэх нь Жун Саны хувьд амьдралдаа анх удаа өөрийгөө толинд хараад царай муутайгаа мэдээд гутрахтай адил мэдрэмж төрүүлж байлаа. Хойд Солонгосчууд улсаа дэлхий дээрх хамгийн бахархмаар сайхан орон гэж ярьцгаадаг бол гадаад ертөнцөд найдваргүй болсон, унан доройтсоор байгаа дэглэмтэй орон хэмээн ярьцгаадаг байх нь. Хүмүүс өлсөж, бас хөдөлмөрийн лагерь руу үй олноороо цөлөгдөж байгааг мэдэх боловч бодит байдал хэзээ ч ийм гэж бодож байсангүй. Өмнөдийн хэвлэл мэдээлэл бас биднийх шиг хэтрүүлэгтэй юм болов уу?

Жун Саны гэртээ харихдаа суудаг галт тэрэг Буддизмын судруудад гардаг там гэгчийг санагдуулдаг байв. Галт тэргэнд хүмүүс пиг чихээстэй учир бие засах газар руу явж чадахгүй. Иймээс эрчүүд цонхоор, эсвэл галт дараагийн зөрлөг дээр зогсох үед гадагш гарч бие засах ба эс чадвал галт тэргэн дотроо бие засна. Тэнэмэл хүүхдүүд, хөдөлж буй галт тэргийг даган гүйж, идэх юм гуйн, хагарсан цонхоор дотогш орох гэж зүтгэцгээнэ. Пхеньяны хойд хэсгийн өгсүүр газарт галт тэрэг эвдэрч удаан хүлээх хэрэг гарах нь олонтаа. Нэг удаа Жун Сан өвлийн цагаар харих гэж явтал галт тэрэг нь эвдэрч, шилгүй цонхоор нь өвлийн жихүүн жавар сийгсэн галт тэргэнд хоёр хоногийг үджээ. Хорьхон хоногтой нялх хүүхэдтэй эмэгтэй, хуримандаа очих гэж яваа залуу хоёртой элгэмсэж, хамтдаа төмөр хувин олж, үйлчлэгчийн үгийг ч тоолгүй, дотор нь гал асааж дулаацсан байна. Гал байгаагүй бол бүгд хөлдөх байсан биз ээ.

1998 онд Хойд Солонгосын эдийн засаг хямралынхаа дээд цэгт хүрээд байсан үеэр Чонжин руу буцаж яваад Өмнөд Хамёнг мужийн нэгэн жижиг хотод бас гацсан байна. Зам үерийн усаар дүүрч, хүлээж байсан зорчигчдыг хүйтэн бороо голд нь ортол дааруулна. Хүлээж байхдаа Жун Сан, хоол олохоор концерт тоглож буй хэсэг тэнүүлчин хүүхдийг ажиглав. Зарим нь илбэ үзүүлж, зарим нь дуулж байлаа. Зургаа долоо орчим настай, насанд хүрсэн үйлдвэрийн ажилчны дүрэмт хувцас дундаас бие нь харагдахтай үгүйтэй хүү том хүнийх шиг хоолойгоор, байдгаараа хичээн, нүдээ аньж: Ури абоги, эцэг минь бидэнд энэ дэлхийд атаархах зүйл үгүй Бидний гэр агуу Их Намын ивээлд бий Бид бүгд ах дүүс Галан шуурга бидэн рүү ирсэн ч Хөөрхөн хүүхдүүд айх хэрэггүй Эцэг минь бидэнтэй байна Бидэнд атаархах зүйл үгүй

хэмээн дуулж байлаа. Жун Сан энэ дууг хүүхэд ахуй үеэсээ л мэднэ. Гэхдээ үг нь багахан өөрчлөгджээ. Бидний эцэг Ким Ир Сен гэхийн оронд хүү Бидний эцэг Ким Чен Ир хэмээн дуулж байв. Энэ бяцхан хүү төмөр замын тавцан дээр зогсож, даарснаасаа чичрэн байж өлсгөлөн гэдсээ тэжээхээр дуулж байлаа. Гэтэл тэр хайртай, хамт байх ёстой эцэг нь хаачив? Хүү хоол олох л гэж, бас өөр дуу мэдэхгүй учраас дуулсан болохоос эцэг гээчдээ хайртайдаа, байгаа бүхэндээ үнэмшилтэйдээ дуулаагүй биз ээ.

Жун Сан халаасаа ухан хүүд арван вон гаргаж өглөө. Гудамжинд дуулж байгаа хүүд энэ бол их мөнгө, том шагнал. Энэ өглөг бол хүүг өрөвдсөн гэхээсээ илүү мэдсэн бүхэндээ тээнэгэлзэж байсан эргэлзээг нь арилгаж өгсний шагнал байсан юм. Давж чадахгүй байсан шугамаа давахад нь тусалсан болохоор тэр талархжээ. Худал бүхэнд итгэдэггүй байснаа сая ойлгов. Энэ бол асар том нээлт байлаа. Тэр бусдаас өөр байсан. Өөрийнхөө талаар олж мэдсэн зүйлдээ дарамтлагдаж санаа зовсон нэгэн байж.

Энэ бүхнийг олж мэдсэнийхээ дараа Жун Сан амьдралаа өөрчлөгдөнө хэмээн эхлээд бодож байж. Гэтэл юу ч өөрчлөгдсөнгүй, бүх юм урдын хэвээр. Бямба гаригийн өглөө бүр их сургууль дээрээ болдог үзэл суртлын лекцийг таслахгүй сууна. Хөдөлмөрийн Намын үүрийн нарийн бичгийн дарга Ким Ир Сений онолын талаар гонгинох нь автомат хариулагчийг санагдуулна. Өвлийн цагт танхим халаалтгүй үед тэрээр ажлаа хурдан дуусгахын түүс болно. Жун Сан ихэвчлэн араар суудал аван бусдыг ажигласан шиг сууна. Уг лекцэнд судлаач, туслах багш, докторын зэрэг горилогч гээд таван зуу орчим хүн оролцоно. Лекцийн үеэр сонсогчид хөлөө хөдөлгөж, гараа өгзөг дороо хийн дулаацуулах гэж оролдоцгооно. Гэвч царай нь их дэлгүүрийн шилэн хоргоны цаана байх хиймэл хүмүүсийг санагдуулдаг байлаа.

Жун Сан өөрийгөө бусад сонсогчтой адил хүйтэн хөндий царайлан суугаагаа анзаарав. Ярьж байгаа зүйлийн талаар бүгд түүнтэй адил бодолтой байх шиг санагдана.

"Бид мэднэ. Бид бүгд наадахыг чинь мэднэ шүү дээ" хэмээн хашгирмаар санагдана. Энд цуглагсад ирээдүйн, улсынхаа хамгийн тэргүүний боловсон хүчнүүд байж ч мэднэ. Толгой нь ажилладаг л бол энэ нийгэм нэг л болохгүй байна гэдгийг ойлгохгүй байхын арга алга.

Жун Сан гагц өөрөө бус өөр олон залуус ярьж буй зүйл, амьдарч буй нийгэмдээ итгэхгүй байгаа гэдгийг ойлгож авав. Залуучууд дуугүй байвч, зүрх сэтгэлээрээ харьцаж, бие биеэ ойлгож дэмжиж байгаа, гагцхүү нүүрэн дээрээ л толгой дохиж, нүдээ ирмэж зүрхлэхгүй байна гэдэгт Жун Сан эргэлзсэнгүй. Их сургуулийн цөөхөн эмэгтэй оюутны нэг Агуу их удирдагчийг магтсан зүйлсийг тэмдэглэлийн дэвтэртээ бичсэн нь Родон Синмун сонинд өгүүлэл болон хэвлэгдэж, үнэнч байдлынхаа төлөө шагнал хүртжээ. Үүнийх нь хариуд оюутнууд харин баахан шоолсон байна. Тэд охиныг өөдгүй амьтан хэмээн бодож байсан ч ил хэлж чадалгүй зүгээр л "чамтай ямар азтай нь гэрлэдэг бол оо" гэж тоглоом шоглоом хийгээд өнгөрсөн байна. Хойд Солонгосын оюутнууд, сэхээтнүүд бусад коммунист системийн орнуудынх шиг тэмцэж зүрхлэхгүй. Прагийн хавар, Тянь Ан Миний талбайн тэмцэл тэнд хэзээ ч гарсангүй. Энэ улсын дарангуйлал зохион байгуулалттай тэмцэл гарах ямар ч нөхцөл бололцоогүй харгис билээ. Төр засгийн эсрэг ямар нэг үйл ажиллагаа явуулсан хүн ганц өөрөө бус, үр удам, хамаатан саднаараа золиослогдох учир тэгж зүрхлэх ч нөхцөлгүй юм. Бузарлагдсан цусыг гурван үеэр нь таслах журамтай нийгэмд гэр бүлээс хэн нэгэн хэрэг үйлдвэл шийтгэл нь эцэг эх, өвөө эмээ, эгч ах, дүү нар, үеэл, ач зээг нь хүртэл бүгдийг хамардаг. "Хэрэв ганц өөрөөрөө дуусдаг сан бол энэ харгис дэглэмээс салахаар тэмцээд азаа үзэх сэн. Гэтэл бүхэл бүтэн гэр бүлийг үе удмаар нь үгүй хийх аюул хүлээж байдаг учраас яаж ч болдоггүй юм" гэж Өмнөд рүү оргосон нэг хүн надад ярьсан билээ.

Улс төрийн ярилцлага хийх, сайн дурын клуб байгуулах ямар ч боломжгүй. Санаа бодлоо чөлөөтэй солилцох байтугай солилцох оролдлого л хийх юм бол нөгөө газар луу илгээгдэнэ. Гурваас дөрвөн хүмүүс нэг бүлэг боллоо гэж үзэхэд дунд нь заавал нэг тагнуул байдаг. Жун Саны дунд сургуулийн дотны найз мэдээлэгч байсныг сүүлд олж мэдсэн билээ. Тэр хүү сургуулийнхаа тэргүүний сурагч, Жун Санаас сайн сурлагатай нэгэн ч, хүүхэд байхдаа полимелитээр өвдөж доголлон болсон учраас Пхеньяний их сургуулиудад тэнцсэнгүй. Жун Саныг Пхеньянаас ирэхэд нь тэр төр засгаа маш ихээр муулж түүнийг өдөөн хатгаж байжээ. Ярианых нь өнгө цаанаа л нэг айсан шинжгүй, зоригтой байхыг Жун Сан ажиглаж, урхи болохоос зайлахгүйг нь мэдээд найзаасаа холдсон юм.

Жун Сан үргэлж өөртөө "Чи Хойд Солонгост амьдарч байгаа тохиолдолд хэзээ ч улс төр ярьж болохгүй. Эцэг эх, сайн найз, багш нар бас найз охинтойгоо ч энэ тухай ярихаас үргэлж зайлсхийх ёстой" хэмээн сануулдаг байжээ. Тиймээс юу бодож явдаг тухайгаа Ми Рантай ч хуваалцаж байсангүй. Өмнөд Солонгосын суваг үздэг, капитализмын талаар эмхтгэл уншдаг зэргээ ч тас нуусан байна. Тийм болохоор Өмнөд Солонгос руу оргох тухай мөрөөдөл сэтгэлдээ хадгалж явдгаа юу ч гэж цухуйлгах билээ дээ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ГОЛ

Хайртай хүндээ итгэхгүйгээр хайрлаж, үерхэнэ гэдэг сэтгэлийн дарамт байдаг бололтой.

Жун Сан, Ми Ран хоёр өмнө нь юу ч бодохгүйгээр, хэдэн цагаар ангийнхан, хамт ажиллагсад, гэрийнхнийхээ талаар ярилцдаг байсан билээ. Харанхуйд хэдэн цагаар бүдрэн байж алхахдаа Жун Сан үзсэн кино, уншсан номынхоо талаар ярьж, шүлэг уншин өгч, Ми Раны гайхаж бахархсан сэтгэлд урамшин баясдаг байжээ. Ми Ран мэдэхгүйгээсээ ичиж нэрэлхдэггүй, өөрийнх нь таних хүмүүсээс тэс өөр хүн. Жун Сан ном уншихдаа дараа нь Ми Ранд ярьж өгнө гэсэн бодол сэтгэлд нь хөг нэмж илүү шимтдэг байжээ. Олон сараар хол байхдаа аль болох сонирхолтой материал уншихыг хичээж, уншсан зүйлээ санаандаа давтаж, Ми Раны үнэнээсээ баясах, гараараа амаа таглахгүй чин сэтгэлээсээ хөхрөхийг нь сэтгэлдээ дүрслэн, өөрийгөө баясгадаг байлаа. Гэтэл одоо үзэл бодол нь өөрчлөгдсөн, түүнийгээ хайртай бүсгүйтэйгээ хуваалцаж чадахгүй болсон байдаг.

Ми Ранд итгэдэггүйдээ ч гол нь биш. Ми Ран түүний хувьд гэр бүлээс нь гаднах хамгийн дотно хүн болж чадсан байв. Бусад найзууд нь холдон одсон болохоор Ми Ран амьдралынх нь төвд зогсож байлаа. Хэллээ гээд сайн юу болох юм бэ? Түүнийгээ өөр шигээ аз жаргалгүй амьтан болгож хувиргах гээ юу? Өмнөдийн ард түмэн хэр сайхан амьдарч байгааг мэдсэнийхээ дараа Ми Ран яаж хүүхдүүдэд Ким Чен Ир-ийг магтсан дуу зааж өгөх юм бэ? Хятад, Орост болж байгаа эдийн засгийн шинэчлэлийн талаар Ми Ран мэдээд яах билээ? гэх мэт асуултууд ар араасаа цувран ирж, эргэлзүүлдэг байв. Жун Сан хайртай бүсгүйнхээ төлөө санаа их зовж байлаа. Ми Раны нийгмийн гарал доогуур учир бүр ч болгоомжтой байх шаардлагатай болов. Хэл хальтраа л бол дуусаа гэсэн үг. Тэд Ми Раны сурагчдын өлсөж буй тухай ярихдаа "нөхцөл байдал", "бэрх гурван сар" мэтчилэнгийн нууц үгнүүд хэрэглэдэг байсан ба шууд үгээр яривал хэрэгт орох байсан биз.

Бас нэг яригдаагүй үлдсэн сэдэв нь хувийн асуудал. Ми Ран түүнийг 1997 онд сургуулиа төгсөөд нутагтаа ирэлгүй, эрдэм шинжилгээний тэнхимдээ үлдэх шийдвэр гаргасанд сэтгэлээр унасан юм шиг санагдаж байлаа. Бохир заваан галт тэргээр Чонжин руу зорчих, урд өмнөхөөс илүү найдваргүй болсон шуудангийн үйлчилгээнээс шалтгаалан хоорондоо харьцах боломж нь улам багасав. Чонжинд ирсэн ч гэсэн Ми Рантай уулзана гэдэг галын шугам руу гар нүцгэн орохтой адил шахам. Хэн нь ч утасгүй, нэгнийхээ гэрийнхэнд зурвас үлдээх аргагүй. Жун Сан гэр, эсвэл ажлынх нь гадаа Ми Раныг олж авах л сонголттой. Цасан шуургатай өдрүүдэд Жун Сан төмөр замыг багцаа болгон Ми Раны ажил руу хэдэн цагаар хүйтэн шуурганд нүдүүлэн, бэдрэн алхдаг байлаа. Гар нь хүйтэнд даарснаасаа болж бадайран ажил дээр нь ирэхэд Ми Ран харьчихсан байх жишээтэй.

Өвөл зуны амралтаар жилд хоёр удаа л бараагаа харалцана. Их удаан уулзаагүйгээс бие биеэсээ гэрэвшиж, дасах гэж бас хэсэг хугацааг авна. Ми Ран их өөрчлөгджээ. Анх уулзахад зоримог

харагдуулдаг байсан богино тайралттай үс нь үгүй болжээ. Үсээ мөрөө хүртэл ургуулж боосон нь бусад залуу охидтой адилхан болгож. Мөн нүүрээ будаж янзалдаг болсныг нь хараад Жун Сан их гайхсан байна.

Үнэн хэрэгтээ тэд нас бие гүйцсэн, том хүмүүс болсон байлаа. Жун Сан хорин долоотой, Ми Ран хорин тавтай. Гэтэл ирээдүйнх нь талаар яригдах ёстой асуудал хөндөгдөхгүй үлдсэн хэвээр.

Энэ сэдэв нэг л өдөр яалт ч үгүй гарч иржээ. Ми Ран хамт сурч байсан найзынхаа хуриманд уригдаж очоод орой нь Жун Сантай уулзав. Тэр хоёр Ми Раны байшингийн ард уулзаад халуун рашааны зүг алхав. Намуун, цэлмэг сайхан үдэш таарч, эргэн тойронд нь хэн ч үгүй нам гүм байжээ. Модны доорх замыг тойрч, хиймэл хүрхрээ, усан сангийн хажуугаар зугаалж, эцэстээ модны доорх вандан сандал дээр сууцгаалаа. Ми Ран найзынх нь хурим ямар болсон, нөхөр нь ямар хүн байсан талаар Жун Санд дуржигнатал ярьж гарав. "Хүмүүс яагаад ийм эрт гэрлэдгийг би ойлгохгүй юм" гэж Жун Сан үг хавчуулна. Ингээд өөрийн цээжилсэн Солонгосын сонгодог яруу найргаас залуухан сүйт бүсгүйн тухай нэгэн бадгийг уншиж өгөв.

Уулын бар ойртож ирсэн ч хадам эхээс чинь илүү айлгана гэж үү?

Хөлдмөөр хүйтэн жавар дайрсан ч хадам эцгээс чинь илүү хайрна гэж үү?

Гишгэлтэд чинь үйрсэн вандуйн шош ч нөхрийн чинь дүүгээс илүү чамайг үзэн ядна гэж үү?

Хамгийн халуун чинжүү ч гэсэн гэрлэсэн эмэгтэйн амьдралаас гашуун биш билээ.

Жун Сан энэ яруу найргийг хөгжилтэй гэж бодож байв. Ми Ран харин эргэлзсэн байдлаар итгэлтэй биш боловч инээн сонссон байна. Сэрэмжлүүлж байна гэж бодсон байх вий гэж Жун Саны сэтгэл зовжээ.

Үнэн хэрэгтээ Жун Сан гэрлэлтийн талаар нэг их зүйл бодохыг хүсдэггүй байлаа. Тийм бодол орж ирсэн ч даруй сарниулна. Нөгөө талаар Ми Ранаас өөр хүнтэй гэрлэнэ гэхээр сэтгэлд нь багтахгүй. Гэтэл Ми Рантай гэрлэчихвэл Хөдөлмөрийн намд элсэх хүсэл нь үлгэр болно. Хөдөлмөрийн Намын гишүүн болохгүйгээр Пхеньянд ямар нэг их сургуульд багшаар орох магадлал бараг үгүй. Урд шөнө нь үзсэн Өмнөдийн телевизийн нэвтрүүлгээс Жун Сан Кубыг эс тооцвол Хойд Солонгос дэлхий дээрх цорын ганц коммунист улс болсныг мэдэж авсан байв. 1989 онд Берлиний хана нурж, хоёр Герман нэгдсэнтэй адил хоёр Солонгос нэг өдөр нэгдэх ч юм билүү. Гудамжинд ялаа шумуул шавсан хүний шарилтай тааралдахдаа, үхлийн ирмэг дээр байна уу гэмээр бяцхан хүүхэдтэй нүүр тулахдаа бидний төгсгөл ойртжээ хэмээн бодох болов. Хойд Солонгосын иргэд дайны байдлаар амьдарч, эмгэнэлт явдал тал бүрээс нь бөмбөгдөн байлаа. Гэтэл ийм нөхцөлд яаж гэрлэлт, сайн сайхан ирээдүйн тухай бодох юм бэ?

Жун Сан гэнэт өөрийгөө болон Ми Раныг тун ихээр өрөвдлөө. Тэд яагаад ийм золгүй хувь заяатай юм бэ? Уг нь Жун Сан тэр шүлгийг Ми Ранд уншиж өгөхдөө гомдоох санаа огт өвөрлөөгүй юм. Ямар нэг далд санаа агуулалгүй, зөвхөн тайтгаруулахын тулд Жун Сан өмнө нь

хийж байгаагүй зүйлээ гэнэт хийж орхив. Тонгойгоод Ми Раны хацар дээр үнсчихлээ.

Үнсэлт л гэж хэлэх байх даа. Ми Раны хацрыг уруулаараа шүргэж, арай л уруулд нь хүргэчихэлгүй зогсов. Гэвч энэ бол арван гурван жил үерхэхдээ гараа барилцахаас өөрөөр хийсэн бие махбодийн анхны ойртолт байлаа.

Ми Ран үргэсэн зээр шиг сандлаас огцом босоод хоёулаа алхъя хэмээв. Тэр уурлаагүй, харин зүгээр л сандарсан аж.

Энэ үнсэлт Ми Раныг алмайруулсан байна. Сексийн тухай тун бага мэдлэгтэй ч үнсэлт бол хүсээгүй зүйлд нь хөтлөх анхны алхам гэдгийг мэдэж байв. Үеийн охид нь эрчүүдтэй унтаж, эвгүй асуудалд орсон тухайгаа ярихыг бишгүй л нэг сонссон. Жирэмслэлтээс сэргийлэх цорын ганц бөгөөд аймшигтай арга нь үр хөндөлт.

Мөрөөдөмтгий найз залуутайгаа адилгүй Ми Ран гэрлэлтийн талаар их боддог байлаа. Гурван эгчийнх нь хоёр нь гэрлээд хүүхэд гаргаж, дунд сургуулийн найз охид нь сүй тавьж эхэлсэн байв. Тэр ирээдүйнхээ талаар ул суурьтай бодох хэрэгтэй болжээ. Жун Саныг өөртэй нь гэрлэнэ гэдэгт Ми Ран огт итгэдэггүй байв.

Ми Раны байдал сайжирч эхэлсэн үе байлаа. 1990-ээд он гэхэд Ким Чен Ир Солонгосын дайны үед буюу 50 жилийн өмнө нөгөө талд байлдаж байсан хүмүүсээс илүү том дайснуудтай болжээ. Хөгшрөхөд хүүхэд насны шарх үрчлээнд нь дарагдан алга болохтой адил Ми Раны гэр бүлд дарсан шившгийн тамга бүдгэрч эхлэв. Хойд Солонгосын хуулиар ч гэсэн бузардсан цус гурван үеийн дараа цэвэршинэ. Ми Ран, дүү нь бас багшийн сургуульд орж чадсан. Хамгийн том эгчийнх нь царайлаг төрх нийгмийн гарлыг нь дарж, маш сайн хүнтэй гэрлэж чаджээ. Нөхөр нь арми дахь энгийн ажилтан бөгөөд тэднийх ойр орчных нь мод талхлагдаагүй үлдсэн цөөхөн газруудын нэг болох цэргийн хаалттай баазад амьдардаг байв. Тэр эгч нь ар гэртээ хусны мөөг, бусад ховор бараа олж өгдгийг нь идэх уух юмаар солилцон боломжийн амьдраад байлаа.

Гэлээ ч Ми Ранд зарим нэг хязгаарлалт тулгарсаар л байв. Гэр бүлээс нь хэн ч Пхеньянд амьдрах эрх авах боломжгүй. Хэрэв Жун Сантай гэрлэвэл тэд сайндаа л Чонжинд амьдрах болно. Гэтэл Жун Саныг ийм байдалд оруулсныхаа хариуцлагыг Ми Ран л хүлээх болно. Их сууснаас царай нь цонхийсон, нүдний шилнийхээ араас ноцтой нүдээр ширтсэн Жун Сан Чонжинд ирчихээд яаж амьдрах болж байна? Чонжины багш нарын адил Толстойн шүлгүүдийг цээжээр мэддэг атлаа хоосон ходоодоо хэрхэн тэжээх аргаа мэддэггүй арчаагүй сэхээтэн болон л хувирах байх.

Тэгээд ч Жун Саны эцэг эх гэж хүмүүс байна. Ми Ран хэзээ ч нүүр тулж байгаагүй боловч тэдний тухай ихийг сонсчээ. Жун Сан түүнтэй гэрлэнэ гэвэл эцэг эх нь лав ухаан алдаж унана. Аягүй л бол аав нь амиа хорлохоор айлгаж, ээжийнх нь өвчин даамжрах биз. Жун Сан үүрэг хариуцлага хүлээсэн гэр бүлийнхээ чухал хүн нь. Гэтэл энэ бүхнээ огоороод Ми Рантай гэрлэнэ гэж үү?

Японоос ирэгсэд өөрсөдтэйгөө адилхан хүмүүстэй л гэрлэдэг заншилтай. Эцэг эх нь Японд

амьдарч байсан мөнгөтэй охинтой хүүгээ гэрлүүлнэ, үгүй бол тэр өөрөө их сургуулийнхаа нэг удам угсаа сайтай охинтой гэрлэх байх. Ми Раны дэврүүн, яруу найраг унших дуртай найз залуу зиндааных нь хүн үнэхээр биш байлаа. "Үнэнийг хүлээн зөвшөөр" гэж Ми Ран өөртөө тулгана.

Амьдрал нь Жун Сангүйгээр ямар байх талаар төсөөлөх гэж Ми Ран оролдож үзлээ. Жирийн. Яруу найраггүй. Үйлдвэрийн ажилчин юм уу уурхайчинтай гэрлэж насаараа уурхайн тосгон, сайндаа л, Чонжинд амьдарна. Өмнө нь өндөр гээчийн хана буйг мэдэрч байлаа.

Ми Раны багшийн ажил тэсвэрлэшгүй болов. Анх ангид нь 50 хүүхэд байсан бол одоо 15 болжээ. Өглөө бүр

цэцэрлэгийнхээ хуучин барилга руу орохдоо зүрх алдана. Үгүй болсон хүүхдүүд цэцэрлэгт бөөн уйтгар гуниг үлдээжээ. Хүүхдүүд урд өмнөх шигээ хөгжилдөн инээлдэхээ больж, хичээлээ хийх сонирхолгүй болсон байв. Ким Ир Сенийг нас барснаас хойш цалингийн бараа хараагүй багш нар ч хичээл заах идэвхгүй болсон байлаа. Эрхлэгчээсээ цалин хэзээ буух талаар асуухад мөрөө хавчаад Өмнөд Солонгостой нэгдсэний дараа л магадгүй юм хэмээн ёжилчихно.

Ми Ран өөр ажил олох талаар бодож эхлэв. Зах дээр юм зарах ч юм уу эсвэл оёдлын үйлдвэрт ажилладаг ч юм уу. Ингэвэл багш болж нийгмийн байдлаа дээшлүүлэх гэж тун их чармайсан Ми Ран буцаад доод давхарга руу орно. Гэхдээ одоо энэ бүхэн хамаатай гэж үү?

Ми Раны санааг зовоосон өөр нэг асуудал аав нь болоод байв. Дөнгөж жаран тавтай мөртлөө нүднийх нь өмнө агшаад байх аж. Тэ Вугийн шөрмөслөг нуруу насны эрхээр бөгтийж, турж эцсээр байлаа. Энэ нь гэр бүлээ тэжээх чадалтайгаараа бахархдаг ээжийг нь их ичээх болжээ. Тэ Ву өдрийг байшиндаа эргэлдэж, юухан хээхэн янзалж өнгөрөөнө. Гэтэл юм хийж байгаад л дундаас нь будилж юу хийж байснаа мартаж орхино. Угийн дуугүй байсан тэрбээр одоо гэрт хэн л байна хамаагүй, заримдаа бүр өөртэйгээ зогсолтгүй ярих болжээ. Хагас зууны туршид дотроо хадгалсан зүйлсээ одоо гаргаж ярих болов. Өмнөд Чунчонд өнгөрөөсөн бага насаа, царайлаг сайхан эгч нарынхаа талаар бахархангуй дурсана. Нэгэн цагт язгууртан байсан ааваараа гайхуулж ярихдаа аньсага нь чийгтсэн харагдах болов. Ми Раны гурав дахь эгчийн хурим дээр Тэ Ву амьдралдаа анх удаа согтжээ.

Ми Раны аав өөртэй нь ойролцоо насны эрчүүдээс архи уудаггүйгээрээ ялгардаг байжээ. Энэ нь өөрийгөө хамгаалах арга байсан бөгөөд 1960-аад оны үед өөртэй нь адилхан Өмнөд Солонгосын дайны олзлогдогч байсан найз нь архи ууж, хэт их зүйл ярьснаасаа болоод асуудалд орсон учраас уухаас татгалзах болсон аж. Гэтэл Тэ Ву одоо тоохоо больж эхлэв. Хуримын ёслол гэрт нь болж, Ми Раны ээж гэртээ нэрсэн архиар зочдоо дайлжээ. Зочид явах үед Тэ Ву согтож хүүхэд ахуйдаа дуулж байсан нэгэн дуугаа дуулсан байна.

Ээжийнхээ гарыг атгадаг байлаа Түүсэн жимсийг нь амталж Хийсэн бялууг нь иддэг байлаа Ай би ээжийнхээ гарыг ямар их санана вэ?

Гэрийнхэн нь хөршийнхнөө сонсчих вий гэхээс толгойтой үс нь боссон гэнэ.

Ми Раны аав Тэ Ву 1997 онд 68 настайдаа өөд болов. Тэр үед Ми Ран гэртээ байсангүй. Аав нь амьсгал хураахынхаа өмнө "Ээж ээ" хэмээн дуудсан гэж дүү нь эгч нартаа хэлсэн байна.

Өнгөрөхөөсөө хэдэн сарын өмнөөс эхлээд Тэ Ву гэрийнхнийхээ талаар ярьж эхэлжээ. Ганц хүүдээ өөрийнх нь талын эцэг өвгөдийн нэрсийг угийн бичигтээ бичихийг хүсэв. Өөрөө айлын ганц хүү болохоор хүү нь гал голомтыг нь залгамжилж, эцэг өвгөдөө дурсаж яваасай хэмээн хүсэж байсан аж.

Тэ Вугийн сүүлчийн хүслүүдийн дотор биелүүлэхэд хэцүү нэгэн зүйл байсан нь Өмнөд Солонгос дахь ах дүү, төрөл төрөгсдөд нь нас барсан тухай нь дуулгах явдал байлаа. Энэ хүсэлт амьсгал хурааж буй эрийн ухаан нь самуурав уу гэмээр сонсогдож байв.

Солонгосын дайн төгссөнөөс хойш бараг хагас зуун өнгөрөөд байхад хоёр Солонгосын хооронд утсан болон шуудан харилцаа огт бий болсонгүй. Улаан Загалмайнханд мэдээ дамжуулахыг огт хориглодог. (2000 оноос эхэлж нарийн зохион байгуулсан, гэр бүлийн уулзалтууд болж эхэлсэн байна. Гэвч зөвхөн Солонгосын дайнаас болж салсан гэр бүлүүдэд хамаатай байжээ). Ми Ран болон эгч дүү нар нь Өмнөд Солонгост байгаа эмээ өвөө нь аль хэдийн үгүй болсон гэж боддог, аавынхаа эгч нарын талаар ямар ч мэдээлэлгүй байв. Иймээс аавынхаа хүслийг биелүүлж нас барсан тухай нь эгч нарт нь дуулгах ямар ч бололцоогүй байжээ.

Аав нь нас барснаас нэг жилийн дараа Ми Раны эгч Со Хи гэртээ амьсгаадсаар орж ирлээ. Амьсгаадсанаасаа болоод нүүр нь улайж, саявтархан нэг найз нь Хятад руу ирж очих эрх авсан бөгөөд аавынх нь эгч нартай холбоо тогтоож чадах хүмүүсийг мэднэ гэснийг гэрийнхэндээ яриу. Хятад орчих л юм бол Өмнөд Солонгос руу утсаар яриад холбоо барьчихна гэж найз нь хэлсэн байв.

Ми Ран Со Хи хоёр эхлээд их л сэжиглэв. Гэрийнхнээсээ гадна өөр хэн нэгэнд итгэнэ гэдэг дэндүү эрсдэлтэй хэрэг. Нууц цагдаагийнхан хүмүүсийг ингэж л барьж авдаг.

Хэд хоног тандсаны эцэст Со Хигийн найзыг үнэнч хүн гэсэн дүгнэлтэд хүрэв. Хамаатнууд нь Хятадад байдаг, түүнээс гадна бүхэл бүтэн сүлжээтэй болохыг мэдэж авлаа. Со Хигийн найзынх нь танил тэднийг хил рүү машинаараа хүргэж өгөөд, хилийн цэргийн офицертой уулзуулж өгнө. Тэр офицер зохих хүмүүсийг хахуульдаж, хаагуур хил давахыг нь зааж өгөх ба хилийн цаахантай амьдрах Со Хигийн найзын үеэл тэднийг тосон авч гэртээ байлгахаар тохирчээ. Ингээд Ми Ран Со Хи хоёр хамтдаа явахаар болсон байна. Энэ том нууцаа ганцхан хүнд итгэж ярьсан нь дөнгөж гэрлэсэн эгч нь байв. Гэвч эгч нь нууцыг удаан хадгалж тэссэнгүй, ээждээ хэлж орхижээ. Ээж нь бууж гарав. Гэрлээгүй бүсгүйчүүд Хятад руу хамгаалалтгүй явж яасан ч болохгүй. Гэрлээгүй охид хил даваад хүчиндүүлсэн, хулгайлагдаж хүчээр биеэ үнэлэх болсон эсвэл тэднийг алаад эд эрхтнийг нь зардаг гээд л элдэв зүйлийн явган яриа сонссон эхийн буруу ч гэж юу байх билээ.

Ингээд гэр бүлийн хурал хийж хэрхэхээ хэлэлцэв. Ми Раны дүү энэ гэр бүлийн цорын ганц эр хүн тул би явна гэж зүтгэсэн боловч ээж нь зөвшөөрсөнгүй. Дөнгөж хорин хоёр настай нялхаараа байгаа, тэгээд ч ганц хүүгээ ийм аюултай зүйлд явуулахгүй хэмээн ээж нь хэлжээ.

Эцэст нь Ми Ран, Со Хи, Сок Жу гурвыг явуулахаар тогтов. Дөнгөж сая гэрлэсэн эгч нь явахыг зүрхэлсэнгүй, харин нөхөр хүүхдүүдтэйгээ цэргийн баазад амьдардаг хамгийн том эгч нь тэртэй тэргүй явж чадахгүй болохоор түүнээс нуухаар тохиролцсон байна.

Ми Раныхан хэзээ ч дарангуйлагч дэглэмийг даган бишрэгсэд байсангүй. Гэвч бас идэвхтэй эсэргүүцэж ч явсангүй. Ким Ир Сений хөргийн тоосыг өглөө болгон арчих гэрийн эзэгтэй нарыг ээж нь шоолдог байжээ. Бусдадаа мэдэгдэлгүйгээр, шөнөдөө чихэвчээр Өмнөд Солонгосын радио сонсдог байсан бага хүү Сок Жу хамгийн зоригтой нь. Бусад нь болж буй үйл явдлыг сонирхох завгүйгээр ажиллацгаадаг байлаа.

Бусад айлтай харьцуулахад Ми Раных шинэ эдийн засгийн үед амьжиргаагаа дажгүй залгуулж, амьдрал нь сайжирч байв. Ээж нь эрдэнэ шишийн тээрмээ ажиллуулж хоёр идэхгүй ч, хоосон хонохгүй болгоод байсан тул эх нутгаасаа явах гэж амь тавин зүтгэхээргүй байв. Гэвч олдсон боломжийг ашиглахаар шийджээ. Энэ шийдвэрийн араас нэг зүйл нөгөөгөө даган гарч ирсээр, больё гэвч оройтсон байв. Аавынх нь сүүлчийн захиас хүүхдүүдийг хилийн зүг, осолтой аялалд дууджээ.

Тэдний цорын ганц зорилго нь Хятадад очиж аавынхаа ах дүү нартай холбоо тогтоох байлаа. Аавынхаа хамаатнуудыг олж чадах эсэхээ, олсон ч өөрсөдтэй нь холбогдоход дуртай байх эсэхийг мэдэлгүйгээр таг харанхуй явах гэж байлаа. Тэр үед Өмнөд Солонгос руу оргох тухай бодол хэнийх нь ч толгойд ороогүй.

Төлөвлөгөөнийх нь бэлтгэл ажил хэдхэн долоо хоногийн дотор биелэгдлээ. Баян хууран байшингийнх нь нимгэн хананы цаанаас саваагүй хөрш нь чих тавьж төлөвлөгөөгий нь сүйрүүлэх магадлал өндөр учраас гэртээ юу ч хийж чадсангүй. Гаднаа юу ч болоогүй юм шиг тайван байх ёстой. Ямар ч онцгой зүйл бусдад ажиглагдах ёсгүй. Гэртээ байгаа зүйлсээ ч аялалдаа зориулан мөнгө олохоор зарж чадсангүй. Байшингийнхаа цонхыг хулгайчаас сэргийлэн таглаж ч болсонгүй.

Ми Ранд яаралтай хийх нэг зүйл байлаа. Явахын урд шөнө хувцасныхаа шүүгээн дороос нандигнан боосон нэгэн зүйлийг гаргаж ирэв. Боодол дотор Жун Санаас ирсэн захидлууд, өгсөн бэлгүүдийг хадгалсан байв. Хамгийн нандин зүйл нь болох эрвээхэй хэлбэртэй болор шигтгээтэй үсний хавчаараа үлдээн, бүх захидлыг жижиглэн урж хаялаа. Хоёр эгч, дүү гурваас нь өөр хэн ч мэдэхгүй Жун Сан тэр хоёрын харьцааг нууц хэвээр үлдээх нь Ми Ранд хамгаас чухал байв.

Ми Раныхан Хятад руу түр явах гэж байгаа гэж яривч тэр үнэн хэрэгтээ хэзээ ч эргэж ирэхгүй, аавынх нь ах дүү нар хүлээж авсан аваагүй Өмнөд руу оргож магад гэсэн сэм бодол яваандаа сэтгэлд нь оржээ. Явсных нь дараа тэднийг эх орноосоо урвагчид хэмээн цоллож намын үүрийн нарийн бичгийн дарга нь энэ хүн намын ивээлээр боловсрол олж авчихаад эх орноосоо урвалаа хэмээн сүр дуулиан болгон зарлахыг нь төсөөлж байв. Ми Ран хайртай хүндээ гай болохыг хүсэхгүй байлаа. Явсных нь дараа тэр сайн эмэгтэйтэй гэрлэж, Хөдөлмөрийн намдаа элсэн эрдэмтэн болоод үлдсэн амьдралаа Пхеньянд өнгөрөөх болно.

Намайг ойлгож уучлах болно. Ингэсэн нь бид хоёрын хэн хэнд дээр хэмээн өөртөө давтан хэлнэ.

Ми Ран жижигхэн үүргэвч үүрээд аяндаа гарлаа. Дугуйгаа унаж дүү ээж хоёр руугаа ердийнхөөрөө даллан яваад өгөв. Бусдын анхаарал татахаас болгоомжилж гэрээсээ тус тусдаа гарахаар шийдсэн байлаа. Бага үдийн алдад ээж нь хажуу айлынхаа авгайд нэг гэрлэсэн охиныхоо хүүхдийг харахаар хоёр долоо хоног орчим явахаар шийдсэн гэж яриу. Тэднийг алга болсон талаар цагдаад мэдэгдэхээс өмнө цаг хожих арга байжээ.

Тэд Чонжинд Ми Раны эгчийнд уулзацгаав. Ми Ран эгчтэйгээ хил хүргэж өгөх машиныг хайхаар гарлаа. Тэр огт айж сандарсангүй, хийх ёстой зүйлээ л хийж байгаа мэт сэтгэгдэл төрж байв. Гэвч эгчтэйгээ гудамж хөндлөн гарах гэж байгаад санамсаргүй хажуу тийшээ хартал гудамжны эсрэг талд Жун Сан, үгүй бол түүнтэй маш адил хүн цүнх үүрэн алхаж байгааг хараад арай л зүрх нь зогсчихсонгүй. Ми Ран хараа сайтай учраас зургаан эгнээ машины замын цаанаас түүнийг танилаа гэж өөрийгөө боджээ. Уг нь Пхеньянд ажилдаа дарагдан энд явах ёсгүй ч яах аргагүй мөн санагдаад байв. Эхлээд гүйж зам гарч очоод тэврэх сэн гэж хүссэн боловч мэдээж олон хүнтэй газар тэгж чадахгүй юм чинь. Түүнийг санадгаа, өөрт нь зөвхөн сайныг хүсдгээ, багшийн сургуульд орох урам өгснийх нь төлөө, амьдрах итгэл хайрласных нь л төлөө өнөөгийнхөө амжилтанд хүрсэн, бас одоо ингээд явах зоригтой болсноо, мөн орхиод явах гэж байгаагийнхаа төлөө уучлал гуйх гэхчлэн Жун Сандаа хэлэх зүйл Ми Ранд даанч олон байлаа. Гэвч энэ бүхнийг хэлбэл өөрийгөө, гэр бүлээ ч аюулд оруулахаа мэдэж байсан учраас зориглосонгүй.

Тиймээс тэр Жун Сан ч бай түүнтэй адил ч бай залууг далд ортол нь байн байн харсаар цааш алхав.

Тэд машины ард чимээгүйхэн сууж, аав нь Солонгосын дайны дараа хоригдож асан лагерь байдаг Мусан хот руу хөдөлцгөөв. Уурхай, үйлдвэрүүд нь хаагдаж Мусан сүг сүнсний гэмээр хот болон хувирчээ. Гэтэл гаднаас харагдах үхмэл амьдралын цаана хууль бус наймаа цэцэглэн хөгжиж байлаа. Уг хот Түмэн голын хамгийн нарийн хэсэгт оршдогийн тул хулгайгаар Хятад руу хил давуулах бизнесийн гол зангилаа хэсэг нь болсон байжээ. Тэдний машины жолооч паспорт, замын зөвшөөрөлгүй иргэдийг хил рүү авчрахад гаршсан нэгэн байлаа. Бичиг баримт маш нарийн шалгадаг учир галт тэргээр явах боломжгүй.

Хүнтэй тааралдвал гэр бүлээрээ оргон зугтаж байна гэж сэжиглэхээргүй харагдаж байлаа. Хятадад очсоныхоо дараа өрөвдөлтэй харагдахгүйн тулд өдөр тутам өмсдөг хувцасныхаа дотуур хамгийн сайн гэснийгээ өмссөн байв. Тэдний хувцас Мусанд хуриманд ирсэн гэсэн хуурамч түүхийг нь нотлохоор харагдана. Амралтын өдрүүдэд аялахаар яваа учир бараг ачаа гэхээр юмгүй. Ачаанд нь гэр бүлийн хэдэн зураг, хатаасан далайн хүнс, хатаасан загас, хавч зэрэг Чонжиныхны голчлон хэрэглэдэг хүнсний зүйл байв. Эдгээр хүнсийг өөрсдөө хэрэглэх гэж биш харин хахуульд өгөхөөр авч гарсан юм. Мусаны замд хоорондоо тавин милийн зайтай хоёр шалган өнгөрүүлэх цэг байрлана. Хэдхэн жилийн өмнө замын бичиггүй хэн ч Мусан руу нэвтрэхээр оролдож зүрхлэхгүй байж. Гэвч 1998 онд хүнсээр юуг ч худалдан авахаар болсон байлаа.

Хил давах ажиллагаа саргүй шөнө шалганы ажилтнууд нам унтсан үеэр явагдахаар нарийн зохион байгуулагдсан байлаа. Гарах газар нь Мусаны захад шалганы харуулууд хоорондоо хоёр зуун метрт байрлах хэсэг. Хятадын талд туршлагатай хөтөч ээлжит "илгээмжээ" хүлээж байв.

Ми Ран ганцаараа явав. Ээж, эгч, дүү нь төлөвлөгөөний дагуу түрүүлээд явсан байжээ. Нэг гэр бүлийн гишүүд тусдаа аялсан нь дээр, баригдсан тохиолдолд өлсөөд хоол эрээд явж байна гэж тайлбарлавал үнэмшилтэй. Аз нь дайрвал хөдөлмөрийн лагерьт нэг жил хоригдох зэрэг хөнгөн ялаар шийтгүүлж болно. Харин гэр бүлээрээ баригдвал урьдчилан зохион байгуулсан зугтаах оролдлого хэмээн үзэж, оноох шийтгэлийг нь бодохоос ч аймаар. Урд нь зугтаад баригдсан жишээ мэдэхгүй болохоор яг ямар шийтгэл хүлээхийг сайн мэдэхгүй байв. Гэвч Ми Ран ийм бодлыг толгойноосоо хөөхийг хичээнэ.

Хөтөч түүнийг Мусанаас голтой зэрэгцүүлэн гаргасан шороон зам дагуулан гаргаж өгөв. Зам эрдэнэ шишийн талбай хүрээд дуусахад Ми Раныг ганцааранг нь орхилоо. Чигээрээ л яваад байгаарай. Замаа алдаж болохгүй шүү хэмээн хөтөч хэлээд салан одов.

Ми Раны тайван байдал замхран алга боллоо. Уг нь арван сар гэхэд цаг агаар зун шиг дулаахан сайхан байсан боловч шөнөдөө намрын сэрүү орж Ми Ран айсан, даарснаасаа болоод бүх бие нь чичирч эхэлжээ. Хэдхэн навч мөчрөөсөө дүүжлэгдэн үлдэж, нүцгэрсэн модод Ми Раныг төдийлөн сайн хааж чадахгүй байв. Ургац хураалт одоо дууссан байх ёстой гээд аль болохоор чимээ гаргахгүйг хичээн хурдан алхавч эрдэнэ шишийн хатсан үндэс хөлийнх нь доор шажигнан дуугараад байх аж. Хэн нэгэн ажиглаад юу юугүй л шилэн дээрээс нь бариад авах гэж байгаа юм шиг санагдана.

Гэрэл гаргахгүйгээр чигээрээ яваад байгаарай гэсэн хөтчийн зааврыг дагахад тун хэцүү байлаа. Аль зам нь зөв юм бол? Нөгөө гол чинь хаачив? Өдийд хүрчихсэн байх ёстой биш үү, арай эрдэнэшишийн талбайг тойроод яваад байсан юм биш биз гэх бодол толгойд нь эргэлдэнэ.

Тэгж явж байгаад золтой л нэг хана мөргөчихсөнгүй. Хана яг улаан зам дээр нь тулсан ба хэр урт үргэлжилснийг харах боломжгүй байв. Шорон, цэргийн ангиудын гаднах хашаа шиг цагаан цементэн хашаа юм. Арай занганд орчихсон юм биш байгаа? Буруу замаар явчихаж гэдэгтээ Ми Ран итгэх шахав. Эндээс аль болох хурдан холдох хэрэгтэйг ухаарав.

Ми Ран хашааг даган алхаж гарав. Хашааг гараараа багцаа болгон тэмтэрч явтал, намссаар байгаад давж болох хэмжээнд очлоо. Голын далан болгож барьсан хаалт байсныг сая л ойлгов. Ингээд хашааг давж ус руу гулсан орлоо.

Хойд Солонгост намар их хуурай улиралд тооцогдох ба усны хэмжээ их л доогуур, Ми Раны өвдөг хавьцаа татах боловч хэт хүйтэн байснаас хөл нь мэдээ алдав. Өмсөж явсан кет нь усаар дүүрч, хоёр хөл нь тугалга мэт хүндэрлээ. Өмднийхөө шуумгийг дээш нь болгох заавраа сандарсандаа болоод таг мартаж орхиж. Лаг шаварт шигдэж байгаагаа мэдэрч, хөлөө нэг нэгээр нь зөөж, тэнцвэр алдаж унахгүйн тулд маш болгоомжтой урагш ахив. Чанх урагшаа яваад байгаарай гэсэн хөтчийн үгийг аман дотроо давтаад л яваад байлаа.

Гэнэт ус шагайгаар нь татахыг мэдрэв. Тэгээд уснаас гарч, норж голдоо ортол даарсан тэрээр эргэн тойрноо ажиглалал аль хэдийн Хятадад ирчихсэн байжээ. Гэвч тэнд Ми Ранаас өөр хэн ч алга. Хоолой нь хатаж, хүн дуудах гэсэн ч айсандаа дуу нь гарсангүй.

Ингээд үнэнээсээ айж эхлэв. Ардаа үлдсэн эх орноо эргэж нэг харав. Өөрийг нь будилуулсан цагаан ханыг нөгөө талаас нь харав. Түүний доор хөтчийн даган одсон зам байх ёстой. Тэр замаа эргээд олдог сон бол Мусан руу буцчихмаар санагдана. Мусанаас Чонжин орох галт тэргэнд суугаад дараа өдөр нь гэхэд гэртээ харьчихна. Ажилдаа буцаад очно. Түүнийг оргох гэж байсныг хэн ч мэдэхгүй. Ингээд юу ч болоогүй мэт амьдралаа үргэлжлүүлнэ хэмээх бодолд дарагдаж зогстол гэнэт "Эгч ээ" гэх дуу сонстож, дүүгийнхээ гараас хөтлөн ахин хэзээ ч ирэхгүйгээр Хойд Солонгосыг орхин одлоо.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ

ГЭНЭТИЙН УХААРАЛ

Пхеньян дахь Их сургуульд байхдаа гэрийнхэн, найз нартайгаа холбоо барих гэж Жун Сан шуудангийн тогтолцооны ааш аягийг харна. Ми Ранаас гадна байнга холбоотой байдаг хэд хэдэн хүн байлаа. Ээж нь тэжээвэр нохдынхоо тухай, харин аав нь захиа шалгагч нарт таалагдахын тулд "Асар ихийг өгсөн Ким Ир Сен болон Хөдөлмөрийн намын төлөө сайн сурааарай" хэмээн бичнэ. Өвлийн хүйтэн болоод ирэхэд шуудангийн ажилтнууд захиаг шатааж дулаацдаг байж магад гэж сэжиглэсэн хэвээр. Жун Сан хэдэн сараар захиа авахгүй. Арав, арван нэг, арван хоёр сар хүртэл Ми Ранаас нэг ч захиа ирэхгүй болохоор Жун Саны санаа зовж эхлэв.

Өвлийнхөө амралтаар Чонжинд ирэхдээ дүүгээсээ Ми Рантай тааралдсан эсэхийг нь аль болох хайнга байдлаар асуутал дүү нь "Тэр чинь явчихсан шүү дээ" хэмээн шулуухан хэлэв. Сонссондоо итгэсэнгүй. "Явчихсан? Хаашаа явсан гэж?". Ми Раныг явахаар бэлдэж байсан тухай Жун Сан огт сэжиг аваагүй. Тэр бүх юмаа ярьдаггүй байсан гэж үү? Зун ирүүлсэн захиа нь хөндийвтөр өнгө аястай мэт санагдсан ч гэрлэх санаа байхгүй болохоор нь бяцхан гомдоо биз гэж бодоод орхижээ. Ганц ч үг хэлэлгүй орхиод явсан гэж бодохоос Жун Сан итгэж ядан байлаа. Дүүгээ шалгааж гарав. Тэд бүгд явчихсан гэнэ билээ. Хүмүүсийн ярих нь Өмнөд рүү гарсан гэсэн. Дүү нь ердөө ийм л зүйл мэдэж байлаа.

Тэр Ми Раны амьдарч байсан газар руу явлаа. Эхлээд шалгалт хийж яваа царай гарган гэрийнх нь ойролцоо баахан эргэлдэв. Хэт ойртож болохгүй байлаа. Гэдэс нь базалж, гүрээний нь судас цохилохыг мэдрэв. Хэдэн өдрийн дараа дахин эргэж ирлээ. Олон жилийн турш сэтгэлээ дэнслүүлэн Ми Раныг хүлээн зогсдог байсан газраа очиж зогслоо. Гэрт нь өөр айл амьдарч байхыг харав.

Амралтаараа, бас өөр тохиолдлоор гэртээ ирэх бүртээ Жун Сан гэрийнх нь хажууд зогсдог байсан газраа очно. Явган ярианаас өөр юм олж сонсохгүй нь тодорхой болохоор мэдээлэл олох гэж биш гэмээ наманчлах гэж очдог байв. Тэр ямар тэнэг амьтан байгаа вэ? Шийдэмгий бус хулчгар сэхээтэн. Алхам бүхнээ хэмжсээр байтал юм бүхнээс оройтдог хэмээн өөрийгөө үзэн ядна. Явсных нь дараа л гэрлэх саналаа аль эрт тавих минь яалаа гэж толгойгоо барив. Уг нь хамтдаа Өмнөд рүү оргох санал тавих байсан юм. Харамсалтай нь зориг зүрх хүрэхгүй явсаар оройтож. Үерхэж байхдаа асуудлыг өөрөө л шийднэ хэмээн бодож байсан. Ми Ранаас гурав ах, бас эр хүн шүү дээ. Тэгээд дээд боловсролтой, Пхеньянаас шүлэг цээжлэн ирж уншиж өгч, үзсэн кино, уншсан номоо түүнтэй хуваалцаж байсан. Гэтэл Ми Ран өөрөөс нь илүү зоригтой байжээ. Тэр өөрөө хулчгар. Хэн ч тодорхой мэдэхгүй байсан ч Жун Сан дотоод сэтгэлдээ Ми Раныгаа Өмнөдөд байгааг мэдэрч байв.

"Чөтгөр гэж, Ми Ран надаас түрүүлчихлээ" хэмээн өөртөө хэлэв.

Үнэн хэрэгтээ Ми Ран ганц Жун Санаас ч биш, өөр олон зуун хүнээс түрүүлсэн байлаа.

Солонгосын дайн дуусаад бараг хагас зуун жил болоход Хойдоос Өмнөд рүү дөнгөж 923 хүн зугтан гарсан байлаа. Гэтэл Берлиний хана байхад Зүүн Германаас Баруун руу жилд дунджаар 21000 хүн оргож гардаг байсантай харьцуулахад энэ бол өчүүхэн тоо.

Оргогсдын ихэнх нь дипломатууд болон албан ажлаар гадагшаа явагсад байв. Ким Чен Иррийн толгой цохих профессоруудын нэг болох Хванг Жан Ёп Бээжин рүү албан ажлаар яваад буцах замдаа Өмнөд Солонгосын ЭСЯ-нд хандаж орогнол хүссэн юм. Хааяа нэг цэрэггүй бүс рүү нэвтрэх замаар цэргүүд оргоно. Цөөн хэдэн загасчин Өмнөд рүү завиараа очсон байна.

Үүний эсрэг Хойд Солонгосын засгийн газар хүний санаанд оромгүй арга хэмжээ авч эхлэв. Чонжин болон бусад хотын далайн эргийн дагуу хашаа босгож, ард иргэдээ зугтахаас сэргийлэн, гадаадад албан томилолтоор явах хүмүүсийн эхнэр хүүхдийг барьцаа болгож үлдээнэ. Оргогсод эрх чөлөө нь хайртай хүмүүсийнх нь цус нулимсаар олддогийг бүгд ойлгодог билээ. Ар гэрийнхэн нь үлдсэн амьдралаа хөдөлмөрийн лагерьт өнгөрөөх нь ойлгомжтой.

1990ээд оноос эхлэн байдал өөрчлөгдлөө. Эх орныг нь нөмөрсөн өлсгөлөн, Хятадын эдийн засгийн өөрчлөлт тэдний нутгаасаа оргох санааг нь улам идэвхжүүлжээ. Хилийн цаанаас харахад Түмэн голын ойролцоо орших усан онгоцны зогсоол дээр цоо шинэхэн машин сүлжилдэн давхих нь харагдаж, Хятадын эдийн засаг нүдэн дээр нь эрс сайжирч байлаа.

Ми Ранд тусалсан нөгөө сүлжээ улам өргөжив. Түмэн голын дагуу шинэ, хамгийн нарийн зурвасыг олж хилийн цэргийнхнийг нь хахуульдах арга олцгоожээ. Хэрэв сэлж чадахгүй бол хүн хөлслөн гаргуулна. Иймэрхүү маягаар Хятад руу оргогсдын тоо 2001 он гэхэд 100,000-д хүрч, тэдгээрээс цөөхөн нь Өмнөд Солонгост гарсан байна.

Хойд Солонгосчууд Хятад руу оргож, хятадууд Хойд Солонгос руу бараа зөөж, хоёр талдаа хөдөлгөөн ихтэй болов. Зөөдөг бараа нь хувцас хүнсээр хязгаарлагдсангүй: Ном, радио, сэтгүүл, хориотой Библи, хулгайгаар олшруулж хямд зарах DVD-нүүд гээд маш их зүйл байлаа. Нэг наймаачин биедээ мянга шахам DVD нууж, дээр нь хилийн цэргийнхнийг хахуульдах хэдэн хайрцаг тамхи шингээгээд хил давна. Хятадад үйлдвэрлэсэн DVD тоглуулагч 20 доллар орчим ба эдийн засаг сэргэж, хүмүүс худалдан авах чадвартай болсон байлаа. Хамгийн эрэлт ихтэй нь Титаник, Кон-Эйр, Гэрч зэрэг кинонууд. Эднээс ч илүү алдартай, сайн зарагддаг нь Өмнөд Солонгосын савангийн дууриуд байв. Өмнөд Солонгосын инээдмийн кинонууд, савангийн дууриудад ихэвчлэн ажилчин түвшний хүмүүсийн амьдралыг дүрсэлсэн байдаг ба тэдний хэрэглэж буй сав суулга, жүжигчдийнх нь өмссөн хувцсыг ажиглаж, амьдралдаа анх удаа Ким Ир Сен, Ким Чен Иррийн тухай биш кино төрөлх хэл дээрээ үзэн, нөгөө талд амьдрал ямар байгаа талаар бага ч болов төсөөлөлтэй болсон аж.

Хойд Солонгосын засгийн газар АНУ, Өмнөд Солонгосыг өөрсдийн үзэл суртлыг дэлгэрүүлж, нам төрийг нь унагаах хорт бодлого явуулах зорилгоор элдэв ном, DVD тарааж байна хэмээн буруутгав. DVD зарсан хүмүүс баригдаж, зарим тохиолдолд цаазаар авхуулах хүртэл ялаар

шийтгүүлж байв. Гадаадын соёлын аюултай талын тухай Хөдөлмөрийн намын үүрийн нарийн бичгийн дарга нар хүмүүст дараах байдлаар ухуулга хийж байв.

Бидний дайснууд империалист ертөнцийг гоё сайхан болгож харуулах, өөрсдийн хөрөнгөтний үзэл суртлыг тараахаар тусгайлан бэлдсэн материалыг ашиглаж байна. Хэрэв бид энэ ялзарсан үзэл суртал, зүй бус оролдлогод автвал хувьсгалч үзэл бодол маань доголдож, агуу их удирдагч Ким Ир Сенийг дахин шүтэх явдал үгүй болох аюултай.

Гэтэл мэдээлэл зөвхөн ном сонин, киногоор төдийгүй хүмүүсийн ам дамжин тархаж эхлэв. Кино үзэж чадахгүй нь бусдаар яриулж, хөрш орнуудын эдийн засгийн хөгжил, технологийн дэвшлийн талаар итгэмээргүй зүйлүүд сонстох боллоо. Өмнөдөд жолооч нар согтууруулах ундаа хэрэглэсэн эсэхийг шалгадаг төхөөрөмж рүүгээ үлээгээд эрүүл л бол асдаг машин зохион бүтээж гэнэ (цуу яриа). Энгийн Хятад тариачин өдөрт гурван удаа хоолондоо цагаан будаа хэрэглэдэг гэнэ (бодит байдал) гэхчлэн ярьцгаах болов.

Нэг цэрэг найзад нь хамаатных нь хүн Америкт үйлдвэрлэсэн хумсны хутга бэлэглэснийг гайхуулсан тухай ярьсан аж. Нөгөө цэрэг түүгээр нь хумсаа авч, хурц цэвэрхэн иртэйг нь гайхан, ийм жижиг зүйлийг яаж ингэж мундаг хийж чадаж байна аа хэмээн алмайрчээ. Тэгээд манай улс ийм сайхан хумсны хутга хийж чадахгүй байж Америктай яаж цэрэг зэвсгээрээ өрсөлдөх вэ дээ хэмээн гунигтайгаар санаа алдсан гэдэг.

Бас нэг оюутан Өмнөд Солонгосын нэгэн иргэн харуулын шугам дээр зогсож байгааг зурагтаар үзжээ. Уг нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр капиталист нийгэмд ажилчин хүнийг хэрхэн мөлжиж байгааг харуулахыг зорьсон байна. Гэтэл нөгөө дарлагдсан ажилчин нь тэр үед моодонд орж байсан цахилгаантай хүрэм өмсөж, халаасандаа үзгэн бал хийсэн байхыг уг оюутан анзаарчээ.

1990ээд оны дундуур Хойд Солонгосын тэнгисийн цэргийн нэг ажилтан Шар тэнгист завьтайгаа явж байтал гэнэт Өмнөдийн долгион баригджээ. Гэтэл радиогоор нь гэрийнхээ гадаа машин тавих зай булаацалдаж буй хоёр залуу эмэгтэйн тухай инээдмийн жүжиг дамжуулж байв. Тавих зай олдохгүй болтол олон машинтай байдгийг тэр огт ойлгосонгүй. Гуч гарч яваа, нэлээд дээгүүр алба хашдаг түүний мэддэг хүмүүсийн дотор ялангуяа залуу эмэгтэйчүүд хэзээ ч машинтай байсангүй. Иймээс радиогийн нэвтрүүлгийг зөгнөлт жүжиг нэвтрүүлж байна хэмээн боджээ. Тэгээд нэлээд хэдэн өдрийн турш судалсны эцэст үнэхээр Өмнөд тийм олон машинтай юм байна гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

Дээр дурдсан гурван иргэн гурвуулаа Өмнөд рүү оргон гарсан билээ.

Ким эмч хэзээ ч өөрийгөө нутгаасаа гарна гэж төсөөлж байсангүй. Бусад орнуудад юу болж буйг сонирхдоггүйдээ биш Хойд Солонгос бол дэлхий дээрх хамгийн сайхан орон учир би өөр тийшээ яваад яах юм бэ гэж боддогт гол учир нь байлаа.

Хүүхэд байхад нь аав нь дүрвэн ирэхээсээ өмнө Хятадад ямар хүнд хүчир амьдралтай байсан тухайгаа хангалттай ярьсан учир Ким эмч тийм л бодлоор өссөн байлаа. Жирийн барилгачны

охин тэрбээр анагаахын сургуульд үнэ төлбөргүй сурч эмч болсон нь төр засгийн ач бөгөөд хэзээ нэгэн цагт ачийг нь хариулна гэсэн бодол тээн явдаг байв. Кимийн хамгийн том мөрөөдөл нь Хөдөлмөрийн намд элсэж, улс эх орондоо хүчин зүтгэх байлаа.

"Хэрвээ намд маань хэрэгтэй гэвэл би зүрхээ ч өгөхөд бэлэн, тийм л эх оронч байсан" гэж тэрээр хожим нь дурсан ярьсан юм.

Ким эмч сайн дурын ажил буюу намын үүрийн нарийн бичгийн даргын туслахын ажлаа илүү цагаар хийж байв. Ким Ир Сенийг өнгөрсний дараах өвлөөс Ким эмч сайн дурын ажилдаа өглөө эрт 7:30-д ирэх ёстой болжээ. Учир нь тэрээр нарийн бичгийн дарга нөхөр Чун гэдэг халдварт шар өвчний эмч, тавь гаруй насны, салан замбараагүй эмэгтэйн өрөөг бусад ажилтнууд ирэхээс өмнө цэвэрлэх ёстой байжээ. Өрөө жижгэвтэр, хананд нь хоёр удирдагчийн зургийг өлгөж, ханаа дагуулан бичиг баримтны олон шүүгээ эгнүүлэн тавьсан байна. Хуучин модон ширээнийх нь шургуулга бараг хаагдахгүй тул бичиг цаас нь саган, шалан дээгүүр хөглөрдөг байжээ. Хоёр удирдагчийн хөргийг сонинууд үргэлж нийтлэх тул сонинг харин шалан дээр огт хаяхгүй, ширээн дээр нямбай гэгч нь давхарлан тавьсан байна. Нарийн бичгийн дарга, нөхөр Чун сайн уншиж чадахгүй тул Ким эмчээр Родон Синмун болон Хамбук Синмун сонинуудыг уншуулж лекциэ бэлдүүлнэ. Хариуд нь нөхөр нарийн бичгийн дарга өөрийг нь намын гишүүнд нэр дэвшихэд тусална хэмээн бат итгэж байжээ. Түүгээр ч барахгүй багшийгаа даган суралцаар байгаад өөрөө намын үүрийн нарийн бичиг болохыг мөрөөдөж зүрхэлнэ гээч.

Эмх замбараагүй хөглөрсөн цаасуудыг янзалж байхдаа модон шүүгээгээ онгорхой орхисныг анзаарав. Саваагүй зан нь хөдөлж, нэг том дугтуйг сугалан гаргалаа. Дугтуйнаас хяналтад байдаг таньдаг ажилтнуудынх нь нэрстэй цаас гарч ирлээ. Нэр бүрийн ард хяналтанд байгаа учир шалтгааныг нь бичсэн байх агаад ихэвчлэн нийгмийн байдал, тухайлбал сүмд явдаг эцэг эхтэй, хуучин газрын эздийн үр удам, Японоос цагаачлан ирэгсдийн үр хүүхэд, Хятадад хамаатан садан нь байх хүмүүс гэх мэт шалтгаанууд бичээстэй ажээ.

Гэтэл хамгийн гайхалтай нь тэнд Ким эмчийн өөрийн нэр дурайж байх нь тэр.

Тэр нүдэндээ итгэсэнгүй. Бүх амьдрал нь, зан байдал нь өө сэвгүй байсан биш үү. Ким төрөлхийн ёсорхуу, дүрэм журмыг яг таг биелүүлэгч хүн. Оюутан үедээ онц сурлагатан байж, үргэлж сайн дурын ажлуудыг дуртай нь аргагүй гүйцэтгэдэг асан. Хэдийгээр аавынх нь хамаатнууд Хятадад байсан ч Ким эмч хэзээ ч тэдэнтэй холбогдож байсангүй. Энэ алдаа байх аа гэж амандаа үглэв.

Яваандаа бүх зүйл ил болжээ. Нарийн бичгийн дарга, нөхөр Чун түүнийг хуурч, намд элсүүлэх ямар ч бодолгүй атлаа авьяас чадвар, хөдөлмөрч занг нь ашиглаж байж. Түүнээс гадна өөрийг нь тагнаж байж ч магадгүйг мэдрэв. Эмнэлгийнх нь намын нөхөд түүнийг их л сонирхон байгааг олж мэдлээ.

Энэ явдлаас хоёр жилийн дараа түүнийг тагнаж байсан нь батлагдав. Нэгэн өдөр үндэсний аюулгүй байдлын тусгай ажилтан эмнэлэг дээр нь гэнэт хүрч ирлээ. Эхлээд Ким эмч тэр хүн хамт

ажилладаг нэгэнтэй нь, эсвэл өвчтөнтэй нь уулзахаар ирсэн байх хэмээн бодож суутал ганц өөрийнх нь тухай элдэв асуултаар булаад эхлэхээр л сая өөрийг нь зорьж ирснийг ойлгов. Түүний гол зорилго нь Ким эмчийг оргохоор завдаж байгаа эсэхийг мэдэх явдал байжээ.

Эх орноосоо явах аа? Би яагаад явах ёстой билээ? хэмээн өөдөөс нь асуув. Тэр хэзээ ч энэ талаар бодож байсангүй. Хүмүүс элдэв юм ярилцахыг сонссон ч түүний хүрээнд оргож, эх орноосоо урвасан хүн байсангүй. Гэтэл үндэсний аюулгүй байдлын тусгай ажилтан оргох шалтгуудыг нь тоочив. Хамаатан садан нь Хятадад байдаг, нөхрөөсөө салсан, бас ажлаасаа цалин авахгүй байгаа гэх мэт.

"Чамайг бид ажиглаж байгаа шүү. Зугтаад үзээрэй" хэмээн сүрдүүлээд явсан байна.

Сүүлд нь тусгай ажилтантай ярьсан яриагаа сэтгэлдээ тунгаан бодоод үзвэл үнэндээ түүний зөв байлаа. Харин ч санаа өгсөнд нь талархууштай. Ингээд Ким эмчийн сэтгэлд өөр нэгэн бодол төрөх болж, бодлоосоо айхгүй байгаадаа гайхав.

Амьдрал нь үнэхээр авах юмгүй байлаа. Салсныхаа дараа нөхөр байсан хүн нь удалгүй дахин гэрлэжээ. Хүүг нь Хойд Солонгосын хуулийн дагуу хадмынх нь өсгөж, хааяа нэг амралтын өдрүүдээр барааг нь харах болжээ. Хүүтэйгээ уулзах болгондоо турж эцэн, царай алдсаныг харж, өр нь өмрөх шахна.

Гэвч тэр өөрөө ч хадмуудаасаа дээрдэх юмгүй амьдарч байв. Бусад эмч нар эм дамлан зарж, аборт хийх зэргээр амьжиргаандаа нэмэрлэж байсан бол Ким эмчид тийм чадвар ч, зориг зүрх ч байсангүй. Харин өвчтөнүүдийнх нь бэлэглэдэг хүнс л голыг нь зогоож байв. Гэтэл удалгүй өвчтөнүүд нь өөрсдөө ч идэх юмгүй боллоо.

1997 онд Ким эмч өлсгөлөн хүүхдийн нүд рүү харж тэдний төлөө юу ч хийж чадахгүйгээ мэдрэхээс халшран хүүхдийн тасгаас гарлаа. Үхэж буй хүмүүстэй тулгарахаас зайлсхийн судалгааны тасагт шилжжээ. Гэтэл судалгаа хийх ямар ч нөхцөл байсангүй. Эмч нар өглөөний үзлэгээ хам хум дуусгаад л хоолны эрэлд гарна. Арай гэж өглөөний хоолоо олж идчихээд л өдрийн хоолны эрэлд гарах замаар амьдрал нь үргэлжилж байлаа. Ким эмч ажлаасаа эрт гарч ууланд очоод идэж болох өвс ургамал хайн бэдэрнэ. Заримдаа мод цавчин зарж хүртэл үзэв. Турсаар байгаад 36 кг болсон ба хөх нь агшиж сарын тэмдэг нь ч ирэхээ болилоо. Гуч гарч байгаа атлаа арван хоёр настай сургуулийн охин шиг харагдана. Өлсгөлөнгийн эхний өдрүүдэд нялх хүүхдээс ч хамаагүй хоолыг нь булаан идмээр санагдаж байсан бол аяндаа тэр мэдрэмж нь арилж, юу ч мэдрэхээ болиод, бие нь агаарт хөөрч буцаж газарт бууж байгаа мэт санагдах болсон байна. Туйлдталаа ядарч, өглөө босч чадахаа болив. Эхлээд намын үүрийн нарийн бичгийн даргын туслахын ажлаа орхиж, 1998 гэхэд эмнэлэг рүүгээ ч очихоо болилоо. Амьдрах гэж элдвийн зүйл хийж үзэв. Зах дээр архи, нүүрс зарж хүртэл үзлээ. Анагаахын сургуульд үзсэн зүйлээ мартаж байгаадаа ч харамссангүй. Өлсгөлөнгийн энэ хүнд бэрх үед амьд үлдэх л юунаас ч илүү чухал.

Нэг удаа зах дээр явж байгаад хуучин найзтайгаа тааралджээ. Тэд дунд сургуульдаа эн тэнцүүхэн сурлагатай гялалзсан охид байж. Найз нь ангийн дарга байв. Тааралдсандаа баярлан түр

ярилцан саатсан байна. Ким эмч гэрийнхний нь талаар асуухад нөхөр, хоёр настай хүү хоёр нь хоорондоо гурван өдрийн зөрүүтэй нас барцгаасан гэж жишим ч үгүй хэллээ. Ким эмч харамсаж буйгаа илэрхийлэх гэтэл "Зүгээрээ, харин ч хоолны сав хоёроор багассан" гэж хариулсан байна.

Ким эмч найз нь галзуурсан уу, эсвэл сэтгэцийн өөрчлөлтөд орсон уу гэдгийг ялгаж чадсангүй. Гэхдээ Хойд Солонгост удах юм бол өөрөө нэг бол үхнэ, үгүй бол найз шигээ болно гэдгээ л сайн мэдэж байлаа.

Аав нь өөд болохынхоо өмнө Хятадад байдаг хамаатнуудынхаа нэрс, өөрийн мэдэх хаягаа Ким эмчид хэлж өгсөн билээ. Аав нь сайн дураараа өлсөж үхэхийнхээ өмнө чичирсэн гараараа бичиж өгсөн цаасыг тухайн үедээ Ким эмч доромжлол хэмээн үзэж нэгэн хайрцагт далдаас далд нуусныг уншигч авхай та мэдэх билээ. Тэр хайрцгаа ухаж аавынхаа өгсөн бичгийг гаргаж ирээд болгоомжтой дэлгэн үзлээ. "Тэд чамд заавал тусална" гэж аав нь нүд анихынхаа өмнө хэлсэн билээ.

Хөтөч хөлслөх, хилийн харуулуудыг хахуульдах мөнгөгүй байсан болохоор Ким эмч Хятад руу цор ганцаар, өөрийнхөө ухаан, зөн совиндоо хувь заяагаа даатган явлаа. 1999 он гэхэд хүмүүс хаагуур гарах талаар бусдаасаа зөвлөгөө аван олноороо хил давах болсон байв. Хаврын улирал эхлээд удаагүй, хахир хатуу өвлийн жавар дөнгөж зөөлөрч эхэлсэн ч Түмэн гол хөлдүү хэвээр байсан үе. Ким эмч Түмэн голын алхаад гарч болдог хэсгийг хүнээр заалгасан болохоор хэд алхаад л том чулуу авч шидэн мөс цөмрөх эсэхийг шалган аяллаа үргэлжлүүлж байлаа. Ямар ч байсан Солонгосын хэсэгт мөс тэс хөлдүү хэвээр байв. Тэр балетийн бүжигчин мэт нэг хөлөө зугуухан тавьж, дараа нь нөгөө хөлөө зөөн урагшилж байлаа. Шидсэн чулуу нь хэсэг шавар луу шигдэн орох үед Ким замынхаа хагасыг туулсан байв. Хага ташим хүйтэн ус бүсэлхийд нь хүртэл цаашаа явсаар л. Гараараа ус самардан цаашилсаар байлаа.

Эцэст нь голын эрэг дээр гуйвсаар гарч ирэв. Хөл нь мэдээгүй болж, хөлдсөн өмдөн дотроо байгаа үгүй нь ч мэдэгдэхгүй болов. Цааш модон дундуур үүр хаяартал алхаж, жижигхэн тосгоны хаяанд тулж ирлээ. Хөлдөхөөс айн зогсохгүй цааш явья гэтэл ямар ч чадалгүй болсон байв. Ингээд нутгийн сайхан сэтгэлтэй хүмүүст найдахаас аргагүй болов.

Ким эмч цааш шавартай замаар арай гэж нэгэн малчин айлыг зүглэн гэлдэрлээ. Ихэнх айлууд хашаатай, төмөр хаалгатай харагдана. Нэгэн хашааны үүдэнд ирээд хаалгыг нь түлхтэл азаар онгорхой байж таарлаа. Төмөр аяганд дүүрэн будаа газар хэвтэж байна. Ойртон харвал хэрчим махтай цэвэрхэн цав цагаан будаа. Ким эмч хамгийн сүүлд цэвэр цагаан будаатай аяга хэзээ харснаа санахаар оролдсон ч чадсангүй. Ийм сайхан хоол яагаад ингээд газар хэвтэж байгааг ер ойлгосонгүй. Гэтэл гэнэт нохой хуцахаар нь л учрыг ойлголоо.

Энэ мөчийг хүртэл Ким эмч Хятадыг өөрийнхөө улстай адил ядуу хэмээн бодож байсан юм. Тэр өөрийнх нь эх орон дэлхий дээрх хамгийн сайхан газар гэж итгэхийг ямар их хүсэж байсан гээч. Бүх л амьдралынхаа туршид ой ухаандаа хадгалж ирсэн түүний итгэл үнэмшил нь нүдэн дээр нь замхран алга боллоо. Ингэж л тэрбээр Хятадын нохой нь Хойд Солонгосын эмчээс илүү сайхан хоол идэж байгаа бодит үнэнтэй нүүр тулсан юм.

АРВАН ЗУРГААДУГААР БҮЛЭГ

СОЛИЛЦООНЫ ЭХНЭРҮҮД

Эхний боломж гарангуут л Ок Хиг нутгаасаа оргон зайлна гэхэд хэн ч гайхахгүй биз. Хатагтай Сонгийн ууган охин Ок Хи сургуулийн сурагч байхаасаа л бүхэл үндэстнээрээ Ким Ир Сенийг тахин шүтэх хандлагатай эвлэрдэггүй байлаа. Хичээлээсээ ирэнгүүтээ л улаан бүчээ тайлаад шидчихнэ.

1994 онд Ким Ир Сенийг нас барахад дусал нулимс унагаагүй нэгэн билээ.

Гэрийнхэн нь өлбөрч байсан он жилүүдэд бухимдал нь тартагтаа тулав. Төр засгаа улс орныхоо эдийн засгийг унагасанд, аавынхаа, дүүгийнхээ үхэлд буруутган байлаа. Зурагтаар "Бид социалист эх орондоо хувцас, хүнс гэж зовохгүй амьдарч байна. Цээжээ тэнийлгэн дэлхийн улс түмнүүд рүү бахархалтайгаар харцгаая" хэмээн "Журмын Нөхдийн жагсаал" гэж нэрлэгдэх дуу дуулан, туг намируулан, хөл нийлүүлэн алхах хүмүүсийг гаргахад хөх инээд нь хүрч зурагтаа унтраадаг байжээ. Үнэн хэрэгтээ Ок Хигийн эх орноосоо зугтах шалтгаан нь эхлээд нөхрөөсөө зугтах хүслээс улбаалан гарсан бол дараа нь эх оронд нь ноёрхсон дэглэмээс хол байх үзэл болон хувирсан юм.

Гэрлэлт нь эхнээсээ л бүтэлгүй байсан билээ. Ок Хи нөхөр Ёнг Сутайгаа бусад хосын л адил мөнгө, сексээс болон хэрэлддэг байсан бол цаг хэцүү болоод ирэхэд хүнс, улс төрөөс болон муудалцдаг болжээ. Хэрэв Ок Хиг бууж өгөхгүй бол нөхөр нь хийсэж унатал нь алгаддаг байлаа.

Ёнг Су архи уудаг ч ажлаа хаясангүй. Энэ үед түүний галт тэрэгний үйлчлэгчийн ажил хамгийн ашигтайд тооцогдож байлаа. Ажлаа хийхийн хажуугаар бараа зөөж, Хятадуудад наймаалан амьдралаа болгоод байв. Үйлдвэрийн ажилчдын тоног төхөөрөмжөө тонож олсон зэс утас, хаягдал ганг нэг килограммыг нь таван воноор худалдан авч 25 воноор дамлан зарна. Нөхөр нь намын гишүүн биш мөртлөө гишүүн юм шиг аашилж аяглахаар нь Ок Хи эхэндээ гайхдаг байлаа. Тэр хувиа бодохын сул тал, капиталист нийгмийн бузар булай явдлын талаар эхнэр болон сонсож буй хүн бүхэнд амаа цангатал ярьдаг байжээ. Ким Чен Ирийг амаа олохгүй магтаж, Ок Хигийн тэвчээрийг бас бардаг байж. Гэтэл одоо шал өөр хүн болж "намын хэлсэн бүрийг тэнэг хүн л дагадаг байх. Мөнгө л бүх асуудлыг шийднэ шүү дээ" хэмээн ярьдаг болжээ.

Ёнг Сугийн хаягдал төмрийн бизнес цэцэглэж, нэлээд хөлжиж амжив. Хил яваад ирэхдээ уут уутаар нь цагаан будаа, шар буурцгийн сүмс гэртээ авчирна. Гэрт нь идэж уух зүйл ийм элбэг дэлбэг байхад өлбөрч үхэх шахаад байгаа эцэг эх, дүү нартаа жаахан илүүчилье хэмээн Ок Хиг асуухад шууд л "Цаг ийм хэцүү байхад бид яагаад хүнсээ бусадтай хуваалцах ёстой гэж" хэмээн боож үхэх шахна.

Ёнг Су Ок Хиг гэр бүлийнхэндээ нууцаар туслаад байна хэмээн харддаг учир галт тэрэгний хуваарь тодорхой бус үед хэдийд ирэхээ мэдэхгүй байж, өл залгах төдий хүнс, мөнгө орхиж явах

болов. 1998 онд найм, зургаан настай хоёр хүүхэд, эхнэрээ бүтэн долоо хоног огт идэх юм, мөнгө үлдээлгүй орхин явж байжээ. Тэр үеэр хүүхдийн баяр болж, хүү нь хичээлдээ үдийн хоол авч явах ёстой байлаа. Гэтэл гэрт нь идчихмээр юу ч байсангүй. Ок Хи гадуур хамаатан саднаараа гүйж, хүнс гуйсан боловч хэнд нь ч өгөхөөр юм байсангүй. Аргаа бараад зах ортол жигнэмэг зараад сууж буй дүүтэйгээ тааралдаж, овоо хэдэн жигнэмэг аваад сургууль руу гүйгээд очтол хүү нь тоглоомын талбай дээр нүд дүүрэн нулимстай буруу хараад сууж байлаа. "Миний хүү, ээжийгээ уучлаарай" гэж хэлээд ууттай жигнэмгээ өгөхдөө өөрийн эрхгүй нулимс нь асгарсан гэнэ.

Өмнө нь хөгжимчин байсан Ёнг Су сайхан хоолойтой, сэтгэл татам залуу, бас дээр нь мөнгөтэй болсон тул найзуудтайгаа хүүхэн эргүүлэн шөнө дөлөөр л гэрийн бараа харна. Нэг шөнө Ок Хи хүүхдүүдтэйгээ ид унтаж байтал хаалга дуугарч Ёнг Су орж ирэхдээ бүдэрч, түүнийг нь шоолсон эмэгтэй хүний инээх дуулдлаа. Найз бүсгүй нь үү, биеэ үнэлэгч үү гэдгийг Ок Хи ялгасангүй, ялгахыг ч хүссэнгүй.

Үүний дараа Ок Хи оргох төлөвлөгөөгөө нилээд бодож, эрчимтэй бэлдэж эхэллээ. Ок Хи салах өргөдөл өгч болох ч салчихвал орон гэр, үр хүүхэд ч үгүй үлдэх байв. Хэдийгээр Хөдөлмөрийн нам феодалын нийгмийн эмэгтэйчүүдийг дарлах бурангуй ёсыг халсан гэх боловч саллаа гээд эмэгтэй хүнд дээрдэх юм огт үгүй. Нөхөр нь яаж ч дарамталдаг байсан шүүхийн шийдвэрээр орон гэр, үр хүүхэд нь нөхрийн талд үлдэх нь мадаггүй. Тэгээд ч өмгөөлөх эцэг нь нас барсан, бас нийгмийн гарлын хувьд доогуур учраас өөрийнх нь талд шийдвэр гарна гэж горьдсоны ч хэрэггүй байжээ. Ок Хи Хятад явж мөнгө олон, байр авч чадвал нөхрөөсөө хүүхдүүдээ салгаж авах хөшүүрэг болж магад гэж горьдож байв.

Нэг шөнө Ёнг Су шөнө согтуу ирээд, эхнэрээ доороо хийж байгаад балбаж гарав. Ок Хигийн хавирга нь хугарчих шиг болжээ. Гэтэл гэнэт хаалга тогших сонсогдож, онгойлгож өгвөл нэгэн эр галт тэрэгний буудал руу очих зам асуун, нөхөр нь хариулах хооронд Ок Хи өндийж, гал тогоо руу гүйн ороод, тэндээсээ арын хаалгаар гадагш гаран зугтлаа. Унтлагын хувцастай Ок Хи шөнийн арван цагт зүг чигээ ч умартан гүйж гарлаа. Найман сарын сүүл болохоор шөнөдөө төдийлөн сэрүүн биш, даарахааргүй байв. Хэсэг гүйж, нөхрөө араас нь дагаж байгаа эсэхийг шалгасныхаа дараа хаашаа очихоо бодож хэсэг саатав. Өнгөрсөн арван жилд нөхрөө зодох болгонд аавынх руугаа гүйж, ээж нь түүний хавдсан уруул дээр жин тавин, цусыг нь угааж халамжилдаг байлаа. Маргааш өглөө нь Ёнг Су ирж уйлж дуулан, ахиж тийм үйлдэл гаргахгүй хэмээн учирлах гуйх хослуулан байж эхнэрээ гэртээ буцааж аваачна. Ок Хид хэрвээ амьдралаа өөрчлөх хүсэлтэй бол одоо л яг тэр цаг нь ирсэн мэт санагдав.

Ок Хи нөхрийнхөө хамт ажиллагсдад танигдахаас болгоомжилж, галт тэрэгний буудал руу оролгүй, зам даган хотын захын эхний буудал хүртэл алхлаа. Орон гэргүй тэнүүлчин олон болсон болохоор унтлагын хувцастай эмэгтэйг хэн ч анзаарсангүй.

Ок Хи галт тэрэгний буудал дээр хоёр хонов. Өлсөж цангасандаа хөл нь гуйван арай гэж тогтоно. Хилийн хот Мусан руу явах галт тэрэг хөдөлж, үдэгсэд хөл хөөртэй харагдана. Бүх хүчээ дайчлан галт тэрэг рүү дайрах олны дунд орж явчихлаа. Хүмүүс уралдан орж чадалтай нь суудал эзлэн, чадал муутай нь суудлын хажуугаар зогсож, багтахгүй зарим нь жорлон, тамбур

дээр зогсож, бүр багтахгүй нь галт тэрэгний ардаас зүүгдэн явж байлаа. Ялаа ч багтахааргүй шахцалдсан галт тэргэнд үйлчлэгч явж хүмүүсийн тасалбар, замын бичгийг шалгах ямар ч боломжгүй учраас Ок Хи асуудалгүй явсаар нэг хоногийн дараа Мусанд ирлээ. Түүнд бичиг баримт, мөнгө, хоол, хувцасны аль нь ч байсангүй.

Гучин хоёр настай, эрүүл чийрэг бие бялдар нь түүнд үлдсэн цорын ганц зүйл байсан юм. Ок Хи царайлаг сайхан бүсгүй биш байлаа. Ээж нь түүнийг ухаантай гэж магтахаас биш хөөрхөн гэж хэлж байсангүй. Харин дунд дүү нь кино од шиг царайлаг. Хэдий тийм ч гэсэн өлсгөлөнгийн хүнд үед Ок Хи амьдрах чадвараар бусдаас давуу байсан юм. Намхан, ээжтэйгээ адил бахим биетэй түүний жижигхэн хамар наснаас нь залуухан харагдуулж, инээхэд нь тэгш цагаан шүд нь яралзана. Ок Хи биеэ үнэлнэ гэхэд дэндүү хөгшдөхөөс гадна санаанд нь тийм зүйл буух ч үгүй байлаа. Гэхдээ үүнээс өөр арай аятайхан аргаар өөрийгөө худалдах боломж бас байв.

Түмэн голын цаахна эрдэнэ шишийн талбай шарлан үргэлжилнэ. Тосгод хоол хүнсээр биш эмэгтэйчүүд, эхнэрүүдээр дутаж байлаа. Уламжлал ёсоор эр хүйстнийг дээдэлж, хүүхдийн тоог хязгаарласаар Хятадад арван эмэгтэй тутамд арван гурван эрэгтэй ноогддог гаж тогтолцоонд хүрсэн байлаа. Насанд хүрэх үү үгүй юу охид хөдөөнөөс зугтаж, хотод ирэн тэр үед ид цэцэглэн хөгжиж байсан үйлдвэрүүдэд ажиллахыг эрхэмлэх болов. Хөдөөд гучин таваас дээш настай мөнгө болоод царай муутай, урагшгүй нэгэнд эхнэр олдох нь ховор. Иймээс хятад эрчүүд гурван зуу орчим доллар төлж зуучлагчид хандана. Залуухан, царайлаг эхнэртэй больё гэвэл илүү ч төлөх хэрэг гарна. Гэвч нас, царай хамгийн том үзүүлэлт биш байлаа. Бэлэвсэрч үлдсэн хөгшчүүл хоолоо хийлгэж, гэрээ цэвэрлүүлэх эрүүл чийрэг 60 гаруй насны эмэгтэйчүүдийг ч бас ихээр сонирхож байв.

Хятадуудын хувьд Хойд Солонгосын эмэгтэйчүүд боломжийн санагдана. Нүүр царай, биед нь өлсгөлөнгөөс болж өөрчлөлт орсон ч тэд Азидаа хамгийн царайлагт тооцогддог нь хөдөлшгүй үнэн. Өмнөд Солонгосын эрчүүд ярихдаа Хойд Солонгосын эмэгтэйчүүд, Өмнөдийн эрчүүдтэй нийлбэл удам зүйн хувьд хамгийн зөв хос болно хэмээдэг ажээ. Хятад эрчүүд тэднийг өөрийнх нь эмэгтэйчүүдээс хамаагүй даруу, дуулгавартай гэж үздэг.

Ок Хи Хятадуудтай гэрлэх зах зээлийн тухай бүгдийг мэднэ. Чонжинд ямар нэг эмэгтэй гэнэт алга болбол "завхай хүүхэн чинь өөрийгөө Хятад эрд зарчихаж" хэмээн шивэр авир хийлцэх бөлгөө.

Энэ зах зээл Мусаны галт тэрэгний буудалд анх үүсчээ. Санал ирэх хүртэл хүүхнүүд буудал дээр зогсоно. Ок Хиг зуучилсан хүн нөхрийнх нь хуучин анд байв. Тэр Ок Хид дараах саналыг тавьжээ. Хөтөч түүнийг Түмэн голыг гатлуулан, Хятад руу найдвартай хүргэж өгнө. Дотуур, гадуур хувцас, хоол, хоноглох газраар хангана. Хэдийгээр Хятадын хуулиар ийм төрлийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй боловч зууч Ок Хид таарсан нөхөр олж өгөх хүртэл аль нэг газарт түр амьдарна. Харин Ок Хи хариуд нь өөрийгөө зарсан төлөөсөө авахгүй.

Ок Хи нөхөр нь солонгосоор ярьдаггүй байх ганцхан нөхцөлтэйгээр энэ саналыг зөвшөөрлөө. Ихэнх эмэгтэй солонгосоор ярьдаг болохоор нь уугуул солонгос эртэй гэрлэхийг хүсдэг байхад

Ок Хигийн хүсэл эсрэгээрээ байлаа. "Намайг хэн ч таньж мэдэхгүй, цоо шинэ орчинд ажиллаж, амьдармаар байна" хэмээн зуучдаа хэлжээ.

Ок Хид оногдсон эр гуч гаруй настай тариачин байв. Тэр 152 см орчим нуруутай, Ок Хигээс өндөргүй. Болхидуухан, мэдрэл муутай мэт харагдах ба ичээд шинэ эхнэрийнхээ нүдийг ч харж чадахгүй дальдрах ажээ. "Эхнэр аваагүйг нь гайхах хэрэггүй л юм байна" хэмээн Ок Хи бодов. Тэднийг Хятадын хил дээрх жижгэвтэр зоогийн газар анх танилцуулжээ. Ок Хитэй хамт хил давж ирсэн өөр нэг бүсгүйд арай хөгжилтэй өндөр залуу таарсанд нь Ок Хи атаархжээ. Гэвч үнэндээ өөрт нь таарсан эр хүссэн хүн нь биш гэж үү. Тэр хэзээ ч хайрлахааргүй тийм л эртэй суухыг хүссэн биз дээ.

Хэдэн мянган эмэгтэй хятад эрчүүдэд ийнхүү зарагдсан билээ. Зарим тооцоогоор Хятадад амьдардаг ойролцоогоор 100,000 Хойд Солонгос иргэдийн гуравны хоёр нь эмэгтэйчүүд ба талаас илүү нь хятад эртэй зуучлуулан гэрлэсэн ажээ. Бүсгүйчүүд зодуулж, хүчиндүүлж, гинжлүүлж боол мэт ажилладаг гэсэн яриа бий. Тэднийг бодвол Ок Хид аз таарав. Нөхрийг нь Миньюан гэдэг, тэр Ёнг Су шиг царайлаг биш ч тайван, дөлгөөн, заримдаа хэт гэнэн ч гэмээр. Анх удаа орондоо оруулахдаа гар дээрээ өргөж, хувинтай бүлээн усанд хөлийг нь угааж өгчээ. Ок Хид тусгай хоол хийж өгч, гал тогоо бариулдаггүй байв. Эцэг эх нь ч мөн адил хандлагатай.

Ок Хи тэр залуутай хоёр жил гаруй хамт амьдарсан юм. Хятад хэл сурч, нөхөртэйгөө хэл нэвтрэлцдэг болов. Сургуулийн хүүхдийн газарзүйн ном судалж, зүг чигтэй болохыг хичээж байв. Тэр анх хил давснаасаа 960 километрийн зайд орших Шандон мужид амьдарч байлаа. Ок Хи автобусны чиглэлийг тогтоон оргохдоо бэлдсээр л байв.

Тэр хоёр удаа жирэмсэлсэн ч үр хөндүүлжээ. Миньюан хүүхэд маш ихээр хүсэж байсан боловч Ок Хи шалтаг тоочин хавьтуулсангүй. Хятадын засгийн газар Хойд Солонгосын эмэгтэйтэй гэрлэсэн гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй учир хүүхэд нь сургуульд ч сурах эрхгүй нэгэн болох билээ. Би хоёр хүүхэдтэй хүн. Нэг л өдөр тэдэн рүүгээ явна гэж Ок Хиг хэлэхэд Миньюан уйтгартайгаар толгой дохидог байжээ.

Явах цаг нь болоход Миньюан Ок Хиг автобусны буудал дээр хүргэж өгөөд зуун доллар өгсөн байна. Миньюан уйлжээ. Ок Хи Миньюаныг үлдээч хэмээн гуйх байх гэж бодсон ч тэгсэнгүй. Анхных нь бодсон шиг мэдрэл муутай хүн ч бас биш байж. Болгоомжтой яваарай гэж хэлээд л Ок Хиг үдэж өгсөн юм.

Ок Хигийн аялал аюул дагуулахуйц байв. Учир нь 2000 он гэхэд хятадууд олноороо цувах Хойд Солонгосчуудаас залхаж, иргэдийнх нь ажлын байрыг булаацалдан, зүүн хойд Хятадын үндэстний тэнцвэрт байдлыг алдагдуулж байна хэмээн үзэх боллоо. Хүний эрхийн төлөө тэмцэгчид Хятад улс нутагт нь хүнс, аюулгүй байдал эрж ирсэн хүмүүст туслах ёсзүйн болон хуулийн үүрэгтэй болохыг нь сануулж байхад, хятадууд яг эсрэгээр, хууль бусаар хил зөрчиж ирсэн этгээдүүдийн тухайд бол манайх НҮБ-ын Цагаачлагчдын Статусын Конвенцид нэгдсэн ч гэлээ үүрэг хариуцлага хүлээх шаардлагагүй хэмээн эсэргүүцэж байжээ. Үнэн хэрэгтээ Хятад улс Хойд Солонгосын Ардын Аюулгүй Байдлын Яамтай 1986 онд хоёр талын хил зөрчигсдийн эсрэг

хамтран ажиллах нууц гэрээнд гарын үсэг зурчихсан, түүндээ захирагдахыг илүүд үзсэн байж.

Хойд Солонгосын цагаачдыг барих кампанит ажлыг Хятадын засгийн газраас үе үе явуулдаг байлаа. Хилийн ойролцоо замын хаалт байрлуулж, хил нэвтрэгсдийн бичиг баримтыг шалгадаг болов. Хятадад хэдэн сар амьдарсныхаа дараа Хойд Солонгосын иргэдийн амьдрал сайжирч, шинэ хувцас худалдан өмсөж, уугуул Солонгосчуудаас амар ялгагдахааргүй болцгооно. Иймээс Хятадын засаг захиргаа Хойд нутгийн цагдаа нарыг нутагтаа ирүүлж, иргэдээ барих боломж олгож эхэлжээ. Оргогсод өөрсдөө ч тагнуул болж, бие биеэ барьж өгөх тохиолдол гарч байлаа. Мөн хятад иргэдтэй амьдарч буй Хойд Солонгос эмэгтэйчүүдийг барьж өгсний шан харамж болгож дөчин доллар өгөхөөр зар тараасан гэнэ. Үүний үр дүнд эмэгтэйчүүдийг гэрээс нь барьж, хууль бус нөхөр хүүхдээс нь салгаж эхэлжээ. Хятад эрчүүд тийм эхнэртэй байсныхаа төлөө торгууль төлсөн ч хүүхдээ авч үлдэх эрхтэй. 2000 оны гурван сард болсон нэгэн кампанит ажлын үр дүнд найман мянга орчим эмэгтэй баригдаж нутаг буцжээ. (2009 он гэхэд ч энэ ажиллагаа явагдсаар байлаа).

Тосгон нь Хойд Солонгосын хилээс хол байсан учир Ок Хи хятад нөхрийнхөө гэрт айх аюулгүй аж төрж байсан юм. Гэвч мөнгө олохын тулд солонгосоор ярьдаг хүмүүс амьдардаг, бас боломж ихтэй хил рүү явахаас өөр аргагүй байлаа. Ок Хи эрх чөлөө, үр хүүхдээ зөвхөн мөнгөтэй байж л олж авна гэсэн бодол үргэлж сэтгэлдээ тээнэ. Амарч тэнхэрсэн тэрээр эхний ээлжинд зоогийн газар юм уу, үйлдвэрт ажил олж хийгээд дараа нь хөл дээрээ боссон хойноо бие даан бизнес эрхлэх төлөвлөгөө гаргав. Ингээд хойд зүг рүү явах автобусанд суун, хил давж ирсэн нутаг руугаа бус Дандон хэмээх Хятад Солонгосын хил дээрх томоохон хотуудын нэгэн рүү явлаа.

Дандон хөл хөдөлгөөн ихтэй, хөгжил сайтай хот. Ялу голыг даган шилэн нүүртэй, гялалзсан сайхан барилгууд сүндэрлэж, бүтээн байгуулалт ид өрнөж байлаа. Голын цаана байх Хойд Солонгосын хөгжилтэй харьцуулахад өдөр шөнө шиг ялгаатай харагдана. Гэвч Ок Хигийн хувьд Дандон тийм сайн сонголт биш болох нь тодорхой болов. Бээжин, Пхеньяны галт тэрэгний гол зам уг хотоор дайран гардаг, Хятад Солонгосын албан ёсны худалдааны ихэнх нь энд байх Найрамдлын гүүрээр дамжин хийгддэг, мөн Хойд Солонгосын худалдааны байгууллагууд энэ хотод төлөөлөгчийн газартай. Түүнчлэн үнэн дүрээ нууцалсан тагнуулчид хөлхсөн газар байв.

Ок Хи 2001 оны нэг сард баривчлагдан нутаг буцаж Синьюжугийн цагдаагийн газарт хүргэгдэв. Хоёр жилийн дотор эх оронд нь бий болсон өөрчлөлтийг хараад Ок Хи арай л ухаан алдаж унасангүй. Тэсгим өвлийн хүйтэнд цагдаагийн газарт нь халаалт байхгүй. Цагдаа, хоригдлууд нь адилхан даарсандаа чичирцгээж байлаа. Цагдаагийн офицер цаас байхгүйгээс ялыг нь модон дээр бичлээ. Ок Хид аз дайрч Ким Чен Иррийн төрсөн өдөр дөхөж байсан учраас хөнгөн ялтай хоригдлуудыг өршөөлөөр суллаж таарав. Ингээд Ок Хи хоёрхон долоо хоногийн дараа суллагдах нь тэр.

Суллагдаад удалгүй ахиад гол гаталж Хятад руу нэвтрэв. Баривчлагдахынхаа өмнө тэр зоогийн газар, тоосгоны үйлдвэрт ажиллаж өдрийн нэг хоёр доллар олж байсан нь Хойд Солонгосын стандартаар бараг сарын цалинтай дүйцэхүйц боловч Хятадад бол тийм их мөнгө биш байлаа. Иймээс ахиухан цалинтай ажил эрэх санаа төрж, цалин сайтай л байвал эрсдэлтэй ч хамаагүй

ажил хайж эхэллээ. Ингээд эцэст нь гэр бүл, хамаатан садныг уулзуулдаг зуучлалын ажил олдов. Хамгийн анхны даалгавар эцэг эх нь Хятад руу гарсан айлын хүүхдийг олж Түмэн голыг гатлан Хятад руу авчрах явдал байлаа. Тэр зөвшөөрөв.

Хүүхдийг Мусанд амьдардаг гэж Ок Хид хэлсэн байв. Тэр Мусаныг сайн мэддэг, нутгийн аялгууг нь мэдэх учир бусдын анхаарлыг татахгүйгээр хэдэн өдөр гадуур яваад хүүхдийг олно гэдэгтэй итгэлтэй байжээ. Гэвч тэр буруу бодож. Мусанд очсон эхний өдөр нь л Ок Хиг хурсан олны дундаас нэгэн цагдаа баривчилжээ. Тэр Хятадад хоёр жил амьдарсны дараа таргалж өнгө зүс орсноос гадна сайхан үнэртэй шампуниар үсээ угаасан учир бусдаас өөр, үнэр нь ч ялгаатай байжээ. Түүнээс гадна уг цагдаа хэрэглэж байсан халаасны радиог нь хураан авснаар барахгүй Өмнөдийн суваг руу яаж тавьдгийг нь заалгаж, чихэвчийг нь ч хураан авчихжээ. Ингээд түүнийг Бовибу руу шилжүүллээ.

Ок Хи зуу гаруй хүнтэй нэгэн саатуулах газар хүргэгдэв. Тэднийг сөхөрч суугаад хөдлөхгүй байхыг тушаав. Өвдөг нь чилээд суудлаа зассан хүмүүсийг эгнээнүүдийн дундуур алхах харуул зодож занчина. Нэг удаа зодуулсныхаа дараа Ок Хигийн нүднээс бусад нь хөдлөхөө болив. Хамт хоригдож байгаа эмэгтэйчүүдийг ажиглахад Хятадад байгсад нь андашгүй, царай зүс гэгээлэг, хувцас хунар сайтай, эрүүл харагдана. Бусад нь эцэнхий, ноорхой, гуталгүй, үс гээг нь ширэлдсэн нь гол гатлахаасаа өмнө баригдсан бололтой.

Хоёр бүлгийг хамтад нь хорьсон явдал сайны шинж гэж Ок Хи бодов. Цагдаагийнхан түүний зуучлах ажил хийснийг мэдэхгүй өнгөрвөл л аврагдах найдвартай. Радиог нь хураасан цагдаа цааш дамжуулалгүй өөртөө үлдээж, байцаагчид нь энэ тухай мэдээлээгүй байх гэж найдав. Тухайн хүний нийгмийн гарал үүсэл, хил зөрчөөд Хятадад юу хийж байсан зэргээс шалтгаалаад оногдох шийтгэл янз бүр. Хоол хүнс хайж хил зөрчигсөд хамгийн хөнгөн ялаар шийтгүүлнэ. Харин Хятадад ажиллаж байсан, Хятад эрчүүдэд эхнэр зуучилж өгсөн, Өмнөд Солонгосчуудтай уулзсан, сүмд очсон, DVD зарсан зэрэг үйлдлүүд хөдөлмөрийн лагерьт насаараа хоригдох эсвэл цаазлах ялаар шийтгэгдэнэ.

Удалгүй хоригдлуудыг амьдардаг газраар нь ангилав.

Ихэнх нь Чонжины оршин суугчид байж таарав. Бүх хүнд хүртэхээр гав байхгүй учраас цагдаа нар хоригдлуудыг гурав гурваар нь, эрхий хуруугаар нь нийлүүлэн, гутлын нийлэг үдээсээр хүлэв. Эрхий хурууг нь чивчиртэл уясан учир цусны эргэлт зогсож хөхөрчээ. Хоёр хүний суудалд гурвуул шахцалдан явцгааж байв. Ок Хигийн эсрэг талд нэгэн эр халаасаа ухахыг харлаа. Тэр эр азаар тамхины асаагуураа авч үлдсэн байсан тул эрхий хурууныхаа үдээсийг шатааж, гурван эр яах ийхийн завдалгүй цонхоор үсрэн зугтав. Хүүхнүүд бие засах газар руу явахаас бусад тохиолдолд хөдлөх эрхгүй. Нэг нь бие засах болоход нөгөө хоёр нь дагаж явах хэрэг гарна. Явсаар галт тэрэг зогслоо. Цонхоор хартал Чонжины галт тэрэгний буудал. Ингэж Ок Хи Хятад руу оргосноосоо гурван жил орчмын дараа буюу 2001 оны есдүгээр сард төрөлх хотдоо айдас, ичгүүр тээсээр буулаа.

Цагдаа нар бөхий бөхий хэмээн хашгичиж байв. Ок Хи ч таньдаг хүнтэй тааралдахаас халшран,

тэртэй тэргүй толгойгоо бөхийлгөн явж байлаа. Тэд буудлын хүлээлгийн өрөөгөөр дамжин, ээж нь жигнэмэг зардаг байсан гол танхимаар гатлан, гэрийнх нь цонхны доогуур шахам өнгөрлөө. Тэр өмнө нь ийнхүү өнгөрөх хоригдлууд дотор таньдаг хүн байгаа эсэхийг цонхоороо харан саваагүйтдэг сэн.

Тэднийг цааш нь Чонжины төв замаар цугларсан олны дэргэдүүр дагуулан явж, дараа нь гүүрээр гарч, үйлдвэрийн дүүргийн хажуугаар өнгөрөн, хотын будаа тариалдаг цорын ганц газар болох намгархаг талбайн дэргэдүүр өнгөрөв. Далай руу эргэж, дээгүүр нь өргөстэй төмөр татсан цементэн хашаатай Нонгпогийн Хорин Саатуулах Төв хэмээх газар авчирлаа. Энэ барилгыг япончууд эзлэн түрэмгийллийнхээ үеэр барьж, өөрсдийг нь эсэргүүцсэн хүмүүсийг хорьдог байжээ. Нонгпо хэмээх нэр нь л дангаараа хэмжээлшгүй их айдас дагуулна. 1970-1980-аад оны үед ажлаас зайлсхийж баашилсан хүмүүсийг хорьдог газрыг ийнхүү нэрлэдэг байжээ. Одоо энэ газрыг хил зөрчсөн болон зөрчихөөр завдсан хүмүүсийг хорих газар болгон ашиглаж байлаа.

Эмэгтэй хоригдлууд гурван том өрөөг гишгэх ч газаргүй болтол нь дүүргэж, зөвхөн хажуу тийшээ харж унтацгааж байлаа. Багтаагүй хүүхнүүд жорлонгийн хажууд шөнийг өнгөрөөхөөс өөр аргагүй. Хэд хоноод л зуу зуугаараа хоригдлууд ирцгээнэ. Хуягууд шинээр ирэгсдийг нүцгэлэн нэгжиж, жирэмсэн эмэгтэйчүүдийг ангилан хэдэн сартай ч байсан хамаагүй эцэг нь хятад хэмээн үзэж үр хөндүүлэхээр явуулж байлаа.

Нонгпод эмэгтэй хоригдлын тоо эрэгтэйчүүдийнхээс хоёр дахин их байв. Бусад эмэгтэйчүүдийн хил зөрчих болсон шалтгаан өөрийнхтэй нь тун төстэй байсныг Ок Хи олж мэдэв. Олонх нь, мөнгө хүнс олоод нөхөр хүүхдүүддээ буцаж ирэхээр шалтаг болгон оргоцгоосон байлаа. Ок Хи эмэгтэйчүүдийг болон өөрийгөө үзэн ядаж байлаа. Хүүхдүүдээ орхисондоо өөрийгөө уучилж чадсангүй.

"Бид чинь юу гээчийн өлөгчингүүд болж хувираа вэ?"

Өлсгөлөн бидний хүн төрхийг алдуулжээ" хэмээн Ок Хи бодлогошрон байлаа.

Хорих лагерьт бодох хугацаа хангалттай байв. Боолын хөдөлмөр олон цагаар хийсний дараа өөрийн шүүмжлэлийн цаг шөнө дөл хүртэл үргэлжилнэ. Хоол гэхээр юм бараг өгөхгүй, өлөн зэлмүүн байлгаж, харгис хэрцгий ханддаг байжээ. Гэтэл Нонгпо бусад лагериудтай харьцуулахад хамгийн сайн нөхцөлтэй нь байсан гэх. Тэнд Бямба гариг болгонд голоос ус зөөж, усанд орох бололцоо олгоно. Хүүхнүүд бие биеийнхээ үснээс бөөс түүцгээнэ. Хорих лагерьт байх хугацаандаа нэг л эмэгтэйг зэрлэгээр зодуулахыг Ок Хи харжээ. Тэр эмэгтэй лагерийн хашаа давах гэж оролдож байгаад баригдаж ухаан алдатлаа балбуулсан юм. Ок Хид хоригдол бүсгүйчүүд айдас багатай байгаа мэт санагддаг байлаа. Тоосго цохих, ногооны талбайг зэрлэг өвснөөс цэвэрлэх гээд албадлагын ажлаа хийж байхдаа бүсгүйчүүдийн нүүрэнд байнга дургүйцэл тодорно. Бидэнд бүх амьдралын маань туршид худал хэлдэг байж. Амьдрал маань худал хуурмаг. Энэ нийгэм тэр чигтээ худал хуурмагаар дүүрэн гэж Ок Хи боддог байсан бөгөөд бусад эмэгтэйчүүд ч адил бодолтойд итгэнэ.

Хорих лагерийн ажилтнууд өөрсдөө ч хүртэл хоригдлуудыг засан хүмүүжүүлэх ажлаас залхаж, Хөдөлмөрийн намаас бэлдэж өгсөн лекцийг хоригдлуудал уншиж өгсөн болж, оромдож байлаа. Хүн бүхэн хуурамч байдлаас залхсан шинжтэй харагдана.

Нэг өдөр эмэгтэйчүүд эрдэнэ шиш түүж байх зуур хорих төвийн захирал урьдчилан бэлдэж өгсөн лекц уншихаар талбай дээр ирлээ. Захирал тэднийг Ким Ир Сений үзэл суртлаар өөрсдийгөө зэвсэглэхийг шаардаж, капитализмын эсрэг тэмцэж, эх орон ард түмнийхөө төлөө өөрсдийгөө зориулах ёстойг ухуулах завсраа дахин Хятад руу оргохгүй гэсэн баталгаа өгч гараа өргөхийг хүсэв. Гэтэл хоригдлууд бүгд чимээгүй болж хэн нь ч гараа өргөсөнгүй. Ок Хи хэзээ ч ийм юм болно гэж төсөөлж байсангүй. Аргаа барсан дарга чимээгүй байдлыг эвдэж та нар дахин орговол баригдаж болохгүй шүү хэмээн анхааруулжээ.

Үнэн хэрэгтээ Ок Хи аль хэдийн дахин оргож, Хятад руу гарах тухайгаа бодож эхэлсэн байлаа. Нэгэн өдөр түүнд лагерийн хашааны гадна боловч өргөст торны дотор хэсэгт зэрлэг өвс зулгаах үүрэг ноогджээ. Гэтэл өргөст тортой хашааны ойролцоо нэгэн эмэгтэй ямаа хариулж явахыг харж, эргэн тойронд нь хуяг байгаа эсэхийг шалгасны дараа түүнийг дуудаж хэсэг зуур яриа өрнүүлэв. Ээжид нь өөрийг нь Нонгпод байгааг дуулгах юм бол дотоожоо өгье гэв. Хойд Солонгост эмэгтэй хүний дотоож олдоц муутай тул энэ нүдээ олсон санал байж эмэгтэй ч зөвшөөрлөө. Ингээд Ок Хи саявтархан Хятадаас авсан шинэ шахам дотуур өмдөө тайлж, дунд нь ээждээ бичсэн зурвасаа хийж, бөмбөг болгон хумиад мөнөөх эмэгтэйд хашааны завсраар дамжуулан өгчээ.

АРВАНДОЛДУГААР БҮЛЭГ

НҮДЭЭ НЭЭГЭЭД, АМАА ХАМХИ

Хатагтай Сонг охиноо хорих лагерьт байгааг мэдээд төдийлөн гайхсангүй. Гурван жилийн өмнө гэрээсээ оргосноос нь хойш ямар ч сураг дуулаагүй хатагтай Сонг бусад урвагч, садар эмстэй адил Хятад руу л оргоо биз хэмээн дургүйцэн бодож явжээ. Эх орноосоо урвасан бол шоронд оролгүй яахав хэмээн бодсон боловч үр нь л юм хойно хатуурхаж чадсангүй. Ууган охиноо Чонжины хамгийн зартай хорих төвд шар махтайгаа хатаж байхад нь буянаараа болог гээд орхиж яаж чадах билээ.

Өлбөрч үхэхийн даваан дээр өнгөрүүлсэн он жилүүддээ хатагтай Сонг их олон эргэлзээгээ гээсэн байна. Ямар ч бэрхшээлтэй асуудлыг хахуулиар шийдэж болдгийг аль хэдийн мэдэж, гудамжны арга барилаас суралцаж эхэлсэн байлаа. Ким Ир Сенийг хараагаад шоронд орчихоогүй л бол хангалттай мөнгө байхад барагтай ялаас мултарч дөнгөдөг цаг үе ирсэн байлаа. Ингээд хатагтай Сонг хар зах дээр очиж, арван боодол тамхи нэг бүрийг нь 50 воноор худалдан авлаа. Бүтэн долоо хоногийн орлогыг нь залгиж буй охиноо дотроо зэмлэн, эрж сурагласаар явж Нонгпог хариуцсан ардын аюулгүй байдлын ажилтныг олов.

Хэдэн өдрийн дараа охин нь хаалгыг нь тогшиж үүдээ тайлав уу, үгүй юу эхийнхээ гар дээр муужран унажээ. Арван сарын сүүлч болж, цаг агаар аль хэдийн хүйтэрсэн байхад Ок Хид өмссөн хувцас бараг үгүй, хөл нүцгэн орж ирэхийг хараад хатагтай Сонг өр нь өмрөх дөхөв. Нонгпод байхад нь гуталдаа мөнгө нуусан байж магад хэмээн хардаж гутлынх нь улыг юу ч үгүй хуулснаас гадна өөрөө цамцныхаа ханцуйг цуулж сарын тэмдэг ирэх үедээ хэрэглэсэн байв. Дотуур өмдөө ямаачин эмэгтэйд өгч, үлдсэн хувцас нь тэр гэхийн тэмдэггүй урагдаж, үс нь бөөс хуурсанд баригдсан байлаа. Гэвч усанд оруулсны дараа охин нь гурван жилийн өмнө гэрээсээ зугтахынхаа өмнөхөөс илүү өнгөлөг, эрүүл чийрэг харагдаж байгааг хатагтай Сонг олж үзлээ. Хэдэн долоо хоногийн турш зутанархуу зүйл, эрдэнэ шишийн голоор өл залгаж байсан ч гэлээ бие нь булчинлаг байжээ.

Ок Хи тасралтгүй ярьж гарлаа. Хөөрсөндөө болоод бараг нэг амьсгаагаар шахам, Хятадад хүмүүс өдөрт гурван удаа цагаан будаа иддэг болох, зах дэлгүүр нь тэдний төсөөлшгүй эд бараагаар дүүрэн байдаг, сүүлийн үеийн загвар ямар байдаг гээд л бүгдийг ярьж өгөв. Ярьсныг нь үг гээлгүй сонссон ээж, хоёр дүүд нь нэг талаар үлгэр шиг, нөгөө талаар улс төрийн ухуулга мэт сонсогдож байлаа.

Өмнөд Солонгост амьдрал ямар байдаг гэнэ? хэмээн тэд сонирхон асуув.

Ок Хи өөрөө очиж үзээгүй учир тодорхой мэдээлэл байхгүй ч зурагтаар үзсэн кино, хүмүүсийн ярианаас олж авсан мэдээллээ хуваалцав. Өмнөд Солонгос бол маш баян орон. Хятадууд ч тэдний хэр баян болохыг төсөөлөхгүй. Хажууд нь Хятад юу ч биш. Би үхэхээсээ өмнө яадаг ч байсан Өмнөд руу явна хэмээн тэр шийдэмгий хэллээ.

Дүү нар нь Ок Хигийн өмнөөс хараад шалан дээр завилан сууж, эгчийгээ алмайран ширтэцгээж байлаа. Заримдаа ярьсан зүйлийг нь бишрэн шүтэвч үе үехэн айдаст автана. Төмөр замын харуултай гэрлэсэн дунд дүү нь бусдаасаа илүү ярианд автаж, Ок Хиг ярих тусам том нүд нь улам бүлтийсээр байлаа. Тэгснээ Ок Хигийн яриаг эргэлзэнгүй байдлаар таслаад, өглөөхөн ээж нь тоосыг нь арчсан эцэг хүү удирдагчийн зураг руу заан "Гэхдээ манай генерал бидний төлөө маш их зүйл хийсэн шүү дээ".... хэмээн ээрэв.

"Танай генерал чинь та бүгдийг солиотой болгосныг харахгүй байна уу? хэмээн Ок Хи өөдөөс нь тас хийтэл хариулав.

Нөхрөөсөө салж, ээжтэйгээ амьдрах болсон бага дүү нь харин том эгчийнхээ ярианд бүрэн автсан ч хэт илэн далангүй ярих түүний өмнөөс бас зовж байлаа. Хэдийгээр хатагтай Сонгийн байшин бусдаас тусгаар боловч гадаа үүдэнд хүн яриаг нь чагнаад зогсож байх бүрэн боломжтой билээ. Энэ гэр бүл хангалттай зовлон амссан, одоо болоо биш үү.

"Та болгоомжтой бай л даа. Ер нь бүгд болгоомжлохгүй бол юу болохыг мэдэж байгаа шүү дээ" гэж тэр анхааруулан хэлэв.

Ок Хи ээж, дүү нартаа сүүлийн гурван жилд туулсан амьдрал, Хятадын сайн сайхны талаар ярьж дууссанахаа дараа сэнхрүүлэх ажилд орлоо. Ойр хавийн айлын эзэгтэй нар Ок Хид эсэн мэнд эргэж ирсэнд нь баяр хүргэнгээ яриаг нь сонсохоор цував.

"Нүдээ нээцгээ л дээ. Манай эх орон тэр чигээрээ шорон л гэсэн үг. Бид ямар өрөвдөлтэй амьдарч байна гээч. Дэлхийн бусад орнуудад хүмүүс яаж амьдарч байгааг та бүхэн огт мэдэхгүй байна" гээд л Ок Хи ухуулгаа эхлэв.

Зурагтаар Ким Чен Ирийг гарах болгонд л Ок Хи "хулгайч, бузар амьтан, худалч" хэмээн хараан зүхэх боллоо.

Сүүлдээ хатагтай Сонгийн тэвчээр алдагдаж эхлэв. Ок Хигийн энэ замбараагүй яриа гэрийнхнээ аюулд оруулж мэдэхээр байв. Өөрийнх нь төрсөн охин биш байсан бол хорьтын даргын үүргээ биелүүлж, хэдийн дээш нь уламжлах байлаа. Энэ бүхнийг сонссон ч хатагтай Сонгийн төр засагтаа үнэнч үзэл өөрчлөгдсөнгүй.

"Чи наад амаа тат. Эх орон, ард түмнээсээ урвачихаад юундаа бахархаад байгаа юм бэ?" хэмээн охин руугаа хашгирав.

Барагтай бол загнадаггүй ээжийгээ ийнхүү хашгирсанд Ок Хи гайхсан боловч дуугаа татахыг хүссэнгүй. Харин ч ээжийгээ хорон үгээр булж гарлаа.

Та яах гэж намайг ийм аймшгийн газар төрүүлсэн юм бэ? Та Ким Чен Ирт надаас илүү хайртай юм уу?

Эх охин хоёр тасралтгүй үзэлцсээр сар гаруй болсны эцэст Ок Хи дараагийн алхмаа хийх тэнхээтэй боллоо. Өмнөх гашуун туршлагаасаа хангалттай суралцсан болохоор ахиж алдаа гаргалгүйгээр Хятад руу буцан очиж, ажил хийж, мөнгө олох төлөвлөгөөтэй байгаа тухайгаа ээж дүү нартаа дуулгав. Хатагтай Сонг охиндоо их л дурамжхан мөнгө зээлүүллээ. Үнэндээ охиныхоо төлөө сэтгэл зовохоос залхаж, явсанд нь баярласан байна.

Ок Хигээс сураг гаралгүй найман сар боллоо. Гэтэл нэг өдөр нэг эмэгтэй хаалгыг нь тогшоод, охиноос нь сураг авчирснаа ярив. Хатагтай Сонг охиноо дахин шоронд орсон байх хэмээн сэжиглэж, хэрхэн хахуульданд гаргаж авах талаар л цухас бодож амжингаа эмэгтэйд гэртээ оруулжээ. Гэтэл охин нь сайнаар барахгүй Хятадын хилийн ойролцоо тосгонд ажил хийж, ээждээ өрийг нь төлөх мөнгөтэй болсон, бүр гэрийнхэндээ хувцас хунар, бэлэг сэлт авсан тухайгаа дамжуулжээ. Гэхдээ өөрөө Чонжинд дахин ирвэл баригдаж магадгүй учраас ээжийгээ хил даван өөр дээрээ ирээч гэсэн байлаа.

Хатагтай Сонг эргэлзэж байв. Тэр энэ эмэгтэйд танихгүй. Гэр бүлд нь бөөн уй гашуу авчирсан 1995 оноос хойш хаашаа ч аялсангүй. Жигнэмэгийн бизнес нь амжилттай байсан болохоор үнэндээ түүнд мөнгө тийм ч их хэрэгтэй байсангүй. Сонгпёны зах наймаачдад зориулан дээгүүрээ саравчтай лангуунууд барьж өгсөн, өөрөө түрээсээ төлөх чадалтай, бас зөвшөөрөлтэй болохоор хийж байгаа зүйлдээ сэтгэл хангалуун болсон байв. Тэрбээр нэгэн ахимаг насны сайхан сэтгэлтэй бэлэвсэн эртэй хамтран амьдрах болж, амьдралдаа урд өмнөхөөсөө илүү хангалуун байлаа. Иймээс Хятад руу эрсдэл дагуулсан аялал хийх ямар ч хэрэгцээгүй юм. Гэтэл нөгөө талаас Ок Хиг шоронгоос гаргах гэж хахуульд хэрэглэсэн 500 вон нь бас чангаа аж. Нөгөө эмэгтэй хатагтай Сонгийг галт тэргээр явах хэрэггүй, охин нь хувийн машин хөлсөлсөн гэхэд сэтгэл нь хөдлөөд зөвшөөрч орхив.

2002 оны зургаадугаар сарын бороотой, халуун өдөр хатагтай Сонг Мусан руу хөдөллөө. Охин дээрээ очоод нэг хоноод ирэх төлөвлөгөөтэй учир их юм авсангүй, хөнгөн явж байв. Гэтэл заасан газар нь очтол Ок Хи байгаа шинж алгаа. Ок Хиг хил дээр ажиллаж байгаа л гэж сонссоноос биш аль хил дээг байгааг нь асуугаагүйгээ хатагтай Сонг анзаарав. Гэтэл хөтөч эмэгтэйн хэлснээр Ок Хи Хятадын талд байгаа ажээ.

Та мөнгө, хувцсаа авахын тулд Хятад руу явах хэрэгтэй. Охин чинь тэнд таныг хүлээж байгаа хэмээн нөгөө эмэгтэй хэллээ. Хатагтай Сонгийг өөрийн нөхөр гэж нэрлэсэн нэгэн эртэй танилцуулаад "Та санаа зовсны хэрэггүй. Нөхөр маань танд тусална" хэмээн хэлэв. Ийм хол ирчихээд буцалтай нь биш гээд явахаар шийдэв. Тэд Хөүрэнг хэмээх бас нэг хилийн хот руу өөр машин хөлөглөн давхилаа. Тэнд очоод харанхуй болтол хүлээв.

Тэднийг гол дээр очиход арван цаг болж, ширүүн бороо орж таарав. Гол эргээ халин урсаж, эрэг нь нялцгай шавраар дүүрсэн байв. Хатагтай Сонг газар хаана дуусаж гол хаанаас эхэлж буйг ч олж харахгүй байжээ. Гэтэл Хойд Солонгосын хилийн хоёр цэрэг ирж нэгдлээ. Нэг нь түүнийг хүүхэд шиг нуруун дээрээ дүүрч, нөгөөх нь хатагтай Сонгийг дүүрсэн цэргийг унахаас сэргийлж гараас нь хөтлөөд гол гаталлаа. Тэд хэд хэдэн удаа бүдэрч, арай л усанд тэр чигээрээ уначихсангүй.

Хэрэв унасан бол давалгаа ядах юмгүй урсгаад явчихаар харагдана. Хойд Солонгос дахь үеийнхнийхээ адил хатагтай Сонг сэлж чадахгүй. "Намайг буцаагаад гаргаад өгөөч. Би буцмаар байна" хэмээн хашгирч, усны давалгаанд хахаж цацан сэхээ авч ядаж байтал хөтөч яах ийхийн зуургүй голын урсгал сөрөн уснаас гарлаа. Нэг хөтөч нь хилийн харуулуудад мөнгө өгч голыг гатлан нутаг руугаа буцаж явлаа. Харин нөгөө хөтөч нь хатагтай Сонгийг дагуулан харанхуйд Хятад руу явав. Уул өгсөн явсаар, гэгээ ороход нэгэн жижиг тосгон руу орж ирлээ.

Тосгонд ирмэгцээ хатагтай Сонг хэзээ ч сууж үзээгүй таксинд баахан гэрэвшин орж суув. Ачааны машин, суудлын тэрэг, мотортой дугуй, тэрэг гээд л зүсэн зүйлийн тээврийн хэрэгслүүд зах руу дохиогоо дуугарган давхилдана. Өглөөний найман цаг болж дэлгүүр, лангуунууд үүдээ нээж байсан үе. Шилэн нүүртэй дэлгүүрүүдийн хамгаалалтын төмөр хаалганууд чахран нээгдэж байлаа. Дэлгүүрийн эзэд хөгжмөө чанга гээч нь тавьсан нь үүдээр нэвт сонсогдож "ямар айхтар чанга, муухай хөгжим бэ" хэмээн хатагтай Сонг цухас бодон, чихээ дармаар болж байлаа. Хэрвээ капитализм гээч нь энэ юм бол тийм ч аятайхан эд биш юм. Арай дэндүү шуугиантай юм. Ок Хи яаж ийм аймаар газар амьдардаг байна аа?

Хатагтай Сонгийн хөтөч зогсож өглөөний унданд зориулан өндөг, зайдас, гахайн тагалцаг худалдаж аваад шороон замаар уруудан, эгнүүлж барьсан байшингуудыг зорин хөдөллөө. Хөтөч байшингуудын нэгний үүдэнд таксинаас буун гэрийн эзэн болон өсвөр насны охинд нь хатагтай Сонгийг танилцуулав. Тэд Хятадын харьяат болсон уугуул солонгосчууд байсан бөгөөд өөртэй нь бараг адилхан аялгуугаар ярих нь сонин. Тэд хатагтай Сонгод байшингаа танилцуулав. Улаан тоосгон хана, вааран дээвэр, банзан хашаа гээд гойдын юмгүй байсан ч гэр дотор нь стерео хөгжим, ус цэвэршүүлэгч, өнгөт телевизор, хөргөгч гээд бүх төрлийн цахилгаан бараа харагдана. Гэрийн эзэн хөргөгчөө онгойлгон шар айраг, жимс, кимчи зэрэг зүсэн зүйлийн идэх уух зүйл гаргаж ирлээ. Хөтөч өөрийн авчирсан хүнсийг гарган тавьж ширээг улам баяжуулав. Ийм их зүйлийг хуримаас бусад үед хатагтай Сонг хэзээ ч харж байгаагүй билээ. Хүссэн бүхэн нь өрөөтэй байвч охиноо л олж харсангүй.

Миний охин хаана байгаа юм бол гэж тэднээс асуув.

Гэрийн эзэн түүн рүү харснаа амандаа хэдэн юм үглэв.

Хатагтай Сонг нэлээд ширүүнээр дахин лавлахад "Өө, охин чинь ажил хайхаар явсан" гэж хариулжээ. Хатагтай Сонг нэг л итгэж өгсөнгүй. Гэрийн эзэд хэтэрхий гэмээр сайхан аашилж, өөрөөс нь нэг юм нуугаад байх шиг санагдсан ч аян замд ядарсандаа болоод цааш нь шалгаалгүй нам унтаад өгөв. Сэрээд хартал Ок Хи ирсэн шинж алга. Намайг хулгайлсан юм биш байгаа гэсэн аймшигт бодол эзэмдэн авлаа.

Хатагтай Сонг зугтах эсэхээ шийдэж ядан эргэлзэж эхлэв. Хаана байгаагаа ч мэдэхгүй хүн чинь хаашаа ч зугтах билээ? Хүргэж өгсөн хөтөч нь аль хэдийн буцжээ. Гэрийн эздийг сэжиглэх ёстой юу, эсвэл жирийн харьцах уу? Охин нь яасан юм бол?

Гэрийн эзэн, эзэгтэй хоёр Ок Хиг замдаа жаахан саатсан байх, удахгүй ирнэ хэмээн ятгасаар

байлаа. Дараагийн өдөр нь Ок Хи утасдлаа. Утасны шугам шажигнаж сайн дуулдахгүй байхыг бодоход их хол байгаа бололтой. Ок Хи бүх юм сайн байгаа, удахгүй очно хэмээн ээждээ итгүүлэхийг оролдож, харин хариуд нь яг хаана байгаагаа хэл хэмээн эх нь шаардав. Ок Хи "Хангүг" хэмээн товч хариулав. Тэр чинь хаана байдаг юм бэ? Шеньяны ойролцоо юу? хэмээн өөрийнх нь байгаа газраас 480 км-ийн цаана орших Хятадын зүүн хойд бүсийн том хотуудын нэрийг хэллээ. Түүнээс ч хол. Би маргааш залгаад танд сайн тайлбарлаж өгье гээд Ок Хи утсаа тасаллаа.

Хойд солонгосчууд өөрсдийн орноо Чусан гэж, харин салан тусгаарласан өмнөд хөршөө Нам Чусан хэмээн нэрлэнэ. Харин Өмнөдүүд өөрсдийнхөө орныг Хангүг хэмээн тэс өөрөөр нэрлэх бүлгээ.

Маргааш нь утсаар ярихдаа Ок Хи Өмнөд Солонгост ирснээ ээждээ хэллээ. Хатагтай Сонг чихэндээ итгэсэнгүй. Уурласандаа чичирч зүрх нь хаагдах нь уу гэмээр шинж тэмдэг илрэв. Ок Хигийн багын дүрсгүйтэл, гэрээсээ оргож хэдэн жил сураггүй болсон, баригдаж ирээд шоронд суусан гээд хийсэн бүх бүтэлгүй зүйлүүдээс хамгийн хүлээн зөвшөөрч боломгүй нь энэ санагдав. Гол гаталж, хил зөрчин, дайсныхаа нутагт ирчихээд ээжийгээ орлуулах гэж байдаг. Хатагтай Сонг амьдралдаа хэзээ ч ингэж бухимдаж байсангүй.

"Чи урвагч. Чи миний охин биш" гэж хэлчихээд утсаа шидчихэв.

Дараагийн гурван өдөр Ок Хи өдөр бүр эхтэйгээ ярихыг оролдовч хатагтай Сонг сонсохыг ч хүссэнгүй. Гэвч хүний эх, өр зөөлөн эм хүн болохоороо аяндаа зөөлөрч эхлэв.

Ок Хи утсаар мэгшин "Ээжээ би танд хайртай. Та энд ирж надтай хамт амьдраач дээ" хэмээн хэлээд өөрийнхөө тэндэх амьдралын талаар товч ярьж өгөв. Өмнөд Солонгост анх очиход нь тусламж болгон засгийн газраас нь мөнгөн тусламж өгсөн. Одоо тэрбээр сайн ажилтай, сайхан амьдарч буй гэнэ.

Наана чинь тийм сайхан байгаа юм бол чи юундаа уйлсан юм бэ? хэмээн хатагтай Сонг мөчөөгөө өгсөнгүй. Түүний бодлоор Америкийн империалист зулбасгануудын утсан хүүхэлдэй Өмнөд Солонгосчууд охиныг нь мөнгөөр худалдан аваад, мэдээлэл салгаж авсныхаа дараа тамлан хороох байх. Өмнөд нутаг руу оргон очсон Хойд Солонгосынхонд хандах хандлага иймэрхүү гэж өмнө нь сонсоод итгэхгүй байх шалтгаан түүнд байгаагүй.

Ээж минь тийм зүйл огт байхгүй. Би энд ирчихээд ганцаардаж, таныг санаад л уйлж байна гэж Ок Хи тайлбарлав.

Хатагтай Сонг Өмнөд руу оргох тухай бодохыг ч хүссэнгүй. Энд хэдэн өдөр ядаргаагаа тайлж амарчихаад л нутаг буцна хэмээн охиндоо хэлж зөрүүдэлсээр л.

Байгаа айлдаа тухлан амарч, унтаж, зурагт үзэн тааваараа сайхан хэд хоногийг үдэв. Айл нь Өмнөд Солонгосын суваг хүлээн авдаг сансрын тавган антентай учир хатагтай Сонг савангийн

дуурь сонирхон, "Шилэн шаахай" хэмээх, хүүхэд байхдаа салж хагацсан эгч дүү хоёрын тухай нэгэн киног ихэд дурлан үзэх болов. Дуртай кино нь гараагүй үед суваг сольж, хөл бөмбөгийн тэмцээн үзэж байлаа.

2002 оны Дэлхийн Хөл Бөмбөгийн аварга шалгууруулах тэмцээнийг Өмнөд Солонгос Японтой хамтран зохион байгуулж байлаа. Хатагтай Сонг хөл бөмбөг сонирхсондоо ч биш ар талд нь болон сурталчилгааны үед харагдах Өмнөд Солонгосын байдлыг сонирхох гэж хөл бөмбөгийн тэмцээнийг нүд салгахгүй үзэж байлаа. Орчин үеийн өндөр барилга, замаар сүлжих гял цал машин, шилэн дэлгүүрийг хараад мэл гайхаж цэл хөхрөв. Тэмцээний дундуур хэзээ ч сонсож байгаагүй гар утас гээч юмыг сурталчлах нь гайхмаар байв.

Өмнөд Солонгосын баг Польш, Португал, Испанийг буулган авч, хагас шигшээд шалгарахад Өмнөдүүд тэр чигтээ гудамжинд гарч тэмдэглэхийг харлаа. Улаан Чөтгөрүүд нэртэй багаа дэмжихээр улаан футболка өмсөж, урдаа жижиг гэрэлтэй бүрээ үлээн байна. Тэд өөртэй нь адилхан хэлээр ярих адилхан л солонгос хүмүүс байлаа. Ганц ялгаа нь аз жаргалтай, өнгө зүстэй, эрх чөлөөтэй харагдаж байсан юм.

Зурагтаар үзсэн зүйлдээ итгэх нь хатагтай Сонгод хэцүү байв. Сэтгүүлчтэй ханилж байсныхаа хувьд зурагтаар зохиомол зүйл гаргаж болдгийг сайн мэднэ. Хөдөлмөрийн намаас бэлдэж өгсөн үзэл суртлын лекцэнд гадаадын телевизүүд Ким Ир Сен, Ким Чен Ирийн бий болгосон агуу их номлолыг булингартуулж, империалист нийгмээ шүтүүлэхийн тулд тусгайлан бэлдсэн, хүний сэтгэлийг урвуулах материалууд ашигладаг хэмээн ойлгуулжээ. Нэг удаагийн лекцэн дээр АНУ-ын Тагнуулын Төв Газрын удирдлага дор Өмнөд Солонгосын утсан хүүхэлдэйнүүд хэт гоёмсог материал тусгайлан бэлдэж, манай ариун ард түмний сэтгэлийг урвуулахаар оролдож байна хэмээн сүржин нь аргагүй сурталдсан билээ. Сайхан сэтгэлтэй, зочломтгой мэт санагдах гэрийн эзэд тархийг нь угааж, Өмнөд Солонгос руу явуулах үүрэг хүлээн охиноос нь мөнгө авсан байх хэмээн сэжиглэв.

Гэвч яаж ч бодсон энэ бүх зүйлийг урьдчилан зохион байгуулсан байх учиргүй. Хятадад л гэхэд хоол хүнс элбэг дэлбэг, олон машин гудамжаар сүлжилдэж, наад захын айл амьдралдаа барааг нь ч хараагүй цахилгаан хэрэгслийг гэртээ авч тавьсан байхыг өөрийн нүдээр харсан болохоор бага багаар бодол нь өөрчлөгдөж эхэллээ.

Байгаа айл нь будаа болохоор автоматаар унтардаг агшаагчтай. Мэдээж тэдний цахилгаан хэрэгслүүд бүгд түүнийг гайхуулж байсан ч будаа агшаагч хамгийн хүчтэй сэтгэгдэл төрүүлжээ. Өөрөө унтрахыг нь хараад гайхаад ч барсангүй. Олон жилийн өмнө тэднийд үүнтэй зүйрлэшгүй болхи будаа агшаагч байсан боловч хоол хийхдээ цахилгаан ашиглах ёсгүй гээд цагдаа нар хураажээ.

Өглөө бүхэн будаа агшаагчийн өглөөний хоол бэлэн болсныг илтгэн дуугарах дуу нь хатагтай Сонгийг бишрүүлж, ийм илбийн юм бас байна аа хэмээн шагширна. Хойд Солонгос хөгжлийн хувьд Хятадаас хэдэн арван жилээр хойно яваа гэдэг нь үнэн юм байна хэмээн бодов. Тэгэхээр Өмнөд Солонгосоос хэр хол хоцорсныг хэн мэдэх билээ? Хатагтай Сонг талийгаач нөхөр нь энэ

бүхнийг харсан бол яах байсан бол хэмээн тэртээд өнгөрсөн ханиа дурсан бодоод өрөвдлөө. Энд ирснээсээ хойш гэрээс огт гараагүй боловч айлынхаа гал тогооны хэрэгслийг судалж, зурагт үзэн уйдах зав огт олдсонгүй. Энэ бүх зүйлийг нөхөр нь үзсэн бол хичнээн сайхан бэ? Тэр хоолонд дуртай байсан болохоор зайдас амтлаад, хэлэх үгээ олохгүй суух байсан даа хэмээн хоол идэж байхдаа аньсага нь чийгтээд ирнэ. Тэгснээ хүүгээ дурсаж эхлэв. Хүүгээ дурсахаас ч сэтгэл нь хөндүүрлэнэ. Тийм чийрэг, царайлаг хүүгээ дөнгөж хорин тавхан насанд нь алдах гэж. Тэр минь амьд байсан бол ямар ихийг үзэх байсан бол? Бид чинь бүгдээрээ ямар их зүйлийг үзэлгүй алдаа вэ? Өөрөө, нөхөр нь, хүү нь, охид нь. Тэд Хойд Солонгост насан туршдаа түгжигдэж, үхтлээ ажиллан, хэний төлөө амьдарч байгаа вэ? Юуны төлөө? Намын заасан замаар бид явна. Бид генералынхаа төлөө амьдралаа зориулна. Бид бусдад атаархахгүй өөрсдийн замаар явна. Энэ бүхэнд итгэж бүхэл амьдралаа үржээ. Гэхдээ үгүй ч юм бил үү? Бүх юм дуусаагүй ч юм билүү? Тэр тавин долоон настай ч эрүүл чийрэг хэвээр. Иймэрхүү бодол үүр цайх үеэр толгойд нь эргэлдэж, будаа агшаагчийн дохионы дуунаар нойрноосоо бүрэн сэргэв. Хатагтай Сонг бүхнийг шинээр эхлэхээр шийдэн бослоо. Энэ бол сэрэх дохио нь байсан юм. Тэр явахад бэлэн болсон байлаа.

АРВАН НАЙМДУГААР БҮЛЭГ

ЭХ ОРНЫ АМЛАЛТ

2002 оны наймдугаар сарын сүүлчээр хатагтай Сонг Далианаас Өмнөд Солонгосын олон улсын нисэх онгоцны буудал Инчон руу нисэх Азиана Авиа Компанийн онгоцонд суусан байлаа. Нэрээ сольж, хуурамч паспортоор хил давахаар нисэх гэж байгаа нь энэ. Онгоцон дахь цорын ганц танил залуу нь өөрөөс нь хэдэн эгнээний урд сууна. Залуу Сонгийн өрөөнд өглөө эрт ирж, эзнээс нь хулгайлж, зургийг нь сахлын хутгаар зүсэн аваад оронд нь хатагтайн зургийг наасан хуурамч паспорт авчирч өгсөн билээ. Хэрвээ хил дээр асуувал Өмнөд Солонгосын жуулчин, Солонгосын Шар Тэнгисийн эсрэг талд байрлах Далианы далайн эргийн амралтын газар хэдэн долоо хоног амраад буцаж яваа хэмээн хариулахаар бэлджээ. Ярьсан зүйлээ батлахын тулд Хатагтай Сонг Хойд Солонгост бол гадаадын хүн шиг харагдахаар хувцасласан байв. Дүүжин загварын жинсэн өмд өмсөж, цав цагаан пүүз хөлдөө углажээ. Мөн спортын гэмээр үүргэвч үүрсэн байв. Хөтчийнхөө зөвлөсний дагуу Өмнөд Солонгосын өөрийнх нь үеийн эмэгтэйчүүдийн засалтаар үсээ тайруулж, хими хийлгэсэн нь Хойд Солонгос гэж танигдахааргүй болгосон байлаа. Оргон зугтаагч шиг харагдахгүйн тулд Хятадад хоёр долоо хоногийн турш царай зүс, бие бялдраа додомдсон учир муугүй харагдана. Хамгийн осолтой, өөрийг нь барьж өгч магадгүй зүйл нь төвөнхийн аялга байжээ. Хамт нисэж буй хүмүүстэйгээ танилцаж, аялгаа мэдэгдүүлэхгүйн тулд наян хором үргэлжлэх нислэгийн туршид суудлаасаа босохгүй байхыг зааварласан аж.

Хатагтай Сонг өвөр дээрээ гараа тавин цэх сууж, их л тайван харагдана. Өмнөд рүү оргохоор нэгэнт шийдсэн тул ийм нөхцөлд сандралгүй, итгэл төгс байлаа. Хятадад тосгоны айлд тухлан байхдаа шөнөжин эргэцүүлэн, өглөө будаа агшаагчийн дуунаар нойрноосоо сэргээд босохдоо эргэлзээ нь бүрэн арилсан юм. Зурагтаар үзсэн ертөнцөө өөрийн нүдээр харж итгэхийг хүссэн билээ. Өөрт нь амьдрах хугацаа хэр үлдсэн билээ. Хойд Солонгост байдал сайжирч охид, ач нарт нь боломж ирэх л байлгүй. Иймээс өөрт олдсон бололцоог ашиглахаар шийдсэн боловч явахаасаа өмнө Чонжинд очиж, үр хүүхдүүдтэйгээ салах ёс хийн, Ок Хигийн өгсөн мянга шахам долларыг өгөхийг хүссэн байна. "Намайг үхчихлээ гэж дүү нар чинь бодохыг би хүсэхгүй байна" хэмээн охиндоо хэлэхэд Ок Хи ээж нь бодлоо өөрчлөх, эсвэл дүү нар нь ятгах вий гэхээс санаа зовж ээжийгээ хориглосон боловч дийлсэнгүй.

Түмэн гол борооны улирлаар үерлээд нэг сарын туршид хатагтай Сонг Чонжинд саатахаас өөр арга байсангүй. Гэвч Өмнөд руу оргон гарах шийдвэрээ огт өөрчлөөгүйгээр барахгүй замд нь тааралдах саад бэрхшээлийг даван туулах итгэл төгс байсан юм. Ок Хигийн хөлсөлсөн зууч нар энэ жижигхэн эмэгтэй хуурамч паспорт өвөртлөн олон улсын нисэх онгоцонд огт сандралгүй төвшин сайхан сууж чадна гэж төсөөлөө ч үгүй аж.

Аяллын хамгийн аюултай хэсэг нь Хятадын хилээр гарч онгоцонд суух байлаа. Хятадын хилийн шалган хуурамч паспортыг нь илрүүлэх л юм бол шууд баривчлан нутагт нь буцаах ба эх нутагт нь шорон угтах байв. Онгоцонд нэгэнт аюулгүй ороод авсан хатагтай Сонгод одоо ганц л саад

үлдээд байлаа. Хятадуудыг дөнгөсөн боловч хуурамч паспорт Өмнөдийн хилийнхнийг хуурч дөнгөхгүй. Тэд ганц хараад л хулгайлагдсан хэмээн зарлагдсан паспорт гэдгийг нь мэднэ. Иймээс хатагтай Сонгийн залуу хөтөч "Та намайг танихгүй шүү. Эмэгтэйчүүдийн бие засах газар ороод нэлээд хүлээгээрэй. Тэгээд дараа нь хилийн шалган дээр очоод, үнэнээ хэл" хэмээн захиад буцан явав. Хатагтай Сонг залууг хилээр гарчихсан гэж итгэх үедээ шалган нэвтрүүлэх цэг дээр очиж үнэнээ хэлэх ёстой. Намайг Сонг Хи Сук гэдэг, тавин долоон настай. Чонжины оршин суугч. Хойд Солонгос дахь өлсгөлөнгийн үеэр гэр бүлийнхнийхээ талыг алдсан. Одоо Өмнөд Солонгост охинтойгоо хамт шинэ амьдрал эхлэхээр ирлээ гэж ярина. Одоо түүнд нуугаад байх зүйл үгүй.

Өмнөд Солонгосын Үндсэн хуулийн гуравдугаар зүйлд заасны дагуу Өмнөд Солонгос нь нийт Солонгосын хойгийн хууль ёсны засгийн газар бөгөөд Хойд Солонгосынхныг оруулаад бүх солонгос үндэстэн тус улсын иргэнд хамаарагддаг ажээ. 1996 онд Хойд Солонгосчуудын Өмнөдийн иргэншлийг Дээд шүүхээр баталгаажуулсан юм. Гэвч бодит байдал арай өөр байлаа. Өмнөд Солонгосын иргэний эрхээ эдлэхийн тулд тэд тус улс руу өөрсдийн хүсэл зоригоор ирэх ёстой. Хойд Солонгосын иргэн Бээжин дэх Өмнөд Солонгосын Элчин Сайдын Яам юм уу бусад консулын газраас эрхээ шаардаж болохгүй болсон байлаа. Коммунист дэглэмтэй байх үеийн хуучин түншдээ үнэнч байх хандлагаас нь шалтгаалан сая саяараа хилийг нь зөрчин Хятад руу цувахыг Хятадын төр засаг үнэндээ хүссэнгүй. Иймээс Хятадад ирж орогнол хүссэн Хойд Солонгосчуудыг тус улс дахь Өмнөдийн дипломат албадад очихыг нь хориглосон байна. Зүүн Германчууд Чехословак, Унгараар дамжиж Баруун руугаа хэдэн мянгаараа оргож байснаас үүдэн Берлиний ханыг 1989 онд нураахаас өөр аргагүй болсоныг Хятадууд сайн мэднэ.

Өмнөд Солонгосын засгийн газар ч мөн адил хэт олон цагаач орж ирж, эдийн засаг болон нийгмийн ачаалал үүсгэхээс сэргийлэн, цагаачлагчдын тоог тодорхой хязгаарт барихыг эрхэмлэж байв.

Эх орноосоо гарч чадсанууд нь янз бүрийн арга хэрэглэнэ. Мөнгөтэй, танил талтай нэг нь хуурамч паспорт аваад Өмнөд рүү нисчихнэ. Өөр нэг арга нь цагаачдыг хүлээн авах талаар Хятад шиг хатуу журам баримталдаггүй Хятадын хөрш Монгол, Вьетнам зэрэг улсууд руу гарна. Цөөн тооны хүн Европ дахь Өмнөдийн ЭСЯ болон Хятад дахь НҮБ-ын албад руу орогнол хүсэн очсон мэдээ бий.

Хятад руу гарсан Хойд Солонгосынхноос маш бага хэсэг нь буюу 100,000 гаруй нь л Өмнөд Солонгос руу зугтаж чадсан байдаг. 1998 онд 71-хэн иргэн Өмнөдөөс иргэншил хүссэн байдаг бол энэ тоо 1999 онд 148, 2000 онд 312, 2001 онд 583, 2002 онд 1139 болон өсчээ. Түүнээс хойш жилд ойролцоогоор 1000-аас 3000 иргэн жил бүр Өмнөдөд ирэх болсон байна.

Хатагтай Сонгийг ирэхэд Өмнөдийн шалган нэвтрүүлэхийн ажилтнууд Хойд Солонгосчууд бичиг баримтгүй, урьдчилан мэдэгдэлгүйгээр ирэхэд аль хэдийн дасал болсон байлаа. Түүнийг ирэхэд төдийлөн дуртай бус хүлээн авсан боловч цочирдсонгүй.

Хатагтай Сонг Инчоны буудал дээр буугаад л зүг чигээ алдав. Өмнө нь цорын ганц удаа буюу сая Хятадаас ирэхдээ л онгоцны буудалд орж үзсэн байжээ. Гэтэл энэ буудал өмнөхөөсөө тэс өөр.

Өмнөх жил нь 5.5 тэрбум доллараар боссон Инчоны нисэх буудал 1950 онд Америкийн генерал Дуглас Мак Артурын цэргүүд газардсан талбайгаас холгүй баригдсан байв. Энэ бол шил төмрөөс бүтсэн аварга том барилга юм. Хүмүүс зугуухнаар хаалганаас холдон урт хонгилоор алхацгаалаа. Хатагтай Сонг хаашаа явахаа мэдэхгүй хэсэг харж зогссоноо хөтөч залуугаасаа холхон хүмүүсийг даган явлаа. Хилийн шалган нэвтрүүлэх цэгийн цонх руу хүмүүсийг дугаарлан зогсоход, зааварласан ёсоор хатагтай Сонг эмэгтэйчүүдийн бие засах газар руу орж аанай л соёлыг гайхав. Бие зассаны дараа усаа хэрхэн татахаа мэдэхгүй баахан гайхаж зогслоо. Гэтэл гар хүрэх шаардлагагүй мэдрэгчтэй учраас ус нь автоматаар татагдав. Нөгөө залуугаа явсан эсэхийг шалгахаар хаалгаар шагайтал дугаарт зогссон хэвээр л байв. Буцаж ороод толинд харж, үсээ янзлан, нүүрнийхээ будгийг сэргээж байхдаа танихгүй царай өөдөөс нь ширтэж буйг харлаа.

Дараагийн удаа шалгахад нь залуу гараад явчихсан байв. Бие засах газраас гарч, хэнд хандахаа шийдэж ядан зогсож байтал өндөр нуруутай цээжинд нь зүүсэн зурагтай үнэмлэх нь хатагтай Сонгийн нүдний түвшинд ирсэн том залуутай бараг мөргөлдөв. Тэр доор бөхийн мэндлээд "Би Хойд Солонгосын иргэн. Орогнол хайж ирлээ" гэж өмнө нь давтаж байсан үгээ хэлэв. Хандсан хүн нь харуул байсан боловч юу хийхээ мэддэг хүн таарч, тэднийг ихэвчлэн хэсэг бүлгээрээ ирдгийг мэдэх тул "та бүхэн хэдүүлээ яваа вэ" хэмээн асуулаа. Ганцаараа явааг нь сонсоод хилийн шалган нэвтрүүлэх цэгийн хажууд байрлах нэгэн албан өрөө рүү дагуулан явав. Утсаар ярьсан дор хэдхэн хормын дотор Өмнөд Солонгосын Үндэсний Тагнуулын Газрын ажилтан хүрэлцэн иржээ.

Хатагтай Сонгийн байцаалт хоёр сар үргэлжлэв. Түүнийг нисэх онгоцны буудлаас тагнуулын газраас шинээр ирсэн цагаачдад зориулан барьсан дотуур байр руу шилжүүллээ. Хэдийгээр хатагтай Сонгийг уг байраас гарахыг хориглосон ч охинтойгоо уулзахыг зөвшөөрсөн учир Ок Хи ээжийгээ эргэхээр ирдэг байжээ. Хойд Солонгосын тагнуулууд зугтсан хүмүүсийнхээ байдлыг судлахаар цагаачлагч хэлбэрээр ирдэг, бас Хятадын иргэн уугуул Солонгосчууд Өмнөдийн иргэншил авах, засгийн газраас Хойд Солонгосын цагаачдад нутагшихад нь дэмжлэг болгож өгдөг 20,000 долларыг авахаар хуурамч паспорт ашиглан хил нэвтрэх гэж оролддог тул Үндэсний Тагнуулын Газар тэдний нэг биш гэдгийг батлахын тулд уртасгасан байцаалт явуулж байв. Хатагтай Сонг өдөр бүр хоёр цагийн байцаалт өгнө. Тэд Чонжины газар нутгийн баримжаа, Хөдөлмөрийн намын байрууд, хот дүүргүүдэд хэрхэн хуваагддаг зэргийн тухай нэгд нэгэнгүй ярих хэрэгтэй болж байлаа. Өнгөрсөн бүх амьдралынх нь дурсамжийг сөхөж, сануулж байсан учраас хатагтай Сонгод байцаалт хэцүү санагдсангүй. Өдөр нь унтаж амран, зурагт үзэж болно. Хөргөгчид соруултай нь хамт хийсэн үнэгүй жимсний шүүсүүд гээд жижиг ч гэсэн хүний төлөө хийсэн бүхэн түүнийг баярлуулж байлаа.

Үндэсний Тагнуулын Газарт байцаалтад орж байсан энэ үеэ хатагтай Сонг түүний хувьд жинхэнэ амралт байсан гэж хожим нь дурсан ярьж билээ. Дараа нь жинхэнэ хүнд ажил эхэлнэ.

Сард нэг доллараас бага орлоготой хүмүүс дэлхийд эдийн засгаараа арван гуравт ордог улсад дасах тийм ч амар даваа биш ажээ. Өмнөд Солонгосын нэг хүнд ноогдох ДНБ 20,000 доллар байдаг нь Хойдынхоос даруй дөч, тавь дахин илүү ажээ.

Цэрэггүй бүсийн хоёр талд явагдах сурталчилгааны нэлээд хэсэг нь Өмнөд, Хойд Солонгосчууд

нэг ард түмэн, нэг үндэстэн гэх боловч үнэн хэрэг дээрээ жаран жил тусгаар оршин тогтносны дараа хоёр улсын эдийн засгийн байдал, ард түмний аж амьдрал тэнгэр газар шиг зөрүүтэй болсон байлаа. Өмнөд Солонгос технологийн дэвшлээрээ дэлхийн тэргүүлэх орнуудын нэг болж чадсан байхад Хойд Солонгосын ард иргэд интернет гэж юу болох талаар огт мэдэхгүй байх жишээтэй. Өмнөд Солонгос бусад хөгжингүй орнууд, тухайлбал Япон, Америк, мөн Европын орнуудаас өргөн зурвасын интернеттэй айл өрхийн тоогоороо илүү гарсан байна. Сүүлийн хагас зуунд Хойд Солонгос эдийн засаг, соёлын талаар зогсонги байсан билээ. Өмнөд Солонгосчууд Англи хэлнээс зээлсэн үгээр баяжуулснаас болж хоёр улсын хувьд хэлний тал дээр ч зөрүү үүсчээ. Өмнөд Солонгосын далан настай дундаж иргэн Хойд Солонгосын яг адил насны иргэнтэй харьцуулахад арав орчим сантиметр өндөр бөгөөд сүүтэй хөөсрүүлсэн ундаа ууж, гамбургер идсэн шиг амьдардаг. Гэтэл Хойд Солонгосчууд Өмнөд Солонгосынхны 60-аад оны үеийг давтан амьдарч байна.

1990ээд оны үеэс оргогсдын тоо өсөж, тэднийг нийгэмшүүлэх талаар Өмнөд Солонгосын засгийн газар илүү анхаарал тавьж эхлэв. Тэргүүний гэгдэх сэтгэл судлаачид, социологчид, түүхчид, багш нараас бүрдсэн баг төлөвлөгөө боловсруулжээ. Одоогоор цагаачдын тоо улсынх нь 44 сая хүн амын тоотой харьцуулахад, 2008 оны сүүлч гэхэд 15,057хан буюу өчүүхэн хэсгийг эзэлж байгаа боловч хожмын нэг өдөр Хойд Солонгосын сая сая иргэн нэгдэхэд хүрвэл асуудал үүснэ. Төлөвлөгөөний дагуу хийгдсэн судалгаанд оролцсон социологич Юн Ин Жин "хэрэв энэ харьцангуй цөөхөн оргогсод манай улсад нийгэмшиж чадахгүй бол хоёр Солонгосын нэгдэх тухай яриа найдваргүй л болох вий. Хэрэв тэд шинэ амьдралаа амжилттай эхэлж дасаж уусаж чадвал бид нэгдэх талаар ярьж болно. Тиймээс бид одоо байгаа хүмүүстээ чадлынхаа хэрээр тусалж, алдсан бүхнээ олж харж, сургамж авах хэрэгтэй" хэмээн хэлсэн билээ.

Өмнөд Солонгосчууд урд өмнө түүхэнд хэрэглэж байсан янз бүрийн загварыг туршиж үзэв. Хуучин ЗХУ болон Хойд Африкаас дүрвэн Еврейн улсад амьдрах эрхээ эдлэхээр ирсэн боловч хэл соёлыг нь бараг мэдэхгүй жүүд цагаачидтай Израйл улс хэрхэн ажилласан болон нэгдсэн Германд амьдрахаар ирсэн Зүүн Германы цагаачдад тулгарсан бэрхшээлийг судлан үзсэн байна.

1999 онд тэд Сөүлээс 80 км-ийн зайд Ханнавон хэмээх тусгай газар байгуулжээ. Сургууль байр хосолсон энэ төвд Өмнөд Солонгост хэрхэн амьдрах талаар Хойд Солонгосын цагаачдад хичээл зааж эхэлсэн байна. Цахилгааны хөлсөө

хэрхэн төлөх, автомат мөнгөний машиныг хэрхэн ашиглахыг заахаас гадна сонинд гарсан англи үг бүхий зарыг уншдаг болгохын тулд латин үсэг заана. Тэднээс бас урд нь Солонгосын дайны талаар, мөн дэлхийн хоёрдугаар дайнд Америкчуудын гүйцэтгэсэн үүргийн талаар бүх заалгасан зүйлээ ор тас мартахыг хүсчээ. Мөн хүний эрх, ардчилсан нийгмийн механизмын талаар хичээл явуулна.

Ангид хичээл зааж байхад бүгдийг ойлгох мөртлөө Ханнавоноос гарахаар л бүх зүйл өөр болчих шиг санагдана. Хатагтай Сонг будилж гүйцдэг байлаа. Бүлгийнхэн нь тойрон аяллаар явж хувцас худалдан авч, үсээ тайруулан, үдийн хоол авч идэх дадлага хийцгээсэн байна. Гэтэл бусад хоолны талаар ойлголт ч байхгүй болохоор бүгдээрээ гоймон авсан аж.

Хааяа гадагш гарахаараа хөөрснөөсөө болоод бүр толгой нь эргэж орхино. Асар их шуугиантай гудамж, гэрлэн чимэглэлүүдийг харахаараа самуурах бөгөөд өндөр барилгуудад бэхэлсэн асар том сурталчилгааны дэлгэцүүдийг хараад учрыг нь олохгүй тул хий дэмий нүдээ л эргэлдүүлнэ. HDTV, MTV, MP3, MP4, HP, TGIF, BBQ гэх мэт товчилсон үгс тайлж чадахааргүй нууц үг мэт санагддаг байлаа. Энэ бүхнээс илүү хамгийн их гайхуулж байсан зүйл бол Өмнөд Солонгосын хүмүүс. Тэд шал өөр үндэстэн мэт санагдаж байв. Охид богино банзал, урт түрийтэй арьсан гутал өмсөж, үсээ элдэв өнгөөр будуулсан байх нь гадаадынхан юм уу гэмээр. Охид хөвгүүд нь чихэндээ хуванцар бөглөө углаж, унжсан урт утсыг нь халаасандаа хийсэн байх нь олонтаа. Тэд гудамжинд хөтлөлцөн явж, үнсэлцэх нь хатагтай Сонгийг маш их цочирдуулав. Эргэн тойрноо хартал өөрөөс нь бусад нь ажирсан шинж алга. Бас нэг өдөр хатагтай Сонг Сөүлийн метроны буудал орж үзжээ. Олон хүмүүс цахилгаан шатаар доош бууж, хонгилоор алхаж нэг шугамаас нөгөө рүү дамжихыг хараад тэд явах зүгээ яаж олдог юм бол хэмээн бодсон аж.

Хатагтай Сонг Ханнавонд гурван сар орчим амьдраад гарах болоход нь төгсөлтийн баяр хийж, Өмнөд Солонгосын газраас өгч буй тэтгэлэг болох 20,000 долларыг гардууллаа. Ингээд тэр өөрийнхөөрөө амьдрах болох нь.

Намайг 2004 онд анх уулзахад хатагтай Сонг нутгаасаа гараад хоёр жил болсон байлаа. Би Лос Анжелес Таймс сонинд нийтлэл бичихээр Чонжиноос гаралтай цагаачидтай ярилцлага хийж эхлээд байсан үе. Сөүлд уг сонины газар хатагтай Сонгтой уулзахаар тохирлоо. Хаалга нээж өгөхөд өө сэвгүй хувцасласан, жижигхэн биетэй, өөртөө итгэлтэй эмэгтэй орж ирэв. Тэр хаш шигтгээтэй ээмэг зүүж, ягаан босоо захтай цамцыг ухаа өнгийн өмдөн дотуур хийж өмссөн байв. Нүүр царай, өмссөн зүүсэн бүхэн нь амьдралаа гартаа авсан ухаалаг эмэгтэй гэдгийг нь илтгэж байлаа.

Ханнавоноос гарснаасаа хойш нэг айлд гэрийн үйлчлэгчийн ажилд оржээ. Хойд Солонгост байхдаа гар хумхилгүй ажиллаад сурчихсан болохоор шинэ амьдралаа эхлээд зүгээр сууна гэж саналтгүй байсан биз. Ок Хигээс тусдаа амьдрахаар шийдэж, ид хөгжиж буй Сөүлээс өмнө зүг гучин километрийн цаана орших Сувон хотод хямдыг нь бодож нэг өрөө байр хөлслөн суух болсон байлаа. Хямгатай амьдарч сурсан, дээрээс нь ажлаа сайн хийж байсан болохоор удалгүй чамлахааргүй мөнгөтэй болж, мөрөөдөж ч зүрхэлдэггүй байсан аяллаа хийж, юм үзэж, нүд тайлахаар шамджээ. Настай эмэгтэйчүүдэд зориулж зохион байгуулдаг жуулчлалын бүлэгт багтаж Өмнөд Солонгосын өнцөг булан бүрээр аялж үзжээ. Түүгээр ч барахгүй дахин Хятад руу, энэ удаа жуулчин болж явсан байна. Мөн Хойд Солонгосоос оргож ирсэн нөхдийн хамт Польшид очиж, хүний эрхийн хуралд хүртэл сууж үзжээ. Найз нөхөдтэй болж, үеийнхээ хүнтэй болзож ч үзсэн байна. Мөн зах дээр очиж, өмнө нь огт амсаж үзээгүй жимс болох манго, киви, папаяа зэргийг амтлахдаа дуртай байлаа. Гадуур хооллох ч түүнд маш их таалагдав. Хэдийгээр гамбургер, пицца идэж сураагүй боловч үхэр, гахайн махан хоолонд дуртай болж, өмнөх ширээн дээрээ мах шарах нь асар их таалагдсан гэнэ.

Зургаан сар тутамд хатагтай Сонг бид хоёр уулзаж хамт хооллодог заншилтай болов. Хойд Солонгосын талаар нийтлэл бичихэд тэр онцгой эх сурвалж минь болж өгдөг байсан. Сонг ахин хэзээ ч Хойд Солонгос дахь дэглэмийг хүлээн зөвшөөрч чадаагүй. Нэг удаа "тэр муу өмхий

зулбасга" хэмээн Ким Чен Ирийг зүхэж, амнаас нь хараалын үг гарахыг би анх удаа сонссон билээ. Гэвч миний уулзсан бусад оргогсод шиг харамсаж гуньсан шинж байгаагүй юм. Хөршүүдийнх нь найрсаг харилцаа, систем унахаас өмнө байсан эрүүл мэндийн үнэ төлбөргүй тогтолцоо гээд Хойд Солонгосын талаар сайнаар дурсах зүйл түүнд байсан. Залуу байхдаа туулсан амьдрал нь дурсагдахад нүдэнд нь нулимс цийлэлзэж, дугуй царай нь зөөлөрч, нөхрөө ярьж эхэлдэг байлаа. Нэг удаа шабу шабу хэмээх гүнжидийн сүмсэнд дарсан үхрийн махтай уур нь гараагүй шөлийг хараад "Үүн шиг сайхан хоол харахаар уйлмаар болох юм даа. Хайртынхаа "хоёулаа сайхан зоогийн газарт орж дарс захиалж ууя" гэж хэлсэн сүүлчийн үгийг хэзээ ч мартаггүй хэмээгээд уйлсандаа уучлал гуйсан юм.

Хүүгийнх нь тухай яриа эхлэхэд дуу нь бүр гарахаа болино. Энэ сэдвийг хөндөхөөр л тэр өөр тийшээ харж, яриаг дүйвүүлэхийг оролддог байлаа. Хүүгээ өөрөөсөө эгч хүүхэнд хайртай болсныг нь хүлээн зөвшөөрөлгүй, хатуу хандаж, хэрэгтэй үед нь тусалж чадаагүйдээ ээж нь өөрийгөө хэзээ ч уучилж чадахгүй хэмээн Ок Хи ярьсан юм.

Гэвч энэ бүхэн өөрийнх нь зугтсан газар болж өнгөрсөн зүйл юм. Тэр өөрийнхөө эрх чөлөөг олж авч, амьдралынхаа үлдсэн жилүүдийг хүн шиг амьдарч өнгөрөөхөөр шийдсэн зоригтой эмэгтэй. Би одоо урдынхаасаа илүү залуу, зоригтой болсноо мэдэрч байна хэмээн ярьж, намайг Хойд Солонгосын тухай олныг асуухад хариуд нь Америк болон миний очиж үзсэн газруудын тухай шалгааж байлаа. Товлосон уулзалтдаа тэр үргэлж шинэлэг сайхан хувцаслаж, эрч хүч, баяр баясгалангаар дүүрэн ирнэ. Бусдын төлөө олон жилийн турш золиослогдсоныхоо дараа одоо өөрийгөө анхааран, амьдралын баяр баясгаланг эдлэх болсон нь энэ. Бага зэрэг жин нэмээд ирмэгц хоолны дэглэм барих түүнд хэцүү байсангүй. Үргэлж нүүрээ будаж янзална. Нэг удаа би түүнтэй уулзахаар Сувонд очоод галт тэрэгнээс дөнгөж буутал сэтгэлээ барьж чадалгүй гүйж ирээд чихэнд минь "Чи намайг хар даа. Би нүдээ янзлуулсан байгаа биз дээ" гэлээ.

Тэр нүдэндээ давхраа хийлгэж арай европжуу төрхтэй болсон байв. Энэ бүхэн үзэл бодол нь өөрчлөгдөж, Өмнөдийн амьдралын хэв маягт дассаныг нь илтгэнэ. Тэр үнэхээр өөр болжээ.

Харин оргож ирэх гэж өчнөөн их чармайлт гаргасан Ок Хигийн Өмнөд дэх амьдрал ээжийнх шигээ жаргалтай байсангүй. Ок Хи ээжтэйгээ бие, дүр төрхийн хувьд усны дусал шиг адилхан атлаа зан аашийн хувьд тэс өөр нэгэн. Ок Хи хар жинсэн өмд, саатай хар цамц, өндөр өсгийтэй хар гутал өмсөнө. Зэс хүрээтэй нүдний шилтэй, хөмсгөө атируулсан Ок Хи их хурц харагдаж байлаа. Эх охин хоёр уулзахаараа тэврэлдэж, үсээ илэлцэн, удаан уулзаагүй хүмүүс шиг аяглах авч нэг дор байгаад ирэхээрээ улс төрийн талаар маргалдаж эхэлдэг байв. Үдийн хоол идэж байхдаа тусламжийн байгууллагад ажилладаг нэгэн найз минь Хойд Солонгост тусламжийн зүйлс зориулсан эзэддээ хүрч чаддаг байсан эсэхийг асуухад Ок Хи цэргийн эрхтнүүд болон намын ажилтнууд замаас нь зувчуулж, Ким Чен Ирийн дэглэмийг бэхжүүлэхэд ашиглагддаг хэмээн хариулахад ээж нь: "Тэгсэн ч гэсэн цөөхөн ч гэсэн хүний аминд ордог л байсан байх" хэмээн хариулж охиныхоо аашийг хөдөлгөлөө.

"Та дандаа л тэр нүглийн дэглэмийг хамгаалж байх юм" хэмээн Ок Хи уурсав. Хатагтай Сонг дургүйцсэн байртай уруулаа жимийж үдийн хоолны туршид өөр юм ярьсангүй.

Ок Хи амьдралдаа сэтгэл дүүрэн биш байлаа. Үргэлж л мөнгөний асуудалтай байна. Өмнөдөд ирэхдээ, түүгээр ч барахгүй ирэхээсээ өмнө Хятадад амьдрах үедээ хүртэл мөнгөний асуудалтай байж. Тэр Өмнөд дэх Солонгос, Хятадын хуурамч бичиг баримт үйлддэг, хууль бус наймаа хийдэг, мөнгө хүүлдэг, хүн наймаалдаг үл бүтэх бүлгүүдтэй орооцолдож эхэлсэн байна. Ок Хи Хойд Солонгосоос сүүлийн удаа явахдаа Өмнөд рүү оргох мөнгөгүй байсан тул тэдгээр үл бүтэх хүмүүсийн нэгтэй зөвшилцөж паспорт, онгоцны тасалбар олж аваад хариуд нь Өмнөдийн засгийн газраас олгох нутагшуулах тэтгэмжээсээ 14 мянган доллар өгөхөөр тохиролцжээ. Тэд гэрээ хийж аль аль нь жинхэнэ нэрээ мэдэхгүй учраас эрхий хурууныхаа хээг дарж баталгаажуулсан ажээ.

Ханнавоноос гараад долоо хоносных нь дараа нөгөө этгээд дөнгөж шинээр авсан гар утас руу нь залгаж мөнгөө авах хүсэлтэй байгаагаа хэллээ. Дугаарыг нь яаж олж авсныг ч мэдсэнгүй. Тэр амласан мөнгөө даруй төлөхийг Ок Хигээс шаарджээ. "Би Сөүлд байна. Байрны чинь гадаа уулзъя" хэмээн залуу хэллээ.

Ок Хи учраа ололгүй их сандрав. Нас залуу оргогсдыг ажил хийгээд амьдралаа аваад явах чадалтайд тооцох учир засгийн газраас өгөх тэтгэмжийн хэмжээ бусдынхаас бага байдаг. Түүнээс гадна байр хөлсөлсний урьдчилгаанд 3000 доллар төлчихсөн байдаг. Нөгөө хүнтэй цагдаагийн газрын өмнө уулзахаар тохирлоо. Удаан маргасны эцэст өгөх мөнгөө 8000 болгон тохиролцож дөнгөлөө.

Үүний дараа санхүүгийн байдлаа дээшлүүлэх зорилгоор Ок Хи оршуулгын газар ажилд оржээ. Уг нь маш их ганцаардаж, ээжийгээ авчрахаар их хэмжээний мөнгө зарлагадаагүй бол санхүүгийн хувьд тэнцвэртэй болох л байж.

Ээжийгээ санаад Өмнөд рүү авчрахын тулд янз бүрийн санаа уралдуулан юу хийхээ төлөвлөж эхэлсэн байна. Өмнөд дэх настай хүмүүсийн талаар тавих нийгмийн халамж, амьдралын түвшинг хараад ээжийгээ ямар нэг аргаар заавал авчрахаар шийджээ.

"Хойд Солонгост хүмүүсийг хөгшрөөд, ажиллаж чадахгүй болоод ирэхээр бараг хүний тооноос хасдаг. Харин Өмнөдөд настай хүмүүс дуулж бүжиглэж, амьдралын сайн сайхныг амталж байна. Гэтэл миний ээж насан туршдаа нуруугаа бөгтийтөл зүтгэчихээд одоо тэнд яаж амьдарч байгааг нь бодохоор маш их өрөвдсөн. Энд авчирч жаахан ч гэсэн амьдрал үзүүлье гэж бодсон юм" хэмээн ярьж билээ.

Хатагтай Сонгийг Өмнөд рүү авчрахаар ятгах тийм амаргүй гэдгийг мэдэх учир өөрийг нь зуучилсан нөхөрт хандлаа. Тэд хамтдаа хатагтай Сонгийг Хятад руу хэрхэн хууран авчрах талаар төлөвлөгөө боловсруулсан байна. Ямар нэг зүйл буруу болж баригдвал ээж нь насаараа хөдөлмөрийн лагерьт хоригдох аюул хүлээж буй учир маш болгоомжтой, найдвартай алхам хийх хэрэгтэй байлаа. Тэндээс орголтыг зохион байгуулахдаа багц болон багц бус үйлчилгээ үзүүлнэ. Хатагтай Сонгод охин нь хамгийн шилдэг багцыг худалдаж авсан болохоор дээд зэрэглэлийн үйлчилгээ үзүүлсэн байна. Багцанд нь Чонжиноос хил рүү хүргэж өгөх хувийн машин, хилийн харуулыг хахуульдах мөнгө, хулгайлагдсан паспорт орсон байв. Уг нь хямд хийж болох л байсан.

Гэвч ээжийгээ дээд зэрэглэлийн үйлчилгээг үзэж тав тухтай зорчоосой гэсэндээ би их хэмжээний мөнгө төлсөн хэмээн Ок Хи ярьсан юм.

Ийм маягаар Ок Хи маш их өрөнд орлоо. Оршуулгын газар илүү цагийн ажилд орсон ч цалин нь өрөө төлөхөд хүрэлцэхгүй байсан учир мөнгө олох өөр арга бодож эхлэв. Гучин найман настай энэ эмэгтэй Ким Ир Сений төлөө ажиллахыг хүмүүст уриалан дуудахаас өөр ажил хийж яваагүй, чадах юм бага учир сайн цалинтай ажил олдохгүй л байлаа.

Ингээд Ок Хи караоке бизнест хөл тавилаа. Норэйбанг хэмээн нэрлэдэг дууны өрөөнүүд ихэвчлэн эрэгтэй зочид дуу дуулж, алжаалаа тайлах зориулалттай. Караокений бүрэн тоног төхөөрөмжтэй эдгээр тусгай өрөөнүүдэд орсон үйлчлүүлэгчдийн сэтгэлийг татах гол зүйл нь хамт дуулж, архи аягалж, бяцхан сээтэгнэх, бүр түүнээс ч илүү үйлчилгээ үзүүлэх бүсгүйчүүд. Энэ бизнест Ок Хигийн гүйцэтгэх үүрэг бол залуу бүсгүйчүүдийг элсүүлж, уг караоке клубт дагуулж ирэн ажил хийлгэж, ажлынхаа үед үйлчлүүлэгчтэй элдэв асуудалд орооцолдохгүй байхыг хариуцна. Сувоны энэ караоке баарны ихэнх үйлчлүүлэгч нь түр байранд амьдардаг, шөнөдөө хийх юмгүй барилгын ажилчид. Ок Хигийн бүлэгт Ханнавоноос дөнгөж гарч ирсэн Хойд Солонгосын цагаач хорь гаруй насны хориод охид байна.

Тэд Хойд Солонгосоос ирсэн болохоор хийж чадах ажил гэж бараг үгүй. "Уг нь охид залуу болохоор ажил хурдан сураад нэг албан газар юм уу, үйлдвэрт ажиллаад сард 900 орчим долларын цалин авч болно л доо. Гэхдээ надтай ажиллаад өдөрт л 100 доллар авч байна шүү дээ" гэж Ок Хи ярьсан юм. Нэг шөнө би Ок Хитэй ажилд нь хамт явлаа. Түүний унах Хьюндайгийн микро автобусны шалан дээр тамхи, мөргөлийн уншлагатай хуурцаг зэрэг хөглөрч байлаа. 17 цаг гэхэд Ок Хигийн ажил эхлэх юм. Ид ачааллын үеэр Сувоноос гарах гэж түгжирсээр арай гэж хурдны замаас гарч хоёр урсгалтай замд орж хөдөө тосгон руу чиглэн давхилаа. Замд тааралдсан тосгон, жижиг хотуудаас охидыг суулгасаар л явав. Тэдний зарим нь даашинз, өндөр өсгийт угласан нь том хүн болж тоглож байгаа хүүхэд шиг харагдана. Хийж буй ажлыг нь цагдаагийнхан хууль бус гэж үзэх боловч "Би тэднийг хүчилдэггүй. Та нар дуулж бүжиглээд үзэгчдээс мөнгө салгах л ажил хийнэ гэж би хэлдэг. Энд том хотуудыг бодвол харин ч амар. Сөүлд бол костюм өмссөн ажил хэрэгч эрчүүд архи уучихаад л охидуудаас өөр юм шалаад эхэлдэг. Гэтэл энэ барилгачид бүдүүлэг ч гэсэн гэнэн амьтад" хэмээн ярьж явлаа.

Караокеныхаа ажлаас Ок Хи хангалттай мөнгө олж өрөө дарснаар барахгүй нэлээд хэдэн мянган доллараар хоёр дүүгээ гэр бүлийнхэнтэй нь авчирсан юм. Хамгийн бага дүү нь таван настай охинтойгоо, харин дунд дүү нь нөхөр хоёр хүүгийн хамт Өмнөдөд ирсэн ба бас караокены бизнест нь нэгджээ.

Өмнөдөд гэр бүлийн гишүүдээс нь үлдэгсэд гэвэл хамгийн хайртай хүү охин хоёр нь л байлаа. Тэр хүүхдүүдээ авчирч чадахгүй байгаадаа шаналдаг байж. Би хувиа бодож хүүхдүүдээ гаргуунд гаргасан хэмээн өөрийгөө буруутгана. Намайг 2007 онд хамгийн сүүлд түүнтэй уулзахад хүү нь арван наймтай, охин нь арван зургаа хүрсэн байлаа. Тэр 1998 оны шөнө гэрээсээ зугтсанаасаа хойш хүүхдүүдтэйгээ

уулзаагүй билээ. Гэвч Хятад дахь хууль бус зуучдаар дамжуулан хүүхдүүддээ мөнгө илгээдэг

юмсанж. Явуулсан мөнгөнөөс нь зуучлагч хөлсөө аваад хил даван наймаа хийгч этгээдээр нутагт нь хүргүүлнэ. Хойд Солонгосоос явсных нь дараа удалгүй Хятадын хилтэй ойролцоо гар утасны сүлжээ барьдаг хотуудад хууль бус утасны үйлчилгээ бий болсон байна. Иймээс хуучин нөхөртэйгөө үе үе холбоо барих болсон ч хүүхдүүдтэй нь огт яриулдаггүй байлаа. Нөхөр нь үе үе хэн Мусанд ирж, эхнэртэйгээ ярина. Гэвч Ок Хи хүүхдүүдээ авчихвал өөр рүү нь мөнгө явуулахгүй гэдгийг мэдэх тул хүүхдүүдээ Өмнөд рүү авна гэж санахын ч хэрэггүй гэдэг ажээ.

"Эртээд нэг шөнө би хүүхдүүдээ зүүдэлсэн. Хүүгийнхээ гараас хөтлөн охиноо нуруун дээрээ үүрээд би Хойд Солонгосоос зугтааж явах юм. Гэтэл биднийг чиглээд дүрэмт хувцас өмссөн өндөр хүн ирж явна. Нөхөр маань л биднийг хөөж яваа бололтой. Сэрээд хартал тэднээсээ бүхэл бүтэн ертөнцөөр таслагдсан байгаагаа мэдээд өр минь өмрөх шиг л болсон доо" хэмээн тэр орой надтай хамт машиндаа явж байхдаа ярьсан билээ.

АРВАН ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

НУТАГТАА ГАДНЫН ХҮМҮҮС

Оргож ирсэн Хойд Солонгосынханд цайвар царай, элбэг хангалуун байдал, брэндийн хувцас, ус цас шиг англи хэл, нэр хүндтэй сургуулиас гардсан цол гээд Өмнөд Солонгосын амьдралын түвшинг илэрхийлдэг үзүүлэлтүүдийн үнэр ч байсангүй. Тавин жилийн өмнө Өмнөдүүд Хойдоосоо илүү байгаагүй ч мартахыг хүсдэг гашуун дурсамжийг нь оргон ирэгсэд сэргээдэг учир, мөн Ким Чен Иррийн дэглэм унаж, эх оронд нь 23 сая орох орон, оочих аягагүй хүн ирэх вий хэмээн айдаг тул цагаачилж ирсэн тэдэнд төдийлөн тааламжтай ханддаггүй. Улс төрийн хувьд хоёр Солонгос нэгдэж, ахин нэг үндэстэн болохыг эрмэлздэг хэмээн ярьж, хүүхдүүд "бид хоёр Солонгос дахин нэгдэхийг хүсэж байна. Энэ бол бидний мөрөөдөл" хэмээн дуулах боловч үнэн хэрэгтээ зарим нь тун болгоомжилдог билээ. Сөүлийн эрдэмтэд хоёр Солонгос дахин нэгдэхэд 300 тэрбумаас 1,8 триллион доллар хэрэгтэй болно хэмээн тооцоолсон байна. Солонгосын дайны дараа төрсөн залуучууд үндэстнийх нь нэг тал нь дарангуйлал, захиргаадалт, цөмийн аюулын дор арай гэж ертөнцийн тоосыг хөдөлгөж байгаа тухай бодох ч үгүй, бодохыг ч хүсэхгүй. Хөгжингүй орнуудын жишгээр, уртасгасан цагаар ажиллаж, зав чөлөө багатай амьдралдаа автан, Хьюндайгийн машинаа жолоодож, Irod-оо сонссон шигээ явахад аливаа зүйлийг мартахаар амархан билээ.

Төр засгаас хичнээн дэмжиж туслалаа ч айдас, өөрсдийгөө өрөвдөх, голох, ичих гээд Өмнөд Солонгост толгой дээгүүр амьдрахад саад болох сэтгэхүйн дарамтууд дүрвэж ирэгсдэд мундахгүй. Нэг талаас бүх талаар тусалж дэмжих төр засаг байвч, нөгөө талаас сэтгэхүйн дарамтаа даван туулж чадахгүйгээсээ болоод иргэн нь болсон нутагтаа гаднын хүн шиг амьдардаг байна.

Ким эмч анх Өмнөд Солонгос руу зугтаж гарах бодол огт өвөрлөөгүй байлаа. 1999 онд Түмэн голыг анх гатлахдаа Хятадад л очьё хэмээн зорьсон билээ. Эцэг нь өнгөрөхөөсөө өмнө цаасан дээр сараачиж өгсөн төрөл төрөгсдийнхөө нэр хаягийн дагуу тэднийг л олж бараадах санаатай байжээ. Хамаатан саднууд нь ажил олж өгч туслах байх хэмээн итгэсэн нь талаар болсонгүй. Ажилд орж хүчээ сэлбэж аваад, мөнгө цуглуулж хүүгээ Хятадад авчирчээ. Хэдийгээр нутагт нь байдал дээрдээгүй, ард иргэд нь өлсгөлөнд нэрвэгдсэн, дээрээс нь Намдаа итгэх итгэл нь дундарсан ч гэсэн яваандаа Чонжинд буцаж очоод, ажилдаа эргэн орж, өөрт нь боловсрол олгосон эх орондоо өрөө төлөх бодолтой байжээ.

Хятадад арай гэж амь голтой ирээд айлын хашаанд газар хэвтэх нохойны хоол хараад Ким эмчийн эх орон, төр засагтаа итгэх итгэл анх гундаж эхэлжээ. Өдөр өнгөрөх тусам өнгөрсөн амьдрал нь худал хуурмагаар дүүрэн орчинд өнгөрснийг мэдэж, бухимдал нь газар авсаар байлаа. Итгэж найдаж явсан бүхэн нь худал хуурмаг болж, нэгэн цагт өөрт нь үнэтэй байсан бүхэн үнэгүйдэж ирэх тусам эх нутгаа гэх сэтгэл нь хөрж, эцэстээ нутаг буцахгүйгээр шийдлээ.

Тосгоны айлын хаалгаар шагайnguут нохой боргож эздээ сэрээсэн байна. Тэр айлд уугуул Солонгос настайвтар эмэгтэй, том болсон хүүтэйгээ амьдардаг байжээ. Ким эмчийн хөлдөөд

дарайсан хувцас, ядарч туйлдсан царайнаас Хойд Солонгосоос зугтаж ирсэн гэдгийг эх хүү хоёр төвөггүй мэдэв. Тэд бүсгүйг гэртээ оруулаад, хуурай хувцас өгч, халуун цай хоолоор дайлсан юм. Ким эмч гучин дөрвөн настай, царай зүсээр тийм ч муугүй учраас айлын эзэд Хятад эрд худалдан нэлээд хэдэн зуун доллар олж болох байсан ч тэгсэнгүй, хоёр долоо хоног хэртэй асарч сувилаад эцгийнх нь хамаатнуудыг олж учруулжээ. Ах дүү нар нь өгөөмөр сайхан сэтгэлээр түүнийг угтан авчээ. Хэзээ ч царайгаа харалцаж байгаагүй хамаатнууд нь Кимийг элгэн садны хэмжээнд хүлээн авсанд баярлаад баршгүй.

Эхний үед Ким эмч уугуул Солонгос үндэстнүүдтэй торох юмгүй холилдож, хятад хэл бага зэрэг сураад ажилчдын боодлын хоол савладаг ажил нэгэн зоогийн газарт хийх болов. Гэвч 2000 оноос эхлэн Хятадын цагдаагийнхан хууль бусаар хил зөрчигсдийг агнах ажиллагаандаа хоёр дахин илүү хүч зарцуулах болжээ. Ким гурван удаа баригдсан боловч ах дүү нар нь тухай бүрт нь цагдаа нарыг хахуульданд суллуулж байв. Сүүлчийн удаа баривчлагдаад суллагдсаныхаа дараа зүүн хойд Хятадад байхад аюултай болсон учир Бээжинд очиж ажил хайхаар галт тэргэнд суув. Янбианы уугуул солонгос гэсэн нэрээр халхавчилж, солонгосоор ярьдаг хүүхэд асрагч хайж байсан зарын дагуу хандсан байна.

Өмнөд Солонгосоос Хятадад урилгаар ирж ажиллаж байсан нэгэн профессор нэг ойтой хүүхдээ харуулахаар түүнийг хөлсөлж авлаа. Ким эмч тохь тухтай орчинд амьдарч, бага насны хүүхэд асрах боломж олдсонд олзуурхан байв. Тэр ажиллах хугацаандаа маш сайн асрагч, гэрийн үйлчлэгч болохоо харуулсан учир нөгөө айл Өмнөд Солонгос руу буцахдаа хамт явъя гэжээ. Чинээлэг солонгосчууд Хятадын уугуул солонгосчуудыг гэрийн үйлчлэгч, хүүхэд асрагчаар хөлслөн нутагтаа аваачих нь цөөнгүй.

Ким эмчид үнэнээ ярихаас өөр сонголт үлдсэнгүй. Нөхрөөсөө салсан, хүүгээ өсгөх эрхээ алдсан, Ким Ир Сенийг нас барсны дараа аав нь амиа хорлосон, хагас өлсгөлөнгийн байдалд өнгөрөөсөн он жилүүд, эмнэлэгт ямар ч тусламж авч чадалгүй амь тавьж байсан хүүхдүүдийн тухай гээд л өнгөрсөн амьдралынхаа тухай нэг нэгэнгүй гэрийн эзэгтэйд ярьж өглөө.

"Бурхан минь. Чи чинь эмч байсан юм уу? Надад хэлэхгүй яасан юм бэ? Тэгсэн бол би чамд өөрөөр хандах байсан юм" гээд бүсгүйчүүд тэврэлдэн уйлалдсан байна.

"Хэрэв би анхнаасаа үнэнээ хэлсэн бол энэ ажилд орж чадахгүй байсан шүү дээ. Гэтэл надад ажил үнэхээр хэрэгтэй байсан юм аа".

Үнэнээ хэлсэн явдал нь Ким эмчийн гэрийн асрагчийн ажилд төд удалгүй цэг тавив. Профессор түүнийг Өмнөд Солонгос руу аваачихаар амласан бөгөөд хэлсэн үгэндээ хүрдэг хүн байжээ. Нутаг буцаад хэдэн сарын болсныхоо дараа профессор түүнийг зуучлагчтай танилцуулж өгөв.

2002 оны гуравдугаар сард Ким эмч Инчоны онгоцны буудал дээр шинэ амьдрал эхлэх итгэл дүүрэн бууж байлаа. Гэвч энэ мэдрэмж удаан үргэлжилсэнгүй. Засгийн газраас авсан тэтгэмжийн 20,000 долларынхаа ихэнхийг нэгэн эрийн ятгалгаар сүлжээний бизнест оруулсан нь маш том алдаа байжээ. Саван болон гоо сайхны бүтээгдэхүүн танил талууддаа зарах ёстой байж. Гэнэн

байдал, сайн ойлголтгүйгээсээ болж уг сүлжээний бизнес пирамидын зарчмаар явагддаг гэдгийг мэдэлгүй, тэтгэмжийн мөнгөө бараг бүгдийг алдсан байна. Үүнээс гадна бас нэг бэрхшээл тулгарав. Хойд Солонгосын сургуулиас олж авсан эмчийн мэргэжил нь Өмнөд нутагт хүчингүйд тооцогддогийг олж мэдсэн байна. Хэрэв эмчээр ажиллах хүсэлтэй бол анагаахын их сургуульд элсэж, бүхнийг эхнээс нь эхлэх, үүний тулд засгийн газрын тэтгэлэгт нас нь ахдах тул өөрөө сургалтын төлбөрөө төлж сурах хэрэгтэй болов. Долоон жил анагаахын дээд сургуульд суралцан төгсөж найман жил ажилласан туршлага нь юу ч биш болон хувирахаар хүн гунихаас өөр яах билээ? Түүнд өөрийгөө үзэн ядах, өрөвдөх мэдрэмж холилдон төрж, хэрхэхээ мэдэхээ больсон байна. Нутгаасаа оргосондоо харамсах үе ч ирэв. Амиа хорлох тухай ч бодож үзсэн байна.

2004 онд түүнтэй анх уулзаад Өмнөд Солонгост ирсэндээ харамсаж байгаа эсэх тухай нь асуухад:

"Хэрэв одоо мэдэж байгаагаа энд ирэхээсээ өмнө мэдэж асан бол би ирэхгүйсэн" хэмээн нуулгүй хариулсан юм. Миний ярилцсан хүмүүсийн цөөнгүй нь ингэж боддог боловч ямар нэгэн шалтгаанаар үнэнээ хэлээгүй гэж би бодсон. Ким эмч одоо хэр нь өөрчлөгдөөгүй, хэн ч харсан Хойд Солонгосынх гэж танигдахаар байгааг би ажигласан юм. Үсээ хар хилэн боолтоор боож, уруулаа 1960-аад оны киноны хэв маяг болох тод улаанаар будсан нь Пхеньяны төвд олноороо тааралдах Хөдөлмөрийн намын гишүүдийг санагдуулам харагдаж байлаа.

Харин хэдэн жилийн дараа дахин уулзахад тэс өөр хүн болж, өөрийгөө өөрчилсөн байлаа. 2007 оны зун тансаг япон ресторан руу алхан орж байгаа бүсгүйг би арай л гэж таньсан билээ. Тэр үсээ мөрөө хүртэл ургуулан, цэнхэр жинсэн өмд өмсөж, чихэндээ шигтгээтэй урт ээмэг унжуулсан харагдана.

"Би Хойд Солонгосын өрөвдөлтэй эмэгтэй хэмээн харагдахаас залхсан" гэж Ким надад хэлж билээ. Ким эмч оюутан охин шиг залуухан харагдаж байлаа. Үнэхээр ч оюутан болсон байв. Өмнөд Солонгосын анагаахын зөвлөлтэй хэдэн жил үзэлцсэний үр дүнд тэр дөчин настайдаа дөрвөн жилийн анагаахын хөтөлбөрт хамрагдахаар болсон байна. Өөрөөсөө хорь орчим дүү охидтой нэг ангид сурч, дотуур байранд хамт амьдарч байгаа гэнэ. Хойд Солонгосын боловсрол муудаа биш Өмнөдийн анагаахын сургууль англи хэл дээр нэр томьёо ихтэй учир хэлний асуудлаас болж хичээл нь их л хүнд байгааг надад хэлсэн юм. Ким эмчийн сурсан цорын ганц гадаад хэл нь орос хэл. Гэхдээ л шинэ орчин, шинэ амьдрал нь түүн таалагдаж байгаа бололтой их л сэтгэл хангалуун харагдав. Сургуулиа төгссөнийхөө дараа дахин эмчийнхээ ажлыг хийхээр төлөвлөсөн бөгөөд дотрын эмч, тэр дундаа гериатрикс буюу хөгшрөлт судлалаар дагнахаар шийдсэн байв. Ээж нь Алцхаймерийн өвчнөөр нас барсан учраас настай хүмүүст зориулсан асрамжийн газар, болж өгвөл бүр асрамжийн газрын сүлжээ нээх мөрөөдөл өвөртөлсөн байлаа.

Нэгэн сайхан өдөр хоёр Солонгос нэгдвэл Өмнөдийн настайчуудын халамжийн системийг Чонжиндоо нэвтрүүлнэ хэмээн ярьсан юм. Энэ нь бүтэхгүй мөрөөдөл мэт санагдах боловч Ким эмчид өөрт нь, өнгөрсөн ирээдүй хоёрыг нь холбох гүүр, эх нутгаа хаяж гарснаа сэтгэлдээ цагаатгах оролдлог мэт санагдана.

Хойд Солонгосоос оргогсдын ихэнх хэцүү хүмүүс гэдэг нь гашуун үнэн байлаа. Ихэнх нь

өлсгөлөнгөөс зугтааж ирсэн боловч бас нэлээд нь гэр бүлийнхэнтэйгээ таарч тохироогүйгээсээ болоод нутгаасаа оргосон байх юм. Шинэ нутагт ирснээр тэдний зан засарсан уу гэвэл үгүй.

Ким Хиюук үүний тод жишээ. Арван естэйдөө Өмнөд Солонгост ирэхдээ ядуу, намхан, гэр орон, өөрт нь туслах хамаатан садан, танил талгүй хэвээрээ л байлаа.

2000 оны долоодугаар сарын зургаанд тэрбээр "Кёвасо 12" хөдөлмөрийн лагериас суллагдахдаа хоол тэжээлийн дутагдлаас болж дөнгөн данган алхаж, хэдэн метр яваад л амрахгүй бол уначих гээд байдаг болсон байжээ. Найзындаа түр амьдрах зуураа дараагийн оргох төлөвлөгөөгөө боловсруулахаар шийджээ. Уг нь хил даван хууль бус наймаа эрхэлмээр байвч юу ч хийхээс буцдаггүй арван дөрөвхөн настай залуу хүүг хөдөлмөрийн лагерь зориг зүрхийг нь үхүүлэн, нугалан дарж авсан байв. Дахин баригдаж, зодуулж үйлээ үзэхийг хүсэхгүй байлаа. Мөн байнгын зугтаж нуугдахаас ч залхаж. Нутагт нь хоргодох юм огт байхгүй. Гэвч Хятад руу орголоо гэхэд дахиад л баригдах нь гарцаагүй. Тэгэхээр цорын ганц боломж нь Өмнөд рүү ямар нэгэн аргаар зугтан гарах явдал хэмээн бодох болжээ. Гэвч Өмнөд рүү хэрхэн гарахаа ч мэдэхгүй, гагцхүү Хятад дахь өөр шиг нь тэнэмэл залуучуудад тусалдаг Өмнөд Солонгосын номлогч нар байдаг тухай олж сонсчээ. Ингээд 2000 оны Зул сарын баярын өмнөх өдөр Түмэн голыг сүүлийн удаа гатлахдаа Христосын сүм олох эрэлд гарлаа.

Ази, Африк, Дундад Азийн орнуудад шашнаа дэлгэрүүлэх, хүмүүнлэгийн тусламж хүргэх зорилгоор номлогч нараа хамгийн их илгээдэг оронд Филиппиний дараа Өмнөд Солонгос ордог билээ. Ихэнх Өмнөдийнхөн Хойд нутгаасаа ирсэн цагаачдад хоёрдмол хандлага үзүүлдэг бол Христосын номлогч нар байдлыг нь маш сайн ойлгож, зөөлөн элгэмсэг ханддагаараа олонд танигджээ. Өмнөдийн хэдэн мянган номлогч зарим тохиолдолд Америкийн Солонгос номлогч нарын хамт зүүн хойд Хятад руу цувж, Хятадын эрх мэдэлтнүүдийн дургүйг хүргэж, асуудалд орохгүйн тулд хувийн байшинд, албан ёсны бүртгэлгүй жижиг хэмжээний сүмүүдийг ажиллуулдаг байна.

Хөдөөний харанхуй орчныг тэдгээр сүмийн улаан гэрэл чимэглэл бүдэг гэрэлтүүлэх ажээ. Хил зөрчигсдийн хувьд өөр нэг аюулгүй орогнох газар бол НҮБ-ын Дүрвэгсдийн Дээд Комиссариатын Газар болон бусад хүмүүнлэгийн чиглэлийн төрийн бус байгууллагууд хэмээгдэх боловч тэдгээр байгууллагууд Хятадын хуулийг зөрчиж, Хойд Солонгосчуудыг орогнуулах эрх байхгүй. Иймээс албан ёсны бүртгэлгүй Христосын сүмүүд, номлогч нар л хил зөрчигсдийг хоол хүнс, орон байраар хангах цорын ганц горьдлого нь юм санж.

Хиюук зүүн хойд Хятадын том хотуудын нэг болох Шеньянд ирж байж Христосын сүм олов. Тавилгын үйлдвэрийн эзэн Өмнөд Солонгосын бизнесмен залуу уг сүмийн үйл ажиллагааг хариуцдаг байсан ба цуу яриагаар бол хүмүүсийг Өмнөд Солонгос руу аюулгүй гаргадаг сүлжээтэй, хөрөнгө бэлтэй нэгэн аж.

"Би Христос шашны тухай мэдэж авмаар байна" хэмээн Хиюук заллаа.

Сүмд хүлээн авсны дараа тэрбээр бусдын адил дүрэм журамд суралцаж, нөхцөл байдалдаа

дасан зохицох хэрэгтэй боллоо. Тэд өглөө таванцагт босож мөргөл үйлдэнэ. Дараа нь өглөөний ундаа ууж, дасгалаа хийгээд Библи судалж, оройн хоолоо иднэ. Дараа нь ахиад мөргөлийн цаг эхэлнэ. Ингээд оройн есөн цаг гэхэд унтах ёстой. Амралтын өдрүүдээс бусад өдрүүд иймэрхүү маягаар үргэлжилнэ. Харин Бямба, Ням гаригуудад хөл бөмбөг тоглож амарна. Өөрийн насны бусад Хойд Солонгосын залуучуудын адилаар Хиюук Есүс Христийн тухай огт сонсоогүй байлаа. Төрөхөөс нь олон жилийн өмнө Чонжин дахь Христосын сүмүүдийг хаасан байв. Настайчуул уг шашныг шүтэвч баригдахаас болгоомжлон, хэнд ч мэдэгдэхгүй нууцаар мөргөл үйлддэг байжээ. Дунд сургуулийн сурах бичгүүдээс Христосын шашны тухай олж мэдсэн зүйл нь номлогч нар өөдгүй, хоёр нүүртэй, харгис амьтад гэх. Хиюук Христосын шашны тухай гутранги, буруу бодолтой хэвээрээ л байлаа. Өмнөд Солонгосын сүм хоол, амьдрах байр өгснийхөө төлөө өөрсдийн номлолыг тулгаж байна хэмээн бухимдан бодно. Хажуугаар нь бас итгэсэн болж хуурч байгаадаа сэтгэл нь зовнино. Аажимдаа Хиюукийн хандлага зөөлөрлөө. Хэсэг хугацааны дараа мөргөлийн үгсийг бувтнасаар байгаад хүүхэд ахуйгаас хойш өөрт нь байгаагүй тайван сайхан сэтгэл төржээ. Ким Ир Сений тухай шүлэг цээжилж байхад нь хэзээ ч ийм сэтгэгдэл төрдөггүй байсан билээ.

Ури абоги буюу бидний эцэг гэж дуулахдаа энэ удаа Ким Ир Сенийг биш Ертөнцийн эзнийг, хүүгийнх нь тухай ярихдаа Ким Чен Ирийг биш Есүсийг ярих болов.

Сүмд таван сар болсных нь дараа сүмийн удирдагч түүнийг цаашаа хөдлөх болсон тухай хэлжээ. Уг сүм үргэлж цагдаагийн хяналтад байх учир зочдынхоо аюулгүй байдлын талаар их л санаа зовнидог байв. Сүмийн удирдагч Хиюукт 1000 юань буюу 125 доллартай тэнцэх мөнгө өгч, хэсэг хүмүүсийг дагуулан Монголын хил рүү очихыг зөвлөв. Тэндээс Өмнөд Солонгос руу явах бололцоо бий гэнэ. Хатагтай Сонгийн орголт онгоцоор нисэж, янзалсан

паспортоор хил давах маягаар зохицуулагдсан дээд зэрэглэлийн үйлчилгээ байсан бол Хиюукийн Монголоор дамжих зам нь азаа үзэх маягийн үйлчилгээ. Гэхдээ өөрийн гэсэн мөнгөгүй хүнд бол хамгийн сайн гарц. Хятадтай адилгүй нь Монгол улс нийслэл хот Улаанбаатартаа байх Өмнөд Солонгосын Элчин Сайдын Яаманд зугтасдыг хүлээн авахыг нь зөвшөөрдөг юм. Үнэн хэрэгтээ Хойд Солонгосчууд Хятадын хилийг аюулгүй даваад Монголын хилийн цэргийнхэнд баригдвал л бараг болчихлоо гэсэн үг. Иймээс Монгол улс Хойд Солонгосын зугтагсдын гол дамжин өнгөрөх баазын нэг болж чадсан байна.

Хиюук хамт явах бүлэг хүмүүсээ удирдан Монгол Хятадын хилийн боомт Эрээн хотыг зорин хөдөллөө. Тэдний бүлэгт Хойд Солонгосын зургаан иргэн байсны дотор эцэг нь Өмнөд Солонгос руу цагаачилсан гуравтай, аравтай хоёр хүү орсон байв. Төлөвлөгөө ёсоор бол тэд Далианаас ирэх хэсэг хүмүүстэй аюулгүй газар нэгдэн, цааш аяллаа үргэлжлүүлэх байлаа. Тэдгээр хүмүүсийн нэг нь Монголын хилд хүрэх замыг мэддэг гэнэ.

Гэвч бүх зүйл буруугаар эргэв. Галт тэргээр явж байтал нөгөө бүлэг нь баривчлагдсан тухай аймшигт мэдээ утсаар ирэв. Хиюук болон бусад нь маш их цочирдож буцья гэвч оройтжээ. Цагдаа нар аль хэдийн хяналтдаа авсан байх магадлалтай учир тохирсон газар руугаа лав очиж болохгүй нь. Цагдаагийнхан гар утсаар байршлыг нь мэдэж болох учир гар утаснуудаа цонхоор шидлээ. Хиюук бүлгийн бусад том хүмүүстэйгээ хэрхэх тухайгаа хэсэг хугацаанд хэлэлцэв. Зам сайтар

зааж өгч, гараар зурсан газрын зураг өгсөн учир ямар ч байсан Монголын хил рүү явахаар шийдлээ.

Хорин нэгэн цаг хүртэл Эрээн хотын галт тэрэгний буудлын ойролцоо бүгж, цагаан гэгээ тасартал хүлээгээд харанхуй болмогц хөдлөхөөр шийдлээ. Тэд Улаанбаатар руу явах галт тэрэгний замыг дагаад хойд зүгийг чиглэх ба баригдахаас сэргийлэн хоорондоо зайтай явах ёстой. Хилийн цөлжсөн хэсэгт очоод 2.1 метр өндөр хашааг давахад л хоёр улсыг заагладаг хүнгүй хэсэгт нэвтрэх ёстой байлаа.

Эрээн хотын галт тэрэгний буудлаас хилийн эхний хайс хүртэл найман км, цаашаа Монголын хилийн эхний харуулын цамхаг хүртэл нэг километр орчим алхаад л хилийн харуулынханд бууж өгөх ёстой. Гэгээтэйд бол ямар ч асуудалгүй хил рүү хүрч чадах л байлаа. Гэтэл говь нутагт шөнийн харанхуйд зүг чиг олоход амаргүй. Одоор зүг чиг баримжаалж, байсхийгээд л тааралдах ялгахын аргагүй адилхан чулуу, халгай, кофены өнгөтэй элс зэрэг нь төөрүүлэх аюултай байлаа.

Төмөр замаас баруун тийш явах ёстой юу, эсвэл эсрэгээрээ зүүн тийш чиглэх ёстой юу хэмээн томчууд нэлээд маргалдсаны эцэст зүүн зүгийг сонгосон нь асар том алдаа болов. Хилийн зурвас зүүн хойд зүгт үргэлжилж байснаа огцом эргэж хойд зүгт муруйсан байна. Гэтэл тэд хил давах ёстой цэгтэй ойртолгүй, хилтэй параллеллаар л алхаад байжээ. Үүр хаяарахад л буруу зүгт явж буйгаа мэдсэн байна. Говьд хүн тэсэхийн аргагүй халуун болж 40 градус хүрч эхлэв. Чигээ өөрчлөн, хилийг заагласан төмөр утсан хашааг олох үед үд дунд өнгөрсөн байв. Бартаатай замаар удаан алхсанаас болж, гутал нь цоорч хөлнөөс нь цус гоожиж байжээ. Халуун наранд арьс нь түлэгдэж, авч явсан зургаан литр ус нь дуусав. Хиюук болон бусад томчууд гурван настай хүүг ээлжлэн үүрч явтал арван настай нь бас гуйвж дайвж эхлэв. Нэгэнт түүнийг үүрч чадахгүйгээс чирч явлаа. Ингэж явтал арайхийн нэг эзгүй гэр таарч, хүүг нэг эмэгтэйтэй орхиод Хиюук ус олж ирэхээр гүйв. Гэрийн дэргэдэх бяцхан шанднаас жаахан ус аваад ирж байтал өнөөх үлдсэн эмэгтэйн муухай чарлах сонстлоо. Хөөрхий хүү насан өөд болжээ.

Монголын хилчид тэднийг орой тийшээ олсон байна. Хэргийн учрыг шийдэхэд үхсэн хүүгийн шарил нэлээд асуудал үүсгэжээ. Шүүх эмнэлэг хүүг алагдсан биш, цангаж үхсэн болохыг тогтоохын тулд цаг хугацаа шаардагдаж, байцаалтыг удаашруулсан байна. Энэ хугацаанд Хиюук болон бусад томчууд Монголын нэгэн шоронд хоригдож байв. Хиюукийн хувьд чөлөөт ертөнц дэх амьдрал нь ийнхүү тун таагүй байдлаар эхэлсэн аж.

Хиюук 2001 оны есдүгээр сарын 14-нд бусад оргогсодтой хамт Улаанбаатараас Өмнөд Солонгост нисэн ирлээ. Инчоны онгоцны буудал дээр Монголд олгосон түр паспорт дээр нь хилийн шалганы байцаагч тамга дараад "Өмнөд Солонгост тавтай морилно уу" гэхэд нь арай л муужраад уначихсангүй.

Бусад оргогсдын адил Хиюукийн хөөрсөн сэтгэл төдөлгүй алга болов. Хөдөлмөрийн лагерьт хоригдсоноос нь болж түүнийг хүнд байцаалт хүлээж байлаа. Өмнөд Солонгосын засгийн газар зугтаж ирсэн хүмүүс дотор гэмт хэрэгтнүүд байх вий хэмээн улам болгоомжтой хандах болсон байлаа. Тэндээс арайхийж чөлөөлөгдлөө гэж бодсон чинь Ханнавон руу илгээгдэж, бас нэг сарыг

үдэхдээ тусгаарлагдсан байдлаас залхаж гүйцсэн байв.

Хиюукийн зан чанар нутагтаа ад үзэгдэж байсан шигээ Өмнөдөд ч ад шоо болов. Тэр түргэн ууртай, үргэлж бусдын өөдөөс өрвөлзөж дургүйг нь хүргэнэ. Цэх сууж чадахгүй. Нурууны өндрийн хэмжээнд асар их анхаарал тавьдаг нийгэмд бие галбир нь ч гологдож байв. Ид өсөлтийн үедээ хоол тэжээлийн дутагдалд орсон хүмүүсийн хувьд байдаг л галбир. Хөл нь хэт богино, толгой нь биедээ томдсон. Хоол тэжээлгүй өлсгөлөнд ороод ирэхээр бие махбодь үе мөчинд очих ёстой тэжээлийг толгой болон их бие рүү нь чиглүүлдэг байна. Өлсгөлөнгийн тухай ном зохиолуудад үүнийг "хатангирших" хэмээн нэрлэсэн байдаг. 2003 онд хийсэн НҮБ-ын Хүүхдийн Сан болон Дэлхийн Хүнсний Хөтөлбөрийн нэгдсэн судалгаагаар Хойд Солонгосын хүүхдүүдийн дөчин хувьд ийм шинж тэмдэг илэрсэн гэнэ.

2004 онд надтай анх уулзахдаа Хиюук Сөүлээс хоёр цагийн зайд орших Буёо хэмээх хотод амьдарч байлаа. Өөр цагаач тэнд байхгүй тул туслах хүн нэг ч үгүй. Том хотын шуугиан, хүн амын нягтшилд дасаж өгөхгүй байгаа тухайгаа хуучилсан юм. Засгийн газраас өгсөн 20,000 долларын тэтгэмжээ ахыг нь олж өгнө гэсэн зуучлагчид бараг бүгдийг нь алдсан байна. Нэг жил гаруй хүлээсний эцэст ахыгаа үхсэн гэдэгт итгэжээ. Ах нь метр наядын өндөртэй тул амьд гарсан байх магадлал бараг үгүй хэмээн ярьсан юм. Намхан байхын нэг давуу тал гэвэл амьд үлдэхийн тулд бага хоол хэрэгтэй болдог.

Хиюук нэг ажилд ороод л удалгүй гарч, дахин нэгийг сонгосоор л байлаа. Эхлээд зайрмаг зөөж байгаад түүнтэй яг адил ажил хийдэг Өмнөд Солонгосын иргэн илүү цалинтай байдгийг мэдмэгц уур нь буцалж ажлаа хаясан билээ. Машины засварчны дамжаанд сууж хэдэн сар засварчнаар ажилласан ч бас л удаан байж тэссэнгүй. Мэргэжлийн боксчин болохоор зорьсон боловч нуруу нь намджээ. Ингээд тэр хэзээ ч найз охинтой болохгүй юм байна хэмээн их л санаагаар унасан гэнэ.

Хиюук маш их ганцаардаж байв. Шинэ хүмүүстэй танилцах ур дүй муутай учир Өмнөдчүүд өөрт нь талтай хандахад төдийлөн ойшоохгүй нь их зантай мэт харагдуулж байв. Хэдийгээр улсынхаа дэглэмийг үзэн ядаж байсан ч Өмнөд Солонгосчууд шүүмжлэхэд өөрийгөө өмөөрдөг зуршилтай. Энэ бол Хойдоос ирсэн цагаачдын өмнө тулгарч байсан гол бэрхшээлийн нэг юм.

Өмнөд Солонгосчуудын дагаж мөрддөг ёс жаяг дургүйцлийг нь төрүүлж байлаа. Хойд Солонгосчууд танихгүй хүнтэй ойр зуурын яриа огт өрнүүлдэггүй, хэрвээ тэгвэл их гайхацгаана. Хөршүүдтэйгээ тааралдахаар найрсгаар мэндлэхэд нь Хиюук нүүрээ бууруулах буюу эсвэл өөдөөс нь ширүүн харна.

"Хүн яриа өдөхөд харилцан ярилцах ёстой гэдгийг би мэддэггүй байсан. Ингэж хүмүүс хоорондоо танилцаж, найз нөхөд болдог ба хэрэв хүсвэл тэд надад тусалж ч болох байсан гэдгийг би тэр үедээ ойлгоогүй" гэж анх Өмнөдөд ирснийхээ дараа тулгарч байсан бэрхшээлүүдээсээ хожим нь Хиюук надад ярьсан билээ.

2008 онд Хиюуктай дахин уулзахад Сөүлд нүүж ирээд бизнес түүхийн чиглэлээр мэргэжихээр коллежид элсэн орсон байв. Тэр хорин зургаа хүрч, найз охинтой болоогүй ч олон залуутай

үерхэж эхэлсэн байлаа. Найзуудынх нь тоонд Мусанаас оргож ирээд удаагүй үеэл нь ч байна. Өөрөөс нь дор хүмүүс байхыг олж үзээд Хиюкийн өөртөө итгэх итгэл дээрдсэн гэнэ. Сургуулийнхаа ойролцоо гудамжинд явж байгаад нэгэн хувийн сургуулийн эзэнтэй тааралджээ. Яриа өрнөхөд Хиюук сурснаараа зугталгүй, харин үнэн байдлаа хэлтэл нөгөө хүн сургуульдаа үнэгүй суралцахыг урьжээ.

Тэр одоо л жинхэнэ байр сууриа олжээ.

ХОРЬДУГААР БҮЛЭГ

ДАХИН УЧИРСАН НЬ

Хойд Солонгост амьдралыг нь доош татаж байсан "бузарлагдсан цус" нь Өмнөдөд ирэхэд нь маш том давуу тал болохыг Ми Ран мэдэрлээ. Өмнөд дэх гэр бүлийн харилцаа нь үнэлж баршгүй зүйл байв. Танихгүй газар ганцаараа ирэх нь дахин төрөхтэй адил болж, ганцаарддаг бусад оргогсодтой адил байдал түүнийг угтсангүй. Түүнийг гэх хамаатан тэнд байсан юм.

Өмнөд Солонгост орчин үеийн амьдрал өрнөж байвч Күнзийн уламжлал нөлөөтэй хэвээр. Айлын ганц хүү болох Ми Раны эцэг гал голомтоо залгамжлах ёстой байсан ба нас барсных нь дараа энэ үүргийг үр хүүхэд нь гүйцэтгэх ёстой.

1998 онд Ми Раныхан Түмэн голыг гатлан Хятад руу гарч ирснийхээ дараа аавынхаа төрсөн нутаг Өмнөд Чунчон мужийн Сёсан дахь мужийн захиргаа руу утас цохиж, эгч нарынх нь тухай лавласан байна. Сёсан тосгоныхон олноороо хот бараадан нүүж, тосгон бараг үгүй болсон байлаа. Гэтэл Өмнөд Солонгост тухайн газар нь хүн амьдарч байгаа эсэхээс үл шалтгаалан хүмүүсийг эцгийнх нь төрсөн газарт харьяалуулдаг. Мужийн захиргаанд эцгийнх нь хоёр эгчийн хаяг байж таарч, захиаг нь дамжуулан өгөхөөр болов. Ми Раны хорин гуравтай дүүд гэр бүлийн цорын ганц эр хүнийх нь хувьд захиа бичих үүрэг ноогдлоо. Би энэ захиаг танай дүүгийн ганц хүүгийн хувьд бичиж байна. Тэрбээр Хойд Хамёнг мужийн дүүрэгт амьдарч байгаад нас барсныг уламжилж байна хэмээн бичээд одоо байгаа хилийн ойролцоох хотын хаяг, бас утасны дугаараа бичиж илгээсэн байна.

Хэдэн долоо хоног өнгөрсний дараа аавынх нь хоёр эгчийн нэг нь залгалаа. Эхлээд үл итгэсэн, тээнэгэлзсэн байдалтай ярьжээ. Дүү нь Солонгосын дайнаас амьд гарсан тухай огт сураг чимээ гараагүй, ямар нэгэн холбоо барих оролдлого, утсаар ярих, захиа бичих зэрэг ямар нэгэн оролдлогогүйгээр хагас зуун өнгөрсөн байхад эргэлзэхээс ч яах билээ. 1961 онд Солонгосын дайн дууссанаас найман жилийн дараа Өмнөд Солонгосын Батлан Хамгаалах Яам Тэ Вуг 1953 оны тулалдаанд амь үрэгдсэн хэмээн албан ёсоор мэдэгджээ. Тэгэхээр Тэ Ву гэр бүлийнхнийхээ хувьд 21 насандаа өнгөрсөн болохоор үр хүүхэдтэй байх ёсгүй. Үндэсний Оршуулгын Газарт дурсгалын самбар дээр нэр нь хүртэл байдаг аж. Мөнгө салгах уран арга биш гэдэгт эгч нар нь яаж итгэх юм? Ми Раны эгч хүүхэд байхад нь аавынхаа ярьдаг байсан зүйлээс мэдэхийнхээ хирээр ярьж өгсөн боловч генийн шинжилгээ өгөхийг санал болгов. Бүгд зөвшөөрлөө.

Гэр бүлийн уулзалт хоёр долоо хоног үргэлжилжээ. Хоёр авга эгч нь зарим нэг хамаатан саднуудынхаа хамт, нийт арван хүн Хятадад хүрэлцэн ирэв. Бие биеэ харангуутаа л генийн шинжилгээ өгөх ямар ч шаардлагагүй гэдгээ ойлгоцгоожээ.

"Бид зүгээр л бие бие рүүгээ ширтэцгээсэн. Бидний дагз, гарын хэлбэр, явж байгаа, ярьж байгаа маань гээд л хоорондоо төстэй зүйл олон байсан. Аав минь айлын ганц хүү болохоор авга эгч нар

маань голомт залгах хүнгүй болж, удам тасарлаа хэмээн их л харуусаж байснаа ярьсан. Тэднийг Хятадад ирэхэд би гайхсандаа, бас баярласандаа чичирч билээ. Тэд эмэгтэй л болохоос биш яг л аав минь байсан юм" хэмээн Ми Раны дүү дурсан ярьж билээ.

Ми Раныханд буцах зам байсангүй. Ээж нь Чонжинд буцан очиж, үлдсэн хоёр охин, зээ нартайгаа хамт амьдрахыг маш ихээр хүссэн ч Хойд Солонгосын засгийн газар Хятадад хамаатан садантайгаа уулзсаныг нь олж мэдсэн бол цаазлуулах ял авах байв. Иймээс бүгд Өмнөд Солонгос руу явахаас өөр замгүй болов.

Ингээд авга эгч нар нь Шенянь дэх Өмнөд Солонгосын консулын газар очиж, зохих хүмүүстэй уулзан Солонгосын дайны ахмад дайчны бэлэвсэн эхнэр, үр хүүхдүүдийг Өмнөд Солонгос руу авч явах хүсэлтэй байгаагаа илэрхийлэхэд нааштай хүлээн авсангүй. Тэр үед буюу 1998 оны хоёрдугаар сард Өмнөд Солонгосын ерөнхийлөгчөөр сонгогдсон Нобелийн шагналтан Ким Дэ Жун Хойд Солонгостой харилцах харьцааг зөөлрүүлсэн "Нарны гэрэл" хэмээх санаачилга гаргасан байлаа. Өмнөд Солонгос, Хятадын харилцаа ч сайнгүй байсан юм. Албаны хүмүүс Ми Ран болон ээж эгч дүү нарыг нь Өмнөд Солонгос руу аваачих нь Хятад, Өмнөд Солонгосын дипломат харилцаанд сэв суулгахаас вий гэхээс болгоомжилсон байх.

Азаар авга эгч, хамаатан саднууд нь асуудлыг шийдэх өөр арга олов. Авга эгч нар нь жижиг зочид буудал, хүүхдүүдийнх нь нэг Сөүлийн захад халуун усны газар ажиллуулдаг бөгөөд Өмнөд Солонгос, Хятадын хооронд нааш цаашаа явж Хойд Солонгосын хамаатнуудаа нутагтаа аваачих арга олохоор хөөцөлдөж эхлэв. Ми Рантай адил насны үеэл нь паспортынхаа, зургийг хуулж аваад оронд нь бүсгүйгийнхийг наасан бол, нэг авга нь паспортоо "гээж", Ми Раны ээж түүнийг нь "олж" ашигласан байна. Тэд хууль бус зүйл хийж байгаагаа мэдэвч өөр арга байсангүй. Үеэлүүдийнх нь нэг нь нэлээд хожим паспорт хуурамчаар үйлдсэн хэргээр шийтгүүлж, сар хиртэй шоронд суусан аж.

1999 оны нэг сард Ми Ран, ээж, эгч дүүтэйгээ Өмнөд Солонгост аюулгүй ирсэн билээ.

Өмнөдөд хүлээн авах гэр бүлтэй учир Ми Ранд тохиолдох бэрхшээл харьцангуй бага байлаа. Тэр Хойд Солонгос хүн гэдэг нь мэдэгддэг байсан боловч Өмнөдийнхнийг үргээх хэмжээнд биш байлаа. Метр жаран нэгийн өндөртэй учраас нутагтаа бол өндөрт, харин Өмнөдийнхний хувьд боломжийн нуруутайд тооцогдоно. Анх Жун Саны кино театрт олж харсан шиг өндөр шанаатай, монхор хамартай хэвээр л. Хойд Солонгосын эмэгтэйчүүд Өмнөдийн эрэгтэйчүүдийг татдаг тэр нууцлаг чанар Ми Ранд бас байлаа. Аятайхан царай зүс, ах дүү нар, төлөв томоотой чанар, байгалиас заяасан ухаан, энэ бүхэн Ми Раныг бусад оргогсдоос ялгаруулж байсан юм. Тэр элдэв төвөггүйгээр магистрын сургалтад элсчээ. Бодсон санаснаа ойлгомжтой илэрхийлэх чадвартай тул Хойд Солонгосын боловсролын тогтолцооны талаар ярилцлага өгөх эсвэл яриа хийхээр байнга уригдах болжээ.

Гуч хүрэхээсээ дөнгөж өмнөхөн биерхүү, өргөн шанаатай, дугуй нүдний шилтэй залуутай танилцжээ. Залуу батлан хамгаалах салбарын энгийн ажилтан. Хоёр гэр бүлийнхэн нь зоригжуулснаар тэд гэрлэж, 2004 оны сүүлээр Ми Ран хүү төрүүлжээ. Хүүгийнхээ нэг насны ойг уламжлалт маягаар зуу гаруй ах дүү, хамаатан садан, найз нөхдөө урьж тэмдэглэсэн байна.

Сөүлийн зүүн хэсэгт байрлах зоогийн газрын дээд давхрыг цагаан цэнхэр бөмбөлгүүдээр чимэглэжээ. Ми Ран нөхөр, хүүгийн хамтаар баяр ёслолын үед өмсдөг өнгөлөг, гоёмсог ханбокоор гоёсон байв. Ми Раны хувцас гялалзсан, цагаан шаргал даавуугаар хийгдсэн бөгөөд захыг нь улаан хар туузаар чимэн хатгамлаар захалсан байв. Тэр өнгөлөг, төлөвшсөн, сайхан сэтгэл гэрэлтсэн бахархмаар эзэгтэй болсон байлаа. Миний мэдэх олон бүсгүйчүүдийн мөрөөдөл болсон царайлаг нөхөр, хүү, удахгүй хамгаалах магистрын зэрэг гээд бүгдийг тэр олж авчээ.

Өмссөн хувцас, ярьж буй байдлаараа Ми Ран Өмнөдийн бүсгүйчүүдээс ялгарахааргүй. Хойд Солонгосчуудыг илэрхий ялгаж өгдөг гуншаа аялгаа тэр аль хэдийн гээжээ. Сөүлд нэг сая доллараар байр авах бэлгүй хүмүүст зориулсан гэмээр хөл хөдөлгөөн ихтэй Сувон дүүрэгт залуу хос байр худалдан авсан байна. Байр нь эргэн тойрон модоор хүрээлэгдсэн, ялгахын аргагүй олон өндөр байшингуудын нэг бөгөөд хажуу талд нь тавьсан дугаараар л бие биеэсээ ялгагдана. Оршин суух болсон энэ газрынх нь барилгууд шинэ, цэвэрхэн, орчин нь тун ч тохилог. Хоёрдугаар давхарт байх зочны өрөөнд нь өглөөний нар тусна. Дотроо уудам саруул энэ байр хүүхдийн өрөөтэй, ажлын өрөөнийх нь ширээн дээр Самсунг фирмийн компьютер тавиаастай. Гал тогоо нь том өрөөтэйгөө нэг бөгөөд орчин үеийн бүхий л хэрэгслээр бүрэн тоноглогдсон аж.

Намайг тэднийд зочлон очиход Ми Ран хүүтэйгээ үдийн хоолоо хийж байлаа. Дөнгөж алхаж эхэлсэн дугуй царайтай хөөрхөн хүү том өрөөндөө хүүхэлдэйн кино үзээд сууж байв.

Бид амьдралд нь гарсан эргэлтийн талаар ярилцацгаав.

Гэрийн ажлаа амжуулж, хүүгээ асрахын зэрэгцээ магистрын сургалтаа гүйцээх гээд маш завгүй байгаагаа хуучлав. Хадмууд нь эрдэм номын мөр хөөхийг нь төдийлөн дэмжихгүй, гэрийн эзэгтэй байлгахыг хүсэж байгаа тухай ч цухас дурдаад авав. Асрагч хөлслөх их үнэтэй болохоор хүүгээ харахын хажуугаар магистрын ажлаа бичнэ гэдэг амаргүй даваа. Хүүхэд төрүүлснээс олсон жингээ хаях гэж бялдаржуулах урлагаар хичээллэж байгаа гэнэ. Стрессээс болж нүүрэн дээгүүр тууралт гарах нь элбэг ажээ. Түүнд тулгараад байгаа асуудлууд миний мэдэх бусад ажил хийдэг эхчүүдийнхээс их ялгарахааргүй санагдсан.

Гэтэл сэтгэлийнхээ гүнд Ми Ран Хойд Солонгосын нийгмийн хамгийн доод ангиас гаралтай, ядуу, "бузартсан цус" судсаар нь урсаж байгаа эмэгтэй хэвээр л байлаа. Ми Ран багаасаа коммунист үзэл суртлаар хүмүүжсэн учраас урвасандаа байнга сэтгэл нь шанаалаастай. Тэр сэтгэлээ онгойтол бусадтай санал бодлоо хуваалцаж чадалгүй олон жилийг үджээ. Овоолсон хүүрийн хажуугаар ямар нэгэн айдасгүй алхаж сурч, үдийн хоолоо сүүлчийн үртэс хүртэл нь, удахгүй өлбөрч үхэх нь тодорхой болсон шавь нартаа өгөх тухай бодох ч үгүй иддэг байсандаа өөрийгөө буруутгана. Өөрсдийгөө буруутан мэт санах, ичих хоёр оргож ирсэн Хойд Солонгосчуудын хувьд түгээмэл тохиолддог сэтгэлийн шаналал юм.

Ми Раны хувьд энэ шаналал хийсвэрлэл биш бодит зүйл байхаас өөр аргагүй. Намайг түүнтэй танилцаад хоёр жил шахам болж байхад тэрбээр нутагт нь үлдсэн хоёр эгчид нь юу тохиолдсон тухай ярьж өгсөн юм. 1999 оны зун, тэднийг Өмнөд Солонгост ирээд зургаан сар орчим болсны дараа ардын аюулгүй байдлын ажилтнууд хоёр эгчийг нь зэрэг шахам гэрээс нь баривчилжээ.

Армийн энгийн ажилтантай гэрлэж, тэгш сайхан амьдралтай болсноор өлсгөлөнгийн үед гэрийнхэндээ хүнс залгуулдаг байсан том эгч Ми Хи, бусдад гэмгүй амьдарч асан Ми Сук хоёр нь амьдралынхаа туршид гэр бүл, үр хүүхэд эх орон, Ким Чен Ирт үнэнч байсныхаа төлөө насаар нь хорионд байлгадаг хөдөлмөрийн лагерьт цөлөгдсөн байна. Хойд Солонгост байхдаа Ми Раны шөнө харсан шиг зүйл эгч нарт нь тохиолджээ. Ялгаа нь гэвэл хүүхдүүдийг нь эцгүүдэд нь үлдээж эхнэрүүдээсээ салах өргөдөл өгөхийг тулгасан байна. 1999 онд аймшигт өлсгөлөн ид нэрвэх үеэр цөлөгдсөн болохоор хоёр эгч нь амь үрэгдсэн байх магадлал тун өндөр.

Эгч нарынх нь хувь заяа гэр бүлд хүнд дарамт болон тусчээ. Эрүүл сайхан хүү төрүүлэхдээ ч, дүү Сок Жу нь Австралийн их сургуульд элсэх урилга авахад ч эднийхэн баярлаж чадсангүй. Энэ бүхэн шударга бус санагдаж байв. Хэдхэн жилийн дараа ирсэн зугтагсдын ар гэрийнхэн ямар нэг харгислал амсаагүйгээр барахгүй Өмнөдөөс илгээсэн мөнгөөр амжиргаагаа залгуулж, гайгүй амьдралтай айлуудын тоонд орцгоодог болсон байна. Ми Раны гэр бүлийнхэн зугтагсдын түүчээ байж, бас нийгмийн доод гарал нь нөлөөлсөн үү, юутай ч маш хүнд шийтгэл хүлээжээ. Ми Раны ээж хатуу чанга сэтгэлтэй, өлсгөлөнгийн үеэр гэр бүлээ аварч гарсан эмэгтэй Өмнөд Солонгост ирсэн даруйдаа сэтгэлээр маш их унасан байна. Өмнөдөд ирэхдээ дөнгөж жаран хоёр настай байсан ч сэтгэл санааны тогтворгүй байдал, эрүүл мэнд хоёр нь түүнийг сөхрүүлжээ. Тэр бөө дээр очиж охидынхоо тухай асуутал амьд байж магад хэмээн хэлсэн нь бүр сэтгэлээр унагаав.

Ми Раны ээж шашин шүтэх болов. Коммунизмын өмнөх жилүүдэд Чонжины сүмүүдэд очдог байсныгаа сэргээж, охидоосоо урваснаа өршөөхийг залбиран, бурханд тасралтгүй мөргөх болжээ.

Ми Ран шашин шүтдэггүй болохоор ээж шигээ бага ч гэсэн сэтгэлээ тайтгаруулах арга байхгүй, уймрах аж. Өөрийгөө буруутгах сэтгэл зүүд нойрноос нь ч салахгүй, борви бохисхийх чөлөөгүй ажиллаж байх үед ч ухаан санаанаас нь холдохгүй. Түүний Хьондэйгийн машин унадаг амьдралынх нь үнийг эгч нар нь амь насаараа төлсөн билээ.

Мөн орхиж явсан найз залуугийнхаа тухай Ми Ран үе үе бодно. Нийгмийн доод гарлаасаа үл хамааран хувь заяагаа өөрөө залж, багш болох зам мөрийг сонгоход нь Жун Сан түүнд сэтгэлийн их дэм өгсөн. Жун Сан Хойд Солонгосын дэглэмийн тухай нэг ч муу үг цухуйлгаагүй мөртлөө Ми Ранд өөрийгөө бодох ёстойг зааж өгсөн нь яваандаа зоригтой, шийдэмгий болоход нь тусалсан.

Биднийг уулзах бүрт Ми Ран найз залуугийнхаа тухай ярина. Би түүнийг ээждээ ч, мэдээжийн хэрэг нөхөртөө ч ярьж зүрхэлдэггүй нууц буюу анхны хайрынхаа гэгээн дурсамжийг надтай хуваалцаж байна уу даа хэмээн боддог. Жун Сан түүнийг кино театрт анх хэрхэн олж харсныг, харанхуй шөнөөр хамтдаа хэрхэн зугаалдаг байсан тухайгаа яриад ирэхээрээ үгээ эвлүүлж ядан сандарч, дунд сургуулийн сурагч охин найздаа нууцаа ярих гээд тэвдэж байх шиг санагдана.

"Гурван жил зөвхөн гараа барилцаж, бүтэн зургаан жил үерхсэний дараа арай гэж хацар дээр минь үнссэн гээд бод доо. Үнсэлт ч гэж зүгээр л уруулаараа хацрыг минь шүргэх шиг л болсон" "Хариу байхгүй хайр л хамгийн удаан оршин тогтнодог юм уу даа" хэмээн бид хошигнон инээлддэг байлаа. Тэр ганц хуучин найз залуугийнхаа талаар ч бус өөрийнхөө гэнэгүй явсан үеийн тухай дурсан бодож байх шиг санагдана.

Жун Саныг яасан бол хэмээн Ми Ранаас асуухад: "Аль хэдийн гэрлэсэн байх аа" гээд дуугаа намсган, тоомжиргүй байдлаар мөрөө хавчив. Нөхөртөө хайртай болохоор Жун Сантай хамт амьдарч чадаагүйдээ харамсдаггүй. Гагцхүү нутгаасаа явахдаа салах ёс хийж чадаагүй нь л харамсал төрүүлдэг хэмээн хүүрнэсэн билээ. Сүүлийн өдөр Чонжинд явж байхыг нь олж харчихаад оргох төлөвлөгөө нь бүтэхгүй болохоос айн дуудаж уулзаагүйгээ дурсан ярив.

"Бидний хооронд ер бусын холбоос бий. Би түүнтэй нэг л өдөр уулзана гэдэгтээ итгэдэг" хэмээн Ми Ран хэлж билээ.

Энэ яриа Ми Ран бид хоёрын дунд 2005 оны арван сарын дундуур, хүүгийнх нь төрсөн өдрийн дараахан болж өнгөрсөн юм. Гурван долоо хоногийн дараа Ми Ран над руу залгаж "Тэр энд ирчихсэн байна шүү дээ" хэмээн харилцуурын цаанаас ч сэтгэл хөдлөл нь мэдрэгдэхээр хэлсэн юм.

Бид Сөүлийн төвд байх манай ажлаас хэдэн гудамжны цаана орших Старбакст кофе уунгаа уулзахаар тохирлоо.

Ми Раны ярьснаас би Жун Саныг биерхүү, царайлаг залуу хэмээн төсөөлж байлаа. Гэтэл надтай уулзахаар туранхай, нүдний шилтэй залуу орж ирэв. Гэсэн ч түүнд нэг л онцгой зүйл байх. Тэгш цагаан шүд нь кино одыг санагдуулна. Хавтгай нүүр, хамрын өргөн самсаа зэрэг нь гайхалтай монголжуу төрхтэй болгож, Рудольф Нуреев шиг харагдуулна. Капучино бэлэн болмогц Жун Сан гүйн очиж, лангуун дээрээс авчрах нь тэр. Туранхай болохоор их шаламгай хөдөлж байлаа. Гэтэл Ми Ран сандарсан байдалтай, богинохон жинсэн банзал өмсөж, нүүрээ ердийнхөөсөө илүү будсан харагдав.

Кофены газар гэж байдаггүй орноос ирсэн гэхэд бүр үйлчлүүлж сурсан хүн шиг байна шүү гэж хэлэхээр завдах үедээ л харин Жун Саныг Өмнөд Солонгост ирээд жил гаруй болж буйг олж мэдэв. Ирэнгүүтээ байцаалт өгч байх явцдаа тусгай ажилтнуудаас Ми Раны гэрлэснийг олж мэдээд, уулзаагүй нь хэн хэндээ дээр хэмээн шийдсэн ажээ. Түүнийг тоохоо больсондоо ингэж шийдсэн биш, үнэн хэрэгтээ Ми Раны явсныг Жун Сан сонсуутаа тэнгэрт ниргүүлэх мэт болсон байна. Ми Ран Жун Саныг сэтгэл санаагаар хэрхэн унасныг төсөөлөх ч үгүй. Ми Раны зугталт Жун Саны итгэлийг алдагдуулжээ. Тэрбээр харилцааныхаа утгагүй байдлаас болоод гүн шаналав. Тэд яагаад бие биедээ итгэдэггүй байсан юм бэ? Хоёулаа оргох тухай бодож байсан атлаа яагаад бие биеэсээ нуусан хэрэг вэ? Үүнээс гадна өөрөө түрүүлж оргож чадаагүйдээ Жун Саны сэтгэл их зовнижээ. Ми Ран өөрийг нь орхиж явсан гэхээсээ илүү өөрөөс нь илүү зоригтой гэдгээ харуулснаар бардам зан нь нуран унав.

"Би уг нь өөрийгөө чамаас илүү сэтгэдэг гэж бодож байсан юм. Гэвч би буруу бодсон байсан" гэж Жун Саныг ярихад Ми Ран дундаас нь тасалж, сэтгэлийг нь засах гэж оролдон "Би тэр үед засаг төрдөө итгэдэггүй байсан. Гэхдээ Жун Сан гадаад ертөнцийн талаар надаас хамаагүй их мэдээлэлтэй явдаг байсан" хэмээгээд Жун Санд цааш ярих боломж олгов.

Ми Раньг явсны дараа тэр судалгааныхаа ажилд хамаг цагаа зориулж, нойр хоолгүй шахам ажиллах болсон ба үүнийх нь ч үр дүн гарч, их сургуулиас нь байнгын ажил санал болгон, Хөдөлмөрийн намд ч элсэх боломж гарч иржээ. Эцэг эх, дүү нар нь баярлаж түүнийг урамшуулж байв. Энэ бол албан тушаал ахуй амьдралын хувьд Хойд Солонгост хамгийн сайн эхлэл байлаа. Пхеньян дахь амьдрал нь ч муугүй. Хөлсөлсөн байр нь дулаахан, юутай ч өлсөхөөргүй байв. Гэтэл Жун Сан тэр бүхнээсээ татгалзлаа. Өөрт нь маш сайн тохирох их сургуулийн охидтой үерхэлгүй, үзэл суртлын лекцүүдэд ч суухаа болилоо. Ажлаа тарж гэртээ ирснийхээ дараа хөшгөө сайн гэгч нь хааж аваад Өмнөд Солонгосын телевиз үздэг байжээ.

2001 онд Жун Сан их сургуульдаа эцэг эхийн бие тааруухан байгаа, том хүүгийн хувьд харж асрах хэрэгтэй

боллоо хэмээн ойлгохоор шалтаг хэлж ажлаасаа гараад Чонжиндоо буцаж ирэв. Үнэн хэрэгтээ хийж байгаа үйлдлийг нь тэр бүр шалгаад байхааргүй, бас Хятадын хилд ойролцоог нь бодож төрсөн хот руугаа тэмцсэн байна. Жун Сан санаанд оромгүй ажил хийж, бүр Ми Рантай алхдаг байсан газрынхаа ойролцоо орших асрамжийн газар хүртэл ажиллаж үзлээ. Мөнгөө үрэлгүй цуглуулж, ихэнх оройг эцэг эхтэйгээ өнгөрүүлэх болов. Ганц найдвар болсон хүү нь итгэлийг нь хөсөрдүүлсэнд гомдсон эцэг хүүтэйгээ огт дуугардаггүй байлаа.

Их хүч хөдөлмөр зарж, бэлтгэсэн Жун Саны оргох төлөвлөгөө Ми Раных шиг амархан бүтсэнгүй.

Жун Сан оргохын тулд мөнгө цуглуулж гурван жил ажил хийжээ. Тэр зохион байгуулалт сайтай, хэлсэн үг, хийсэн үйл болгоноо хариуцахыг хичээдэг хүн болохоор оргох төлөвлөгөөгөө тун нарийн боловсруулжээ. Ямар үед юу өмсөхөө хүртэл шийдсэн байв. Японоос авга ахынхаа явуулсан үнэтэй бөгөөд чанартай харагддаг дугуй хээтэй цамцаа өмсвөл Хятадад гуйлга гуйхаар ирсэн мэт харагдахгүй хэмээн төсөөлж, Японоос ирсэн өмднөөсөө сайныг нь шилэн нямбайлан гялгар уутанд хийн, үүргэвчиндээ хийлээ. Голын усны түвшин ихэсдэг зургаан сард Жун Сан хил давах болов. Харуул хамгаалалт бага байдаг болохоор нь Түмэн голын нэлээд гүнзгий хэсгийг сонгож авчээ. Тэднийг зуучилж авч явж байгаа хүн живэхгүйг нь бодож хуванцар лонх авсан байлаа. Жун Сан болон хамт оргож байгаа дөчин настай эмэгтэй хоёр хувцсаа тайлж дотуур хувцастайгаа үлдэхдээ харанхуй хэдий ч бие биеэсээ ичингүйрэн байлаа. Жун Сан хувцсаа норгохгүйн тулд гялгар уутанд хийв.

Ус эрүүгээр нь татаж, голын урсгал Жун Саны бодож байснаас илүү ширүүн байлаа. Ус хамт явсан эмэгтэйн толгой дээгүүр гарч ирэв. Тэр сэлж чадахгүй учир Жун Сан гараас нь сайтар атгаад цааш сэлжээ. Гэнэт нүцгэн хөлд нь элс тааралдаж, норсон дотуур хувцастайгаа голын эрэг дээр гарч ирэв. Эрэг дээр гарсан хойноо эргэж харвал үүрийн гэгээ хаяарч, Хойд Солонгосын уулс тэнгэрийн хаяанаас тодрон харагдаж байлаа. Тэр бага зэрэг гуньсан боловч удаан зогссонгүй. Гялгар уутанд хийсэн боловч норсон хувцсаа өмсөж зуучийг даган голоос холдон явлаа.

Зургаадугаар сард тийм хүйтэн байх юм гэж Жун Сан огт бодсонгүй. Нойтон гутлын дотор хөл нь холгож цэврүү үсэрлээ. Очоод хоол идэж амарна хэмээн найдаж байсан тосгонд нь хэдэн өдрийн өмнө нутгийнх нь иргэн хулгай хийж байгаад баригдсан тул оргогсдод нутгийн иргэд

таагүй хандах болсон байв. Цагдаад мэдэгдэж магад хэмээн цэрвэж, тэндээс үтэр түргэн холдон явлаа. Жун Сантай хамт явсан эмэгтэй өөрийнхөө очих газар руу хамт явахыг санал болгов. Тэрбээр уг тосгонд нэгэн тариачинтай хамт амьдардаг байжээ. Алхаж байхдаа Жун Санд өөрийнхөө түүхийг ярьж өгсөн байна. Эмэгтэй, тариачинтай хэдэн жил амьдарсан бөгөөд дундаас нь гарсан хүү нэг нас хүрч буй гэнэ. Тэр долоон сарын өмнө баригдаж хөдөлмөрийн лагерьт хоригдож байгаад суллагдаж одоо нөхөр хүү хоёр дээрээ очихоор яарч яваа ажээ. Нөхөр нь Жун Саныг цааш аялахад бэлэн болтол нь гэртээ байлгана хэмээн ятгав.

Гэтэл тариачных орогнох газар биш байлаа. Тариачин эхнэрээ өшиглөн, цохиж Жун Саныг элдвээр хараан загнасан байна. Жун Саныг эхнэрийнхээ амраг гэж бодов бололтой.

Төөрч ганцаардсан Жун Сан хөдөөгөөр баахан тэнүүчилж яваад нэг газар хүн тэрэг олж хараад үсрэн сууж, зуучаас сурсан ганц үг, "шичан" буюу зах руу гэж тэрэгчинд хэллээ. Тэгээд жижгэвтэр ил зах дээр ирээд тэрэгнээс бууж, кимчи зарж буй эмэгтэй дээр очлоо. Түүнийг солонгос хүн байх гэж таагаад өөрийг нь ажилд авчихаар хүн мэдэх эсэхийг асуув. Эмэгтэй хэсэг зуур Жун Саны нүдний шил, өмссөн Япон цамц хоёрыг нь ширтсэнээ "Чи ч дээ хар ажил хэзээ ч хийж үзээгүй хүн шиг л байна даа" хэмээгээд тоосонгүй. Нэлээд ятгасны дараа эмэгтэй Жун Саныг тоосгоны үйлдвэрийн эзэн, солонгос бизнесментэй танилцууллаа.

Жун Сан ойртвол хөмсгийг нь хуйхалчихмаар халуун тоосго өрсөн хүнд тавиур зөөх ажилд орлоо. Харин орой нь ажилчдын байранд, худалдаж авсан тэмдэглэлийн дэвтэр дээрээ анх удаа үнэн сэтгэлийн үгээ чөлөөтэй бичдэг байв. Хойд Солонгост цаасан дээр үнэн бодлоо бичих дэндүү аюултай учир хэн ч зүрхэлдэггүй билээ. Оюутан үеийнхээ тухай төдийгүй яруу найраг бичив. Шантармаар хүнд хүчир ажлын дараа уг дэвтэр л Жун Санд яах гэж нутгаа орхин гарсныг нь сануулдаг байжээ.

Тэр тоосгоны үйлдвэрт хоёр сар ажилласныхаа дараа зорилгоо хэрэгжүүлэх төлөвлөгөөндөө эргэн орох мөнгөтэй болж, Өмнөд Солонгосын хүн амын томоохон бүлэг бас консулын газар байдаг Чингдао руу автобусаар явлаа.

Хятад дахь Өмнөд Солонгосын консулын газруудыг Жун Сан шиг хүмүүсээс хамгаалах зорилгоор чанд хатуу харуулаар хамгаалуулсан байдаг. Гэвч Жун Сан аятайхан хувцаслаад учраа яривал болох байх хэмээн итгэж, үлдсэн мөнгөөрөө шинэ нүдний шил, костюм худалдан авав. Өөртөө бүрэн итгэлтэй тэрбээр консулын байран дээр ирж, харуулуудын хажуугаар өнгөрч, цахилгаан шат руу нэвтэрч ороод консулын долоон давхрын товчийг дарлаа. Гэвч долоо болон наймдугаар давхрын шатнууд тусгай түлхүүрээр ажилладаг байж. Цахилгаан шатнаас гартал бас нэг харуул явж байхыг хараад буцаад шатандаа суув. Тэгээд есөн давхарт буугаад доошоо харайлгав. Байшингаас гарахад нь харуулууд хоорондоо станциар сандралдан ярьж байхыг хараад өөрийг нь барихаар завдаж буйг мэдлээ. Жун Санд аз дайрч баривчлагдахаасаа өмнө байшингаас зугтан гарчээ.

Жун Санд мөнгө ч, өөр санаа ч байсангүй. Ингээд нутаг руугаа буцах талаар бодож эхлэв. Интернет гэгч юм байдгийг нээгээгүй бол тэр буцчих ч байсан биз.

Жун Сан Хойд Солонгосын сайн их сургуулиудын нэгний элит оюутнууды тоонд ордог байсан ч Интернет гээчийг хэрэглэж байсангүй. Уг нь их сургууль нь сайн үзүүлэлттэй IBMийн Пентиум 4 компьютертай боловч тэдгээр нь зөвхөн Хойд Солонгосын дотоод сүлжээнд холбоотой бөгөөд гагцхүү эрдэмтэн судлаачдад зориулсан учраас судалгааны материал, урьдчилаад нарийн шүүлтүүрээр хянагдсан нэвтэрхий толинууд л олддог байлаа. Тус улс интернет хэрэглэхгүй байхаар шийдсэн цөөхөн улсын нэг юм. Чонжин дахь компьютерийн клубуудэд хүүхдүүд зөвхөн тоглоом л тоглож болно.

Жун Сан Интернетийн талаар сонссон учраас Хятадад ирсэн дээрээ үзэх сэн гэсэн хорхой нь хөдлөөд байв. Интернет өөрт нь тулгарсан асуудлыг шийдчих юм шиг хий хоосон мөрөөдөж байлаа. Гэтэл яаж Интернетэд орох вэ? Чингдаогийн автобусны буудал дээр Жун Сан солонгосоор ярих нэг залууг хараад ярилцсан байна. Гэтэл тэр "танд би интернет яаж хэрэглэдгийг заагаад өгье. Их амархан. Та дор нь сурчихна" гээд Интернет кафе руу дагуулан явлаа.

Вэб гэдэг Жун Саны хувьд цоо шинэ нээлт болов. Хулганаа дарах бүрд түүний өмнө шинэ ертөнц нээгдэж байлаа. Нутгаасаа оргон Хятадад ирснээ зөв байж гэдэгт анх удаагаа баттай итгэх болжээ. Хойд Солонгосын том сургуулиудын нэгний тэргүүний оюутан, тэндээ компьютер хамгийн сайн мэддэгт ордог байсан Жун Сан интернетийн талаар захын хүүхдээс дор мэдлэгтэй болохоо мэдсэн юм. Өмнөд Солонгосын хайлтын систем дээр Хойд Солонгосын хүний эрх, оргогсод гэж бичээд нэвтрэх товчийг дарлаа.

Үүнээс хойш Жун Сан орой болтол интернетэд суун бэлэн гоймонгоор хооллож, уншиж судалсаар байв. Бусад оргогсод ч Өмнөд Солонгос руу явахад нь өөртэй нь адил бэрхшээл тулгарч байсныг олж мэдэв. Тэдний хэрэглээд амжилтад хүрсэн, бас бүтэлгүйтсэн стратегиудыг судалж эхлэв. Хойд Солонгосчуудад хамаатай Өмнөд Солонгосын хуулиуд, мөн ямар учраас Өмнөд Солонгос Хятад дахь ЭСЯ-дууд болон консулын газруудаараа дамжуулан Хойд Солонгосын оргогсдыг хүлээн авч болдоггүй, дипломат албаны хүндрэлүүд зэргийг уншиж судалсан байна. Мөн Хятадын газрын зураг, онгоц, галт тэрэгний хуваариудыг ч нарийвчлан үзлээ.

Тэгээд нэг өдөр Инчонд амьдардаг нэгэн сүмийн хамба лам оргогсдыг Монгол руу аваачдаг нууц зам байдаг талаар их л нигүүлсэнгүй сэтгэлээр бичсэнийг олж уншаад "Би Чингдаод байна. Та намайг Өмнөд Солонгос руу явахад тусалж чадах уу" гэсэн утгатай и-мэйл бичжээ.

Жун Саны явсан зам Хиюукийнхтэй яг адилхан байлаа. Энэ шугамаар хэдэн зуун хүн өмнө нь замнасан тул хэрхэн яаж Өмнөдөд аюулгүй очих тухай хангалттай мэдээлэл цугларсан байлаа. Жун Санд зорилгодоо хүрэхэд 2500 доллар хэрэгтэй байсныг Японд байдаг авга ах нь шилжүүлснээр Эрээн хот руу замдаа гарчээ. Эрээнээс элдэв бэрхшээлгүйгээр элсэн цөлөөр дамжиж, Монголын хилийн харуулд баригдсанаар тэд түүнийг Өмнөд Солонгосын ЭСЯ-нд тушаасан байна. Жун Сан Өмнөд Солонгост 2004 оны аравдугаар сард ирж Үндэсний Тагнуулын Албанд хүргэгджээ.

Байцаалтанд орж байх үедээ тусгай ажилтнаас асуусан хамгийн эхний асуулт нь Ми Рантай хэрхэн холбоо барих тухай байлаа. Чингдаод байхдаа нэрийг нь Интернетээс хайж, өгсөн ярилцлагыг нь олж үзсэн болохоор Ми Раныг Өмнөд Солонгост буй гэдэгт итгэлтэй байлаа. Тагнуулын Албанд түүний тухай мэдээлэл заавал хадгалагдаж буйг мэдэж байсан болохоор тийнхүү асуусан хэрэг. Мөрдөгдөж байсан журмын дагуу оргогсдын мэдээллийг тагнуулуудаас сэргийлэн бие биед нь өгдөггүй ёстой.

Та түүний хамаатан садан биш бол уг мэдээллийг бид өгөх ёсгүй.

Тэр миний сүйт бүсгүй, анхны хайр минь байсан юм.

Жун Саныг байцааж байсан ажилтан өрөвч сэтгэлтэй хүн таарч, судалж өгөхөө амлав. Маргааш нь Жун Сан дээр ирээд утсыг нь өгч болохоо, бас Ми Раныг гэрлэсэн гэдгийг хэллээ.

Жун Сан балмагдав. Өнгөрснийг дурсан санахад Ми Раныг өдий хүртэл ганц бие яваа гэж бодох утгагүй, өөрийг нь хүлээж байх нь бүр ч эргэлзээтэй байсан билээ. Ми Ран тэр үед гучин нэгэн нас хүрч, тэд хоорондоо холбоогүй зургаан жилийг үдсэн байв.

"Тэгсэн атлаа, үнэнийг хэлэхэд, түүнийг гэрлэсэн гэж огт санаанд ороогүй шүү" гэж Жун Сан дурсан ярьсан юм.

Жун Сан өөрийгөө тайвшруулахыг оролдож Түмэн голыг гатлахдаа уншсан арван есдүгээр зууны үеийн Унгарын яруу найрагч Пётөөфи Шаандорын яруу найраг санаанд нь орж иржээ.

Амраг хайр, эрх чөлөө Аль аль нь хэрэгтэй.

Амраг хайртынхаа төлөө Амиа өгөхөөс ч буцахгүй Эрх чөлөөний төлөө харин Энхрий янагаа ч хайрлахгүй Өмнө нь Пхеньянд энэ шүлгийг олж уншчихаад сэтгэл нь хөдөлж цээжилсэн байна. Тэр бүсгүйд өгсөн хайраа Пхеньянд амьдрах сонголтоор сольсон бөгөөд Ми Раныг хэзээ ч нэгдүгээрт тавьж байсангүй. Тэр Өмнөд Солонгос руу эрх чөлөөг тэмцэн ирсэн билээ. Одоо түүнд үлдсэн зүйл эрх чөлөө.

Дараагийн саруудад Жун Сан бусад оргогсдын явсан замаар замнав. Ханнавоноос гарч, байр хөлслөөд, гар утас худалдаж авав. Гудамж талбай, дэлгүүр хоршоогоор тэнэж явахдаа гайхширан, заримдаа толгой нь эргэж, их хөлийн газар хөл алдалгүй шиг явахыг хичээх боллоо. Тэр цөөхөн найзтай бөгөөд заримдаа Ми Раныг олж чадахгүйдээ арга барагдаж байлаа. Гэрлэснийг нь сонсоод Жун Сан утасных нь дугаарыг авахыг хүсээгүй юм.

Нэгэнт гэрлэснээс хойш уулзаж зовоогоод яах вэ дээ гэж бодсон байна.

Ханнавонд танилцсан Хойд Солонгосчууд хааяа нэгнийдээ цуглаж шар айраг уудаг заншлаар нэг орой цуглаад байв. Тэдний дунд бодлогоширсон царайтай нэгэн залуу байсан нь Ми Раны дүү болохыг Жун Сан даруй танив. Жун Сан үерхдэг охиныхоо дүүд саймширч чихэр өгдөг байснаа

саналаа. Тэр үед Сок Жу жаахан хүүхэд байсан учраас Жун Саныг таньсангүй.

Тэр орой Жун Сан Сок Жу хоёр танилцаж ярилцаад түүнээс хойших цугларалтуудад ч тааралдаж яриа өрнүүлдэг болов. Хэсэг хугацааны дараа Сок Жу "Та яагаад миний болон манай гэр бүлийнхний талаар ийм их юм мэдээд байна?" гэж сэжиглэсэн байртай асууснаа Жун Саныг хариулахаас өмнө өөрөө санаж гуяа алгандан босон харайгаад "Та чинь эгчтэй минь үерхдэг байсан хүү шив дээ" хэмээн уулга алджээ.

Үүнээс долоо хоногийн дараа Жун Сан хоорондоо адилхан олон өндөр байшингийн хажуугийн явган замаар алхаж явлаа. Сөүлийн зүүн хэсэгт байх метроны буудал дээр Ми Рантай уулзахаар тохирсон учир тэр ийн алхаж явна. Сок Жу түүнийг танимагц Жун Сан Ми Ран руу өөрөө утасдахаас аргагүй байдалд оржээ. Жун Саны хоолойг танимагцаа Ми Раны хоолойд эгдүүцэл тодорч "Чи ийм их удсан байж яагаад над руу залгаагүй юм бэ? Би чамд туслах байсан шүү дээ" хэмээжээ.

Жун Сан эвгүй байдалд оров. Тэр Өмнөдөд ирээд жил гаруй болсон байдаг. Энэ хугацаанд ганцаардаж, гутарч, хэрхэхээ мэдэхгүй байсан үе олон. Өөрийг нь бусдаас хамаагүй илүү ойлгох найздаа, хамгийн эртний анддаа хандаж болох байсан боловч тэгсэнгүй. Гэхдээ өөрийг нь тоолгүй, өөрт нь дуулгалгүй хаяад явсан түүнд гомдсон бяцхан гоморхлоосоо болоод Ми Ранд хандаж чадаагүй. Ингээд уучлал гуйсан байна.

Харин одоо Жун Сан гар утасныхаа цагийг байн байн харан, догдлон хүлээнэ. Буруу шугамаар явчихсан юм болов уу, эсвэл өөр гарцан дээр гараад ирсэн юм болов уу хэмээн өөртөө эргэлзэн өндөлзөж байлаа. Сөүл өдрөөс өдөрт тэлж, түүнийг даган метро улам өргөжиж, шугамын тоо, гарцууд нь олширсоор байсан тул Жун Сан учрыг нь хэзээ ч бүрэн гүйцэд олж үл чадна. Тэдний уулзахаар тохирсон энэ буудал орон сууцны шинэ хорооллыг дагаж баригдсан, энд ээж нь амьдардаг гэж Ми Ран Жун Сантай утсаар ярихдаа хэлсэн байв. Жун Сан таньдаг хүн харагдаж байгаа эсэхийг шалган явган замыг гүйлгэн харлаа. Намар өвлийн завсарт ховорхон тохиодог цэлмэг сайхан өдрийн нэг байлаа. Явган зам дүүрэн хүнтэй байгаагийн ихэнх нь эмэгтэйчүүд. Ажлын өдөр байснаас гадна Өмнөд Солонгосын ихэнх бүсгүй гэрлэснийхээ дараа ажил хийдэггүй учир эмэгтэйчүүд олонх байгааг гайхаж цөхөлтгүй. Бүсгүйчүүд бариу жинсэн өмд өмсөж, үзүүрээс нь сэвсгэр тоглоом уясан гар утсаа санжигнуулан алхацгаана. Зарим нь бараг унадаг дугуйны үнэтэй болов уу гэмээр хүүхдийн тэрэг түрцгээсэн байна. Хойд Солонгост хүүхдийн тэрэг гээч юмыг хэн ч мэдэхгүй. Хөлд ороогүй хүүхдийг эх нь урт бөсөөр нуруундаа даруулан боож авч явдаг. Ми Ран эдгээр эхчүүдтэй л адилхан байгаа даа хэмээн хэсэг хугацаанд бодолд дарагдсанаа сэхээ орж хажуугаар нь өнгөрөөд явчихаагүй байгаа хэмээн эргэн тойрноо хараачлав.

Удаан хүлээв үү? гэж Ми Ран машиныхаа шилийг буулгангаа асуув.

Жун Санд Холливудын сэтгэлд хоногшсон дүр нүдэнд нь туслаа. Олон жилийн туршид түүнтэй дахин уулзах уулзалтаа зураглан, сэтгэлдээ нандигнан явсан бөгөөд манантай өдөр галт тэрэгний буудал дээр хоёр талаасаа бие бие рүүгээ тэмүүлэн гүйх байдлаар төсөөлж байсан бол энэ удаа тэс өөрөөр эргэлээ. Жун Сан дахин уулзах учралаа өөр олон янзаар төсөөлж явсан ч машинтай,

тэр тусмаа Ми Ран жолоог нь барьсан байдлаар хэзээ ч бодож байгаагүй юм.

Тэр автобусны шугам дээр зогссон байсан учир хаалгаа онгойлгож Жун Саныг орж суухыг урив. Ми Ран зам бөглөрөөтэй, энд ирсэн хойно нь машин тавих газар олдохгүй байсан учраас оройтсоноо дуржигнуулан ярьж, уучлал хүслээ. Ми Ран зам руугаа харж Жун Сан харин түүнийг нүд салгахгүй ширтэн байв. Ми Раны ерөнхий төрх хэвээрээ боловч анх хараад таньсангүй. Ми Раныгаа хараад танихгүй байх юм гэж Жун Сан зүүдэлж ч явсангүй. Тэр урьдын адил цоглог байхаа больсон ч юм уу, эсвэл их удаан хол байгаад өөр болсон ч юм шиг санагдаж байж мэдэх юм. Хүүхэд асраад ядарсан нь илэрхий байвч түүнийгээ инээмсэглэлээр дарахыг оролдож, эрүүн дээгүүр нь сэвх гарсныг будгаар нуун янзалжээ. Түүнд охин үеийнх нь төрх бараг л үгүй болж ажамама шинжиндээ орсныг Жун Сан ажиглажээ. Ми Ран хуниастай шаргал банзал, халхгар богино ханцуйтай цамц өмссөн байлаа. Амьдралтай нь адил, хувцаслалт нь бас Ми Ранд үргэлж төвөгтэй санагдана. Охин байхад ямар амар байгаа вэ хэмээн хааяа дурсан боддог аж.

"Чи их тайван байна шүү" гэж Жун Сан чимээгүйг эвдэн хэлэв.

"Үгүй ээ, би чинь дотроо сандраад л явна" гэж Ми Ран хариулав.

Тэд хотын захын тохилог, чимээ анир багатай ресторанд ирж тухаллаа. Эхлээд хэн хэнийхээ гэр бүлийн талаар энгийн зүйл ярилцаж эхлэв. Гэвч энэ талаар хэлэх ярих бүхэнд нь эмгэнэл гарч ирнэ. Эгч нарынх нь талаар Жун Сан асууж ч зүрхэлсэнгүй. Хэзээ ч ахин уулзахгүй байж магадгүй эцэг эхийнх нь талаар Жун Санаас Ми Ран асууж чадсангүй. Тэд ярианыхаа сэдвийг хурдан өөрчилж, Ми Раны гэнэт оргох болсон тухай ярианд шилжив. Яриад эхэлмэгц нь Жун Саны уур хүрч эхэллээ.

"Чи явах гэж байгаа тухайгаа ядаж хальт ч гэсэн мэдэгдэхгүй дээ" Ми Ран тэр үед оргох тухай огт бодоогүй зөвхөн Хятад руу гарч аавынхаа нас барсныг нь авга эгч нартаа дуулгах л бодол өвөрлөж байснаа ярьж итгүүлэхийг оролдов. Жун Сан төдийлөн итгээгүй ч яриаг нь тасалсангүй.

1998 онд Жун Сан Чонжинд очоогүйг нь Ми Ран сонсоод Хятад руу яг гарахынхаа өмнө харсан залуу нь Жун Сан биш байсныг ойлгов.

"Хэрвээ чи Өмнөд Солонгост ирэх байсан юм бол яагаад тэгж удсан юм бэ?" гэж Ми Раныг асуухад Жун Санд хэлэх үг олдсонгүй. Ми Ран уйлан хайлан ярьж байсан ба ярианых нь өнгө ойлгомжтой байлаа. Тийм ээ, бүх юм оройтсон. Ми Ран нөхөрт гарч хүүхэд төрүүлсэн эмэгтэй.

Бие биеэ эргэж олсон хоёрын сэтгэлийн хөдөлгөөн намжжээ. Тэд одоо надтай ярилцахдаа нэгнийхээ талаар гомдоллодог болов. Жун Сан болохоор Ми Ран урьдынх шигээ үзэсгэлэнтэй байхаа больсон гэнэ. Бас Жун Саныг өөр эмэгтэйтэй танилцуулж өгнө гэчихээд сураггүй алга болжээ. Тэд харьцахаараа цахим шуудан эсвэл мессежээр холбогдоно. Орчин үеийн харилцаа холбооны дэвшил тэдний хооронд байсан шидэт утсыг тасалсан аж. Тэдний үерхэл Хойд Солонгосын хүнд бэрх нөхцөлд цэцэглэсэн гэдэг утгаараа үнэтэй байж. Ховор олдох цаасан дээр сэтгэлийн үгээ бичиж, байнга л түлшгүй саатах галт тэргээр нэгнийгээ зорин ирдэг байсан болохоор сэтгэлд нь шингэдэг байж дээ.

"Хүссэн үедээ л түүнтэй утсаар ярьж чадна гэж бодохоор надад тийм ч сонирхолтой санагдахаа больсон. Ийм залуу өдий олон жилийн турш ухаан бодлыг минь яагаад эзэгнэж байсныг ойлгохгүй юм" хэмээн Ми Ран надад үнэнээ хэлсэн билээ.

Нийгмийн гарлын ялгаа одоо чухал биш болжээ. Хойд Солонгост Жун Саны нийгмийн гарал Ми Раныхаас дээгүүр, бас мөнгө, гоёмсог япон цамц, Пхеньянд олж авсан боловсролтой байсан. Гэтэл шинэ газар ирээд найз нөхөд, танил тал гэхээр юмгүй, мөнгө ч үгүй нэгэн болжээ. Сургуульд сурсан шинжлэх ухаан, технологийн боловсрол нь хоцрогдож Өмнөд Солонгост хүлээн зөвшөөрөгдсөнгүй. Иймээс моторт дугуй унан хоол хүргэж өгөх зэргээр хар ажил хийж байлаа. Нэг удаа хоол хүргэж өгөөд явж байхдаа дугуйтайгаа машинд мөргүүлэн унажээ. Дугуй нь зүгээр, өөрөө ч гэмтээгүй болохоор босоод дугуйгаа унан цааш явсан байна. Ресторан дээрээ буцаж очоод болсон явдлыг ярьж өгвөл дарга нь шоолон инээж, "хэрэв чи ийм юу ч мэдэхгүй шинэ хүн биш байсан бол дайрсан жолоочоос нэлээд мөнгө салгах байсан юм" хэмээн ярьж өгөв.

Жун Сан зүгээр л мөрөө хавчив. Өөрийг нь Өмнөдийнхний өөлдөг жижиг сажиг зүйлсийг тэр угаасаа тоодог ч үгүй. Түүний итгэл улам л гүнзгийрч байв. Хэдийгээр эцэг эхтэйгээ хэзээ ч уулзахгүй байж магадгүйгээ мэдэх боловч Өмнөд рүү оргож ирсэндээ огт гомдоллож байсангүй. Амьдралд нь бий болсон өчүүхэн жижиг ч болов эрх чөлөөг туйлын амттайгаар мэдэрч байлаа. Өмнө нь, нутагтаа байхдаа, өмсөх сөн гэж мөрөөддөг байсан жинсээрээ өвч бүрэн хувцаслаж, үсээ мөрөө хүртэл ургуулав. ("Үсээ ургуулах миний мөрөөдөл байсан. Дөч хүрэхээсээ өмнө үсээ ургуулж үзэхгүй бол мөрөөдлөө биелүүлэхээс өөрөө татгалзсан хэрэг болох юм шиг бодогдоод" гэж надад ярьсан билээ). Ном зохиолуудыг шуналтай нь аргагүй уншиж байлаа. Нутагтаа байхдаа хүмүүнлэгийн шинжлэх ухааны төрлийн ном олж уншдаг байсан боловч агуулга нь үнэн эсэх нь эргэлзээтэй. Би түүнд унших ном өгдөг болов. Жорж Орвеллын "1984 он"-ы орчуулсан хувилбар түүнд маш их таалагдсан. Хойд Солонгосын дэглэмийг их сайн ойлгодог байсан байх даа хэмээн тэрбээр Жорж Орвеллаар бахархана.

Бид өнгөрсөн жил Сөүлийн дэлгүүр, үзвэр үйлчилгээний том төв болох Лотте Уорлд дээр уулзав. Цагаан сарын өмнөх Ням гаригийн үд болж байсан юм. Тухтайхан үг сольчих газар эрэн, олны дунд түлхэлцээр нэгэн сушины ресторанд орж суулаа. Захиалсан сушигаа тойрдог тавцангаас авангаа Жун Сан эм найруулагчийн лиценз авахаар сургуульд орсон ба энэ нь түүний хувьд шинээр мэргэжил олж авах хамгийн түргэн арга болох тухай ярьсан билээ. Сургуулийнхаа амралтаар тэр хотын захын барилгын компанид агааржуулагч угсардаг ажил хийдэг болсон байна. Түүн шиг гарал үүсэл, боловсролтой хүнд ийм ажил хийх нь тохиромжгүй мэт надад санагдаж байв. Дахин уулзах үед өөр ажил хийж байх бизээ гэсэн бодол надад төрсөн сөн. Хойд Солонгосын оргогсод Өмнөдөд суурьшихад тийм амар байдаггүй нь надад ажиглагдсан билээ. Дарангуйллын дэглэмд олон жил нухлагдсан хүнд чөлөөт ертөнцөд ирэхэд нь юм бүхэн амар байдаггүй бололтой. Тоо томшгүй олон боломж олгодог ертөнцөд ирээд оргогсод өөрсдийгөө хэн бэ, юу хийж чадах вэ гэдгийг олж нээхээс өөр аргагүй болдог. Хаана амьдрах, юу хийх, тэр бүү хэл өглөө босоод ямар хувцас өмсөхөө шийдэх зэрэг нь сонголт хийж сурсан бидний хувьд ч амаргүй байхад бүхнийг өмнөөс нь шийддэг дэглэмийн дор насаараа амьдарсан хүмүүст бэрх байлгүй яахав дээ.

Оргогсдын зарим нь одоогийн байдалдаа сэтгэл хангалуун бус, нутаг буцахыг хүсэцгээж байгаа. Тэдний ихэнх нь Ким Чен Ир-ийн дэглэм урт насгүй учраас түр зуур Өмнөдөд амьдарч байгаад хэдэн жилийн дараа чөлөөлөгдсөн нутагтаа буцаж суурьших бодолтой ирцгээсэн. 1990-ээд оны үед Ким Ир Сен нас барж, ЗСБНХУ задран унаснаар Хойд Солонгосын дэглэм удахгүй нуран унах нь хэмээн дэлхий дахин хүлээж байсан билээ. Гэвч Пхеньянд очсон хүмүүс өндөр сүрлэг хөшөөд, галуун алхаатай цэргүүдийг хараад уг дэглэм нуралгүй хорин нэгдүгээр зуунтай золгосныг мэдэрсэн юм.

Хойд Солонгосын дэглэм оршин тогтносоор байгаагийн учрыг дэлхий дахин мэдэхийг хорхойсч, зүгээр л сонирхож байхад энэ нь ард иргэд, түүний дотор оргогсдын хувьд эмгэнэл болсоор. Хойд Солонгосын дэглэм тун удалгүй нуран унахгүй л бол Жун Сан 70 нас хүрч байгаа эцэг эхтэйгээ дахин уулзах магадлал тун бага. Хамгийн сүүлд 2010 оны нэгдүгээр сард Жун Сантай уулзахад, эм найруулагчийн ажил авьяасыг нь бүрэн нээх хэмжээний ажил биш болохыг хүлээн зөвшөөрсөн юм. Тэр нутагтаа буцан очиж, бүтээн байгуулалтад оролцохыг хүсдэг гэсэн. Ми Ран 2007 онд ахин нэг охин төрүүлж боловсролын магистрын дипломоо хамгаалсан байна. Тэр ч гэсэн төрсөн нутагтаа эргэн очиж боловсролын салбарыг нь шинэчлэхэд гар бие оролцох мөрөөдөлтэйгөө хуваалцсан билээ. Хойд Солонгосын дэглэм нуран унаж, хөдөлмөрийн лагериудын хаалга нээлттэй болсон тохиолдолд, бас эгч нар нь амьд байж чадах л юм бол тэдэнд уулзах боломж бий. Тэр хүртэл түүнд хүлээхээс өөр хийж чадах зүйл үгүй.

ТӨГСГӨЛ

ХҮЛЭЭЛТ

Миний бие Лос Анжелес Таймс сонины сурвалжлагчаар Сөүлд таван жил ажиллахдаа мэргэжил нэгт сэтгүүлчид, дипломатууд, эрдэмтэн мэргэдтэй олон удаа уулзсан билээ. Бидний яриа ямар нэгэн байдлаар Хойд Солонгосын тухай сэдэв рүү хазайж, тэд Ким Чен Ир-ийн дэглэм нурж унах цаг хугацааг таахыг оролддог байлаа.

Хойд Солонгос судлаачдыг туйлын гайхшруулдаг нэгэн зүйл бол тус улсын дарангуйлагч дэглэмийн оршин тогтносоор байгаагийн нууц. ("Хойд Солонгос улс удахгүй сүйрнэ" хэмээх өгүүллийг алдарт Хойд Солонгос судлаач Николас Эберштадт 1990 оны зургаадугаар сард бичсэн байдаг). Гэвч хамгийн гайхалтай нь Берлиний хана нурж, ЗСБНХУ задран унаж, Хятад улс эдийн засгийн шинэчлэл хийж, Ким Ир Сен нь нас барсны дараа ч уг дэглэм хоёр ч удаагийн өлсгөлөнгийн үеийг даван туулж, эцэг хүү Жорж Бушийн засаг захиргааг хоёуланг нь өнгөрөөсөн ч оршин тогтносоор байгаа билээ. Буш засгийн эрхэнд байхдаа Хойд Солонгосыг Иран, Иракийн адил "нүгэлтнүүдийн" эгнээнд багтааж, Ким Чен Ир-ийг Саддам Хуссейнтэй адил болгоно хэмээн заналхийлж байлаа.

Гэтэл Бушийн хугацаа дуусчихаад байхад Ким Чен Ир эрүүл мэнд нь муудсан ч дэглэмээ хадгалж, засгийн эрхэнд ноёрхсоор л. Ким Чен Ир бол хорьдугаар зууны сүүлчийн, амьд дарангуйлагч юм. Тэр улс эх орноо хүйтэн дайны нөхцөлд байлгаж, иргэдээ худал мэдээллээр мунхруулж, гадныхныг нутагт нь нэвтрэхийг хязгаарлаж, жинхэнэ болон зохиомол дайснуудаа цөмийн зэвсгээр айлган амьдарсаар, улс орноо захирсаар байгаа билээ. 2006 ба 2009 онд Хойд Солонгос хоёр удаа цөмийн туршилт хийсэн. Сүүлийн хориод жилийн туршид сонгогдсон Өмнөдийн ерөнхийлөгч бүр цөмийн зэвсгээр хөөцөлдөхөө боливол дипломат харилцаа тогтоож, Солонгосын дайны асуудалд цэг тавихад бэлэн гэдгээ илэрхийлэн хэлэлцээр байгуулахыг эрмэлзэж байсан ч бүгд талаар болсон юм.

Энэхүү зохиолыг бичиж байх үед Хойд Солонгосын Өмнөд хөрштэйгөө харилцах харилцаа 1990-ээд оны эхэн үеэс илүү муудаж, байдал улам хурцадсаар буй. 2010 оны гуравдугаар сарын 26-нд Шар тэнгист болсон дэлбэрэлтээр Өмнөд Солонгосын харуулын онгоц өртөж 46 хүн амь үрэгдсэн билээ. Тавдугаар сарын 20нд шинжээчид уг онгоцыг Хойд Солонгосын сөнөөгч онгоц дайрсан байж болохыг нотлох хангалттай баримт олсон тухай ярьцгааж байна. Үүнийг цэргийн хүчээр хариулахаас болгоомжилж, Өмнөд Солонгос үлдсэн тусламжаа багасгаж эхэлжээ. 2007 онд консерватив нам ерөнхийлөгчийн сонгуульд ялж Ли Мюн Бак сонгогдсоноор Ким Дэ Жуны нарны туяа бодлогын хүрээнд Хойд Солонгостой явуулж байсан эдийн засаг соёлын солилцооны хөтөлбөрт төгсгөл тавьсан юм.

Хойд Солонгосоос бусад коммунист орон капиталист нийгэмд шилжээд хориод жил болчихоод байхад Ким Чен Ир л 1950-иад онд эцгийнхээ хэрэглэж асан аргаар улс орноо удирдахаар

оролдож байна. Тэрээр өлсгөлөнгийн он жилд хатагтай Сонг шиг хүмүүс амьд үлдэх арга болсон зах зээлийн шинэчлэлийг хүчингүй болгож эдийн засгийн хөгжилд ухралт хийв.

Сүүлийн хэдэн жилд Хөдөлмөрийн Намаас зах зээлийн эдийн засгийг чөдөрлөх зорилготой хэд хэдэн утгагүй журам гаргажээ. Энэхүү журмын дагуу 40-өөс дээш насны эмэгтэйчүүдийг л зах дээр юм зарахыг зөвшөөрнө. Бусад залуу хүмүүс цалин өгөх эсэхээс үл хамааран төрийн өмчит үйлдвэр, аж ахуйн газруудад ажиллах ёстой. Зах дээр юу зарах, зарахгүй талаар улам чанга хязгаарлалт тогтоосоор л. Тусгай цагдаагийнхан захаар эргэлдэж хууль бус хэмээн зарласан бүтээгдэхүүнийг хураадаг болжээ. Хятадаар дамжаад, бидний дайсан Өмнөд Солонгосчуудад зарагдаж мэдэх учраас хориглож байгаа юм гэсэн утгагүй тайлбар хийж цагаан будаа, эрдэнэшишээс гадна буурцгийн шошыг хүртэл зарахыг хориглов. Хятадын гоо сайхны бүтээгдэхүүн арьсан дээгүүр тууралт гаргадаг, хуурай зуушнууд гэдэсний халдвар авчирдаг хэмээн наймаалахыг мөн л хориглов. Хятадаас авчирсан хувцас хунарыг хэт баячуудын хэв маягтай, гял цал хэмээн үзэж мөн л зарахыг зогсоолоо.

Хүндэтгэх шалтгаан байхгүй л бол "Хятадад үйлдвэрлэв" шошготой юуг ч иргэд худалдан авч болохгүй ба иргэд эх орныхоо үйлдвэрлэлийг дэмжих ёстой.

"Биднийг Хятадын эд юмсын оронд эх орныхоо бүтээгдэхүүнийг худалдаж авахыг шаардах боловч манайх юу ч үйлдвэрлэхгүй байна шүү дээ" хэмээн 2009 онд ярилцсан нэгэн наймаачин хүүрнэж билээ. "Манай генерал социализмыг өмнө байсан төрхөнд нь очуулахыг хүсэж байна" хэмээн тэр нэмж өгүүлсэн.

Саяхныг хүртэл хүмүүс хориотой эд зүйл зарж байснаа цагдаагийнхныг харангуут ширээн доогуураа нуух, эсвэл шалгалт хийхээс нь өмнө далд хийдэг байжээ. Гэвч 2009 оны сүүлчээр Хөдөлмөрийн Нам том хөзрөө дэлгэснээр энэ бүхэнд цэг тавьжээ. 11 сарын 30-нд эргэлтэнд байгаа бүх мөнгөн тэмдэгтийг хүчингүй болгож, шинийг үйлдвэрлэх шийдвэр гаргалаа. Тухайн үед нэг ам. доллар 3500 вонтой тэнцэж байжээ. Үүнийгээ үндэсний валютыг бэхжүүлж, мөнгөний эргэлтийг тогтворжуулах ба ханш уналтыг зогсоох оролдлого хэмээн Намын хариуцлагатай ажилтан тайлбарлаж байсан нь үнэмшихэд бэрх юм. Гэвч энэ нь зүгээр л заль байжээ. Хойд Солонгосын засгийн газар иргэдийн зах дээр наймаа хийснээс олсон мөнгийг хураан авах зорилготой ийм шийдвэр гаргасан байна. Энэ шийдвэрээр иргэдийг 100,000 вон л шинэ мөнгөн тэмдэгт рүү шилжүүлэх эрх олгожээ. Энэ нь 30 орчим доллартай л тэнцэнэ.

Хойд Солонгосын дэглэм мөнгөний ханш уналтыг зогсоох ийм төрлийн арга хэмжээ нийт таван удаа авч хэрэгжүүлж байсны хамгийн сүүлийнх нь 1992 онд болжээ. Нийгмийн дунд давхаргынхны хөлс хүчээ шавхаж цуглуулсан мөнгө нь нэг шөнийн дотор цаас болж хувирсан юм.

"Би яаж тайлбарлахаа ч мэдэхгүй байна. Толгой задрах гэж байгаа мэт л болсон. Цуглуулсан бүх мөнгө чинь юу ч биш болно гэхээр үнэхээр аймаар байгаа биз дээ. Хүмүүс гэнэт цочролд орсноосоо болж ухаан алдаж, эмнэлэгт хүргэгдэж байлаа" хэмээн Хятадад саяхан ирсэн Солонгосчуудтай ярилцлага хийж байх үед уулзсан 17 настай охин ярьсан юм. Тэр гурван долоо хоногийн өмнө Хятадад ирсэн байлаа.

Мөнгөн тэмдэгт сольсноос гадна Хөдөлмөрийн Нам бүх захыг хааж, гадаад валютаар наймаа хийхийг хориглолоо. Хүмүүс тэвчихээ больж, эсэргүүцлээ илэрхийлж эхлэв. Захуудыг хаахаар ирсэн цагдаагийн ажилтнуудтай наймаачид зодоон хүртэл хийсэн байна. Хүчингүй болсон мөнгөө хураалгахын оронд хүмүүс жорлонгийн цаас болгох, далай руу шидэх, гудамжинд тараан цацах зэргээр нэг талаас мөнгө олж байснаа нуух, нөгөө талаас дургүйцлээ илэрхийлсэн юм. Чонжины нэгэн эр үнэгүйдсэн мөнгөө шатаасанд уурлаж, Ким Чен Иррийн зургийг шатаасан хэргээр цаазаар авахуулсан ч явдал гарав.

Хэрэгцээт зүйлээ маш хямдханаар улсын дэлгүүрүүдээс авч болно. Тухайлбал өмнө нь нэг килограмм нь 2500 вон хүрч асан будааг шинэ мөнгөөр 25 воноор худалдаж авч болно хэмээн сайхан амлаж байсан авч үнэн хэрэгтээ дэлгүүрт нь будаа, эрдэнэшиш, буудай, ургамлын тосны аль нь ч байсангүй.

Захууд хаагдсаны дараа хүнсний бүтээгдэхүүнийг гудамжинд хар аргаар наймаалах иргэдээс л олж авах боломжтой болов. Гэвч үнэ нь тэнгэрт хаджээ. Нэг килограмм будааг хоёр долоо хоногийнхоо цалингаар авах хэмжээнд очив. Бүтэн долоо хоногийн цалин ганц өндөг авахад хүрэхтэй үгүйтэй боллоо. Нэг өдөрт л гэхэд юмны үнэ хоёр, гурав дахин өсөж, валют солилцооны ханш маш их хэлбэлзэж, гадаад худалдаа зогсоход хүрчээ.

Пхеньянд ажлаар ирсэн хүмүүс ихэвчлэн буудаг Корёо зочид буудалд л гэхэд хэдхэн цагийн дотор еврогийн ханш 41 воноос 120 болтлоо өссөн байна. Ямар ханшаар сольж чадсанаас шалтгаалаад нэг аяга кофе 11-32 долларын үнэд хүрч байжээ. Пхеньяны бараг бүх дэлгүүр, ресторан үүдээ барив. Зарим гадаадын элчин сайдын яамд тус улсаас гарна хэмээн мэдэгдэл хийхэд хүрчээ. Ийнхүү эдийн засаг бараг л сүйрэлд орсон байна.

2009 оны 12 сарын сүүлч гэхэд Хөдөлмөрийн Нам тавьсан хязгаарлалтаа цуцлахаас өөр аргагүйд хүрч өнгөрсөн хоёр сард Намын дарга Ким Ён Ир мөнгөн тэмдэгтийн шинэчлэлийг "сайтар бэлтгэлгүй" хийсэн учир буруу алхам байсныг хүлээн зөвшөөрч иргэддээ маш их зовлон учруулсандаа уучлалт гуйжээ. Уучлалт гуйснаа баталгаажуулахын тулд хэн нэгнийг золигт гаргах арга олсон нь төлөвлөлт, санхүүгийн яамны сайд, намаа тууштай дэмжигч 70 настай Пак Нам Ки байлаа. Энэ хүн аливаа гэрэл зурган дээр үргэлж Ким Чен Иррийн хажууд зогсож харагддаг байжээ. Түүнийг өнгөрсөн гуравдугаар сарын дундуур Пхеньяны стадионд буудан хороосон байна.

Хамгийн харамсалтай нь хохирлыг нөхөхөд дэндүү оройтсон байлаа. Хятад худалдаачид зөвхөн бэлэн мөнгөөр л худалдаа хийхийг хүсэх боловч Хойд Солонгосчуудад мөнгө үгүй. Гуравдугаар сард хилийн ойролцоо надтай уулзсан Хойд Солонгосын иргэд хүнс хоол 1990-ээд оноос хойш хамгийн ихээр хомсдолд орсон хэмээж байв. Өмнөд Солонгосоос тарианы үр, бордоо хангахаа больсноос хойш ургац хураан авахаа больж, эдийн засгийн уналт хурдасчээ.

"Арай ч дэндүү юм болж байна. Тэсэхийн арга алга. Хүмүүс ахиад л өлсгөлөнд автаж эхэллээ" хэмээн Мусанаас ирсэн, өөрийгөө Ли Ми Хий хэмээн танилцуулсан хижээл насны эмэгтэй илэн далангүй хүүрнэсэн юм. Тэр 2009 оныхоо 12 сарын сүүлээр буюу мөнгө сольсноос хоёр долоо

хоногийн дараа Хятадад ирсэн бөгөөд том болсон хүүтэйгээ байнга хууль бус гар утсаар нь холбоо барьдаг байлаа. "Хүнс хоол аажмаар ховордож байсан 1990-ээд онтой огт адилгүй. Тэр үед хэн ч юу ч ярьдаггүй байсан бол хүмүүс одоо гомдоллож эхэлсэн" хэмээн тэр ярьсан юм.

Чонжиноос хойхно оршдог, худалдааны тусгай хот Ражин руу байнга ирж очдог найз минь ярихдаа зах дээр нь будаа, жимс, эрдэнэшишийн аль нь ч байхгүй, зөвхөн гурил л байсан хэмээсэн юм. Ганц нэг шил виски бэлгэнд аваачиж өгдөг албаны хүн найзад минь дараа ирэхдээ будаа авчраарай хэмээн захисан гэнэ.

Эдийн засгийн сүйрэл Хойд Солонгосын хувьд маш тохиромжгүй үед болж байгаа юм. Ким Чен Ир хамгийн том хэзрөө дэлгэх гэж хичээж байна. Энэ нь отгон хүү Ким Чен Ундаа халаагаа өгөх явдал. Ким Чен Ун 1982 эсвэл 83 онд төрсөн ба маш нууцлаг нэгэн. Намайг номоо бичээд сууж байхад Пхеньяны гудамжаар хэнд ч танигдахгүйгээр алхаж явж ч мэднэ. Хөдөлмөрийн Нам 2009 оноос эхлэн түүнийг олонд таниулж эхэлсэн ба 2010 оны нэгдүгээр сарын 8-нд Ким Чен Уны төрсөн өдрийн баярт намын нөхдүүдийг урьсан байна. Он жил өнгөрөхөд түүний зураг аав, өвөө хоёрынхоо хөргийн хажууд айл өрх, албан газар гээд л байж болох бүх газраа залрах биз.

Ким Чен Ирийн эрүүл мэнд тааруу байгаагаас болов уу, ямартай ч Ким Чен Уны халаа авах явдал асар түргэн өрнөж байна. Ким Чен Ир 2008 онд саа өвчин тусаж өрөөсөн гар нь мэдээгүй болсон ба бөөрний өвчин, чихрийн шижин, хорт хавдар туссан ч байж магад. Гуравдугаар сард миний ярилцлага хийсэн 50 настай нэгэн эмэгтэй үзэл суртлын нэгэн лекцин дээр анх Ким Чен Уны тухай сонсчээ. "Ким Чен Ун нь гуч ч хүрээгүй залуухан учир хүмүүс түүнийг эх орноо өөр замаар хөгжүүлнэ хэмээн найдаж байгаа" хэмээн тэр эмэгтэй хэлсэн ба харин Мусаны хижээл эмэгтэй "Эцэг нь эх орноо авч явж чадахгүй, хүмүүс өлсгөлөнд нэрвэгдээд байхад хүү нь юу ч хийж чадах вэ дээ?" хэмээн сэтгэл дундуур хэлсэн юм.

Хойд Солонгос улс хүнсгүйдээд ирэхээрээ суртал ухуулгаа улам эрчимжүүлдэг. Пхеньянд намын залуу гишүүд гудамжны бүдэг гэрэлд иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлнэ хэмээн Ким Чен Ирийн шинэ жилээр хэлсэн үгийг амандаа бувтнан, цээжлэх даалгавраа биелүүлэхийг хичээцгээнэ. Ухуулах хуудас иргэдийг "150 хоногийн тэмцэл" гэгчид уриалан дуудаж, энэхүү тэмцлийн хугацаа нь дуусмагц ахиад "100 хоногийн тэмцэл" зарлаж эх орныхоо төлөө илүү их золиос гаргахыг шаардсаар байгаа билээ. Энэхүү их хүч хөдөлмөрийн үр шимийг 2012 онд Ким Ир Сений төрсний 100 жилийн ойг тэмдэглэх үеэр үзнэ хэмээн хүмүүсийг итгүүлэхийг оролдож байна.

Суртал ухуулгад Хойд Солонгос 2012 он гэхэд хөгжин цэцэглэсэн хүчтэй улс болсон байна хэмээн улиглана. Гэтэл хүмүүст итгэл төрөхгүй л байгаа. 2009 онд Пхеньяны захын хороололд амьдарч байгаад Хятад руу оргосон 28 настай эмэгтэй "Тэд 2012 он гэхэд байдал сайжирч, хүмүүсийн амьдрал дээшилнэ хэмээн яриад л байгаа. Гэтэл үүнд нь яаж итгэх юм бэ? Бодоод үзэхэд одоо өлсөж зовж байгаа хүмүүсийн амьдралыг хоёрхон жилийн дотор яаж сайжруулах юм бэ? хэмээн хэлсэн.

Намайг Хойд Солонгост хамгийн сүүлчийн удаа 2008 оны сүүлчээр очиход 2012 оны онцгой

үйл явдал буюу Ким Ир Сений төрсний 100 жилийн ойн кампанит ажил аль хэдийн эхэлсэн байсан.

2008 онд Пхеньянд нэг удаа, 2009 онд хил рүү хоёр удаа очиход надад олон янзын сэтгэгдэл зэрэг төрж байж билээ. Пхеньянд тав зургаан өндөр барилга сүндэрлэн босож, бас ахиад хэдэн барилгыг эхлүүлж, шат тавьсныг хараад гайхах сэтгэгдэл төрснийг нуух юун. Хөрөө болон алхны дуу гудамжинд сонсогдож байв. Шинэ барилга хэдэн арваараа сүндэрлэн босдог Азийн бусад нийслэлүүдтэй харьцуулахад энэ юу ч биш боловч 1960-аад он дээр гацсан мэт Пхеньяны хувьд үнэхээр гайхмаар зүйл мөн байлаа. Хэдэн арван жилийн туршид удирдагчдын хөшөөнөөс өөр юу ч баригдаагүй шахам байсан юм. Гэтэл одоо 2012 онд Ким Ир Сений төрсний зуун жилийн ойгоор ашиглалтанд өгөх зорилготой 100,000 айлын орон сууц баригдаж байгаа хэмээн хөтөч маань хэлсэн. Хувьсгалын сэдэвтэй дуурь тавьдаг Пхеньяны Их Театрыг засаж байгаа бөгөөд хотдоо хамгийн гоёмсог барилга болох Тэдонгмун кино театрын барилгыг ч янзалж буй гэсэн. Хамгийн хачирхалтай нь Пхеньяны дуусдаггүйгээрээ алдартай барилга болох 105 давхар пирамид хэлбэртэй Ругёнг буудлын нүүрэн хэсгийг засч эхэлсэн явдал байлаа. Египетийн үүрэн утасны алдартай компани болох Ораском гар утасны сүлжээ нэвтрүүлэхээр 400 сая долларын гэрээ байгуулахаар болжээ. Сүлжээ одоо ажиллаж байгаа боловч хэрэглэгчид зөвхөн орон нутгийн дуудлага л хийх эрхтэй. Үүрэн утас Хойд Солонгосыг 21-р зуунд авчрах гэж бартаатай бөгөөд урт замыг туулсан нь гарцаагүй.

Миний Пхеньянд хийсэн хамгийн сүүлчийн аялал налгар сайхан цаг агаартай есдүгээр сард таарч би нэлээд олон эмэгтэйчүүд чамин хийцтэй өндөр өсгийтэй сандал өмссөн байхыг анзаарсан. Мөн анх удаа дунд насны махлаг эмэгтэй явж байхыг харсан. Махлаг гэдэг маань Америк стандартын таргалалт биш, гэхдээ л Пхеньянд тэр хэрийн тарган хүн харсан би гайхаж, булан тойрохоос нь өмнө амжиж зургийг нь дарахаар аппарат руугаа ухасхийсэн юм.

Пхеньяныг гадаадынханд зориулсан үзүүлэнгийн хот гэдэг утгаар нь ихэвчлэн Потёмкин тосгон хэмээн нэрлэдэг. Хаашаа ч явсан, сэжигтэй нь аргагүй ганган хувцасласан хүмүүс хүн итгэхээргүй байдалд байхтай дайралдана. Жишээлбэл: улаан хацартай залуу эмэгтэй үндэсний хувцсаа өмсөөд Ким Ир Сений хөшөөний өмнөх сандал дээр суучихсан, ном уншиж буй царайлна. Сүүлд очихдоо шажигнасан шинэ дүрэмт хувцастай цэргийн төлөөлөгчид Ким Ир Сений хөшөөнд цэцэг өргөхөөр очоод доош бөхийн ёслох үед өмднийх нь шуумаг дээш болж, нүцгэн хөлнүүд гарахыг би олж харсан билээ. Цэргийнхний оймсны хангалт удаан хугацаанд муу байсных биз ээ.

Нью-Йоркийн Филармонийн чуулга 2008 онд Пхеньянд очиход хотыг тэр чигээр нь Зул Сарын баяр мэт чимэглэн, Ким Ир Сений талбайг дүүрэн гэрлээр гийгүүлж, гол гудамжуудыг жижигхэн цагаан гэрэл сүлэн байлаа. Хөгжимчид, сэтгүүлчид гээд нийт 300 гаруй хүний бүрэлдхүүнтэй төлөөлөгчдийн багийг Янкакдо (жуулчдыг тэнүүчлэхээс сэргийлэх зорилгоор тусгай арал дээр барьсан буудал учраас Алькатраз хэмээх хочтой) зочид буудалд буулгав. Концертын талаарх мэдээлэл цагт нь явуулах хэрэгцээг маань биелүүлэхийн тулд байнгын интернетийн холболтоор ч хангав. Өрөөндөө ороход буудлын халаалт хэтэрхий байсан тул бид фудболка, богино өмдтэй байхаас өөр аргагүйдсэн. Хоол нь дэндүү тансаг. Оройн хоолонд яргай загас, хавч, хонины мах, нимгэн хэрчсэн гургуулын мах, Вен хийцийн шоколадтай бялуу зэргээр дайдж байлаа. Өглөөний

хоол нь буфет байсан ба ширээнүүдийг мөсөн баримал, янз бүрийн дүрс болгон урласан шийгуа зэргээр чимэглэж их хэмжээний, өргөн сонголттой хоол унд өрсөн байв. Энэ үнэхээр сайн шоу болж чадсан. Бидний дундах хамгийн сөрөг бодолтой сэтгүүлчэд хүртэл Хойд Солонгос хямрал, өлсгөлөнгийн үеэ амжилттай давж, эдийн засаг нь сэргэж эхэлж байгаа юм болов уу гэсэн сэтгэгдэл төрсөн.

Мэдээж биднийг хуурсан байсан юм. Тэндээс буцсаныхаа дараа, долоо хоноод НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөрийн Пхеньян дахь төлөөлөгч Жон Пиер де Маргеритай утсаар ярьтал, та бүхнийг явсны дараа бүх гэрэл цахилгаан тасарч, ахиад л тас харанхуй нөмөрсөн хэмээн хэлсэн билээ.

Хойд Солонгост хамгийн том хөтөлбөртэй НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөрийнхөн тус улсын эдийн засгийн талаар гайхмаар дүгнэлт хийсэн. 2008 онд 250 өрхийн дунд хийсэн судалгаанаас үзвэл тэдний гуравны хоёр нь хээр талаас түүсэн ногоо, өвсийг хоолны хольц болгон хэрэглэсээр байсан байна. Хүнсний хомсдлоос шалтгаалан томчууд үдийн хоол идэхгүй байгаа гэнэ. Дараагийн хоолоо хаанаас олох гэж байгаа талаар асуухад тэд мэдэхгүй, эсвэл манай хамаатан хамтралаасаа өнөө орой төмс авчирч өгөх байх гэсэн худал хариултаа өгцгөөсөн гэж де Маргери хэлсэн билээ. Судалгаанд хамрагдсан зарим нь асуултад хариулахдаа уйлцгааж байжээ.

НҮБ-ын байгууллагууд энэ улсад 1990-ээд оных шиг өлсгөлөн дахин нүүрлэхгүй боловч хүн ам нь олон жилээр хоол тэжээлийн дутагдалд орсон хэвээр байх шинжтэй хэмээсэн дүгнэлт гаргасан билээ. Өнгөрсөн зун АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн багийнхны ярьснаар хүүхдүүд хоол тэжээлийн дутагдлаас болж танин мэдэхүйн болон нийгмийн хөгжлөөрөө хоцрогдож эхэлсэн хэмээн багш нар нь ярьсан гэнэ. Мөн ажилчид бүтэн өдрөөр, илүү цагаар ажиллах ямар ч чадваргүй болсон байна. Түүнээс гадна буруу хооллолтоос шалтгаалж хоол боловсруулах эрхтний өвчлөл 20-40 хувь нэмэгдэж буй ажээ.

Пхеньянаас гармагц л Хойд Солонгосын үнэн дүр төрх нүдний өмнө зурайна. Пхеньянд байрлах тусламжийн байгууллагуудын ажилтнуудыг ч ямар нэг дагуулгүйгээр хөдөө орон нутаг руу зүглэхийг зөвшөөрдөггүй. Ми Ран Ким Чен Ирийн судалгааны өрөө байгуулах зорилгоор цонхны шилэнд явахдаа анх үхсэн хүн харсан гэх Намбо хот руу би тойрон аяллаар явж үзсэн юм. 2008 оны есдүгээр сард хийсэн энэ аяллын үеэр төв гудамжуудын хажуугаар зүлгэн дээр унтацгаасан орон гэргүйчүүд, ажлын өдрүүдэд хийх юм байдаггүй бололтой хажуулдаад суучихсан хүмүүс хэдэн арваараа тааралдана. Шавар шороо болсон үйлдвэрийн ажилчны хувцас өмссөн, ес орчим насны хөл нүцгэн хүү томдсон өмдөө чирэн гудамжаар алхахыг би анзаарсан сан. Ингэж анх тэдний "тэнэмэл хоолны савнууд" хэмээн нэрлэдэг хүүхдүүдийн нэгийг өөрийн нүдээр олж харсан юм.

Пхеньянаас Намбо ортол 40 км орчим замыг туулахдаа Хойд Солонгосын хүн амын хөлтэй нь хөлхөж, хөлгүй нь мөлхөж хоол ундны эрэлд гарч буйг харсан билээ. Дунд насны албан хаагч эмэгтэйчүүд мөрөндөө хүрз үүрч, ном сугавчлан хөдөө тосгон руу алхаж явааг, замын хажуугаар настай хүмүүс гараараа өвс ургамал яран идэж болохоор зүйл хайж буйг замдаа харсаар л байв. Химийн бордооны оронд хэрэглэсэн хүний ялгадас тариан талбайгаас нь үнэртсээр л. 2008 оноос

эхлэн улс төрийн түгшүүртэй байдлаас болоод Өмнөд Солонгосоос хангадаг байсан химийн бордооны хэмжээ мэдэгдэхүйц багасчээ. Тариан талбай дээр нь бензиний оронд эрдэнэ шишийн гол мод түлж асаадаг болгон өөрчилсөн болов уу гэмээр утаагаар хахаж цацсан хэдэн трактор хөлхөлдөж байлаа. Хүмүүс нуруундаа том том шуудай үүрэн хэдэн жил огт галт тэрэг яваагүй болов уу гэмээр төмөр замыг даган алхацгааж байхыг харав.

Цаг сайхан байхад ч Хойд Солонгос хүн амынхаа хэрэгцээт хүнсний дөнгөж 60 хувийг үйлдвэрлэх чадалтай байсан ба үлдсэнийг нь импортоор оруулж ирэх санхүүгийн бололцоогүй болсон билээ. Пхеньянаас алслагдах тусам хүнсний хомсдол улам л их болно. НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөр, Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллагаас гаргасан хамтарсан судалгаанд Хойд Хамён мужийг хүнсний хомсдолд хамгийн өртөмтгий газраар шалгаруулсан байна.

Энэ номд зориулан ярилцлага авсан хүмүүсээс хэд хэд нь Чонжин дахь гэр бүлтэйгээ Мусан, Хөүрэнг зэрэг хилтэй ойролцоо, Хятадын гар утасны сүлжээ барьдаг газрууд дахь хууль бус утсаар хэрхэн холбоо барьдаг тухайгаа ярьж байсан. 2009 оны гуравдугаар сард дүү нарынхаа нэгтэй утсаар ярьсныхаа дараа хатагтай Сонг "Тэнд байдал маш хүнд байгаа гэнэ. Зах дээр хүнс олдоц муутай мөнгөний ханш асар ихээр унаж, арай л гэж амь зууцгааж байна гэнэ" хэмээн надад хэлсэн юм. Хатагтай Сонгийн ах дүүс өөрийнх нь Хятадаар дамжуулан явуулдаг мөнгөний дэмээр арай дээр амьдарч байгаа гэнэ. Гэхдээ тэр мөнгөнийх нь ихэнхийг цагдаа нар хурааж авдаг гэнэ.

Оргогсдын Хойд Солонгос дахь гэр бүл, хамаатан садан нь тэндээ хамгийн дөнгүүр амьдралтай нь. "Миний нөхөр хэлэхдээ гэрээр нь аюулгүйн ажилтнууд үргэлж ирж, юм шиншилдэг. Өөрт нь сахлын хутга байгааг мэддэг болохоор үргэлж гэрт нь ирж сахлаа хусдаг тухай ярьсан" гэж Ок Хи ярьсан билээ.

Мөнгөний шинэтгэл айл өрхүүдийн хуримтлуулсан мөнгийг юу ч үгүй болгов. Хатагтай Сонгтой 2010 оны нэгдүгээр сард буюу мөнгөн тэмдэгт шинэчилснээс сар хагасын дараа уулзахад "Амьдрал хэцүү байсан. Гэхдээ одоо бүр хэцүү болсон гэнэ" хэмээн ярьсан билээ. Хатагтай Сонг болон бусад оргогсод Хойд Солонгос дахь улс төрийн тогтворгүй байдал даамжирч, нутгаасаа дайжсан хүмүүсийн ар гэрийнхнээс өшөө авах вий хэмээн түгшиж байлаа.

Баян хоосны ялгаа гэмт хэргийн хэмжээнд нөлөөлөв.

Хатагтай Сонгийн хоёр дахь охины нөхөр 2006 он хүртэл галт тэрэгний буудлын харуулын ажил хийж байжээ. Тэд Ок Хигийн тусламжаар тухайн онд Өмнөд руу оргож ирсэн байв. Оргон гарах үеэр нь барааны агуулахаас хүнс хулгайлдаг хулгайчдын тоо их олон болсон учраас харуулуудад байлдааны сумтай буу олгож хулгайчийг харвал устга гэсэн даалгавар өгч байжээ. Төмөр замын ажилчдын хүнсэнд зориулсан эрдэнэ шиш тариалдаг талбай руу хулгайч орвол бас бууд гэсэн тушаал ч өгч байсан гэнэ. Чонжинд хар тамхины асуудал бусад газартай харьцуулахад маш их байдаг. Учир нь эндхийн жижиг үйлдвэрүүдэд "мөс" буюу цагаан метафетафин хэмээгч хүний тархи, сэтгэхүйд нөлөөлөгч сэргээгч бодисын төрлийг үйлдвэрлэдэг бөгөөд хот дотроо ч, Хятадын хил дээр ч өргөнөөр наймаалдаг юм. Энэ бодис хямд, дээр нь хоол идэх дуршлыг багасгадаг учир өнөөгийн Хойд Солонгосын амьдралын хэв маягт сайн тохирдог байна.

Пхеньянд ажиглагдсан шиг шинэ барилгууд сүндэрлэж байгаа үзэгдэл Чонжинд бараг үгүй. Хотод сүүлд бий болсон хоёр шатахуун түгээх станцийг эс тооцвол шинээр баригдсан зүйл үгүйтэй адил. Хамгийн сүүлд боссон барилга гэвэл 1990ээд оны сүүлээр хайрт удирдагчийн дуртай цэцэг гэгдэх Кимжонилиад зориулж барьсан ягаан өнгөтэй байшин. Нэгдүгээр төв замын дагуух барилгуудын нүүрэн хэсгийг ногоон, улаан шар өнгөөр сэргээн будсан боловч хүрээнүүд нь унах дөхсөнөөс, доогуур нь яваа хүмүүс байнга болгоомжлохгүй бол толгой дээрээс нь унах аюул отох болжээ. Замын хажуугаар тодорхой зайд байрлуулсан олон самбар дээр эдийн засгийн тэргүүн шугам хэмээх төр засгийн сүүлийн үеийн уриа лоозонг бичжээ.

Сүүлийн хэдэн жилийн дотор, өмнө нь улсын эзэмшлийн зоогийн газрууд байгаад эдийн засгийн хямралын үед үүдээ барьсан байшингуудад шинээр хувийн зоогийн газрууд, караоке баарууд нээгдсэн боловч энэ төрлийн бизнес тогтвортой ажиллаж чадахгүй, удалгүй бүрэн зогсдог байна.

"Чонжинд хөгжлийн ямар ч шинж тэмдэг олж хараагүй.

Харин ч эсрэгээрээ уруудаад л, хөгжлийн хувьд ухраад байна уу гэмээр харагдсан. Бүх зүйл нурж сүйрч, улам л муудаад байгаа мэт. Ихэнх үйлдвэр ажиллахгүй.

Үйлдвэрүүдийн найман яндан тутмын нэгээс нь л утаа гарч байсан" хэмээн НҮБ-ын Дэлхийн Хүнсний Хөтөлбөрийн Азийн Бүсийн Дэд Захирал Антони Бэнбюри Чонжинд 2008 оны наймдугаар сард очоод ирснийхээ дараа надад ярьсан билээ.

Гадаад валютын хомсдолд орсон Хойд Солонгос улс сүүлийн жилүүдэд Чонжин руу гадаадын жуулчдыг бага багаар нэвтрүүлэх болов. Жуулчид Чилбо орох, буцах замдаа Чонжиноор дайрах боломжтой. Европоос ирсэн миний найз 2010 онд очсоныхоо дараа Чонжинг "итгэмээргүй ядуу хот" хэмээн тодорхойлсон билээ. Хотын төвд настайчууд, хүүхэд голдуу хүмүүсээс бүрдсэн баг зам засаж байх юм гэнэ. Найзын минь ажигласнаар тэд өглөөний таван цагаас шөнө харуй бүрийн хүртэл хүнд чулуу зөөж, алхаар буталж хайрга болгоно. "Шоронгийн хоригдлууд ажил хийж байгаагаас ямар ч ялгаагүй харагдаж байлаа" хэмээн найз минь хуучилсан.

Надад сайхан сэтгэлээр хандаж, өөрийн авсан гэрэл зургуудаа энэхүү номд минь хандивласан Германы газарзүйч Экхарт Дэгэ 2008 онд Чонжинд ба Ми Раны өссөн дүүрэгт очих зөвшөөрөл авч чадсан байна. Тэр ч эдийн засгийн үйл ажиллагаа явагдаж байгаа шинж тэмдэг бараг олж үзээгүй бөгөөд цорын ганц харсан зүйл нь орох замд хэдэн мянган хар ажилчин гар аргаар зам барьж байсан нь юм. "Хэдэн мянган ажилчин уулыг хүрэээр ухан шороо зөөж, пирамид барьж байгаа юм шиг жижиг жижгээр нь овоолон асгаж байлаа" хэмээн Дэгэ хэлсэн билээ.

Чонжин хотод маш олон хүн, Хойд Солонгосчуудын хувьд онцлог гэмээр байдал буюу хөлөө нугалан цээжиндээ авч, өлмийн гүдгэр дээрээ тэнцвэрийн цэгийг нь тааруулан сууцгааж байлаа. Дэлхийн бусад улс оронд хүмүүс ямар нэг зүйл хийж байхыг хардаг бол энд хүмүүс зүгээр л сууцгаадаг.

Энэ бол олон хүний анзаарснаар Хойд Солонгост л байдаг үзэгдэл. Суух сандалгүйдээ ч юм уу

тэд хэдэн цагаар хаа нэгтээ ийм байдалтай сууж цагийг өнгөрүүлдэг. Тэд трамвай хүлээж байгаа ч юм уу, өнгөрч яваа машинуудыг хардаг ч байж магад. Эсвэл тодорхой нэг юмыг биш, зүгээр л ямар нэг өөрчлөлтийг хүлээж байгаа ч юм бил үү?

Барбара Демик 2010 оны долоодугаар сар

ТАЛАРХАЛ

Өөрсдийнхөө амьдарч асан ертөнцийн талаар надад болон уншигчдад маань ойлголт өгөх гэсэндээ сайн дураараа, сониуч асуултад минь ундууцалгүй, сэтгэлийнх нь шархыг хөндсөн дурсамжаасаа хуваалцахдаа цааргалалгүй, цаг заваа харамгүй зориулсан номынхоо гол баатруудад гүнээ талархсанаа юуны өмнө илэрхийлье. Мөн надад тусалж, сайхан сэтгэлээр хандаж байсанд нь тэдний гэр бүлийнхэнд ч талархья.

Энэхүү номд орсон ярилцлагуудын ихэнхийг орчуулж дамжуулсан Жинна Парксын хэлний авьяас, тэвчээрийг гайхан биширснээ дурдья. Талийгаач доктор Жэй Нам намайг анх Чонжины оршин суугчидтай танилцуулж өгсөн юм. К хэмээн нэрлэсэн зоригтой, эмэгтэйн тусламжгүйгээр би Хойд Солонгосын талаар өдий зэргийн мэдлэгтэй болж чадахгүй л байсан болов уу. К маань нөхрийнхөө хамтаар Хойд Солонгосоос Өмнөд рүү цагаачилсан иргэдийн төлөө амь бие хайрлалгүй зүтгэж байсан ба одоо тэтгэвэртээ гарч, АНУ-д амьдарч байгаа. Түүнийг энд дурсахгүй өнгөрөх аргагүй юм.

Жу Сунг Ха, өөрөө Хойд Солонгосын дэглэмийн тухай ном бичнэ гэж ярьдаг Донг А Илбо, Ким До Сён, Ким Ён Ил, Чо Мён Чол, Ким Хи Ян, Ким Дэ Жин зэрэг энэ номд ороогүй боловч улс орныхоо амьдралын талаар ойлгуулж өгсөн хүмүүс бас бий.

Хойд Солонгосын асуудлаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг энд дурдах ёстой. Сөүлд байдаг "Гүүд Френдз" ТББ Хойд Солонгосын талаар маш сайн мэдээллийн товхимол эрхлэн гаргадаг юм. "Хойд Солонгосын ард түмнийг аварья" хөдөлгөөний тэргүүн Ли Ян Ва надад зөвлөгөө өгч, Чонжины талаарх дүрслэлийг минь баяжуулсан гэрэл зураг, видео олох газрууд руу чиглүүлэн өгч байлаа. Мөн Тим Питерс, Майкл Хоровитз, Сюзанне Шолт, Хан Ки Хон, Санни Хан, Хамба лам Ким Ён Шик, Чун Ки Вон, Хүний Эрхийн Хяналт, Хойд Солонгосын Хүний Эрхийн Иргэний Эвсэл зэрэг нь онцгой сайн эх сурвалж болсон юм. До Хи Юуны цэргийн олзлогдогсод, хулгайлагдсан хүмүүсийн талаар хийсэн судалгаа Ми Раны аавын талаар бичихэд минь үнэтэй суурь болсон.

Хүмүүнлэгийн болон тусламжийн байгууллагуудаас Швейцарийн Хөгжил ба Хамтын Ажиллагааны Агентлагийн ажилтан Катрина Зелвеггер, Америкийн агрономич Пил Жу Ким Жуу, НҮБ-ын Дэлхийн Хүнс Хөтөлбөрийн ажилтнууд болох Жон Пиер де Маргари, Жералд Бурке, болон Тони Бэнбури нар мөн надад тусалж байсан билээ.

Цаг заваа харамгүй зориулсан Солонгос судлаач Майкл Брийн, Скот Шнайдер, Стивен Хаггард, Маркус Ноланд, Николас Эберштадт, Боб Гарлин, Леонид Петров, Брайн Майерс, Даниел Пинкстон, Доналд Грег, Дэвид Хок, Brent Чой нарт талархлаа илэрхийлье.

Зохиолоос нь олон удаа ишлэл авч номдоо ашигласан Андрей Ланков надад маш их тусалсан. Доналд Макинтайр, Анна Файфилд нарын сэтгэлийг Хойд Солонгосын тухай сэдэв эзэлсэн болохоор надтай бодол санаагаа харамгүй хуваалцсан билээ.

Чарльз Шерман болон Сөүлд хамт ажиллаж байсан нөхөд, тухайлбал Жениффер Николсон, Жениффер Вийл, Скот Диаз, Сью Лин Ку, Патрисио Гонзалез, Паскал Бианнак Легер, Лачлан Страхан, Лили Петровска зэрэг хүмүүст үргэлж сэтгэлийн дэм өгч байсанд нь баярлалаа. Энэхүү номыг бүтээхэд туслалцаа үзүүлсэн Мун Ил Ва, Тим Саваж, Пол Экерт, Жаспер Бекер, Чо Сан Хун, Ким Жун Юн, Доналд Киорк, "Эцэг удирдагчийн агуу их хайрын дор" хэмээн номоос нь нэлээд олон ишлэл авсан Брэдли Мартин, Чи Жун Нам, Лим Бо Ён нар надтай олон ярилцлагад хамт орсон юм.

Энэхүү номд зориулан зургаа өгсөн хүмүүс буюу 2008 онд Чонжин хот, дүүрэгт очсон Экхарт Дэгэ, Жон Чун, Эрик Лаффорги, сурвалжлагч Анна Файфилд, Жонатан Воттс нарт баярлалаа. Асар их эрсдлийн дунд авсан Хойд Солонгосчуудын гэрэл зургуудаас Чонжиныг ялган өгсөн Ажиапрессийн Жиро Ишимаруд мөн баярлалаа.

Хийсэн судалгаа нь энэхүү номд орсон хүмүүс бол Лина Юун Парк, Парк Жу Мин, Хисако Уено, Рай Сасаки нар юм. Ховард Юун номын төлөвлөгөө боловсруулахад хувь нэмрээ оруулсан билээ.

Миний найз Жулие Тален, Тирза Байрон хоёр надад "номоо өдөр тутмын сонины бичлэгийн хэв маягтай болго" хэмээн зөвлөсөн юм. Жим Двайер байхгүй байсан бол би энэ номоо хэвлүүлж чадах асан эсэхээ сайн мэдэхгүй байна. Маргарет Скот, Тирза Байрон нар ч номын төлөвлөгөө хийж, бичих явцад зөвлөгөө өгдөг байлаа. Энэхүү номд үнэтэй хувь нэмрээ оруулсан бусад хүмүүсийг нэрлэвэл Гэйди Эпштэйн, Молли Фаулер, Эд Гарген, Эден Сориана Гонзага, Ли Хокштэйдер, Ализа Маркус, Руф Маркус, Номи Моррис, Иван Оснос, Катерин Петерсон, Флор де Пренюф, Дэвид Шмерлер, Изабел Шмерлер, Лена Сун, Жеэйн Вон Берген, Николас Вон Хофмен, Эрик Вайнер, Лора Вайдес Муноз, Трэйси Вилкинсон нар байна. Коллежид сурч ахуйд минь, баримтат тууж бичихдээ бусад зохиолчийн бичлэгийн загвар, бүтцийг харж сурах чадвар олгосон талийгаач багш Жон Херсидээ өдгөө, олон жилийн хойно баярлаад ч баршгүй нь. Түүний бичсэн "Хирошима" ном нь зургаан хүний амьдралын түүхийг нэгтгэн бичих явцад минь нөлөөлж маш их урам зориг өгч байлаа.

2006 оны Зул сарын баяраар айхтар ханиад хүрчихээд хүнд байсан мөртлөө босож миний төлөөлөгч болохоор зөвшөөрсөн, бас биелүүлэх ёстой үүргээсээ хамаагүй илүүг хийж өгсөн Филип Брофиг олсондоо би өөрийгөө их азтайд тооцдог. Номын хэвлэлт хариуцсан Жули Грау, Селина Спигел нар эхний өдрөөс л номыг минь ойлгож дэмжсэн. Лора Ван Дер Вийр номын дизайныг хийсэн билээ.

Лос Анжелес Таймс сонинд намайг анх хоёр Солонгосыг хариуцуулахаар ажилд авсан Саймон Ли, редактор Дийн Бакуэй, Жон Карл, Марк Дувойзин, Дуг Франц, Маржори Миллер, Брус Валлас нар сонинд ажиллахад дуртай болгосон төдийгүй эрэн сурвалжлах сэтгүүл зүйгээр дагнахад минь зоригжуулсан хүмүүс.

Жулие Макинен энэхүү номын эх үүсвэр болох Чонжины тухай цуврал өгүүллэгүүдийг чадварлагаар хянаж өгсөн. Марк Магнайер, Жон Глионна, Валерий Райтмэн, Чин Чин Ни, Дон Ли,

Дэвид Пирсон зэрэг Лос Анжелес Таймс сонинд хамт ажилладаг нөхөд маань надад бас тусласан.

20062007 онд Хүмүүнлэгийн Ухааны Зөвлөлийн Феррисын Принсетоны Их Сургуульд тэтгэлгээр суралцаж байхад минь Жозеф Хенригийн танхимд номоо бичих боломж олгосон. Лиза Коэн, Марта Мендоза, Т. Р Рэйд болон Рөүз Тэн нарын судлаачид мөн Гарри Бас, Марианн Кэйс, Гэйб Хадсон, Жефф Нунакава зэрэг багш нар үнэтэй зөвлөгөө хайрласан билээ.

Эцэст нь цорын ганц зээ хүүг нь дагуулаад Солонгос явлаа гэж хэлэхэд минь "Ямар сайхан боломж вэ" гэсээр хүлээн авсан ээж Гладис Демиктээ асар их талархаж явдгаа илэрхийлье. Тэр үргэлж ажил, амьдралд минь урам хайрладаг билээ. Мөн ухаан бодлыг минь эзэмдсэн Хойд Солонгостой бяцхан ухаандаа мөчөөрхөн барьцалгүй, " Та номоо дуусах болоогүй юу" гэж олон удаа асуусан хүү Николастаа би одоо " Тийм ээ" гэж хариулах эрхтэй боллоо.

Table of Contents

[Өмнөтгөл](#)

[Зохиогчийн үг](#)

[Нэгдүгээр бүлэг - Эцэс төгсгөлгүй харанхуйд хөтлөлцөн алхдаг байлаа](#)

[Хоёрдугаар бүлэг - Бохирдсон цус](#)

[Гуравдугаар бүлэг - Үнэнчээр итгэгчид](#)

[Дөрөвдүгээр бүлэг - Хар толбо бүдгэрэв](#)

[Тавдугаар бүлэг - Хайр дурлалын түүх](#)

[Зургаадугаар бүлэг - Бурхан үгүй болов](#)

[Долдугаар бүлэг - Дусал залгуулахын тулд шар айргийн шил хоёрыг авчрах хэрэгтэй](#)

[Наймдугаар бүлэг - Баян хуур ба самбар](#)

[Есдүгээр бүлэг - Сайн нь түрүүлж үхдэг](#)

[Аравдугаар бүлэг - Бүтээлч эхчүүд](#)

[Арван нэгдүгээр бүлэг - Тэнэмэл хоолны савууд](#)

[Арван хоёрдугаар бүлэг - Тоглоом төдий дүрэм журам](#)

[Арван гуравдугаар бүлэг - Худгийн мэлхий](#)

[Арван дөрөвдүгээр бүлэг - Гол](#)

[Арван тавдугаар бүлэг - Гэнэтийн ухаарал](#)

[Арван зургаадугаар бүлэг - Солилцооны эхнэрүүд](#)

[Арвандолдугаар бүлэг - Нүдээ нээгээд, амаа хамхи](#)

[Арван наймдугаар бүлэг - Эх орны амлалт](#)

[Арван есдүгээр бүлэг - Нутагтаа гаднын хүмүүс](#)

[Хорьдугаар бүлэг - Дахин учирсан нь](#)

[Төгсгөл](#)

[Талархал](#)